МАНДАЛ
даатгал

# ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА
# 2018

АНДЕРРАЙТЕР: ГОЛОМТ КАПИТАЛ

# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

"Мандал Даатгал" ХХК /цаашид "Үнэт цаас гаргагч" гэх/ нь Монгол Улсын "Компанийн тухай хууль", "Үнэт цаасны зах зээлийн тухай хууль" болон Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо /цаашид "СЗХ" гэх/ болон Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК /цаашид "МХБ" гэх/-ийн холбогдох журмуудын дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгож байгаа болно.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгыг Үнэт цаас гаргагчаас нэг бүрийн 4,800 төгрөгийн үнэтэй нийт 1,560,754 ширхэг энгийн хувьцааг МХБ-ээр дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгохтой холбоотойгоор хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн болно. Үнэт цаас гаргагч нь халаасны 1,243,016 ширхэг энгийн хувьцааг хувьцаа эзэмшигч "Юу Эм Си Капитал" ХХК-ийн 317,738 ширхэг энгийн хувьцааны хамт санал болгож байгаа бөгөөд халаасны хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлсэн 5,966,476,800.0 төгрөгийн санхүүжилтийг СЗХ-ны 2013 оны 07 сарын 17-ны өдрийн 250 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага"-ын дагуу зарцуулж, хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх замаар эрсдэл даах чадварыг сайжруулна. Одоогийн хувьцаа эзэмшигч "Юу Эм Си Капитал" ХХК-ийн 317,738 ширхэг хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө нь үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхгүй байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулга нь Хөрөнгө оруулагч таны хараат бус үнэлгээ гаргах, шинжилгээ хийхийг орлохгүй бөгөөд тэдгээрт тооцогдохгүй. Хөрөнгө оруулагч та Үнэт цаас гаргагч болоод түүний гаргаж буй үнэт цаас, холбогдох мэдээллийн талаар өөрийн хөндлөнгийн судалгаа шинжилгээг хийсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийж буй бөгөөд өөрийн мэргэжлийн санхүүгийн, хуулийн болон бусад зохих мэргэжлийн зөвлөхүүдтэйгээ зөвлөлдөхийг зөвлөж байна.

Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зарим ирээдүйн болон зөвхөн одоогоор цаг хугацааны шинж чанартай гаргасан мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөлөл нь Андеррайтерийн холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, итгэл үнэмшил дээр тулгуурласан бөгөөд санаатайгаар ямар нэгэн мэдээллийг орхигдуулаагүй болно. Андеррайтер нь эдгээр мэдээлэл, мэдэгдэл, тооцоолол, төсөөллийг гаргахдаа аль болох үнэн зөв мэдээллийг ашиглан бодит байдалд нийцүүлэхийг зорьсон боловч мэдээллийн үнэн зөв байдалд хариуцлага хүлээхгүй бөгөөд тооцоолол, ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа өгөөгүй болно.

**ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Энэхүү үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч танд тус үнэт цаасыг худалдан авах шийдвэр гаргахад туслах шаардлагатай бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно. Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй, нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлаж тодруулах зүйл байвал Үнэт цаас гаргагч болон Андеррайтер Голомт Капитал ҮЦК ХХК-д хандаж тодруулна уу.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC



Огноо: 2018/04/16

Үнэт цаасны танилцуулга
СЗХ
он сар өдөр
Б 2018 .08. 29

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

# ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.7, 33.8 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.4 дэх заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7. (а), 6.7 (б) хэсэг, 7 дугаар зүйлийн 7.9.4, 7.9.5, 7.9.6 дахь заалтууд, 2018 оны 02 сарын 12-ны өдрийн 18/004 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол, 2018 оны 02 сарын 15-ны өдрийн 18/002 тоот ТУЗ-ийн тогтоолыг тус тус үндэслэн нийт 1,560,754 ширхэг энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-иар дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгож байна.

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Мандал Даатгал ХХК |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Нийт зарласан хувьцааны тоо | 25,000,000 ширхэг |
| Нийт эргэлтэд гаргасан хувьцааны тоо | 5,000,000 ширхэг |
| Нийт халаасалсан хувьцааны тоо | 1,243,016 ширхэг |
| Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ | 1,000 төгрөг |
| Олон нийтэд санал болгох эзэмшлийн хувь | 25.00% |
| Олон нийтэд санал болгох хувьцааны тоо | 1,560,754 ширхэг *(Халаасны нийт 1,243,016 ширхэг хувьцаа болон хувьцаа эзэмшигч "Юу Эм Си Капитал" ХХК-ийн эзэмшлийн 317,738 ширхэг хувьцаа)* |
| Олон нийтэд санал болгосны дараах гаргасан хувьцааны тоо | 6,243,016 ширхэг |
| Нэгж хувьцааны үнэ | 4,800 төгрөг |
| Олон нийтээс татан төвлөрүүлэх дүн | 7,491,619,200 төгрөг |
| Хувьцааг арилжаалах арга: | Тогтоосон үнээр санал болгох |

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК



Огноо: 2018/04/16

# АГУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД ..... 1
ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА ..... 2
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР ..... 7
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ ..... 8
1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ..... 9
1.1. Үнэт цаас гаргагчийн хаяг, байршил ..... 9
1.2. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл ..... 9
1.3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчид ..... 9
1.4. Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл ..... 11
1.4.1. Голомт Файнэншил Групп ХХК ..... 11
1.4.2. Юу Эм Си Капитал ХХК ..... 13
1.5. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт ..... 14
1.6. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл ..... 17
1.6.1. Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг ..... 19
1.7. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай 21
1.8. Үнэт цаас гаргагчийн түүх ..... 22
1.9. Үнэт цаас гаргагчийн ололт, амжилтууд ..... 23
1.10. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа ..... 23
1.10.1. Даатгалын үйл ажиллагааны тухай ..... 24
1.10.2. Үнэт цаас гаргагчийн даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн ..... 31
1.10.3. Үнэт цаас гаргагчийн нийт хураамжийн орлого ..... 31
1.10.4. Үнэт цаас гаргагчийн харилцагчдын тоо ..... 35
1.10.5. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын суваг ..... 35
1.10.6. Үнэт цаас гаргагчийн давхар даатгалын зардал ..... 36
1.10.7. Үнэт цаас гаргагчийн нөхөн төлбөрийн хэмжээ ..... 38
1.10.8. Үнэт цаас гаргагчийн нөөц сан ..... 40
1.10.9. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалтын орлого ..... 42
1.11. Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө, биет болон биет бус хөрөнгө ..... 44
1.12. Үнэт цаас гаргагчийн санхүү тайлан, шинжилгээ ..... 46
1.12.1. Орлогын тайлан ..... 46
1.12.2. Санхүү байдлын тайлан ..... 47
1.12.3. Санхүүгийн шинжилгээ ..... 48
1.13. Эрсдэлийн хүчин зүйлс, удирдлага ..... 50
1.13.1. Даатгалын эрсдэл ..... 50
1.13.2. Бизнесийн эрсдэл ..... 51
2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ ..... 55
2.1. Монгол Улсын эдийн засгийн байдал, цаашдыг чиг хандлага ..... 55
2.2. Монгол Улсын Даатгалын салбар ..... 59
2.2.1. Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл ..... 59
2.2.2. Салбарын нийт хөрөнгийн хэмжээ ..... 60
2.2.3. Салбарын нийт нөөц сан, өр төлбөр ба эздийн өмч ..... 61
2.2.4. Салбарын нийт хураамжийн орлого ..... 62
2.2.5. Салбарын нөхөн төлбөрийн хэмжээ ..... 64
2.2.6. Салбарын ашигт ажиллагаа ..... 64
2.2.7. Өрсөлдөгчийн судалгаа ..... 65
3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ..... 69
3.1. Үнэт цаасны танилцуулга ..... 69
3.2. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр ..... 69
3.3. Үнэт цаас эзэмшигчийн эрх ..... 70
3.4. Үнэт цаас эзэмшигчийн үүрэг ..... 71
3.5. Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлогын төсөл ..... 71
3.6. Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл ..... 73



Огноо: 2018/04/16

3.7. Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт ........ 74
3.8. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө ........ 75
3.9. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах ........ 77
4. ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ ........ 79
4.1. Хараат бус аудиторын дүгнэлт ........ 79
4.2. Үнэлгээний байгууллагын хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний дүгнэлт ........ 82
4.2.1. Хөрөнгийн үнэлгээ ........ 82
4.2.2. Бизнесийн үнэлгээ ........ 83
4.3. Хуулийн дүгнэлт ........ 88
4.4. Андеррайтерийн дүгнэлт ........ 92
5. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТАНИЛЦУУЛГА ........ 106
5.1. Андеррайтер ........ 106
5.2. Хуулийн зөвлөх ........ 107
5.3. Хараат бус аудит ........ 108
5.4. Үнэлгээний компани ........ 109
6. ХАВСРАЛТ ........ 111
6.1. Улсын бүртгэлийн гэрчилгээ ........ 111
6.2. Тусгай зөвшөөрөл ........ 113
6.3. Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл ........ 114
6.4. Компанийн дүрэм ........ 116
6.5. Үнэт цаас гаргах тухай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол ........ 135
6.6. Үнэт цаасны үнэ тогтоох тухай ТУЗ-ийн тогтоол ........ 137
6.7. Үнэт цаас гаргагчийн шинэчилсэн дүрмийн төсөл ........ 138
6.8. Ногдол ашгийн бодлогын төсөл ........ 159
6.9. 2017 оны Хараат бус аудитын тайлан ........ 162
6.10. Хуулийн зөвлөхийн дүгнэлт ........ 197
6.11. Бизнесийн үнэлгээний тайлан ........ 230
6.12. Хөрөнгийн үнэлгээний тайлан ........ 283

## ГРАФ

Граф 1. Ашигт ажиллагаа 2012-2017 ........ 12
Граф 2. Арилжааны дүн, 2012-2017 ........ 12
Граф 3. Томоохон даатгалын ТОП-5 компанийн нийт хураамжийн орлого, тэрбум төг. ........ 23
Граф 4. Даатгалын зах зээлд эзлэх хувь ........ 23
Граф 5. Нийт хураамжийн орлого 2011-2017 ........ 31
Граф 6. Нийт хураамжийн орлого, даатгалын хэлбэрээр 2017 ........ 32
Граф 7. Даатгалын нийт хураамжийн орлогын бүтэц 2013-2017 ........ 32
Граф 8. Даатгалын хэлбэр тус бүрийн орлогын өсөлт 2014-2017 ........ 33
Граф 9. Нийт хураамжийн орлого, харилцагчийн төрлөөр 2013-2017 ........ 33
Граф 10. Иргэдийн даатгалын НХО, өсөлт ........ 33
Граф 11. Байгууллагын даатгалын НХО, өсөлт ........ 33
Граф 12. Иргэдийн даатгалын НХО, хэлбэрээр 2013-2017 ........ 34
Граф 13. Байгууллагын даатгалын НХО, хэлбэрээр 2013-2017 ........ 34
Граф 14. Харилцагч, гэрээний тоо, гэрээний дундаж дүн 2011-2017 ........ 35
Граф 15. Салбарын НХО, борлуулалтын сувгаар 2017 ........ 35
Граф 16. Мандал Даатгалын НХО, борлуулалтын сувгаар 2017 ........ 35
Граф 17. НХО vs. ДД хураамжийн зардал 2013-2017 ........ 36
Граф 18. ДД хураамж, хэлбэрээр 2017 ........ 37
Граф 19. ДД хураамжийн зардал 2013-2017 ........ 37
Граф 20. ДД нөхцөлийн шинэчлэлийн үр ашиг ........ 38
Граф 21. Нийт нөхөн төлбөр vs. цэвэр нөхөн төлбөрийн хэмжээ ........ 39
Граф 22. ОТХ-д эзлэх цэвэр нөхөн төлбөр ........ 39
Граф 23. Нийт нөхөн төлбөр, хэлбэрээр 2017 ........ 39



Огноо: 2018/04/16

Граф 24. Нөөц сангийн хэмжээ 2015-2017 ........ 40
Граф 25. Хөрөнгө оруулалтын задаргаа 2013-2017 ........ 43
Граф 26. Хөрөнгө оруулалтын задаргаа 2013-2017 ........ 43
Граф 27. Хөрөнгө оруулалтын өгөөж 2013-2017 ........ 43
Граф 28. Монгол Улсын гадаад худалдааны 70 орчим хувийг бүрдүүлэгч зэс, нүүрсний үнийн өөрчлөлтийн график ........ 55
Граф 29. Ам.долларын эсрэг төгрөгийн ханш ........ 55
Граф 30. Монгол Улсын ДНБ өсөлт, инфляци ........ 55
Граф 31. ДНБ-ний бүтэц 2017 ........ 56
Граф 32. Монгол Улсын зээлжих зэрэглэл ........ 57
Граф 33. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт ........ 58
Граф 34. Тавaарын ханшийн таамаглал, 2018-2020 ........ 58
Граф 35. Нэвтрэлтийн түвшин – Ердийн даатгал ........ 59
Граф 36. Дотоодын даатгалын салбарын нэвтрэлтийн түвшний төсөөлөл ........ 59
Граф 37. Нийт хөрөнгийн хэмжээ 2013-2017 ........ 60
Граф 38. Зах зээлд эзлэх хувь, нийт хөрөнгөөр 2017 ........ 61
Граф 39. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ ........ 61
Граф 40. Даатгалын салбарын нийт эх үүсвэрийн бүтэц ........ 62
Граф 41. Даатгалын салбарын нийт хураамжийн орлого, төрлөөр ........ 62
Граф 42. Салбарын нийт хураамжийн орлого ........ 62
Граф 43. НХО, хэлбэрээр ........ 63
Граф 44. НХО-ын өсөлтийн хүчин зүйлс ........ 63
Граф 45. Даатгалын компаниудын нийт хураамжийн орлогын хэмжээ ........ 63
Граф 46. Салбарын түүхэн нөхөн төлбөрийн хэмжээ ........ 64
Граф 47. Салбарын түүхэн ашигт ажиллагаа ........ 64
*Граф 48. Өрсөлдөгчдийн нийт хураамжийн орлого 2013-2017* ........ 66
Граф 49. Өрсөлдөгчдийн нийт хураамжийн орлогын өсөлт ........ 66
Граф 52. Бодь Даатгал: НХО vs ДД хураамж ........ 67
Граф 51. Монгол Даатгал: НХО vs ДД хураамж ........ 67
Граф 50. Мандал Даатгал: НХО vs ДД хураамж ........ 67
Граф 54. Мандал даатгалын хөрөнгийн задаргаа ........ 68
Граф 53. Бодь даатгалын хөрөнгийн задаргаа ........ 68
Граф 55. Монгол даатгалын хөрөнгийн задаргаа ........ 68

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн эзэмшил ........ 9
Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн халаасны хувьцааны мэдээлэл ........ 10
Хүснэгт 3. Олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгосны дараах эзэмшил ........ 10
Хүснэгт 4. Голомт Файнэншил Групп ХХК-ийн холбоотой талуудын товч мэдээлэл ........ 11
Хүснэгт 5. Топ-3 банкны нийт актив ........ 12
Хүснэгт 6. Топ-3 банкны зээл ........ 12
Хүснэгт 7. Топ-3 банкны хадгаламж ........ 12
Хүснэгт 8. Юу Эм Си Холдинг ХХК-ийн холбоотой талуудын товч мэдээлэл ........ 13
Хүснэгт 9. ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд ........ 15
Хүснэгт 10. Ажилтны тоо ........ 16
Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн мэдээлэл ........ 17
Хүснэгт 12. ТУЗ-ийн дарга Ө. Ганзориг ........ 18
Хүснэгт 13. ТУЗ-ийн хараат гишүүн Н.Монсор ........ 18
Хүснэгт 14. ТУЗ-ийн хараат гишүүн О. Ганжолоо ........ 18
Хүснэгт 15. ТУЗ-ийн хараат гишүүн А. Амундра ........ 18
Хүснэгт 16. ТУЗ-ийн хараат бус гишүүн Жим Двайер ........ 19
Хүснэгт 17. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга ........ 19
Хүснэгт 18. Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг ........ 19
Хүснэгт 19. Үнэт цаас гаргагчийн даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн ........ 31

Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын суваг ....... 36
Хүснэгт 21. НХО-д эзлэх давхар даатгалын хураамжийн зардал ....... 38
Хүснэгт 22. Засгийн газрын ам.долларын бондын мэдээлэл ....... 56
Хүснэгт 23. ОУВС-ийн Өргөтсөн санхүүжилтийн хөтөлбөрийн нөхцөл ....... 57
Хүснэгт 24. Даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо ....... 60
Хүснэгт 25. Өрсөлдөгчдийн ерөнхий мэдээлэл ....... 65
Хүснэгт 26. Өрсөлдөгчдийн зах зээлд эзлэх байр суурь ....... 67
Хүснэгт 27. Үнэлгээний эцсийн үр дүн ....... 73
Хүснэгт 28. Санхүүгийн голлох үзүүлэлтүүд ....... 75
Хүснэгт 29. Орлогын тайлангийн төсөөлөл 2018-2022 ....... 75
Хүснэгт 30. Санхүү байдлын төсөөлөл 2018-2022 ....... 76
Хүснэгт 31. Хөрөнгийн үнэлгээний үр дүнгийн нэгтгэл ....... 83
Хүснэгт 32. Үнэлгээний эцсийн үр дүн ....... 83
Хүснэгт 33. Үнэлгээний үр дүнгүүдийн харьцуулалт ....... 84
Хүснэгт 34. Мөнгөн урсгалын төсөөлөл ....... 85
Хүснэгт 35. Үнэ цэнийн тооцоолол ....... 85
Хүснэгт 36. Жишиг компанийн аргаар тооцсон үнэлгээний үр дүн ....... 86
Хүснэгт 37. Жишиг арилжааны аргаар тооцсон үнэлгээний үр дүн ....... 86

## ЗУРАГ

Зураг 1. Голомт Файнэншил Групп ХХК-ийн холбоотой талууд ....... 11
Зураг 2. Юу Эм Си Холдинг ХХК-ийн холбоотой талууд ....... 13
Зураг 3. Үнэт цаас гаргагчийн бүтэц ....... 14
Зураг 4. Давхар даатгалын төрөл ....... 29
Зураг 5. Давхар даатгалын шинэчлэгдсэн нөхцөл ....... 37

СЗХ
он сар өдөр
2018.08.29
БҮРТГЭВ

# НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
он сар өдөр
01

| | |
|---|---|
| Ам.доллар | Америкийн Нэгдсэн Улсын мөнгөн тэмдэгт |
| ААН | Аж ахуйн нэгж |
| АТТ | Арилжааны Төлбөр Тооцоо ХХК |
| ББӨ | Борлуулсан барааны өртөг |
| БДК | Брокер, дилерийн компани |
| ДД | Давхар даатгал |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| МБТХНС | Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан |
| МХБ | Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК |
| НДШ | Нийгмийн даатгалын шимтгэл |
| НЖДӨ | Нийлмэл жилийн дундаж өсөлт |
| НХО | Нийт хураамжийн орлого |
| НӨАТ | Нэмэгдсэн өртгийн албан татвар |
| ОУВС | Олон Улсын Валютын Сан |
| ОТХ | Орлогод тооцсон хураамж |
| ОТХН | Орлогод тооцоогүй хураамжийн нөөц |
| СЗХ | Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо |
| Төгрөг (₮) | Монгол Улсын мөнгөн тэмдэгт |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| УБ | Улаанбаатар хот |
| УБЕГ | Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар |
| УБНХНС | Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан |
| УБХНС | Учирч болзошгүй хохирлын нөөц сан |
| ҮЦЗЗТХ | Үнэт цаасны зах зээлийн тухай хууль |
| ҮЦТХТ | Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК |
| ҮЦК | Үнэт цаасны компани |
| ХК | Хувьцаат Компани |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХОМК | Хөрөнгө оруулалтын менежментийн компани |
| ХЭХ | Хувьцаа эзэмшигчдийн хурал |

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС

2018 .08. 29 № 01

# ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУДЫН МЭДЭЭЛЭЛ

## АНДЕРРАЙТЕР:

| | |
|---|---|
| Компанийн нэр: | Голомт Капитал ҮЦК ХХК |
| Регистрийн дугаар: | 5481589 |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот 210464, Сүхбаатар дүүрэг, Олимпийн гудамж 12/1, Очир төв, 401 тоот |
| Утас: | +976-70121530 |
| И-мейл: | info@golomtcapital.com |

## АУДИТОР:

| | |
|---|---|
| Компанийн нэр: | Улаанбаатар Аудит Корпораци ХХК |
| Регистрийн дугаар: | 2577542 |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Их тойруу, Маргад центр |
| Утас: | +976-70110744 |
| Факс: | +976-70110722 |
| И-мейл: | info@mn.gt.com |

## ХУУЛЬ:

| | |
|---|---|
| Компанийн нэр: | Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН |
| Регистрийн дугаар: | 5722292 |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-8, Монгол ТВ цамхаг, 10 давхар, 1001-1003 тоот |
| Утас: | +976-77119008 |
| Факс: | +976-77119008 |
| И-мейл: | contact@bnp.mn |

## ҮНЭЛГЭЭ:

| | |
|---|---|
| Компанийн нэр: | БДО Аудит ХХК |
| Регистрийн дугаар: | 2546442 |
| Хаяг: | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-гийн гудамж, Нарны зам-62, Юнион Бюлдинг, В блок, 15-р давхар, 1502 тоот |
| Утас: | +976-77404040; +976-77404041 |
| Факс: | +976-77451150 |
| И-мейл: | info@bdo.mn |



Огноо: 2018/04/16

# 1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

## 1.1. Үнэт цаас гаргагчийн хаяг, байршил

| | |
|---|---|
| Нэр: | *"Мандал Даатгал" ХХК* |
| Хаяг: | *Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Нарны зам 87, НСКБ барилга, 4 давхар* |
| Утас: | *+976-70117017* |
| Факс: | *+976-70117017* |
| И-мейл: | *info@mandal.mn* |
| Веб хуудас: | *www.mandal.mn* |

## 1.2. Үнэт цаас гаргагчийн хуулийн этгээдийн бүртгэл

| | |
|---|---|
| Байгуулагдсан огноо: | *2011 он* |
| УБЕГ-т бүртгэгдсэн огноо: | *2011 оны 04 сарын 26 өдөр* |
| Улсын бүртгэлийн дугаар: | *9017001021* |
| Регистрийн дугаар: | *5473489* |
| Тусгай зөвшөөрөл олгогдсон огноо: | *2011 оны 06 сарын 02* |
| Тусгай зөвшөөрлийн тогтоол: | *№ 146* |
| Үйл ажиллагааны үндсэн чиглэл: | *Ердийн даатгалын үйл ажиллагаа* |

## 1.3. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчид

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт 25,000,000 ширхэг энгийн хувьцаа зарласан ба үүнээс нэг бүр нь 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6,243,016 ширхэг хувьцааг гаргаснаас 1,243,016 ширхэг хувьцааг халаасалсан байна.

Энэхүү танилцуулгыг бэлтгэх үед, үнэт цаас гаргагч нь нийт 5.0 тэрбум төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй ба дараах хувь хэмжээгээр нэр заасан хуулийн этгээдүүд эзэмшиж байна.

*Хүснэгт 1. Үнэт цаас гаргагчийн эзэмшил*

| Нэр | РД | Хаяг | Хувьцааны тоо, ширхэг | Эзэмшлийн хувь | Нэрлэсэн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|
| *"Голомт Файнэншил Групп" ХХК* | *5845742* | *СБД, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Голомт хотхон, А66 тоот* | *2,550,000* | *51%* | *1,000* | *2,550,000,000* |
| *"Юу Эм Си Капитал"ХХК* | *5434815* | *ХУД, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 66-2* | *2,450,000* | *49%* | *1,000* | *2,450,000,000* |
| ***Нийт*** | | | ***5,000,000*** | ***100%*** | | ***5,000,000,000*** |

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 болон 6.3 дах заалтуудын дагуу Үнэт цаас гаргагчийн 51%-ийг эзэмшиж буй "Голомт Файнэншил Групп" ХХК нь Үнэт цаас гаргагчийн толгой компани бөгөөд, Үнэт цаас гаргагчийн гаргасан хувьцааны 49%-ийг "Юу Эм Си Капитал" ХХК эзэмшиж буй учир "Юу Эм Си Капитал" ХХК-ийн хараат компани болж байна.

Үнэт цаас гаргагч нь өөрийн гаргасан хувьцаанаас 1,243,016 ширхэг хувьцааг 2014 оны 10 сарын 21-ний өдөр эргүүлэн худалдан авч халаасалсан байна. Компанийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.7 болон 33.8 дахь хэсэгт заасны дагуу уг хувьцаа нь зарласан боловч гаргаагүй хувьцаа гэж тооцогдох бөгөөд компани нь энэ хувьцааг дахин гаргаж болно.

СЗХ-ны "Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай" тогтоолыг Хавсралт 6.3-аас харна уу.

*Хүснэгт 2. Үнэт цаас гаргагчийн халаасны хувьцааны мэдээлэл*

| Нэр | РД | Хаяг | Хувьцааны тоо, ширхэг | Нэрлэсэн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| *"Мандал Даатгал" ХХК* | *5473489* | *Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Нарны зам 87, НСКБ барилга, 4 давхар* | *1,243,016* | *1,000* | *1,243,016,000* |

*Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.7, 33.8 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.4 дэх заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7. (а), 6.7 (б) хэсэг, 7 дугаар зүйлийн 7.9.4, 7.9.5, 7.9.6 дахь заалтууд, 2018 оны 02 сарын 12-ны өдрийн 18/004 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол, 2018 оны 02 сарын 15-ны өдрийн 18/002 тоот ТУЗ-ийн тогтоолыг тус тус үндэслэн эргүүлэн худалдан авч халаасалсан буюу зарласан хувьцаанаас 1,243,016 ширхэг хувьцаа, хувьцаа эзэмшигч "Юу Эм Си Капитал" ХХК-ийн эзэмшлийн 317,738 ширхэг хувьцаа, нийт 1,560,754 ширхэг энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-иар дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгохоор шийдвэрлэсэн байна.*

МХБ-ээр дамжуулан нийт 1,560,754 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгосны дараах эзэмшлийг дараах хүснэгтээр харууллаа.

*Хүснэгт 3. Олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгосны дараах эзэмшил*

| Нэр | Олон нийтэд хувьцаа санал болгосноос өмнөх хувьцааны тоо | Олон нийтэд хувьцаа санал болгосноос өмнөх эзэмшлийн хувь | Олон нийтэд хувьцаа санал болгосны дараах хувьцааны тоо | Олон нийтэд хувьцаа санал болгосны дараах эзэмшлийн хувь |
|---|---|---|---|---|
| *"Голомт Файнэншил Групп" ХХК* | *2,550,000* | *51%* | *2,550,000* | *40.85%* |
| *"Юу Эм Си Капитал"ХХК* | *2,450,000* | *49%* | *2,132,262* | *34.15%* |
| *"Мандал Даатгал" ХХК* | *(1,243,016)* | *-* | *-* | |
| ***Бусад эзэмшигчид*** | | *-* | *1,560,754* | *25.00%* |
| ***Нийт*** | ***5,000,000*** | ***100%*** | ***6,243,016*** | ***100.00%*** |

Үнэт цаас гаргагч олон нийтэд нээлттэй хүрээнд хувьцаа санал болгосны дараа, "Голомт Файнэншил Групп" ХХК нь толгой компани бус хараат компани болох бол "Юу Эм Си Капитал" ХХК нь хараат компани хэвээр байна.

## 1.4. Үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдийн мэдээлэл

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 болон 6.3 дахь заалтуудын дагуу одоогийн байдлаар "Голомт Файнэншил Групп" ХХК нь Үнэт цаас гаргагчийн толгой компани, "Юу Эм Си Капитал" ХХК нь Үнэт цаас гаргагчийн хараат компани юм. Иймд, үнэт цаас гаргагчийн холбоотой этгээдүүд нь эдгээр хуулийн этгээдүүдтэй холбоотой этгээд байна.

### 1.4.1. Голомт Файнэншил Групп ХХК

"Голомт Файнэншил Групп" ХХК нь Үнэт цаас гаргагчийн 51%-ийг эзэмшиж буй хуулийн этгээд ба банк санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулахаар 2015 онд үүсгэн байгуулагдсан холдинг компани юм. "Голомт Файнэншил Групп" ХХК нь Голомт Банк, "Голомт Лизинг" ХХК болон "Голомт Ассет Менежмент ХОМК" ХХК-ийн толгой компани буюу эдгээр хуулийн этгээдүүд нь Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компаниуд юм. Голомт Банк нь "Голомт Капитал ҮЦК" ХХК-ийн 100%-ийн хувьцаа эзэмшигч байна.

"Голомт Файнэншил Групп" ХХК-ийн бүтцийг дараах зураглалаар харуулж байна.

*Зураг 1. Голомт Файнэншил Групп ХХК-ийн холбоотой талууд*




*Хүснэгт 4. Голомт Файнэншил Групп ХХК-ийн холбоотой талуудын товч мэдээлэл*

| № | Нэр | РД: | Үүсгэн байгуулагдсан он | Үйл ажиллагаа |
|---|---|---|---|---|
| 1 | Голомт Банк | 2075377 | 1995 | Арилжааны банк |
| 2 | Голомт Капитал ҮЦК ХХК | 5481589 | 2011 | Брокер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтер |
| 3 | Голомт Лизинг ХХК | 5980755 | 2015 | Санхүүгийн түрээсийн үйлчилгээ |
| 4 | Голомт Ассет Менежмент ХОМК ХХК | 6011888 | 2015 | Хөрөнгө оруулалтын менежментийн компани |

**Голомт Банк** нь 1995 онд үүсгэн байгуулагдсан ба дотоодын банкны секторын Топ-3 банкуудын нэг юм. Тус банк нь нийт 112 салбар, тооцооны төв, өөртөө үйлчлэх цэгтэй ба хөдөлмөрийн зах зээлд нийт 1,800 гаруй ажлын байрыг бий болгосон байна. 2017 оны 3-р улирлын байдлаар тус

банк нь нийт банкны секторын 18%-ийг нийт активаар, 16%-ийг нийт зээлээр, 23%-ийг нийт харилцах, хадгаламжаар бүрдүүлж байна. 2017 оны 3-р улирлын байдлаар тус банк нь 3.2 их наяд төгрөгийн хадгаламж, 2.1 их наяд төгрөгийн зээлийн багцтай ажилласан ба энэ нь өмнөх оны мөн үеэс тус тус 24.5%, 8.6% өссөн үзүүлэлт юм.

*Хүснэгт 5. Топ-3 банкны нийт*




*Хүснэгт 6. Топ-3 банкны зээл*




*Хүснэгт 7. Топ-3 банкны*




*Эх сурвалж: Монголын Банкны Холбоо*

***Голомт Капитал ҮЦК ХХК*** нь 2011 онд Голомт Банкны 100%-ийн хөрөнгө оруулалттай охин компани болж үүсгэн байгуулагдсан ба гадаад ба дотоодын биржүүдэд үнэт цаасны брокер, хөрөнгө оруулалтын зөвлөх, андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай байгууллага юм. 2017 онд тус компанийн арилжааны дүн 7.7 дахин өсөж 92.6 тэрбум төгрөг хүрсэн ба МХБ-ийн нийт арилжааны 8.5%-ийг бүрдүүлж, нийт 58 үнэт цаасны компаниас 4-т орсон байна. Ашигт ажиллагаагаар 3-т оржээ.

*Граф 2. Арилжааны дүн, 2012-2017*




*Граф 1. Ашигт ажиллагаа 2012-2017*




*сая төгрөгөөр*

***Голомт Лизинг ХХК*** нь 2015 оны 06 сарын 26-ны өдөр үүсгэн байгуулагдсан ба санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхэлж буй компани юм.

***Голомт Ассет Менежмент ХОМК*** нь СЗХ-ны 2015 оны 11 сарын 23-ны өдрийн 402 тоот тогтоолын дагуу үйл ажиллагаа явуулж буй хөрөнгө оруулалтын менежментийн компани юм.

## 1.4.2. Юу Эм Си Капитал ХХК

“Юу Эм Си Капитал” ХХК нь Үнэт цаас гаргагчийн гаргасан энийн хувьцааны 49%-ийг эзэмшиж буй хуулийн этгээд ба “Юу Эм Си Холдинг“ ХХК-ийн охин компани юм. “Юу Эм Си Холдинг” ХХК нь “Юу Эм Си Капитал” ХХК-ийн 80%-ийг эзэмшдэг ба үлдсэн 20%-ийг Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал Б. Жавхлан (10%), Ерөнхийлөгч М. Баярбахдал (10%) нар эзэмшдэг байна. “Юу Эм Си Холдинг” ХХК нь “Юу Эм Си Альфа” ХХК, “Орхон Деко” ХХК болон “Эн Пи Си энд Мандал” ХХК-ийн 100%-ийг эзэмшдэг буюу эдгээр хуулийн этгээдүүд нь Үнэт цаас гаргагчийн зэргэлдээ компани юм. Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч “Юу Эм Си Капитал” ХХК нь нийт 12 холбоотой талуудтай ба түлхүү үл хөдлөх хөрөнгө, бизнесийн консалтингийн үйл ажиллагаа эрхэлж байна.

*Зураг 2. Юу Эм Си Холдинг ХХК-ийн холбоотой талууд*




*Хүснэгт 8. Юу Эм Си Холдинг ХХК-ийн холбоотой талуудын товч мэдээлэл*

| № | Нэр | РД: | Үүсгэн байгуулагдсан он | Үйл ажиллагаа |
|---|---|---|---|---|
| 1 | Юу Эм Си Капитал ХХК | 5434815 | 2010 | Санхүүгийн үйлчилгээ, консалтинг |
| 2 | Мандал Лайф ХХК | 5573289 | 2012 | Зөвлөх үйлчилгээ |
| 3 | Юу Эм Си Алфа ХХК | 5366895 | 2010 | УХХ удирдлага, зөвлөх |
| 4 | Орхон Деко ХХК | 5396921 | 2010 | Гадаад худалдаа, Мебель модон эдлэлийн үйлдвэрлэл, худалдаа |
| 5 | Эн Пи Си энд Мандал ХХК | 5723809 | 2013 | Хүний нөөцийн удирдлага |
| 6 | Анхны хос ХХК | 5497418 | 2011 | Консалтинг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | Экүити Партнерс ХХК | 5620686 | 2012 | Консалтинг |
| 8 | Блю Базаар ХХК | 5785952 | 2014 | УХХ түрээс, гадаад худалдаа |
| 9 | Альфа Консалтинг Партнерс ХХК | 5998824 | 2015 | УХХ зөвлөх, судалгаа |
| 10 | Альфа Аппс ХХК | 6065791 | 2016 | Програм хангамжийн үйлчилгээ, Үл хөдлөх хөрөнгийн судалгаа |
| 11 | Маркет Плейс Менежмент ХХК | 5642019 | 2012 | Үл хөдлөх хөрөнгийн түрээс |
| 12 | Маркет Плейс ХХК | 5630061 | 2012 | УХХ түрээс, гадаад худалдаа |
| 13 | Эйч Кю Констракшин ХХК | 5434815 | 2010 | Барилгын засвар, засал чимэглэл |

## 1.5. Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт

Компанийн тухай хуулийн 59.1 дүгээр заалт, компанийн дүрмийн 6.1-т зааснаар компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа Эзэмшигчдийн Хурал (ХЭХ) байх ба ХЭХ-ын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь 4 хараат, 1 хараат бус гишүүнтэй байх ба Аудит, Эрсдэлийн болон Гүйцэтгэл үнэлгээний хороотой байна. ТУЗ-ийн томилсон гүйцэтгэх удирдлага нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана. Үнэт цаас гаргагч нь 2018 оны 01 сарын 05-ны өдрийн HR/18/003 тоот Гүйцэтгэх захирлын тушаалаар бүтэц, зохион байгуулалтыг 5 хэлтэс, 6 албатай болгож өөрчилсөн байна.

*Зураг 3. Үнэт цаас гаргагчийн бүтэц*



## Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн эрх барих дээд байгууллага нь ХЭХ байх ба ХЭХ нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна. ХЭХ-ыг санхүүгийн жил дууссанаас 4 сарын дотор буюу 05 сарын 01-ний өдрийн дотор ТУЗ зарлан хуралдуулах эсвэл ТУЗ, хувьцаа эзэмшигчийн санаачлалаар ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна.

## Төлөөлөн удирдах зөвлөл

ХЭХ-ын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь 4 хараат, 1 хараат бус гишүүнтэй байх ба Аудит, Эрсдэлийн болон Гүйцэтгэл үнэлгээний хороодтой байна. ТУЗ-ийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.

## Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод

**Аудит, эрсдэлийн хороо**

Аудитын хорооны дарга нь санхүү, бүртгэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна. Аудит, эрсдэлийн хороо нь Компанийн дотоод журам, тушаалын хэрэгжилт, биелэлтэд хяналт тавих, хууль эрх зүйн гол эрсдэлүүдийг тодорхойлох, хянах, компанийн дотоод аудит нэгж болон хөндлөнгийн аудитын байгууллагын хоорондын харилцааг зохицуулах, компанийн санхүүгийн мэдээллийн үнэн зөв, ил тод байдал, бүрэн бүтэн байдлыг шалгаж батлах, ТУЗ-д мэдээллэх, компанийн дотоод хяналтын системд хяналт тавих, дотоод аудитын үйл ажиллагааг зохион байгуулж удирдлагаар хангах, сайжруулах, боловсронгуй болгох, компанийн эрсдэлийн удирдлагын стратеги, бодлоготой танилцаж, хэлэлцэж, батлах, даатгалын тухайлсан нэг гэрээнүүдтэй танилцах, шаардлагатай тохиолдолд давхар даатгагч руу шилжүүлэхийг гүйцэтгэх удирдлагад үүрэг болгох, нийт хүлээгдэж буй хариуцлага, түүнд харгалзах нөөцийн сан, эрсдэл даах чадварын шинжилгээтэй улирал бүр танилцах, зөрчил илэрсэн тохиолдолд засуулах арга хэмжээ авах үүрэгтэй бөгөөд зөрчил гаргасан албан тушаалтантай компанийн Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага тооцох эрхтэй юм.

**Гүйцэтгэлийн үнэлгээний хороо**

Гүйцэтгэлийн үнэлгээний хороо нь зөвлөлийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, компанийн болон гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг хянах, гүйцэтгэлд суурилсан цалин урамшууллын асуудлыг зохицуулах бодлогыг боловсруулахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй байна.

*Хүснэгт 9. ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд*

| № | Хороо | Гишүүдийн тоо | Гишүүд | Албан тушаал |
|---|---|---|---|---|
| 1 | Аудит, Эрсдэлийн хороо | 3 | О.Ганжолоо<br>Жим Драйер<br>Н. Монсор | Хорооны дарга<br>Гишүүн<br>Гишүүн |
| 2 | Гүйцэтгэлийн үнэлгээний хороо | 3 | Жим Двайер<br>Ө.Ганзориг<br>О.Ганжолоо | Хорооны дарга<br>Гишүүн<br>Гишүүн |

## Гүйцэтгэх захирал

ТУЗ-ийн томилсон гүйцэтгэх удирдлага нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасан компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө.

СЗХ
2018 .08. 29
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

## Хүний нөөц

Үнэт цаас гаргагч нь хүний нөөцийн уян хатан, оновчтой стратеги, бодлогыг хэрэгжүүлэн ажиллахыг эрхэмлэдэг ба ажилчдаа бүх талаар нь хөгжүүлж, зах зээлд өрсөлдөхүйц цалин урамшуулал олгоход анхааран ажилладаг. Үнэт цаас гаргагч нь 2018 оны 01 сарын 05-ны өдрийн байдлаар нийт 108 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилласан бөгөөд хэлтэс тус бүрээр ангилбал дараах байдалтай байна:

*Хүснэгт 10. Ажилтны тоо*

| № | Алба | Ажилчдын тоо |
|---|---|---|
| 1. | Удирдлага | 2 |
| 2. | Байгууллагын даатгалын хэлтэс | 19 |
| 3. | Иргэдийн даатгалын хэлтэс | 63 |
| 4. | Даатгалын бодлогын хэлтэс | 5 |
| 5. | Санхүү бүртгэлийн хэлтэс | 5 |
| 6. | Захиргааны хэлтэс | 8 |
| 7. | Маркетингийн алба | 1 |
| 8. | Эрсдэлийн алба | 5 |
| | **Нийт** | **108** |

## Хэлтэсийн үйл ажиллагааны үндсэн чиглэл

### Байгууллагын даатгал хэлтэс

Байгууллагын даатгалын хэлтэс нь аж ахуйн нэгж, албан байгууллагад зориулсан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлж зах зээлд борлуулах, борлуулалтын дараах үйлчилгээ болон нөхөн төлбөрийн үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг.

Тус хэлтэс нь даатгалын борлуулалтын алба, харилцагчийн халамжийн алба гэсэн 2 албатай. Даатгалын борлуулалтын алба нь байгууллагуудад даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээгээ танилцуулж борлуулах үүрэг бүхий даатгалын менежерүүдээс бүрддэг. Харилцагчийн халамжийн алба нь даатгуулагчдад эрсдэлийн талаарх сургалт орох, даатгуулагчийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн ажлуудыг хэрэгжүүлэх, нөхөн төлбөрийн тохиолдлыг бүртгэж баримтжуулан тооцоолол хийх, даатгуулагчдад мэдээлэл хүргэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

### Иргэдийн даатгалын хэлтэс

Иргэдийн даатгалын хэлтэс нь хувь хүмүүст зориулсан даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, зах зээлд борлуулах, борлуулалтын дараах үйлчилгээ болон нөхөн төлбөрийн үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг.

Иргэдийн даатгалын хэлтэс нь даатгалын борлуулалтын алба, нөхөн төлбөр, үйлчилгээний алба гэсэн 2 албатай. Даатгалын борлуулалтын алба нь даатгуулагчтай шууд гэрээ байгуулдаг шууд борлуулалтын баг болон банк, брокер гэх мэт даатгалын зуучлагчдаар дамжуулан даатгал борлуулдаг сувгийн борлуулалтын багтай. Нөхөн төлбөр, үйлчилгээний алба нь нөхөн төлбөр, үйлчилгээ, шуурхай дуудлагын нэгжүүдтэй бөгөөд даатгалын тохиолдлыг бүртгэж баримтжуулах, нөхөн төлбөрийн тооцоолол хийх, даатгуулагчдад мэдээлэл хүргэх, лавлагаа, санал хүсэлтийг бүртгэн авч шийдвэрлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг.

### Даатгалын бодлогын хэлтэс

Даатгалын бодлогын хэлтэс нь компанийн үндсэн бүтээгдэхүүн болох даатгалын гэрээний андеррайтингийн нөхцөл боловсруулж, суурь үнийг тооцоолох чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус хэлтэст андеррайтер, актуарч, давхар даатгалын мэргэжилтэн зэрэг албан тушаалтнууд харьяалагддаг бөгөөд даатгалын багцын эрсдэлийн бодлогыг мөн хариуцан ажилладаг.

МОНГОЛ УЛС

**Санхүү бүртгэлийн хэлтэс**

Санхүү бүртгэлийн хэлтэс нь компанийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагааг гүйцэтгэж, санхүүгийн тайлан гаргах үндсэн үүрэгтэй. Мөн компанийн жилийн төсөв, төлөвлөгөөг боловсруулж, гүйцэтгэлийг хянах, мөнгөн хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлж, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх функцийг хэрэгжүүлдэг.

**Захиргааны хэлтэс**

Захиргааны хэлтэст мэдээллийн технологи, хүний нөөц, хууль, үйл ажиллагааны эрсдэлийн функцүүд хамаардаг бөгөөд даатгалын борлуулалт, нөхөн төлбөрийн үйлчилгээ зэрэг үндсэн үйл ажиллагааг дэмжиж, компанийн өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангах үүргийг хэрэгжүүлдэг.

## 1.6. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл

Компанийн тухай хуулийн 84.1 дэх заалтад "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж заасны дагуу үнэт цаас гаргагч нь дараах эрх бүхий албан тушаалтнуудтай үйл ажиллагаа явуулж байна.

Үнэт цаас гаргагч нь 2018 оны 03 сарын 31-ний байдлаар дараах бүрэлдэхүүн бүхий ТУЗ-тай үйл ажиллагаа явуулж байна. 2018 оны 02 сарын 23-ны өдрийн 18/001 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолоор Л.Болормаа-г ТУЗ-ийн хараат гишүүнээс чөлөөлж А.Амундра-г томилсон байна. СЗХ-ны 2015 оны 407 тоот тогтоолоор батлагдсан "Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам"-ын 5.4.4-т заасны дагуу Үнэт цаас гаргагч нь 2018 оны 03 сарын 19-ний өдөр СЗХ-д ТУЗ-д өөрчлөлт оруулах зөвшөөрөл авахаар хүсэлт явуулсан ба энэхүү танилцуулгыг бэлтгэх үед зөвшөөрөл хараахан гараагүй байна.

*Хүснэгт 11. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн мэдээлэл*

| № | Овог нэр | Албан тушаал | Эрхэлдэг ажил | Компанийн засаглалын гэрчилгээ авсан эсэх |
|---|---|---|---|---|
| 1 | Ө.Ганзориг | ТУЗ-н дарга | Голомт Банк Гүйцэтгэх захирал | Авсан |
| 2 | А.Амундра | ТУЗ-н хараат гишүүн | Бодь Интернэшнл ХХК Гүйцэтгэх захирал | Авсан |
| 3 | О.Ганжолоо | ТУЗ-н хараат гишүүн | Голомт файнэншил групп ХХК Гүйцэтгэх захирал | Авсан |
| 4 | Н.Монсор | ТУЗ-н хараат гишүүн | Юу Эм Си Альфа ХХК Гүйцэтгэх захирал | Авсан |
| 5 | Жим Двайер | ТУЗ-н хараат бус гишүүн | Mongolian Private Capital ХХК Дарга | Авсан |
| 6 | З. Одмаа | ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | Мандал Даатгал ХХК ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | Авсан |

Хүснэгт 12. ТУЗ-ийн дарга Ө. Ганзориг

| Овог нэр | Ө. Ганзориг |
|---|---|
| Мэргэжил | Эдийн засагч |
| Боловсрол | 2006-2007: Санхүүгийн удирдлага, Маастрихтын Менежментийн Их Сургууль<br>1998-2002 : Нягтлан бодох бүртгэл , Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль |
| Ажилласан туршлага | 2016-одоог хүртэл: Гүйцэтгэх захирал, Голомт Банк<br>2015-2016: Ерөнхийлөгч, Голомт Банк<br>2011-2015: Ерөнхий захирал, Үүсгэн байгуулагч, Мандал Даатгал ХХК<br>2008-2011: Гүйцэтгэх захирал, Тэнгэр Даатгал<br>2006-2008 : Дэд захирал, Улаанбаатар Хотын банк<br>2002-2006 : Дилер, Худалдаа Хөгжлийн банк<br>2001-2002 : Хянагч нябо, TACIS |

Хүснэгт 13. ТУЗ-ийн хараат гишүүн Н.Монсор

| Овог нэр | Н. Монсор |
|---|---|
| Мэргэжил | Компьютерийн шинжлэх ухаан |
| Боловсрол | 2001-2005 : Компьютер программ хангамж, ШУТИС |
| Ажилласан туршлага | 2014-одоог хүртэл: Гүйцэтгэх захирал, Бльюбазаар ХХК<br>2013-одоог хүртэл: Гүйцэтгэх захирал, Маркетплейс ХХК<br>2011-одоог хүртэл: Гүйцэтгэх захирал, Юу Эм Си Альфа ХХК<br>2007-2010: Мэдээллийн ажилтан, АНУ-ын элчин сайдын яам<br>2005-2006: Мэдээллийн ажилтан, Дэлхийн Зөн ОУБ |

Хүснэгт 14. ТУЗ-ийн хараат гишүүн О. Ганжолоо

| Овог нэр | О. Ганжолоо |
|---|---|
| Мэргэжил | Эдийн засагч |
| Боловсрол | 1997-2002 : Эдийн засагч, ХБНГУ-ын Берлин хотын Чөлөөт Их Сургууль |
| Ажилласан туршлага | 2014- одоог хүртэл: Гүйцэтгэх захирал, Голомт файнэншил групп ХХК<br>2011-2017 : Санхүү удирдлагын газрын захирал, Бодь Интернэшнл ХХК |

Хүснэгт 15. ТУЗ-ийн хараат гишүүн А. Амундра

| Овог нэр | А. Амундра |
|---|---|
| Боловсрол | 1993-2003 : Бүрэн дунд 1-р сургууль |
| Ажилласан туршлага | 2017-одоог хүртэл : Гүйцэтгэх захирал, Бодь Интернэшнл ХХК<br>2009-2017: Гүйцэтгэх захирал, Монгол масс медиа ХХК<br>2011-2012: Гүйцэтгэх захирал, Ийглбродкастинг ХХК<br>2009-2011: Гүйцэтгэх захирал, Боловсрол суваг телевиз ХХК |

Хүснэгт 16. ТУЗ-ийн хараат бус гишүүн Жим Двайер

| Овог нэр | Жим Двайер |
|---|---|
| Боловсрол | 1968-1970: Бизнесийн удирдлагын магистр, Columbia Graduate School of Business<br>1961-1965: Бизнесийн удирдлагын бакалавр, University of Notre Dame |
| Ажилласан туршлага | 2017-одоог хүртэл: Дарга, Mongolian Private Capital ХХК<br>2007-2016: Дарга Монголын Бизнес Зөвлөл<br>2008-2012 : Үйл ажиллагаа хариуцсан захирал, QGX Mongol ХХК<br>2003-2007 : Үйл ажиллагаа хариуцсан захирал, NAMBC-Mongolia<br>2001-2003: Хөрөнгө оруулалтын банкны зөвлөх, Bearing Point (KPMG консалтинг) |

Хүснэгт 17. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

| Овог нэр | З. Одмаа |
|---|---|
| Боловсрол | 2006-2010: Маркетингийн удирдлага, ШУТИС, КТМС |
| Ажилласан туршлага | 2011-одоог хүртэл: Маркетингийн менежер, Мандал Даатгал<br>2010-2011: Маркетингийн мэргэжилтэн, Тэнгэр Даатгал |

## 1.6.1. Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг

2018 оны 03 сарын 31-ны өдрийн байдлаар дараах удирдлагын багтай үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 18. Үнэт цаас гаргагчийн удирдлагын баг

| № | Овог нэр | Албан тушаал | Мэргэжил |
|---|---|---|---|
| 1 | Б. Жавхлан | Гүйцэтгэх захирал | Мэдээлэл технологи |
| 2 | М. Баярбахдал | Ерөнхийлөгч | Бизнесийн удирдлага |
| 3 | Г. Баярцэцэг | Ерөнхий нягтлан бодогч | Нягтлан бодогч |
| 4 | Д. Нямрагчаа | Иргэдийн даатгал хариуцсан дэд ерөнхийлөгч | Мэдээлэл технологи |
| 5 | Ж. Гарваа | Байгууллагын даатгал хариуцсан дэд ерөнхийлөгч | Бизнесийн удирдлага |
| 6 | Ч. Баттүшиг | Актуарч | Математик |

**Б. Жавхлан, Гүйцэтгэх захирал**

Б. Жавхлан нь Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирлын албан тушаалыг 2016 оны 10 сараас эхлэн одоог хүртэл хашиж байгаа бөгөөд өмнө нь үнэт цаас гаргагчийн иргэдийн даатгалын газар, бизнес хөгжил болон эрсдэлийн удирдлагын газрыг хариуцан ажиллаж байсан. Тэрээр даатгалын салбарт 8 жил ажилласан туршлагатайгаас гадна Мэдээлэл технологийн салбарт 2000 оноос хойш ажилласан байна. Өнгөрсөн хугацаанд хэд хэдэн мэдээлэл технологийн амжилттай шийдлүүдийг боловсруулж гаргасан ба Япон улсын Токио хотод Мэдээлэл технологийн Төслийн удирдагчаар таван жил ажилласан. Б. Жавхлан нь Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийг Компьютерийн ухааны бакалавр зэрэгтэй дүүргэсэн.

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ 2018.08.29
№ 01

### М. Баярбахдал, Ерөнхийлөгч

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

М.Баярбахдал нь маркетинг, уул уурхайн хайгуулын бизнес хөгжил болон мэдээлэл, харилцаа холбооны технологийн салбарт ажиллаж байсан туршлагатай. QGX ХХК-д үйл ажиллагаа хариуцсан захирлаар ажиллаж байсан бөгөөд ажиллах хугацаандаа нүүрс, алт, зэсийн томоохон төслүүдийг хөгжүүлэх ажлыг хийсэн. Мөн MCS Электроникс болон Юнител ХХК-ийн маркетингийн албыг удирдаж байсан туршлагатай. Баярбахдал нь бизнесийн удирдлагын бакалавр болон АНУ-ын SUNY New Platz Их сургуулийн Бизнесийн Удирдлагын магистр зэрэгтэй.

### Г. Баярцэцэг, Ерөнхий нягтлан бодогч

Г.Баярцэцэг нь Үнэт цаас гаргагчид 2013 оноос хойш ажиллаж байна. Тэрээр нийтийн хоол, худалдаа үйлдвэрлэлийн салбарт 2 жил, иргэний нисэхийн салбарт 4 жил, ердийн даатгалын салбарт 5 орчим жил, нийт 10 гаруй жилийн ажлын туршлагатай. Өнгөрсөн хугацаанд ажиллаж буй байгууллагууддаа санхүүгийн үр ашгийг сайжруулах тухай төслийн багт ажиллаж, тодорхой шийдлүүдийг амжилттай боловсруулж, нэвтрүүлж байсан туршлагатай. Г.Баярцэцэг нь "Мандах бүртгэл" дээд сургуулийн Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй, Удирдлагын мэргэшсэн нягтлан бодогч цолтой.

### Д. Нямрагчаа, Иргэдийн даатгал хариуцсан дэд ерөнхийлөгч

Д.Нямрагчаа нь мэдээлэл технологийн чиглэлээр 6 жил, даатгалын чиглэлээр 6 жил ажилласан туршлагатай. Тэрээр өмнө нь УБДС ТӨХК- д инженерээр ажиллаж байсан бөгөөд 2012 оноос хойш Мандал Даатгал ХХК-д мэргэжилтнээс дэд ерөнхийлөгч хүртэл албан тушаалд ажиллаж байна. Д.Нямрагчаа нь Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийг Компьютерийн ухааны бакалавр зэрэгтэй.

### Ж. Гарваа, Байгууллагын даатгал хариуцсан дэд ерөнхийлөгч

Ж.Гарваа нь байгууллагын даатгалын бизнес хөгжлийн алба, борлуулалтын алба, харилцагчийн халамж, нөхөн төлбөрийн албуудыг тус тус хариуцан ажиллаж байна. Тэрээр даатгалын салбарт 6 жил ажилласан туршлагатайгаас гадна MCS-АРВ ХХК болон Мон Сүү ХХК-уудад маркетингийн чиглэлээр ажиллаж байсан.

### Ч. Баттүшиг, Актуарч

Ч. Баттүшиг нь 2013 оноос одоог хүртэл Үнэт цаас гаргагчид актуарчаар ажиллаж байгаа бөгөөд өмнө нь Изинис эйрвэйз ХХК-д өгөөжийн мэргэжилтэн, "Олонлог" бүрэн дунд боловсролын сургуульд математикийн багшаар ажиллаж байсан туршлагатай. Тэрээр 2004 онд МУИС-ийн МКС-ийг математикийн ухааны бакалаврын зэрэгтэй дүүргэсэн байна.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC

СЗХ
он сар өдөр
2018 .08. 29
БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
он .... сар .... өдөр
01

## 1.7. Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай

“Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс” ХХН нь 2014 оны 03 сарын 12 өдрийн СЗХ-ны 72 тоот тогтоолоор авсан “Үнэт цаасны зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх” тусгай зөвшөөрлийн хүрээнд 2018 оны 02 сарын 21-ний өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 18/020 тоот “Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ”-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгох үйл ажиллагаанд хуулийн зөвлөхийн үүргийг гүйцэтгэсэн.

Хуулийн дүгнэлтэд тусгаснаар, даатгалын үйлчилгээнд хамаарах гэрээ, хэлцлээс бусад гэрээ, хэлцлийг судлан үзэхэд Үнэт цаас гаргагч нь хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл байгуулаагүй байна.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
мандал даатгал
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC

СЗХ он сар өдөр 2018 08 29 № 69

## 1.8. Үнэт цаас гаргагчийн түүх

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...он ...сар ...өдөр

Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагдсан цагаас хойш өнөөг хүртэлх онцлох үйл явдал бүхий он цагийн товчоог дараах зураглалаар харуулав.

| | |
|---|---|
| 2011/06 | Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авч, үйл ажиллагаагаа эхлүүлэв. |
| 2011/09 | Монголд анх удаа даатгалын суурь системийг нэвтрүүлэв. |
| 2011/11 | Уламжлалт "Эрсдэлийн удирдлагын форум" арга хэмжээг зохион байгуулж эхлэв. |
| 2012/04 | Өмнөговь аймгийн Цогтцэций суманд салбар нээв. |
| 2012/09 | Хаан Банктай хамтран Монгол анх удаа даатгалын зуучлалын үйлчилгээг үзүүлж эхлэв. |
| 2012/11 | Харилцагч нарт зориулсан "Эрсдэлийн удирдлагын семинар"-г улирал бүр зохион байгуулж эхлэв. |
| 2012/12 | Banker Blanket Bond буюу банкны бүрэн баталгааг хийж эхлэв. |
| 2013/11 | Дархан-Уул аймаг, Дархан хотод даатгалын салбар шинээр нээв. |
| 2014/06 | Багцаа Treaty Whole Account даатгалаар давхар даатгуулж, эрсдэл даах чадвараараа салбартаа тэргүүлдэг болов |
| 2014/08 | Голомт Санхүүгийн Нэгдэлтэй хамтарч 100% Монголын хөрөнгө оруулалттай компани болов. |
| 2014/09 | Олон улсын стандартад нийцсэн "Сонголт" тээврийн хэрэгслийн багц даатгал нэвтрүүлэв. |
| 2015/01 | Хэрэглэгчийн үйлчилгээний албыг байгуулж, даатгалын лавлах үйлчилгээг нэвтрүүлэв. |
| 2015/08 | Монголын анхны ухаалаг гар утсанд зориулсан даатгалын бүтээгдэхүүнийг нэвтрүүлэв |
| 2015/10 | Дотоодын хувийн эрүүл мэндийн даатгал "Жаргалан"-г зах зээлд нэвтрүүлэв |
| 2015/10 | Эрдэнэт хотод салбар нээв. |
| 2016/06 | Бага насны хүүхдүүдийг эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилготой "Хонхтой ном"-ыг гаргаж нийслэлийн төрийн болон хувийн өмчит нийт 564 цэцэрлэгийн 2,690 бүлэгт хандивлав. |
| 2016/07 | "Жаргалан" эрүүл мэндийн даатгалын "Эх үрсийн багц"-ыг зах зээлд нэвтрүүлж, Гурван гал, Интермед эмнэлгүүдтэй хамтран жирэмсэн эхчүүдэд зориулсан сургалтуудыг зохион байгуулав. |
| 2017/09 | Монголд анх удаа шуурхай дуудлагын үйлчилгээнд Yamaha TRICITY скүүтэрийг ашигладаг болов. |

МАНДАЛ ДААТГАЛ ХХК МАНДАЛ даатгал УЛААНБААТАР ХОТ 5473489

МОНГОЛ УЛС GOLOMT CAPITAL LLC ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК



Огноо: 2018/04/16

Үнэт цаасны танилцуулга
он сар өдөр
2018.08.29

## 1.9. Үнэт цаас гаргагчийн ололт, амжилтууд

| | Шагнал | Он |
|---|---|---|
| BUSINESS COUNCIL OF MONGOLIA | “2012 оны Дотоодын шилдэг байгууллага” өргөмжлөл | 2012 |
| Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим | “Санхүүгийн салбарын онцлох энтрепренер” | 2012 |
| Bloomberg TV Mongolia | “Жаргалан” Эрүүл мэндийн даатгал “Шилдэг Инноваци” шагнал | 2016 |

## 1.10. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь Даатгалын тухай хууль, СЗХ-ны дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай байгууллага юм. СЗХ-ны 2011 оны 06 сарын 02-ны өдрийн 146 тоот тогтоолоор Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба үүний хүрээнд авто тээврийн хэрэгсэл, хөрөнгө, гэнэтийн осол, эмчилгээ, барилга угсралтын болон бусад 17 хэлбэрийн эрсдэлийг даатгах нийт 52 төрлийн даатгалын бүтээгдэхүүнийг борлуулж ажиллаж байна. 2017 оны эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь 42,748 харилцагчтай болж богино хугацаанд дотоодын даатгалын салбарын 16%-ийг бүрдүүлэгч, даатгалын зах зээлийн Топ-3 компанийн нэг болж өргөжсөн байна.

*Граф 3. Даатгалын зах зээлд эзлэх хувь*




*Граф 4. Томоохон даатгалын ТОП-5 компанийн нийт хураамжийн орлого, тэрбум төг.*




Эх сурвалж: СЗХ

он сар өдөр 2018.08.29 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...... он .... сар .... өдөр

## 1.10.1. Даатгалын үйл ажиллагааны тухай

### Даатгалын тухай ерөнхий ойлголт

Даатгал гэдэг нь гэрээний үндсэн дээр нэг талаас даатгуулагч өөрийн эд хөрөнгө, ашиг сонирхлоо болзошгүй аюул, эрсдэлээс учирч болох хохирлоо нөхөх баталгаатай байх болон тохиролцсон болзлоор нөхөн авах зорилгоор даатгуулж, түүний төлөө зохих хураамж төлөх, нөгөө талаас даатгагч нь даатгуулагчид учирч болох хохирлыг бүрэн буюу зарим хэсгийг төлөхөөр үүрэг хүлээж, эрх эдлэх харилцаа юм. Өөрөөр хэлбэл, даатгал гэдэг нь аливаа эрсдэлээс иргэн, аж ахуйн нэгж байгууллагын эд хөрөнгө, ашиг сонирхлыг бүрэн бүтэн байлгах буюу хамгаалах зориулалт бүхий мөнгөн хөрөнгийн сан байгуулах үйл ажиллагаа юм.[1]

Даатгалын талаар илүү нарийн ойлголт авахын тулд дараах үндсэн ухагдахууныг ойлгох нь зүйтэй.[2]

| № | Нэр томьёо | Тайлбар |
|---|---|---|
| 1 | *Даатгал* | *Ирээдүйд учирч болох аливаа эрсдэлийг шилжүүлэх, багасгахад чиглэсэн үйл ажиллагаа* |
| 2 | *Даатгалын зүйл* | *Даатгалд хамрагдаж байгаа эд хөрөнгө, хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрийн чадвар* |
| 3 | *Даатгалын гэрээ* | *Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх даатгалын харилцааг зохицуулсан эрх зүйн баримт бичиг* |
| 4 | *Даатгалын үнэлгээ* | *Даатгалын объектыг үнэлж даатгуулсан мөнгөний хэмжээ* |
| 5 | *Даатгалын тохиолдол* | *Даатгуулсан зүйлд эрсдэл тохиолдож, хохирол учрах үйл явц* |
| 6 | *Даатгалын хураамж* | *Даатгалын үнэлгээнээс хамаарч даатгуулагчийн төлж байгаа мөнгөний дүн* |
| 7 | *Даатгалын нөхөн төлбөр* | *Гэрээний дагуу даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгө* |
| 8 | *Даатгалын баталгаа* | *Даатгалын компанийн зүгээс даатгуулагчдаа даатгасныг баталгаажуулан өгч буй баримт бичиг* |
| 9 | *Даатгалын хугацаа* | *Даатгалын гэрээний хүчинтэй хугацаа* |

*Эх сурвалж: Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв, Монголбанк*

Даатгалын харилцаанд даатгагч, даатгуулагчаас гадна даатгалын мэргэжлийн оролцогч болон зохицуулагч байгууллагууд оролцдог. Даатгалын мэргэжлийн оролцогч гэдэгт даатгалын зуучлагч, даатгалын төлөөлөгч, даатгалын хохирол үнэлэгч, даатгалын актуарч зэрэг орох ба СЗХ-оос тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа эрхэлдэг.

| № | Оролцогч | Тайлбар |
|---|---|---|
| 1 | *Даатгагч* | *Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан мэргэжлийн байгууллага* |
| 2 | *Даатгуулагч* | *Өөрийн эд хөрөнгө, эрүүл мэнд, ашиг сонирхлоо даатгуулж, даатгалын хураамж төлж байгаа хувь хүн, хуулийн этгээд* |

[1] Монголын Даатгагчдын Холбоо, Available from URL: http://www.mia.mn/content.html?id=25
[2] Даатгалын тухай, Монголбанкны Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв, Available from URL: https://www.mongolbank.mn/documents/financialliteracy/publications/11.pdf

МАНДАЛ ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ 5473489

МОНГОЛ УЛС GOLOMT CAPITAL LLC 5481589 ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

2018 .08. 29 өдөр БҮРТГЭВ

| | | |
|---|---|---|
| 3 | *Даатгалын төлөөлөгч* | *Даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх үүрэг бүхий этгээд* |
| 4 | *Даатгалын зуучлагч* | *Даатгагчийг даатгуулагчтай холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс, шагнал авах эрх бүхий этгээд* |
| 5 | *Даатгалын хохирол үнэлэгч* | *Даатгалын тохиолдлоор үүссэн бодит хохирлын мөнгөн дүнг хараат бусаар тогтоох үүрэг бүхий этгээд* |
| 6 | *Даатгалын актуарч* | *Даатгагчид учирч болох эрсдэлийг урьдчилан үнэлж, эдийн засаг, математикийн тооцоо, судалгааны үндсэн дээр үйл ажиллагаа явуулдаг этгээд* |
| 7 | *Даатгалын зохицуулагч* | *Даатгалын харилцаа хуулийн дагуу явагдаж буй эсэхийг илрүүлж, хууль сахиулах үүрэг бүхий төрийн байгууллага* |

*Эх сурвалж: Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв, Монголбанк*

Даатгал нь маш олон төрөлтэй байдаг бөгөөд тэдгээрийг даатгалын харилцааны шинж чанар, хугацаа, зорилго зэргээс хамааруулж ангилдаг. Монгол Улсын "Даатгалын тухай хууль"-д зааснаар даатгалыг урт хугацааны ба ердийн даатгал гэж ангилах бөгөөд албан журмын ба сайн дурын гэсэн хоёр хэлбэртэй байна.

Даатгалыг зорилгоос нь хамаарч арилжааны ба нийгмийн даатгал гэж ангилна.

| | Даатгалын төрөл | Тайлбар | Жишээ |
|---|---|---|---|
| Объектоор нь | *Хувь хүний* | *Хүний амь нас, эрүүл мэнд, хөдөлмөрийн чадварт учрах эрсдэлээс хамгаалах зориулалт бүхий даатгал* | *Амь насны даатгал, эрүүл мэндийн даатгал* |
| Объектоор нь | *Эд хөрөнгийн* | *Хөрөнгөнд өөрийн болон бусдын буруугаас эсвэл давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс шалтгаалан учирсан хохирлыг нөхөн төлөх зориулалт бүхий даатгал* | *Хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийн даатгал* |
| Объектоор нь | *Хариуцлагын* | *Даатгуулагч этгээдийн зүгээс гуравдагч этгээдэд учруулсан хохирлыг даатгагчаар нөхөн төлүүлэхээр тохиролцож хийсэн даатгал* | *Жолоочийн, эмчийн, өмгөөлөгчийн хариуцлагын даатгал* |
| Хугацаагаар нь | *Ердийн даатгал* | *Нэг хүртэлх жилийн хугацаанд хувь хүний эд хөрөнгө амь нас эрүүл мэндэд учрах эрсдэлээс хамгаалах зориулалт бүхий даатгал* | *Гэнэтийн осол, эмчилгээний, хөрөнгийн, авто тээврийн хэрэгслийн, ачааны, барилга угсралтын, газар тариалангийн, мал амьтдын даатгал* |
| Хугацаагаар нь | *Урт хугацааны даатгал* | *Нэгээс дээш жилийн хугацаанд хувь хүний амьдралд учирч болох эрсдэлээс хамгаалах зориулалт бүхий даатгал* | *Хугацаат амьдралын, насан туршийн, хуримтлалын, тэтгэврийн, эрүүл мэндийн даатгал* |
| Төрлөөр нь | *Заавал* | *Хуульд заасны дагуу заавал даатгуулах даатгал* | *Жолоочийн хариуцлагын даатгал, нийгмийн даатгал* |

| | | | |
|---|---|---|---|
| | Сайн дурын | Иргэн, хуулийн этгээдүүд өөрийн хүсэлтийн үндсэн дээр даатгуулж болох даатгал | Тээврийн хэрэгслийн даатгал |
| Зорилгоор нь | Нийгмийн даатгал | Төрөөс хэрэгжүүлж буй ашгийн төлөө бус даатгал | Тэтгэврийн, эрүүл мэндийн, тэтгэмжийн, ажилгүйдлийн даатгал |
| | Арилжааны даатгал | Хувийн даатгалын компаниудын хэрэгжүүлдэг ашгийн төлөөх даатгал | Эд хөрөнгийн, тээврийн хэрэгслийн, орон сууцны даатгал |

*Эх сурвалж: Олон нийтийн боловсрол, мэдээллийн төв, Монголбанк*

## Орлогод тооцсон хураамж

Даатгалын үйл ажиллагаа эрхлэх явцад орж ирсэн нийт хураамжийн орлого (Gross Written Premium)-ыг орлогоор тооцохгүй бөгөөд үүнээс давхар даатгалын зардал, буцаалт, орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн өөрчлөлт болон давхар даатгалын хойшлогдсон төлбөрийг хассан дүнг орлогод тооцдог. Үүнийг орлогод тооцсон хураамж буюу earned premium гэж нэрлэдэг. Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг даатгалын гэрээний хугацаанаас хамааруулан нийт хураамжийн орлогыг хувь тэнцүүлэн хуваарилж тооцох буюу тайлант хугацаанд орлогод хүлээн зөвшөөрөгдөөгүй хураамжийн орлогыг хэлнэ.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангаас хэзээд ч нөхөн төлбөр гарах боломжтой тул даатгалын байгууллага нь тус нөөц санг хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулдаг ба энэ нь дотоодын зах зээлийн хувьд арилжааны банкны хадгаламж, хадгаламжийн сертификат болон Засгийн газрын үнэт цаас байдаг.

### *Орлогод тооцсон хураамж (Earned premium)*

СЗХ-ны 2016 оны 03 сарын 11-ний өдрийн 70 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-д зааснаар орлогод тооцсон хураамж (цаашид "ОТХ" гэх) гэж тайлант хугацаанд орлогод хүлээн зөвшөөрөгдсөн хураамжийн орлого буюу даатгалын хураамжийн цэвэр орлогоос орлогод тооцоогүй хураамжийн нөөц (цаашид "ОТХН" гэх)-ийн өөрчлөлтийг хасаж хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг нэмж тооцсон дүнг хэлнэ.

$$\text{Даатгалын хураамжийн цэвэр орлого} \\ = \text{Нийт хураамжийн орлого} - \text{давхар даатгалын хураамж} \\ - \text{даатгалын хураамжийн буцаалт}$$

$$\text{ОТХ} = \text{Даатгалын цэвэр хураамж} - \Delta\text{ОТХН} - \Delta\text{Хойшлогдсон давхар даатгалын хураамж}$$

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасаж Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлтийг тодорхойлно. Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг дансны тайлант үеийн үлдэгдлээс эхний үлдэгдлийг хасаж хойшлогдсон давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг тодорхойлно.

ҮЭ
он сар өдөр
2018.08.29
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
он .... сар .... өдөр

## Нөөц сангийн ангилал

Даатгалын байгууллага нь дараах ангиллаар нөөц санг байгуулна. Үүнд:

| Даатгалын хураамжийн нөөц сан<br>*Premium reserve* | Даатгалын нэхэмжлэлийн нөөц сан<br>*Outstanding claims reserve* |
|---|---|
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН)<br>*Unearned premium reserve or UPR* | Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц (УБНХН)<br>*Incurred but not reported or IBNR* |
| Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС)<br>*Unexpired risk reserve or URR* | Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС)<br>*Reported but not Paid or RBNP* |

*Эх сурвалж: СЗХ*

***Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН)***

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа даатгалын гэрээ бүрийн хувьд “хувь тэнцүүлсэн арга”-аар буюу тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр тодорхойлно.

$$\text{ОТХН} = \sum_{i=1}^{n} (\text{ДНХ} - \text{ДБ}) * \frac{\text{Х}}{\text{Н}}$$

| | |
|---|---|
| *ДНХ* | *тухайн даатгалын гэрээний нийт хураамжийн орлого* |
| *ДБ* | *тухайн даатгалын гэрээний даатгалын хураамжийн буцаалт* |
| *Х* | *тухайн даатгалын гэрээний хүчинтэй байх үлдсэн хугацаа/өдрөөр/ бөгөөд үүнийг гэрээний нийт хугацаанаас тухайн гэрээний тайлагналын өдөр хүртэл үргэлжилсэн хугацааг хасаж тооцно* |
| *Н* | *тухайн даатгалын гэрээний нийт үргэлжлэх хугацаа* |
| *i* | *тухайн даатгалын гэрээний дугаар* |

***Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБХНС)***

Учирч болзошгүй хохирлын нөөц санг даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх учирч болох хохирол болон үйл ажиллагааны зардлын нийлбэр нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцөөс давсан тохиолдолд тухайн нэмэгдэл хариуцлагын хэмжээгээр тооцно.

$$\text{УБХНС} = \left(\frac{\text{НТ} + \text{ҮАЗ}}{\text{ЦХ} - \Delta\text{ОТХН}} - \mathbf{1.0}\right) * \boldsymbol{OTXN}$$

| | |
|---|---|
| *НТ* | *даатгалын хэлбэрийн даатгалын нөхөн төлбөрийн цэвэр зардал/давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр орохгүй/ ба нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлтийн нийлбэр/давхар даатгалын хэсэг орохгүй/,* |
| *ҮАЗ* | *даатгалын хэлбэрийн /хэлбэрээр задлах эсэх/ үйл ажиллагааны зардал, үүнд: даатгалын гэрээний зардал, ерөнхий ба удирдлагын зардал, борлуулалт маркетингийн зардал, санхүүгийн зардал, бусад зардал хамаарна. Зардлуудыг хэлбэрээр задлах боломжгүй бол хэлбэр тус бүрийн орлогод тооцсон хураамжийг нийт орлогод тооцсон хураамжид харьцуулсан хувийн жинг үйл ажиллагааны* |

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
мандал даатгал
Б. Нямбаатар
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

| | |
|---|---|
| | зардлын дүнгээр үржүүлэн даатгалын хэлбэр тус бүрээрх зардлын задаргааг тооцож болно. |
| ЦХ | даатгалын хэлбэрийн даатгалын хураамжийн цэвэр орлого |
| ∆ОТХН | даатгалын хэлбэрийн даатгалын орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн нийт өөрчлөлт/хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлтийг хасна/ |
| ОТХН | даатгалын хэлбэрийн даатгалын Орлогод тооцоогүй хураамжийн нийт нөөц |

***Даатгалын нэхэмжлэлийн нөөц сан***

Даатгагч тайлагналын өдөр шийдвэрлэгдээгүй үлдсэн болон тайлагналын өдрөөс өмнөх хугацаанд үүссэн бөгөөд даатгагчид мэдэгдэхээр хүлээгдэж байгаа бүх нэхэмжлэлийг барагдуулахтай холбоотой нийт хариуцлагыг нарийвчлан тооцсон дүнг даатгалын нэхэмжлэлийн нөөц сан гэх ба энэ нь Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан болон учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан гэж ангилагдана.

***Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС)***

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санд тайлангийн хугацаанд даатгуулагч даатгагчид тухайн гэрээнд заасан аливаа хэлбэрээр /бичгээр, утсаар, цахим шуудан болон бусад/ мэдэгдсэн даатгалын тохиолдлоос үүсэх даатгагчийн урьдчилан тооцоолсон хариуцлагын хэмжээ болон тайлангийн хугацаанд төлөгдөөгүй үлдсэн нэхэмжлэлийн хэмжээ хамаарна. Томьёолбол:

$$\text{МБТХНС} = \text{А} + \text{Б} - \text{В} + \text{Г}$$

| | |
|---|---|
| *А* | *тайлангийн үеэс /сар, улирал, жил байж болох/ өмнөх үед даатгалын тохиолдол нь учирсан бөгөөд нэхэмжилсэн эсэхээс үл хамааран даатгагчид мэдэгдсэн даатгалын өр төлбөрийн дүн /өмнөх тайлант үеийн Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сангийн тухайн гэрээгээрх үлдэгдэл буюу тухайн хугацаанд хамаарах даатгалын нэхэмжилсэн хохирлын дүн дээр даатгагчид мэдэгдсэн боловч нэхэмжлээгүй хохирлыг нэмсэн дүнтэй тэнцэнэ/.* |
| *Б* | *тайлангийн үед даатгалын тохиолдол нь учирсан бөгөөд нэхэмжилсэн эсэхээс үл хамааран даатгагч мэдсэн даатгалын өр төлбөрийн дүн, эдгээр нь компанийн нэхэмжлэлийн бүртгэлд орсон байна /даатгалын нэхэмжилсэн хохирлын дүн дээр даатгагч мэдсэн боловч нэхэмжлээгүй хохирлыг нэмсэн дүнтэй тэнцэнэ/.* |
| *В* | *тайлангийн хугацаанд /зөвхөн тухайн улиралд/ барагдуулсан нэхэмжлэл* |
| *Г* | *даатгалын хохирол үнэлгээний зардал, энэ нь дараах зүйлүүдийн нийлбэрээс бүрдэнэ:*<br>1. *тайлангийн хугацааны эцэст шийдвэрлэгдээгүй байгаа нэхэмжлэлийн хохирол үнэлгээний зардлын дүн*<br>2. *шаардлагатай бол хөндлөнгийн шинжээчийн зардлын дүнг нэмж тооцох* |

***Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС)***

Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг даатгагч даатгалын хэлбэр тус бүрээр үнэн зөв бөгөөд бодитой статистикт тулгуурлан актуар аргачлалаар тооцоолсон даатгагчийн хамгийн сайн төсөөлөлд үндэслэн тооцно. Тухайн нөөцийг тайлант хугацааны эцсийн байдлаар учирсан боловч мэдэгдээгүй байгаа хохиролд зориулан байгуулна. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийг тооцоход даатгагч хохирлын гурвалжны хөгжлийн аргуудыг ашиглана. Эдгээр арга нь актуар төсөөлөл, аргачлалд суурилна.

*СЗХ-ны 2016 оны 03 сарын 11-ний өдрийн 70 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам" -ын дагуу даатгагч бүр даатгалын нөөц сан тооцож, бүрдүүлж байна.*

он сар өдөр
2018.08.29
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

## Давхар даатгалын хураамжийн зардал

Даатгуулагчийн өөртөө хүлээж чадах хэмжээнээс давсан хохирлоос хамгаалах зорилгоор давхар даатгагчаас давхар даатгуулагчийн худалдан авч буй хамгаалалтын давхар даатгал гэнэ. Даатгалын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 болон 46.1.2 дах заалтуудад зааснаар нь даатгагч нь давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанид эсхүл Монгол Улсын даатгалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаад улсын даатгалын компанид гэрээний дагуу хүлээсэн үүргээ дахин даатгуулж болно.

*Зураг 4. Давхар даатгалын төрөл*




Давхар даатгалын гэрээг трийти болон факультатив гэсэн хоёр төрөлд ангилдаг. Трийти давхар даатгал гэж даатгалын компани даатгуулагчтай байгуулсан даатгалын гэрээнүүдээ багцаар нь давхар даатгагчтай харилцан тохиролцсон нөхцөлөөр шууд давхар даатгалд хамруулахыг хэлдэг. Өөрөөр хэлбэр даатгалын компани давхар даатгалын компанитай урьдаас давхар даатгалд хамруулах бүтээгдэхүүний төрөл, гэрээний нөхцөлүүдээ харилцан тохиролцсоны үндсэн дээр даатгуулагчтай байгуулж буй гэрээ бүрээ автоматаар давхар даатгалд хамруулах үйл ажиллагаа юм. Трийти давхар даатгалыг хувь тэнцүүлсэн (proportional) болон хохирлын хэтрэлтийн (excess of loss) гэж хоёр ангилдаг.

Хувь тэнцүүлсэн (Proportional) төрлийн гэрээгээр даатгалын компани даатгуулагчтай байгуулсан гэрээ бүрийн хураамжийн орлогынхоо тодорхой хувийг давхар даатгагчид шилжүүлж, нөхөн төлбөр гарсан тохиолдолд уг шилжүүлсэн хувиар давхар даатгагчаар нөхөн төлбөрийг төлүүлдэг.

Харин excess of loss нь давхар даатгагчтай тохиролцсон тодорхой дүн хүртэлх нөхөн төлбөрийг даатгалын компани өөрөө хариуцаж, уг дүнгээс давсан хэсгийг давхар даатгагчаар төлүүлэх нөхцөлтэйгөөр байгуулдаг давхар даатгалын гэрээний төрөл юм. Treaty төрлийн давхар даатгалыг харьцангуй бага үнэлгээ бүхий олон тоогоор хийгддэг даатгалын төрлүүдэд ихэвчлэн ашигладаг.

Факультатив давхар даатгал нь даатгалын компани даатгуулагчийн өмнө хүлээсэн эрсдэлийг хэсэгчлэн болон бүхэлд нь даатгалын гэрээ тус бүрээр давхар даатгагчтай харилцан тохиролцож даатгуулахыг хэлдэг. Энэ төрлийн давхар даатгалыг харьцангуй өндөр үнэлгээ бүхий цөөн тоогоор хийгддэг даатгалын төрлүүдэд ашигладаг.

## Хөрөнгө оруулалтын орлого

Даатгалын байгууллага нь байгуулсан нөөц санг СЗХ-ны 2013 оны 07 сарын 17-ны өдрийн 250 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС

СЗХ 2018 08 29 өдөр БҮРТГЭВ № 1

хийхэд тавигдах шаардлага"-ын дагуу дараах хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд хөрөнгө оруулж болно.

| № | Хөрөнгийн ангилал | Хөрөнгө оруулах дээд хувь /нөөц санд эзлэх хувиар/ |
|---|---|---|
| 1 | Засгийн газраас гаргасан өрийн хэрэгсэл | 100% |
| 2 | Төв банкны үнэт цаас | 100% |
| 3 | Санхүүгийн түрээс | 10% |
| 4 | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | 60% |
| 5 | Хөрөнгө оруулалтын сан /нээлттэй эсхүл хаалттай/ | 20% |
| 6 | Аймаг нийслэлийн гаргасан өрийн хэрэгсэл | 60% |
| 7 | Компанийн өрийн хэрэгсэл /СЗХ-оос тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн холбогдох этгээдээс бусад компанийн өрийн хэрэгслийг ойлгоно./ | 20% |
| 8 | МХБ-ийн I ангиллын хувьцаат компанийн хувьцаа | 10% |
| | МХБ-ийн II ангиллын хувьцаат компанийн хувьцаа | 5% |
| 9 | Тухайн даатгалын компанийн холбогдох этгээдэд үл хамаарах банк бус санхүүгийн байгууллагад итгэлцлээр байршуулах | 20% |

*Эх сурвалж: СЗХ*

## Даатгалын компанийн үндсэн үзүүлэлтүүд

Даатгалын байгууллагын үйл ажиллагааны үр ашигт байдлыг дараах үндсэн харьцаагаар тооцдог. Үүнд:

- Хохирлын харьцаа (Loss ratio) нь даатгалын байгууллага нь олсон орлогод тооцсон хураамжийн хэдэн хувийг нөхөн төлбөрт төлж байгааг харуулах ба дараах томьёогоор бодно.

$$\text{Хохирлын харьцаа} = \frac{\text{Цэвэр нөхөн төлбөр}}{\text{Орлогод тооцсон хураамж}}$$

- Зардлын харьцаа (Expense ratio) нь даатгалын байгууллагын орлогод тооцсон хураамж нь үйл ажиллагааны зардлыг нөхөж байгаа эсэхийг харуулах ба дараах томьёогоор бодно.

$$\text{Зардлын харьцаа} = \frac{\text{Үйл ажиллагааны зардал}}{\text{Орлогод тооцсон хураамж}}$$

- Нийлмэл харьцаа (Combined ratio): Нийлмэл харьцаа нь даатгалын компанийн ашигт ажиллагааг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд уг үзүүлэлт 100%-аас бага бол даатгалын үндсэн үйл ажиллагааны хувьд ашигтай, 100%-аас их бол алдагдалтай ажиллаж байгааг илэрхийлнэ. Нийлмэл харьцаа нь хохирлын болон зардлын харьцааны нийлбэр буюу дараах томьёогоор бодно.

$$\text{Нийлмэл харьцаа:} \frac{(\text{Цэвэр нөхөн төлбөр} + \text{Үйл ажиллагааны зардал})}{\text{Орлогод тооцсон хураамж}}$$

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC

2018.08.29
БҮРТГЭВ
№ 01

## 1.10.2. Үнэт цаас гаргагчийн даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны 2011 оны 06 сарын 02-ны өдрийн 146 тоот тогтоол, 2012 оны 04 сарын 18-ны өдрийн 146 тоот тогтоол, 2012 оны 06 сарын 20-ны өдрийн 163 тоот, болон 2013 оны 05 сарын 08-ны өдрийн 188 тоот тогтоолын дагуу нийт 16 хэлбэрийн 52 нэр төрлийн сайн дурын даатгалын бүтээгдэхүүн борлуулах эрхтэй байна.

*Хүснэгт 19. Үнэт цаас гаргагчийн даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн*

| № | Даатгалын хэлбэр | Хэлбэрийн зөвшөөрөл авсан огноо, дугаар |
|---|---|---|
| 1 | Гэнэтийн осол, эмчилгээний даатгал | СЗХ-ны 2011/06/02 №146 тогтоол |
| 2 | Хөрөнгийн даатгал | СЗХ-ны 2011/06/02 №146 тогтоол |
| 3 | Авто тээврийн хэрэгслийн даатгал | СЗХ-ны 2011/06/02 №146 тогтоол |
| 4 | Ачааны даатгал | СЗХ-ны 2011/06/02 №146 тогтоол |
| 5 | Барилга угсралтын даатгал | СЗХ-ны 2011/06/02 №146 тогтоол |
| 6 | Газар тариалангийн даатгал | СЗХ-ны 2012/06/20 №163 тогтоол |
| 7 | Мал амьтдын даатгал | СЗХ-ны 2012/06/20 №163 тогтоол |
| 8 | Агаарын хөлгийн даатгал | СЗХ-ны 2011/06/02 №146 тогтоол |
| 9 | Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | СЗХ-ны 2011/06/02 №146 тогтоол |
| 10 | Хариуцлагын даатгал | СЗХ-ны 2011/06/02 №146 тогтоол<br>СЗХ-ны 2012/04/18 №94 тогтоол |
| 11 | Санхүүгийн даатгал | СЗХ-ны 2012/06/20 №163 тогтоол |
| 12 | Зээлийн даатгал | СЗХ-ны 2013/05/08 №188 тогтоол |
| 13 | Итгэлцлийн даатгал | СЗХ-ны 2013/05/08 №188 тогтоол |
| 14 | Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал | СЗХ-ны 2013/05/08 №188 тогтоол |
| 15 | Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | СЗХ-ны 2013/05/08 №188 тогтоол |
| 16 | Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал | СЗХ-ны 2013/05/08 №188 тогтоол |

## 1.10.3. Үнэт цаас гаргагчийн нийт хураамжийн орлого

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа эхэлсэн жилд буюу 2011 онд 7 сая төгрөгийн иргэдийн даатгал, 532 сая төгрөгийн байгууллагын даатгалын хураамжийн орлого, нийт 539 сая төгрөгийн хураамжийн орлого олж байсан бол 2017 онд 22.5 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлогыг олж 6 жилийн дотор 42 дахин өссөн байна. 2012-2017 оны нийт хураамжийн орлогын жилийн дундаж өсөлт 27.6% байсан ба энэ салбарын жилийн дундаж өсөлтөөс даруй 17% өндөр байна.

*График 5. Нийт хураамжийн орлого 2011-2017*



2017 оны эцсийн байдлаарх нийт хураамжийн орлого 22.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 72% өссөн ба энэ нь барилга угсралтын даатгалын орлого 36.8 дахин, эрүүл мэндийн даатгал 3.0 дахин, гэнэтийн ослын даатгал 2.7 дахин өссөнтэй холбоотой юм. Үнэт цаас гаргагч нь 2017 онд Оюу Толгой ХХК-ийн барилга угсралтын сонгон шалгаруулалтад шалгарсан нь барилга угсралтын өсөлтөд нөлөөлсөн байна. Уг даатгал нь даатгалын фронтингийн үйлчилгээний хүрээнд хийгдэж байгаа буюу нийт хураамжийн орлого нь 100% давхар даатгалын зах зээл рүү гарах юм. Эрүүл мэндийн даатгалын өсөлтөд дотоодын томоохон аж ахуйн нэгжүүд ажилтнуудаа "Жаргалан" эрүүл мэндийн даатгалд хамруулсан нь нөлөөлжээ. Ингэснээр, гэнэт ослын даатгалын хэлбэрээр салбартаа нэгт оржээ. Мөн тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн орлого 45% өсөж 3.6 тэрбум төгрөгт хүрч мөн л салбартаа нэгт жагссан байна.

*Граф 6. Нийт хураамжийн орлого, даатгалын хэлбэрээр 2017*




2017 онд нийт хураамжийн орлогын 60%-ийг барилга угсралт, хөрөнгө болон тээврийн хэрэгслийн даатгал бүрдүүлжээ.

Нийт хураамжийн орлогыг даатгалын хэлбэрээр ангилбал барилга угсралтын, эрүүл мэндийн болон гэнэтийн ослын даатгалын эзлэх хувь өсөлттэй байгаа бол бусад даатгалын бүтээгдэхүүн уналттай байна. Энэ нь Үнэт цаас гаргагчийн нийт хураамжийн орлого солонгорсон байдалтай буюу нэг бүтээгдэхүүнээс хамаарах хамаарал бага байгааг илтгэж байна.

*Граф 7. Даатгалын нийт хураамжийн орлогын бүтэц 2013-2017*




Даатгалын хэлбэр тус бүрийн нийт хураамжийн орлогын 2014-2017 оны жилийн өсөлтийг дараах графиар харуууллаа. Үнэт цаас гаргагч нь нийт хураамжийн орлогоор дотоодын зах зээлд 3-т орж байгаа ч 2014-2017 оны нийт хураамжийн орлогын өсөлт хэлбэлзэл өндөртэй байгаа нь үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа өсөлтийн шатандаа явж байгаа буюу цаашид өсөлт гарах орон зай байгааг харуулж байна.

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ

Граф 8. Даатгалын хэлбэр тус бүрийн орлогын өсөлт 2014-2017




Дэлхийн даатгалын салбарын нийт хураамжийн орлогын 50%-ийг иргэд бүрдүүлдэг бол Монгол Улсын даатгалын салбарын 70%-ийг байгууллага, 30%-ийг иргэд бүрдүүлдэг гэж Үнэт цаас гаргагчийн шинжээчид тооцоолж байна. 2017 оны эцсийн байдлаар, нийт хураамжийн орлогоос Оюу Толгой ХХК-ийн барилга угсралтын даатгалыг (даатгалын фронтингийн үйлчилгээ) хасаж тооцвол иргэдийн даатгал 43.2%, байгууллагын даатгал 56.8%-тай гарсан ба энэ нь балансалсан, эрүүл үзүүлэлт болж байна.

Граф 9. Нийт хураамжийн орлого, харилцагчийн төрлөөр 2013-2017




*Байгууллагын даатгалаас даатгалын фронтингийн үйлчилгээний хураамжийг хасав

2013-2017 оны иргэдийн даатгалын жилийн дундаж өсөлт 36.2% байсан бол байгууллагын даатгалын дундаж өсөлт 21.4% байна.

Граф 10. Иргэдийн даатгалын НХО, өсөлт




Граф 11. Байгууллагын даатгалын НХО, өсөлт




МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС



Огноо: 2018/04/16

Иргэдийн даатгалын нийт хураамжийн орлогыг хэлбэр тус бүрээр ангилан дараах графаар харуулав. 2017 оны байдлаар, үнэт цаас гаргагчийн нийт иргэдийн даатгалын 95.2%-ийг бүрдүүлж байна. Тээврийн хэрэгслийн даатгалын хураамжийн орлого 45% өсөж 3.6 тэрбум төгрөг, гэнэтийн ослын даатгалын хураамжийн орлого 145% өсөж 1.7 тэрбум төгрөгт хүрсэн ба ингэснээр уг даатгалын хэлбэрүүдээр салбартаа нэгт жагссан байна.

*Граф 12. Иргэдийн даатгалын НХО, хэлбэрээр 2013-2017*




Байгууллагын даатгалын нийт хураамжийн орлого 2016-2017 онд өсөлтийн шатандаа орсон нь эрүүл мэнд, гэнэтийн осол болон барилга угсралтын даатгал өссөнтэй холбоотой юм. 2017 оны байдлаар нийт байгууллагын даатгалын орлогын 97.8%-ийг дараах 6 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн эзэлж байна.

*Граф 13. Байгууллагын даатгалын НХО, хэлбэрээр 2013-2017*



2018 .08. 29 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

## 1.10.4. Үнэт цаас гаргагчийн харилцагчдын тоо

2017 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаас гаргагч нь нийт 1,457 байгууллага, 41,291 иргэдтэй нийт 72,902 даатгалын гэрээ байгуулсан ба энэ нь өмнөх оны мөн үеэс 20.7% буурсан үзүүлэлт юм. Үүнтэй холбоотойгоор гэрээний дундаж дүн өмнөх оноос 117% өсөж 309,163 төгрөгт хүрчээ. Үнэт цаас гаргагчийн гэрээний дундаж дүн 2012 онд хамгийн өндөр буюу 756,217 төгрөг байсан ба энэ нь нийт хураамжийн орлогын 79.4%-ийг байгууллагын даатгал эзэлж байсантай холбоотой юм. Үүнээс хойш байгууллагын даатгалын эзлэх хувь буурсаар 2017 онд 56.8% болжээ.

*Граф 14. Харилцагч, гэрээний тоо, гэрээний дундаж дүн 2011-2017*




## 1.10.5. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын суваг

Үнэт цаас гаргагч нь өөрийн шууд борлуулалтын алба, салбарууд болон даатгалын зуучлагч, төлөөлөгчөөр дамжуулж даатгалын бүтээгдэхүүнийг борлуулдаг. 2016 онд нийт хураамжийн орлогын 54%-г шууд борлуулалт, 36%-г даатгалын зуучлагч, 10%-г даатгалын төлөөлөгчөөр бүрдүүлсэн бол 2017 онд 66%-г шууд борлуулалт (₮14.8 тэрбум), 31%-г даатгалын зуучлагч (₮7.0 тэрбум), 3%-г даатгалын төлөөлөгч (₮651 сая) бүрдүүлсэн байна. 2017 онд дотоодын даатгалын компаниуд 47%-г шууд борлуулж, 53%-г даатгалын зуучлагч, төлөөлөгчөөр дамжуулж борлуулжээ. Үүнээс дүгнэхэд, Үнэт цаас гаргагч нь бусад даатгагчидтай харьцуулахад шууд борлуулалт хийх чадвартай, бусад борлуулалтын сувгаас хараат бус байна.

*Граф 16. Мандал Даатгалын НХО, борлуулалтын сувгаар 2017*




*Граф 15. Салбарын НХО, борлуулалтын сувгаар 2017*




МАНДАЛ ДААТГАЛ ХХК МАНДАЛ даатгал УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС GOLOMT CAPITAL LLC ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

2017 онд Үнэт цаас гаргагч нь Улаанбаатар хот, Өмнөговь аймаг, Дархан-уул аймагт нийт 3 салбар, 22 даатгалын зуучлагч, 14 даатгал төлөөлөгчөөс 3 төлөөлөгчөөр дамжуулан борлуулалт хийжээ.

*Хүснэгт 20. Үнэт цаас гаргагчийн борлуулалтын суваг*

| | 2016 | 2017 | Тусгай зөвшөөрөл авсан эсэх |
|---|---|---|---|
| Салбар | 3 | 3 | Тийм |
| Даатгалын зуучлагч арилжааны банк | 5 | 5 | Тийм |
| Даатгалын зуучлагч ББСБ | 19 | 17 | Тийм |
| Даатгалын төлөөлөгч хувь хүн | 13 | 14 | Тийм |

## 1.10.6. Үнэт цаас гаргагчийн давхар даатгалын зардал

Үнэт цаас гаргагч нь 2014 оны 06 сараас 2017 оны 07 сарын 01-ний өдрийг хүртэл Variable Quota Share нөхцөлт давхар даатгалын гэрээний хүрээнд бүхий л даатгалын бүтээгдэхүүндээ тодорхой хувь заан давхар даатгалд хамруулдаг байсан нь эрсдэл даах чадварыг нэмэгдүүлсэн ч ашигт ажиллагааг дэмжиж чадаагүй юм. Тухайлбал, 2013-2017 онд дунджаар нийт хураамжийн орлогын 55.3%-г зөвхөн давхар даатгалын хураамжийн зардалд төлсөн бол ердийн даатгалын салбарын бусад компаниуд тухайн жилүүдэд дунджаар 32%-г төлжээ. Энэ нь Үнэт цаас гаргагч нь зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх үүднээс өөрийн хөрөнгөөс давсан үнэлгээтэй эрсдэлийг давхар даатгал ашиглан даатгаж, уг эрсдэлийг бууруулах зорилгоор маш консерватив арга барил ашиглаж эрсдэлийн ихэнх хувийг давхар даатгал руу шилжүүлдэгтэй холбоотой юм. 2017 онд ердийн даатгалын салбарт, Бодь Даатгал хамгийн их хэмжээний давхар даатгалын хураамжийг буюу 16.7 тэрбум төгрөгийг (НХО-ын 59%) төлсөн бол Үнэт цаас гаргагч удаалж НХО-ын 50%-ийг давхар даатгалд төлжээ. Бодь Даатгал нь өнгөрсөн онд нийт хураамжийн орлогоор тэргүүлсэн ба Үнэт цаас гаргагчтай төстэй буюу нийт 5 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй байна. Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгөө нэмэгдүүлснээр давхар даатгал руу шилжүүлэх эрсдэлийн хэмжээг бууруулж ашигт ажиллагааг дэмжих боломжтой болох юм.

*График 17. НХО vs. ДД хураамжийн зардал 2013-2017*




Эх сурвалж: Мандал Даатгал, СЗХ



Огноо: 2018/04/16

2017 оны давхар даатгалын хураамжийн зардлын өсөлт (52%) нийт хураамжийн орлогын өсөлтөөс (72%) удаан байсан ба энэ нь өнгөрсөн оны сүүлийн хагас жилд тус компани давхар даатгалын нөхцөлийг Excess of Loss болгож өөрчилсөнтэй холбоотой юм. Тус оны давхар даатгалын зардлын 52%-н өсөлт нь Оюу Толгой ХХК-ийн барилга угсралтын даатгалын фронтингийн үйлчилгээтэй холбоотой юм. 2013-2017 оны давхар даатгалын жилийн дундаж өсөлт 24.3% байсан бол ба нийт хураамжийн орлогын жилийн дундаж өсөлт 27.6% байжээ. Давхар даатгалыг хэлбэрээр ангилбал, 56%-ийг барилга угсралт, 19%-ийг хөрөнгийн даатгал, 9%-ийг хариуцлагын даатгал эзэлж байна.

*Граф 18. ДД хураамжийн зардал 2013-2017*




*Граф 19. ДД хураамж, хэлбэрээр 2017*




Үнэт цаас гаргагч нь өөрийн нөөц сан, хувьцаат капиталын хэмжээ болон түүхэн нөхөн төлбөрийн харьцаанд суурилан өөрийн эрсдэл даах чадварыг буюу өөрөөсөө гаргах нөхөн төлбөрийн дээд хязгаарыг 50,000 ам.доллар (122 сая төгрөг) байхаар тогтоосон ба үүнээс давсан хэсгийг давхар даатгалд шилжүүлэх юм. Үүний хүрээнд Үнэт цаас гаргагч нь 2017 оны 3-р улирлаас трийти давхар даатгалын нөхцөлөө өөрчилж Variable Quota Share гэрээнээс Excess of Loss[3] төрлийн гэрээ рүү шилжсэн байна.

Үнэт цаас гаргагчийн нь давхар даатгалын трийти гэрээг жил бүр сунгадаг ба 2017 оны 07 сарын 01-ний өдөр байгуулсан гэрээ нь дараах ерөнхий нөхцөлтэй байна:

*Зураг 5. Давхар даатгалын шинэчлэгдсэн нөхцөл*




[3] Давхар даатгалын төрлийн тухай тайлбарыг энэхүү танилцуулгын 1.10.1 хэсгээс харна уу.

Түүнчлэн, Үнэт цаас гаргагч нь бүх даатгалын бүтээгдэхүүнийг давхар даатгалд хамргадуулах бус дараах даатгалын хэлбэрт багтах бүтээгдэхүүнийг давхар даатгахаар болсон байна. Ингэснээр нийт хураамжийн орлогын 46.0%-ийг давхар даатгалын хураамжийн зардалд төлөх юм.

*Хүснэгт 21. НХО-д ээлэх давхар даатгалын хураамжийн зардал*

| Даатгалын хэлбэр | 2017A | | | 2018E | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Байгууллага | Иргэд | Нийт | Байгууллага | Иргэд | Нийт |
| Тээврийн хэрэгслийн даатгал | 22.6% | 22.0% | 22.1% | - | - | - |
| Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал | 23.2% | 13.6% | 14.2% | - | - | - |
| Эд хөрөнгийн даатгал | 68.3% | 40.7% | 61.0% | 83.0% | 11.8% | 48.1% |
| Барилга угсралтын даатгал | 100.0% | - | 100.0% | 99.9% | - | 99.9% |
| Гэнэтийн ослын даатгал | - | 31.4% | 35.8% | - | - | - |
| Хариуцлагын даатгал | 100.0% | - | 100.0% | 64.5% | - | 64.5% |
| Эрүүл мэндийн даатгал | 52.4% | - | 52.4% | 43.7% | 51.0% | 45.3% |
| Бусад | 23.5% | 52.9% | 28.0% | 23.0% | - | 8.0% |
| **Нийт** | **76.1%** | **22.6%** | **49.9%** | **69.6%** | **8.0%** | **46.0%** |

*Дээрх шинэчлэгдсэн нөхцөл нь үнэт цаас гаргагчийн түүхэн мэдээлэл датан дээр суурилсан болно.*

2017 оны 07 сарын 01-ний өдрөөс эхэлсэн трийти давхар даатгалын нөхцөлийн өөрчлөлт нь богино хугацаанд компанийн ашигт ажиллагаанд эергээр нөлөөлсөн ба хуучин нөхцөлийн дагуу цэвэр ашиг 733 сая төгрөг гарах байсан бол Excess of Loss нөхцөл рүү шилжсэнээр цэвэр ашиг 1.1 тэрбум төгрөг болж 324 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Түүнчлэн, мөнгөн хөрөнгө, цэвэр хураамжийн орлого, орлогод тооцсон хураамжид дараах эерэг нөлөөг үзүүлжээ.

*Граф 20. ДД нөхцөлийн шинэчлэлийн үр ашиг*




## 1.10.7. Үнэт цаас гаргагчийн нөхөн төлбөрийн хэмжээ

2017 оны жилийн эцсийн байдлаар, үнэт цаас гаргагчийн нийт нөхөн төлбөрийн хэмжээ 14% өсөж 4.7 тэрбум төгрөг, цэвэр нөхөн төлбөр 10% өсөж 2.1 тэрбум төгрөг хүрчээ. Тус онд нийт 7,645 нөхөн төлбөрийн тохиолдол үүссэн ба нөхөн төлбөр шийдвэрлэх дундаж хугацаа нь 7 хоног байжээ. 2013-2014 онуудад Үнэт цаас гаргагч нь нийт нөхөн төлбөрийн дунджаар 86%-ийг өөрөө барагдуулдаг байсан бол 2016-2017 онд 45%-ийг барагдуулдаг болсон байна. Энэ нь Үнэт цаас гаргагч нь өөрийн үүрэх эрсдэлийн тодорхой хэмжээг давхар даатгалд хамргадуулж, нийт хураамжийн орлогын 50 орчим хувийг давхар төлдөгтэй холбоотой юм.

СЗХ 2018 .08.29 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ

Граф 21. Нийт нөхөн төлбөр vs. цэвэр нөхөн төлбөрийн хэмжээ




2017 онд Үнэт цаас гаргагчийн хохирлын харьцаа 45%-иас 29% болж буурсан нь салбарын дундаж харьцаанаас 9% бага үзүүлэлт бөгөөд энэ нь орлогод тооцсон хураамж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 67% өссөнтэй холбоотой юм.

Граф 22. ОТХ-д эзлэх цэвэр нөхөн төлбөр




Үнэт цаас гаргагчийн барагдуулсан нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр ангилбал, автотээвэр хэрэгслийн, жолоочийн хариуцлагын, гэнэт осол, эмчилгээний даатгалын нөхөн төлбөр нийт нөхөн төлбөрийн 83%-ийг бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагч нь жолоочийн хариуцлагын даатгалын нөхөн төлбөрийн 57%-ийг өөрөөсөө гаргадаг буюу бусад даатгалын хэлбэрүүдтэй харьцуулахад хамгийн их байхад барилга угсралтын даатгалын хамгийн бага буюу 1%-тай байна. Энэ нь барилга угсралтын даатгалыг 99% давхар даатгасантай холбоотой юм.

Граф 23. Нийт нөхөн төлбөр, хэлбэрээр 2017




Эх сурвалж: Мандал Даатгал, СЗХ

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC

СЗХ он сар өдөр 2018 08 29 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...... он .... сар .... өдөр

### 1.10.8. Үнэт цаас гаргагчийн нөөц сан

СЗХ-ны 2016 оны 03 сарын 11-ний өдрийн 70 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын нөөц санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"-ын үнэт цаас гаргагч нь дараах төрлийн нөөц санг байгуулсан байна. Үүнд:

- Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН)
- Учирсан боловч мэдэгдээгүй хураамж нөөц сан (УБМХНС)
- Мэдэгдсэн боловч нэхэмжлээгүй хураамжийн нөөц сан (МБНХНС)
- Учирч болзошгүй хураамжийн нөөц сан (УБХНС)
- Тусгай нөөц сан [4] (ТНС)

2017 оны байдлаар үнэт цаас гаргагч нь нийт 9.4 тэрбум төгрөгийн орлогод тооцоогүй хураамжийн нөөц (25%-ийн өсөлт), 2.9 тэрбум төгрөгийн (31%-н өсөлт) нөхөн төлбөрийн нөөц санг байгуулсан байна.

Граф 24. Нөөц сангийн хэмжээ 2015-2017




- **Орлогод тооцоогүй хураамжийн нөөц (ОТХН)**

2017 оны эцсийн байдлаар, хүчинтэй байгаа нийт 66,931 ширхэг хэлцэл дээр орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг даатгагчийн хүлээн авсан даатгалын хураамжаас гэрээний үлдэх хугацаанд ноогдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоход энэ сангийн үлдэгдэл цэвэр дүнгээр 5,7 тэрбум төгрөгөөр байгуулагдлаа.

| *Сая төгрөг* | Цэвэр ОТХНС | Нийт ОТХНС | ДД-д харгалзах ОТХНС |
|---|---|---|---|
| *Автотээврийн хэрэгслийн даатгал* | *1,776* | *1,996* | *220* |
| *Барилга угсралтын даатгал* | *12* | *591* | *579* |
| *Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал* | *2,128* | *2,492* | *364* |
| *Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал* | *319* | *420* | *100* |
| *Хариуцлагын даатгал* | *583* | *1,819* | *1,237* |
| *Хөрөнгийн даатгал* | *797* | *1,808* | *1,011* |
| *Бусад* | *126* | *240* | *115* |
| ***Нийт*** | ***5,741*** | ***9,366*** | ***3,626*** |

[4] Нөөц сангийн тайлбар, томьёоллыг энэхүү танилцуулгын 1.7.1 хэсгээс харна уу.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК МАНДАЛ даатгал УЛААНБААТАР ХОТ 5473489

МОНГОЛ УЛС GOLOMT CAPITAL LLC

СЗХ
2018.08.29
БҮРТГЭВ

МОНГОЛЫН STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

- **Учирсан боловч мэдэгдээгүй хураамж нөөц сан (УБМХНС)**

2017 онд УБМХНС-г байгуулахдаа дараах 2 үзүүлэлтийг ашигласан.

A. Хүлээгдэж буй хохирлын харьцаа
B. УБМХНС хүчин зүйл

Эхний үзүүлэлт болох Хүлээгдэж буй хохирлын харьцааг гаргахдаа СЗХ-ны 2007 оноос 2016 онд зарлаж байсан даатгалын салбарын тоон өгөгдлүүд болон Үнэт цаас гаргагчийн 2014-2016 оны хохирлын харьцааны үзүүлэлтийг ашиглан хүлээгдэж байгаа нөхөн төлбөрийн дундаж хэмжээг таамагласан байна. Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сангийн дүнг хүснэгтлэн харуулбал дараах байдалтай байна.

| *Сая төгрөг* | Нийт УБМХНС | ДД-д харгалзах УБМХНС | Цэвэр УБМХНС |
|---|---|---|---|
| *Автотээврийн хэрэгслийн даатгал* | *49.17* | *20.56* | *28.61* |
| *Барилга угсралтын даатгал* | *18.04* | *17.86* | *0.18* |
| *Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал* | *120.29* | *59.68* | *60.61* |
| *Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал* | *38.84* | *16.85* | *21.99* |
| *Хариуцлагын даатгал* | *10.72* | *8.56* | *2.15* |
| *Хөрөнгийн даатгал* | *79.91* | *48.95* | *30.97* |
| *Бусад* | *17.36* | *6.99* | *10.37* |
| ***Нийт*** | ***334.33*** | ***179.44*** | ***154.88*** |

Нөөц сангийн тооцоололд гинжин шатны /Chain ladder method/ аргачлалыг ашигласан болно.

- **Мэдэгдсэн боловч нэхэмжлээгүй хураамжийн нөөц сан (МБНХНС)**

Тус нөөц санг тайлант үеийн эцэст даатгалын компани мэдсэн боловч хараахан төлж амжаагүй байгаа нөхөн төлбөрүүдийн нийт хариуцлагын хэмжээгээр байгуулдаг. Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг СЗХ-ны журмын дагуу тооцоолоход нийт дүнгээр 702.2 сая төгрөгөөр байгуулагджээ.

| *Сая төгрөг* | Нийт МБТХНС | ДД-д харгалзах МБТХНС | Цэвэр МБТХНС |
|---|---|---|---|
| *Автотээврийн хэрэгслийн даатгал* | *41.83* | *11.18* | *30.65* |
| *Ачааны даатгал* | *1.9* | *1.73* | *0.17* |
| *Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал* | *40.19* | *9.69* | *30.5* |
| *Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал* | *27.93* | *10.82* | *17.11* |
| *Хариуцлагын даатгал* | *550.19* | *495.19* | *55* |
| *Хөрөнгийн даатгал* | *40.19* | *6.58* | *33.62* |
| ***Нийт*** | ***702.23*** | ***535.19*** | ***167.04*** |

- **Учирч болзошгүй хураамжийн нөөц сан (УБХНС)**

2017 оны орлогод тооцсон хураамжийн дүн 7.0 тэрбум төгрөг, цэвэр нөхөн төлбөрийн дүн 2.1 тэрбум, үйл ажиллагааны зардал нь 4.7 тэрбум төгрөг, нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлтийн дүн 64.3 сая төгрөг гарсан байна. Эдгээр үр дүнг ашиглан СЗХ-ноос баталсан томьёоны дагуу тооцоход тус нөөц сангийн үлдэгдэл 617.8 сая төгрөгөөр байгуулагдсан байна.

*Томьёонд цэвэр Орлогод тооцоогүй хураамжийн нөөц сангийн дүнг ашигласан болно.*

МАНДАЛ даатгал
Б. Ибилгэ
МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
2018.08.29
БҮРТГЭВ

| Сая төгрөг | УБХНС-ийн дүн |
|---|---|
| *Автотээврийн хэрэгслийн даатгал* | *5* |
| *Барилга угсралтын даатгал* | *18* |
| *Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал* | *-* |
| *Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал* | *156* |
| *Хариуцлагын даатгал* | *-* |
| *Хөрөнгийн даатгал* | *397* |
| *Бусад* | *42* |
| ***Нийт*** | ***618*** |

- **Тусгай нөөц сан (ТНС)**

СЗХ-ноос баталсан журмын дагуу 2015 оны эцэст байгуулсан "Учирч болзошгүй хохирлын нөөц сан"-гийн 90 хувь болох 1.26 тэрбум төгрөгөөр энэхүү тусгай нөөц санг байгуулсан болно.

Даатгалын байгууллага нь байгуулсан нөөц сан болон хувь нийлүүлсэн хөрөнгийг СЗХ-оос баталсан журмын дагуу хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулдаг ба үүнээс хүртсэн өгөөж нь ашигт ажиллагаанд нөлөөлөх томоохон хүчин зүйл болдог. 2017 онд үнэт цаас гаргагчийн нийт нөөц сангийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 27% буюу 2.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь хөрөнгө оруулалтын хэмжээний өсөлтөд нөлөөлж, улмаар хөрөнгө оруулалтын орлого 23% өсөж 1.2 тэрбум төгрөг хүрэхэд нөлөөлжээ.

## *1.10.9. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалтын орлого*

Аливаа даатгалын компани нь даатгуулагчаас цугларсан даатгалын хураамжийг нөөц сан хэлбэрээр байршуулж, тэдгээр даатгуулагчид ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийн бодит хохирлыг төлөх, даатгуулагчдын санхүүгийн найдвартай ар тал байх үүрэгтэй байдаг. Иймд, даатгалын компани нь нөөц сан болон хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрээр эсвэл хөрвөх чадвар өндөртэй бусад хөрөнгө хэлбэрээр байршуулж, түүнээс олсон хөрөнгө оруулалтын олз нь ашгийг бий болгогч томоохон хүчин зүйл болдог. Өөрөөр хэлбэл, даатгагч нь ихэнх тохиолдолд орлогод тооцсон хураамжаас үйл ажиллагааны зардлаа барагдуулж, харин хөрөнгө оруулалтын орлогоор ашиг олдог байна.

Үнэт цаас гаргагч нь байгуулсан нөөц сан болон хувь нийлүүлсэн хөрөнгийг СЗХ-ны 2013 оны 07 сарын 17-ны өдрийн 250 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага"-ын дагуу түлхүү арилжааны банкны хадгаламж, Засгийн газрын үнэт цаас болон компанид бондод байршуулан удирдаж байна.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС

2017 оны эцсийн байдлаар Үнэт цаас гаргагч нь нийт 9.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг арилжааны банкны хадгаламж болон үнэт цаасанд байршуулсан ба энэ нь өнгөрсөн оны мөн үеэс 2.8 дахин өссөн үзүүлэлт юм. 2017 оны нийт хөрөнгө оруулалтын 91%-ийг буюу 8.4 тэрбум төгрөгийг банк санхүүгийн байгууллагад буюу хадгаламж, хадгаламжийн сертификатад байршуулсан байна. Үлдсэн 9%-ийг буюу 813 сая төгрөгийг Засгийн газрын үнэт цаас, "Сүү Бонд", "Монголиан Мортгэйж Фанд ББСБ" ХХК-ийн бондод байршуулжээ.

*График 26. Хөрөнгө оруулалтын задаргаа 2013-2017*




*График 25. Хөрөнгө оруулалтын задаргаа 2013-2017*




Үнэт цаас гаргагчийн мөнгөн хөрөнгө, хөрөнгө оруулалтын үлдэгдлийг сүүлийн 3 жилээр харвал:

| № | Үзүүлэлт *(сая төгрөг)* | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|
| 1 | *Бэлэн мөнгө* | *13* | *8* | *10* |
| 2 | *Банкинд дах мөнгөн хөрөнгө (хүүгийн авлагын хамт)* | *5,217* | *6,469* | *8,634* |
| 3 | *Засгийн газрын бонд (хүүгийн авлагын хамт)* | *513* | - | *1,137* |
| 4 | *Компанийн бонд (хүүгийн авлагын хамт)* | *1* | - | *553* |
| 5 | *Банк бус санхүүгийн байгууллага дах мөнгөн хөрөнгө* | *450* | *500* | *700* |
| 6 | *Үл хөдлөх хөрөнгөөрх хөрөнгө оруулалт* | *110* | *237* | *237* |
| | ***Нийт*** | ***6,304*** | ***7,214*** | ***11,271*** |

2013-2017 оны хөрөнгө оруулалтын орлогын жилийн дундаж өсөлт 8.5% байсан ба 2017 онд 23% өсөж 1.3 тэрбум төгрөг хүрчээ.

*График 27. Хөрөнгө оруулалтын өгөөж 2013-2017*






Огноо: 2018/04/16

СЗХ он сар өдөр 2018.08.29 № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭВ 01 ..... он .... сар .... өдөр

Хөрөнгө оруулалтын орлогыг сүүлийн 3 жилээр харвал:

| № | Үзүүлэлт (сая төгрөг) | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|
| 1 | Банкин дах харилцах дансны хүүгийн орлого | 8 | 23 | 28 |
| 2 | Банкин дах хадгаламж, хадгаламжийн сертификатын дансны хүүгийн орлого | 870 | 724 | 766 |
| 3 | Засгийн газрын бондын хүүгийн орлого | 70 | 37 | 234 |
| 4 | Компанийн бондын хүүгийн орлого | - | - | 39 |
| 5 | Банк бус санхүүгийн байгууллагын хүүгийн орлого | 35 | 106 | 129 |
| 6 | Бусад хөрөнгө оруулалтын орлого | - | 127 | 60 |
| | **Нийт** | **983** | **1,017** | **1,255** |

## 1.11. Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө, биет болон биет бус хөрөнгө

"Улаанбаатар Аудит Корпораци" ХХК нь 2013 оны 02 сарын 27-ны өдөр СЗХ-ны 70 тоот тогтоолоор авсан "Үнэт цаас зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд 2018 оны 03 сарын 20-ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2018/29 тоот "Аудитын үйлчилгээний нэмэлт гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгох үйл ажиллагаанд аудитын байгууллагын үүргийг гүйцэтгэсэн. "Улаанбаатар Аудит Корпораци" ХХК-ийн гүйцэтгэсэн аудитын тайланд тусгаснаар 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгө нь 6,000,892 мянган төгрөг байна. Үүнээс хувьцаат капитал 6,243,016 мянган төгрөг, халаасны хувьцаа 1,243,016 мянган төгрөг, хуримтлагдсан ашиг 1,000,892 мянган төгрөг байна.

Мөн энэхүү тайланд тусгаснаар Үнэт цаас гаргагч нь нийт 582,921 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй ба үүнээс 288,956 мянган төгрөг нь үндсэн хөрөнгө, 57,325 мянган төгрөг нь биет бус хөрөнгө, 236,640 мянган төгрөг нь хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө байна.

"БДО Аудит" ХХК нь 2014 оны 01 сарын 29-ний өдөр СЗХ-ны 22 тоот тогтоолоор авсан "Үнэт цаас зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд 2018 оны 02 сарын 20-ний өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2018-Ү1 тоот "Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгох үйл ажиллагаанд үнэлгээний компаниар оролцож байгаа болно. Тус үнэлгээний компанийн 2017 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаарх "Хөрөнгийн үнэлгээний тайлан"-д тусгаснаар Үнэт цаас гаргагч нь нийт 622,352.7 мянган төгрөгийн эргэлтийн бус хөрөнгөтэй байна. Үүнд тээврийн хэрэгсэл, конторын тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, тооцоолох техник, програм хангамж, борлуулах зориулалтаар эзэмшиж буй орон сууц болон бусад үндсэн хөрөнгө орсон ба энэхүү үнэлгээг "Хөрөнгийн үнэлгээний тухай" хууль болон Олон улсын үнэлгээний стандартад заасны дагуу гүйцэтгэсэн болно.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК

МОНГОЛ УЛС GOLOMT ... LLC

| мянган төгрөг | Үнэлгээний өдрөөрх дансны үнэ | Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ | Ашигласан арга, хандлага |
|---|---|---|---|
| *Борлуулах зориулалтаар эзэмшиж байгаа орон сууц* | *236,640.0* | *249,864.0* | *Зах зээлийн хандлага* |
| *Үндсэн хөрөнгө* | | | |
| *Тээврийн хэрэгсэл* | *78,166.5* | *71,733.0* | *Зах зээлийн хандлага* |
| *Конторын тоног төхөөрөмж* | *13,606.8* | *13,606.8* | *Өртгийн хандлага* |
| *Тавилга эд хогшил* | *103,797.4* | *103,797.4* | *Өртгийн хандлага* |
| *Тооцоолох техник* | *67,123.9* | *67,123.9* | *Өртгийн хандлага* |
| *Бусад үндсэн хөрөнгө* | *26,261.5* | *19,627.6* | *Өртгийн хандлага* |
| *Биет бус хөрөнгө* | | | |
| *Программ хангамж* | *57,325.3* | *96,600.0* | *Өртгийн хандлага* |
| ***Эргэлтийн бус хөрөнгө*** | ***582,921.3*** | ***622,352.7*** | |

Хөрөнгийн үнэлгээний тайланд тусгаснаар үнэт цаас гаргагчийн эргэлтийн бус хөрөнгийг задаргаа нь дараах байдалтай байна. Үүнд:

**Борлуулах зориулалтаар эзэмшиж байгаа орон сууц**

| Хаяг | ҮХХ-ийн өмчлөгчийн нэр, Регистрийн дугаар | ҮХХ-ийн гэрчилгээний дугаар | Эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо, дугаар | Талбайн хэмжээ |
|---|---|---|---|---|
| *ХУД, 11-р хороо, Маршал таун хотхон, 102-р байрны 17 тоо* | *Мандал даатгал ХХК Регистрийн дугаар: 547389* | *000107249* | *Ү2013-2206014229 /06/10* | *116 кв.м* |

**Тээврийн хэрэгсэл**

| Хөрөнгийн нэр | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Ашиглалтад орсон огноо | Дансны үнэ | Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ |
|---|---|---|---|---|---|
| *Автомашин - 15-21 УНҮ PRIUS* | *1* | *19,850,000* | *2014/01/23* | *13,241,098* | *7,443,000* |
| *Автомашин 76-86 УНО PRIUS20* | *1* | *15,677,176* | *2011/09/05* | *6,519,160* | *8,800,000* |
| *Автомашин 43-02 УНН Lexus* | *1* | *82,922,537* | *2011/07/01* | *38,953,099* | *36,000,000* |
| *Yamaha маркийн Tricity загварын мотоцикл Гурван дугуйт-УБ 05-63 (цагаан)* | *1* | *6,828,625* | *2017/06/15* | *6,484,387* | *6,500,000* |
| *Yamaha маркийн Tricity загварын мотоцикл Гурван дугуйт- УБ 03-95 (хар)* | *1* | *6,828,625* | *2017/06/15* | *6,484,387* | *6,500,000* |
| *Yamaha маркийн Tricity загварын мотоцикл* | *1* | *6,828,625* | *2017/06/15* | *6,484,387* | *6,500,000* |

| | | |
|---|---|---|
| *Үнэт цаасны танилцуулга Гурван дугуйт- УБ 03-34 (улаан)* | | |
| ***Нийт дүн*** | ***78,166,518*** | ***71,733,000*** |

**Биет бус хөрөнгө: Программ хангамж**

| Хөрөнгийн нэр | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Ашиглалтанд орсон огноо | Дансны үнэ | Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ |
|---|---|---|---|---|---|
| *Даатгал, санхүүгийн цогц програм (Heavenpro)* | *1* | *118,290,000* | *2015/12/31* | *52,175,735* | *86,300,000* |
| *Даатгуулагчийн эрсдэлийн үнэлгээний програм хангамж* | *1* | *5,500,000* | *2016/12/01* | *3,666,667* | *4,200,000* |
| *Актив дэриактари (Active Directory)* | *1* | *11,558,296* | *2015/03/12* | *2,977,052* | *6,100,000* |
| ***Нийт дүн*** | | ***156,743,704*** | | ***57,325,354*** | ***96,600,000*** |

## 1.12. Үнэт цаас гаргагчийн санхүү тайлан, шинжилгээ

### *1.12.1. Орлогын тайлан*

| | *2014* | *2015* | *2016* | *2017* |
|---|---|---|---|---|
| ***Нийт хураамжийн орлого*** | ***8,035*** | ***9,184*** | ***13,093*** | ***22,533*** |
| *Даатгалын хураамжийн буцаалт* | *(204)* | *(230)* | *(973)* | *(1,208)* |
| *Давхар даатгалын хураамжийн зардал* | *(4,421)* | *(5,784)* | *(7,419)* | *(11,244)* |
| ***Цэвэр хураамжийн орлого*** | ***3,409*** | ***3,170*** | ***4,701*** | ***10,081*** |
| *ОТХНС-ийн өөрчлөлт* | *(7)* | *(400)* | *5,255* | *1,893* |
| *Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт* | *-* | *-* | *(4,771)* | *1,145* |
| ***ОРЛОГОД ТООЦСОН ХУРААМЖ*** | ***3,402*** | ***2,770*** | ***4,217*** | ***7,043*** |
| *Нийт нөхөн төлбөрийн зардал* | *1,323* | *1,121* | *4,116* | *4,706* |
| *Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр* | *(248)* | *-* | *(2,115)* | *(2,534)* |
| *Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр* | *-* | *(154)* | *(111)* | *(98)* |
| ***Нөхөн төлбөрийн цэвэр зардал*** | ***1,075*** | ***967*** | ***1,891*** | ***2,074*** |
| *Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт* | *1,348* | *(53)* | *239* | *444* |
| *НТНС-ийн ДД-д ногдох хэсгийн өөрчлөлт* | *-* | *-* | *(335)* | *(380)* |
| *УБХНС-ийн өөрчлөлт* | *(187)* | *357* | *236* | *243* |
| ***Зардалд тооцсон нөхөн төлбөр*** | ***2,235*** | ***1,271*** | ***2,030*** | ***2,381*** |
| *Даатгалын гэрээний зардал* | *(153)* | *(731)* | *(1,121)* | *(1,204)* |
| *Давхар даатгалын шимтгэлийн орлого* | *239* | *1,732* | *1,271* | *925* |
| *Хөрөнгө оруулалтын олз, гарз* | *885* | *975* | *994* | *1,227* |
| ***Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)*** | ***2,139*** | ***3,476*** | ***3,330*** | ***5,610*** |
| *Түрээсийн орлого* | *-* | *-* | *-* | *-* |
| *Хүү, эрхийн шимтгэлийн орлого* | *-* | *8* | *23* | *28* |
| *Бусад орлого* | *250* | *13* | *27* | *63* |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Ерөнхий ба удирдлагын зардал | (1,934) | (2,498) | (2,686) | (3,555) |
| Борлуулалт, маркетингийн зардал | (178) | (422) | (456) | (485) |
| Санхүүгийн зардал | - | - | - | - |
| Бусад зардал | (461) | (39) | (5) | (417) |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | 49 | (15) | (62) | 28 |
| Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | (15) | - | (8) |
| Бусад ашиг (алдагдал) | (20) | - | - | - |
| **Татварын өмнөх ашиг (алдагдал)** | **(155)** | **508** | **171** | **1,265** |
| Татварын зардал | (87) | (91) | (85) | (163) |
| **ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)** | **(243)** | **417** | **85** | **1,103** |

## 1.12.2. Санхүү байдлын тайлан

| | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 208 | 1,966 | 3,720 | 1,805 |
| Даатгалын авлага | 738 | 2,056 | 3,350 | 4,402 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 1,391 | 373 | 445 | 401 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 414 | 99 | 190 | 182 |
| Хөрөнгө оруулалт | 6,112 | 4,228 | 3,258 | 9,229 |
| Хадгаламж, хадгаламжийн сертификат | 5,630 | 3,715 | 3,258 | 8,417 |
| Үнэт цаас /цэвэр/ | 482 | 513 | - | 813 |
| Даатгалын хөрөнгө | - | 469 | 5,711 | 4,869 |
| ДД-ын хойшлогдсон хураамж | - | - | 4,771 | 3,626 |
| Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг | - | - | 335 | 715 |
| Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал | - | 469 | 606 | 528 |
| Үндсэн хөрөнгө /Цэвэр/ | 370 | 387 | 294 | 289 |
| Биет бус хөрөнгө /Цэвэр/ | 7 | 109 | 105 | 57 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 150 | 110 | 237 | 237 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **9,390** | **9,797** | **17,309** | **21,472** |
| Даатгалын өглөг | 1,140 | 318 | 2,037 | 2,055 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 41 | - | - | - |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 549 | 698 | 677 | 1,139 |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөц | - | 2,218 | 7,473 | 9,366 |
| Нөхөн төлбөрийн нөөц сан | 3,264 | 1,749 | 2,224 | 2,911 |
| Учирсан болович мэдэгдээгүй ХНС | - | 182 | 287 | 334 |
| Мэдсэн болович төлөөгүй ХНС | - | 172 | 305 | 702 |
| Учирч болзошгүй ХНС | - | 140 | 375 | 618 |
| Тусгай нөөц сан | - | 1,256 | 1,256 | 1,256 |
| **Нийт өр төлбөр** | **4,994** | **4,984** | **12,411** | **15,471** |
| Эзэмшигчдийн өмч | 5,000 | 6,243 | 6,243 | 6,243 |
| Халаасны хувьцаа | - | (1,243) | (1,243) | (1,243) |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | (604) | (187) | (102) | 1,001 |
| **Нийт эздийн өмч** | **4,396** | **4,813** | **4,898** | **6,001** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **9,390** | **9,797** | **17,309** | **21,472** |

- Үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулалтын хэмжээ өмнөх оны мөн үеэс 2.8 дахин өссөн ба нийт хөрөнгийн 43.0%-ийг бүрдүүлж байна.



Огноо: 2018/04/16

СЗХ
2018 08 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

- 2017 оны жилийн эцсийн байдлаар, Үнэт цаас гаргагч нь 582.9 сая төгрөгийн биет болон биет бус хөрөнгөтэй байсан ба энэ нь нийт хөрөнгийн 3%-ийг бүрдүүлж байна. Даатгалын салбарын хэмжээнд, биет болон биет бус хөрөнгө нийт хөрөнгийн 13.4% байдаг байна. Энэ нь даатгалын байгууллага санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг буюу үйлдвэрлэл эрхэлдэггүй, үйл ажиллагаанд зөвхөн ажилчдын байр, эд хогшил болон програм хангамж шаардлагатай байдагтай холбоотой юм.
- Өрийн харьцаа өнгөрсөн оны мөн үетэй ижил түвшинд буюу 0.72-тай гарсан. Үнэт цаас гаргагч нь зээлгүй бөгөөд өр төлбөрийн 60.5%-ийг орлогод тооцоогүй хураамжийн нөөц сан, 18.8%-ийг нөхөн төлбөрийн нөөц сан (УБМХНС, МБТХНС, УБХНС, ТНС) эзэлж байгаа буюу нийт 79.4%-ийг нөөц сан бүрдүүлж байна. Энэ нь даатгалын байгууллага нь нөхөн төлбөрийн тохиолдол үүсэхэд хангалттай нөөц сан шаардлагатай байдагт мөн уг санг нийт хураамжийн орлогоос байгуулдагтай холбоотой юм.
- 2017 онд 1.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай гарсантай холбоотойгоор Үнэт цаас гаргагч нь анх удаа хуримлагдсан ашигтай гарчээ.

### 1.12.3. Санхүүгийн шинжилгээ

| | Дундаж | 2014 | 2015 | 2016 | 2017 | Салбар |
|---|---|---|---|---|---|---|
| НХО өсөлт | 35% | 10% | 14% | 43% | 72% | 26% |
| ОТХ өсөлт | 17% | -31% | -19% | 52% | 67% | 23% |
| Хөрөнгө оруулалтын орлогын өсөлт | 10% | 6% | 10% | 2% | 23% | 34% |
| Цэвэр ашиг өсөлт | | - | - | -80% | 1193% | 11% |
| | | | | | | |
| Бохир маржин (ОТХ/НХО) | 34% | 42% | 30% | 32% | 31% | 57% |
| Цэвэр маржин (Цэвэр ашиг/ОТХ) | 6% | -7% | 15% | 2% | 16% | 11% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 6% | -6% | 9% | 2% | 18% | 11% |
| Нийт активийн өгөөж | 2% | -3% | 4% | 0.5% | 5% | 4% |
| | | | | | | |
| Хохирлын харьцаа (Цэвэр нөхөн төлбөр/ОТХ) | 35% | 32% | 35% | 45% | 29% | 38% |
| Зардлын харьцаа (Ү/а зардал/ОТХ) | 80% | 76% | 107% | 75% | 63% | 23% |
| Нийлмэл харьцаа (Хохирлын харьцаа+зардлын харьцаа) | 115% | 107% | 142% | 119% | 93% | 61% |

*Эх сурвалж: Мандал Даатгал ХХК, СЗХ, Монголын Даатгагчдын Холбоо*

- 2017 онд Үнэт цаас гаргагчийн нийт хураамжийн орлого 72% өссөн ба энэ нь барилга угсралтын даатгалын орлого 36.8 дахин, эрүүл мэндийн даатгал 3.0 дахин, гэнэтийн ослын даатгал 2.7 дахин өссөнтэй холбоотой юм. Үнэт цаас гаргагч нь 2017 онд Оюу Толгой ХХК-ийн барилга угсралтын сонгон шалгаруулалтад шалгарсан нь барилга угсралтын даатгалын өсөлтөд нөлөөлсөн байна. Эрүүл мэндийн даатгалын өсөлтөд дотоодын томоохон аж ахуйн нэгжүүд ажилтнуудаа "Жаргалан" эрүүл мэндийн даатгалд хамруулсан нь нөлөөлжээ.
- Орлогод тооцсон хураамж 67% өссөн нь 2017 оны 07 сарын 01-ээс давхар даатгалын гэрээний нөхцөлийг Excess of Loss[5] болгож өөрчилсөнтэй холбоотой юм. Ингэснээр, үнэт цаас гаргагч нь давхар даатгагчид зөвхөн 50,000-2,950,000 ам.долларын үнэлгээтэй эрсдэлийг шилжүүлж 50,000 ам.доллар буюу 122 сая төгрөг хүртэлх эрсдэлийг өөрөө даадаг болсон байна.
- Давхар даатгалын хураамжийн зардал буурснаар мөнгөн хөрөнгийн хэмжээ өсөж, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэн, улмаар хөрөнгө оруулалтын орлого өмнөх оны мөн үеэс 23% өссөн байна.

[5] Давхар даатгалын төрлийн тухай тайлбарыг энэхүү танилцуулгын 1.10.1 хэсгээс харна уу.

GOLOMT CAPITAL LLC

2018.08.29

- **Дээрх давхар даатгалын нөхцөлийн өөрчлөлт нь цэвэр ашгийг 324 сая төгрөгөөр нэмэгдүүлж өнгөрсөн онд цэвэр ашиг 13.0 дахин өсөж, цэвэр ашгийн маржин 2%-иас 16%, өөрийн хөрөнгийн өгөөж 2%-иас 18%, нийт активийн өгөөж 0.5%-иас 5% болж өссөн байна.**
- Хохирлын харьцаа 29% болж буурсан нь цэвэр нөхөн төлбөрийн хэмжээ 10% өссөн ч орлогод тооцсон хураамж 67%-р өссөнтэй холбоотой юм. Мөн зардлын харьцаа 63% хүрсэн нь үйл ажиллагаа зардал 42% өссөн ч ОТХ илүү хурдацтай өссөн нь нөлөөлжээ. Ингэснээр, үнэт цаас гаргагчийн нийлмэл харьцаа 93% хүрч, үүсгэн байгуулагдсан цагаас хойш анх удаа 100%-иас бага гарлаа. Нийлмэл харьцаа 100%-иас бага гарвал, даатгалын бизнес ашигтай ажиллаж байгааг, 100%-иас их гарвал ашиггүй ажиллаж байгааг илэрхийлдэг.
- 2017 оны санхүүгийн харьцаанаас дүгнэхэд, давхар даатгалын нөхцөлийн өөрчлөлт нь компанид богино хугацаанд эерэг нөлөөг авчирсан байна. Цаашид өөрийн хувьцаат капиталыг нэмэгдүүлснээр эрсдэл даах чадвар сайжирч улмаар давхар даатгалын хураамжийн хэмжээг өнөөгийн түвшнээс бууруулах боломж бүрдэх юм. Ингэснээр зардал буурч, эргэлдэх мөнгөн хөрөнгө нэмэгдэж, хөрөнгө оруулалтын орлого нэмэгдэх, цэвэр ашиг өсөх, зах зээлд эзлэх байр суурь дээшлэх гэх мэт олон давуу талтай байна.
- 2017 онд Үнэт цаас гаргагч нь санхүүгийн зарим үзүүлэлтүүдээр салбарын дунджаас илүү ажиллаж чадсан байна. Тухайлбал, салбарын нийт хураамжийн орлогын дундаж өсөлт 26% байхад Үнэт цаас гаргагчийн өсөлт 72% байв. Мөн салбарын дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 11% байхад, үнэт цаас гаргагч 18%-ийн өгөөжтэй ажиллажээ.



















МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC

СЗХ
он 2018 сар 08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

## 1.13. Эрсдэлийн хүчин зүйлс, удирдлага

### *1.13.1. Даатгалын эрсдэл*

**Андеррайтингийн үйл ажиллагаа, актуар тооцоолол**

Даатгал нь учирч болзошгүй тааламжгүй үйл явдлын эрсдэлийг бууруулах, учирч болох хохирлыг богино хугацаанд арилгах зорилготой даатгуулагчдын хураамжаар сан бүрдүүлж уг сангаас хохирол учирсан нэгэнд нөхөн төлбөр олгож эрсдэлийг даван туулахад нь тусалдаг санхүүгийн хэрэгсэл юм. Даатгуулагчид аливаа гэнэтийн эрсдэл тохиолдоход хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэхийн тулд даатгалын санг зөв бүрдүүлэх, эрсдэл учрах нь 100% тодорхой тохиолдлыг даатгахгүй байх зарчмыг баримталж ажиллах үүргийг хүлээдэг.

Иймд даатгалын гэрээгээр харилцагчийн өмнө хүлээж буй үүрэг нь даатгалын зарчимд нийцэж буй эсэх, харилцагчийн эрсдэлд тохирсон хураамжийг тооцоолж даатгалын тохиолдол үүсэхэд нөхөн төлбөр олгоход хангалттай нөөц сан бүрдүүлж буй эсэх нь даатгалын үндсэн үйл ажиллагааны гол эрсдэл юм.

Үнэт цаас гаргагчийн даатгалын үйл ажиллагааны эрсдэлийг Даатгалын бодлогын хэлтэс хариуцан ажилладаг бөгөөд уг хэлтэст андеррайтинг, актуар тооцоолол, давхар даатгалын үйл ажиллагаа харьяалагддаг.

Андеррайтингийн үйл ажиллагаа нь даатгуулагчтай байгуулж буй даатгалын гэрээгээр ямар эрсдэлүүд хамрагдах, хамрагдахгүйг олон улсын даатгалын гэрээний стандартын дагуу даатгуулагчид ойлгомжтой байдлаар боловсруулахад чиглэдэг. Мөн даатгуулагчийн эрсдэлд тохирсон нэмэлт хамгаалалт, харилцагчийн онцлогт тохирсон андеррайтингийн үйлчилгээг актуарч болон давхар даатгагчийн судалгаа, зөвлөгөөгөөр хамтран боловсруулдаг.

**Даатгалын багцын эрсдэл**

Даатгалын компани нь худалдаа үйлчилгээний компаниуд болон бусад санхүүгийн байгууллагуудын адил олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон төрлийн зах зээлд зориулж гарган багцын эрсдэлээ бууруулахад анхаардаг. Даатгалын багцын эрсдэлийг актуарч хариуцан ажилладаг бөгөөд даатгалын төрлийг нэмэгдүүлэх, шинээр бүтээгдэхүүн хөгжүүлж зах зээлд нэвтрүүлэх ажлыг байгууллагын даатгал болон иргэдийн даатгалын бизнес хөгжил хариуцсан менежерүүд хариуцдаг.

Мөн эрсдэлийн албаны шинжээч нар даатгалын багцын судалгаа хийж Удирдлагын хорооны хуралд улирал бүр танилцуулж, хорооноос өгсөн чиглэлийн дагуу багцын үзүүлэлтийг сайжруулах ажлуудыг хийж хэрэгжүүлдэг.

**Давхар даатгал**

Даатгалын компани нь харилцагчаас өөртөө шилжүүлэн авсан эрсдэлийг бүтнээр нь болон тодорхой хэсгийг нь давхар даатгалд шилжүүлж эрсдэлийг тараан байршуулдаг. Ялангуяа өөрийн хөрөнгө буюу даатгалын компанийн эрсдэл даах чадвараас өндөр үнэлгээ бүхий томоохон эд хөрөнгө, хариуцлагыг даатгах үед давхар даатгалыг зайлшгүй ашиглах шаардлага үүсдэг. Үнэт цаас гаргагч нь 2014 онд анх хувь оролцооны /variable quota share/ багцын давхар даатгалын гэрээ байгуулж 2017 оны 2-р хагаст excess of loss багцын давхар даатгалд шилжсэн. Уг давхар даатгалын гэрээний нөхцөлөөр 50,000 ам.доллараас бага дүнтэй нөхөн төлбөрийг Үнэт цаас гаргагч өөрөө хариуцаж, 50,000-3,000,000 ам долларын нөхөн төлбөрийг давхар даатгагчаас төлүүлэх бөгөөд харилцагчтай байгуулж буй бүх төрлийн даатгалын гэрээнүүд давхар даатгалд хамрагдсан байна. 3,000,000 ам.доллараас дээш үнэлгээ бүхий томоохон даатгалуудыг тухай бүрд нь давхар даатгагчтай тохиролцож факултатив хэлбэрээр давхар даатгалд хамруулдаг.

МАНДАЛ даатгал
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Давхар даатгалд эрсдэлээ шилжүүлэхтэй холбоотойгоор үүсдэг нэг эрсдэл нь давхар даатгагчтай байгуулж буй гэрээ болон даатгуулагчтай байгуулж буй гэрээний зөрүү юм. Даатгуулагчтай байгуулсан гэрээнд заасан даатгалын хамгаалалтаа давхар даатгагчтай байгуулсан гэрээнд тусгалгүй орхигдуулснаар эрсдэл учрахад нөхөн төлбөрийг даатгагч өөрийн нөөц сангаас бүрэн төлөх эрсдэл учирдаг. Үнэт цаас гаргагч нь давхар даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө андеррайтер, давхар даатгалын мэргэжилтэн, даатгалын менежер зэрэг ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр гэрээний зөрүү гарсан эсэхийг шалгаж уг эрсдэлээс сэргийлдэг.

**Нөхөн төлбөр шийдвэрлэлт**

Даатгалын үйл ажиллагааны бусад бизнесээс онцлогтой нь ёс зүйн гажуудал /moral hazard/-ын асуудал үүсэх магадлал хамгийн өндөртэй санхүүгийн салбар юм. Даатгалын тохиолдлыг зориудаар бий болгох эсвэл хуурамч баримт материал бүрдүүлж нөхөн төлбөр авах оролдлого хийх үзэгдэл аль ч улс оронд байдаг. Иймд, даатгалын тохиолдол буюу ослыг шалгаж, даатгалын нөөц санг гэнэтийн осолд өртсөн даатгуулагчдад зарцуулах, залилангийн шинжтэй нөхөн төлбөрт зарцуулахгүй байхад анхаарч ажилладаг.

Нөхөн төлбөр шийдвэрлэлтийн процессын хувьд, үнэт цаас гаргагч нь нөхөн төлбөрийн материалуудыг тохиолдлын шинж тэмдгээс нь хамааруулж оноо өгөн тодорхой ба эргэлзээтэй ангилалд хуваарилж эргэлзээтэй материалууд болон өндөр үнийн дүнтэй нөхөн төлбөрийн материалуудыг Нөхөн төлбөрийн дэд хороогоор шийдвэрлүүлдэг. Мөн эргэлзээтэй ослын тохиолдлуудыг магадлахын тулд Замын цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Ус цаг уур орчны шинжилгээний хүрээлэн гэх мэт мэргэжлийн байгууллагууд, экспертүүдтэй хамтран ажиллаж, нөхөн төлбөрийн мэргэжилтнүүдээ чадавхжуулахад анхаардаг.

## 1.13.2. Бизнесийн эрсдэл

**Эдийн засгийн байдлаас хамаарсан эрсдэл**

Даатгалын салбар нь макро эдийн засгийн байдалтай шууд хамааралтай байдаг. Ялангуяа байгууллагын даатгал нь эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг. Эдийн засгийн идэвхжил сулрахад төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа суларч түүнийг дагасан даатгалын үйл ажиллагаа мөн буурч, нөгөө талаар аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгийн урсгал буурдагтай холбоотойгоор даатгалдаа зарцуулах зардал нь буурах хандлагатай байдаг. Иргэдийн зах зээлийн хувьд эдийн засгийн уналтын үед даатгуулах хандлага нь төдийлөн буурдаггүй, тогтвортой байдаг. Монгол Улсын даатгалын салбарын нийт хураамжийн орлогын 70 орчим хувийг байгууллагын даатгал бүрдүүлдэг тул эдийн засгийн уналтад мэдрэг байдаг. Үнэт цаас гаргагч нь макро эдийн засгийн эрсдэлд өртөмтгий байдлыг бууруулахын тулд иргэдийн даатгалын зах зээлийг тэлэх, иргэд болон байгууллагын даатгалын балансаа хангахад анхаарч ажилладаг. Иргэдийн даатгалын зах зээлд чиглэсэн "Сонголт" тээврийн хэрэгслийн даатгал, "Жаргалан" эрүүл мэндийн даатгал, банкуудаар дамжуулан борлуулж буй даатгалууд амжилттай борлуулагдаж, тогтвортой орлогын суурийг бэхжүүлж байгаа бөгөөд цаашид илүү олон төрлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

**Хууль эрх зүйн орчинтой холбоотой эрсдэл**

Даатгалын үйл ажиллагаа нь СЗХ-оос гаргасан дүрэм, журмуудын хүрээнд нарийн зохицуулалттай явагддаг санхүүгийн үйлчилгээ юм. Ялангуяа нөөцийн сан байгуулах, мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулах үйл ажиллагаа нь зохицуулагч байгууллагын дүрэм журмуудаар хязгаарлагддаг. Тухайлбал, даатгалын компаниудын дүрмийн сангийн доод хэмжээг 5 тэрбум төгрөг болгож нэмэгдүүлэх тухай журам 2018 оны 7 сарын 1-ээс хэрэгжиж эхэлнэ. Үнэт цаас гаргагчийн хувьд, уг шаардлагыг 3 жилийн өмнөөс биелүүлээд байна.

Мөн бизнесийн үйл ажиллагаанд шууд бусаар нөлөөлөх хууль эрхзүйн зохицуулалтын эрсдэлүүд үүсдэг. Тухайлбал, осолд холбогдсон жолооч нар гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол даатгуулагчаас цагдаагийн тодорхойлолт шаардахгүйгээр нөхөн төлбөр олгодог байх тогтоол гарснаар зам тээврийн ослыг баталгаажуулахад хүндрэл үүсэж шуурхай дуудлагын хүчин чадлаа нэмэгдүүлэх шаардлагатай тулгарсан байна. Нөгөөтэйгүүр, Зөрчлийн тухай хуулиар зам тээврийн дүрэм зөрчсөн жолоочийг торгодог болсон нь осолд холбогдсон жолооч нар даатгалын компанид дуудлага өгөхгүйгээр хоорондоо тохиролцох, үүнийг олон нийтэд буруугаар ойлгуулж даатгалын компаниудын нэр хүндэд халдах тохиолдлууд гарч байна.

**Өрсөлдөөнтэй холбоотой эрсдэл**

Даатгалын зах зээл нь одоогоор нэвтрэл бага байгаа хэдий ч байгууллагын даатгалын зах зээлд үнийн өрсөлдөөн явагдах хандлагатай байдаг. Үнэт цаас гаргагчийн байгууллагын даатгалын зах зээлд үйлчилгээгээр ялгарах, харилцагчийн эрсдэлийн боловсролыг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн сургалт зөвлөгөөг харилцагчдад өгч урт хугацааны хамтын ажиллагааг бий болгох, үнэнч харилцагчдын бааз суурийг бэхжүүлэхэд анхаарч ажилладаг.

Байгууллагын харилцагчдад эрсдэлийн мэдээлэл хүргэх, эрсдэлийг даван туулсан туршлагаас хуваалцдаг "Монгол Улсын эрсдэлийн удирдлагын форум"-ыг 2011 оноос хойш жил бүр тасралтгүй зохион байгуулж байна.

**Валютын ханшийн эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь давхар даатгалын төлбөр тооцоо болон гадаадын улс оронд тохиолдсон зарим ослын нөхөн төлбөрийг валютаар гүйцэтгэдэг тул ханшийн эрсдэл нь боломжит эрсдэлүүдийн нэг юм.

Трийти давхар даатгалын төлбөрийг төгрөгөөр гүйцэтгэдэг тул ханшийн эрсдэл үүсдэггүй ч факултатив хэлбэрийн давхар даатгалын төлбөрийн харилцагч болон давхар даатгагчтай тухай бүр төгрөг эсвэл валютаар төлбөр хийх эсэхийг харилцан тохиролцдог ба уг гэрээний төлбөрийг харилцагчаас хураамж шилжиж ирсэн даруйд давхар даатгагч руу шилжүүлэх бодлого барьдаг тул мөн валютын ханшийн зөрүү үүсдэггүй.

**Зээл, хадгаламжийн хүүгийн эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь зээлийн хөрөнгөөр эх үүсвэрээ бүрдүүлдэггүй тул зээлийн хүү өсөх нь үйл ажиллагаанд шууд нөлөөлөхгүй юм. Үнэт цаас гаргагч нь харилцагчдын хураамжийн орлого, нөөцийн сангийн ихэнх хувийг банканд хадгалуулж өгөөж хүртдэг тул хадгаламжийн хүү буурах нь хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулах эрсдэлтэй. Уг эрсдэлийг бууруулахын тулд үнэт цаас гаргагч нь 2017 оноос "Хөрөнгө оруулалтын дэд хороо"-г байгуулан СЗХ-оос баталсан даатгалын компанийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны журмын хүрээнд мөнгөн хөрөнгийнхөө тодорхой хэсгийг бусад санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулж өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарч байна.

**Хөрвөх чадварын эрсдэл**

Томоохон даатгалын тохиолдол үүсэхэд нөхөн төлбөр төлөх бэлэн мөнгөний нөөцгүй байх нь даатгалын компанийн боломжит эрсдэл юм. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөө богино хугацаат хадгаламжаар өөр өөр банкуудад ялгаатай дуусах хугацаатайгаар байршуулж уг эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгадаг.

Мөн 300 сая орчим төгрөгийг өдөр бүр харилцах дансандаа байршуулж харилцагчдын нөхөн төлбөрийг хугацаа алдалгүйгээр төлөхийг зорьж ажилладаг.

**Үйл ажиллагааны эрсдэл**

Бизнесийн үйл ажиллагааны процессын аль нэг хэсэгт доголдол гарсны улмаас үйл ажиллагаа доголдох, санхүүгийн хохирол учрах, компанийн нэр хүнд унах нь аливаа бизнесийн байгууллагад тохиолддог гол эрсдэл юм. Үнэт цаас гаргагч нь 2017 онд хуучин Эрсдэлийн хэлтсийг татан

буулгаж, даатгалын эрсдэлийг Даатгалын бодлогын хэлтэст шилжүүлж, Эрсдэлийн албыг шинээр байгуулан үйл ажиллагааны эрсдэлийг уг албанд хариуцуулсан байна. Эрсдэлийн албанд дотоод аудиторын албан тушаалыг шинээр бий болгож өдөр тутмын үйл ажиллагааны процесст хяналт тавих, илэрсэн доголдлыг цаг алдалгүй засаж сайжруулах ажлыг гүйцэтгэн ажиллаж байна.

Мөн удирдлагын хорооны дэргэдэх "Дотоод хяналтын дэд хороо" дотоод хяналтын ажлыг тогтмол хугацаанд хийж Удирдлагын хороонд танилцуулдаг.

**Нэр хүндийн эрсдэл**

Даатгалын салбар нь нэр хүндийн эрсдэлд өртөх магадлал өндөртэй салбар юм. Иргэдийн даатгалын талаарх мэдлэг дутмаг, даатгалын гэрээний нөхцөлүүдтэй сайн танилцдаггүй, нөгөө талаас даатгалын компанийн зүгээс даатгуулагчдад гэрээ болон үйлчилгээний нөхцөлүүдийг сайн тайлбарлаж ойлгуулдаггүйгээс нөхөн төлбөрийн тохиолдол үүсэхэд баримтжуулалт сайн хийгддэггүй, даатгалын компанид мэдэгддэггүй, зарим тохиолдолд даатгалын гэрээнд хамрагдаагүйн улмаас нөхөн төлбөр авахаар материал бүрдүүлэх үед даатгалын компаниас нөхөн төлбөрийг олгохоос татгалздаг. Эдгээр үл ойлголцлоос даатгуулагч даатгалын компанид сэтгэл хангалуун бус байх, улмаар уг сэтгэгдлээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр илэрхийлэх, зарим тохиолдолд даатгалын компанийг сүрдүүлж нөхөн төлбөр авах оролдлого хийх тохиолдол гардаг.

Үнэт цаас гаргагч нь Үйлчилгээний нэгжээрээ харилцагчийн гомдол, санал, хүсэлтийг бүртгэж, гомдлыг ангилан дүн шинжилгээ хийж, хариу тайлбарыг өгдөг. 2018 оноос иргэдийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын нөхөн төлбөрийн олгогдсон болон татгалзсан тохиолдлууд, татгалзсан шалтгаан зэргийг цуврал видеогоор хүргэж байна.

**Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэл**

Үнэт цаас гаргагчийн ажилтнуудын ихэнх нь оффист байрладаг тул хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлд өртөх магадлал бага ч шуурхай дуудлагын ажилтнууд болон нөхөн төлбөрийн мэргэжилтнүүд ослын газар дээр ажилладаг тул эрсдэлд өртөх магадлалтай байдаг. Шуурхай дуудлагын ажилтнууд нь ослын үзлэг хийж байхдаа зам тээврийн осолд өртөх, сэтгэл санааны тавгүй байдалд орсон харилцагчтай харьцдаг тул халдлагад өртөх магадлалтай байдаг. Нөхөн төлбөрийн мэргэжилтнүүдийн хувьд эвдрэл гэмтэлтэй эд хөрөнгөд үзлэг хийхдээ унаж бэртэх эрсдэлтэй байдаг.

Үнэт цаас гаргагч нь уг эрсдэлийг бууруулахын тулд дотооддоо болон ОШМИ, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг тогтмол явуулдаг. Мөн үнэт цаас гаргагч нь эдгээр ажилтнуудыг гуравдагч даатгалын компанийн гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна.

**Үнэт цаасны зах зээлийн эрсдэл**

Үнэт цаасны зах зээлд оролцогчдын итгэл үнэмшил буурч дотоодын үнэт цаасны зах зээлийн эрэлт буурснаар үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар саарах, арилжааны идэвх буурах, хувьцаа үнэгүйдэх зэрэг зах зээлд эрсдэл үүсдэг. Энэ нь үнэт цаас гаргагчийн хувьцаанд болон гаргахаар төлөвлөж буй өрийн бичигт сөргөөр нөлөөлж ханшийн хэлбэлзлийг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.

**Үнэт цаасны зах зээлийн эрэлттэй холбогдон үүсэж болох эрсдэл**

Монголын хөрөнгийн зах зээл дээр 2005 оноос хойш нийт 31 компани хөрөнгийн зах зээлээс хувьцаагаар хөрөнгө татан төвлөрүүлсэн бөгөөд нийт 190 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татсан байна. Үүнээс сүүлийн 1 жилд хийгдсэн Сүү Бонд, Ай Түүлс ХК, Лэнд.мн ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа амжилттай явагдсан нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчдын идэвх сонирхлыг нэмэгдүүлсэн гэж үзэж байна. Гэсэн хэдий ч нийт иргэдийн санхүүгийн боловсрол, хуримтлалын түвшин бусад өндөр хөгжилтэй улсуудтай харьцуулахад бага,

зах зээлд идэвхтэй тоглогч, оролцогчдын тоо харьцангуй цөөн хэвээр байгаа тул үнэт цаасны хөрвөх чадвар сул байх эрсдэл мөн байгаа болно.

# 2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ

## 2.1. Монгол Улсын эдийн засгийн байдал, цаашдыг чиг хандлага

Монгол Улсын эдийн засаг нь frontier economy буюу хөгжиж эхлэх гэж буй эдийн засагтай орон гэсэн олон улсын ангилалд багтдаг. Уг ангилалд багтдаг орнуудын эдийн засгийн өсөлтөд гадаадын хөрөнгө оруулалт, дотоодын томоохон төслүүд, эдийн засагт голлох нөлөө үзүүлдэг уул уурхайн бүтээгдэхүүний үнийн нөлөөллийн хэмжээ өндөр байдаг.

Тэр ч утгаараа 2011-2012 онуудад Монгол Улсын эдийн засаг хамгийн өндөр өсөлтийг үзүүлсэн буюу жилд 17.5 хувь хүрч өссөн нь Оюу Толгой төслийн бүтээн байгуулалтын ажил эхэлсэнтэй холбоотойгоор гадаадын хөрөнгө оруулалт Монгол Улсад орж ирсэн нь нөлөөлсөн. Мөн энэ үед дэлхийн зах зээлд уул уурхайн бүтээгдэхүүн тэр дундаа коксжих нүүрсний үнэ өссөн нь Таван Толгойн олборлолтыг нэмэгдүүлсэн бөгөөд эдийн засагт үзүүлэх нөлөөллийг нэмэгдүүлсэн.

*Граф 28. Монгол Улсын гадаад худалдааны 70 орчим хувийг бүрдүүлэгч зэс, нүүрсний үнийн өөрчлөлтийн график*




*Эх сурвалж: Bloomberg terminal*

Өнгөрсөн жилүүдэд дэлхийн зах зээл дээрх уул уурхайн бүтээгдэхүүний үнэ буурсан, Оюу Толгойн бүтээн байгуулалт дууссан, Монгол Улсын Засгийн газрын тогтвортой бус бодлого зэрэг хүчин зүйлсээс хамаарч, эдийн засагт орж ирэх гадаадын хөрөнгө оруулалтын урсгал багассан, экспортын хэмжээ буурсан, дотоодын худалдан авагчдын бодит орлого буурсан зэрэг нь эдийн засгийн өсөлт 2014-2016 онд буурах нөхцөлийг бүрдүүлсэн бөгөөд 2016 онд өсөлт 1.2 хувь хүрсэн юм. Харин 2017-2018 онд эсрэгээрээ зэс, нүүрсний үнэ олон улсын зах зээлд сэргэсэн, уул уурхайн салбарыг дагасан бусад салбаруудын өсөлт нэмэгдсэн зэрэг хүчин зүйлсийн нөлөөллөөр эдийн засгийн өсөлт 5.1 хувь болон өсжээ.

*Граф 30. Монгол Улсын ДНБ өсөлт, инфляци*




*Граф 29. Ам.долларын эсрэг төгрөгийн ханш*




*Эх сурвалж: ҮСХ, Монголбанк*



Огноо: 2018/04/16

СЗХ
он сар өдөр
2018.08.29
Б 1 1 3 Б

Монгол Улсын эдийн засгийг бүтцээр нь ангилбал уул уурхайн салбар дангаараа хамгийн өндөр буюу 24 хувийг эзэлж байгаа бол бусад салбарууд болох хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэр, бөөний болон жижиглэнгийн худалдаа голлох байр суурийг буюу нийт эдийн засгийн 35 хувийг бүрдүүлж байна.

*Граф 31. ДНБ-ний бүтэц 2017*




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Мөн сүүлийн жилүүдэд дотоодын эдийн засагт ажиглагдсан гол өөрчлөлтүүдийн нэг нь Олон улсын зах зээл дээрээс Монгол Улсын босгосон гадаад өрийн бичиг байлаа. Уг гадаад зээлүүдийн нөлөөллөөр 2012-2016 онуудад төсвийн болон мөнгөний тэлэх бодлогыг хэрэгжүүлж эдийн засгийн өсөлтөд тодорхой хэмжээний эерэг үзүүлэлтүүдийг авчирч байв.

*Хүснэгт 22. Засгийн газрын ам.долларын бондын мэдээлэл*

| Бондын нэр | Дүн (Сая ам.доллар) | Хүү | Дуусах хугацаа | Гаргасан огноо |
|---|---|---|---|---|
| Khuraldai | 600 | 8.750% | 2024/03/09 | 2017/03/09 |
| DBM- Samurai | 267 | 1.520% | 2023/12/25 | 2013/12/25 |
| Mongol 2022 | 1,000 | 5.125% | 2022/12/05 | 2012/12/05 |
| Mongol 2018 - dim sum | 150 | 7.500% | 2018/06/30 | 2015/06/30 |
| Mongol 2021 | 500 | 10.875% | 2021/04/06 | 2016/04/06 |
| Mongol 2023 | 800 | 5.625% | 2023/05/01 | 2017/10/25 |

Эх сурвалж: Bloomberg Terminal

Уг бодлогуудын сөрөг тал нь төгрөгийн гадаадын валюттай харьцах ханшинд муугаар нөлөөлж 2014-2017 онд төгрөгийн ханш ам.долларын эсрэг 46%, Еврогийн эсрэг 27%, Юанийн эсрэг 36% тус тус унагахад хүргэсэн юм. Цаашлаад Монгол Улсын эдийн засаг нь гадаад өрийн дарамтад орсон бөгөөд бондын эргэн төлөлтийг төсвийн тэнцлээр төлөх боломжгүй болсны улмаас 2017 онд дефолт зарлах хэмжээний эрсдэлд ороод байв.

Энэ үед Монгол Улсын зээлжих зэрэглэл жил дараалан буурсан бөгөөд зээлжих зэрэглэл олон улсын үнэлгээний агентлагуудын нэг болох Moody's агентлагаас 2017 оны 2 сард Caa1 Negative watch ангилалд шилжсэн нь өнгөрсөн жилүүдэд авч байсан хамгийн бага үнэлгээ байлаа.

СЗХ
2018 .08. 29
БҮРТГЭВ

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
01

Граф 32. Монгол Улсын зээлжих зэрэглэл

| Агентлаг | Дүн | Шинж | Өдөр |
|---|---|---|---|
| Moody's | B3 | stable | Jan 18 2018 |
| Fitch | B- | positive | Nov 17 2017 |
| Moody's | Caa1 | stable | Mar 30 2017 |
| Moody's | Caa1 | negative watch | Feb 15 2017 |
| Fitch | B- | stable | Nov 22 2016 |
| Moody's | Caa1 | stable | Nov 18 2016 |
| Moody's | B3 | negative watch | Aug 26 2016 |
| S&P | B- | stable | Aug 19 2016 |
| Fitch | B | stable | Nov 24 2015 |
| S&P | B | stable | Nov 03 2015 |

Эх сурвалж: tradingeconomics.com

Монгол Улсын гадаад өрийг эдийн засгийн дотоод боломжоор төлөх чадваргүй болсон цаг үед Засгийн газар ОУВС-тай хамтран "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр" хэрэгжүүлэх болж 2017-2020 оны хооронд нийт 5.5 тэрбум ам.долларын дотогшлох урсгалыг бий болгосон нь гадаад өрийн дарамтыг бууруулж, валютын ханшид эерэгээр нөлөөлсөн тул 2018 онд Монголын үнэлгээ нэмэгдэн B3 болж өссөн.

ОУВС-тай хамтран хэрэгжүүлэх хөтөлбөр нь 2017 оны 5 сарын 24-ны өдөр батлагдсан бөгөөд 3 жилийн хугацаанд ОУВС-аас 434.3 сая ам.долларын санхүүжилт, ОУВС болон олон улсын байгууллагууд болон хандивлагч орнуудаас нийтдээ 5.5 орчим тэрбум ам.долларын хөнгөлөлттэй санхүүжилтийг төсвийн алдагдал, төлбөрийн тэнцлийн зориулалтаар авч ашиглах юм.

Хүснэгт 23. ОУВС-ийн Өргөтсөн санхүүжилтийн хөтөлбөрийн нөхцөл

| № | Санхүүжүүлэх байгууллага | Дүн (ам.доллар) | Хугацаа | Хүү |
|---|---|---|---|---|
| 1 | ОУВС | 434.3 сая | 15 сар | <2% |
| 2 | Азийн Хөгжлийн Банк | 900 сая | Тодорхойгүй | Тодорхойгүй |
| 3 | Дэлхийн Банк | 600 сая | 15 сар | 2% |
| 4 | Япон улс | 850 сая | >10 сар | 1-1.5% |
| 5 | БНСУ | 450 сая | Тодорхойгүй | Тодорхойгүй |
| 6 | БНХАУ-ын Төв банкны своп хэлцэл | 2.2 тэрбум (15 тэрбум юань) | 3 сар | - |
| | **Нийт** | **5.5 тэрбум** | | |

Эх сурвалж: ОУВС, Сангийн яам

Цаашлаад төлбөрийн тэнцлийг сайжруулан макро эдийн засгийн тэнцвэрийг хангаж, дунд хугацаанд өрийн дарамтыг бууруулах, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, түүхий эдийн үнээс хэт хамааралтай байдлыг өөрчлөх, бизнесийн таатай орчин бүрдүүлэх зэрэг бодлого хэрэгжүүлснээр, дунд хугацаанд эдийн засгийн өсөлт нэмэгдэж 6.3%, инфляцын түвшин 6.1-7.0% болно гэж заажээ.

Мөн хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын төлбөрийн тэнцэл сайжирч, төсвийн нэгдмэл байр суурьтай болж татварын бодлогыг шинэчлэх ба төсвийн зарлагыг үе шаттай бууруулж, Хөгжлийн банкны засаглалыг сайжруулж бие даасан хараат бус байдлыг хангаж, өрийн тогтвортой байдлыг хангах юм.

Үр дүнд нь дотоодын эдийн засагт инфляцын тогтвортой орчин, гадаад худалдааны эерэг баланс, уул уурхайн бүтээгдэхүүний үнийн тогтвортой байдал тогтох бөгөөд 2017 онд ажиглагдсан үг өсөлтийг цаашид хадгалагдан 2020 онд мөн жилд 5 хувиар өсөх таамаглалыг ОУВС-аас

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC

СЭХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

дэвшүүлээд байна. Мөн хөтөлбөр нь 2018-2020 онд үргэлжлэн хэрэгжсэнээр ДНБ-ий өсөлтийн хэмжээ 2018 онд 5.0, 2019 онд 6.3, 2020 онд 5.0 хувиар тус тус өсөхөөр байна.

Граф 33. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт




Эх сурвалж: Сангийн Яам, ОУВС

Үүнээс гадна, дэлхийн эдийн засгийн өсөлт дунд хугацаанд харьцангуй тогтвортой байх хандлагатай байгаа нь эрдэс бүтээгдэхүүний үнэ тогтвортой байх боломжийг бүрдүүлж байгаа болов ч БНХАУ болон зарим хөгжингүй орнууд нүүрсний хэрэглээнээс татгалзаж, хэрэглээгээ бууруулах бодлого баримталж байгаатай холбоотойгоор нүүрсний үнэ 2018-2020 онд 2017 оны түвшингээс буурч болзошгүй байна.

Граф 34. Тавaарын ханшийн таамаглал, 2018-2020




Эх сурвалж: Bloomberg Terminal

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

## 2.2. Монгол Улсын Даатгалын салбар

Монгол Улсад даатгалын салбар үүсэж хөгжөөд 83 жил болж байгаа ч арилжааны даатгалын хэлбэрт шилжээд 28 жил болж байгаа нь хөгжлийнхөө гарааны шатанд байгаа шинэ салбар болохыг илтгэж байна. Даатгалын салбар нь Монгол Улсын санхүүгийн секторын нэг хүрэхгүй хувийг эзэлдэг. 2016 онд амьдралын бус даатгал (property & casualty буюу ердийн даатгал)-ын салбарын нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь буюу зах зээлийн нэвтрэлтийн түвшин 0.48% хүрсэн ба дэлхийн дундаж үзүүлэлт 2.8%, Азийн дундаж үзүүлэлт 1.85% байдаг байна. 2017 онд Монгол Улсын ердийн даатгалын салбарын нэвтрэлтийн түвшин 0.53% болж өссөн нь дотоодын зах зээл цаашид тэлэх боломжтойг харуулж байна.

*Граф 35. Нэвтрэлтийн түвшин – Ердийн даатгал*




*Эх сурвалж: СЗХ, Swiss Re Ltd Economic Research & Consulting*

2020 он гэхэд дотоодын ердийн даатгалын салбарын нэвтрэлтийн түвшин Азийн дундаж түвшин буюу 1.71% хүрэхэд, нийт хураамжийн орлого 649 тэрбум төгрөг буюу одоогийн үзүүлэлтээс 4.5 дахин өсөх боломжтой байна.

*Граф 36. Дотоодын даатгалын салбарын нэвтрэлтийн түвшний төсөөлөл*




*Эх сурвалж: СЗХ, Сангийн Яам, ОУВС, Swiss Re*

### 2.2.1. Даатгалын салбарын ерөнхий мэдээлэл

2017 оны байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 42, даатгалын хохирол үнэлэгч 29 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн 251 салбар, төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 209 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 53 салбар, төлөөлөгчийн газар СЗХ-оос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. Өмнөх онуудтай харьцуулахад,

даатгалын салбарт оролцогч хувь хүмүүс буурсан бол хуулийн этгээдүүдийн өсөлт харьцангуй тогтвортой байна.

*Хүснэгт 24. Даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо*

| № | Оролцогч байгууллага | 2013 | 2014 | 2015 | 2016 | 2017 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ердийн даатгалын компани | 16 | 16 | 15 | 15 | 15 |
| 2 | Урт хугацааны даатгалын компани | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| 3 | Давхар даатгалын компани | | | 1 | 1 | 1 |
| 4 | Даатгалын төлөөлөгч | 3,187 | 3,260 | 3,340 | 3,091 | 2,893 |
| 5 | Даатгалын зуучлагч | 20 | 30 | 37 | 40 | 42 |
| 6 | Даатгалын хохирол үнэлэгч | 14 | 20 | 27 | 31 | 29 |
| 7 | Актуарч | 15 | 15 | 15 | 15 | 21 |
| 8 | Даатгалын үйл ажиллагаанд аудит хийх эрх бүхий аудитын компани | - | - | - | 42 | 42 |
| 9 | Аудитор | - | - | - | 126 | 130 |
| | **Бүгд** | **3,253** | **3,342** | **3,436** | **3,362** | **3,174** |

Эх сурвалж: СЗХ

## 2.2.2. Салбарын нийт хөрөнгийн хэмжээ

2017 онд даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.4% өсөж 244.7 тэрбум төгрөг хүрсэн бол ердийн даатгалын компаниудын хөрөнгө 16.7% өсөж 194 тэрбум төгрөгт хүрлээ. 2013-2017 оны даатгалын компаниудын нийт хөрөнгийн жилийн дундаж өсөлт 14% байсан бол ердийн даатгалын компаниудын жилийн дундаж өсөлт 9.9% байна.

*Граф 37. Нийт хөрөнгийн хэмжээ 2013-2017*




Эх сурвалж: СЗХ

СЗХ-ны "Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн батлах" тухай 355 дугаар тогтоолын дагуу ирэх онуудад нийт хөрөнгийн хэмжээ өсөх төлөвтэй байна.

*СЗХ-ны 2012 оны 12 сарын 12-ны өдрийн 355 тоот тогтоолоор батлагдсан "Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн батлах" тухай шаардлагын дагуу 2016 оны 12 сарын 31-ний өдрөөс өмнө ердийн даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 5.0 тэрбум төгрөг байхаар заасан байна. 2017 оны байдлаар уг шаардлагыг нийт 15 ердийн даатгалын компаниас зөвхөн 3 ердийн даатгалын компани хангасан байна. Иймд хугацааг СЗХ-ны 2016 оны 06 сарын 15-ны өдрийн 236 тоот тогтоолоор 2018 оны 06 сарын 30-ны өдөр хүртэл сунгасан байна.*

2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

Граф 38. Зах зээлд эзлэх хувь, нийт хөрөнгөөр 2017




Ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгийн салбарын хэмжээнд эзлэх хувийг авч үзвэл, Монгол Даатгал 14%, Мандал Даатгал 9%, Тэнгэр Даатгал 8%, Миг Даатгал 7%, Практикал Даатгал 5% эзэлсэн буюу эдгээр 5 компани нь салбарын нийт хөрөнгийн 42%-ийг бүрдүүлж байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад Миг Даатгал нийт хөрөнгө өсөлтөөрөө тэргүүлж 40.1% өссөн бол Соёмбо даатгал хамгийн бага өсөлт буюу 3%-ийг үзүүлсэн байна. Нийт хөрөнгийн хэмжээгээр Үнэт цаас гаргагч нь 15 ердийн даатгалын компаниас 2-т оржээ.

Граф 39. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ




Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

## 2.2.3. Салбарын нийт нөөц сан, өр төлбөр ба эздийн өмч

Даатгалын компаниудын өр төлбөр ба эздийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 13.4 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 24.0 тэрбум төгрөгөөр, эздийн өмч 7.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Эздийн өмчийн өсөлтийн шалтгаан нь СЗХ-ны "Даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн батлах" тухай 355 дугаар тогтоолын дагуу зарим нэр бүхий компаниудын дүрмийн сангийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой байна.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
мандал даатгал

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC

Граф 40. Даатгалын салбарын нийт эх үүсвэрийн бүтэц




Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2017 онд даатгалын компаниудаас нөөц сангийн хэмжээгээрээ Монгол Даатгал тэргүүлсэн буюу 10.5 тэрбум төгрөгийн нөөц сантай байна. Нөөц сангийн хэмжээгээр Үнэт цаас гаргагч нь нийт 15 ердийн даатгалын компаниас 7-т оржээ.

## 2.2.4. Салбарын нийт хураамжийн орлого

Граф 41. Даатгалын салбарын нийт хураамжийн орлого, төрлөөр




Даатгалын компаниуд 2017 оны байдлаар нийт 1,015,275 иргэн, албан байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, 144.3 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсний 97.8 хувь буюу 141.2 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд, 0.9 хувь буюу 1.3 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компани, 1.3 хувь буюу 1.9 тэрбум төгрөгийг давхар даатгалын компани эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хураамжийн орлого 26% буюу 29.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. 2011-2017 оны жилийн дундаж өсөлт 17.0% байна.

Граф 42. Салбарын нийт хураамжийн орлого




Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

Даатгалын зах зээлд нийт 21 хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүн борлуулагдаж байгаагаас 2017 онд даатгалын хураамжийн нийт орлогын 79.2% нь даатгалын 5 хэлбэрийн хураамжийн орлогоос



Огноо: 2018/04/16

бүрдэж байгаагийн 25.4%-г хөрөнгийн даатгал, 21.1%-г ЖХАЖД, 12.9%-г авто тээврийн хэрэгслийн даатгал, 12.4%-г гэнэтийн ослын даатгал, 7.5%-г хариуцлагын даатгалын хураамж тус тус эзэлж байна.

*Граф 43. НХО, хэлбэрээр*




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

Даатгалын хураамжийн нийт орлого 25.4% өсөж 144.3 тэрбум төгрөг хүрэхэд нөлөөлсөн гол хүчин зүйлс нь дараах даатгалын хэлбэрийн өсөлт байлаа.

*Граф 44. НХО-ын өсөлтийн хүчин зүйлс*




*Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо*

2017 онд нийт хураамжийн орлогоор Бодь Даатгал тэргүүлж нийт 28.2 тэрбум төгрөгийн орлого олж зах зээлийн 20.0%-ийг бүрдүүлсэн бол Үнэт цаас гаргагч нь зах зээлийн нийт хураамжийн орлогын 16%-ийг бүрдүүлж 3-т орсон байна.

*Граф 45. Даатгалын компаниудын нийт хураамжийн орлогын хэмжээ*



Үнэт цаасны танилцуулга
2018.08.29

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

### 2.2.5. Салбарын нөхөн төлбөрийн хэмжээ

Даатгалын тохиолдлын улмаас 2017 оны байдлаар нийт 61,234 даатгуулагчдад 45.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгожээ. Нийт салбарын хэмжээнд нөхөн төлбөрийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

*Граф 46. Салбарын түүхэн нөхөн төлбөрийн хэмжээ*




Даатгалын компаниудын даатгалын нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр нь авч үзвэл жолоочийн хариуцлагын албан журмын даатгалаар 29,728 даатгуулагчид нийт 15.5 тэрбум төгрөгийн, авто тээврийн хэрэгслийн даатгалаар 12,550 даатгуулагчид 8.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг тус тус олгосон нь хамгийн өндөр дүнтэй нөхөн төлбөр олгосон даатгалын хэлбэрүүд байна.

### 2.2.6. Салбарын ашигт ажиллагаа

Даатгалын компаниудын цэвэр ашиг 2017 оны 4 дүгээр улиралд 13.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.8 тэрбум төгрөгөөр өссөн байна.

*Граф 47. Салбарын түүхэн ашигт ажиллагаа*




МАНДАЛ ДААТГАЛ ХХК
GOLOMT CAPITAL LLC



Огноо: 2018/04/16

2017 онд Үнэт цаас гаргагч санхүүгийн зарим үзүүлэлтүүдээр салбарын дунджаас илүү ажиллаж чадсан байна. Тухайлбал, салбарын дундаж нийт хураамжийн орлогын өсөлт 26% байхад Үнэт цаас гаргагчийн өсөлт 72% байв. Мөн салбарын дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 11% байхад Мандал даатгал 18%-ийн өгөөжтэй гарсан байна.



















## 2.2.7. Өрсөлдөгчийн судалгаа

Даатгалын салбарт нийт 15 ердийн даатгалын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаагаас Бодь Даатгал, Монгол Даатгал болон үнэт цаас гаргагч тэргүүлж зах зээлийн 53.5%-ийг эзэлж байна. Үнэт цаас гаргагч нь өнгөрсөн онд Топ-3 даатгалын компанийн нэг болсон байр сууриа баталгаажуулсан ба цаашид зах зээлд эзлэх байр сууриа бататгах бөгөөд дээшлүүлэх бодлого баримталж байгаа тул Бодь Даатгал болон Монгол Даатгалыг гол өрсөлдөгчид гэж тодорхойллоо.

**Ерөнхийн мэдээлэл**

Бодь Даатгал болон Монгол Даатгал нь салбарын ууган компаниуд ба орон даяар 20 гаруй салбаруудтай олон нийтэд танигдсан компаниуд боловч үнэт цаас гаргагч нь маш богино хугацаанд эдгээр өрсөлдөгч компаниудтай дүйцэхүйц хураамжийн орлогыг олж, салбарын шилдэг даатгалын компанийн нэг болж чадсан байна.

*Хүснэгт 25. Өрсөлдөгчдийн ерөнхий мэдээлэл*

| | Бодь даатгал | Монгол даатгал | Мандал даатгал |
|---|---|---|---|
| Үүсгэн байгуулагдсан огноо | 1995 | 1995 | 2011 |
| Хувь нийлүүлэгчид | Л. Болд<br>Л.Болдхуяг | Милленниум Секюритис Менежмент Лимитед | Голомт Файненшл Групп<br>Юу Эм Си Капитал |
| Салбарын тоо | 24 | 29 | 3 |
| Нийт хураамжийн орлого 2017 (тэрбум төг) | 28.2 | 24.8 | 22.5 |

*Эх сурвалж: mongoldaatgal.mn, bodi-insurance.com, Мандал даатгал, СЗХ*

**Нийт хураамжийн орлого**

2017 онд Бодь Даатгал нь нийт 28.2 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого олж зах зээлийг тэргүүлсэн ба энэ нь өмнөх оны мөн үеэс 40% өссөн үзүүлэлт байв. 2016 оны тэргүүлэгч компани байсан Монгол Даатгалын нийт хураамжийн орлого 0.3% өсөж 24.8 тэрбум төгрөг хүрч 2-т орлоо. Харин үнэт цаас гаргагчийн орлого 72% өсөж, салбарын нийт хураамжийн орлогын 16%-ийг бүрдүүлэн, Топ-3 даатгалын компанийн болсон байр сууриа баталгаажуулсан байна.

*График 48. Өрсөлдөгчдийн нийт хураамжийн орлого 2013-2017*




Эх сурвалж: СЗХ

Доорх графиас Бодь даатгалын орлогын өсөлт тогтворгүй, Монгол даатгалын орлогын өсөлт удааширсан мөн Мандал даатгалын орлого тогтвортой бөгөөд хурдацтай өсөж байгааг харж байна. Монгол даатгалын нийт хураамжийн орлого сүүлийн 3 жилд ижил түвшинд хадгалагдаж байна.

*График 49. Өрсөлдөгчдийн нийт хураамжийн орлогын өсөлт*




Эх сурвалж: СЗХ

2013 оноос хойш Монгол даатгалын зах зээлд эзлэх байр сууриа алдаж байгааг доорх графиас харах боломжтой юм. Тухайлбал, тус компани нь 2013, 2014, 2016 онуудад тэргүүлэгч компани байсан бол 2017 онд зах зээлд эзлэх байр суурь нь буурч салбарын нийт хураамжийн орлогын 17.6%-ийг бүрдүүлжээ. Бодь Даатгалын зах зээлд эзлэх байр суурь өсөж тус компани нь нийт зах зээлийн 20%-ийг дангаараа бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагчийн хувьд, бизнесийн өсөлтийн шатанд явж байгаатай холбоотойгоор зах зээлд эзлэх байр суурь хурдацтай өсөж байна. Үнэт цаас гаргагч нь 2013-2014 онд нийт 15 ердийн даатгалын компаниас 6-т, 2015 онд 4-т, 2016-2017 онд 3-т орж зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлжээ.

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
он сар өдөр
2018 Р.08.Г29 В

Хүснэгт 26. Өрсөлдөгчдийн зах зээлд эзлэх байр суурь

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
он сар өдөр




Эх сурвалж: СЗХ

2017 онд ердийн даатгалын салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд нийт хураамжийн орлогын 32%-ийг давхар даатгалд төлсөн бол Бодь даатгал 59%-ийг, Мандал даатгал 50%-ийг давхар даатгалын байгууллагад төлсөн байна. Энэ нь Бодь даатгал болон Мандал даатгалын өөрийн хөрөнгийн хэмжээ бага буюу дангаараа даах эрсдэлийн хэмжээ бага байгаатай холбоотой юм. Бодь даатгалын өөрийн хөрөнгө 5 тэрбум төгрөг байсан бол Мандал даатгалын өөрийн хөрөнгө 6 тэрбум төгрөг байжээ. Харин Монгол Даатгал нь нийт хураамжийн орлогын 31%-ийг давхар даатгалд төлсөн нь салбарын дунджаас бага үзүүлэлт байлаа. Энэ нь Монгол даатгалын өөрийн хөрөнгийн хэмжээ салбартаа хамгийн өндөр буюу 11.7 тэрбум төгрөг байгаатай холбоотой юм. Ингэснээр тус компанийн давхар даатгал руу шилжүүлэх эрсдэл бага байх улмаар компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

Граф 52. Бодь Даатгал: НХО vs ДД хураамж




Граф 52. Монгол Даатгал: НХО vs ДД хураамж




Граф 52. Мандал Даатгал: НХО vs ДД хураамж




Эх сурвалж: СЗХ

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
мандал даатгал
Б. Нямбаатар
5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК



Огноо: 2018/04/16

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ

**Нийт хөрөнгө**

Ердийн даатгалын зах зээлийн нийт хөрөнгийн хэмжээ 193.6 тэрбум төгрөг хүрсэн ба үүний 36.8%-ийг Бодь даатгал, Монгол даатгал, Мандал даатгал бүрдүүлж байна. Монгол Даатгал нь ердийн даатгалын зах зээлд хамгийн өндөр хөрөнгөтэй ба үүний 32%-г нөхөн төлбөрийн нөөц сан, 33%-ийг өр төлбөр, 35%-г эздийн өмч бүрдүүлж байна. Бодь даатгалын хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 35% өссөн ба энэ нь эздийн өмч 11%-р буурсан, өр төлбөр 85% өссөн, нөөц сан 40% өссөнтэй холбоотой байна. Бодь даатгалын нийт хөрөнгийн 51%-ийг өр төлбөр бүрдүүлж байна.

*Граф 53. Бодь даатгалын хөрөнгийн задаргаа*




*Граф 55. Монгол даатгалын хөрөнгийн задаргаа*




*Граф 54. Мандал даатгалын хөрөнгийн задаргаа*




*Эх сурвалж: СЗХ*

Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн хэмжээ өмнөх оноос 24% өссөн ба үүнд нөөц сан 31%, өр төлбөр 23%, эздийн өмч 23% өссөн нь нөлөөлжээ. Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн 58%-ийг өр төлбөрийн ээлж байгаа ба энэ нь өрсөлдөгчидтэй харьцуулбал өндөр байна. Үнэт цаас гаргагчийн өр төлбөрийн 75%-ийг орлогод тооцоогүй нөөц сан бүрдүүлж байна.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

# 3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

## 3.1. Үнэт цаасны танилцуулга

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Мандал Даатгал ХХК |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Нийт зарласан хувьцааны тоо | 25,000,000 ширхэг |
| Нийт гаргасан хувьцааны тоо | 5,000,000 ширхэг |
| Нийт халаасалсан хувьцааны тоо | 1,243,016 ширхэг |
| Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ | 1,000 төгрөг |
| Олон нийтэд санал болгох эзэмшлийн хувь | 25.00% |
| Олон нийтэд санал болгох хувьцааны тоо | 1,560,754 ширхэг *(Халаасны нийт 1,243,016 ширхэг хувьцаа болон хувьцаа эзэмшигч "Юу Эм Си Капитал" ХХК-ийн эзэмшлийн 317,738 ширхэг хувьцаа)* |
| Олон нийтэд санал болгосны дараах гаргасан хувьцааны тоо | 6,243,016 ширхэг |
| Нэгж хувьцааны үнэ | 4,800 төгрөг |
| Олон нийтээс татан төвлөрүүлэх дүн | 7,491,619,200 төгрөг |
| Хувьцааг арилжаалах арга: | Тогтоосон үнээр санал болгох |

## 3.2. Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.7, 33.8 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.4 дэх заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7. (а), 6.7 (б) хэсэг, 7 дугаар зүйлийн 7.9.4, 7.9.5, 7.9.6 дахь заалтууд, 2018 оны 02 сарын 12-ны өдрийн 18/004 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол, 2018 оны 02 сарын 15-ны өдрийн 18/002 тоот ТУЗ-ийн тогтоолыг тус тус үндэслэн эргүүлэн худалдан авч халаасалсан буюу зарласан хувьцаа болох 1,243,016 ширхэг хувьцаа, хувьцаа эзэмшигч "Юу Эм Си Капитал" ХХК-ийн эзэмшлийн 317,738 ширхэг хувьцаа, нийт 1,560,754 ширхэг энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-иар дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгохоор шийдвэрлэсэн байна.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын болон ТУЗ-ийн тогтоолын хуулбарыг Хавсралт 6.5, 6.6-аас харна уу.

он сар өдөр
2018.08.29
№ 1

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
.... он .... сар .... өдөр

## 3.2. Үнэт цаас эзэмшигчийн эрх

Үнэт цаас эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 34 дугаар зүйлд заасан дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон “бүртгэлийн өдөр” компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;
- ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хувиарлаагүй бол алданги төлөхийг шаардах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;
- Нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх;
- Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;
    - Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;
    - Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;
    - Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.
    - Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон, эсхүл компанийн мэдлийн багц хувьцааг худалдсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчид нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.
- Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх;
- Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх;
- Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөргүй хуулбарлан авах;
- Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;
- Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх;
- Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84.4-т заасан үүргээ биелүүлээгүйн улмаас компанид хохирол учруулсан бол уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;
- Хууль тогтоомж болон компанийн дүрмээр тогтоосон бусад эрх.

МАНДАЛ даатгал
МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

2018.08.29 он сар өдөр БҮРТГЭВ

МАНДАЛ хөрөнгийн даатгал MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ... он ... сар ... өдөр

## 3.4. Үнэт цаас эзэмшигчийн үүрэг

Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй. Үүнд:

- Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;
- Нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;
- Нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай компанид бичгээр мэдэгдэх.

Компанийн хувьцаа эзэмшигчид дараах хяналтыг тавина. Үүнд:

- Нийт гаргасан энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгийг СЗХ-ны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.
- Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшил, өмчлөлд буй энэ дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.1 дэх хэсэгт заасан хөрөнгийн талаар СЗХ-оос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:
    - худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөх;
    - өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх болон багасгах үр дагаварт хүргэх хувьцаа гаргах, хуваарилах, хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувийг бууруулах буюу нэмэгдүүлэх үр дагаварт хүргэх хэлцэл хийх.

## 3.5. Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлогын төсөл

Үнэт цаас гаргагч нь "Ногдол ашгийн журам"-ын төслийг боловсруулсан ба дараах нөхцөлүүдийг тусгасан байна. Үүнд:

**Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах хэлбэр**

1.1. ТУЗ нь хууль тогтоомж, Компанийн дүрмийг үйл ажиллагаандаа чанд баримтлан менежментийн оновчтой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг эрмэлзэж ажиллах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж нэгж хувьцаанд ногдох өгөөж /EPS/ болон өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/-ийг хамгийн өндөр түвшинд барихыг урьтал болгон ажиллана.

1.2. Ногдол ашгийг Компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилах бөгөөд дараах нөхцөлүүд хангагдсан нөхцөлд хуваарилна. Үүнд:

1.2.1. Ашигтай ажилласан байх, ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байх;

1.2.2. Бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хүртэх өгөөжийг өндөрсгөх зорилгоор ТУЗ-өөс боловсруулсан бизнесийн төсөл хөтөлбөр, арга хэмжээг тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх, холбогдох хөрөнгө оруулалт үлдсэн байх;

1.2.3. Компанийн ногдол ашгийн ойрын ба хэтийн бодлого, хуваарилалт нь ирээдүйд компанид хөрөнгө оруулалт татахуйц байх;

1.2.4. Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг,

МАНДАЛ даатгал ХХК 5473489

ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

2018 .08. 29
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс их байх;

1.2.5. Хуваарилж буй ногдол ашгийн хэмжээ нь компанийн тухайн жилийн бодит боломжоос хэтэрхий дээгүүр, эсхүл хэтэрхий доогуур биш байх;

1.2.6. Компанийн төлбөрийн чадвар даатгалын тухай хууль тогтоомжид заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байх;

1.2.7. Даатгалын нөөц сан нь даатгалын тухай хууль тогтоомжид заасан хэмжээнд хүрэлцэж байх;

1.2.8. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

1.3. Компани 1 /нэг/ төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

1.4. Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хэлбэрээр хуваарилах бөгөөд бэлэн мөнгө болон эд хөрөнгө, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

1.5. Ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн дансанд шилжүүлнэ.

**Ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах**

2.1. Компани ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргаж, энэ тухай хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна. ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

2.2. ТУЗ ногдол ашиг хуваарилахаар шийдсэн бол уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр, ногдол ашиг тараах хэлбэр, төрөл зэргийг заана.

2.3. ТУЗ-өөс ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журмыг хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байхаар тооцож шийдвэрлэнэ.

2.4. ТУЗ ногдол ашиг хуваарилах, тараахтай холбоотой гаргасан шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигч болон олон нийтэд 2-оос доошгүй сонин хэвлэлээр мэдэгдэх бөгөөд уг мэдээлэлд тухайн төрлийн нэгж хувьцаанд ногдуулан хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээ, ногдол ашгийг төлөх хугацаа, төлөх арга зам, ногдол ашгийн талаар лавлагаа авах утасны дугаар зэргийг тусгана. Компани нь өөрийн вэб сайтад энэ талаар мэдээллийг оруулсан байвал зохино.

2.5. ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.

2.6. ТУЗ нь Компанийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдрийг тогтоох бөгөөд тус өдрөөр тасалбар болгож Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иас хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй хуулгыг гаргуулна.

2.7. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25%-аас дээш хувиар багассан тохиолдолд компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 /арван таван/ өдрийн дотор зээлдүүлэгчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

2.8. Ногдол ашгийг тодорхойлсон тооцооллыг тухайн жилд Гүйцэтгэх захирал санал болгосноор Төлөөлөн удирдах зөвлөл батална.

**Гурав. Ногдол ашиг хуваарилах, тайлагнах, мэдээлэл хүргүүлэх**

3.1. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгө, үнэт цаас хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

3.2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө

СЗХ 2018. 08. 29 өдөр БҮРТГЭВ №

3.3. Ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухай үндэслэлээ тухайн жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, хэрэв хуваарилан олгохоор шийдвэрлэсэн бол уг ногдол ашгийн тайланг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

3.4. Ногдол ашиг хуваарилалтын тайланг тогтоосон журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-д хүргүүлнэ.

3.5. Компани ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 /арван тав/ өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ

3.6. Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

3.7. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

3.8. ТУЗ нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн талаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд ногдол ашиг тараах тухай мэдээллийг компанийн вэб сайтад байршуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу олон нийтэд мэдээлнэ.

Ногдол ашгийн бодлогын төслийн дэлгэрэнгүйг Хавсралт 6.8-аас харна уу.

## 3.6. Үнэт цаасны үнэ тогтоосон үндэслэл

Үнэт цаас гаргагчийн “БДО Аудит” ХХК-тай байгуулсан 2018 оны 02 сарын 20-ний өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2018-Ү1 тоот “Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээ”-ний хүрээнд үнэлгээний байгууллага нь үнэт цаас гаргагчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.

Бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо үнэлгээний компани нь ах зээлийн хандлага ба орлогын хандлагыг авч үзсэн байна. Зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээнд жишиг компанийн арга зүй болон жишиг арилжааны арга зүйг ашигласан бол орлогын хандлагаар тооцсон үнэлгээнд хорогдуулсан мөнгөн урсгалын загварыг удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцжээ. Үнэлгээний компани нь дээр дурдсан арга хандлагуудаас Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүн нь бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна гэж дүгнэсэн байна.

Мандал Даатгал ХХК нь үнэлгээний өдрийн байдлаар 1,805,206 мянган төгрөгийн мөнгө ба түүнэй адилтгах хөрөнгө, 8,416,719 мянган төгрөгийн хадгаламжийн сертификат, 812,728 мянган төгрөгийн үнэт цаастай, санхүүгийн өр төлбөргүй бөгөөд бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **23,619,153 – 25,208,593 мянган төгрөг** байх үндэслэлтэй байна гэж үнэлгээний байгууллага дүгнэсэн байна.

*Хүснэгт 27. Үнэлгээний эцсийн үр дүн*

| *мянган төгрөг* | *Доод хязгаар* | *Дээд хязгаар* |
|---|---|---|
| *Урт хугацааны өсөлтийн түвшин* | *3.61%* | *5.61%* |
| **Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ** | **23,619,153** | **25,208,593** |
| Хувьцааны тоо ширхэг | 5,000,000 | 5,000,000 |
| **Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр)** | **4,723.83** | **5,041.72** |

**Дээрх үнэлгээний үр дүн болон зах зээлийн өнөөгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2018 оны 02 сарын 15-ны өдрийн 18/002 тоот тогтоолоор нэгж хувьцааны үнийг 4,800 төгрөг байхаар тогтоосон байна.**

Бизнесийн үнэлгээний дэлгэрэнгүйг энэхүү танилцуулгын Хавсралт 6.11-аас харна уу.

## 3.7. Үнэт цаасаар татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй хүрээнд нэг бүрийн 4,800 төгрөгийн үнэтэй 1,560,754 ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар нийт 7,491,619,200 төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлнэ. Үүнээс, 1,243,016 ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө буюу 5,966,476,800 төгрөг нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх бол үлдсэн "Юу Эм Си Капитал" ХХК-ийн эзэмшлийн 317,738 ширхэг хувьцааг худалдсан хөрөнгө буюу 1,525,142,400 төгрөг нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхгүй юм.

Үнэт цаас гаргагч нь энэхүү нэмэлт мөнгөн хөрөнгө болох 5,966,476,800 төгрөгийг СЗХ-ны 2013 оны 12 сарын 12-ны өдрийн 498 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага"-ын дагуу зарцуулахаар төлөвлөж байна.

Аливаа даатгалын байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгө/мөнгөн хөрөнгөө нэмэгдүүлэхэд дараах зэрэг нөлөөг авчирдаг. Үүнд:

- **Зах зээлд эзлэх байр суурь өсөх:** Хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдсэнээр үнэт цаас гаргагч нь өндөр дүн бүхий хохирлын эрсдэлийг даатгах чадвартай болж зах зээлд эзлэх байр суурийа нэмэгдүүлэх боломжтой ба энэ нь нийт хураамжийн орлогын өсөлтөд эергээр нөлөөлнө.

- **Орлогод тооцсон хураамж өсөх:** Даатгалын тухай хуульд даатгалын байгууллага нь өөрийн хөрөнгөөс давсан дүнгийн эрсдэл даахыг хориглосон байдаг. Иймд, даатгалын байгууллагууд нь өөрийн хөрөнгөөс давсан эрсдэлийг давхар даатгагчид шилжүүлж, давхар даатгалын хураамж төлдөг ба энэ нь ашигт ажиллагааг бууруулдаг.

- Үнэт цаас гаргагчийн хувьд өөрийн эрсдэл даах чадварыг 50,000 ам.доллар буюу 122 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд үүнээс давсан хэсгийг трийти болон факултатив давхар даатгалаар эрсдэлийг шилжүүлдэг. 2016 онд нийт хураамжийн орлогын 57%, 2017 онд 50%-ийг давхар даатгалд шилжүүлсэн нь сайжирсан үзүүлэлт боловч дахин сайжруулах орон зай байгааг харуулж байна. Тухайлбал, 2017 оны 07 сарын 01-ны өдрөөс эхэлсэн трийти давхар даатгалын нөхцөлийн өөрчлөлт нь богино хугацаанд компанийн ашигт ажиллагаанд эергээр нөлөөлсөн ба хуучин нөхцөлийн дагуу цэвэр ашиг 733 сая төгрөг гарах байсан бол Excess of Loss нөхцөл рүү шилжсэнээр цэвэр ашиг 1.1 тэрбум төгрөг болж 324 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Компанийн мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлж эрсдэл даах чадварыг 3 дахин буюу 150,000 ам доллар (370 сая төгрөг) хүргэвэл цэвэр хураамжийн орлогод 20% хувийн эерэг нөлөөтэй гэж үнэт цаас гаргагч тооцоолжээ.

- **Хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх:** Мөнгөн хөрөнгийг 5,966,476,800 төгрөгөөр нэмэгдүүлснээр хөрөнгө оруулалтын орлого дунджаар 46%-иар өсөх боломжтой ба энэ нь ашигт ажиллагаанд нөлөөлөх гол хүчин зүйл болох юм.

СЗХ 2018 .08. 29 өдөр № 11

МАНДАЛ даатгал

MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...... он .... сар .... өдөр

## 3.8. Үнэт цаас гаргагчийн дунд хугацааны бизнес төлөвлөгөө

***Зорилт:** Үнэт цаас гаргагч нь ирэх 5 жил буюу 2022 онд дараах санхүүгийн гоплох үзүүлэлтүүдээ сайжруулж, жилийн 11 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай компани болохоор зорин ажиллаж байна.*

*Хүснэгт 28. Санхүүгийн гоплох үзүүлэлтүүд*

| Үзүүлэлт (тэрбум төг.) | 2017 | 2022 |
|---|---|---|
| Нийт хураамжийн орлого | 22.5 | 45 |
| Нийт хөрөнгө | 21 | 71 |
| Цэвэр ашиг | 1 | 11 |

Уг зорилтыг биелүүлэхийн тулд дараах ажлуудыг авч хэрэгжүүлнэ.

**Иргэдийн даатгал**

Иргэдийн даатгалын зах зээлд, тээврийн хэрэгслийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүнийг түлхүү борлуулахаар төлөвлөж байна.

Улаанбаатар хотод 400,000 орчим тээврийн хэрэгсэл идэвхтэй хөдөлгөөнд оролцдог. 2017 оны статистик мэдээллээр 53,324 автомашин тээврийн хэрэгслийн даатгалтай байна. Өөрөөр хэлбэл зах зээлийн нэвтрэлт /penetration rate/ 13%-тай байна. Энэ хувь нэмэгдэх томоохон орон зай байгаа бөгөөд 3 жилийн дотор үнэт цаас гаргагч нь одоогийн борлуулалтаа 2 дахин нэмэгдүүлнэ гэж төлөвлөсөн байна. Үнэт цаас гаргагч нь шууд борлуулалтын багаараа уг төлөвлөгөөг биелүүлэх бөгөөд даатгалын менежерүүдийн тоог одоогийнхоос 50%-аар нэмэгдүүлж, мөн одоогийн нэгж ажилтны бүтээмжийг 50%-аар нэмэгдүүлснээр төлөвлөгөөг гүйцэтгэнэ.

Үнэт цаас гаргагч нь 2015 онд анх "Жаргалан" хувийн эрүүл мэндийн даатгалыг нэвтрүүлсэн. Хувийн эрүүл мэндийн даатгал нь дөнгөж зах зээлд нэвтэрч эхэлж буй тул нэвтрэлтийн түвшин маш бага байна. Улаанбаатар хотод 1.4 сая хүн амьдарч байгаагаас 5,000 орчим хүн л хувийн эрүүл мэндийн даатгалд хамрагджээ. Ирэх 3 жилийн дотор үнэт цаас гаргагчийн одоогийн эрүүл мэндийн даатгалын борлуулалтаа 2 дахин нэмэгдүүлнэ гэж төлөвлөсөн байна.

Иргэдийн зах зээлд зориулсан даатгалын бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх, даатгуулагчдад хүргэх үйлчилгээгээ хурдан шуурхай болгохын тулд онлайн болон гар утасны аппликейшнээр даатгал хийж, нөхөн төлбөрийн үйлчилгээ үзүүлэхээр ажиллаж байна.

**Байгууллагын даатгал**

Байгууллагын даатгалын зах зээлд борлуулж буй даатгалын бүтээгдэхүүнүүд нь хэлбэрийн хувьд цөөн хэдий ч даатгалын нарийн мэргэжлийн ур чадвар шаардсан, салбар бүрийн онцлогоос хамаарсан олон төрлийн бүтээгдэхүүн байдаг. Эдгээр бүтээгдэхүүний нөхцөлийг боловсруулах, харилцагчдад ойлгомжтой байдлаар хүргэхийн тулд байгууллагын даатгалын мэргэжилтнүүд, андеррайтингийн багаа чадавхжуулах замаар өрсөлдөх чадвараа сайжруулж борлуулалтаа дэмжихээр төлөвлөж байна.

Мөн гадаадын давхар давхар даатгалын зах зээлд Монгол Улсын даатгалын зах зээл болон Мандал даатгалыг таниулах, ялангуяа Хятад, азийн улс орнуудад болж буй road show-нд идэвхтэй оролцохоор төлөвлөж байна.

*Хүснэгт 29. Орлогын тайлангийн төсөөлөл 2018-2022*

| (сая төг.) | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| ***Нийт хураамжийн орлого*** | ***24,500*** | ***28,360*** | ***33,586*** | ***35,305*** | ***45,450*** |
| *Давхар даатгалын хураамжийн зардал* | *11,271* | *11,863* | *13,680* | *10,560* | *13,960* |
| *Даатгалын хураамжийн буцаалт* | *1,020* | *1,239* | *1,538* | *1,955* | *2,544* |

МАНДАЛ даатгал УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС GOLOMT CAPITAL LLC ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Цэвэр хураамжийн орлого** | **12,209** | **15,257** | **18,368** | **22,790** | **28,946** |
| ОТХНС-ийн өөрчлөлт | (1,729) | (1,472) | (1,452) | (2,038) | (2,833) |
| **Орлогод тооцсон хураамж** | **10,480** | **13,786** | **16,916** | **20,752** | **26,113** |
| Цэвэр нөхөн төлбөр | 3,540 | 4,507 | 5,670 | 7,231 | 9,467 |
| Нөөц сангийн өөрчлөлт | (320) | (661) | (626) | (767) | (1,072) |
| Даатгалын гэрээний зардал | 1,877 | 2,811 | 3,259 | 3,835 | 4,595 |
| Давхар даатгалын шимтгэлийн орлого | 369 | 379 | 574 | 835 | 1,214 |
| Хөрөнгө оруулалтын орлого | 1,796 | 2,726 | 3,576 | 4,743 | 6,357 |
| **Даатгалын үйл ажиллагааны ашиг** | 6,908 | 8,912 | 11,511 | 14,496 | 18,549 |
| Үйл ажиллагааны зардал | 4,650 | 5,094 | 5,395 | 5,742 | 6,170 |
| **Татварын өмнөх ашиг (алдагдал)** | 2,258 | 3,818 | 6,116 | 8,754 | 12,380 |
| Орлогын татварын зардал | 226 | 382 | 612 | 875 | 1,238 |
| **Цэвэр ашиг/алдагдал** | **2,032** | **3,436** | **5,505** | **7,878** | **11,142** |

Хүснэгт 30. Санхүү байдлын төсөөлөл 2018-2022

| (сая төг.) | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 19,010 | 21,745 | 26,221 | 32,584 | 41,568 |
| Даатгалын авлага | 3,738 | 4,235 | 4,934 | 5,931 | 7,370 |
| Бусад хөрөнгө | 180 | 180 | 180 | 180 | 180 |
| Даатгалын хөрөнгө | | | | | |
| ДД-ын хойшлогдсон хураамж | 4,069 | 5,883 | 8,335 | 11,260 | 16,010 |
| Нөхөн төлбөрийн нөөцийн ДД-ын ногдох хэсэг | 1,247 | 1,733 | 2,201 | 2,621 | 3,289 |
| Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал | 1,178 | 1,362 | 1,595 | 1,897 | 2,300 |
| Үндсэн хөрөнгө /Цэвэр/ | 294 | 386 | 439 | 451 | 423 |
| Биет бус хөрөнгө /Цэвэр/ | 105 | 105 | 105 | 105 | 105 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 237 | 237 | 237 | 237 | 237 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **30,058** | **35,866** | **44,247** | **55,266** | **71,482** |
| **ӨР ТӨЛБӨР** | - | - | - | - | - |
| Давхар даатгалын өглөг | 2,551 | 1,961 | 1,291 | 321 | - |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөц | 9,877 | 11,691 | 14,144 | 17,069 | 20,723 |
| Нөхөн төлбөрийн нөөц сан | 3,675 | 4,823 | 5,917 | 7,104 | 8,845 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН** | 16,104 | 18,476 | 21,352 | 24,493 | 29,568 |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | - | - | - | - | - |
| Эзэмшигчдийн өмч | 10,966 | 10,966 | 10,966 | 10,966 | 10,966 |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | 2,988 | 6,424 | 11,929 | 19,807 | 30,948 |
| **ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | 13,954 | 17,390 | 22,895 | 30,773 | 41,914 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **30,058** | **35,866** | **44,247** | **55,266** | **71,482** |

**Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй хүрээнд хувьцаа санал болгох замаар 5,966,476,800 төгрөг татсанаар орлогод тооцсон хураамж 49%, хөрөнгө оруулалтын орлого 46%, цэвэр ашиг 84% өсөх төлөвтэй байна. Мөн цэвэр маржин 19% болж өсөж нийлмэл харьцаа 92.5% болж буурах төлөвтэй байна.** 2018-2022 оны үнэт цаас гаргагчийн бизнес төлөвлөгөөний дагуу 2022 он гэхэд нийлмэл харьцаа өнөөгийн түвшин буюу 93%-с 75% болж буурах, өөрийн хөрөнгийн өгөөж 27% болж өсөх төлөвтэй байна. Үнэт цаас гаргагчийн гол санхүүгийн үзүүлэлтүүдийг дараах графуудаар илэрхийллээ.

| | 2017A | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|---|
| НХО өсөлт | 72% | 9% | 16% | 18% | 5% | 29% |
| ОТХ өсөлт | 67% | 49% | 32% | 23% | 23% | 26% |
| Хөрөнгө оруулалтын орлогын өсөлт | 23% | 46% | 52% | 31% | 33% | 34% |
| Цэвэр ашиг өсөлт | 1193% | 84% | 69% | 60% | 43% | 41% |

МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
117236007 5473489
GOLOMT CAPITAL LLC
Огноо: 2018/04/16

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| *Бохир маржин (ОТХ/НХО)* | *31%* | *43%* | *49%* | *50%* | *59%* | *57%* |
| *Цэвэр маржин (Цэвэр ашиг/ОТХ)* | *16%* | *19%* | *25%* | *33%* | *38%* | *43%* |
| *Өөрийн хөрөнгийн өгөөж* | *18%* | *15%* | *20%* | *24%* | *26%* | *27%* |
| *Нийт активийн өгөөж* | *5%* | *7%* | *10%* | *12%* | *14%* | *16%* |
| *Хохирлын харьцаа (Цэвэр нөхөн төлбөр/ОТХ)* | *29%* | *34%* | *33%* | *34%* | *36%* | *37%* |
| *Зардлын харьцаа (Ү/а зардал/ОТХ)* | *63%* | *59%* | *56%* | *51%* | *44%* | *38%* |
| *Нийлмэл харьцаа (Хохирлын харьцаа+зардлын харьцаа)* | *93%* | *93%* | *89%* | *85%* | *80%* | *75%* |

## 3.9. Үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах

Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа нь МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 дугаар сарын 25-ны өдрийн 2018/01 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор шинэчилэн баталсан "Арилжааны журам"-ын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-өөс 2018 оны 02 сарын 15-ны өдрийн 18/002 тоот тогтоолын дагуу нийтэд санал болгох энгийн хувьцааны үнийг 4,800 төгрөгөөр тогтоосон бөгөөд МХБ-н Анхдагч зах зээлийн арилжааны Тогтоосон үнийн аргыг ашиглан санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй 1,560,754 ширхэг энгийн хувьцааны худалдан авах захиалгыг МХБ болон СЗХ үнэт цаасыг бүртгэсэн өдрөөс хойш 4 хоног үнэт цаасны танилцуулга арга хэмжээнүүд явагдсаны дараа 2018 оны 09 сарын 4-өөс 14 хоногийн турш авах ба 2018 оны 09 сарын 18-ны өдөр арилжааг хаахаар төлөвлөж байна.




1. Бүртгүүлэх - МХБ болон СЗХ-с зөвшөөрөл гарч бүртгүүлэх
2. Roadshow/нийтэд мэдээллэх аян - Бүртгүүлсэн өдрөөс 4 хоногийн дотор
3. Захиалга авах/Book building - Бүртгүүлсэн өдрөөс 18 хоногийн дотор
4. Арилжаа - Бүртгүүлсэн өдрөөс 18 хоногийн дараа
5. Төлбөр тооцоо - Арилжааны өдрөөс Т+0 горимоор

Үнэт цаасны танилцуулга
2018.08.29
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
БҮРТГЭВ
МАНДАЛ даатгал

**Үнэт цаасны анхдагч арилжаанд оролцох заавар**

Хөрөнгө оруулагч нар үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаанд дараах зааврын дагуу оролцоно.

1. ***Арилжааны данс нээлгэх***
   *- Хүссэн ҮЦК дээр арилжааны данс нээлгэх;*
   *- ҮЦК нь ҮЦТХТ болон Арилжааны Төлбөр Тооцоо ХХК дээр харилцагчийн дансыг нээлгэнэ.*
2. ***Мөнгөө байршуулах***
   *Арилжааны Төлбөр Тооцоо ХХК дээрх өөрийн нэр дээрх 0120 0000 • • • • тоот дансанд мөнгөө байршуулна.*
3. ***Захиалга өгөх***
   *Өөрийн үйлчлүүлдэг ҮЦК-д үнэт цаас худалдан авах захиалга өгнө.*
4. ***Арилжаа хаагдах***
   *Анхдагч зах зээлийн арилжаа хаагдаж үнэт цаас хөрөнгө оруулагчийн нэр дээр шилжинэ.*

**Мөнгөн хөрөнгө байршуулах**

Шинээр хувьцаа худалдан авах хүсэлтэй хөрөнгө оруулагч нь өөрийн хүссэн банкаар дамжуулан Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь өөрийн нэрийн дансандаа мөнгөө байршуулах боломжтой.

"ҮЦТХТ" ХХК болон "Арилжаа төлбөр тооцоо" ХХК-нь хувьцааны мөнгөн төлбөр нь бүрэн байршсан хөрөнгө оруулагчдын дансны мэдээллийг МХБ руу анхдагч зах зээлийн арилжаа эхлэхээс өмнө хүргүүлэх ба Андеррайтерийн компани нь МХБ-тэй хамтран тус хөрөнгө оруулагчдын захиалгыг нийлүүлэх ажиллагааг анхдагч зах зээлийн арилжаа хаасны дараа явуулан, холбогдох тайлан мэдээг СЗХ-нд хүргүүлнэ.

**Арилжааны шимтгэл**

Үнэт цаас худалдан авагч нь гүйлгээний үнийн дүнгийн тодорхой хувиар тооцсон үйлчилгээний хөлс буюу шимтгэлийг өөрийн сонгосон болон захиалга өгсөн БДК-д төлөх ба уг шимтгэлд МХБ, Үнэт цаасны төлбөр, тооцоо төвлөрсөн хадгаламжийн байгууллага болон БДК-ийн шимтгэлийн нийт дүн багтсан байна. МХБ-ийн гишүүн БДК-уудын шимтгэл нь харилцан адилгүй болохыг анхаарна уу.

**Албан татвар**

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хувь хүн нь "Хувь хүний орлогын албан татварын тухай хууль"-ийн 13.1.3-т заасан орлого (ногдол ашгийн орлого)-ын нийт дүнгээс, 14.1.3-т заасан орлого (хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого)-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс тус хуулийн 23.1-т заасан 10 хувийн хэмжээгээр татвар төлнө.

Үнэт цаасанд хөрөнгө оруулагч хуулийн этгээд буюу аж ахуйн нэгж нь "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль"-ийн 16.3.1-т заасан "ногдол ашгийн орлого"-ын нийт дүнгээс, 16.8-д заасан "хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого-оос худалдаж авсан үнийг хассан зөрүүгээс энэ хуулийн 17.1, 17.2.1-т заасан албан татвар төлнө.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК



Огноо: 2018/04/16

2018 .08. 29 оны
БҮРТГЭВ
№ 1

МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ
... сар .... өдөр
U1

# 4. ХАРААТ БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ДҮГНЭЛТИЙН ХУРААНГУЙ

## 4.1. Хараат бус аудиторын дүгнэлт

### Санхүүгийн тайлангийн аудит хийсэн тухай тайлан

*Дүгнэлт*

Бид "Мандал Даатгал" XXK (цаашид "Компани" гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, "Мандал даатгал" XXK-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон СЗХ-ны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

*Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол Улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

*Бусад асуудал*

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь Компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

*Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүрээх үүрэг хариуцлага*

Компаний удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд

санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

*Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор буюу тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон

шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

### *Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар*

Монгол Улсад даатгалын үйл ажиллагааг зохицуулах үндсэн хууль тогтоомж нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, СЗХ-ны тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрэм, журмууд байна.

Компани нь 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдаж, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даатгалын байгууллагууд дагаж мөрдөх үүрэгтэй "Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ыг баримталж санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

### *Төлбөрийн чадварын талаар*

Компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа 109.82% (2016: 101.27%) байгаа нь Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журмын 3.12-д заасан "Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино" гэсний дагуу зохистой байна.

### *Аудитын тайлангийн хэрэглээ*

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувь нийлүүлэгч болон хөрөнгө оруулагч нарт зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

## 4.2. Үнэлгээний байгууллагын хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний дүгнэлт

### 4.2.1. Хөрөнгийн үнэлгээ

**Хураангуй үр дүн**

*Эргэлтийн бус хөрөнгө*

- Хөрөнгө оруулалтын буюу ирээдүйд борлуулах зориулалтаар эзэмшиж байгаа орон сууц болон тээврийн хэрэгслийн үнэ цэнийг тооцохдоо бид зах зээлийн хандлагыг хэрэглэсэн.
- Харин бусад үндсэн хөрөнгө болон компанийн үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа программ хангамжийн үнэ цэнийг тооцохдоо тухайн хөрөнгийг олж бэлтгэх үеийн ам долларын төгрөгийн ханш ба үнэлгээний өдрийн ам. доллартой харьцах төгрөгийн ханш хоорондын ялгаагаар индексжүүлэн тооцсон нөхөн оруулах өртгөөс ашигласан хугацаанд ногдох хуримтлагдсан элэгдэл, аливаа үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тооцоолсон.

*Эргэлтийн хөрөнгө*

- Компанийн 2017 оны 12 сарын 31-ний санхүүгийн тайланд авлага болон бараа материалаар тусгагдсан эргэлтийн хөрөнгийг тэдгээрийн насжилтын тайланд суурилан шинжилж, авлагын цуглуулагдахгүй байх магадлалаар жигнэсэн хорогдуулсан өртгөөр үнэлсэн.
- Бид өөрсдийн хийсэн шинжилгээ, компанийн удирдлагатай хийсэн ярилцлага, аудиторын тайланд суурилан мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болон хөрөнгө оруулалтын дансны үнэ нь эдгээр хөрөнгийн бодит үнэ цэнэтэй тэнцүү байна гэж дүгнэсэн.
- Компанийн даатгалын хөрөнгө болон урьдчилж гарсан зардал зэрэг хөрөнгө нь ирээдүйн орлого болон актуэр тооцоололд суурилан тооцоологдсон учраас үнэлгээний өдрийн бодит үнэ цэнийг илэрхийлнэ гэж дүгнэсэн.

*Үнэлгээний үр дүнгийн талаарх дүгнэлт*

- Бидний гүйцэтгэсэн үнэлгээний шинжилгээгээр, Мандал даатгал ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Борлуулах зориулалтаар эзэмшиж буй орон сууц нь ойролцоогоор 249,364 (хоёр зуун дөчин есөн сая гурван зуун жаран дөрвөн мянган төгрөг) мянган төгрөг, конторын болон үйл ажиллагаанд ашиглаж байгаа үндсэн хөрөнгө нь ойролцоогоор 275,888.7 (хоёр зуун далан таван сая найман зуун наян найман мянга долоон зуун төгрөг) мянган төгрөг, даатгалын үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамжууд нь ойролцоогоор 96,600 (ерэн зургаан сая зургаан зуун мянган төгрөг) мянган төгрөгийн зах зээлийн үнэ цэнэтэй байх үндэслэлтэй гэж бид дүгнэж байна.
- Бидний хийсэн шинжилгээ, цуглуулсан нотолгоо, тооцоолол, аудит хийгдсэн санхүүгийн тайлангаас үзэхэд үнэлгээний тохируулгын дараах байдлаар Мандал даатгал ХХК-ийн эргэлтийн хөрөнгө нь 20,260,192.3 (хорин тэрбум хоёр зуун жаран сая нэг зуун ерөн хоёр мянга гурван зуун төгрөг) мянган төгрөг байна.
- Мандал даатгал ХХК-ийн 2017 оны 12 сарын 31-нээрх орлогод тооцоогүй хураамжийн нөөц нь 9,366,278.0 мянган төгрөг, нөхөн төлбөрийн нөөц сан нь 2,910,658.8 мянган төгрөг, даатгалын өглөг нь 2,055,456.1 мянган төгрөг, бусад санхүүгийн бус өр төлбөр 1,138,865.0 мянган төгрөг байх бөгөөд эдгээрийн нийлбэрээр 15,471,258.9 мянган төгрөгийн нийт өр төлбөртэй байна.
- Дахин үнэлэгдсэн нийт хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцсон Мандал даатгал ХХК-ийн 2017 оны 12 сарын 31-нээр цэвэр өөрийн хөрөнгийн хэмжээ 5,411,256.1 мянган төгрөг байна.

Хүснэгт 31. Хөрөнгийн үнэлгээний үр дүнгийн нэгтгэл

| мянган төгрөг | Үнэлгээний өдрөөрх дансны үнэ | Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ | Ашигласан арга, хандлага |
|---|---|---|---|
| **А. Эргэлтийн бус хөрөнгө** | **582,921.3** | **622,352.7** | |
| Борлуулах зориулалтаар эзэмшиж байгаа орон сууц | 236,640.0 | 249,864.0 | Зах зээлийн хандлага |
| Үндсэн хөрөнгө | - | - | |
| Тээврийн хэрэгсэл | 78,166.5 | 71,733.0 | Зах зээлийн хандлага |
| Конторын тоног төхөөрөмж | 13,606.8 | 13,606.8 | Өртгийн хандлага |
| Тавилга эд хогшил | 103,797.4 | 103,797.4 | Өртгийн хандлага |
| Тооцоолох техник | 67,123.9 | 67,123.9 | Өртгийн хандлага |
| Бусад үндсэн хөрөнгө | 26,261.5 | 19,627.6 | Өртгийн хандлага |
| Биет бус хөрөнгө | | | |
| Программ хангамж | 57,325.3 | 96,600.0 | Өртгийн хандлага |
| **Б. Эргэлтийн хөрөнгө** | **20,889,229.2** | **20,260,192.3** | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн | 1,805,206.3 | 1,805,206.3 | Нэрлэсэн үнэ |
| Даатгалын авлага | 4,402,449.9 | 3,854,655.9 | Хорогдуулсан өртөг |
| Бусад авлага /цэвэр дүнгээр/ | 401,174.1 | 341,859.5 | Хорогдуулсан өртөг |
| Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн | 182,385.1 | 160,456.9 | Хорогдуулсан өртөг |
| Хөрөнгө оруулалт | 9,229,437.6 | 9,229,437.6 | Бодит үнэ цэнэ |
| Даатгалын хөрөнгө | 4,868,576.1 | 4,868,576.1 | Дансны үнээр |
| **В. Нийт хөрөнгө** | **21,472,150.5** | **20,882,545.0** | |
| **Г. Нийт өр төлбөр** | **-15,471,258.9** | **-15,471,258.9** | **Дансны үнээр** |
| **Д. Цэвэр өмч** | **6,000,891.3** | **5,411,286.1** | |

## 4.2.2. Бизнесийн үнэлгээ

### Хураангуй үр дүн

- Бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо бид зах зээлийн хандлага ба орлогын хандлагыг авч үзсэн. Зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээнд бид жишиг компанийн арга зүй болон жишиг арилжааны арга зүйг ашигласан бол орлогын хандлагаар тооцсон үнэлгээнд хорогдуулсан мөнгөн урсгалын загварыг удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцсон.

**Бизнесийн 100 хувийн хувь оролцооны үнэ цэнийн дүгнэлт**

- Бид мэргэжлийн багийн түвшинд шүүн тунгаасны үндсэнд дээр дурдсан арга хандлагуудаас Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүн нь үнэлгээний өдрөөр байдлаар бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна гэж дүгнэсэн.
- Мандал Даатгал ХХК нь үнэлгээний өдрийн байдлаар 1,805,206 мянган төгрөгийн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө, 8,416,719 мянган төгрөгийн хадгаламжийн сертификат, 812,728 мянган төгрөгийн үнэт цаастай, санхүүгийн өр төлбөргүй бөгөөд бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **23,619,153 – 25,208,593 мянган төгрөг** байх үндэслэлтэй байна.

Хүснэгт 32. Үнэлгээний эцсийн үр дүн

| *мянган төгрөг* | *Доод хязгаар* | *Дээд хязгаар* |
|---|---|---|

| | | |
|---|---|---|
| *Урт хугацааны өсөлтийн түвшин* | *3.61%* | *5.61%* |
| **Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ** | **23,619,153** | **25,208,593** |

*Хүснэгт 33. Үнэлгээний үр дүнгүүдийн харьцуулалт*

| *Үнэлгээний арга хандлага* | *мянган төгрөг* |
|---|---|
| Жишиг арилжааны арга | 23,209,501 |
| Жишиг компанийн арга | 27,294,624 |
| Хорогдуулсан мөнгөн урсгал | 23,619,153 |
| Тохируулсан цэвэр активын арга | 5,411,286 |

## Үнэлгээний арга хандлага

- Бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнийг үнэлэхдээ бид дараах зүйлсийг нэгтгэн авч үзсэн. Үүнд:
  - Ердийн даатгалын үйл ажиллагааг хамарсан бизнесийн зах зээлийн үнэ цэнэ;
  - Мандал-ын эзэмшиж буй хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ;
- Мандал-ын үндсэн бизнесийн шугам нь ердийн даатгалын үйл ажиллагаа бөгөөд энэ бизнесийн шугамаас өөр аливаа үйл ажиллагаа, түүнээс бий болсон орлого түүхэн тайлант хугацаанд үүсээгүй болно.
- Мандал-ын бизнесийг үнэлэхдээ бид дараах төсөөлөлд үндэслэн орлогын хандлагаас ХМУ-ний загвар, зах зээлийн хандлагаас жишиг компани ба жишиг арилжааны арга зүйг сонгон ашигласан бөгөөд хөрөнгийн хандлагаар тооцсон үнэлгээнд ач холбогдол өгөөгүй ч үнэ цэнийн баталгаажуулалт хийх зорилгоор авч үзсэн.
  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд, догол мөр 40.2 буюу 40.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд орлогын хандлагыг тогтмол хэрэглэдэг. Мөн түүнчлэн, компани нь урьдчилан харах боломжтой ирээдүйд бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх төсөөлөл баримталдаг. Иймээс тасралтгүй хугацаанд уг бизнесийн бий болгож чадах эдийн засгийн өгөөж буюу мөнгөн урсгалд үндэслэн ХМУ-ний загвар боловсруулах боломжтой.
  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд, догол мөр 20.2 буюу 20.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд зах зээлийн хандлагыг ихэвчлэн ашигладаг. Зах зээлийн хандлага нь бизнесийн хувьд хамгийн бодитой, ул үндэслэлтэй үнэ цэнийн дүгнэлт гаргах боломж олгодог. Учир нь энэ аргын үед бизнесийн үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа, ижил буюу жиших боломжтой бизнесийн орц мэдээлэлд үндэслэдэг. Даатгалын салбарын уламжлалт эрсдэлээс (зохицуулалтын нөлөө, системийн эрсдэл) шалтгаалан дан ганц ХМУ загвар ашиглан үнэ цэнэ тооцох нь хангалтгүй бөгөөд хүрэлцээгүй гэж бид үзсэн. Иймээс сүүлийн жилүүдэд даатгалын салбарт хийгдсэн бодит арилжаа, нээлттэй жишиг компаниудын зах зээлийн үнэ цэнийг шинжлэх замаар үнэлгээний өдрөөр байдлаар зах зээлийн арилжааны ханшийг тогтоосон.
  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд-ын догол мөр 70.2 юм уу 70.3-ын шалгуурыг маш цөөн тохиолдолд хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд өртгийн хандлагыг ихэвчлэн хэрэглэдэггүй. Гэсэн ч хөрөнгөд суурилсан бизнесийн хувьд орлого болон зах зээлийн хандлагын үр дүнг баталгаажуулах зорилгоор хөрөнгийн аргаар үнэлгээ бэлтгэж болно.
- Орлогын ба зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээний үр дүн хоорондоо нийцгүй байж болно. Энэ нь үнэлгээний хандлагуудын дотоод шинж чанараас ихээхэн хамаарна. Тухайлбал, ХМУ-ний хандлага нь ирээдүйд бүтээн босгох үйлдвэрийн ажилд шаардагдах капитал, хугацааны мэдээллийг тусгахад хамгийн зохистой хандлага юм. Харин зах зээлийн хандлага нь салбарын

Үнэт цаасны танилцуулга
2018 .08. 29 өдөр

МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ

ь өнөөгийн төлөв байдал, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, хөрөнгө оруулагчдын хандлагыг тусгахад илүү тохиромжтой байдаг.

## Үнэлгээний үр дүн

*Орлогын хандлага: ХМУ загвар*

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ, удирдлагаас хүлээн авсан бизнесийн төлөвлөгөөнд суурилан Мандал-ын ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцож, бизнесийн үнэ цэнийг тодорхойлсон.
- Мөнгөн урсгалын төсөөлөл нь удирдлагаас бидэнд ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн бөгөөд хорогдуулах хүүний тооцооллыг БДО Монгол-ын шинжилгээгээр 23.8%-иас 24.8% байхаар тооцсон. Мөн түүнчлэн бид дараах арга зүй, параметрүүдийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан.
  - Бизнесийн үлдэх үнэ цэнэ буюу эцсийн мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.
  - Урт хугацааны өсөлтийн параметрийг сонгохдоо Сангийн яам-ны урт хугацааны эдийн засгийн өсөлтийн судалгаанд тодорхойлсон 3.6%-иас 5.6% байхаар сонгон авсан.
  - Урт хугацааны хүлээгдэж буй инфляц 6.44% байна.
  - Хувьцаат капиталын цэвэр дансны үнэ таамагласан хугацааны туршид өөрчлөгдөхгүй гэж таамагласан.
  - Бид хорогдуулах хүүний үеийг дундаж үеийн аргаар тооцсон.
- Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **23,619,153 – 25,208,593 мянган төгрөг** байна.

*Хүснэгт 34. Мөнгөн урсгалын төсөөлөл*

| *Мянган төгрөг* | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| **Татварын дараах цэвэр ашиг** | **1,906,234** | **2,602,224** | **3,869,198** | **5,519,404** | **7,927,123** |
| Хойшлогдсон татвар | - | - | - | - | - |
| Тохируулсан татварын дараах цэвэр ашиг | 1,906,234 | 2,602,224 | 3,869,198 | 5,519,404 | 7,927,123 |
| Хувьцаат капиталын эхний үлдэгдэл | 5,000,000 | 5,000,000 | 5,000,000 | 5,000,000 | 5,000,000 |
| **Нуугдмал чөлөөт мөнгөн урсгал** | **1,906,234** | **2,602,224** | **3,869,198** | **5,519,404** | **7,927,123** |
| Хувьцаат капиталын эхний үлдэгдлийн өгөөж | 38.12% | 52.04% | 77.38% | 110.39% | 158.54% |
| Хувьцаат капиталын эхний үлдэгдлийн тохируулсан өгөөж | 38.12% | 52.04% | 77.38% | 110.39% | 158.54% |
| Хөрөнгө оруулалтын өгөөж | 10.85% | 14.14% | 15.06% | 15.75% | 16.26% |
| **Нуугдмал үлдэгдэл орлого** | **665,338** | **1,361,328** | **2,628,302** | **4,278,508** | **6,686,227** |

*Хүснэгт 35. Үнэ цэнийн тооцоолол*

| *Мянган төгрөг* | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| **Тасралттай мөнгөн урсгал** | **1,906,234** | **2,602,224** | **3,869,198** | **5,519,404** | **7,927,123** |
| **Тасралтгүй мөнгөн урсгал** | | | | | **31,681,740** |
| Хорогдуулах үе | 0.50 | 1.50 | 2.50 | 3.50 | 4.50 |
| Хорогдуулах хүчин зүйл | 0.90 | 0.73 | 0.59 | 0.47 | 0.38 |
| Хорогдуулсан дискрет мөнгөн урсгал | 1,712,606 | 1,888,175 | 2,268,266 | 2,611,841 | 3,029,698 |
| Хорогдуулсан эцсийн мөнгөн урсгал | | | | | 12,108,567 |
| **100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ** | | | | | **23,619,153** |
| **100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян ам доллар)** | | | | | **9,731** |

*Зах зээлийн хандлага: ЖКАЗ*

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үйлчлүүлэгчтэй ижил бизнесийн эрсдэл бүхий жишиг компаниудын зах зээлийн үнэлгээг тооцож, бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнийг тодорхойлсон.
- Үнэлгээний баг жишиг компаниудыг сонгохдоо эдийн засгийн анхдагч орчны (1) ижил эрсдэлтэй улс орнуудын (2) ойролцоо эрсдэлтэй улс орнуудын ердийн даатгал компаниудыг судалсан. Хэрэв ижил эрсдэлтэй орчин байрлах даатгалын компаниуд хангалттай буюу хүрэлцээтэй орц мэдээлэлгүй бол ойролцоо эрсдэлтэй компаниуд руу шилжих замаар түүврийн цар хүрээг өргөтгөсөн.
- Жишиг компанийн арга зүйгээр тооцсон үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **27,294,624 мянган төгрөг** байна.
- Жишиг компанийн мэдээлэлд тохируулга хийснээр орц мэдээллийн түвшин 1-р зэрэглэлээс 2-р зэрэглэл рүү шилжсэн тул жишиг компанийн арга зүйд үнэлгээний баг ач холбогдол өгөөгүй болохыг анхаарна уу.

*Хүснэгт 36. Жишиг компанийн аргаар тооцсон үнэлгээний үр дүн*

| ***Жишиг компанийн аргаарх зах зээлийн үнэлгээ*** | |
|---|---|
| **Татварын өмнөх ашиг** | **1,265,073** |
| Хүүний зардал | - |
| Элэгдэл, хорогдол | - |
| **ХТЭХӨА** | **1,265,073** |
| | |
| ***Жишиг компанийн аргаарх зах зээлийн үнэлгээ*** | |
| Анхдагч үнэлгээ | |
| Санхүүгийн хэмжүүр | 1,265,073 |
| Үндсэн үржүүлэгч | 21.58x |
| **Тохируулсан зах зээлийн үнэлгээ** | **27,294,624** |
| **Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян.төг)** | **27,294,624** |
| **Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян.ам доллар)** | **11,246** |

*Зах зээлийн хандлага: ЖААЗ*

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үйлчлүүлэгчтэй ижил бизнесийн эрсдэл бүхий жишиг компаниудын нэгдэл ба худалдан авалтын зах зээл дахь арилжаануудыг судлах замаар бизнесийн 100%- ийн хувь оролцооны үнэ цэнийг тодорхойлсон.
- Ази Номхон далайн бүс нутагт хийгдсэн жишиг арилжааны мэдээлэл хомс байснаас үүдэн үнэлгээний түүврийн хязгаарыг тэлж, Ойрх дорнод, Европын бүс нутагт хийгдсэн даатгалын арилжааг судалсан. Цаашлаад, сонгогдсон арилжааны параметрүүдийг эдийн засгийн анхдагч орчны ялгаагаар тохируулж, хэт хэлбэлзэлтэй элементүүдийг засварласан.
- Жишиг арилжааны аргаар тооцсон үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **23,209,501 мянган төгрөг** байна.
- Жишиг арилжааны мэдээлэлд тохируулга хийснээр орц мэдээллийн түвшин 1-р зэрэглэлээс 2-р зэрэглэл рүү шилжсэн тул жишиг арилжааны арга зүйд үнэлгээний баг ач холбогдол өгөөгүй болохыг анхаарна уу.

*Хүснэгт 37. Жишиг арилжааны аргаар тооцсон үнэлгээний үр дүн*

| ***Жишиг арилжааны аргаарх зах зээлийн үнэлгээ*** | |
|---|---|
| **Татварын өмнөх ашиг** | **1,265,073** |
| Орлогын албан татвар | 162,548 |

| | |
|---|---|
| **ХТЭХӨА** | **1,102,525** |

***Жишиг арилжааны аргаарх зах зээлийн үнэлгээ***

| | |
|---|---|
| Анхдагч үнэлгээ | |
| Санхүүгийн хэмжүүр | 1,102,525 |
| Үндсэн үржүүлэгч | 21.05x |
| **Тохируулсан зах зээлийн үнэлгээ** | **23,209,501** |
| **Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян.төг)** | **23,209,501** |
| **Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян.ам доллар)** | **9,563** |

*Өртгийн хандлага: Тохируулсан цэвэр активын арга*

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үйлчлүүлэгчийн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлж, цэвэр активт тохируулга хийх замаар бизнесийн үнэ цэнийн доод хязгаарыг тодорхойлсон.
- Тохируулсан цэвэр активын аргыг ихэвчлэн устгалын үнэ цэнэ тооцоход ашигладаг. Бид энэ аргыг үйлчлүүлэгчийн өмчид ногдох үнэ цэнийн доод хязгаар тогтоох зорилгоор ашигласан.
- Мандал-ын хөрөнгийн үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгасны дараа үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **5,411,286 мянган төгрөг** байна.

## 4.3. Хуулийн дүгнэлт

Өмгөөллийн "Батбаяр энд Партнэрс" ХХН /цаашид "Хуулийн фирм" гэнэ/ нь Үнэт цаас гаргагчтай 2018 оны 02 сарын 21-ний өдөр байгуулсан №18/020 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ /цаашид "Гэрээ" гэнэ/-ний дагуу Мандал даатгал ХХК-аас анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргахтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасан асуудлын хүрээнд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, энэхүү хуулийн дүгнэлт /цаашид "Хуулийн дүгнэлт" гэнэ/ бэлтгэн хүргүүлж байна.

Тус Хуулийн фирм нь анх удаа олон нийтэд үнэт цаас санал болгох энэхүү төслийн үйл ажиллагаанд оролцож байгаа андеррайтерийн компани болох Голомт капитал ҮЦК ХХК, үнэлгээний компани болох БДО Аудит ХХК, аудитын компани болох Улаанбаатар Аудит Корпораци ХХК болон үнэт цаасаа олон нийтэд санал болгож байгаа Мандал даатгал ХХК, түүний хувьцаа эзэмшигчид, нэгдмэл сонирхолтой этгээдүүд, эрх бүхий албан тушаалтан болон холбоотой этгээдүүдтэй аливаа харилцан хамааралгүй, ашиг сонирхлын хувьд холбоогүй, хөндлөнгийн этгээд болохыг үүгээр баталгаажуулж байна.

**Хуулийн дүгнэлт гаргах үндэслэл, ажлын даалгавар**

Мандал даатгал ХХК-аас анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргаж, компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулахтай холбогдуулан Хуулийн фирм нь Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны №408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 5 дугаар зүйлийн дахь заалт, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2018 оны №2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан дараах асуудлуудыг Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК хангаж буй эсэхэд Хуулийн дүгнэлт гаргаж өгөхөөр харилцан тохиролцсон. Үүнд:

1. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх, улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх;
2. Компанийн дүрэм, дотоод журмууд, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод журмуудын төсөл нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-т нийцсэн эсэх;
3. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан эсэх болон тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал;
4. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;
5. Сүүлийн 3 жил дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
6. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл, үр дагавар буй эсэх;
7. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;
8. Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;
9. Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох.

Гэрээгээр хүлээсэн Ажлын даалгаварт (i) Мандал даатгал ХХК-ийн хэлбэрийг өөрчлөхөд холбогдох өөрчлөн байгуулах асуудал; (ii) Санхүүгийн зохицуулах хороонд хуулиар олгогдсон хянан шалгах

асуудлын хүрээнд багтсан Мандал даатгал ХХК нь даатгалын хууль тогтоомж, багц дүрэм, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар болон Санхүүгийн зохицуулах хорооноос бүрэн эрхийнхээ хүрээнд зөвшөөрөл олгосон аливаа асуудлаар дахин тусгайлсан дүгнэлт гаргах ажил багтаагүй болохыг анхаарна уу.

Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлттэсэн бөгөөд гадаад улсын хууль тогтоомж, хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх, гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлох, гадаад улсын хуулийн дагуу хүчин төгөлдөр байдлыг тодорхойлохтой холбоотой бичгээр байгуулсан гэрээ, хэлцэлтэй холбоотой асуудал багтаагүй болно.

**Үнэт цаас гаргагчийн анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа үнэт цаасны тухай**

Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд компанийн мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх замаар эрсдэл даах чадварыг өсгөх, зах зээлд эзлэх байр суурийг дээшлүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор нийт гаргасан өөрийн энгийн хувьцааны 25%-ийг олон нийтэд эзэмшүүлэх замаар Мандал даатгал ХХК-ийн хэлбэрийг өөрчлөхөөр шийдвэрлэсэн гэж Хуулийн фирм ойлгосон. Улмаар Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчид 2018 оны 02 сарын 12-ны өдөр ээлжит бүс хурал хийж, №004 тоот "Компанийн хэлбэрийг өөрчлөх, түүнтэй холбоотой авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын дагуу дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

(i) Мандал даатгал ХХК-ийг "хувьцаат компани" болгох замаар өөрчлөн байгуулж хэлбэрийг өөрчилж, эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсгэн байгуулагдсан хувьцаат компанид шилжүүлэх;
(ii) Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж 1,243,016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) ширхэг энгийн хувьцаа гаргаж олон нийтэд санал болгох;
(iii) Мандал даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигч Юу Эм Си капитал ХХК-ийн эзэмшилд байгаа Мандал даатгал ХХК-ийн 317,738 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгохоор шийдвэрлэснийг зөвшөөрч баталгаажуулах;
(iv) Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн хэлбэрийг өөрчлөн байгуулах төслийг баталж тус тус шийдвэрлэсэн байна.

Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2018 оны 02 сарын 15-ны өдрийн №002 тоот "Нийтэд санал болгох энгийн хувьцааны нэрлэсэн үнийг тогтоох тухай" тогтоолын дагуу нийтэд санал болгох энгийн хувьцааны үнийг 4,800 (дөрвөн мянга найман зуун) төгрөгөөр тогтоосон байна. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагаас гаргасан эдгээр шийдвэрүүд нь хуульд нийцсэн[6], Компанийн хуульд тусгасан шаардлагыг хангасан, хүчин төгөлдөр шийдвэрүүд байна гэж Хуулийн фирм үзлээ.

Түүнчлэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан өөрчлөн байгуулах төслөөс харвал Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигч Юу Эм Си капитал ХХК нь Мандал даатгал ХХК-ийн хувьцааны олон нийтэд арилжаалагдах тархалтын хувийг нэмэгдүүлэх зорилгоор өөрийн эзэмшилд байгаа Мандал даатгал ХХК-ийн 317,738 ширхэг энгийн хувьцааг Мандал даатгал ХХК-ийн нийтэд анх удаа санал болгож байгаа үнэт цаасны хамт, ижил үнээр олон нийтэд санал болгохоор Хувьцаа эзэмшигчийн 2018 оны 02 сарын 09-ний өдрийн №18/001 тоот

[6] Компанийн тухай хууль (2011),
23 дугаар зүйл.Компанийг өөрчлөх
23.1Хувьцаат компанийгхязгаарлагдмал хариуцлагатай комлани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно.
23 2.Энэ хуулийн 23.1-д заасны дагуу компанийг өөрчлөх төслийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хурадд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.
23,3,Энэ хуулийн 23.2-т заасантөсөлд компанийг өөрчлөхзорилго, нөхцөл, журам, хугацаа, хувьцаагхарилцан хөрвүүлэхарга, тооцоо, хувьцаа эзэмшигчдийн хурлыгхуралдуулах хугацаа зэргийгтусгасан байна.
23.5 Компанийг өөрчлөхөд түүний эрх, үүрэг, хариуцлага шинээр бий болж байгаа компанид шилжинэ.
23.6 Компанийг өөрчлөх тохиолдолд холбогдох өөрчлөлтийг компанийн оноосон нэр болон дүрэмд тусгана,
55 дугаар зүйл Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох
55.1 Компанийн эдхөрөнгө, эдхөрөнгийн эрхийн/компанийн хувьцаа болон бусад үнэтцаасыгорощуулан/ зах зээлийн үнэгэжтухайн эД хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, түүнийг худалдах үүрэг хүлээгээгүй худалдагч болон эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, худалдан авах үүрэг хүлээгээгүй худалдан авагч хоёрын харилцан тохиролцсон үнийг хэлнэ.
55.2.Энэ хууль болон компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтооно.

шийдвэрийн дагуу шийдвэрлэсэн байна. Ингэснээр үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болж хувьцаагаа нийтэд худалдсаны дараа Юу Эм Си капитал ХХК нь Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн 34.15% хувь буюу хяналтын багцыг эзэмшигч хэвээр үлдэж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22 дахь заалтад "нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл" гэж энэ хуульд заасан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг хэлнэ гэж заасан байх бөгөөд мөн зүйлийн 4.1.21 дэх хэсэгт "нийтэд санал болгох" гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу үнэт цаасаа 50-аас дээш тооны этгээдэд санал болгон худалдахаа мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэхийг хэлнэ гэж заасан байна. Эдгээр хуулийн зохицуулалтын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд Мандал даатгал ХХК-ийн энгийн хувьцааг бүртгэснээр Мандал даатгал ХХК-ийн хэлбэр өөрчлөгдөн хувьцаат компани болж Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК болон түүний хувьцаа эзэмшигчид үнэт цаасаа нийтэд чөлөөтэй арилжих, арилжихыг санал болгох эрхтэй гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Хөрөнгө оруулагч, хувьцаа худалдан авах сонирхолтой этгээдүүдэд уламжлах санамж**

Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт агуулагдсан зохицуулалтын дагуу даатгалын үйл ажиллагаа нь санхүүгийн үйлчилгээний[7] төрөлд хамаарах бөгөөд даатгагч даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа явуулахдаа Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч, түүний хяналт[8] дор үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг онцлогтой байна. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Даатгалын тухай хуульд заасны дагуу компани[9] буюу ашгийн төлөө зохион байгуулагдсан хуулийн этгээдэд олгохоор хуульд заасан бөгөөд хариуцлагын хэлбэрийн хувьд олон нийтэд нээлттэй[10] буюу хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон зохицуулалт байхгүй. Иймд Мандал даатгал ХХК нь Компанийн тухай хуульд заасны дагуу хэлбэрээ өөрчилж хувьцаат компани болох, нийтэд үнэт цаасаа санал болгох боломжтой байна. Үнэт цаас гаргагч нь нэмж гаргасан хувьцаагаа нийтэд амжилттай санал болгосон тохиолдолд Монгол Улсын хэмжээнд анхдагч даатгалын үйлчилгээ үзүүлэгч хувьцаат компани болж байна.

Үнэт цаас гаргагч нь энгийн хувьцаагаа олон нийтэд санал болгосноор хөрөнгө оруулагч Та бүхэн үнэт цаасны зах зээлийн арилжаанд оролцож үнэт цаасыг худалдан авах эрх нээлттэй боловч даатгалын салбарын онцлог болон зохицуулалттай байгууллагын хяналттай хуулиар ногдуулсан дараах хориглолт, хязгаарлалтууд үйлчилдэг болохыг анхаарч судлан хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Үүнд:

---

- Санхүүгийн эохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005).
8 дугаар эүйл.Хуулийн үйлчлэх хүрээ
3 1.Энэ хуульд заасан санхүүгийн үйлчилгээнддараахүйл ажиллагаа хамаарна:
3.1.3.даатгагчийн Даатгалын тухай хуульд ваасан үйл ажиллагаа;
- Даатгалын тухай хууль (2004)
13 дугаар зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх 13.1.Зохицуулах хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
13.1.1.энэ хуу;1ийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн даатгалын уйл ажиллагаанд хяналттавих;
13.1.2.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хучингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэдхяналттавих;
13.1.3даатгалын бащдурмийг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд ньхяналттавих;
13.1.4.даатгалын *дотоод,* гадаад эах зээлийг судлах, даатгалын талаарх албан ёсны мэдээлэл гаргах;
13.1.5 даатгагч, даатталын мэргэжлийн аролцсгчийн нэгдсэн бүртгэл хөтлөх;
13.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
13.2 Зохицуулах хороо нь даатгагч дамлуурах болон даатгалын уйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийгхамгаалах зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлнэ.
' Даатгалын тухай хууль (2004 он)
4.1.Энэ хуу/здхэрэглэсэн дараах нэртомьёогдор дурдсан утгаар ойлгоно:
4.1.1. "даатгалын үйл ажиллагаа" гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлберийгтөлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг;
4.1 2 "даатгагч" гэж энэ хүулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэхтусгай зөвшөөрөл авсан компанийг;
[10]Компанийн тухай хууль (2011).
3.7 "Нээлттэй хувьцаат компэни" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа ньүнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ.

- Санхүүгийн зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран шууд буюу шууд бусаар эзэмших, өмчлөх;
- Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийгдангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөх.

Товчхон дүгнэж хэлбэл хөрөнгө оруулах сонирхолтой этгээд нь үнэт цаасны анхдагч зах зээлийн болон хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцогч Мандал даатгал ХХК-ийн олон нийтэд санал болгож гүйлгээнд гаргасан энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авах, улмаар өмчлөлийн үнэт цаасаа цаашид захиран зарцуулах нөхцөлд салбарын зохицуулах байгууллага буюу Санхүүгийн зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрлийг заавал авах шаардлага үүсэж байгааг анхаарна уу.

Хуулийн дүгнэлтийн дэлгэрэнгүй Хавсралт 6.10-аас харна уу.

Үнэт цаасны танилцуулга

2018.08.29

## 4.4. Андеррайтерийн дүгнэлт

ГОЛОМТ КАПИТАЛ

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДАД

**ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК**
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Олимпийн гудамж 12/1 Очир Центр 401 тоот,
Улаанбаатар, 210644, Монгол Улс
Утас: 70121530, 70121529
И-мэйл: info@golomtcapital.com

2018.04.16 № 15/051

танай -ны № -т

### МАНДАЛ ДААТГАЛ ХХК-ИЙН ОЛОН НИЙТЭД НЭЭЛТТЭЙ ХҮРЭЭНД САНАЛ БОЛГОЖ БУЙ ЭНГИЙН ХУВЬЦААНД ӨГӨХ АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

"Голомт Капитал ҮЦК" ХХК нь /цаашид "Андеррайтер" гэх/ нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2015 оны 03 сарын 23-ны өдөр олгосон "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд "Мандал Даатгал" ХХК /цаашид "Үнэт цаас гаргагч" гэх/-тай 2018 оны 02 сарын 20-ны өдрийн 18/013 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" /цаашид "Андеррайтерийн гэрээ" гэх/-г байгуулж, Үнэт цаас гаргагчийн нэг бүр нь 4,800 төгрөгийн үнэтэй 1,560,754 ширхэг энгийн хувьцааг "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-иар дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон нийт 7,491,619,200 төгрөгийн санхүүжилт татах үйл ажиллагаанд андеррайтераар ажиллаж байгаа билээ.

Үнэт цаас гаргагч нь халаасны 1,243,016 ширхэг хувьцааг санал болгох замаар татан төвлөрүүлж буй 5,966,476,800 төгрөгийг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2013 оны 12 сарын 12-ны өдрийн 498 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага"-ын дагуу хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулах ба даатгалын байгууллагын хувьд хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх нь эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж улмаар зах зээлд эзлэх байр суурийг дээшлүүлэх, орлогод тооцсон хураамжийг өсгөх, хөрөнгө оруулалтын орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой байдаг.

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн энгийн хувьцааг арилжаалах үйл ажиллагааг Монгол Улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Даатгалын тухай хууль болон Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК (МХБ)-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам" болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж байгаа болно. Мөн андеррайтерийн үйлчилгээний төрлийг Андеррайтерийн гэрээний дагуу Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3 дугаар зүйлд заасан андеррайтерийн төрлөөр буюу "дээд зэргийн хүчин чадлаар" гүйцэтгэж байгаа болно.

Энэхүү үнэт цаасны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 11 сарын 23-ны өдрийн 408 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.1, МХБ-ийн ТУЗ-ийн 2018 оны 01 сарын 25-ны өдрийн 2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн 2015 оны 04 сарын 30-ны өдрийн 2015/06 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан МХБ-ийн ТУЗ-ийн 2012 оны 02 сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор шинэчилэн батлагдсан "Арилжааны журам"-ын дагуу явагдана.

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд үнэт цаас санал болгон хөрөнгө оруулалт татах бэлтгэл ажлын хүрээнд Андеррайтертай Андеррайтерийн үйлчилгээний гэрээ байгуулан ажиллахаас гадна дараах бэлтгэл ажлуудыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

МАНДАЛ ДААТГАЛ ХХК

000009



Огноо: 2018/04/16

1. Үнэт цаас гаргагч нь "Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс" ХХН хуулийн фирмтэй 2018 оны 02 сарын 21-ний өдөр 18/020 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ" байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд хуулийн зөвлөхийн үүргийг гүйцэтгүүлж байна. "Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс" ХХН хуулийн фирм нь 2014 оны 03 сарын 12 өдрийн Санхүүгийн Зохицуулах Хорооны 72 тоот тогтоолоор авсан "Үнэт цаас зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхэд Санхүүгийн Зохицуулах Хорооны 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.2.2-т заасан 9 асуудал, МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.5-д заасан 7 асуудлыг шалгаж хуулийн дүгнэлтийг бэлтгэх үйлчилгээг хийж гүйцэтгүүлсэн.
2. Үнэт цаас гаргагч нь "Улаанбаатар Аудит Корпораци" ХХК аудитын компанитай 2018 оны 03 сарын 20-ны өдөр 2018/29 тоот "Аудитын үйлчилгээний нэмэлт гэрээ" байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд аудитын байгууллагын үүргийг гүйцэтгэж байна. "Улаанбаатар Аудит Корпораци" ХХК нь 2013 оны 02 сарын 27-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 70 тоот тогтоолоор авсан "Үнэт цаас зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд "Аудитын тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль", "Даатгалын тухай хууль", Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Даатгалын багц дүрэм, журам, заавар, бусад холбогдох хууль, тогтоол, дүрэм журам, аудитын Олон улсын стандарт, компанийн дотоод стандарт, бодлого, журам, горим, аргачлалыг үндэслэн Үнэт цаас гарагчийн 2017 оны 12 дугаар 31-ээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргасан.
3. Үнэт цаас гаргагч нь "БДО Аудит" ХХК үнэлгээний компанитай 2018 оны 02 сарын 20-ний өдөр 2018-Ү1 тоот "Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээ" байгуулан үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох үйл ажиллагаанд үнэлгээний байгууллагын үүргийг гүйцэтгэж байна. "БДО Аудит" ХХК нь 2014 оны 01 сарын 29-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 22 тоот тогтоолоор авсан "Үнэт цаас зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, СЗХ болон МХБ-ээс баталсан дүрэм, журам нийцүүлэн, тэдгээр байгууллагаас тавигдсан шаардлагын дагуу Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн.
4. Үнэт цаас гаргагч нь Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 2018 оны 02 сарын 12 өдрийн 18/004 тоот тогтоол, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 02 сарын 15-ны өдрийн 18/002 тоот тогтоолоор энэхүү Үнэт цаасыг гаргах тухай шийдвэр гаргасан.

Энэхүү үнэт цаасыг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжих ажлын хүрээнд Андеррайтер нь дараах үндсэн чиглэлүүдээр холбогдох судалгаа шинжилгээний ажлуудыг хэрэгжүүллээ.Үүнд:

1. Компанийн бизнесийн тухай болон өнөөгийн байдлын судалгаа, танилцуулга
2. Компанийн үйл ажиллагаа явуулж буй салбарын өнөөгийн байдал болон эрх зүйн орчин
3. Компанийн санхүүгийн байдлын талаар нарийвчилсан дүгнэлт, шинжилгээ
4. Компанийн ирээдүйн төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний шинжилгээ
5. Нэгж хувьцааны үнийг тогтоох, түүнтэй холбоотой судалгаа шинжилгээ
6. Хувьцааны борлуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хөрөнгө оруулагчдыг олж тодорхойлох
7. Хувьцаа гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт, үр ашгийн тооцоо

Дээрх судалгаа, шинжилгээнд тулгуурлан Андеррайтер нь энэхүү нийтэд танилцуулах үнэт цаасны танилцуулгыг бэлтгэн гаргалаа.

Үнэт цаас гаргагчийн энэхүү энгийн хувьцаа гаргах төсөл дээр Андеррайтерийн зүгээс Голомт Капитал ҮЦК-ийн Гүйцэтгэх захирал Э. Амарбаясгалан, Хөрөнгө оруулалтын хэлтсийн хөрөнгө оруулалтын менежер Б.Намуугэрэл нар ажилласан болно.

**Андеррайтерын үйлчилгээний хүрээнд хийсэн судалгаа шинжилгээнүүдээс бид дараах дүгнэлтүүдийг гаргалаа.**

Даатгалын үйл ажиллагааны тухай

Даатгал нь гэрээний үндсэн дээр даатгуулагч өөрийн эд хөрөнгө, ашиг сонирхлоо болзошгүй аюул, эрсдэлээс учирч болох хохирлоо нөхөх баталгаатай байх болон нөхөн авах зорилгоор даатгуулж, түүний төлөө зохих хураамж төлөх, нөгөө талаас даатгагч нь даатгуулагчид учирч болох хохирлыг бүрэн буюу зарим хэсгийг төлөхөөр үүрэг хүлээж, эрх эдлэх харилцаа юм. Ингэснээр даатгагч байгууллага нь даатгуулагчийн төлсөн хураамжаар орлого олох боловч даатгуулагчид хэзээд ч эрсдэл учирч, нөхөн төлбөрийн тохиолдол үүсэх боломжтой тул даатгалын байгууллага нь нийт хураамжийн орлогыг орлого гэж тооцохгүй бөгөөд үүнээс давхар даатгалын зардал, буцаалт, орлогод тооцоогүй нөөц сангийн өөрчлөлт болон давхар даатгалын хойшлогдсон төлбөрийг хассан дүнг орлогод тооцдог. Үүнийг орлогод тооцсон хураамж буюу earned premium гэж нэрлэдэг. Орлогод тооцоогүй нөөц санг даатгалын гэрээний хугацаанаас хамааруулан нийт хураамжийн орлогыг хувь тэнцүүлэн хуваарилж тооцох буюу тайлант хугацаанд орлогод хүлээн зөвшөөрөгдөөгүй хураамжийн орлогыг хэлнэ.

Орлогод тооцоогүй нөөц сангаас хэзээд ч нөхөн төлбөр гарах боломжтой тул даатгалын байгууллага нь тус нөөц санг хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалтын хэрэгсэлд байршуулдаг. Иймд, даатгалын компани нь нөөц сан болон хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хэлбэрээр эсвэл хөрвөх чадвар өндөртэй бусад хөрөнгө хэлбэрээр байршуулж, түүнээс олсон хөрөнгө оруулалтын олз нь ашгийг бий болгогч томоохон хүчин зүйл болдог.

Өөрөөр хэлбэл даатгалын байгууллагын орлогын гол эх үүсвэр нь орлогод тооцсон хураамж ба хөрөнгө оруулалтын орлого болдог. Даатгагч нь ихэнх тохиолдолд орлогод тооцсон хураамжаас үйл ажиллагааны зардлаа барагдуулж, хөрөнгө оруулалтын орлогоор ашиг олдог байна.

*Давхар даатгал*

Даатгуулагчийн өөртөө хүлээж чадах хэмжээнээс давсан хохирлоос хамгаалах зорилгоор давхар даатгагчаас давхар даатгуулагчийн худалдан авч буй хамгаалалтын давхар даатгал гэнэ. Давхар даатгалын гэрээг трийти болон факультатив гэсэн хоёр төрөлд ангилдаг. Трийти давхар даатгал гэж даатгалын компани даатгуулагчтай байгуулсан даатгалын гэрээнүүдээ багцаар нь давхар даатгагчтай харилцан тохиролцсон нөхцөлөөр шууд давхар даатгалд хамруулахыг хэлдэг. Өөрөөр хэлбэр даатгалын компани давхар даатгалын компанитай урьдаас давхар даатгалд хамруулах бүтээгдэхүүний төрөл, гэрээний нөхцөлүүдээ харилцан тохиролцсоны үндсэн дээр даатгуулагчтай байгуулж буй гэрээ бүрээ автоматаар давхар даатгалд хамруулах үйл ажиллагаа юм. Трийти давхар даатгалыг хувь тэнцүүлсэн (proportional) болон хохирлын хэтрэлтийн (excess of loss) гэж хоёр ангилдаг. Proportional төрлийн гэрээгээр даатгалын компани даатгуулагчтай байгуулсан гэрээ бүрийн хураамжийн орлогынхоо тодорхой хувийг давхар даатгагчид шилжүүлж, нөхөн төлбөр гарсан тохиолдолд уг шилжүүлсэн хувиар давхар даатгагчаар нөхөн төлбөрийг төлүүлдэг. Харин excess of loss нь давхар даатгагчтай тохиролцсон тодорхой дүн хүртэлх нөхөн төлбөрийг даатгалын компани өөрөө хариуцаж, уг дүнгээс давсан хэсгийг давхар даатгагчаар төлүүлэх нөхцөлтэйгээр байгуулдаг давхар даатгалын гэрээний төрөл юм. Treaty төрлийн давхар даатгалыг харьцангуй бага үнэлгээ бүхий олон тоогоор хийгддэг даатгалын төрлүүдэд ихэвчлэн ашигладаг.

Факультатив давхар даатгал нь даатгалын компани даатгуулагчийн өмнө хүлээсэн эрсдэлийг хэсэгчлэн болон бүхэлд нь даатгалын гэрээ тус бүрээр давхар даатгагчтай харилцан тохиролцож даатгуулахыг хэлдэг. Энэ төрлийн давхар даатгалыг харьцангуй өндөр үнэлгээ бүхий цөөн тоогоор хийгддэг даатгалын төрлүүдэд ашигладаг.

2018 .08. 29 өдөр
№ 01

МОНГОЛЫН ХӨРЕНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ

Компанийн бизнес, үйл ажиллагааны талаар

Үнэт цаас гаргагч нь 2011 онд үүсгэн байгуулагдаж тус оны 06 сарын 02-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооны 146 тоот тогтоолоор "Ердийн даатгалын үйл ажиллагаа" эрхлэх тусгай зөвшөөрлийг авч үйл ажиллагаагаа эхлүүлсэн байна. Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаагаа эхэлсэн жилд буюу 2011 онд нийт 539 сая төгрөгийн хураамжийн орлого олж байсан бол 2017 онд 22.5 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлогыг олж 6 жилийн дотор 42 дахин өссөн байна. 2012-2017 оны нийт хураамжийн орлогын жилийн дундаж өсөлт 27.6% байсан ба энэ салбарын жилийн дундаж өсөлтөөс даруй 17% өндөр байна.

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 06 сарын 02-ны өдрийн 146 тоот, 2012 оны 06 сарын 20-ны өдрийн 163 тоот, 2012 оны 04 сарын 18-ны өдрийн 94 тоот тогтоол болон 2013 оны 05 сарын 08-ны өдрийн 188 тоот тогтоолын дагуу нийт 16 хэлбэрийн 58 нэр төрлийн сайн дурын даатгалын бүтээгдэхүүн борлуулах эрхтэй ба 2017 онд нийт хураамжийн орлогын 60%-ийг барилга угсралт, хөрөнгө болон тээврийн хэрэгслийн даатгал бүрдүүлжээ.

Дэлхийн даатгалын салбарын нийт хураамжийн орлогын 50%-ийг иргэд бүрдүүлдэг бол Монгол Улсын даатгалын салбарын 70%-ийг байгууллага, 30%-ийг иргэд бүрдүүлдэг гэж Үнэт цаас гаргагчийн Судалгааны алба тооцоолж байна. 2017 оны эцсийн байдлаар, Үнэт цаас гаргагчийн нийт хураамжийн орлогоос Оюу Толгой ХХК-ийн барилга угсралтын

даатгалыг (даатгалын фронтингийн үйлчилгээ) хасаж тооцвол иргэдийн даатгал 43.2%, байгууллагын даатгал 56.8%-тай гарсан ба энэ нь балансалсан, эрүүл үзүүлэлт болж байна. 2017 оны байдлаар үнэт цаас гаргагч нь нийт 1,457 байгууллага, 41,291 иргэдтэй нийт 72,902 даатгалын гэрээ байгуулсан ба энэ нь өмнөх оны мөн үеэс 20.7% буурсан үзүүлэлт юм. Харин гэрээний дундаж дүн өмнөх оноос 117% өсөж 309,163 төгрөгт хүрчээ.

Үнэт цаас гаргагч нь өөрийн шууд борлуулалтын алба, салбарууд болон даатгалын зуучлагч, төлөөлөгчөөр дамжуулж даатгалын бүтээгдэхүүнийг борлуулдаг. 2017 онд 66%-г шууд борлуулалт, 31%-г даатгалын зуучлагч, 3%-г даатгалын төлөөлөгч бүрдүүлсэн байна. 2017 онд дотоодын даатгалын компаниуд 47%-г шууд борлуулж, 53%-г даатгалын зуучлагч, төлөөлөгчөөр дамжуулж борлуулжээ. Үүнээс дүгнэхэд, Үнэт цаас гаргагч нь бусад даатгагчидтай харьцуулахад шууд борлуулалт хийх чадвартай, бусад борлуулалтын сувгаас хараат бус байна.

Үнэт цаас гаргагч нь өөрийн нөөц сан, хувьцаат капиталын хэмжээ болон түүхэн нөхөн төлбөрийн харьцаанд суурилан өөрийн эрсдэл даах чадварыг буюу өөрөөсөө гаргах нөхөн төлбөрийн дээд хязгаарыг 50,000 ам.доллар (122 сая төгрөг) байхаар тогтоосон ба үүнээс давсан хэсгийг давхар даатгалд шилжүүлэх юм. Үүний хүрээнд Үнэт цаас гаргагч нь 2017 оны 3-р улирлаас трийти давхар даатгалын нөхцөлөө өөрчилж Variable Quota Share гэрээнээс Excess of Loss төрлийн гэрээ рүү шилжсэн байна. Энэ нь богино хугацаанд компанийн ашигт ажиллагаанд эергээр нөлөөлсөн ба хуучин нөхцөлийн дагуу цэвэр ашиг 733 сая төгрөг гарах байсан бол Excess of Loss нөхцөл рүү шилжсэнээр цэвэр ашиг 1.1 тэрбум төгрөг болж 324 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

2017 оны жилийн эцсийн байдлаар, үнэт цаас гаргагчийн нийт нөхөн төлбөрийн хэмжээ 14% өсөж 4.7 тэрбум төгрөг, цэвэр нөхөн төлбөр 10% өсөж 2.1 тэрбум төгрөг хүрчээ. 2013-2014 онуудад Үнэт цаас гаргагч нь нийт нөхөн төлбөрийн дунджаар 86%-ийг өөрөө барагдуулдаг байсан бол 2016-2017 онд 45%-ийг барагдуулдаг болсон байна. 2017 оны байдлаар үнэт цаас гаргагч нь нийт 9.4 тэрбум төгрөгийн орлогод тооцоогүй хураамжийн нөөц (25%-ийн өсөлт), 2.9 тэрбум төгрөгийн (31%-н өсөлт) нөхөн төлбөрийн нөөц санг байгуулсан байна.

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны журмын дагуу байгуулсан нөөц сан болон хувь нийлүүлсэн хөрөнгийг СЗХ-ны 2013 оны 12 сарын 12-ны өдрийн 498 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага"-ын дагуу зарцуулдаг ба энэ нь ашигт ажиллагаанд нөлөөлөх гол хүчин зүйл болдог. 2017 оны эцсийн байдлаар нийт 9.2 тэрбум төгрөгийн 91%-ийг банк, санхүүгийн байгууллагад, 9%-ийг

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
5473489
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

компанийн бондод байршуулсан байна. 2013-2017 оны хөрөнгө оруулалтын орлогын жилийн дундаж өсөлт 8.5% байсан бол 2017 онд 23% өсөж 1.3 тэрбум төгрөг хүрчээ.

Үйл ажиллагаа явуулж буй салбарын өнөөгийн байдлын талаар

Монгол Улсад даатгалын салбар үүсэж хөгжөөд 83 жил болж байгаа ч арилжааны даатгалын хэлбэрт шилжээд 28 жил болж байгаа нь хөгжлийнхөө гарааны шатанд байгаа шинэ салбар болохыг илтгэж байна. Даатгалын салбар нь Монгол Улсын санхүүгийн секторын нэг хүрэхгүй хувийг эзэлдэг. 2016 онд амьдралын бус даатгал (property & casualty буюу ердийн даатгал)-ын салбарын нийт хураамжийн орлогын ДНБ-д эзлэх хувь буюу зах зээлийн нэвтрэлтийн түвшин 0.48% хүрсэн ба дэлхийн дундаж үзүүлэлт 2.8%, Азийн дундаж үзүүлэлт 1.85% байдаг байна. 2017 онд Монгол Улсын ердийн даатгалын салбарын нэвтрэлтийн түвшин 0.53% болж өссөн нь дотоодын зах зээл цаашид тэлэх боломжтойг харуулж байна. 2020 он гэхэд дотоодын ердийн даатгалын салбарын нэвтрэлтийн түвшин Азийн дундаж түвшин буюу 1.71% хүрэхэд, нийт хураамжийн орлого 649 тэрбум төгрөг буюу одоогийн үзүүлэлтээс 4.49 дахин өсөх боломжтой байна.

2017 оны байдлаар ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1, даатгалын зуучлагч 42, даатгалын хохирол үнэлэгч 29 компани даатгалын зах зээлд үйл ажиллагаа явуулж байна. Мөн даатгалын компанийн 251 салбар, төлөөлөгчийн газар, даатгалын зуучлагч компанийн 209 салбар, даатгалын хохирол үнэлэгч компанийн 53 салбар төлөөлөгчийн газар СЗХ-оос олгосон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

2017 онд даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 17.4% өсөж 244.7 тэрбум төгрөг хүрсэн бол ердийн даатгалын компаниудын хөрөнгө 16.7% өсөж 194 тэрбум төгрөгт хүрлээ. Даатгалын компаниудын өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нөөц сан 13.4 тэрбум төгрөгөөр, өр төлбөр 24.0 тэрбум төгрөгөөр, эзэмшигчдийн өмч 7.1 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Даатгалын компаниуд 2017 оны байдлаар нийт 1,015,275 иргэн, албан байгууллагатай даатгалын гэрээ байгуулж, 144.3 тэрбум төгрөгийн нийт хураамжийн орлого төвлөрүүлсний 97.8 хувь буюу 141.2 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниуд эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт хураамжийн орлого 26% буюу 29.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. 2017 онд нийт хураамжийн орлогоор Бодь Даатгал тэргүүлж нийт 28.2 тэрбум төгрөгийн орлого олж зах зээлийн 20.0%-ийг бүрдүүлсэн бол Үнэт цаас гаргагч нь зах зээлийн нийт хураамжийн орлогын 16%-ийг бүрдүүлж 3-т орсон байна.

Даатгалын компаниудын цэвэр ашиг 2017 оны 4 дүгээр улиралд 10.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.0 тэрбум төгрөгөөр буурсан байна. 2017 онд Үнэт цаас гаргагч санхүүгийн зарим үзүүлэлтүүдээр салбарын дунджаас илүү ажиллаж чадсан байна. Тухайлбал, салбарын дундаж нийт хураамжийн орлогын өсөлт 26% байхад Үнэт цаас гаргагчийн өсөлт 72% байв. Мөн салбарын дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 11% байхад Мандал даатгал 18%-ийн өгөөжтэй гарсан байна.

Компанийн санхүүгийн байдалд хийсэн шинжилгээ

2017 онд үнэт цаас гаргагчийн нийт хураамжийн орлого 72% өссөн ба энэ нь барилга угсралтын даатгалын орлого 36.8 дахин, эрүүл мэндийн даатгал 3.0 дахин, гэнэтийн ослын даатгал 2.7 дахин өссөнтэй холбоотой юм. Үнэт цаас гаргагч нь 2017 онд Оюу Толгой ХХК-ийн барилга угсралтын сонгон шалгаруулалтад шалгарсан нь барилга угсралтын өсөлтөд нөлөөлсөн байна. Эрүүл мэндийн даатгалын өсөлтөд дотоодын томоохон аж ахуйн нэгжүүд ажилтнуудаа "Жаргалан" эрүүл мэндийн даатгалд хамруулсан нь нөлөөлжээ.

Орлогод тооцсон хураамж 67% өссөн нь 2017 оны 07 сарын 01-ээс давхар даатгалын гэрээний нөхцөлийг Excess of Loss болгож өөрчилсөнтэй холбоотой юм. Ингэснээр, үнэт цаас гаргагч нь давхар даатгагчид зөвхөн 50,000-2,950,000 ам.долларын үнэлгээтэй эрсдэлийг шилжүүлж 50,000 ам.доллар буюу 122 сая төгрөг хүртэлх эрсдэлийг өөрөө даадаг болсон байна.

Давхар даатгалын хураамжийн зардал буурснаар мөнгөн хөрөнгийн хэмжээ өсөж, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэн, улмаар хөрөнгө оруулалтын орлого өмнөх оны мөн үеэс 23% өссөн байна. Давхар даатгалын нөхцөлийн өөрчлөлт нь цэвэр ашгийг 324 сая төгрөгөөр нэмэгдүүлж өнгөрсөн онд цэвэр ашиг 13.0 дахин өсөж, цэвэр ашгийн маржин 2%-иас 16%, өөрийн хөрөнгийн өгөөж 2%-иас 18%, нийт активийн өгөөж 0.5%-иас 5% болж өссөн байна.

Хохирлын харьцаа 29% болж буурсан нь цэвэр нөхөн төлбөрийн хэмжээ 10% өссөн ч орлогод тооцсон хураамж 67%-р өссөнтэй холбоотой юм. Мөн зардлын харьцаа 63% хүрсэн нь үйл ажиллагаа зардал 42% өссөн ч ОТХ илүү хурдацтай өссөн нь нөлөөлжээ. Ингэснээр, үнэт цаас гаргагчийн нийлмэл харьцаа 93% хүрч, үүсгэн байгуулагдсан цагаас хойш анх удаа 100%-с бага гарлаа.

2017 оны санхүүгийн харьцаанаас дүгнэхэд, давхар даатгалын нөхцөлийн өөрчлөлт нь компанид богино хугацаанд эерэг нөлөөг авчирсан байна. Цаашид өөрийн хувьцаат капиталыг нэмэгдүүлснээр эрсдэл даах чадвар сайжирч улмаар давхар даатгалын хураамжийн хэмжээг өнөөгийн түвшнээс бууруулах боломж бүрдэх юм. Ингэснээр зардал буурч, эргэлдэх мөнгөн хөрөнгө нэмэгдэж, хөрөнгө оруулалтын орлого нэмэгдэх, цэвэр ашиг өсөх, зах зээлд эзлэх байр суурь дээшлэх гэх мэт олон давуу талтай байна.

2017 онд Үнэт цаас гаргагч нь санхүүгийн зарим үзүүлэлтүүдээр салбарын дунджаас илүү ажиллаж чадсан байна. Тухайлбал, салбарын дундаж нийт хураамжийн орлогын өсөлт 26% байхад Үнэт цаас гаргагчийн өсөлт 72% байв. Мөн салбарын дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 11% байхад, үнэт цаас гаргагч 18%-ийн өгөөжтэй ажиллажээ.

Аудитлагдсан санхүүгийн тайлан болон зардлын тухай дэлгэрэнгүй задаргааг үнэт цаасны танилцуулгаас үзэх боломжтой.

<u>Хууль эрх зүйн орчны талаар</u>

Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаа явуулж буй зохицуулалттай байгууллага юм. Үүний хүрээнд, Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан дараах нийт 33 даатгалын багц дүрэм, журам, зааврыг баримтлал болгон өдөр тутмын үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

| № | Журам | Баталсан огноо |
|---|---|---|
| 1 | Албан журмын даатгагчдын холбооны дүрэм | 2011-11-23 |
| 2 | Албан журмын даатгагчдын холбооны санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам | 2015-01-14 |
| 3 | Гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийн журам | 2013-10-23 |
| 4 | Албан журмын даатгагчдын холбооны шуурхай албаны ажиллах журам | 2015-01-21 |
| 5 | Даатгагч, жолоочийн даатгалын сангаас хохирогчид олгосон нөхөн төлбөрийн мэдээллийг цагдаагийн байгууллагад ирүүлэх, түүнийг ашиглах журам | 2012-02-01 |
| 6 | Даатгагчаас даатгуулагчид төлбөртэйгээр мэдээлэл, баримт бичиг өгөх нөхцөл, төлбөрийн жишиг хэмжээ тогтоох журам | 2007-12-26 |



Огноо: 2018/04/16

| | | |
|---|---|---|
| 7 | Даатгагчийн үйл ажиллагааныхаа тодорхой хэсгийг бусдад шилжүүлэх болон нэгтгэх үед гаргах өргөдлийг хянан шийдвэрлэх журам | 2007-06-12 |
| 8 | Даатгагчийг татан буулгах, дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагааг явуулах журам | 2008-02-28 |
| 9 | Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааг зохистой явуулах ёс зүйн журам | 2007-10-30 |
| 10 | Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, түүний биелэлтэд хяналт тавих журам | 2012-01-18 |
| 11 | Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага | 2013-07-17 |
| 12 | Даатгагчийн үйл ажиллагааг түр зогсоох нөхцөл | 2008-05-08 |
| 13 | Даатгагчийн хөрөнгийг тусгаарлан байршуулах, түүний зарцуулалтад хяналт тавих журам | 2010-06-16 |
| 14 | Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагааг зохицуулах журам | 2010-05-28 |
| 15 | Даатгалын байгууллагын үйл ажиллагаанд хийх газар дээрх хяналт, шалгалтын журам | 2009-12-23 |
| 16 | Даатгалын гэрээ байгуулж чадаагүй жолооч нарыг даатгагч нарт хуваарилах журам | 2011-11-23 |
| 17 | Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага | 2013-10-23 |
| 18 | Даатгалын сургалт явуулах, шалгалт авах журам | 2008-04-18 |
| 19 | Даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдтэй холбогдох мэдээллийг хэвлэн нийтлэх журам | 2007-11-29 |
| 20 | Даатгуулагчдад сугалаа, бэлэг, урамшуулал олгохыг хориглох тухай | 2012-12-12 |
| 21 | Дамжин өнгөрөх болон түр хугацаагаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орж ирж байгаа тээврийн хэрэгслийн жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам | 2012-02-01 |
| 22 | Жолоочийн даатгалын баталгааны загварыг хэрэглэх журам | 2015-03-24 |
| 23 | Жолоочийн даатгалын мэдээллийн сангийн журам | 2012-12-26 |
| 24 | Жолоочийн даатгалын сангийн санхүүжилтийг төвлөрүүлэх, данс байршуулах, сангийн хөрөнгийг шилжүүлэх, зарцуулах журам | 2011-11-23 |
| 25 | Жолоочийн даатгалын санд хөрөнгө шилжүүлэх журам | 2013-01-23 |
| 26 | Жолоочийн даатгалын хураамжийн хэмжээг тооцох итгэлцүүр хэрэглэх журам | 2011-11-23 |
| 27 | Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх болон түр хугацаагаар орж ирж байгаа авто тээврийн хэрэгсэл эзэмшигч, өмчлөгчийг жолоочийн даатгалд хамруулах журам | 2012-02-01 |
| 28 | Ердийн даатгалын компанийн үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журам | 2012-06-20 |
| 29 | Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам | 2015-11-23 |
| 30 | Актуарчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, актуарын стандарт, үнэлгээ болон актуарчийн хяналт шалгалт хийх, тайлан гаргах журам | 2016-03-04 |
| 31 | Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам | 2016-03-11 |

| | | |
|---|---|---|
| 32 | Даатгал түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам | 2016-03-04 |
| 33 | Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журам | 2016-04-06 |

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.7, 33.8 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.4 дэх заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон Үнэт цаас гаргагчийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7. (а), 6.7 (б) хэсэг, 7 дугаар зүйлийн 7.9.4, 7.9.5, 7.9.6 дахь заалтууд, 2018 оны 02 сарын 12-ны өдрийн 18/004 тоот Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол, 2018 оны 02 сарын 15-ны өдрийн 18/002 тоот ТУЗ-ийн тогтоолыг тус тус үндэслэн эргүүлэн худалдан авч халаасалсан буюу зарласан хувьцаа болох 1,243,016 ширхэг хувьцаа, хувьцаа эзэмшигч "Юу Эм Си Капитал" ХХК-ийн эзэмшлийн 317,738 ширхэг хувьцаа, нийт 1,560,754 ширхэг энгийн хувьцааг Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-иар дамжуулан олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгохоор шийдвэрлэсэн байна.

Компанийн тухай хуулийн 33.7 болон 33.8-д зааснаар "Компани өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авсан тохиолдолд уг хувьцааг зарласан боловч гаргаагүй хувьцаа гэж тооцно", "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компани нь энэ хуулийн 33.7-д заасан хувьцааг дахин гаргаж болно" гэж заасны дагуу тус компани нь өөрийн халаасны хувьцаанаас 1,243,016 ширхэг хувьцааг гаргах эрх зүйн үндэслэлтэй байна. Мөн дараах хуулийн үндэслэлээр үнэт цаас гаргагч нь хувьцаа эзэмшигч "Юу Эм Си Капитал" ХХК-ийн 317,738 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгох үндэслэлтэй байна. Үүнд:

1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалтад ""үнэт цаасны анхдагч зах зээл" гэж үнэт цаас гаргагч үнэт цаасаа нийтэд санал болгох замаар арилжихтай холбогдсон харилцааг" хэлнэ гэж тодорхойлсон ба уг заалтад шинээр эсвэл нэмж гаргасан хувьцаа байна гэж нарийвчлан тодорхойлоогүй байна. Иймд, үнэт цаасны анхдагч зах зээлд санал болгох хувьцаанд эргэлтэд гаргасан хувьцааг хамруулан ойлгох үндэслэлтэй байна. Мөн тус хуулийн 4.1.5 дах заалтад ""үнэт цаасны хоёрдогч зах зээл" гэж үнэт цаасны анхдагч зах зээлд гаргасан үнэт цаасыг дахин арилжихтай холбогдсон харилцааг;" хэлнэ гэж тодорхойлсон ба үүнд зөвхөн хувьцаа эзэмшигч хооронд хийх арилжааг хэлнэ гэж тодорхойлоогүй байна.
2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтад "Үнэт цаас гаргагч дангаар, эсхүл зохицуулалттай этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр үнэт цаасаа үнэт цаасны анхдагч зах зээлд худалдахаар 50 ба түүнээс дээш тооны хөрөнгө оруулагчид танилцуулах, сурталчлах замаар санал болгоно" гэж заасан нь нийтэд санал болгох нь 50 ба түүнээс дээш тооны хөрөнгө оруулагчид санал болгохыг хэлдэг буюу зөвхөн шинээр эсвэл нэмж хувьцаа гаргахыг хэлнэ гэж тусгайлан заагаагүй байна.
3. Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль-д эргэлтэд гаргасан хувьцааг олон нийтэд санал нээлттэй хүрээнд анхдагч зах зээлээр арилжаалахыг хориглосон зохицуулалт байхгүй тул энэхүү хэлцэл нь хууль, эрх зүйн хүрээнд зөрчилгүй гэж дүгнэж байна.
4. Мөн МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.1.1-д "Өөрийн эзэмшлийн хувийг санал болгох: Үнэт цаас гаргагчийн одоогийн хувьцаа эзэмшигч болон хувьцаа эзэмшихээр захиалга өгсөн этгээд нь өөрийн эзэмшлийн хувьцаагаа олон нийтэд худалдахаар санал болгож болно. Энэ тохиолдолд компани нь нэмэлт хөрөнгө оруулалт татахгүй" гэж заасны дагуу "Юу Эм Си Капитал" ХХК нь өөрийн эзэмшлийг олон нийтэд санал болгох үндэслэлтэй байна.

Энэхүү үнэт цаасны бүртгэл болон арилжаа нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.6, 10.7, СЗХ-ны 2015 оны 11 дүгээр сарын 23-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ийн

2018 оны 01 дугаар сарын 25-ны 2018/01 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ-ийн ТУЗ-ын 2012 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 02 тоот тогтоолоор баталсан МХБ-ийн "Арилжааны журмын" дагуу явагдана.

Үнэт цаас гаргах замаар татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалтын талаар

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд нээлттэй хүрээнд нэг бүрийн 4,800 төгрөгийн үнэтэй 1,560,754 ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар нийт 7,491,619,200 төгрөгийг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлнэ. Үүнээс, 1,243,016 ширхэг энгийн хувьцаа санал болгох замаар татан төвлөрүүлсэн хөрөнгө буюу 5,966,476,800 төгрөг нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх бол үлдсэн "Юу Эм Си Капитал" ХХК-ийн эзэмшлийн 317,738 ширхэг хувьцааг худалдсан хөрөнгө буюу 1,525,142,400 төгрөг нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэхгүй юм.

Үнэт цаас гаргагч нь энэхүү нэмэлт мөнгөн хөрөнгө болох 5,966,476,800 төгрөгийг СЗХ-ны 2013 оны 07 сарын 17-ны өдрийн 250 тоот тогтоолоор батлагдсан "Ердийн даатгалын компанийн даатгалын нөөц сангаас хөрөнгө оруулалт хийхэд тавигдах шаардлага"-ын дагуу зарцуулахаар төлөвлөж байна.

Аливаа даатгалын байгууллага нь хувь нийлүүлсэн хөрөнгө/мөнгөн хөрөнгөө нэмэгдүүлэхэд дараах эерэг нөлөөг авчирдаг. Үүнд:

- **Зах зээлд эзлэх байр суурь өсөх:** Хувь нийлүүлсэн хөрөнгө нэмэгдсэнээр үнэт цаас гаргагч нь өндөр дүн бүхий хохирлын эрсдэлийг даатгах чадвартай болж зах зээлд эзлэх байр суурийа нэмэгдүүлэх боломжтой ба энэ нь нийт хураамжийн орлогын өсөлтөд эергээр нөлөөлнө.

- **Орлогод тооцсон хураамж өсөх:** Даатгалын тухай хуульд даатгалын байгууллага нь өөрийн хөрөнгөөс давсан дүнгийн эрсдэл даахыг хориглосон байдаг. Иймд, даатгалын байгууллагууд нь өөрийн хөрөнгөөс давсан эрсдэлийг давхар даатгагчид шилжүүлж, давхар даатгалын хураамж төлдөг ба энэ нь ашигт ажиллагааг бууруулдаг.

- Үнэт цаас гаргагчийн хувьд өөрийн эрсдэл даах чадварыг 50,000 ам.доллар буюу 122 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд үүнээс давсан хэсгийг трийти болон факултатив давхар даатгалаар эрсдэлийг шилжүүлдэг. 2016 онд нийт хураамжийн орлогын 57%, 2017 онд 50%-ийг давхар даатгалд шилжүүлсэн нь сайжирсан үзүүлэлт боловч дахин сайжруулах орон зай байгааг харуулж байна. Тухайлбал, 2017 оны 07 сарын 01-ны өдрөөс эхэлсэн трийти давхар даатгалын нөхцөлийн өөрчлөлт нь богино хугацаанд компанийн ашигт ажиллагаанд эерэгээр нөлөөлсөн ба хуучин нөхцөлийн дагуу цэвэр ашиг 733 сая төгрөг гарах байсан бол Excess of Loss нөхцөл рүү шилжсэнээр цэвэр ашиг 1.1 тэрбум төгрөг болж 324 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Компанийн мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлж эрсдэл даах чадварыг 3 дахин буюу 150,000 ам доллар (370 сая төгрөг) хүргэвэл цэвэр хураамжийн орлогод 20% хувийн эерэг нөлөөтэй гэж үнэт цаас гаргагч тооцоолжээ.

- **Хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх:** Мөнгөн хөрөнгийг 5,966,476,800 төгрөгөөр нэмэгдүүлснээр хөрөнгө оруулалтын орлого дунджаар 46%-иар өсгөх боломжтой ба энэ нь ашигт ажиллагаанд нөлөөлөх гол хүчин зүйл болох юм.

Компанийн бизнесийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийн хүчин зүйлсийн талаар

Андеррайтерийн хувьд үнэт цаас гаргагч компанийн бидэнд ирүүлсэн мэдээлэл үнэн, цаашид хэрэгжих төсөл хөтөлбөрүүд төлөвлөсний дагуу хэрэгжих боломжтой гэсэн таамаглалд үндэслэн энэхүү проспектусыг боловсруулсан боловч энэхүү төсөөлөл нь ирээдүйд биелэхгүй байх

2018 08 28

боломжтой юм. Ялангуяа өнөөгийн хурдацтай хөгжил, эдийн засгийн өндөр хөрвөх чадвартай цаг үед бизнесийн орчин өөрчлөгдөх, улс орны эдийн засгийн байдал солигдох зэрэг олон төрлийн гадаад эрсдэл бизнес эрхлэгчдэд тулгарч байдаг. Тиймээс компанид учирч болох эрсдэлүүдийг нарийн судалж, аль болох сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх нь цаашид тогтвортой үйл ажиллагаа явуулах үндсэн алхам болох бөгөөд компанийн үнэт цаасанд хөрөнгө оруулагч нь энэхүү эрсдэлийг ойлгосны үндсэн дээр хөрөнгө оруулалт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Компанид учирч болохуйц эрсдэлийг ангилан харвал:

**Андеррайтингийн үйл ажиллагаа, актуар тооцоолол**

Даатгал нь учирч болзошгүй тааламжгүй үйл явдлын эрсдэлийг бууруулах, учирч болох хохирлыг богино хугацаанд арилгах зорилготой даатгуулагчдын хураамжаар сан бүрдүүлж уг сангаас хохирол учирсан нэгэнд нөхөн төлбөр олгож эрсдэлийг даван туулахад нь тусалдаг санхүүгийн хэрэгсэл юм. Даатгуулагчид аливаа гэнэтийн эрсдэл тохиолдоход хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэхийн тулд даатгалын санг зөв бүрдүүлэх, эрсдэл учрах нь 100% тодорхой тохиолдлыг даатгахгүй байх зарчмыг баримталж ажиллах үүргийг хүлээдэг.

Иймд даатгалын гэрээгээр харилцагчийн өмнө хүлээж буй үүрэг нь даатгалын зарчимд нийцэж буй эсэх, харилцагчийн эрсдэлд тохирсон хураамжийг тооцоолж даатгалын тохиолдол үүсэхэд нөхөн төлбөр олгоход хангалттай нөөц сан бүрдүүлж буй эсэх нь даатгалын үндсэн үйл ажиллагааны гол эрсдэл юм.

Үнэт цаас гаргагчийн даатгалын үйл ажиллагааны эрсдэлийг Даатгалын бодлогын хэлтэс хариуцан ажилладаг бөгөөд уг хэлтэст андеррайтинг, актуар тооцоолол, давхар даатгалын үйл ажиллагаа харьяалагддаг.

Андеррайтингийн үйл ажиллагаа нь даатгуулагчтай байгуулж буй даатгалын гэрээгээр ямар эрсдэлүүд хамрагдах, хамрагдахгүйг олон улсын даатгалын гэрээний стандартын дагуу даатгуулагчид ойлгомжтой байдлаар боловсруулахад чиглэдэг. Мөн даатгуулагчийн эрсдэлд тохирсон нэмэлт хамгаалалт, харилцагчийн онцлогт тохирсон андеррайтингийн үйлчилгээг актуарч болон давхар даатгагчийн судалгаа, зөвлөгөөгөөр хамтран боловсруулдаг.

**Даатгалын багцын эрсдэл**

Даатгалын компани нь худалдаа үйлчилгээний компаниуд болон бусад санхүүгийн байгууллагуудын адил олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон төрлийн зах зээлд зориулж гарган багцын эрсдэлээ бууруулахад анхаардаг. Даатгалын багцын эрсдэлийг актуарч хариуцан ажилладаг бөгөөд даатгалын төрлийг нэмэгдүүлэх, шинээр бүтээгдэхүүн хөгжүүлж зах зээлд нэвтрүүлэх ажлыг байгууллагын даатгал болон иргэдийн даатгалын бизнес хөгжил хариуцсан менежерүүд хариуцдаг.Мөн эрсдэлийн албаны шинжээч нар даатгалын багцын судалгаа хийж Удирдлагын хорооны хуралд улирал бүр танилцуулж, хорооноос өгсөн чиглэлийн дагуу багцын үзүүлэлтийг сайжруулах ажлуудыг хийж хэрэгжүүлдэг.

**Давхар даатгал**

Даатгалын компани нь харилцагчаас өөртөө шилжүүлэн авсан эрсдэлийг бүтнээр нь болон тодорхой хэсгийг нь давхар даатгалд шилжүүлж эрсдэлийг тараан байршуулдаг. Ялангуяа өөрийн хөрөнгө буюу даатгалын компанийн эрсдэл даах чадвараас өндөр үнэлгээ бүхий томоохон эд хөрөнгө, хариуцлагыг даатгах үед давхар даатгалыг зайлшгүй ашиглах шаардлага үүсдэг. Үнэт цаас гаргагч нь 2014 онд анх хувь оролцооны /variable quota share/ багцын давхар даатгалын гэрээ байгуулж 2017 оны 2-р хагаст excess of loss багцын давхар даатгалд шилжсэн. Уг давхар даатгалын гэрээний нөхцөлөөр 50,000 ам.доллараас бага дүнтэй нөхөн төлбөрийг Үнэт цаас гаргагч өөрөө хариуцаж, 50,000-3,000,000 ам долларын нөхөн төлбөрийг давхар даатгагчаас төлүүлэх бөгөөд харилцагчтай байгуулж буй бүх төрлийн даатгалын гэрээнүүд

давхар даатгалд хамрагдсан байна. 3,000,000 ам.доллараас дээш үнэлгээ бүхий томоохон даатгалуудын тухай бүрд нь давхар даатгагчтай тохиролцож факултатив хэлбэрээр давхар даатгалд хамруулдаг.

Давхар даатгалд эрсдэлээ шилжүүлэхтэй холбоотойгоор үүсдэг нэг эрсдэл нь давхар даатгагчтай байгуулж буй гэрээ болон даатгуулагчтай байгуулж буй гэрээний зөрүү юм. Даатгуулагчтай байгуулсан гэрээнд заасан даатгалын хамгаалалтаа давхар даатгагчтай байгуулсан гэрээнд тусгалгүй орхигдуулснаар эрсдэл учрахад нөхөн төлбөрийг даатгагч өөрийн нөөц сангаас бүрэн төлөх эрсдэл учирдаг. Үнэт цаас гаргагч нь давхар даатгалын гэрээ байгуулагдахаас өмнө андеррайтер, давхар даатгалын мэргэжилтэн, даатгалын менежер зэрэг ажилтнуудын бүрэлдэхүүнтэйгээр гэрээний зөрүү гарсан эсэхийг шалгаж уг эрсдэлээс сэргийлдэг.

**Нөхөн төлбөр шийдвэрлэлт**

Даатгалын үйл ажиллагааны бусад бизнесээс онцлогтой нь ёс зүйн гажуудал /moral hazard/-ын асуудал үүсэх магадлал хамгийн өндөртэй санхүүгийн салбар юм. Даатгалын тохиолдлыг зориудаар бий болгох эсвэл хуурамч баримт материал бүрдүүлж нөхөн төлбөр авах оролдлого хийх үзэгдэл аль ч улс оронд байдаг. Иймд, даатгалын тохиолдол буюу ослыг шалгаж, даатгалын нөөц санг гэнэтийн осолд өртсөн даатгуулагчдад зарцуулах, залилангийн шинжтэй нөхөн төлбөрт зарцуулахгүй байхад анхаарч ажилладаг.

Нөхөн төлбөр шийдвэрлэлтийн процессын хувьд, үнэт цаас гаргагч нь нөхөн төлбөрийн материалуудыг тохиолдлын шинж тэмдгээс нь хамааруулж оноо өгөн тодорхой ба эргэлзээтэй ангилалд хуваарилж эргэлзээтэй материалууд болон өндөр үнийн дүнтэй нөхөн төлбөрийн материалуудыг Нөхөн төлбөрийн дэд хороогоор шийдвэрлүүлдэг. Мөн эргэлзээтэй ослын тохиолдлуудыг магадлахын тулд Замын цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Шинжлэх ухаан технологийн их сургууль, Ус цаг уур орчны шинжилгээний хүрээлэн гэх мэт мэргэжлийн байгууллагууд, экспертүүдтэй хамтран ажиллаж, нөхөн төлбөрийн мэргэжилтнүүдээ чадавхжуулахад анхаардаг.

**Эдийн засгийн байдлаас хамаарсан эрсдэл**

Даатгалын салбар нь макро эдийн засгийн байдалтай шууд хамааралтай байдаг. Ялангуяа байгууллагын даатгал нь эдийн засгийн нөхцөл байдлаас ихээхэн хамаардаг. Эдийн засгийн идэвхжил сулрахад төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа суларч түүнийг дагасан даатгалын үйл ажиллагаа мөн буурч, нөгөө талаар аж ахуйн нэгжүүдийн мөнгөн хөрөнгийн урсгал буурдагтай холбоотойгоор даатгалдаа зарцуулах зардал нь буурах хандлагатай байдаг. Иргэдийн зах зээлийн хувьд эдийн засгийн уналтын үед даатгуулах хандлага нь төдийлөн буурдаггүй, тогтвортой байдаг. Монгол Улсын даатгалын салбарын нийт хураамжийн орлогын 70 орчим хувийг байгууллагын даатгал бүрдүүлдэг тул эдийн засгийн уналтад мэдрэг байдаг. Үнэт цаас гаргагч нь макро эдийн засгийн эрсдэлд өртөмтгий байдлыг бууруулахын тулд иргэдийн даатгалын зах зээлийг тэлэх, иргэд болон байгууллагын даатгалын балансаа хангахад анхаарч ажилладаг. Иргэдийн даатгалын зах зээлд чиглэсэн "Сонголт" тээврийн хэрэгслийн даатгал, "Жаргалан" эрүүл мэндийн даатгал, банкуудаар дамжуулан борлуулж буй даатгалууд амжилттай борлуулагдаж, тогтвортой орлогын суурийг бэхжүүлж байгаа бөгөөд цаашид илүү олон төрлийн бүтээгдэхүүнийг хөгжүүлж зах зээлд нэвтрүүлэхээр ажиллаж байна.

**Хууль эрх зүйн орчинтой холбоотой эрсдэл**

Даатгалын үйл ажиллагаа нь СЗХ-оос гаргасан дүрэм, журмуудын хүрээнд нарийн зохицуулалттай явагддаг санхүүгийн үйлчилгээ юм. Ялангуяа нөөцийн сан байгуулах, мөнгөн хөрөнгийг хөрөнгө оруулалтын хэрэгслүүдэд байршуулах үйл ажиллагаа нь зохицуулагч байгууллагын дүрэм журмуудаар хязгаарлагддаг. Тухайлбал, даатгалын компаниудын дүрмийн

сангийн доод хэмжээг 5 тэрбум төгрөг болгож нэмэгдүүлэх тухай журам 2018 оны 7 сарын 1-ээс хэрэгжиж эхэлнэ. Үнэт цаас гаргагчийн хувьд, уг шаардлагыг 3 жилийн өмнөөс биелүүлээд байна.

Мөн бизнесийн үйл ажиллагаанд шууд бусаар нөлөөлөх хууль эрхзүйн зохицуулалтын эрсдэлүүд үүсдэг. Тухайлбал, осолд холбогдсон жолооч нар гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бол даатгуулагчаас цагдаагийн тодорхойлолт шаардахгүйгээр нөхөн төлбөр олгодог байх тогтоол гарснаар зам тээврийн ослыг баталгаажуулахад хүндрэл үүсэж шуурхай дуудлагын хүчин чадлаа нэмэгдүүлэх шаардлагатай тулгарсан байна. Нөгөөтэйгүүр, Зөрчлийн тухай хуулиар зам тээврийн дүрэм зөрчсөн жолоочийг торгодог болсон нь осолд холбогдсон жолооч нар даатгалын компанид дуудлага өгөхгүйгээр хоорондоо тохиролцох, үүнийг олон нийтэд буруугаар ойлгуулж даатгалын компаниудын нэр хүндэд халдах тохиолдлууд гарч байна.

**Өрсөлдөөнтэй холбоотой эрсдэл**

Даатгалын зах зээл нь одоогоор нэвтрэл бага байгаа хэдий ч байгууллагын даатгалын зах зээлд үнийн өрсөлдөөн явагдах хандлагатай байдаг. Үнэт цаас гаргагчийн байгууллагын даатгалын зах зээлд үйлчилгээгээр ялгарах, харилцагчийн эрсдэлийн боловсролыг нэмэгдүүлэх, эрсдэлийг бууруулахад чиглэсэн сургалт зөвлөгөөг харилцагчдад өгч урт хугацааны хамтын ажиллагааг бий болгох, үнэнч харилцагчдын бааз суурийг бэхжүүлэхэд анхаарч ажилладаг.

Байгууллагын харилцагчдад эрсдэлийн мэдээлэл хүргэх, эрсдэлийг даван туулсан туршлагаас хуваалцдаг "Монгол Улсын эрсдэлийн удирдлагын форум"-ыг 2011 оноос хойш жил бүр тасралтгүй зохион байгуулж байна.

**Валютын ханшийн эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь давхар даатгалын төлбөр тооцоо болон гадаадын улс оронд тохиолдсон зарим ослын нөхөн төлбөрийг валютаар гүйцэтгэдэг тул ханшийн эрсдэл нь боломжит эрсдэлүүдийн нэг юм.

Трийти давхар даатгалын төлбөрийг төгрөгөөр гүйцэтгэдэг тул ханшийн эрсдэл үүсдэггүй ч факултатив хэлбэрийн давхар даатгалын төлбөрийн харилцагч болон давхар даатгагчтай тухай бүр төгрөг эсвэл валютаар төлбөр хийх эсэхийг харилцан тохиролцдог ба уг гэрээний төлбөрийг харилцагчаас хураамж шилжиж ирсэн даруйд давхар даатгагч руу шилжүүлэх бодлого барьдаг тул мөн валютын ханшийн зөрүү үүсдэггүй.

**Зээл, хадгаламжийн хүүгийн эрсдэл**

Үнэт цаас гаргагч нь зээлийн хөрөнгөөр эх үүсвэрээ бүрдүүлдэггүй тул зээлийн хүү өсөх нь үйл ажиллагаанд шууд нөлөөлөхгүй юм. Үнэт цаас гаргагч нь харилцагчдын хураамжийн орлого, нөөцийн сангийн ихэнх хувийг банканд хадгалуулж өгөөж хүртдэг тул хадгаламжийн хүү буурах нь хөрөнгө оруулалтын өгөөжийг бууруулах эрсдэлтэй. Уг эрсдэлийг бууруулахын тулд үнэт цаас гаргагч нь 2017 оноос "Хөрөнгө оруулалтын дэд хороо"-г байгуулан СЗХ-оос баталсан даатгалын компанийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны журмын хүрээнд мөнгөн хөрөнгийнхөө тодорхой хэсгийг бусад санхүүгийн хэрэгслүүдэд хөрөнгө оруулж өгөөжийг нэмэгдүүлэхэд анхаарч байна.

**Хөрвөх чадварын эрсдэл**

Томоохон даатгалын тохиолдол үүсэхэд нөхөн төлбөр төлөх бэлэн мөнгөний нөөцгүй байх нь даатгалын компанийн боломжит эрсдэл юм. Үнэт цаас гаргагч нь хөрөнгөө богино хугацаат хадгаламжаар өөр өөр банкуудад ялгаатай дуусах хугацаатайгаар байршуулж уг эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгадаг.

Мөн 300 сая орчим төгрөгийг өдөр бүр харилцах дансандаа байршуулж харилцагчдын нөхөн төлбөрийг хугацаа алдалгүйгээр төлөхийг зорьж ажилладаг.

### Үйл ажиллагааны эрсдэл

Бизнесийн үйл ажиллагааны процессын аль нэг хэсэгт доголдол гарсны улмаас үйл ажиллагаа доголдох, санхүүгийн хохирол учрах, компанийн нэр хүнд унах нь аливаа бизнесийн байгууллагад тохиолддог гол эрсдэл юм. Үнэт цаас гаргагч нь 2017 онд хуучин Эрсдэлийн хэлтсийг татан буулгаж, даатгалын эрсдэлийг Даатгалын бодлогын хэлтэст шилжүүлж, Эрсдэлийн албыг шинээр байгуулан үйл ажиллагааны эрсдэлийг уг албанд хариуцуулсан байна. Эрсдэлийн албанд дотоод аудиторын албан тушаалыг шинээр бий болгож өдөр тутмын үйл ажиллагааны процесст хяналт тавих, илэрсэн доголдлыг цаг алдалгүй засаж сайжруулах ажлыг гүйцэтгэн ажиллаж байна.

Мөн удирдлагын хорооны дэргэдэх “Дотоод хяналтын дэд хороо” дотоод хяналтын ажлыг тогтмол хугацаанд хийж Удирдлагын хороонд танилцуулдаг.

### Нэр хүндийн эрсдэл

Даатгалын салбар нь нэр хүндийн эрсдэлд өртөх магадлал өндөртэй салбар юм. Иргэдийн даатгалын талаарх мэдлэг дутмаг, даатгалын гэрээний нөхцөлүүдтэй сайн танилцаггүй, нөгөө талаас даатгалын компанийн зүгээс даатгуулагчдад гэрээ болон үйлчилгээний нөхцөлүүдийг сайн тайлбарлаж ойлгуулдаггүйгээс нөхөн төлбөрийн тохиолдол үүсэхэд баримтжуулалт сайн хийгддэггүй, даатгалын компанид мэдэгддэггүй, зарим тохиолдолд даатгалын гэрээнд хамрагдаагүйн улмаас нөхөн төлбөр авахаар материал бүрдүүлэх үед даатгалын компаниас нөхөн төлбөрийг олгохоос татгалздаг. Эдгээр үл ойлголцлоос даатгуулагч даатгалын компанид сэтгэл хангалуун бус байх, улмаар уг сэтгэгдлээ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр илэрхийлэх, зарим тохиолдолд даатгалын компанийг сүрдүүлж нөхөн төлбөр авах оролдлого хийх тохиолдол гардаг.

Үнэт цаас гаргагч нь Үйлчилгээний нэгжээрээ харилцагчийн гомдол, санал, хүсэлтийг бүртгэж, гомдлыг ангилан дүн шинжилгээ хийж, хариу тайлбарыг өгдөг. 2018 оноос иргэдийн даатгалын боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор даатгалын нөхөн төлбөрийн олгогдсон болон татгалзсан тохиолдлууд, татгалзсан шалтгаан зэргийг цуврал видеогоор хүргэж байна.

### Хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэл

Үнэт цаас гаргагчийн ажилтнуудын ихэнх нь оффист байрладаг тул хөдөлмөрийн аюулгүй байдлын эрсдэлд өртөх магадлал бага ч шуурхай дуудлагын ажилтнууд болон нөхөн төлбөрийн мэргэжилтнүүд ослын газар дээр ажилладаг тул эрсдэлд өртөх магадлалтай байдаг. Шуурхай дуудлагын ажилтнууд нь ослын үзлэг хийж байхдаа зам тээврийн осолд өртөх, сэтгэл санааны тавгүй байдалд орсон харилцагчтай харьцдаг тул халдлагад өртөх магадлалтай байдаг. Нөхөн төлбөрийн мэргэжилтнүүдийн хувьд эвдрэл гэмтэлтэй эд хөрөнгөд үзлэг хийхдээ унаж бэртэх эрсдэлтэй байдаг.

Үнэт цаас гаргагч нь уг эрсдэлийг бууруулахын тулд дотооддоо болон ОШМИ, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар зэрэг мэргэжлийн байгууллагуудтай хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг тогтмол явуулдаг. Мөн үнэт цаас гаргагч нь эдгээр ажилтнуудыг гуравдагч даатгалын компанийн гэнэтийн ослын даатгалд хамруулсан байна.

### Үнэт цаасны зах зээлийн эрсдэл

Үнэт цаасны зах зээлд оролцогчдын итгэл үнэмшил буурч дотоодын үнэт цаасны зах зээлийн эрэлт буурснаар үнэт цаасны зах зээлийн хөрвөх чадвар саарах, арилжааны идэвх буурах,

үнэгүйдэх зэрэг зах зээлд эрсдэл үүсдэг. Энэ нь үнэт цаас гаргагчийн хувьцаанд болон гаргахаар төлөвлөж буй өрийн бичигт сөргөөр нөлөөлж ханшийн хэлбэлзлийг нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож байна.

**Үнэт цаасны зах зээлийн эрэлттэй холбогдон үүсэж болох эрсдэл**

Монголын хөрөнгийн зах зээл дээр 2005 оноос хойш нийт 31 компани хөрөнгийн зах зээлээс хувьцаагаар хөрөнгө татан төвлөрүүлсэн бөгөөд нийт 190 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт татсан байна. Үүнээс сүүлийн 1 жилд хийгдсэн Сүү Бонд, Ай Түүлс ХК, Лэнд.мн ББСБ ХК-ийн хувьцааны арилжаа амжилттай явагдсан нь Монгол Улсын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулагчдын идэвх сонирхлыг нэмэгдүүлсэн гэж үзэж байна. Гэсэн хэдий ч нийт иргэдийн санхүүгийн боловсрол, хуримтлалын түвшин бусад өндөр хөгжилтэй улсуудтай харьцуулахад бага, зах зээлд идэвхтэй тоглогч, оролцогчдын тоо харьцангуй цөөн хэвээр байгаа тул үнэт цаасны хөрвөх чадвар сул байх эрсдэл мөн байгаа болно.

**ДҮГНЭЛТ**

Голомт Капитал ҮЦК ХХК нь андеррайтерийн үйлчилгээний хүрээнд хийсэн дээрх болон бусад судалгаа шинжилгээ, тооцоо, мөн үнэт цаас гаргахтай холбогдуулан бусад мэргэжлийн байгууллагуудын хийсэн тайлан дүгнэлтүүдэд үндэслэн "Мандал Даатгал" ХХК-ийн хувьцааг олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгон арилжаалах боломжтой гэж үзсэн бөгөөд энэхүү хувьцааны анхдагч зах зээлийн нэг бүрийн үнийг 4,800 төгрөгөөр, нийт 1,560,754 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгон 7,491,619,200 төгрөгийг татан төвлөрүүлэх боломжтой гэж үзэн энэхүү дүгнэлтийг гаргалаа.

Энэхүү дүгнэлт нь дээрх тооцоолол болон компанийн ирээдүйн төсөөллийн биелэлтийн баталгаа болохгүй бөгөөд компанийн хөрөнгө оруулагчид нь компанийн үйл ажиллагаа болон хувьцааны үнэлгээнд нөлөөлж болох гадаад дотоод эрсдэлийг ойлгосны үндсэн дээр өөрийн шийдвэрээр хөрөнгө оруулахыг зөвлөж байна.

**Дүгнэлтийг гаргасан:**

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН МЕНЕЖЕР Б. НАМУУГЭРЭЛ

**Хянаж баталгаажуулсан:**

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Э. АМАРБАЯСГАЛАН

# 5. ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН ТАНИЛЦУУЛГА

## 5.1. Андеррайтер

"Голомт Капитал ҮЦК ХХК" нь 2012 онд "Голомт Банк" ХХК-ийн 100% хөрөнгө оруулалттайгаар түүний охин компани болон байгуулагдсан. Андеррайтер нь СЗХ-оос 2011 оны 11 сарын 02-ны өдөр "Харилцагчийн нэрийн өмнөөс түүний даалгавраар гүйцэтгэх хөрөнгө оруулалтын бусад ажил, үйлчилгээ эрхлэх", 2014 оны 03 сарын 26-ны өдөр "Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх" тусгай зөвшөөрөл мөн 2015 оны 3 сарын 23-ны өдөр "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийг тус тус авч иргэд, ААН-үүдэд хөрөнгө оруулалтын цогц үйлчилгээг үзүүлж байна.

| | |
|---|---|
| Нэр: | *"Голомт Капитал ҮЦК" ХХК* |
| Улсын бүртгэлийн дугаар: | *9011287134* |
| Регистрийн дугаар: | *5481589* |
| Хаяг: | *401 тоот, Очир төв, Олимпийн гудамж 12/1, Улаанбаатар 210464, Монгол Улс* |
| Утас: | *+976-70121530* |
| Факс: | *+976-70121529* |
| И-мейл: | *info@golomtcapital.com* |
| Веб хуудас: | *www.golomtcapital.com* |

Андеррайтерийн хөрөнгийн зах зээлд гаргасан гол амжилтууд:

- Анхны Real-time онлайн арилжааны системийг нэвтрүүлсэн
- Анхны даатгагдсан бонд "Эрчим бонд"-г гаргасан
- Анхны ББСБ-ын даатгагдсан бонд "ММФ бонд"-г гаргасан
- Анхны ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг гүйцэтгэсэн
- Засгийн газрын олон улсын зах зээлд гаргасан "Мазаалай бонд"-д дотоод зөвлөхөөр ажилласан
- 2013 онд МХБ-ийн нийт арилжааны 49%-г гүйцэтгэсэн
- Жил бүр "Mongolian Investment Summit"- ийг зохион байгуулдаг
- 2017 онд хаалттай хүрээнд "ММФ бонд II" болон "Урбан бонд I, II"-г гаргасан
- 2017 онд "Сүү" ХК-ийн 6.0 тэрбум төгрөгийн бондыг амжилттай гарган түүхэн дээд амжилт тогтоосон
- 2018 онд хаалттай хүрээнд "NFC Bond", "Urban Bond"-ыг гаргасан

### Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээний тухай

Андеррайтер нь 2015 оны 3 сарын 23-ны өдөр СЗХ-ны 156 тоот тогтоолоор авсан 3/97 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2018 оны 02 сарын 20-ны өдрийн 18/013 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгох үйл ажиллагаанд андеррайтерийн үүрэг гүйцэтгэж байгаа болно.

Тус гэрээний зорилго нь Андеррайтер нь Компанид хөрөнгийн зах зээлээс нээлттэй хүрээнд хөрөнгө татахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх, шаардагдах тооцоолол, судалгаа, бэлтгэл ажлуудыг гүйцэтгэх, зөвлөгөө өгөх, хөрөнгө оруулагч нарт Компанийг танилцуулах, санал болгох, санхүүжилт

татаж өгөх. Компани нь Зөвлөхийг Гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь дэмжин ажиллаж шаардлагатай мэдээлэл, материалыг гарган өгч хамтран ажиллахаар харилцан тохиролцсонтой холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчид нээлттэй хүрээнд санхүүжилт татахад СЗХ болон МХБ-ээс гаргасан Үнэт цаасны бүртгэлийн журмын дагуу үнэт цаас гаргах төлөвлөгөөг боловсруулах, үнэт цаасны бүртгэлийн шалгуурыг хангахад зөвлөгөө өгөх, үүнтэй холбоотойгоор компанийн нэрийн өмнөөс СЗХ болон МХБ-тэй харилцах, үнэт цаасны танилцуулга материалыг (Проспектус) бэлтгэх, болон гэрээний хавсралтуудад өөрөөр заагаагүй тохиолдолд тухай бүр холбогдох үнэт цаасыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3 дугаар зүйлд заасан андеррайтерийн үйлчилгээний төрлөөр өөрийн бүхий л хүчин чармайлтыг гарган арилжаалах,
- Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийг Гэрээгээр хүлээсэн ажлаа гүйцэтгэхэд нь шаардлагатай үнэн зөв, бодит мэдээлэл, бичиг баримт болон материалуудын эх хувь болон баталгаажсан хуулбарыг цаг тухайд нь бүрэн гаргаж өгөх үүрэг хүлээнэ.

## 5.2. Хуулийн зөвлөх

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН нь 2013 оны 06 сарын 18-ны өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн мэргэшсэн бизнесийн хуулийн фирм юм. Тус Хуулийн фирм нь үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлийг СЗХ-ны 2014 оны №72 тоот тогтоолын дагуу авсан. Үнэт цаасны зах зээлийн оролцогчдод хууль зүйн туслалцаа, хөндлөнгийн дүгнэлт гаргаж өгөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй. Гадаад, дотоодын хөрөнгийн биржид хувьцаа, өрийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах хэд хэдэн удаагийн ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн туршлагатай, тэргүүлэх хуулийн фирм юм.

| | |
|---|---|
| Компанийн нэр: | *Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН* |
| Регистрийн дугаар: | *5722292* |
| Хаяг: | *Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Монгол ТВ цамхаг, 10 давхар, 1001-1003 тоот* |
| Утас: | *+976-77119008* |
| Факс: | *+976-77119008* |
| И-мейл: | *contact@bnp.mn* |

### Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний тухай

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН нь 2014 оны 03 сарын 12 өдрийн СЗХ-ны 72 тоот тогтоолоор авсан "Үнэт цаас зах зээлд оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх" тусгай зөвшөөрөл авсан мэргэшсэн хуулийн фирм юм. Тус Хуулийн фирм 2018 оны 02 сарын 21-ний өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 18/020 тоот "Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгох үйл ажиллагаанд хуулийн зөвлөхийн үүргийг гүйцэтгэж байгаа болно.

Тус гэрээний нь зорилго нь үнэт цаас гаргагч нь үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотойгоор мэдээлэл, баримт материалыг шалгаж, дараах асуудлаар хуулийн дүгнэлт гаргахад оршино. Үүнд:

- Хуулийн зөвлөх нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхэд СЗХ-ны 408 тоот

тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 1.2.2-т заасан 9 асуудал, МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4.5-д заасан 7 асуудлыг шалгаж хуулийн дүгнэлтийг Монгол хэл дээр бэлтгэх

- Үнэт цаас гаргагч нь Хуулийн зөвлөхтэй бүх талаар хамтран ажиллаж үнэт цаасны танилцуулгад тусгагдсанаас бусад шаардлагатай мэдээллийг гаргаж өгч хамтран ажиллах үүрэг хүлээнэ.

## 5.3. Хараат бус аудит

"Улаанбаатар Аудит Корпораци" ХХК нь СЗХ-ны 2013 оны 02 сарын 27-ны өдрийн 70 тоот тогтоолоор үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрлийг авсан. Үнэт цаасны зах зээл дээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдээс гадна Хувьцаат компани, үнэт цаасны зах зээл дээр шинээр хувьцаа, бонд гаргаж байгаа компаниудтай хамтарч ажилладаг.

| | |
|---|---|
| Компанийн нэр: | *Улаанбаатар Аудит Корпораци ХХК* |
| Регистрийн дугаар: | *2577542* |
| Хаяг: | *5-р хороо, Их тойруу, Маргад центр* |
| Утас: | *+976-70110744* |
| Факс: | *+976-70110722* |
| И-мейл: | *info@mn.gt.com* |

Үнэт цаасны зах дээл дээр шинээр хувьцаа, бонд гаргасан, гаргахаар ажиллаж байсан дараах компаниудын санхүүгийн тайланд аудит хийсэн туршлагатай байна. Үүнд:

- Монинжбар ХК
- Монфреш ХХК (аудит, хөрөнгийн үнэлгээ)
- Нүүдэлчин групп (Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудит)
- Улаанбаатар БҮК ХК

МХБ-д бүртгэлтэй үйлчлүүлэгч компаниуд:

- АПУ ХК, Атар-Өргөө ХК, Багануур ХК, Монголын цахилгаан холбоо ХК, Монгол шуудан ХК, Монинжбар ХК, Дулааны II цахилгаан станц ХК, Дулааны III цахилгаан станц ХК, Дулааны IV цахилгаан станц ХК, Монголын төмөр зам ХК, Улаанбаатар дулааны сүлжээ ХК, Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ХК, МҮДИКС ХК

Тус байгууллага нь 2013 оны 12 сараас эхлэн дэлхийн 130 гаруй оронд салбартай, 47,000 гаруй ажилтантай, дэлхийд эхний 6-д ордог аудит, зөвлөх үйлчилгээний байгууллагуудын нэг болох Грант Торнтон Интернешнлийн Монгол Улс дахь корреспондент фирмээр хүлээн зөвшөөрөгдөн үйл ажиллагаагаа явуулж байна.

### Аудитын үйлчилгээний нэмэлт гэрээний тухай

"Улаанбаатар Аудит Корпораци" ХХК нь 2013 оны 02 сарын 27-ны өдөр СЗХ-ны 70 тоот тогтоолоор авсан "Үнэт цаас зах зээлд оролцогчид аудитын үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд 2018 оны 03 сарын 20-ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2018/29 тоот "Аудитын үйлчилгээний нэмэлт гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгох үйл ажиллагаанд аудитын байгууллагын үүргийг гүйцэтгэж байгаа болно.

Тус гэрээний зорилго нь Монгол Улсын "Иргэний хууль", "Даатгалын тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн болон Аудитын тухай" хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, заавар, олон улсын хэмжээнд дагаж мөрддөг санхүүгийн тайлагналын болон аудитын стандартын

дагуу үнэт цаас гаргагчийн 2017 оны 12 дугаар 31-ээр тасалбар болгосон санхүүгийн тайланд аудит хийж, тайлан дүгнэлт гаргахад оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Аудит нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн (баланс) тайланг аудитоор шалгуулж баталгаажуулах, бүртгэлээ улам сайжруулан зохион байгуулахад нь туслах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн тайланд аудит хийж тайлан дүгнэлт гаргахдаа Монгол Улсын "Аудитын тухай хууль", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль", "Даатгалын тухай хууль", СЗХ-оос баталсан Даатгалын багц дүрэм, журам, заавар, бусад холбогдох хууль, тогтоол, дүрэм журам, аудитын Олон улсын стандарт, компанийн дотоод стандарт, бодлого, журам, горим, аргачлалыг үндэслэн санхүүгийн тайлан дахь тоон үзүүлэлтүүдийг нотлох баримт бичгийг шалган, удирдлагын ашигласан бүртгэлийн бодлого, зарчим болон гол чухал тооцооллуудыг үнэлж, аудитын явцад илэрсэн дотоод хяналтын сул тал ба материаллаг болон материаллаг бус зөрчил дутагдлуудын талаар тайлан бичиж дүгнэлт өгөх,
- Үнэт цаас гаргагч байгууллагын аж ахуй, санхүүгийн үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэл, тайланд стандартын дагуу зөв тусган, эдгээртэй холбоотой баримт, материал, тайлбарыг бүрэн танилцуулах бөгөөд энэ талаар үүсэх хариуцлагыг хүлээх тухайгаа нотолсон тодорхойлолтыг аудиторт гаргах үүргийг хүлээнэ.

## 5.4. Үнэлгээний компани

БДО-ийн Монгол Улс дахь оффис 2012 оны 12 сард Улаанбаатар хотод Монгол Улсын аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай "Итгэлт Аудит" ХХК-ийн суурин дээр үүсгэн байгуулагдсан. Тус компани нь 2014 оны 01 сарын 29-ний өдөр СЗХ-ны 22 тоот тогтоолоор авсан "Үнэт цаас зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрөл авсан байна.

| | |
|---|---|
| Компанийн нэр: | *БДО Аудит ХХК* |
| Регистрийн дугаар: | *2546442* |
| Хаяг: | *Монгол Улс, Улаанбаатар хот, СБД-1, ЮНЕСКО-гийн гудамж, Нарны зам-62, Юнион Бюлдинг, B блок, 15-р давхар, 1502 тоот* |
| Утас: | *+976-77404040; +976-77404041* |
| Факс: | *+976-77451150* |
| И-мейл: | *info@bdo.mn* |

"БДО Аудит" ХХК нь 2 партнер, 40 орчим мэргэлжилтнүүдтэй ба аудит ба баталгаажуулалт, үнэлгээ ба шинжилгээ, бизнесийн зөвлөх үйлчилгээ, дотоод гадаад аутсорсинг, татвар ба хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа явуулж байна. Тус компани Голомт Банк, Чингис Хаан Банк, Энэржи Ресурс, MCS, Unitel, Витафит, Би Ди Сек, Багануур, Эрдэнэс Таван Толгой, Дархан Нэхий гэх мэт дотоодын шилдэг аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлсэн туршлагатай байна.

### Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээний тухай

"БДО Аудит" ХХК нь 2014 оны 01 сарын 29-ний өдөр СЗХ-ны 22 тоот тогтоолоор авсан "Үнэт цаас зах зээлд оролцогчид хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэх" тусгай зөвшөөрлийн хүрээнд 2018 оны 02 сарын 20-ний өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан 2018-Ү1 тоот "Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээ"-ний дагуу олон нийтэд нээлттэй хүрээнд энгийн хувьцаа санал болгох үйл ажиллагаанд үнэлгээний компаниар оролцож байгаа болно.



Огноо: 2018/04/16

Тус гэрээний зорилго нь Үнэлгээний компани нь хүрээнд Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, стандарт болон дүрэм, журмын дагуу Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг СЗХ болон МХБ-иас баталсан дүрэм, журам нийцүүлэн, тэдгээр байгууллагаас тавигдсан шаардлагын дагуу мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэхэд оршино.

Энэхүү гэрээний хүрээнд талууд дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн мэдээлэл, баримт материалд үндэслэн өөрийн сонгосон аргачлалын дагуу Монгол Улсын үнэт цаасны зах зээлд шинээр хувьцаа гаргах албан хэрэгцээнд шийдвэр гаргах үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу мэргэжлийн үнэлгээчнээр оролцох, Олон улсын үнэлгээний стандарт, Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон холбогдох хууль, дүрэм, журмын дагуу Үнэт цаас гаргагчийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээг хийх, тайлан гаргах үйлчилгээг холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн гүйцэтгэх
- Үнэт цаас гаргагч нь Үнэлгээний компанитай бүх талаар хамтран ажиллаж шаардлагатай бүхий л мэдээллийг гаргах үүргийг хүлээнэ.

# 6. ХАВСРАЛТ

## 6.1. Улсын бүртгэлийн гэрчилгээ

Хууль зүйн сайдын 2016 оны А/204 дугаар тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
**ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ**
000136728

2011.04.26
/ Бүртгэсэн он,сар,өдөр /

9017001021
/ Улсын бүртгэлийн дугаар /

5473489
/ Регистрийн дугаар /

Мандал даатгал ХХК - Даатгал
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Тогтоол
/ шийдвэрийн нэр /

146
/ дугаар /

2011.04.21
/ он, сар, өдөр /

6512 Ердийн даатгалын үйл ажиллагаа
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

/ код / / Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй
/ хугацаа /

2
/ гишүүдийн тоо /

6,243,016.0
/ өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, 13, нарны зам, Норт Спринг Капитал Блү барилга, 2 болон 4 давхар, Утас1: 70107007, Утас2: , Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар Хуулийн этгээдийн бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2017 он 1 сар 27 өдөр



Огноо: 2018/04/16

*Үнэт цаасны танилцуулга*

СЗХ
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

## Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

| Д/д | Нэмэлт өөрчлөлтийн агуулга | Бүртгэсэн | |
|---|---|---|---|
| | | Огноо | Ажилтан тэмдэг |
| 1 | Батсайхан овогтой Жаөхлан-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. | 2016.11.15 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | Дахин гэрчилгээ олгов. | 2017.01.27 | Э.Эрдэнэбилэг |
| 2 | 'Орхон аймаг дахь' Орхон, Баян-Өндөр, 4-р баг, Хүрэнбулаг, , , , Анхдагчын талбай, Саруул төв, 207 тоот байрлах салбар нэгжийг бүртгэв. | 2017.09.18 | С.Мөнхсанчир |

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.

* 0 0 0 1 3 6 7 2 8 *

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК



Огноо: 2018/04/16

Үнэт цаасны ... СЗХ ... 2019.08.29 ... БҮРТГЭВ

МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

# ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар 2/21

2011 оны 06 сарын 02 өдөр

Монгол улсын "Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль", "Даатгалын хууль" тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 06 сарын 02 өдрийн 146 дугаар тогтоолоор "Мандал даатгал" ХХК-д Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА С.ДАВААСҮРЭН

"тэмдэг"

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Энэхүү гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
Б. Ихбаяр
УГААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
... LLC
... КАПИТАЛ ҮЦК ХХК



Огноо: 2018/04/16

Үнэт цаасны танилцуулга
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ



## 6.3. Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах зөвшөөрөл

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 21 өдөр Дугаар 390 Улаанбаатар хот

"Мандал женерал даатгал" ХХК-ийн хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.3.2, 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. "Мандал женерал даатгал" ХХК-ийн хувь нийлүүлэгч "Юу эм си капитал" ХХК-ийн эзэмшлийн нэг ширхэг нь 1,000 /нэг мянган/ төгрөгийн үнэ бүхий 5,000,000 /таван сая/ ширхэг буюу 5,000,000,000 /таван тэрбум/ төгрөгийн хувьцаанаас 2,550,000 /хоёр сая таван зуун тавин мянга/ ширхэг буюу 2,550,000,000 /хоёр тэрбум таван зуун тавин сая/ төгрөгийн хувьцааг "Голомт файнэншил групп" ХХК-д худалдаж, хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж дараах байдлаар тогтоохыг зөвшөөрсүгэй:

| | Хувь нийлүүлэгч | Хөрөнгийн хэмжээ /төгрөгөөр/ | | | Дүрмийн санд эзлэх хувь /%/ |
|---|---|---|---|---|---|
| | | Эхний үлдэгдэл | Өөрчлөлт | Эцсийн үлдэгдэл | |
| 1 | "Юу эм си капитал" ХХК | 5,000,000,000.0 | (2,550,000,000.0) | 2,450,000,000.0 | 39,24 |
| 2 | "Голомт файнэншил групп" ХХК | 0.0 | 2,550,000,000.0 | 2,550,000,000.0 | 40,85 |
| 3 | "Мандал женерал даатгал" ХХК | 1,243,016,000.0 | 0.0 | 1,243,016,000.0 | 19,91 |
| | Нийт | 6,243,016,000.0 | 0.0 | 6,243,016,000.0 | 100,00 |

3. Хувь нийлүүлэгчдийн бүрэлдэхүүнд оруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, компанийн шинэчилсэн дүрмийг Улсын

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

000427
МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаасны танилцуулга
СЭХ
он сар ... өдөр
2018.08.29
№01

бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн, холбогдох баримтыг 2014 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг "Мандал женерал даатгал" ХХК /Ч.Бат-Идэр/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА Д.БАЯРСАЙХАН

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
мандал даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК



Огноо: 2018/04/16

СЭХ
2018.08.29
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛ
МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

16/002 ТООТ "МАНДАЛ ЖЕНЕРАЛ ДААТГАЛ" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН ХАВСРАЛТ №1

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
117236007 5473489

2016 ОНЫ [7] ДУГААР САРЫН [8]

МАНДАЛ ДААТГАЛ ХХК-ИЙН

ШИНЭЧИЛСЭН ДҮРЭМ

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

Үнэт цаасны танилцуулга
ХХ
сар өдөр
2018.08.29
№ 01



## АГУУЛГА


| | | |
|---|---|---|
| 1. | Нэр Томьёо | 3 |
| 3. | Компанийн Эрх Зүйн Байдал | 3 |
| 4. | Үйл Ажиллагааны Чиглэл | 3 |
| 5. | Үйл Ажиллагаа Явуулах Хугацаа | 4 |
| 6. | Хувь Нийлүүлсэн Хөрөнгө, Өөрийн Хөрөнгө, Хувьцаа болон Бусад Үнэт Цаас | 4 |
| 7. | Хувьцаа Эзэмшигчдийн Хурал | 5 |
| 8. | Төлөөлөн Удирдах Зөвлөл | 7 |
| 9. | Гүйцэтгэх Захирал | 10 |
| 10. | Ногдол Ашиг Төлөх, Компанийн Эд Хөрөнгийн Захиран Зарцуулах | 10 |
| 11. | Эрх Бүхий Этгээдийн Хариуцлага | 11 |
| 12. | Санхүүгийн Хяналт | 12 |
| 13. | Дотоод Журам | 14 |
| 14. | Өөрчлөн Зохион Байгуулах, Татан Буулгах | 14 |
| 15. | Баримтлах Хууль | 15 |
| 16. | Бусад | 15 |
| Хавсралт А нэр томъёо | | 16 |




МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473469

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК



Огноо: 2018/04/16

Монгол улсын хуулийн дагуу байгуулагдсан Мандал Даатгал ХХК (цаашид "**Компани**" гэх) Иргэний Хууль, Компанийн Хууль, Даатгалын Хууль, Хуулийн Этгээдийн Улсын Бүртгэлийн Хууль болон бусад Холбогдох Хуулийн дагуу байгуулагдсан болно.

## 1. Нэр Томьёо

Энэхүү Дүрмийн текст эсхүл ерөнхий агуулга өөрөөр дурдаагүй бол энэхүү Дүрэмд том үсгээр эхлэн бичсэн бүх нэр томьёог Хавсралт А-д дурдсан утгаар ойлгоно.

## 2. Компанийн Эрх Зүйн Байдал

2.1 Компанийн оноосон нэрийг монгол хэлээр **Мандал Даатгал ХХК**, англи хэлээр **Mandal Daatgal LLC** гэнэ.

2.2 Компанийн албан ёсны хаяг буюу үйл ажиллагаагаа явуулах үндсэн газар:

НСКБ барилга, 2,4 давхар
Нарны зам 87,
13-р хороолол,
Сүхбаатар дүүрэг,
1-р хороо,
Улаанбаатар хот
Монгол улс

2.3 Компани нь түүний албан ёсны хаягт өөрчлөлт орох тухай бүрт Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ), Хуулийн Этгээдийн Бүртгэлийн Газар (ХЭБГ) болон холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

2.4 Холбогдох Хуулийн дагуу Компани нь ашгийн төлөө хуулийн этгээд байна.

2.5 Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэртэй байна. Хувьцаа Эзэмшигч нь Компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд зөвхөн Компанид эзэмшиж байгаа хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

2.6 Компани нь Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн шийдвэрээр болон СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрлийг үндэслэн Монгол Улсад болон гадаад улсад өөрийн салбар, төлөөлөгчийн газраа нээж болно.

2.7 Компани өөрийн тэмдэгтэй байна.

## 3. Үйл Ажиллагааны Чиглэл

3.1 Компани нь дор дурдсан төрлийн ердийн даатгалын үйл ажиллагаа явуулж болох бөгөөд тэдгээр үйл ажиллагааг явуулахад шаардлагатай эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ:

- 3.1.1. гэнэтийн осол, эмчилгээний зардлын;
- 3.1.2 хөрөнгийн;
- 3.1.3. төмөр зам, усан зам, агаарын болон авто тээврийн хэрэгслийн;
- 3.1.4. ачааны;
- 3.1.5. барилга угсралтын;
- 3.1.6 нисэх онгоцны;
- 3.1.7 жолоочийн хариуцлагын албан журмын;
- 3.1.8 хариуцлагын;
- 3.1.9 мал амьтдын;
- 3.1.10 газар тариалангийн;
- 3.1.11 санхүүгийн;
- 3.1.12 зээлийн;
- 3.1.13 итгэлцлийн;

Үнэт цаасны танилцуулга
2018 08 29 В



3.1.14 төмөр замын болон усан замын тээврийн хэрэгсэл, агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын; болон

3.1.15 Холбогдох Хуулиар зөвшөөрсөн даатгалтай холбоотой үйл ажиллагаа.

3.2 Компани нь үйл ажиллагаагаа ТУЗ баталж СЗХ зөвшөөрсөн бизнес төлөвлөгөөний дагуу явуулна.

## 4. Үйл Ажиллагаа Явуулах Хугацаа

4.1 Компани нь Тусгай Зөвшөөрөл Олгосон Өдрөөс эхлэн даатгалын үйл ажиллагаа явуулна.

4.2 Компани нь үйл ажиллагаагаа тодорхой хугацаагүйгээр явуулна.

## 5. Хувь нийлүүлсэн хөрөнгө, Өөрийн хөрөнгө, Хувьцаа болон бусад үнэт цаас

### 5.1 Хувь Нийлүүлсэн Хөрөнгө

5.1.1. Компанийн Хувь Нийлүүлсэн Хөрөнгө гэж хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг хэлнэ. Хувь Нийлүүлсэн Хөрөнгөнд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй. Компанийн Хувь Нийлүүлсэн Хөрөнгө нь Компанийн Өөрийн Хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байна.

5.1.2. Компанийн Хувь Нийлүүлсэн Хөрөнгө нь таван тэрбум (5,000,000,000.00) төгрөг байна.

5.1.3. Компани нь Хувь Нийлүүлсэн Хөрөнгөд аливаа өөрчлөлт хийхээсээ өмнө Даатгалын Тусгай Зөвшөөрлийн Журамд заасан баримт бичиг болон мэдээллийг СЗХ-д хүргүүлж, СЗХ-ны зөвшөөрлийг авна.

5.1.4. Өөрийн Хөрөнгийн хэмжээ нь Компанийн тухайн жилийн санхүүгийн тайлангаар Хувь Нийлүүлсэн Хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг тайлан гарснаас арван (10) Ажлын Өдрийн дотор ТУЗ нь Хувьцаа Эзэмшигчдийн Хурал (ХЭХ)-ыг зарлаж, Хувь Нийлүүлсэн Хөрөнгөд өөрчлөлт оруулах, Компанийг дахин хөрөнгөжүүлэх эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлнэ.

### 5.2 Компанийн энгийн хувьцаа эзэмшигчид

5.2.1 Компанийн нийт гаргасан бөгөөд эргэлтэнд байгаа энгийн хувьцааг эзэмшигч-хуулийн этгээд:

| Энгийн хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг | | Регистрийн дугаар | Эзэмшиж буй хувьцааны ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 5.2.1.1 | "Голомт Файнэншил Групп" ХХК<br>Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Голомт хотхон, А66 тоот | 5845742 | 2'550'000 (хоёр сая таван зуун тавин мянга) ширхэг | 1000.00 (нэг мянган ширхэг) | 2,550,000,000.00 төгрөг (хоёр тэрбум таван зуун тавин сая) |
| 5.2.2.2 | "Юу Эм Си Капитал" ХХК<br>Хан-Уул дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, 66-2 | 5434815 | 2'450'000 (хоёр сая дөрвөн зуун тавин мянга) ширхэг | 1000.00 (нэг мянган ширхэг) | 2,450,000,000.00 (хоёр тэрбум дөрвөн зуун тавин сая) төгрөг |



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

**5.3 Зарласан, гаргасан болон халаасны хувьцаа, тэдгээрийн нэгжийн үнэ, эзэмшигч**

5.3.1. Компани нь нэг бүр нь 1,000.00 (нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй хорин таван сая (25,000,000.) ширхэг энгийн хувьцаа гаргах эрхтэй байна.

5.3.2. Компани нь нэг бүр нь 1,000.00 (нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6,243,016 (зургаан сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаа) ширхэг хувьцаа гаргасан.

5.3.3. Компани нь нэг бүр нь 1,000 (нэг мянга)төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,243,016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан ширхэг халаасны хувьцаатай.

| | Халаасны хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг | Регистрийн дугаар | Халаасны хувьцааны тоо | | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэрлэсэн үнэ | Тоо | Нийт үнэ |
| 5.3.3.1. | "Мандал Даатгал" ХХК<br>Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж 7/1, Мандал Бюлдинг 4 давхар | 5473489 | 1000.00 (нэг мянган ширхэг) | 1.243.016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаа) ширхэг | 1'243'016.00 (нэг тэрбум хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) төгрөг |

5.3.3.2 Энгийн хувьцаа нэг бүр саналын нэг эрхтэй байна.

5.3.3.3 Энгийн хувьцаа нэг бүр хуваагдахгүй бөгөөд Хувьцаа Эзэмшигчийн нэр дээр бүртгэгдсэн байна.

5.3.3.4 Компанийн зарласан энгийн хувьцаанаас хувьцаа нэмж (эсхүл энэхүү Дүрэмд заасан бусад үнэт цаас) гаргах тогтоолыг Хувьцаа Эзэмшигчдийн Хурал (ХЭХ)-ын шийдвэр (тогтоол гэсэн нэртэй байна)-ээр батална. Тухайн тогтоол нь гаргах хувьцааны төрөл, тоо болон нөхцөл, болзлыг тусгасан байна.

5.3.3.5 Компани нь энгийн хувьцааг нэрлэсэн үнээс нь доогуур үнээр гаргаж болохгүй.

5.3.3.6 Компанийн нийт гаргасан хувьцааны арав (10) буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа Хувьцаа Эзэмшигч нь СЗХ-ны урьдчилан бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр Компанийн хувьцааг аливаа этгээдэд шилжүүлэхгүй.

5.3.3.7 Компанийн нийт гаргасан хувьцааны арав (10) буюу түүнээс дээш хувийг шууд болон шууд бусаар эзэмших хүсэлтэй этгээд нь СЗХ-ны бичгээр олгосон зөвшөөрлийг авсан байна.

5.3.3.8 Компанийн хувьцааны төлбөрийг зөвхөн мөнгөн хөрөнгөөр хийх бөгөөд Хувь Нийлүүлсэн Хөрөнгөд оруулах өөрчлөлтийг зөвшөөрсөн СЗХ-ны мэдэгдлийг хүлээн авснаас хойш гурван (3) Ажлын Өдрийн дотор хувьцааны төлбөрийг СЗХ-ны тусгай дансанд шилжүүлж, арван (10) хоног байршуулна.

5.3.3.9 СЗХ-ны бичгээр урьдчилан олгосон зөвшөөрөлгүйгээр Компани нь хувьцаатай холбогдох дараах үйлдлийг хийхгүй:

5.3.3.9.1 Компанийн хувьцааг худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл тийнхүү захиран зарцуулахыг Компанийн хувьцаа эзэмшигчид зөвшөөрөх;

5.3.3.9.2. Хувь Нийлүүлсэн Хөрөнгийг нэмэгдүүлэх болон багасгах үр дагаварт хүргэх хувьцаа гаргах болон хуваарилах, эсхүл хувьцаа



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC

СЗХ
2018 оны 08 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

16/002 тоот "МАНДАЛ ЖЕНЕРАЛ ДААТГАЛ" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН ХАВСРАЛТ №1

эзэмшигчдийн эзэмшиж байгаа хувьцааны хувийг бууруулах буюу нэмэгдүүлэх үр дагаварт хүргэх хэлцэл хийх.

5.4 **Энгийн хувьцаанаас бусад үнэт цаас**

Компани нь энгийн хувьцаанаас гадна бусад үнэт цаасыг (үүнд, гэвч үүгээр хязгаарлахгүйгээр, давуу эрхийн хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаас, опцион болон бонд) Холбогдох Хуульд нийцүүлэн болон ХЭХ-аас тодорхойлсон нөхцөл, болзлын дагуу гаргаж болно.

5.4 **Компани Өөрийн Үнэт Цаасыг Худалдан Авах ба Эргүүлэн Авах**

Компани нь өөрийн гаргасан үнэт цаасыг Компанийн Хуулийн зүйл заалтын дагуу худалдан авч эсхүл эргүүлэн авч болно.

5.5 **Үнэт Цаас Эзэмшигчдийн Бүртгэл**

5.5.1 Компани нь Холбогдох Хуулийн дагуу Компанийн үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлийг (цаашид "**Үнэт Цаас Эзэмшигчдийн Бүртгэл**" гэх) хөтөлнө. Үнэт Цаас Эзэмшигчдийн Бүртгэлд хувьцаа эзэмшигч нь иргэн бол түүний овог, нэр, регистерийн дугаар, хуулийн этгээд бол түүний татварын байгууллагад бүртгэгдсэн хаяг, регистерийн дугаар байх бөгөөд хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны төрөл, тоо, бусдад шилжүүлсэн хувьцааны тоо, тийнхүү хувьцаа шилжүүлэн авсан этгээдийн овог нэр, болон бусад холбогдох мэдээлэл байна.

5.5.2 Хувьцаа эзэмшигчийн Компанид эзэмшиж байгаа хувьцааны тоо болон тухайн хувьцаатай холбоотой эрхийг гэрчилсэн үнэт цаасны гэрчилгээг Компани нь хувьцаа эзэмшигчид олгож болно. Тийм тодорхойлолт нь үнэт цаасанд тооцогдохгүй.

6. **Хувьцаа Эзэмшигчдийн Хурал**

6.1 ХЭХ нь Компанийн эрх барих дээд байгууллага байна.

6.2 ХЭХ нь ээлжит болон ээлжит бус байж болно.

6.3 ХЭХ-ыг ТУЗ-ийн шийдвэрээр Компанийн санхүүгийн жил дууссанаас дөрвөн (4) сарын дотор зарлаж хуралдуулна.

6.4 Дээрх 6.3 дах хэсэгт заасан хугацаанд Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн хурал хуралдуулахаас бусад бүрэн эрх тухайн өдрөөс эхлэн дуусгавар болох бөгөөд ийнхүү ТУЗ-ийн бүрэн эрх дуусгавар болсон өдрөөс хойш Компанийн байгуулсан аливаа гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр бус байна.

6.4.1 Дээрх 6.3 дах хэсэгт заасан хугацаанд Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг хуралдуулаагүй тохиолдолд Компанийн хувьцаа эзэмшигчид нь өөрсдийн санаачилгаар Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит Хурлыг хуралдуулж, ТУЗ-ийн шинэ гишүүдийг томилно.

6.5 Хувьцаа Эзэмшигчдийн Ээлжит бус хурлыг ТУЗ-өөс тийнхүү зарлан хуралдуулах тухай тогтоолыг Холбогдох Хуулийн дагуу батлан хуралдуулж болно.

6.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц нь Компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 75 (далан тав) хувиас илүү хувийг эзэмшиж буй Хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор бүрдэж, хурал хүчин төгөлдөр болно.

6.7 Хувьцаа эзэмшигчдийн хурал нь дор дурдсан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх онцгой бүрэн эрхтэй:

(a) Энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эсхүл шинэ дүрэм батлах;



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС

(б) Нэгтгэх, нийлэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар Компанийг өөрчлөн зохион байгуулах;

(в) Компанийн өрийг хувьцаагаар солих;

(г) Компанийг татан буулгах болон татан буулгах комисс томилох;

(д) Компанийн хувьцааг нэгтгэх буюу хуваах;

(е) ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

(ё) Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

(ж) Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

(з) Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;

(и) Компанийн Хуульд заасны дагуу Компани өөрийн хувьцааг худалдан авахыг зөвшөөрөх;

(й) Компанийн ногдол ашгийн бодлогыг батлах;

(к) ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох;

(л) Компанийн Хууль эсхүл энэхүү Дүрмээр тогтоосон хувьцаа эзэмшигчдийн батлах, зөвшөөрөх бусад асуудлууд; болон

(м) ТУЗ-өөс шийдвэрлүүлэхээр оруулсан бусад асуудлууд.

6.8 Хувьцаа эзэмшигч нь эзэмшиж буй саналын эрхтэй хувьцааныхаа тоотой тэнцүү тоогоор Хувьцаа эзэмшигчдийн хуралд санал өгнө.

6.9 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргаж буй шийдвэр нь, энэхүү Дүрмийн 6.7.а-6.7.е зүйлүүдэд заасан асуудлуудын хувьд Хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхийн буюу 66.66 хувиас багагүй саналаар, бусад асуудлаар энгийн олонх буюу 51 хувиас багагүй саналаар хүчин төгөлдөр болно.

## 7. Төлөөлөн Удирдах Зөвлөл

7.1 Компани нь ТУЗ-тэй байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь өөрийн үйл ажиллагааны эрх зүйн баримт бичгийг батлаж, дагаж мөрдөнө.

7.2 ТУЗ нь таван (5) гишүүнтэй байна. Эдгээрийн нэг нь хараат бус гишүүн байна.

7.3 ТУЗ-ийн гишүүн нь хувьцаа эзэмшигч-хуулийн этгээдийг төлөөлсөн хувь хүн байх бөгөөд хувьцаа эзэмшигч-хуулийн этгээдтэй нэгдмэл ашиг сонирхолгүй байж болно.

7.4 Нэг хувьцаа эзэмшигч-хуулийн этгээд нь ТУЗ-д 2 (хоёр) хүнийг томилж, энэ тухай тухайн хувьцаа эзэмшигч-хуулийн этгээдийн ХЭХ-ын шийдвэр гаргана. Энэхүү шийдвэрийг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

7.5 ТУЗ-ийн гишүүнийг нэг (1) жилийн хугацаатайгаар ХЭХ-ын шийдвэрээр томилох бөгөөд 3 (гурав) хүртэл удаа улируулан томилж болно. ТУЗ-ийн нэг бүрэн эрхийн хугацаанаас дараагийн бүрэн эрхийн хугацаа эхлэхэд ТУЗ-ийн гишүүдийн хамгийн багадаа 2 (хоёр) гишүүн ротация хийсэн байвал зохино.

ЗХ
2018.08.20 өдөр
№ 11



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
ТЗВ 01

7.6 ТУЗ-ийн гишүүнийг томилсон Хувьцаа эзэмшигч-хуулийн этгээд нь тухайн гишүүнийг бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болох бөгөөд түүний оронд шинэ гишүүн томилж болно.

Хэрэв ТУЗ-ийн гишүүн тэтгэвэрт гарсан, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн, өвчилсөн эсхүл ажиллах чадваргүй болсон, нас барсан эсхүл чөлөөлөгдсөн шалтгаанаар тухайн гишүүнийг томилсон хувьцаа эзэмшигч нь үлдсэн хугацаанд орлох гишүүнийг томилно. Нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаатай адил байна.

7.7 ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, ТУЗ-ийн хурлыг хуралдуулах, даргалах зэрэг Компанийн тухай хууль ба энэ дүрэмд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний бүрэн эрхийг ТУЗ-ийн хурлаас томилсон ТУЗ-ийн гишүүн хэрэгжүүлнэ.

7.8 Компанийн Хууль эсхүл энэхүү Дүрэмд тусгайлан заасан ХЭХ-ыг бүрэн эрхэд хамаарах асуудлаас бусад дараах асуудлуудыг ТУЗ нь хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхтэй:

7.9.1. Компанийн удирдлага болон бодлого чиглэлийг тодорхойлох;

7.9.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг хуралдуулах;

7.9.3 Хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал, хуралтай холбогдох бусад асуудлыг тодорхойлох;

7.9.4. Компанийн зарласан хувьцааны төрөл хэмжээнд багтаан хувьцаа гаргах;

7.9.5 Дүрэмд заасан энгийн хувьцаа болон бусад үнэт цаасанд хамаарах үнэт цаас гаргах;

7.9.6. Компанийн Хуулийн 55-р зүйлийн дагуу эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;

7.9.10. Компани өөрийн хувьцааг худалдан авах буюу эргүүлэн авах;

7.9.11. Гүйцэтгэх Захирлыг томилох, бүрэн эрхийг нь тодорхойлох;

7.9.12. Гүйцэтгэх Захиралтай байгуулах гэрээний нөхцөл, болзол, цалин хөлс, урамшууллын хэмжээ, үүрэг хариуцлагыг тогтоох;

7.9.13. Компанийн жилийн бизнесийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргах;

7.9.14. аудитор томилох, аудитортой байгуулах гэрээний нөхцлийг тодорхойлох;

7.9.15. Компанийн хувьцаанд төлөх ногдол ашгийн хэмжээ, ногдол ашгийг төлөх журмыг тодорхойлох;

7.9.16. ХЭХ ба Гүйцэтгэх Удирдлагаас батлан гаргахаас бусад эрх зүйн баримт бичгийг батлах;

7.9.17.Компанийн салбар, төлөөлөгчийн газрыг нээх;

7.9.18. Компанийг өөрчлөн зохион байгуулах талаарх хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх; болон

7.9.19. Гүйцэтгэх удирдлагын оруулсан бусад асуудал.

7.10. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг (“**ТУЗ-ийн Нарийн Бичгийн Дарга**” гэх) ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно. ТУЗ-ийн Нарийн Бичгийн Дарга нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
123

Үнэт цаасны танилцуулга
сар өдөр
2018 . 08 . 29



МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
01

7.10.1. ХЭХ-ын болон ТУЗ-ийн бичиг хэргийг хариуцан хөтлөх, Хувьцаа Эзэмшигчдэд мэдээлэл хүргэх;

7.10.2. ХЭХ-ын болон ТУЗ-ийн хурлын бэлтгэлийг хангах, хурлын зар, хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл болон гарах шийдвэрийн төсөл, бусад баримт бичгийг зохих журмын дагуу бэлтгэх, хүргэх ажлыг зохион байгуулах;

7.10.3. ХЭХ-ын болон ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хөтлөх, гарах шийдвэрийг зохих журмын дагуу баталгаажуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

7.10.4. ХЭХ-ын болон ТУЗ, Гүйцэтгэх Захирал болон бусад оролцогч талуудын хоорондын үйл ажиллагааны уялдааг хангах ажлыг зохион байгуулах;

7.10.5. ТУЗ-ийн дотоод үйл ажиллагааны зохион байгуулалтыг хариуцан зохицуулах.

7.9 ТУЗ-ийн хурлыг улирал тутамд нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд, хэрвээ шаардлагатай бол, нэмэлт ТУЗ-ийн хурлыг хуралдуулж болно. ТУЗ-ийн хурал гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно.ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн асуудал нэг бүрт шийдвэр гарах бөгөөд ТУЗ-ийн хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэгдэнэ. ТУЗ-ийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлууд:

7.11.1 ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг зохицуулсан журам гаргаж батална.

7.11.2. ТУЗ-ийн хурлыг Хувьцаа Эзэмшигчийн, ТУЗ-ийн даргын, ТУЗ-ийн аль нэг гишүүний эсхүл Гүйцэтгэх Захирлын санаачилгаар зарлан хуралдуулж болно.

7.11.3. ТУЗ-ийн гишүүдийн дөрөв (4) гишүүн эсвэл тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчид ТУЗ-ийн хуралд оролцсоноор хурлын ирц бүрдэж, хурал хүчин төгөлдөр болно.

7.11.4. ТУЗ-ийн хурлаар баталсан шийдвэр тус бүрээр ТУЗ-ийн тогтоол гаргана.

7.11.5. ТУЗ нь эчнээ санал хураалтаар тогтоол гаргаж болно.

7.11.6. ТУЗ-ийн тогтоол нь хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн санал(тавны дөрөв, хэрэв хуралд 4 гишүүн оролцсон бол дөрөвний гурвын санал)-аар хүчин төгөлдөр болно. Хэрвээ ТУЗ-ийн гишүүн нь Компанийн Хуульд зааснаар тодорхой асуудлаар санал өгөх эрхгүй бол тухайн асуудлаар санал өгөх эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар уг асуудлыг шийдвэрлэнэ.

7.11.7. ТУЗ-ийн гишүүн бүр ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын нэг эрхтэй байна. Санал тэнцсэн тохиолдолд ТУЗ-ийн даргын саналаар асуудлыг шийдвэрлэхгүй.

7.11.8. ТУЗ-ийн дэргэд Аудитын хороо ба Эрсдэлийн хороо ажиллана.

7.11.9. ТУЗ-ийн хурлын тэмдэглэл нь дараах мэдээллийг агуулсан байна:

7.11.9.1 Хурал болсон газар, цаг;

7.11.9.2. Хуралд оролцсон гишүүдийн нэрс;

7.11.9.3. Хурлаар хэлэлцсэн асуудал;

7.11.9.4. Хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн бүх асуудлууд болон асуудал тус бүрээр өгсөн саналын үр дүн; болон

7.11.9.5. Хурлаар батлагдсан тогтоолууд.



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT ... LLC
КАПИТАЛ ҮЦК ХХК



Огноо: 2018/04/16

7.11.10. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд ТУЗ-ийн дарга эсхүл хурлыг даргалсан гишүүн гарын үсэг зурах бөгөөд гарын үсэг зурсан этгээд нь хурлын тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцна.

7.11.11. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд гарсан алдаа нь уг хурлын шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

## 8. Гүйцэтгэх Захирал

8.1 Компани нь Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах нэг (1) Гүйцэтгэх Захиралтай байна.

8.2 Гүйцэтгэх Захирал нь энэхүү Дүрэм болон Гүйцэтгэх Захирлын Гэрээгээр тогтоосон эрх хэмжээний үндсэн дээр болон хүрээнд үйл ажиллагаа явуулна.

8.3 Гүйцэтгэх Захирлын Гэрээ нь дараах асуудлыг агуулсан байна:

8.3.1.Гүйцэтгэх Захирлын эрх, үүрэг;

8.3.2. Гүйцэтгэх Захирлын хариуцлагын хэмжээ, хязгаар;

8.3.3. Гүйцэтгэх Захирлыг хариуцлагаас чөлөөлөх нөхцөл; болон

8.3.4. Гүйцэтгэх Захирлын цалин, урамшуулал.

8.4 Гүйцэтгэх Захирал нь Гүйцэтгэх Захирлын Гэрээнд заасан Гүйцэтгэх Захирлын бүрэн эрхийн хэмжээ, хязгаарын хүрээнд Компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, Компанийн ашиг сонирхлыг төлөөлөх зэргээр Компанийг итгэмжлэлгүйгээр төлөөлж болно.

8.5 ТУЗ нь Гүйцэтгэх Захирлын бүрэн эрхийг хэдийд ч дуусгавар болгож болно.

## 9. Ногдол Ашиг Төлөх, Компанийн Эд Хөрөнгийн Захиран Зарцуулах

9.1 Ногдол ашиг төлөх эсэх болон хэрвээ төлөхөөр бол, ногдол ашигийг төлөх хугацаа, хэмжээ болон нөхцөлийг тогтоосон шийдвэр гаргах нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарна.

9.2 ТУЗ нь Компанийн санхүүгийн жил дууссанаас хойш тавин (50) хоногийн дотор ногдол ашиг төлөх эсхүл үл төлөх эсэх тухай шийдвэрийг гаргах бөгөөд шийдвэрийг гаргаснаас хойш ажлын гурван (3) өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд бичгээр мэдэгдэж, шийдвэрийн хуулбарыг хүргүүлнэ.

9.3 Ногдол ашгийг бэлэн мөнгөөр, эд хөрөнгөөр, Компанийн болон бусад этгээдийн үнэт цаасаар төлж болно.

9.4 Хэрвээ Хувьцаа Эзэмшигч нь Компанид эзэмшиж байгаа хувьцаагаа ногдол ашиг төлөх өдрөөс өмнө гэхдээ ногдол ашгийн бүртгэлийн өдрийн дараа худалдах эсхүл шилжүүлсэн бол Хувьцаа Эзэмшигч нь тухайн хувьцаанд ногдох ногдол ашгийн авах эрхтэй байна.

9.5 Хэрвээ ногдол ашиг төлөх шийдвэр гарсан бол Компани нь ногдол ашгийг түүнийг төлөх өдөр төлөх үүрэгтэй. Хэрвээ ногдол ашгийг тэрхүү төлөх ёстой өдөр төлөөгүй бол, Хувьцаа Эзэмшигчийн шаардсанаар, Компани нь Хувьцаа Эзэмшигчид Иргэний Хуульд заасан алданги төлөх бөгөөд уг алдангитай холбогдон Компанид учирсан аливаа хохирлыг Гүйцэтгэх Захирал Компанид нөхөн төлнө.

9.6 Дараах нөхцөл бүрдсэн тохиолдолд Компани нь ногдол ашиг төлж болно:

9.6.1. Ногдол ашиг төлсний дараа Компани нь төлбөрийн чадвартай байх;

9.6.2. Ногдол ашиг төлсний дараа Компанийн Өөрийн Хөрөнгө нь дор дурдсаны нийлбэр дүнгээс илүү байх:

9.6.3. Холбогдох Хуулинд заасан Хувь Нийлүүлсэн Хөрөнгийн доод хэмжээ;




Огноо: 2018/04/16

Үнэт цаасны танилцуулга
СЗХ
он сар өдөр
2018 08 29
№ 01



МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
01
МАНДАЛ ДААТГАЛ ХХК

9.6.4. Компанийн давуу эрхийн хувьцааны хуримтлагдсан бөгөөд төлөгдөөгүй ногдол ашиг (хэрэв байгаа бол); болон

9.6.4. Компанийн давуу эрхийн хувьцааны татан буулгалтын үнэ (хэрэв байгаа бол).

9.6.5. Ногдол ашиг төлсний дараа Даатгалын Хууль болон Даатгалын Багц Дүрэмд заасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг хангасан хэвээр байх.

9.6.6. Ногдол ашиг төлсний дараа Даатгалын Багц Дүрэмд заасан даатгалын нөөц санд тавигдах доод хэмжээг хангасан хэвээр байх.

9.7 Компани нь эргүүлэн авсан хувьцаандаа ногдол ашиг төлөхгүй.

9.8 Ногдол ашиг төлсний дараа Компанийн Өөрийн Хөрөнгө нь хорин таваас (25%) дээш хувиар багассан тохиолдолд Өөрийн Хөрөнгийн хэмжээг Компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш арван таван (15) Ажлын Өдрийн дотор өөрийн зээлдүүлэгчдэд бичгээр мэдэгдэнэ.

9.9 Компани нь аливаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг захиран зарцуулснаас Компанийн өөрийн хөрөнгө Холбогдох Хууль болон энэхүү Дүрмээр тогтоосон Хувь Нийлүүлсэн Хөрөнгийн хэмжээнээс багасах эсхүл Компани төлбөрийн чадваргүй болох үр дагаварт хүргэх тохиолдолд аливаа эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг зах зээлийн үнээс нь доогуур үнээр захиран зарцуулж болохгүй.

## 10. Эрх Бүхий Этгээдийн Хариуцлага

10.1 Эрх Бүхий Этгээдийн Хүлээх Үүрэг

10.1.1. Энэхүү Дүрэм болон Дотоод Дүрэм Журамд тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, эрх мэдлээ хэрэгжүүлэх бөгөөд Компанийн эрх ашгийг дээдлэн үйл ажиллагаандаа Компанийн Хууль, Даатгалын Хууль, Даатгалын Багц Дүрэм, энэхүү Дүрэм, Дотоод Дүрэм Журам болон гэрээнд заасан үүргээ чанд биелүүлнэ.

10.1.2. Эрх, үүргээ гүйцэтгэх явцдаа болон Эрх Бүхий Этгээдтэй байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш гурван (3) жилийн туршид Компанийн нууц мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхлын төлөө ашиглах, ТУЗ-ийн зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд задруулахыг хориглоно.

10.1.3. Компанийн эрх ашигт нийцсэн бөгөөд үндэслэл бүхий шийдвэр гаргана.

10.1.4. Үүссэн болон үүсч болзошгүй сонирхлын зөрчлийн талаар Компанид нэн даруй мэдэгдэнэ.

10.1.5. Өөрийн эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ хөндлөнгийн аливаа этгээдээс аливаа бэлэг, урамшуулал авахгүй.

10.2 Өөрийн Хөрөнгөөр Хүлээх Хариуцлага

10.2.1. Эрх Бүхий Этгээд нь дор дурдсан хууль бус үйлдэл, эс үйлдлийн улмаас Компани, Хувьцаа Эзэмшигчид болон Компанийн зээлдүүлэгчдэд учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө:

10.2.2. Хувийн ашиг сонирхлын үүднээс Компанийн нэрийг ашигласан;

10.2.3. Компанийн Хувьцаа Эзэмшигч болон зээлдүүлэгчдэд санаатайгаар хуурамч мэдээлэл өгсөн;

10.2.4. Мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

2018 .08.16 0092 тоот "МАНДАЛ ЖЕНЕРАЛ ДААТГАЛ" ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭРИЙН ХАВСРАЛТ №1

10.3. Компанийн Хуулийн 97 дугаар зүйлд заасан журмын дагуу Компанийн бичиг баримтыг хадгалаагүй;

10.4. Компанийн Хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлэл авах эрх бүхий этгээдэд гаргаж өгөөгүй эсхүл хугацаа хожимдуулан гаргаж өгсөн; эсхүл

10.5. Энэхүү Дүрмийн 10.1 хэсэгт заасан үүргээ биелүүлээгүй эсхүл удаа дараа зөрчсөн.

10.5.1. Энэхүү Дүрмийн 10.1 хэсэгт заасан заасныг зөрчин шийдвэр гаргасан Эрх Бүхий Этгээдүүд нь хамтын хариуцлага хүлээх бөгөөд хохирлыг тэнцүү хэмжээгээр нөхөн төлнө.

10.5.2. Энэхүү 10.2 дугаар зүйлд заасан хариуцлагыг Холбогдох Хуульд заасан бусад хариуцлагатай давхар хүлээлгэж болно.

10.6. Эрх Бүхий Этгээдийн Нэгдмэл Сонирхолтой Этгээдүүд

Эрх Бүхий Этгээд нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш арван (10) хоногийн дотор өөрийн Нэгдмэл Сонирхолтой Этгээдийн жагсаалтыг гаргаж, ТУЗ-ийн Нарийн Бичгийн Даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүрд арван (10) хоногийн дотор ТУЗ-ийн Нарийн Бичгийн Даргад мэдэгдэнэ.

## 11. САНХҮҮГИЙН ХЯНАЛТ

### 11.3. Урьдчилгаа Төлбөр болон Зээлтэй Холбогдох Хязгаарлалтууд

Компани нь дараах үйл ажиллагааг явуулахгүй:

11.3.1. Компанийн хувьцааг төлбөрийн баталгаа болгох замаар урьдчилгаа төлбөр авах, мөнгө зээлдүүлэх;

11.3.2. Аливаа сангаас холбогдох этгээдэд зээл олгох;

11.3.3. Аливаа этгээдэд барьцаагүй зээл олгох;

11.3.4. Холбогдох этгээдийн бусдаас авсан зээлд баталгаа, батлан даалт гаргах;

11.3.5. Хувь Нийлүүлсэн Хөрөнгийн болон даатгалын нөөц сангийн мөнгөн хөрөнгийг холбогдох этгээд болон түүний үүсгэн байгуулсан банкинд байршуулах.

### 11.4. Нягтлан Бодох Бүртгэл болон Тайлан

11.4.1. Компани нь Хувьцаа Эзэмшигч болон бусад эрх бүхий этгээдэд хүргүүлэх нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайланг Холбогдох Хуулийн дагуу хөтөлж, бэлдэнэ.

11.4.2. Компанийн санхүүгийн жил нь хуанлийн жил байх бөгөөд тухайн жилийн 1-р сарын 1-нээр эхэлж 12-р сарын 31-нд дуусгавар болно.

11.4.3. Гүйцэтгэх Захирал нь Компанийн нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

### 11.5. Санхүүгийн Тайлан болон Жилийн Үйл Ажиллагааны Тайлан

11.5.1. Компанийн санхүүгийн тайлан нь дараах мэдээллийг агуулна:

11.5.2. Баланс;

11.5.3. Орлого, үр дүнгийн тайлан;

11.5.4. Мөнгөн гүйлгээний тайлан;

11.5.5. Хуримтлагдсан ашгийн тайлан;

11.5.6.Тухайн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, хэлцэл тус бүрийн төрөл, үнийн дүн;

11.5.7. Компанийн удирдлагад олгосон цалин, шагнал, урамшуулал;

11.6. Зохих нэмэлт тайлбар болон хууль болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоосон бусад мэдээлэл.

11.6.1. ТУЗ нь Компанийн бүтэц, зохион байгуулалт, хөрөнгө болон бизнесийн үйл ажиллагааны талаарх жилийн тайлан бэлтгэж Хувьцаа Эзэмшигчид танилцуулна. Жилийн тайланд дараах мэдээллийг агуулсан байна:

11.6.1.1. тухайн санхүүгийн жилд явуулсан үйл ажиллагааны танилцуулга, уг үйл ажиллагааны үр дүн, өмнөх жилтэй харьцуулахад гарсан өөрчлөлт, Компанийн бүтэц, зохион байгуулалт, болон бүтэц зохион байгуулалтын хувьд өмнөх жилтэй харьцуулахад гарсан өөрчлөлтүүд; болон

11.6.1.2. Компанийн Эрх Бүхий Этгээдэд олгосон урамшууллын хэмжээ, Компанийн удирдлагын тухайн жилд гаргасан зардал.

11.6.2. ТУЗ нь санхүүгийн тайлангийн талаарх тайлан дүгнэлтээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.

11.6.3. Компани нь улирал дууссанаас хойш 30 хоногийн дотор улирлын санхүүгийн тайлан, үйл ажиллагааны мэдээг гаргаж Хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ. Тайлан мэдээнд дараах зүйлс багтана. Үүнд:

11.6.3.1. Улирлын санхүүгийн хураангуй тайлан;

11.6.3.2. Улирлын санхүүгийн тайланд удирдлагын багаас өгсөн дүгнэлт, тайлбар, тухайн улиралд болсон гол үйл явдал;

11.6.3.3. Компанийн нөөц сангийн товч тайлан;

11.6.3.4.Том дүнтэй нөхөн төлбөрийн мэдээ;

11.6.3.5.Эрсдлийн удирдлагын хорооны хурлын тэмдэглэл;

11.6.3.6.Хувьцаа эзэмшигчдийн шаардсан бусад мэдээ мэдээлэл.

11.6.4. Компани нь санхүүгийн жил дууссанаас 120 хоногийн дотор аудитлуулсан санхүүгийн тайланг Хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.

**11.7. Компанийн Бичиг Баримтыг Хадгалах**

11.7.1. Компани нь дараах бичиг баримтыг хадгална:

11.7.1.1. Энэхүү Дүрэм, Дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд, Компани үүсгэн байгуулах тогтоол шийдвэрүүд, болон Компанийн бүртгэлийн гэрчилгээ;

11.7.1.2. Хувьцаа Эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх Захирлын батлсан тушаал, шийдвэр, тогтоол, Дотоод Дүрэм Журам;

11.7.1.3. Компанийн салбар, төлөөлөгчийн газрын дүрэм, журам;

11.7.1.4. Баланс дээр бүртгэгдсэн Компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн өмчлөлийг нотлох бичиг баримтууд;

11.7.1.5.Хувьцаа Эзэмшигчдийн болон ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, Гүйцэтгэх Захирлын тушаал, шийдвэрүүд;

11.7.1.6.Жилийн санхүүгийн тайлан, Компанийн бизнесийн үйл ажиллагааны тайлангууд;

11.7.1.7.Энгийн хувьцаа болон үнэт цаас гаргах журам болон гаргахтай холбоотой шийдвэрүүд;

11.7.1.8.Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт бичгүүд;

11.7.1.9.Эрх Бүхий Этгээдийн Нэгдмэл Сонирхолтой Этгээдийн жагсаалт, нэгдмэл сонирхолтой этгээд тус бүрийн Компанид эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл; болон

11.7.1.10.Компанийн Хуульд заасан бусад баримт бичиг.

11.8.Компани нь энэхүү 11.4-р зүйлд заасан бичиг баримтыг Компанийн үйл ажиллагаа явуулах үндсэн газар эсхүл Хувьцаа Эзэмшигчийн мэдэх, нэвтрэх боломжтой газар хадгална.

11.9. Компани нь энэхүү Дүрэм болон Дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг хугацаагүй хадгална. Компани нь энэхүү Дүрмийн 11.4-р зүйлд заасан баримт бичгийг 5 жилээс доошгүй хугацаанд хадгалах бөгөөд уг хугацааны дараа тэдгээр бичиг баримтыг архивт шилжүүлж болно.

11.10. Гүйцэтгэх Захирал нь энэхүү Дүрмийн 11.4-р зүйлд заасан баримт бичгийг хадгалах, эрх бүхий этгээд тэдгээр баримт бичигтэй танилцах боломж олгох, архивт шилжүүлэх үүргийг хүлээнэ. Гүйцэтгэх Захирал нь компанийн баримт бичгийг хөтлөх ажлыг бэлтгэх, зохион байгуулах талаар биечлэн хариуцлага хүлээнэ.

**11.11. Мэдээллийг Танилцуулах**

11.11.1.Компани нь хууль тогтоомжоор хориглосноос бусад баримт бичгийг (түүнд Гүйцэтгэх Захирлын гаргасан тушаал, шийдвэр болон Компанийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг зэрэг орно, гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) Хувьцаа Эзэмшигчийн хүссэнээр Хувьцаа Эзэмшигчид танилцуулах бөгөөд боломжийн төлбөртэйгээр баримт бичгийн хуулбар хийхийг зөвшөөрөх боловч Холбогдох Хуулийн дагуу задруулахыг хориглосон баримт бичгийг Хувьцаа Эзэмшигчид танилцуулах үүрэг хүлээхгүй.

11.11.2. Хувьцаа Эзэмшигч нь Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт, эзэмшиж байгаа хувьцааны тоо, төрөл зэргийг агуулсан бүртгэлийг авах хүсэлт гаргаж болно. Гүйцэтгэх Захирал эсхүл Хувьцаа Эзэмшигчийн Бүртгэлийг хөтлөх эрхтэй байгууллага нь хүсэлт гаргаснаас хойш таван (5) Ажлын Өдрийн дотор гаргаж өгнө. Хувьцаа Эзэмшигч нь тийм бүртгэлийн зардлыг хариуцна.

**12. Дотоод Журам**

11.12.1.Хувьцаа Эзэмшигч нь ТУЗ, Гүйцэтгэх Захирлын үйл ажиллагаа түүнчлэн Эрх Бүхий Этгээдийн үүрэг, мөн Компанийн бизнесийн үйл ажиллагааны

Үнэт цаасны танилцуулга
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ



МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
МАНДАЛ ДААТГАЛ ХХК

шаардлагаар эсхүл дотоод менежментийн шаардлагаар бусад асуудлыг зохицуулсан Дотоод Дүрэм Журам гаргаж болно.

11.12.2.Дотоод Дүрэм Журам нь Хувьцаа эзэмшигч эсхүл түүний эрх олгосноор ТУЗ баталснаар хүчин төгөлдөр болно.

## 13. Өөрчлөн Зохион Байгуулах, Татан Буулгах

13.1. Холбогдох Хуульд заасны дагуу Компани нь нэгтгэх, нийлэх, хуваах, эсхүл өөрлөгдөх хэлбэрээр өөрчлөн зохион байгуулагдаж болно.

13.2. ТУЗ нь татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа Компанид үлдэх эд хөрөнгийг Хувьцаа Эзэмшигчид хуваарилах журам зэргийг агуулсан тогтоолын төслийг Хувьцаа Эзэмшигчдийн хуралд оруулна. Уг тогтоол нь татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам зэргийг агуулсан байна.

13.3.Хувьцаа Эзэмшигчийн шийдвэрээр Компанийн хэдийд ч татан буулгаж болно.

13.4.Компани нь үйл ажиллагаагаа түдгэлзүүлэх болон зогсоох тухай шийдвэрийг уг шийлвэр гарснаас хойш гурван (3) Ажлын Өдрийн дотор ХЭБГ-т хүргүүлнэ.

13.5.Татан буулгах комисс томилогдсоноор Гүйцэтгэх Захирлын эрх мэдэл дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ. Татан буулгах комисс нь Компанийг шуухэд төлөөлнө.

13.6.Татан буулгах комисс нь Хувьцаа Эзэмшигчийн баталсан тогтоол, Иргэний Хууль, Компанийн Хууль болон бусад Холбогдох Хуулийн дагуу зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг хангах журам болон Компанийн үлдэх хөрөнгийг тараах журмыг батална.

13.7.Татан буулгах комисс Компанийн эд хөрөнгийг хуваарилсны дараа Компанийг татан буулгах үйл ажиллагаа дуусгавар болсон тухай ХЭБГ-т мэдэгдэж, татан буулгах балансын хувийг хүргүүлнэ.

13.8.ХЭБГ Компанийн нэрийг Улсын бүртгэлээс хассан өдөр Компанийг татан буугдсанд тооцно.

## 14. Баримтлах Хууль

Энэхүү Дүрмийн хүчин төгөлдөр эсэх, тайлбарлах, хэрэгжүүлэх, нэмэлт өөрчлөлт оруулах, дуусгавар болгох зэрэг асуудлыг Холбогдох Хуулиар зохицуулж, тайлбарлана.

## 15. Бусад

### 15.4. ХЭБГ-т Бүртгүүлэх Мэдээлэл

Компанийн дор дурдсан мэдээлэлд өөрчлөлт орсон тохиолдолд ХЭБГ-т гурван (3) Ажлын Өдрийн дотор бүртгүүлнэ. Үүнд:

15.4.1Компанийн нэр, регистрийн дугаар;

15.4.2.Компанийн төрөл, хэлбэр;

15.4.3.Компанийн ерөнхий захиргааны оршин байгаа газрын албан ёсны хаяг;

15.4.4.Компанийг байгуулсан арга;

15.4.5.Компанийн хувьцаа эзэмшигчид;

15.4.6.Компанийн үүсгэн байгуулах баримт бичгийн талаарх;

15.4.7.Компани өөрчлөн байгуулагдсан тохиолдолд эрх залгамжлалын талаарх;



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
1117236573 5481589

130

Үнэт цаасны танилцуулга
2018 08 29 өдөр
БҮРТГЭВ
№ 1

МАНДАЛ даатгал
STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01



15.4.8.Компанийн Хувь Нийлүүлсэн Хөрөнгийн хэмжээ;

15.4.9.Гүйцэтгэх Захирал;

15.4.10.Компанийн эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн талаарх; болон

15.4.11.Компанийн салбар, төлөөлөгчийн газрын хууль ёсны хаяг (хэрэв байгаа бол).

15.5. Хэл

Энэхүү Дүрмийг Монгол хэл дээр таван (5) эх хувь хийсэн болно. Эх хувиудын хооронд зөрүү гарвал ХЭБГ-т хадгалагдаж байгаа хувийг баримтална.

15.6. Хүчин Төгөлдөр Болох Өдөр

Энэхүү Дүрэм нь ХЭБГ-т бүртгэгдсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

15.7. Дүрэмд Нэмэлт Өөрчлөлт Оруулах, Дүрмийн Шинэчилсэн Найруулга

Энэхүү Дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт болон энэхүү Дүрмийн шинэчилсэн найруулгыг Хувьцаа Эзэмшигч батална. Компани нь Дүрмийн нэмэлт өөрчлөлт, шинэчилсэн найруулгыг Хувьцаа Эзэмшигч уг нэмэлт өөрчлөлт болон шинэчилсэн найруулгыг баталсан тогтоол гарснаас хойш арван (10) Ажлын Өдрийн дотор ХЭБГ, СЗХ-нд бүртгүүлнэ. Энэхүү Дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт болон энэхүү Дүрмийн шинэчилсэн найруулга нь ХЭБГ-т бүртгэгдсэн өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

15.8. Холбогдох Хуулиудийн Зөрчил

Энэхүү Дүрэм нь Холбогдох Хуультай зөрчилдөх эсхүл нийцэх тохиолдолд Холбогдох Хуулийн тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байгаа заалтуудыг баримтална.

15.9. Хавсралтууд

Энэхүү Дүрмийн Хавсралтууд нь энэхүү Дүрмийн салшгүй хэсэг бөгөөд энэхүү Дүрэмтэй адил заавал биелэгдэх хүчин төгөлдөр байна.



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал

МОНГОЛ УЛС
131

ХАВСРАЛТ А

## НЭР ТОМЬЁО

1. Энэхүү Дүрмийн текст болон агуулга нь өөрөөр тодорхойлоогүй бол дор дурдсан нэр томьёо нь дор дурдсан агуулгатай:

"**Нэгдмэл Сонирхолтой Этгээд**" гэж Компанитай холбогдох дараах этгээдүүдийг хэлнэ[1]:

(а) тодорхой гэрээний үндсэн дээр хамтран Компанийн удирдлагын гаргах шийдвэрийг тодорхойлох боломжтой бүлэг хүмүүс;

(б) Компанийн нэгдэлд хамаарч байгаа бол уг компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон тэдгээрийн Эрх Бүхий Этгээдүүд;

(в) Компанийн удирдлагын гаргах шийдвэрийг тодорхойлох боломжтой компани болон хувь хүн эсхүл бүлэг хүмүүс (гэрээний үндсэн дээр);

(г) Нэг хүн эсхүл бүлэг хүмүүс гаргах шийдвэрийг нь тодорхойлох боломж бүхий компани;

(д) Компани болон Компанийн Эрх Бүхий Этгээдүүд;;

(е) Компанийн Хувьцаа Эзэмшигчид;

(ё) Хувь хүн болон:

(i) тухайн этгээд (түүний Нэгдмэл Сонирхолтой Этгээд нь) гуравны нэг болон түүнээс дээш хувийг нь эзэмшдэг компани;

(ii) тухайн этгээд (түүний Нэгдмэл Сонирхолтой Этгээд нь) эрх бүхий албан тушаал хашдаг компани;

(a) Энэ зүйлийн (1) болон (2) дахь хэсэгт заасан компанийн нэгдэлд хамаарах компани;

(b) Энэ зүйлийн (3) дахь хэсэгт заасан компанийн хувьцааны гуравны нэг болон түүнээс дээш хувийг эзэмшигч эсхүл уг компанийн эрх бүхий этгээд;

(ж) ажил олгогч болон түүний ажилтан.

"**Холбогдох Хууль**" гэж Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа, энэхүү Дүрмээр зохицуулсан харилцаатай холбогдох Компанид хамаарах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц түүнчлэн хууль, тогтоомж, дүрэм, улсын их хурлын тогтоол, ерөнхийлөгчийн зарлиг, засгийн газрын тогтоол, засгийн газрын гишүүний тогтоол, яамны дүрэм журам, тушаал, болон бусад (үндэсний болон орон нутгийн) хууль тогтоомж, гүйцэтгэх эсхүл эрх зүйн норм тогтоосон акт.

"**ТУЗ**" буюу "**Төлөөлөн Удирдах Зөвлөл**" гэж энэхүү Дүрмийн дагуу тухай бүр томилогдсон Компанийн төлөөлөн удирдах зөвлөл.

"**Иргэний Хууль**" гэж 2002 оны 2-р сарын 5-ны өдөр хүчин төгөлдөр болсон, түүнээс хойш нэмэлт өөрчлөлт орсон Монгол улсын Иргэний хууль.

"**Компани**" гэж Удиртгал хэсэгт заасныг хэлнэ.

"**Компанийн Хууль**" 2011 оны 11-р сарын 06-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд түүнээс хойш нэмэлт өөрчлөлт орсон Компанийн тухай Монгол улсын хуулийн шинэчилсэн найруулга.

[1] Компанийн Хуулийн 99-р зүйл

**"ТУЗ-ийн гишүүн"** гэж энэхүү Дүрмийн дагуу тухай бүр томилогдсон Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн.

**"Гүйцэтгэх Захирал"** энэхүү Дүрэмд заасны дагуу томилогдсон Компанийн гүйцэтгэх захирал.

**"Гүйцэтгэх Захирлын Гэрээ"** гэж ТУЗ болон Гүйцэтгэх Захирлын хооронд байгуулсан Гүйцэтгэх Захирлын эрх хэмжээг тодорхойлсон гэрээ.

**"СЗХ"** гэж Монгол улсын Санхүүгийн Зохицуулах Хороо.

**"Эрх Бүхий Этгээд"** гэж Хувьцаа Эзэмшигч, ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх Захирал, санхүүгийн албаны захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (хэрэв байгаа бол) зэрэг Компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээд[2].

**"Даатгалын Хууль"** гэж 2005 оны 6-р сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд түүнээс хойш нэмэлт өөрчлөлт орсон Даатгалын тухай Монгол улсын хууль.

**"Даатгалын Тусгай Зөвшөөрлийн Журам"** гэж 2008 оны 3-р сарын 28-ны өдрийн СЗХ-ны 61 тоот тогтоолоор баталсан бөгөөд түүнээс хойш нэмэлт өөрчлөлт орсон Ердийн Даатгал, Давхар Даатгалын болон Даатгалын Мэргэжлийн Оролцогчийн Үйл Ажиллагаа Эрхлэх Тусгай Зөвшөөрлийн Журам.

**"Даатгалын Багц Дүрэм"** гэж Даатгалын Хуулинд заасны дагуу эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах зорилгоор баталсан дүрэм, журам, заавар, шаардлага, нөхцөл, болзол.

**"Дотоод Дүрэм Журам"** энэхүү Дүрмийн дагуу баталж, нэмэлт өөрлөлт оруулсан Компанийн дотоод дүрэм, журам.

**"ХЭБГ"** гэж Монгол улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Хуулийн Этгээдийн Бүртгэлийн Газар.

**"Лиценз Олгосон Өдөр"** гэж Холбогдох Хуулийн дагуу СЗХ-ноос Компанид ердийн даатгалын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн тусгай зөвшөөрөл олгосон өдөр.

**"МНТ"** or **"Монгол Төгрөг"** гэж Монгол улсын хууль ёсны мөнгөн тэмдэгт.

**"Өөрийн Хөрөнгө"** гэж Компанийн балансад тусгагдсан биет болон биет бус хөрөнгийн дүнгээс Компанийн нийт өр төлбөрийг хасаад үлдсэн хэсэг[3]

**"Хувь Нийлүүлсэн Хөрөнгө"** гэж Компаниас Хувьцаа Эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүн[4]

**"Хуулийн Этгээдийн Бүртгэлийн Хууль"** гэж 2003 оны 10-р сарын 1-ны өдөр хүчин төгөлдөр болсон бөгөөд түүнээс хойш нэмэлт өөрчлөлт орсон Хуулийн Этгээдийн Улсын Бүртгэлийн тухай Монгол улсын хууль.

**"Ажлын Өдөр"** гэж Монгол улсад банк нээлттэй ажилладаг өдөр (Бямба, Ням болон нийтээр амрах баярын өдрүүдээс бусад өдрүүд).

2. Хавсралт, зүйл болон хэсэг гэдэг нь энэхүү Дүрмийн хавсралт, зүйл болон хэсгийг хэлж байгаа болно.

3. Холбогдох Хууль болон бусад хууль, дүрэм журам эсхүл бусад хэм хэмжээ тогтоосон акт хэмээн энэхүү Дүрэмд дурдсан нь тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон тэдгээр Холбогдох Хууль болон бусад хууль, дүрэм журам эсхүл бусад хэм хэмжээ тогтоосон актыг хэлнэ.

[2] Компанийн Хуулийн 84.1 болон 84.10-р зүйлүүд
[3] Компанийн Хуулийн 30.3-р зүйл
[4] Компанийн Хуулийн 30.1-р зүйл



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС

Үнэт цаасны танилцуулга



4. Энэхүү Дүрэмд дурдсан баримт бичиг, гэрээ, хэлцэл нь тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон тийм баримт бичиг, гэрээ, хэлцлийг мөн хамаарна.

5. Энэхүү Дүрэмд дурдсан ганц тоо нь олон тоог илэрхийлэх бөгөөд хүйс нь бүх хүйсийг илэрхийлсэн болно.

6. Энэхүү Дүрмийн зүйл заалтын гарчигийг зөвхөн лавлагаа буюу иш татах зорилгоор оруулсан бөгөөд тэдгээр гарчиг нь энэхүү Дүрмийг тайлбарлахад ямар нэгэн байдлаар нөлөөлөхгүй.

7. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх Захирал болон Компанийн бусад албан тушаалтан гэдэг нь энэхүү Дүрмийн дагуу томилогдсон бөгөөд Компанид тухайн албан тушаалыг тухай бүр хашиж байгаа этгээдийг хэлнэ.

8. Монгол улсын засгийн газрын байгууллага эсхүл яам, тамгын газар хэмээн дурдсан нь улсын, бүсийн, орон нутгийн эсхүл бусад түвшний тухайн эрх бүхий байгууллага, газар, хэлтэсийг хамаарна. Яам, алба, газар, хэлтэс, комисс, агентлаг зэргээр дурдсан нь холбогдох захиргааны чиг үүргийг залгамжлан авсан тухайн байгууллагын эрх залгамжлагч байгууллагыг мөн хамаарна.

9. "үүнд", "үүнийг оролцуулан тооцно" эсхүл "үүнд, гэвч үүгээр хязгаарлагдахгүйгээр" эсхүл "үүнд, гэвч үүгээр хязгаарлахдахгүйгээр, оролцуулан тооцно" зэрэг хэллэгүүд нь тийнхүү бичсэн утгаар тайлбарлагдана.

*** *** ***

6.5. Үнэт цаас гаргах тухай Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоол

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
Регистрийн дугаар: 5473489
Хаяг: НСКБ барилга, 4 давхар, Нарны зам 87,
13-р хороолол, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар хот 14230, Монгол улс
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292, Улаанбаатар 15160
(976) 75773000
(976) 70117017
info@mandal.mn
www.mandal.mn

2018 оны 9 сарын 12 өдөр Дугаар 18/004 Улаанбаатар хот

## МАНДАЛ ДААТГАЛ ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

**Компанийн хэлбэрийг өөрчлөх, түүнтэй холбоотой авах зарим арга хэмжээний тухай**

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг , 23 дугаар зүйлийн 23.1, 23.2 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.7, 33.8 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.4 дэх заалтууд, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг болон "Мандал Даатгал" ХХК-ийн (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.7.(а), 6.7.(б) хэсэг, 7 дугаар зүйлийн 7.9.4, 7.9.5, 7.9.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Мандал Даатгал" ХХК-ийг хувьцаат компани болгох замаар хэлбэрийг өөрчлөн байгуулахыг зөвшөөрч, компанийн эрх, үүрэг хариуцлагыг шинээр бий болж байгаа хувьцаат компанид шилжүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Компанийн хэлбэрийг өөрчлөх төслийг нэгдүгээр хавсралтаар батлсугай.
3. Компанийн зарласан энгийн хувьцаанаас 1,243,016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаа) ширхэг энгийн хувьцааг гүйлгээнд гаргаж Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээр нийтэд санал болгохоор шийдвэрлэсүгэй.
4. Хувьцаа эзэмшигч "Юу Эм Си Капитал" ХХК нь Мандал Даатгал ХХК-ийн эзэмшиж буй энгийн хувьцаанаас 317,738 (гурван зуун арван долоон мянга долоон зуун гучин найм) ширхэг хувьцааг нэмж гаргасан энгийн хувьцаатай хамт нийтэд санал болгохоор шийдвэрлэснийг зөвшөөрсүгэй.
5. Нийтэд санал болгохоор нэмж гаргасан энгийн хувьцаанаас одоогийн хувьцаа эзэмшигчид тэргүүн ээлжид худалдан авах эрхээ эдлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.
6. Шинээр бий болж байгаа хувьцаат компанийн шинэчилсэн дүрмийг хоёрдугаар хавсралтаар батлсугай.
7. Нэмж гаргасан энгийн хувьцааг нийтэд санал болгох зах зээлийн үнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоохыг зөвшөөрсүгэй.
8. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хооронд 2014 оны 10 сарын 08-ны өдөр байгуулагдсан "Хувьцаа эзэмшигчдийн гэрээ"-г дуусгавар болсныг үүгээр баталгаажуулсугай.
9. Компанийг өөрчлөн байгуулахтай холбоотойгоор шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж холбогдон гарсан асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажиллах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
Регистрийн дугаар: 5473489
Хаяг: НСКБ барилга, 4 давхар, Нарны зам 87,
13-р хороолол, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар хот 14230, Монгол улс
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292, Улаанбаатар 15160
(976) 75773000
(976) 70117017
info@mandal.mn
www.mandal.mn

2018 оны 2 сарын 12 өдөр Дугаар 18/004 Улаанбаатар хот

10. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үнэт цаас гаргахтай холбоотой ажлыг хууль тогтоомжийн хүрээнд удирдан зохион байгуулах, Санхүүгийн зохицуулах хороо, "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-д үнэт цаасны танилцуулгыг андеррайтерийн компанитай хамтран бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлан)-д даалгасугай.

11. Компанийг өөрчлөн байгуулахтай холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д холбогдох баримт материалыг хүргүүлэх, шинэчилсэн дүрмийг Оюуны Өмч, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар, Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлан)-д даалгасугай.

Хувьцаа эзэмшигч
"Голомт Файнэншл Групп" ХХК-ийг төлөөлж
ТУЗ-ийн дарга Д.Баясгалан

Хувьцаа эзэмшигч
"Юу Эм Си Капитал" ХХК-ийг төлөөлж
Хувьцаа эзэмшигч Ө.Ганзориг



Огноо: 2018/04/16

2018.08.29

## 6.6. Үнэт цаасны үнэ тогтоох тухай ТУЗ-ийн тогтоол

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
БҮРТГЭВ
01

МАНДАЛ даатгал

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
Регистрийн дугаар: 5473489
Хаяг: НСКБ барилга, 4 давхар, Нарны зам 87,
13-р хороолол, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Улаанбаатар хот 14230, Монгол улс
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292, Улаанбаатар 15160
(976) 75773000
(976) 70117017
info@mandal.mn
www.mandal.mn

2018 оны 2 сарын 15 өдөр Дугаар 18/002 Улаанбаатар хот

### МАНДАЛ ДААТГАЛ ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

**Нийтэд санал болгох энгийн хувьцааны нэрлэсэн үнийг тогтоох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 43 дугаар зүйл болон 55 дугаар зүйл, "Мандал Даатгал" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.9.6 дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 2 сарын 12-ны өдрийн ээлжит бус хурлын №18/004 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн хэлбэрийг өөрчлөх асуудлыг шийдвэрлэсэнтэй холбогдуулан "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгож байгаа "Мандал даатгал" ХХК-ийн энгийн хувьцааны үнийг 4,800 (дөрвөн мянга найман зуун) төгрөг байхаар тогтоосугай.

2. Нийтэд санал болгож байгаа энгийн хувьцааг "Монголын Хөрөнгийн Бирж" ТӨХК-аар дамжуулан нийтэд санал болгох, худалдах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Жавхлан)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн (О.Гэнкологоо)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ө. ГАНЗОРИГ

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
Б. Жавхлан

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC

## 6.7. Үнэт цаас гаргагчийн шинэчилсэн дүрмийн төсөл

*Мандал даатгал ХК-ийн 2018 оны .... сарын ....-ны/ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын №.... тоот тогтоолын ..... хавсралтаар батлагдсан.*

# МАНДАЛ ДААТГАЛ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Мандал Даатгал” компани нь нээлттэй хувьцаат компани /цаашид “Компани” гэх/ мөн.

1.2. Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Даатгалын тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан бусад холбогдох хэм хэмжээний акт болон энэхүү дүрмээр компанийн үйл ажиллагааг зохицуулна

1.3. Компанийн оноосон албан ёсны нэрийг

- Монголоор: **“Мандал даатгал” ХК**
- Англиар: “**Mandal daatgal” Joint stock company** гэнэ.

1.4. Компанийн оршин байгаа газрын хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, 13 дугаар хороолол, Нарны зам-87, Норт спринг капитал блю барилга, 4 давхар.

1.5. Компани нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд нээлттэй ХК гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

1.6. Компани өөрийн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

1.7. Компани өөрийн бэлгэдэл, барааны тэмдэгтэй байх бөгөөд түүнийг хэрэглэх эрхийг зөвхөн “Мандал даатгал” ХК эдэлнэ.

1.8. Компани нь үйл ажиллагаандаа нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ болон компанийн засаглалын шилдэг жишгийг удирдлага болгоно.

1.9. Компани нь үйл ажиллагаагаа тодорхойгүй хугацаагаар явуулна.

1.10. Компанийг энэхүү дүрэм болон Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу өөрчлөх болон өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгана.

## Хоёр. Компанийн эрх зүйн байдал

2.1. Компани нь өөрийн тусгаарласан хөрөнгөтэй байх ба бие даан эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх эдэлнэ. Компани нь бие даасан баланс, өөрийн нэр бүхий тэмдэг, компанийн логотой байх ба Компани нь банканд төгрөгийн, гадаад валютын болон бусад данстай байна. Компани нь шүүх ажиллагаанд нэхэмжлэгч, хариуцагч, болон гуравдагч этгээдээр оролцох эрхтэй.

2.2. Компани нь өөрийн материаллаг болон мөнгөн хөрөнгөтэй байх ба тэдгээрийг ашиглах, захиран зарцуулах болон бусад эрхийг эдэлнэ.

2.3. Хувьцаа эзэмшигчид Компанийн хариуцлагыг хүлээхгүй ба Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй болно.

2.4. Компани нь өөрийн салбар, төлөөлөгчийн газрыг нээж болно. Салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрх эдлэхгүй ба Компаниас баталсан дотоод журмын дагуу үйл ажиллагаа явуулна.

2.5. Компанийн салбар, төлөөлөгчийн газрыг Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ" гэх) шийдвэрээр байгуулж зохих журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-нд бүртгүүлнэ.

2.6. Компани нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан бусад эрхийг эдэлнэ.

**Гурав. Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэл**

3.1. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, худалдах /үйлчилгээ үзүүлэх/ замаар ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийг өсгөж, тэдний ашиг сонирхлыг хангаж ажиллах нь компанийн үндсэн зорилго мөн.

3.2. Үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж, хууль, дүрэм, журмуудыг чанд сахих замаар хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж, ашигт ажиллагааг бий болгох замаар хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг эрхэмлэн ажиллах нь компанийн эрхэм зорилго мөн.

3.3. Компани нь ердийн даатгалын үндсэн үйл ажиллагааг дараах хэлбэрээр эрхэлнэ. Үүнд:

3.3.1. *Гэнэтийн осол, эмчилгээний зардлын;*
3.3.2. *Хөрөнгийн;*
3.3.3. *Авто тээврийн хэрэгслийн;*
3.3.4. *Ачааны;*
3.3.5. *Барилга угсралтын;*
3.3.6. *Агаарын хөлгийн;*
3.3.7. *Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын;*
3.3.8. *Хариуцлагын;*
3.3.9. *Санхүүгийн;*
3.3.10. *Газар тариалангийн;*
3.3.11. *Мал амьтдын;*
3.3.12. *Зээлийн;*
3.3.13. *Итгэлцлийн;*
3.3.14. *Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн;,*
3.3.15. *Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийн өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын;*
3.3.16. *Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын;*
3.3.17. *Жолоочийн хариуцлагын албан журмын;*
3.3.18. *Хууль болон Даатгалын багц дүрмээр зөвшөөрсөн даатгалын хэлбэр, даатгалтай холбоотой үйл ажиллагаа.*

3.4. Монгол Улсын хууль тогтоомж, Даатгалын багц дүрмийн дагуу зөвшөөрөл авахаар тусгайлан заасан үйл ажиллагааг явуулахдаа холбогдох зөвшөөрлийг авна.

3.5. Үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор нээлттэй зах зээл дээр үйл ажиллагаа явуулна.

**Дөрөв. Компанийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө**

4.1. Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 6,243,016 ширхэг энгийн хувьцаа байна.

4.2. Хувь нийлүүлсэн хөрөнгө түүний доод хэмжээг даатгалын ангилал, давхар даатгалын онцлогийг харгалзан Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоох бөгөөд уг хэмжээг баримтална. Дүрмийн санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхгүй.

4.3. Компани нээлттэй буюу хаалттай захиалгын үндсэн дээр хувьцаа болон бусад үнэт цаас гаргаж болно.

4.4. Компани гүйлгээнд гаргасан өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авсан бол эдгээр хувьцааг халаасны хувьцаа гэж үзэх бөгөөд балансад хувь нийлүүлсэн хөрөнгийн хэсэгт нэрлэсэн үнээр нь хасах тэмдэгтэйгээр харуулна.

4.5. Компанийн нийт хөрөнгөнөөс өр төлбөрийг хассан дүнг өөрийн хөрөнгө гэх бөгөөд өөрийн хөрөнгийн дүн нь санхүүгийн тайлан баланс гарах бүрд өөрчлөгдөнө.

4.6. Жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь энэхүү дүрэмд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн дүнгээс бага болсон тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/ нь ийнхүү бага болсон шалтгааныг судлан, дүгнэлт гаргаж, дахин хөрөнгөжүүлэх, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг бууруулах /хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар/ тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оруулан хэлэлцүүлнэ. Хэрвээ ийнхүү бага болсон нь алдагдалтай ажилласнаас шалтгаалсан бөгөөд дахин хөрөнгөжүүлэх, хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах замаар шийдвэрлэх боломжгүй бол компанийг татан буулгах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

4.7. Шинээр хувьцаа гаргаж хөрөнгө оруулбал тэр хэмжээгээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны тоо нэмэгдэнэ.

4.8. Цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилаад үлдсэн ашгийн хэмжээгээр компанийн өөрийн хөрөнгө нэмэгдэх бөгөөд хувьцааны тоо өөрчлөгдөхгүй.

4.9. Алдагдал гарсан, үндсэн ба эргэлтийн хөрөнгийг устгасан, найдваргүй авлагыг данснаас хассан зэрэг тохиолдолд тэр хэмжээгээр компанийн хуримтлагдсан ашиг болон өөрийн хөрөнгө буурна. Хувьцааны тоо болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөхгүй.

4.10. Үндсэн ба эргэлтийн хөрөнгийг дахин үнэлж, үнэлгээний зөрүүг бүртгэлд тусгасан тохиолдолд өөрийн хөрөнгө ба хувьцааны балансын үнэ нэмэгдэж, хорогдоно.

4.11. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг дараах байдлаар нэмэгдүүлж хорогдуулж болно:

4.11.1. Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөх;

4.11.2. Хувьцааны нэрлэсэн үнийг өөрчлөлгүйгээр хувьцааг хуваах эсхүл нэгтгэх;

4.11.3. Хувьцаа нэмж гаргах болон худалдан авсан халаасны хувьцааг хүчингүй болгох.

4.12. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт орох тухай бүр Санхүүгийн зохицуулах хорооноос зохих зөвшөөрлийг авна.

## Тав. Хувьцаа эзэмшигчийн эрх, үүрэг

5.1. Компанийн энгийн хувьцааг эзэмшсэн этгээд компанийн хувьцаа эзэмшигч болно.

5.2. Энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:

5.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлах, эчнээ санал хураалт явуулах тухай шийдвэр гаргах үед ТУЗ-өөс тогтоосон "бүртгэлийн өдөр" компанийн хувьцааг эзэмшиж байсан этгээд хуралд оролцож, хэлэлцэж буй бүх асуудлаар өөрийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаатай хувь тэнцүүлэн санал өгөх;

5.2.2. ТУЗ-өөс ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн үед хувьцаанд ногдох ногдол ашиг авах, ногдол ашиг олгохоор зарласан боловч хуульд заасан хугацаанд хувиарлаагүй бол алданги төлөхийг шаардах;

5.2.3. Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос эзэмшиж буй хувьцааны тоогоор хувь хүртэх;

5.2.4. Нэмж гаргасан хувьцаа, хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах, энэ эрхээ бусдад бүрэн болон хэсэгчлэн шилжүүлэх;

5.2.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлаар шийдвэр гаргахад эсрэг саналтай байсан, эсвэл санал хураалтад оролцоогүй хувьцаа эзэмшигч бүр өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах;

5.2.5.1. Нийлэх, нэгдэх, хуваах болон хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчлөх;

5.2.5.2. Хэлцэл хийхийн өмнөх улирлын сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдаж авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл хийсэн, компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдаж авах эрхийн бичиг болон энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах зэрэг их хэмжээний хэлцэл хийх;

5.2.5.3. Хувьцаа эзэмшигчдийн эрхийг хязгаарласан нэмэлт өөрчлөлтийг дүрэмд оруулсан, эсхүл ийм агуулгатай компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

5.2.5.4. Нэг хувьцаа эзэмшигч түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хамт компанийн энгийн хувьцааны 75-аас дээш хувийг эзэмших болсон, эсхүл компанийн мэдлийн багц хувьцааг худалдсан тохиолдолд бусад хувьцаа эзэмшигчи д нь компанид хувьцаагаа эргүүлэн авахыг шаардах эрхтэй.

5.2.6. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх;

5.2.7. Энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч жил бүрийн 3 дугаар сарын 1-ний дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын талаар нэмэлт санал гаргах, компанийн ТУЗ-д болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комисст нэр дэвшүүлэх;

5.2.8. Компанийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал шийдвэр болон хууль тогтоомжоор нийтэд мэдээлэхийг хориглосноос бусад баримт бичигтэй танилцах, үнэ төлбөргүй хуулбарлан авах;

5.2.9. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нь компанийн аж ахуй, санхүүгийн үйл ажиллагаанд аудитын шалгалт хийлгэх;

5.2.10. Энгийн хувьцааны 10 хувиас дээш хувийг эзэмшиж буй этгээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулахаар ТУЗ-д саналаа хүргүүлэх;

5.2.11. Компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуулийн 84.4-т заасан үүргээ биелүүлээгүйн улмаас компанид хохирол учруулсан бол уг албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;

5.2.12. Хууль тогтоомж болон энэхүү дүрмээр тогтоосон бусад эрх.

5.3. Компанийн хувьцаа эзэмшигч дараах үүрэгтэй. Үүнд:

5.3.1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн нэр, оршин байгаа хаягийн өөрчлөлтөө тухай бүр үнэт цаасны бүртгэл хөтлөх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;

5.3.2. Нийт гаргасан хувьцааны 1/3 болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу тендер санал зарлах;

5.3.3. Нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай компанид бичгээр мэдэгдэх.

5.4. Компанийн хувьцаа эзэмшигчид дараах хяналтыг тавина. Үүнд:

5.4.1. Нийт гаргасан энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлэхийг хориглоно.

5.4.2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшил, өмчлөлд буй энэ дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.1 дэх хэсэгт заасан хөрөнгийн талаар Санхүүгийн зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараах үйлдэл хийхийг хориглоно. Үүнд:

5.4.2.1. худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөх;

5.4.2.2. өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх болон багасгах үр дагаварт хүргэх хувьцаа гаргах, хуваарилах, хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувийг бууруулах буюу нэмэгдүүлэх үр дагаварт хүргэх хэлцэл хийх.

5.5. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр эрсдэл хүлээнэ.

## Зургаа. Компанийн үнэт цаасыг гаргах, худалдах, эргүүлэн авах

6.1. Компани давуу эрхийн хувьцаа, өрийн бичиг болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг гаргаж болно.

6.2. Энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг нийтэд санал болгон гаргахаар, энгийн хувьцааг нэмж гаргахаар шийдвэрлэсэн бол Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хороонд бүртгүүлнэ.

6.3. Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй үнийн дүн бүхий өрийн бичиг гаргах асуудлыг ТУЗ шийдвэрлэнэ. ТУЗ-ийн шийдвэрт гаргах өрийн бичгийн тоо, нэрлэсэн үнэ, зориулалт, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, нөхцөл, эргэж төлөгдөх хугацаа, эргүүлэн авах үнэ, энгийн хувьцаанд хөрвөх эсэхийг заасан байна.

6.4. Хувьцаа бусад үнэт цаасны үнийг Компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу Компанийн ТУЗ тогтооно.

6.5. Компани нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас буюу эд хөрөнгийн бусад хэлбэрээр хийж болно.

6.6. Компаниас шинээр болон нэмж гаргаж байгаа үнэт цаасны төлбөрийг зөвхөн мөнгөн хэлбэрээр хийнэ.

6.7. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу брокерт захиалга өгөх замаар худалдан авч болно.

6.8. Компани энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь эсхүл зарим хэсгийг худалдаж авч болно. Харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджаас 25 хувиас илүүгүй байна.

6.9. Компани өөрийн гаргасан үнэт цаасыг худалдаж авах шийдвэрийг энгийн хувьцааны 5-аас дээш хувийг худалдаж авахаас бусад тохиолдолд ТУЗ гаргах бөгөөд уг шийдвэртээ худалдаж авах үнэт цаасны төрөл, тоо, үнэ, төлбөр хийх хугацаа, ашиглах журам зэргийг заана.

## Долоо. Компанийн удирдлага

### Хувьцаа эзэмшигчдийн хурал

7.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хуралд бэлдэх, хурлын зар мэдээг хүргэх, хурал хуралдуулах, тэмдэглэл хөтлөх, шийдвэр болон хурлын тэмдэглэлийг баталгаажуулах, холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг асуудлыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг хүргэх

журам" болон Компанийн ТУЗ-өөс баталсан "Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах журам"-аар зохицуулна.

7.2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит ба ээлжит бус хэлбэртэй байна.

7.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас дөрвөн сарын дотор буюу 5 дугаар сарын 01-ны дотор ТУЗ зарлан хуралдуулна.

7.4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны дийлэнх олонх (гуравны хоёр) оролцсоноор хурал хүчин төгөлдөр болно.

7.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдан явуулна. ТУЗ-ийн дарга хуралд оролцох боломжгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай асуудлыг шийдвэрлэсэн ТУЗ-ийн хурлаас томилогдсон этгээд хурлыг удирдана. Хурал удирдахаар томилогдсон этгээд хуралд хүрэлцэн ирэх боломжгүй нь хурал хуралдах үед илэрхий болсон бол хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар хурал даргалагчийг сонгоно.

7.6. Шаардлагатай үед ТУЗ, эсхүл ТУЗ-ийн 2-оос доошгүй хараат бус гишүүн, саналын эрхийн 10-аас доошгүй хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчийн санаачилгаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ТУЗ-өөс зарлан хуралдуулах, ТУЗ энэхүү үүргээ хэрэгжүүлээгүй бол тухайн этгээд өөрөө зарлан хуралдуулах эрхтэй.

7.7. Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ:

7.7.1. компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;

7.7.2. нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр компанийг өөрчлөн байгуулах;

7.7.3. компанийн өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;

7.7.4. компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

7.7.5. хувьцааг хуваах буюу нэгтгэх;

7.8. Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ:

7.8.1. ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;

7.8.2. компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу хувь нийлүүлэгчдэд хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлүүлэх эсэх;

7.8.3. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцүүлэх;

7.8.4. компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг хийх тухай шийдвэрийг ТУЗ санал нэгтэй гаргаж чадаагүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор шийдвэрлэх;

7.8.5. компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

7.8.6. Компанийн тухай хуулийн 49.10-д заснаас бусад тохиолдолд компанийн өөрийн гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг худалдан авахыг зөвшөөрөх;

7.8.7. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал.

7.9. Компанийн нэг ширхэг энгийн хувьцаа нэг саналын эрхтэй байна.

7.10. ТУЗ-ийн гишүүдийг сонгоход санал хураах кумулятив аргыг хэрэглэнэ. Энэ аргыг хэрэглэхдээ тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааны тоог ТУЗ-д сонгогдох гишүүний тоогоор үржүүлж саналын эрхийн тоог тодорхойлно. ТУЗ-ийн гишүүнд сонгогдохоор нэр дэвшсэн хүмүүсийн нэрийг саналын хуудсанд оруулахдаа ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж хүмүүсийн нэрсийг тус тусад нь жагсаана.

7.11. Хувьцаа эзэмшигч өөрийн төлөөлөх этгээдийг бичгээр олгосон итгэмжлэлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулж болох бөгөөд уг этгээд нь энэ тухайгаа ТУЗ-д хурал эхлэхээс өмнө мэдэгдэнэ.

7.12. Төлөөлөх тухай итгэмжлэл нь гагцхүү тухайн хувьцаа эзэмшигчдийн хуралд хүчинтэй. Хувьцаа эзэмшигчдийн хурал хойшилсон боловч тухайн хурлаар хэлэлцэхээр товлосон асуудал өөрчлөгдөөгүй тохиолдолд итгэмжлэл дараагийн хуралд хүчинтэй хэвээр байна.

7.13. Хувьцаа эзэмшигч хурлаас гарах шийдвэрийн төсөлд бичгээр санал ирүүлсэн тохиолдолд түүнийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон гэж үзнэ.

7.14. Хувьцаа эзэмшигчдийн хуралд ирүүлсэн саналын хуудас, мөн хувьцаа эзэмшигчийн итгэмжлэлийг хурлыг зарласан өдрөөс эхлэн хурал хуралдах өдрийн хурал эхлэх цаг хүртэл бүртгэнэ. Бүртгэлийг тооллогын комиссын дарга эсхүл түүний томилсон этгээд гүйцэтгэнэ.

7.15. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэлийг Компанийн тухай хуулийн 74-р зүйлд заасан журмын дагуу хөтөлж, хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор холбогдох эрх бүхий этгээдээр баталгаажуулна. Хурлын тэмдэглэлийн тус бүр нэг хувийг гарсан шийдвэрийн хамт Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад баталгаажсанаас хойш ажлын 3 хоногийн дотор хүргүүлнэ.

7.16. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэх асуудлыг эчнээ санал хураах замаар шийдвэрлэж болно. Харин хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулж болохгүй.

7.17. Эчнээ санал хураалт явуулах шийдвэрийг ТУЗ гаргах бөгөөд энэхүү шийдвэрт Компанийн тухай хуулийн 73.3-т заасан асуудлыг тусгасан байна.

7.18. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлыг тусгасан санал хураах хуудсыг саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрөөс ажлын 30-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг аргаар хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах, санал тоолох ажлыг Тооллогын комисс хариуцан гүйцэтгэнэ.

7.19. Саналын хуудсыг хүлээн авснаас хойш ажлын 3 хоногийн дотор санал хураасан дүн, санал хураалтын тайланг тооллогын комисс гаргаж, ТУЗ-д хүргэнэ.

7.20. ТУЗ нь энэхүү дүрмийн 7.18-д заасан тайланд үндэслэн шийдвэр гаргаж, шийдвэр гарснаас хойш ажлын 7 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдэд гарсан шийдвэрийн тухай мэдээллийг хурлын зар мэдээг хүргэдэг аргаар хүргэнэ.

## Найм. Төлөөлөн удирдах зөвлөл

8.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид "ТУЗ" гэнэ/ байна. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, нэр дэвшүүлэх журам, тэдний үйл ажиллагааны болон үйл ажиллагаанд нь дүгнэлт өгөх журам, ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг, бүрэн эрх, нарийн бичгийн даргын эрх, үүрэг зэргийг Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын кодексийн зарчимд нийцсэн "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-аар тогтоох бөгөөд уг журмыг ТУЗ батлан мөрдүүлнэ.

8.2. ТУЗ нь зарласан хувьцааны тоонд багтаан энгийн хувьцаа нэмж гаргах, нээлттэй хаалтай хүрээнд санал болгох, нийтэд санал болгох үнийг тогтоох бүрэн эрхтэй.

8.3. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй байх бөгөөд 3 нь энэ дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт заасан шалгуурыг хангасан хараат бус гишүүн байна.

8.4. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 3 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх үргэлжилнэ.

8.5. ТУЗ-ийн гишүүн мэргэшил, ёс зүйн өндөр шаардлага хангасан компанийн эрх ашгийг тэргүүн ээлжинд эрхэмлэдэг этгээд байвал зохино.

8.6. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь дараах шалгуурыг хангасан этгээд байна:

2018 . 08 . 29

8.6.1. дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэггүй;
8.6.2. өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа нэгдлийн бусад оролцогч компанид эрх бүхий албан тушаал хашдаггүй;
8.6.3. төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй;
8.6.4. өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн өнгөрсөн жилийн нийт борлуулалтын 1 хувиас дээш хэмжээний үнийн дүн бүхий хэлцлийг компанитай хийж байгаагүй;
8.6.5. компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшдэг этгээд, эсхүл компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш;
8.6.6. компани болон түүний хараат, охин компани, компанид нэгдэлд хамаарах компанийн нэгдэлд сүүлийн 1 жилийн хугацаанд эрх бүхий албан тушаалтан болон бусад албан тушаалд ажиллаж байгаагүй;
8.6.7. компанийн өрсөлдөгч аж ахуйн нэгж болон түүнд харьяалагддаг компанийн нэгдлийн аливаа оролцогч компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд биш.

8.7. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо энэ дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт заасан шалгуурыг хангасан этгээдийн нэрийг хараат бус гишүүнд нэр дэвшүүлнэ. Хараат бус гишүүнд нэрийг нь дэвшүүлж буй этгээд нь өөрөө зөвшөөрлөө бичгээр өгсөн байх бөгөөд энэ дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт заасан шалгуурыг хангаж байгаа гэдгээ албан ёсоор баталгаажуулсан байна. Энэхүү баталгааг хуурамчаар гаргасан нь тогтоогдвол ТУЗ-ийн дарга энэ талаар хувьцаа эзэмшигч болон Санхүүгийн зохицуулах хороо, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэх үүрэгтэй.

8.8. Компанийн ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо болон хувьцаа эзэмшигчдийн хуралд дараах мэдээллийг үнэн зөвөөр тайлагнах үүрэгтэй:
8.8.1. нэр дэвшүүлсэн этгээдийг нэр;
8.8.2. нэр дэвшигчийн нас, боловсролын байдал, ажилласан туршлага болон бусад дэлгэрэнгүй мэдээлэл;
8.8.3. нэр дэвшигчийн сүүлийн 5 (тав) жилийн хугацаанд эрхэлж байсан ажил, албан тушаал;
8.8.4. нэр дэвшүүлэх үед түүний эрхэлж байгаа ажил, ажил тушаал, сонгуульт ажлууд;
8.8.5. нэр дэвшигч нь компанийн хоорондын харилцан хамаарал байгаа эсэх;
8.8.6. нэр дэвшигч нь компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ямар нэг хамааралтай эсэх;
8.8.7. компанийн томоохон бизнесийн түншүүдтэй ямар нэг хамааралтай эсэх;
8.8.8. нэр дэвшигчийн орлогын эх үүсвэр, болон түүний ТУЗ-ийн гишүүний ажил үүрэгт нөлөөлөхүйц бусад нөхцөл байдлын талаарх мэдээлэл.

8.9. ТУЗ-ийн гишүүд нь Компанийн тухай хуульд заасан эрх бүхий албан тушаалтны хүлээх үүргийг хэрэгжүүлж ажиллахаас гадна, дараах үүргийг гүйцэтгэнэ:
8.9.1. компанийн ашиг сонирхлын төлөө, үнэнч шударгаар ажиллах;
8.9.2. ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн нууц болон нийтэд тараагдаагүй мэдээллийг өөрийн хувийн ашиг сонирхол буюу бусад этгээдийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх;
8.9.3. ТУЗ-д аливаа сонирхлын зөрчлийн талаар мэдээллээ бичгээр мэдэгдэж, тухайн асуудлыг шийдвэрлэхэд санал хураалтад оролцохгүй байх;
8.9.4. хувьцаа эзэмшигчдэд компанийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал болон компанийн засаглалын жишгийн талаар цаг тухайд нь үнэн зөв мэдээллийг бүрэн хангах;
8.9.5. өрсөлдөгч компанийн ТУЗ-ийн гишүүн, ажилтан, албан хаагчаар ажиллахгүй байх.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ

GOLOMT CAPITAL ҮЦК ХХК

8.10. ТУЗ-ийн гишүүн нь үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл төлөөлөн удирдах зөвлөл түр томилж болно.

8.11. ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар ТУЗ-ийн даргыг сонгоно.

8.12. ТУЗ-ийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих, ТУЗ-ийн зөвшөөрснөөр тодорхой асуудлаар тушаал, шийдвэр гаргах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

8.13. ТУЗ нь Компанийн тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- 8.13.1. компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл, стратеги, энэ дүрэмд заагаагүй үйл ажиллагааны чиглэлийг тогтоох;
- 8.13.2. компанийн жил бүрийн бизнес төлөвлөгөө, төсвийг батлах;
- 8.13.3. хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, эчнээ санал хураалт явуулах шийдвэр гаргах;
- 8.13.4. хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувь нийлүүлэгчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- 8.13.5. компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт болон цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах,
- 8.13.6. компанийн тухай хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тогтоох;
- 8.13.7. компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох;
- 8.13.8. компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөл, олгох шагнал, урамшуулал, хариуцлагын хэмжээг тогтоох;
- 8.13.9. компанийн аудиторыг сонгож, түүнтэй хийх гэрээний нөхцөлийг тогтоох;
- 8.13.10. ногдол ашгийн бодлогыг EPS хамгийн өндөр байх нөхцөлийг бодож тодорхойлох;
- 8.13.11. ТУЗ-ийн үйл ажиллагааны болон компанийн сайн засаглалын зарчмуудыг хэвшүүлэхтэй холбоотой “Монголын компанийн засаглалын кодекс”-т заасан бусад дотоод журмуудыг батлах;
- 8.13.12. Зарласан болон халаасны хувьцаанаас нээлттэй болон хаалттай гүйлгээнд гаргах шийдвэр гаргах;
- 8.13.13. өөрийн гаргасан хувьцаа болон бусад үнэт цаасыг эргүүлэн авах эсхүл худалдан авах шийдвэр гаргах;
- 8.13.14. компанийн салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн дарга, захирлыг томилох;
- 8.13.15. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох;
- 8.13.16. компанийг өөрчлөн байгуулах талаар хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 8.13.17. компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу их хэмжээний хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 8.13.18. компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт тодорхойлсон сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 8.13.19. эрх бүхий албан тушаалтны компанид учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 8.13.20. гадаад, дотоодын байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах, хувь нийлүүлэн хөрөнгө оруулах, компанийн хөрөнгөөр баталгаа гаргах;
- 8.13.21. компанийн ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар гүйцэтгэх захирлын эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлыг шийдвэрлэх;
- 8.13.22. хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал.

Үнэт цаасны танилцуулга
2018.08.29

МАНДАЛ даатгал

8.14. Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг ТУЗ-ийн нийт гишүүдийн 100 хувийн саналаар гаргана.

8.15. ТУЗ-ийн хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно.

8.16. ТУЗ-ийн хурлын шийдвэр нь тогтоол хэлбэртэй байх бөгөөд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. ТУЗ албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байж болно.

8.17. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга, түүний гишүүд, компанийн гүйцэтгэх захирал болон дотоод хяналтын алба, хараат бус аудитын байгууллагын санаачилга, шаардлагаар хуралдуулна. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

8.18. ТУЗ-ийн хурлын зохион байгуулалтыг нарийн бичгийн дарга хариуцаж, тэмдэглэл хөтөлнө. Мөн хурлын тухай зар, хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичиг, гарах шийдвэрийн төслийг ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж баталгаажуулсан байх бөгөөд хурал хуралдахаас 3-аас доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хариуцан гишүүдэд хүргэнэ.

8.19. ТУЗ-ийн даргын эзгүйд түүний томилсон ТУЗ-ийн аль нэг гишүүн хурлыг удирдана. ТУЗ-ийн дарга аливаа этгээдийг томилоогүй бол хуралд оролцож байгаа хамгийн ахмад гишүүн хурлыг удирдана. ТУЗ-өөс тодорхой асуудлыг шийдвэрлэх эрхийг ТУЗ-ийн дэргэдэх аль нэг Хороонд олгож болно.

8.20. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно. Компанийн тухай хуульд тусгайлан заасан зарим асуудлыг ТУЗ-ийн гишүүд санал нэгтэй гаргана.

8.21. ТУЗ нь мэдээлэл харилцаа холбооны техник хэрэгсэлийг ашиглан хуралдаж болно. Энэ тохиолдолд энэ дүрмийн 8 дугаар зүйлийн 8.39 дэх хэсэг нэгэн адил мөрдөгдөнө.

8.22. Тухайн шийдвэрлэж буй асуудлаар ТУЗ-ийн зарим гишүүд Компанийн тухай хуульд заасны дагуу санал өгөх эрхгүй бол шийдвэрийг саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.

8.23. ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцсэн тохиолдолд даргын саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Гишүүн нь эсрэг саналтай байвал түүнийгээ протоколд тэмдэглүүлэх эрхтэй.

8.24. ТУЗ-ийн гишүүн нь саналын эрхээ бусад гишүүд болон гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

8.25. ТУЗ-ийн гишүүн удаан хугацаагаар үүргээ хэрэгжүүлж чадахгүй болсон, нас барсан тохиолдолд орлох гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо түр томилно. Түр томилогдсон гишүүн нь энэ дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасан шаардлагыг хангасан байна. Хараат бус гишүүнд нэр дэвшсэн боловч сонгогдож чадаагүй гишүүдийн дотроос нөхөн сонгох асуудлыг тэргүүн ээлжинд дэвшүүлж болно.

8.26. ТУЗ-ийн гишүүдийн тоо нь тогтоосон нийт гишүүдийн тооноос 2 дахин бага болсон тохиолдолд компани нь 3 сарын дотор ТУЗ-ийн гишүүдийг сонгохоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулна.

8.27. ТУЗ-ийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.27.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлж хяналт тавих, үнэн зөвийг хариуцах;

8.27.2. хувьцаа эзэмшигчдийн хурлын болон ТУЗ-ийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих;

8.27.3. хувьцаа эзэмшигчдийн жил бүрийн ээлжит хурлын бэлтгэлийг энэ дүрэмд заасны дагуу хангаж байгаа эсэхэд хяналт тавих, жил бүрийн 3 дугаар сарын 15-ны дотор хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг гаргасан байх асуудлыг ТУЗ-ийн дарга биечлэн хариуцах ёстой;

8.27.4. ТУЗ-өөс олгосон бусад эрх хэмжээ.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
1117236007 5473489
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаасны танилцуулга
2018 о. 08 р 29 в
№ 1

МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

## Ес. ТУЗ-ын дэргэдэх хороод

9.1. Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, байнгын, мэргэшсэн байдлаар үйл ажиллагааг явуулах зорилготой Нэр дэвшүүлэх, Аудитын болон Цалин урамшууллын хороотой байна. Эдгээр хороодын гишүүд нь ТУЗ-ийн гишүүдээс бүрдэх бөгөөд тухайн хорооны нийт гишүүний 2/3-оос доошгүй нь хараат бус гишүүн байна.

9.2. **Аудитын хороо:**

9.2.1. ТУЗ-ийн аудитийн хорооны дарга нь хараат бус гишүүн байх бөгөөд санхүү, бүртгэл, эрсдэлийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн байна.

9.2.2. ТУЗ-ийн аудитийн хороо нь дараах чиг үүрэгтэй байна:

9.2.2.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

9.2.2.2. компанийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байгаа эсэх, хууль болон эрх бүхий байгууллагаас тогтоосон мэдээлийг нийтийн хүртээл болгож байгаа байдалд хяналт тавих;

9.2.2.3. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллын талаарх гүйцэтгэх удирдлагын саналыг хянах, ТУЗ-д танилцуулах;

9.2.2.4. хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүрэгт хамаарах асуудлаар шалгалт хийж дүгнэлт гаргах талаар хөндлөнгийн аудитийн байгууллагад чиглэл өгөх /чухам ямар чиглэлээр шалгалт хийж, дүгнэлт гаргасан байх талаар аудитийн байгууллагатай байгуулах гэрээнд тусгах замаар энэ эрхээ хэрэгжүүлнэ/;

9.2.2.5. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих;

9.2.2.6. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

9.3. **Нэр дэвшүүлэх хороо:**

9.3.1. ТУЗ-ийн нэр дэвшүүлэх хороо нь дараах чиг үүрэгтэй:

9.3.1.1. ТУЗ-ийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага зэргийг үнэлэх шалгуурыг тогтоох;

9.3.1.2. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигч нь ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлага, хараат бус гишүүний хувьд энэ дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргах;

9.3.1.3. ТУЗ-д нэр дэвшигчийг сонгон шалгаруулж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх /саналын хуудсанд шууд нэрийг нь оруулах/;

9.3.1.4. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

9.3.1.5. гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээний нөхцөлийг тодорхойлох;

9.3.1.6. ТУЗ-ийн гишүүдээс бусад эрх бүхий албан тушаалтны ажил үүргийн гүйцэтгэлд гүйцэтгэх захирлаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

9.3.1.7. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

GOLOMT CAPITAL LLC
GOLOMT КАПИТАЛ ҮЦК ХХК

9.3.2. ТУЗ-д нэр дэвшсэн аливаа этгээдийн нэрийг саналын хуудсанд оруулах эсэх тухай асуудлыг хэлэлцэхдээ тухайн этгээд нь дараах нөхцөл байдлыг хянах үүрэгтэй:

9.3.2.1. Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан ТУЗ-ийн гишүүнд тавигдах ур чадвар, мэдлэг боловсрол, ажлын туршлагын талаарх шаардлагыг хангаж байгаа эсэх;

9.3.2.2. жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хуралдуулаагүй, эсхүл зохих журмын дагуу хуралдуулаагүйгээс бүрэн эрх нь дуусгавар болсон ТУЗ-д ажиллаж байсан эсэх;

9.3.2.3. өмнө компанийн ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан этгээдийн нэрийг дахин дэвшүүлж байгаа бол ТУЗ-ийн гишүүний хувьд үүргээ зохих ёсоор хэрэгжүүлсэн эсэх;

9.3.2.4. компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан эсэх;

9.3.3. Дор дурдсан этгээд ТУЗ-ийн гишүүн байхыг хориглоно:

9.3.3.1. эрх зүйн чадамжгүй;

9.3.3.2. урьд нь эдийн засаг, аж ахуйн нэгжийн эсрэг гэмт хэрэгт шийтгэгдсэн бөгөөд ялтай байх хугацаа нь дуусаагүй байгаа;

9.3.3.3. өмнө нь дампуурсан хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалд ажиллаж байсан;

9.3.3.4. Компанийн тухай хуулийн 81.5.7-д заасан хугацаа өнгөрөөгүй байгаа;

9.3.3.5. Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас 2 болон түүнээс дээш удаа захиргааны хариуцлага хүлээж байсан.

9.4. **Цалин урамшууллын хороо**

9.4.1. Цалин урамшууллын хороо нь дараах чиг үүрэгтэй:

9.4.1.1. эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

9.4.1.2. эрх бүхий албан тушаалтанд олгох цалин урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин урамшуулал олгох санал боловсруулах;

9.4.1.3. компанийн цалин урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх;

9.4.1.4. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

## Арав. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

10.1. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ТУЗ-ийн даргын санал болгосон этгээдийг ТУЗ томилно. ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар ажиллах этгээд нь компанийн засаглалын асуудлаар сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна. Нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийг ТУЗ-ийн дарга томилно.

10.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь дараах чиг үүрэгтэй байх бөгөөд түүнийг сонгох, үйл ажиллагааг нь зохицуулах хэнахтай холбоотой нарийвчилсан асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тогтооно:

10.2.1. компанийн засаглалын талаар бодлого боловсруулахад оролцох;

10.2.2. бүрэн эрхийнхээ хүрээнд компанийн ажилтнууд компанийн засаглалын бодлогыг дагаж мөрдөх, компанид сайн засаглалын практикийг хэвшүүлэх үйл явцыг удирдан чиглүүлэх арга хэмжээ авах;

10.2.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл болон түүний хороодын хуралд бэлдэх, зарлах, хуралдуулах арга хэмжээг зохион байгуулах;

10.2.4. компанийн ТУЗ нь гүйцэтгэх албаны хэлтэс газрууд үр дүнтэй мэдээлэл солилцох тогтолцоог хариуцах;
10.2.5. мэдээллийг нийтэд хүргэх арга хэмжээ авах замаар компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах;
10.2.6. хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талаас ТУЗ-д ирүүлсэн аливаа санал, гомдол хүсэлтийг шийдвэрлэхэд оролцох, компани доторх маргааныг шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авах, санал боловсруулах;
10.2.7. хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий сонирхогч этгээд Компанийн тухай хууль болон энэ дүрмээр тогтоосон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх боломж олгох;
10.2.8. компанийн сайн засаглалын талаар олон улсын болон бусад компанийн туршлага, төрийн болон төрийн бус байгууллагаас энэ талаар дэвшүүлж буй санал санаачилгыг судлах замаар өөрийн компанийн засаглалыг цаашид сайжруулах санал боловсруулах;

## Арван нэг. ТУЗ-ийн хараат бус гишүүн

11.1. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь бусад гишүүдтэй адил эрх, үүрэгтэй байхаас гадна дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
11.1.1. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын шийдвэр нь хууль тогтоомж, компанийн дүрэм болон холбогдох дотоод журмуудад нийцэж байгаа эсэх, компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлж байгаа эсэхэд хяналт тавих, ийм зөрчилтэй шийдвэр гаргахаас сэргийлэх, гаргасан бол зөрчлийг арилгахыг шаардах, шаардлагыг эс биелүүлбэл асуудлыг ТУЗ-д тавьж хэлэлцүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахыг шаардах, хуралдуулаагүй тохиолдолд 2-оос доошгүй хараат бус гишүүн хамтран хурал зарлан хуралдуулах;
11.1.2. компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах талаар гүйцэтгэх удирдлагад үүрэг өгч хэрэгжилтийг хянах, холбогдох этгээдээс шаардах;
11.1.3. хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зарчмын зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах;
11.1.4. компанийн ТУЗ-өөс шилжүүлсэн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заасан бусад чиг үүрэг.

## Арван хоёр. Гүйцэтгэх удирдлага

12.1. Компанийн гүйцэтгэх удирдлага /цаашид “гүйцэтгэх захирал” гэх/ нь энэ дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.
12.2. Гүйцэтгэх захирлын бүрэн эрх, үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргах журам, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, цалин урамшуулал зэргийг ТУЗ-ийн гүйцэтгэх удирдлагатай байгуулсан гэрээгээр зохицуулна.
12.3. Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлнэ.
12.4. ТУЗ компанийн гүйцэтгэх захиралтай байгуулах гэрээнд ТУЗ-ийг төлөөлөн ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.
12.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн гишүүн байж болно. Харин ТУЗ-ийн дарга байх эсхүл өөр компанийн гүйцэтгэх захирлаар ажиллахыг хориглоно.
12.6. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд компанийн нэрийн өмнөөс хэлцэл хийх, гэрээ байгуулах зэрэг Компанийн тухай хууль болон энэ

СЗХ 2018.08.29

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE

дүрэмд зааснаар компанийг бүхий л харилцаанд итгэмжлэлгүйгээр төлөөлнө. Үүнд:

12.6.1. компанийн стратеги, үйл ажиллагааны чиглэлийн талаар санал, жил бүрийн бизнес төлөвлөгөөний төсөл боловсруулж, ТУЗ-ийн хуралд оруулж батлуулан хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна;

12.6.2. хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн захирлуудыг томилох саналыг ТУЗ-д оруулж батлуулан, тэдэнтэй компанийг төлөөлөн хөдөлмөрийн ба үр дүнгийн гэрээ байгуулна;

12.6.3. компанийн хөрөнгийг ТУЗ-өөс тогтоосон эрх хэмжээний хүрээнд захиран зарцуулна;

12.6.4. компанийн дотоод журмыг батална;

12.6.5. өөрийн эрх хэмжээний хүрээнд тушаал гаргана;

12.6.6. компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хүмүүстэй харилцаж, ТУЗ-ийн өгсөн чиглэлийн дагуу гэрээ, хэлэлцээр байгуулна;

12.6.7. компанийг төлөөлөх итгэмжлэл олгоно;

12.6.8. компанийн ажиллагсдын хөдөлмөрийн сахилга бат, хөдөлмөр хамгаалалтын дэг журмын хэрэгжилт, технологийн горимын хэрэгжилт болон аж ахуй санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгө зарцуулалт, ашиглалтад хяналт тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх;

12.6.9. Монгол Улсын хууль, тогтоомж болон ТУЗ-ийн тогтоолын биелэлтийг зохион байгуулна.

12.6.10. Компани, түүний бүтэц, зохион байгуулалтын талаар санал боловсруулж, ТУЗ-өөр батлуулан, ажлын байрны шаардлагыг тогтоон уг шаардлагад нийцсэн ажилтан, албан хаагчдын баг бүрдүүлэх;

12.6.11. компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна;

12.6.12. хувьцаа эзэмшигчдэд ТУЗ-ийн хурлын шийдвэр, компанийн санхүүгийн тайлантай танилцах боломжоор хангана;

12.6.13. компанийн улирал, жилийн үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн хуралд тайлан тавьж хэлэлцүүлнэ. Энэхүү тайланд тухайн хугацаад хийсэн гэрээ, хэлцлийн дотор компанийн аль нэг эрх бүхий албан тушаалтны хувьд сонирхлын зөрчилтэй хэлцэл байсан эсэх, байсан бол тухайн хэлцлийг Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлд заасан журмын дагуу хийсэн эсэх тухай асуудлыг тусгасан байна.

12.7. Компанийн ТУЗ нь гүйцэтгэх захирлыг албан тушаалаас нь хэдийд ч чөлөөлөх эрхтэй. Түүнийг чөлөөлсөн тохиолдолд шинээр гүйцэтгэх захирлыг сонгох хүртэл ТУЗ-өөс томилсон этгээд захирлын үүргийг түр гүйцэтгэнэ.

12.8. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхээр ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-ийн дарга болон гишүүнд гаргаж болно. Энэхүү саналыг гаргахдаа хэлэлцүүлэх асуудлын талаарх танилцуулга, гарах шийдвэрийн төсөл зэргийг хүргүүлнэ.

12.9. Даатгалын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан үндэслэл журмын дагуу Актуарчийг Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оруулж болно.

## Арван гурав. Компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн хариуцлага

13.1. Дараах этгээдүүд нь Компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно. Үүнд:

13.1.1. ТУЗ-ийн дарга, гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;

13.1.2. Гүйцэтгэх захирал;

13.1.3. Ерөнхий нягтлан бодогч;

13.2. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй. Үүнд:

МАНДАЛ ДААТГАЛ ХХК МАНДАЛ даатгал УЛААНБААТАР ХОТ 5473489

МОНГОЛ УЛС GOLOMT CAPITAL LLC ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК 5481589

13.2.1. Компанийн тухай хууль, энэхүү дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журамд заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтлах;

13.2.2. ТУЗ-ийн зөвшөөрснөөс бусад тохиолдолд компанийн нууцад хамрагдах мэдээ, тайлан, гэрээ, эрхийн холбогдолтой материалыг гуравдагч этгээдэд дамжуулах болон хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх;

13.2.3. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;

13.2.4. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;

13.2.5. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх;

13.2.6. Эрх бүхий албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарсанаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

13.3. Албан тушаалаас өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн хугацаанд энэ дүрмийн 13 дугаар зүйлийн 13.2.2 дахь хэсэгт заасан үүргийг хүлээнэ.

13.4. Албан тушаалтан энэ дүрмийн 13 дугаар зүйлийн 13.2 болон 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт заасан үүргээ хэрэгжүүлээгүй, удаа дараа зөрчсөн, мөн тэдгээрийн дор дурдсан үйлдэл, эс үйлдлийн улмаас компани, хувьцаа эзэмшигчид болон зээлдүүлэгчид бусад оролцогч талуудад хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр хариуцан барагдуулна.

13.4.1. Компанийн нэрийг хувийн сонирхлоор ашигласан;

13.4.2. Хувьцаа эзэмшигч, зээлдүүлэгч, бусад оролцогчдод хуурамч мэдээлэл өгсөн;

13.4.3. Эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх үүргээ биелүүлээгүй;

13.4.4. Компанийн тухай хуулийн 97 дугаар зүйлд заасан компанийн баримт бичгийг зохих журмын дагуу хадгалаагүй;

13.4.5. Компанийн тухай хуулийн 98 дугаар зүйлд заасан мэдээллийг хувьцаа эзэмшигчид гаргаж өгөөгүй, эсхүл хугацаа хоцруулан гаргаж өгснөөс хувьцаа эзэмшигчид учирсан хохирлыг нөхөн төлөхөөс гадна энэ шалтгаанаар компанид торгуулийн арга хэмжээ оногдуулсан бол энэхүү торгуулийг тухайн эрх бүхий албан тушаалтнаар төлүүлнэ.

13.5. Энэхүү Дүрмийн 13.1-т заасан эрх бүхий албан тушаалтнууд нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхдээ Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг баримтална.

13.6. Компанийн эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, компанийн дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

## Арван дөрөв. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, татвар, тайлан, аудит

14.1. Компанийн санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэж 12-р сарын 31-ний өдөр дуусна. Компанийг татан буулгах онд санхүүгийн жил нь 1-р сарын 1-ний өдөр эхлэж татан буулгасан өдөр дуусна.

14.2. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу ногдуулах аливаа татвар, төлбөрүүдийг зохих ёсоор төлнө. Татварыг дотоодын мөнгөн тэмдэгтээр төлнө.

14.3. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын татварыг улсын төсөвт төлсний дараа Компани өөрийн санхүүгийн байдлаас хамааран Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтоосон хэмжээгээр нөөцийн болон бусад санг байгуулж болно.

14.4. Санхүүгийн ба нягтлан бодох бүртгэлийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчим, стандартын дагуу хөтөлнө.

14.5. Компани нь хуулиар тогтоосон журмын дагуу нягтлан бодох бүртгэл хөтлөн санхүүгийн тайлан гаргаж, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржээс тогтоосон нэмэлт мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад зохих хугацаанд нь хүргүүлэн нийтэд мэдээлэх үүрэгтэй.

14.6. Компани нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг компанийн гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг ерөнхий нягтлан бодогч гүйцэтгэх захиралтай хамтран хариуцна.

14.7. Компани дор дурдсан бүртгэлийг заавал хөтлөх бөгөөд бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх, холбогдох бичиг баримтыг зохих журмын дагуу хадгалсан байх бөгөөд Гүйцэтгэх захирал хариуцна. Үүнд:

14.7.1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэр, хаяг, холбоо барих утас, цахим шуудангийн хаяг, эзэмшиж буй үнэт цаасны төрөл, тоо зэрэг мэдээллийг тусгана. Нийтэд санал болгон гаргасан үнэт цаасны бүртгэлийг үнэт цаасны хадгаламжийн байгууллагатай гэрээ байгуулан хөтлүүлнэ;

14.7.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын болон хурлын шийдвэр, хуралд зориулан хувьцаа эзэмшигчдэд тараасан материал, хувьцаа эзэмшигчдээс хурлаар хэлэлцэх асуудлын талаар ирүүлсэн саналын бүртгэл. Хурал, хурлын шийдвэрийн бүртгэлд хурал хийсэн байр, он,сар,өдөр, хурлын дарга, протокол хөтөлсөн этгээдийн овог, нэр, гишүүдийн ирц, хэлэлцсэн асуудал, шийдвэр; ТУЗ-ийн хурал, хурлын шийдвэрийн бүртгэл;

14.7.3. Компанийн дүрэм, түүнд орсон өөрчлөлтийн бүртгэл.

14.7.4. Компанийн болон эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэл;

14.7.5. Компанийн хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа этгээдийн бүртгэл;

14.7.6. Төрийн эрх бүхий хяналт, зохицуулалтын байгууллагад хүргүүлсэн мэдээ, тайлангийн бүртгэл;

14.7.7. Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ, гүйцэтгэх захирлаас баталсан компанийн засаглалын, хөдөлмөрийн, цалин урамшууллын, хөдөлмөр хамгааллын гэх мэт дотоод журам, зааврын бүртгэл;

14.7.8. Компанийн санхүүгийн тайланд болон ТУЗ, гүйцэтгэх захирал, эрх бүхий бусад этгээдийн хүсэлтээр хийсэн аудитын шалгалтын тайлангийн бүртгэл;

14.7.9. Компанийн бусадтай байгуулсан гэрээ, хэлцлийн бүртгэл;

14.7.10. ТУЗ болон гүйцэтгэх захирлын шийдвэрээр тогтоосон бусад бүртгэл.

14.8. Компани нь энэхүү дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэгт заасан бүртгэлтэй холбогдох үндсэн бичиг баримт болон дор заасан бичиг баримтыг хадгална:

14.8.1. Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлүүд, лиценз;

14.8.2. Компанийн өмчлөл болон эзэмшилд байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт;

14.8.3. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт;

14.8.4. Салбар төлөөлөгчийн газрын дүрэм;

14.8.5. Гүйцэтгэх удирдлагын хурлын тэмдэглэл, тушаал, шийдвэр;

14.8.6. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт.

14.9. Энэ дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.5 болон 14.6 дахь хэсэгт заасан бичиг баримтыг 5 (таван) жил хадгалаад архивд шилжүүлэх бөгөөд бусад Компанийн дүрэм, хүчин төгөлдөр гэрээ, тусгай зөвшөөрөл зэргийг хугацаагүйгээр хадгална.

14.10. Компани нь нягтлан бодох бүртгэлийн баримт бичгээ 6 (зургаан) жилээс доошгүй хугацаагаар хадгалах бөгөөд хадгалах газрын хаягийг Зохицуулах хороонд бичгээр мэдэгдэнэ.

14.11. Компани нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт болон даатгалын багц дүрэмд заасан, эсхүл Зохицуулах хорооноос тогтоосон нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, санхүүгийн тайлангийн агуулга, хэлбэрийг хангасан санхүүгийн тайланг улирал тутам, аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлнэ.

14.12. Санхүүгийн тайланд дараах үндсэн бүрдэл хэсгүүд орно. Үүнд:

14.12.1. Баланс;

14.12.2. Орлогын, үр дүнгийн тайлан;

14.12.3. мөнгөн гүйлгээний тайлан;

14.12.4. Хуримтлагдсан ашгийн тайлан;

14.12.5. Нэмэлт, тайлбар, тодруулга; Тухайн тайлангийн хугацаанд хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийн жагсаалт, нэр төрөл, үнийн дүнгийн хамт;

14.12.6. Эрх бүхий албан тушаалтанд олгосон цалин урамшууллын дүн, албан тушаалтан бүрээр нэрээр;

14.12.7. Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон нэмэлт мэдээлэл, тайлбар, тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан болон бусад зүйл.

14.13. Компани нь аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хугацаанд дараах баримт бичгийн хамт Санхүүгийн зохицуулах хороонд тушаана. Үүнд:

14.13.1. Удирдлагын тайлан;

14.13.2. Аудитын дүгнэлт;

14.13.3. Тухайн санхүүгийн жилд компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн үйл явдлын тухай тодруулга, тайлбар;

14.13.4. Даатгалын багц дүрэмд заасан бусад баримт бичиг.

14.14. Санхүүгийн тайланг гаргахад хэрэглэсэн хөрөнгийн үнэлгээ, элэгдэл тооцсон аргууд, орлогын зохицуулалт, хараат болон охин компаниудад оруулсан хөрөнгө оруулалт, оролцооны хувь хэмжээ, ногдол ашгийн бодлого, хуримталсан ашиг, үнэ ханшны хэлбэлзлийг тайланд хэрхэн тусгасан тухай болон хууль тогтоомжид заасан шаардлагатай бусад тайлбар, тодруулгыг заавал хийсэн байна.

14.15. Компани санхүүгийн тайлангаа шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаандаа бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор гэрээний үндсэн дээр аудиторыг томилон ажиллуулна.

14.16. Санхүүгийн тайланг компанийн ТУЗ-ийн зөвшөөрлөөр томилогдсон хөндлөнгийн аудитын байгууллагаар хянуулах бөгөөд ТУЗ санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хэлэлцүүлнэ.

14.17. Компани нь Монгол Улсын аль нэгэн болон хэд хэдэн банканд төгрөгийн болон валютын данс нээх эрхтэй бөгөөд шинээр данс нээлгэсэн, хаалгасан тухай бүр Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж байна. Компани нь гадаадын банканд валютын данс нээх бол энэ тухайгаа Монголбанк болон Татварын албанд албан ёсоор мэдэгдэнэ.

14.18. Компанийн ТУЗ нь санхүүгийн тайлан, түүнд хавсаргасан нэмэлт тайлбар тодруулга, тайлангийн талаарх аудитын болон ТУЗ-ийн дүгнэлтээс гадна дараах мэдээллийг тусгасан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичнэ:

14.18.1. компанийн бүтэц зохион байгуулалт түүнд гарсан өөрчлөлт;

14.18.2. тайлангийн хугацаанд компанийн эрхлэн явуулсан үйл ажиллагаа түүний талаарх танилцуулга, гарсан өөрчлөлт, үр дүн;

14.18.3. компанийн өмчлөл, эзэмшилд байгаа эдийн болон эдийн бус хөрөнгө, тусгай зөвшөөрөл зэргийн талаарх мэдээлэл, эдгээрт гарсан өөрчлөлт.

14.19. Гүйцэтгэх захирал нь энэхүү дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.10 дахь хэсэгт заасан мэдээлэлтэй танилцах боломжоор хувьцаа эзэмшигчдийг хангана.

14.20. Энэ бүлэгт дурдагдаагүй бусад асуудлыг Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Даатгалын тухай хуулиар зохицуулна.

## Арван тав. Ногдол ашиг

15.1. Компани нь ногдол ашгийн бодлоготой байх бөгөөд нийтэд ил тод байршуулна.

15.2. Ногдол ашгийн бодлогыг ТУЗ-өөс баталж мөрдөнө.

## Арван зургаа. Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд тавих хяналт

**Дотоод хяналт:**

16.1. Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

16.2. Компанийн өдөр тутмын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг гүйцэтгэх захирлын томилсон дотоод хяналтын алба хэрэгжүүлнэ.

16.3. Дотоод хяналтын алба нь компанийн үндсэн үйл ажиллагааны технологи, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр зохион байгуулалт, санхүү бүртгэл, эрх зүйн мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд ТУЗ-тэй зөвшилцөн гүйцэтгэх захирлын баталсан Дотоод хяналтын журмын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

16.4. Дотоод хяналтын албаны ажилтнууд нь компанийн ажилтан албан хаагчдын ажлын байранд хэзээ ч нэвтрэх, аливаа мэдээллийг шаардан гаргуулах эрхтэй байна.

16.5. Дор дурдсан этгээдийг дотоод хяналтын албанд ажиллуулахыг хориглоно:

16.5.1. эрх зүйн чадамжгүй;

16.5.2. урьд нь дампуурсан компанийн удирдлагад ажиллаж байсан;

16.5.3. компанийн эрх бүхий албан тушаалтны нэгдмэл сонирхолтой этгээд эсвэл ямар нэг шалтгаанаар тэдний нөлөөнд автах боломжтой/ найз нөхрийн болон өмнө хамт ажиллаж байсан зэргээр холбоо харилцаатай/;

16.5.4. толгой компани болон хараат буюу салбар компанид ажилладаг;

16.5.5. өмнө нь авлигын хэрэгт шийтгэгдэж байсан.

16.6. Дотоод хяналтын албанаас хийх шалгалт нь ээлжит болон тусгай гэсэн хэлбэртэй байна. Ээлжит шалгалтын хуваарийг өмнөх жилийн 12 дугаар сард албаны дарга боловсруулан гүйцэтгэх захирлаар батлуулж ажиллана. Харин ТУЗ болон гүйцэтгэх захирлын даалгавраар, тэдний баталсан удирдамжийн дагуу тодорхой асуудлаар хийх шалгалтыг тусгай шалгалт гэнэ.

16.7. Гүйцэтгэх захирлын зөвлөлийн хуралдаанаар дотоод хяналтын албаны Компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд тавих хяналтыг ТУЗ өөрийн аудитын хороогоор дамжуулан хэрэгжүүлнэ.

**Аудиторын /хөндлөнгийн/ хяналт**

СЗХ

16.8. Аудитын тухай Монгол Улсын хуульд заасны дагуу компани нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулж, ажиллуулна.

16.9. Санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийх аудитын шалгалт нь ээлжит ба ээлжит бус байна.

16.10. Компанийн жилийн санхүүгийн тайланд дүгнэлт өгөхийн тулд ээлжит шалгалт хийнэ.

16.11. Ээлжит бус шалгалтыг ТУЗ, түүний аудитын хорооны шийдвэр, компанийн энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч болон гүйцэтгэх захирлын саналаар хэдийд ч хийж болно.

16.12. Компанийн ТУЗ-ийн аудитын хороо аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална. Гэрээнд компанийн болон аудитын байгууллагын эрх үүрэг, хариуцлага, аудитын үйлчилгээний хөлсний хэмжээг заана. Аудитын дүгнэлтийн шинж чанараас хамааруулан аудитын хөлсний хэмжээг тогтоохыг хориглоно.

16.13. Аудитын ээлжит шалгалтын хөлсийг компани хариуцан төлөх бөгөөд ээлжит бус шалгалтыг түүнийг захиалж, гэрээ байгуулж хийлгэсэн хувьцаа эзэмшигч хариуцаж төлнө. Шалгалтын явцад компанийн эрх бүхий албан тушаалтан компанид хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд хариуцан төлнө.

16.14. Эрх бүхий албан тушаалтан аудиторын шаардлагаар компанийн санхүү-эдийн засгийн үйл ажиллагааны талаарх баримт бичгийг танилцуулах үүрэгтэй.

16.15. Аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд гаргасан дүгнэлтийнхээ талаар тайлбар өгөх үүрэгтэй оролцож болно.

16.16. Дараах этгээдийг компанийн аудитороор сонгон ажиллуулахыг хориглоно:

16.16.1. компанийн нэгдмэл сонирхолтой этгээд, компанийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд компанийн буюу нэгдмэл сонирхолтой компанийн хөлсний ажилтан, эрх бүхий албан тушаалтан бол;

16.16.2. компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн хувьцаа эзэмшигч, эсхүл компанийн болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох бусад эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг бол;

16.16.3. компанитай аудитаас бусад асуудлаар аливаа хэлцэл хийсэн этгээд бол;

16.16.4. Санхүүгийн зохицуулах хороонд бүртгэлгүй бол.

16.17. Аудитор нь дүгнэлтээ зөвхөн бичгээр гаргах бөгөөд дүгнэлтэд дараах асуудлыг заавал тусгасан байна:

16.17.1. компанийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт үнэн зөв эсэх;

16.17.2. нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалт зохих журмын дагуу хийгдсэн эсэх, зөрчил илэрсэн бол зөрчлийг тохиолдол тус бүрээр тодорхойлсон;

16.17.3. шалгалтын хугацаанд хийсэн сонирхлын зөрчилтэй хэлцлийн жагсаалт, эдгээр хэлцлийг КТХ-д заасан журмын дагуу хийсэн эсэх тухай дүгнэлт;

16.17.4. Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржээс тогтоосон бусад мэдээлэл;

16.17.5. ТУЗ-ин аудитын хорооны саналаар аудитын үйлчилгээ үзүүлэх гэрээнд заасан бусад асуудлын талаарх мэдээлэл, дүгнэлт.

**Арван долоо. Сонирхлын зөрчлийг зохицуулах**

Үнэт цаасны танилцуулга
2018.08.29

17.1. Компанийн үйл ажиллагаанд гарч болох компани түүний бизнесийн түншүүд /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч г.м/, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид зэргийн хооронд гарсан аливаа зөрчил маргаан, сонирхлын зөрчлийг хэлэлцэн тохирох замаар зохицуулах нь ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын анхаарлын төвд байх асуудал болно.

17.2. Аливаа зөрчил, маргаан үүссэн үед компанийн эрх зүйн хэлтэс /хуулийн зөвлөх/ шалтгааныг судалж, хэрхэн шийдвэрлэж болох тухай саналаа холбогдох дээд шатны удирдлагад танилцуулна.

17.3. Энэ дүрмийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан саналыг холбогдох удирдлага судалж үзээд зохих арга хэмжээ авах замаар зөрчлийг зохицуулах үүрэгтэй.

17.4. Зөрчил маргаан нь эрх бүхий албан тушаалтнуудын хооронд гарсан, эрх бүхий албан тушаалтан болон бусад оролцогч талуудын хооронд гарсан /зээлдүүлэгч, худалдан авагч, үйлчлүүлэгч, бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгч, ажилтнууд, хувьцаа эзэмшигчид, төрийн хяналт зохицуулалтын байгууллагууд, үйл ажиллагаа явуулж буй нутаг дэвсгэрийн захиргааны байгууллага, оршин суугчид г.м/ бол зөрчил маргааныг шийдвэрлэхэд тухайн сонирхлын зөрчилтэй эрх бүхий албан тушаалтан оролцохгүй.

17.5. Компани нь Компанийн тухай хуулийн арван хоёрдугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг хийхдээ дараах журмыг баримтална:

17.5.1. компанитай болон охин компанитай хийж буй аливаа хэлцэлд тухайн хэлцлийг хийх талаар шийдвэр гаргах, шийдвэр гаргахад оролцох эрх бүхий аль нэг албан тушаалтан оролцож байгаа /өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь хэлцлийн нөгөө тал болж байгаа, эсхүл хэлцэлд зуучлагч төлөөлөгч болж байгаа, эсхүл хэлцлээс шууд болон шууд бусаар орлого хүртэж байгаа бол оролцож байгаа гэж үзнэ/ бол тухайн албан тушаалтан энэ тухайгаа хэлцэл хийх шийдвэр гаргах үед гүйцэтгэх захиралд болон аудитийн хорооны даргад мэдэгдэнэ. Гүйцэтгэх захирал өөрөө хэлцэлд оролцогч этгээд бол ТУЗ-ийн даргад мэдэгдэнэ;

17.5.2. хэлцэл хийх шийдвэр гаргах болон хэлцэлтэй холбогдох үнэ тогтооход хэлцэлд оролцож буй эрх бүхий албан тушаалтан оролцож, санал өгөхгүй;

17.5.3. хэлцэл хийхэд оролцох этгээд гэдгээ мэдээгүй, сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компанид хохирол учруулсан бол эрх бүхий албан тушаалтан уг хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

17.5.4. Компанийн тухай хуулийн 92.3-т заасан тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ.

## Арван найм. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах

18.1. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

18.2. Компанийг дараах тохиолдолд татан буулгана. Үүнд:

18.2.1. Шүүхийн шийдвэрээр;

18.2.2. Санхүүгийн зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрсөн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр.

18.3. Энэ дүрмийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд даатгагчийг татан буулгасан шийдвэр хүчин төгөлдөр бус байна.

18.4. Компанийг татан буулгасан тохиолдолд Компанийн төлөх ёстой бүх өр төлбөрийг барагдуулсны дараа

18.5. Компанийг татан буулгахтай холбоотой бусад асуудлыг Даатгалын тухай хуулиар зохицуулна.

## Арван ес. Дүрэм хүчин төгөлдөр болох

19.1. Энэ дүрмийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцсон, энэ асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор баталж, Оюуны өм, улсын бүртгэлийн ерөнхий газрын, Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.

19.2. Энэхүү дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэх бөгөөд ийнхүү шийдвэрлэсэн нэмэлт өөрчлөлт нь энэхүү дүрмийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт заасан байгууллагад бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэ дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

--ooOoo--

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС

## 6.8 Ногдол ашгийн бодлогын төсөл

СЗХ 2018 .04.24 БҮРТГЭВ № 91

МАНДАЛ даатгал

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ..... он .... сар .... өдөр

# МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН НОГДОЛ АШГИЙН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.6. Энэхүү Ногдол ашгийн журам нь Мандал даатгал ХК /цаашид "Компани" гэх/-ийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах бодлогыг тодорхойлох үндсэн баримт бөгөөд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, энэ талаарх мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, хуваарилсан ногдол ашгийг тараах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.7. Энэхүү журам нь нийтэд ил тод байх бөгөөд компанийн вэб сайтад байршуулж болно.

**1.8.** Энэхүү журмыг Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ" гэх/-өөс ердийн журмын дагуу баталснаар хүчин төгөлдөр болох бөгөөд шинэчлэн батлах болон хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ.

### Хоёр. Ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах хэлбэр

2.1. ТУЗ нь хууль тогтоомж, Компанийн дүрмийг үйл ажиллагаандаа чанд баримтлан менежментийн оновчтой үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг эрмэлзэж ажиллах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж нэгж хувьцаанд ногдох өгөөж /EPS/ болон өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/-ийг хамгийн өндөр түвшинд барихыг урьтал болгон ажиллана.

2.2. Ногдол ашгийг Компанийн татвар төлсний дараах цэвэр ашгаас хуваарилах бөгөөд дараах нөхцөлүүд хангагдсан нөхцөлд хуваарилна. Үүнд:

2.2.1. Ашигтай ажилласан байх, ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байх;

2.2.2. Бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн хүртэх өгөөжийг өндөрсгөх зорилгоор ТУЗ-өөс боловсруулсан бизнесийн төсөл хөтөлбөр, арга хэмжээг тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх, холбогдох хөрөнгө оруулалт үлдсэн байх;

2.2.3. Компанийн ногдол ашгийн ойрын ба хэтийн бодлого, хуваарилалт нь ирээдүйд компанид хөрөнгө оруулалт татахуйц байх;

2.2.4. Ногдол ашиг төлсний дараа Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгалтын үнэ, хуульд заасан өөрийн хөрөнгийн доод хэмжээний нийлбэрээс их байх;

2.2.5. Хуваарилж буй ногдол ашгийн хэмжээ нь компанийн тухайн жилийн бодит боломжоос хэтэрхий дээгүүр, эсхүл хэтэрхий доогуур биш байх;

2.2.6. Компанийн төлбөрийн чадвар даатгалын тухай хууль тогтоомжид заасан шалгуур үзүүлэлтийг хангаж байх;

МАНДАЛ ДААТГАЛ ХХК МАНДАЛ даатгал УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС GOLOMT CAPITAL LLC ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

2.2.7. Даатгалын нөөц сан нь даатгалын тухай хууль тогтоомжид заасан хэмжээнд хүрэлцэж байх;

2.2.8. Компани эргүүлэн авах үүрэгтэй үнэт цаасаа бүрэн авсан байх.

2.3. Компани 1 /нэг/ төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна.

2.4. Ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хэлбэрээр хуваарилах бөгөөд бэлэн мөнгө болон эд хөрөнгө, эсхүл компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.

2.5. Ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигч бүрийн дансанд шилжүүлнэ.

**Гурав. Ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах**

6.1. Компани ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг ТУЗ гаргаж, энэ тухай хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна. ТУЗ нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

6.2. ТУЗ ногдол ашиг хуваарилахаар шийдсэн бол уг шийдвэрт хувьцаа бүрд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр болон ногдол ашиг төлөх өдөр, ногдол ашиг тараах хэлбэр, төрөл зэргийг заана.

6.3. ТУЗ-өөс ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журмыг хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байхаар тооцож шийдвэрлэнэ.

6.4. ТУЗ ногдол ашиг хуваарилах, тараахтай холбоотой гаргасан шийдвэрийн талаар хувьцаа эзэмшигч болон олон нийтэд 2-оос доошгүй сонин хэвлэлээр мэдэгдэх бөгөөд уг мэдээлэлд тухайн төрлийн нэгж хувьцаанд ногдуулан хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээ, ногдол ашгийг төлөх хугацаа, төлөх арга зам, ногдол ашгийн талаар лавлагаа авах утасны дугаар зэргийг тусгана. Компани нь өөрийн вэб сайтад энэ талаар мэдээллийг оруулсан байвал зохино.

6.5. ТУЗ-өөс ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнана.

6.6. ТУЗ нь Компанийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдөр буюу бүртгэлийн өдрийг тогтоох бөгөөд тус өдрөөр тасалбар болгож Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иас хувьцаа эзэмшигчдийн дэлгэрэнгүй хуулгыг гаргуулна.

6.7. Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь 25%-аас дээш хувиар багассан тохиолдолд компани нь ногдол ашгийг шилжүүлсэн өдрөөс хойш ажлын 15 /арван таван/ өдрийн дотор зээлдүүлэгчид өөрийн хөрөнгийн үлдэгдлийн хэмжээг бичгээр мэдэгдэнэ.

**6.8.** Ногдол ашгийг тодорхойлсон тооцооллыг тухайн жилд Гүйцэтгэх захирал санал болгосноор Төлөөлөн удирдах зөвлөл батална.

**Дөрөв. Ногдол ашиг хуваарилах, тайлагнах, мэдээлэл хүргүүлэх**

8.1. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгө, үнэт цаас хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

8.2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан үед төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө.

8.3. Ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн бол энэ тухай үндэслэлээ тухайн жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, хэрэв хуваарилан олгохоор шийдвэрлэсэн бол уг ногдол ашгийн тайланг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хуралд тайлагнана.

8.4. Ногдол ашиг хуваарилалтын тайланг тогтоосон журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-д хүргүүлнэ.

8.5. Компани ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 /арван тав/ өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

8.6. Ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчийн ногдол ашгийг түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд компани хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

8.7. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

**8.8.** ТУЗ нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн талаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх үүрэгтэй бөгөөд ногдол ашиг тараах тухай мэдээллийг компанийн вэб сайтад байршуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу олон нийтэд мэдээлнэ.

**Тав. Бусад**

5.1. Ногдол ашгийг ТУЗ-ийн шийдвэрт заасан хугацаанд багтааж хуваарилах бөгөөд хугацаанд нь төлөөгүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

5.2. ТУЗ-ийн тогтоосон хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл тухайн компани ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

5.3. ТУЗ нь энэхүү журамд тусгагдаагүй аливаа асуудлыг Даатгалын тухай хууль, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм, зохицуулах байгууллагаас баталсан мөрдвөл зохих бусад хэм хэмжээ тогтоосон актад зааснаар шийдвэрлэнэ.

--ooOoo--

## 6.9. 2017 оны Аудитын тайлан

**"УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ" ХХК**

*Грант Торнтон Интернэйшнлийн гишүүн*

Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, ЮНЕСКО-ийн гудамж,
Далай тауэр, 9-р давхар Улаанбаатар хот, Монгол улс
Утас: 70110799, 70110744, Факс: 976-70110722
И-мэйл: info@mn.gt.com
Вэб: www.grantthorton.mn
Шуудан: "Монгол шуудан" ХК

огноо 2018.03.23 № 178

**"МАНДАЛ ДААТГАЛ" ХХК-ИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ НАРТ**

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**

Бид "Мандал даатгал" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, "Мандал даатгал" ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдсан "*Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар*"-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

### *Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

### *Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Компаний удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### *Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн ул иттэх хандлагыг баримтлан ажилладаг

*Аудитын тайлангийн хэрэглээ*

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн Компанийн хувь нийлүүлэгчид болон хөрөнгө оруулагч нарт зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

..........................................

**Б.ОСОРГАРАВ**
**УДИРДАХ ПАРТНЕР**
Монгол улс, Улаанбаатар хот
2018 оны 3 дугаар сарын 23

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
Огноо: 2018/04/16

# Санхүүгийн тайлан ба Хараат бус аудиторын тайлан

## "Мандал даатгал" XXK

2017 оны 12 дугаар сарын 31

ЗАХИРЛУУДЫН БОЛОН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

"Мандал Даатгал" ХХК-ийн ТУЗ-ийн дарга Өлзийбаярын Ганзориг, Компанийн гүйцэтгэх захирал Батсайханы Жавхлан болон Ерөнхий нягтлан бодогч Ганбаатарын Баярцэцэг бид энэхүү тайлангийн 1-27 дугаар хуудсанд үзүүлсэн компанийн санхүүгийн тайлангууд нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх компанийн санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

| | | |
|---|---|---|
| Ө.ГАНЗОРИГ | Б.ЖАВХЛАН | Г. БАЯРЦЭЦЭГ |
| ТУЗ-ийн дарга | Гүйцэтгэх захирал | Ерөнхий нягтлан бодогч |
| Огноо: 2018.03.23 | Огноо: 2018.03.23 | Огноо: 2018.03.23 |



Огноо: 2018/04/16

“МАНДАЛ ДААТГАЛ” ХХК

## КОМПАНИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

| | | |
|---|---|---|
| **КОМПАНИЙН НЭР:** | Монгол | "Мандал даатгал" ХХК |
| **ТУЗ-ИЙН ГИШҮҮД:** | Дарга | Ө.Ганзориг |
| | Гишүүн | Н.Монсор<br>О.Ганжолоо<br>Л.Болормаа |
| | Хараат бус гишүүн | Джим Двейр |
| **УДИРДЛАГЫН БАГ:** | Гүйцэтгэх захирал | Б.Жавхлан |
| | Ерөнхийлөгч | М.Баярбахдал |
| | Байгууллагын даатгал хариуцсан дэд ерөнхийлөгч | Ж.Гарваа |
| | Иргэдийн даатгал хариуцсан дэд ерөнхийлөгч | Д.Нямрагчаа |
| **КОМПАНИЙН ХАЯГ:** | Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Нарны зам 87, НСКБ барилга, 4 давхар<br>Утас 7011-7017 | |
| **РЕГИСТРИЙН ДУГААР:** | 5473489 | |
| **ҮЙЛ АЖИЛЛАГАА:** | Ердийн даатгалын үйл ажиллагаа | |
| **АЖИЛЛАГСАДЫН ТОО:** | 100 | |
| **АУДИТОР:** | "Улаанбаатар аудит корпораци" ХХК,<br>Аудит, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн зөвлөгөө, сургалт, үнэлгээний итгэмжлэгдсэн байгууллага<br>Далай тауэр, ЮНЕСКО-гийн гудамж, Сүхбаатар дүүрэг-1, Улаанбаатар 14230, Монгол улс<br>Т + 976 70 110744<br>Ф + 976 70 110722<br>Website: www.grantthornton.mn,<br>E-mail: info@mn.gt.com | |

Үнэт цаасны тананилцуулга
2018-08-28
МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ 5473489
МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

# Агуулга


| | |
|---|---|
| Хараат бус аудиторын дүгнэлт | 1 |
| Санхүүгийн байдлын тайлан | 4 |
| Орлогын дэлгэрэнгүй тайлан | 5 |
| Өмчийн өөрчлөлтийн тайлан | 7 |
| Мөнгөн гүйлгээний тайлан | 8 |
| Санхүүгийн тайлангийн тодруулгууд | 9 |




Огноо: 2018/04/16

ХХ
Үнэт цаасны танилцуулга
2018.08.23

МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ 01

**"УЛААНБААТАР АУДИТ КОРПОРАЦИ" ХХК**
Хараат бус аудит, баталгаажуулалт, татварын болон зөвлөх үйлчилгээний
Грант Торнтон Интернэйшнлийн Монгол улс дахь гишүүн

# Хараат бус аудиторын дүгнэлт

**"Улаанбаатар аудит корпораци" ХХК**
Далай тауэр, ЮНЕСКО-гийн гудамж, Сүхбаатар дүүрэг-1,
Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 976 70 110744
Ф + 976 70 110722

**Ulaanbaatar audit corporation LLC**
Dalai Tower, UNESCO street,
Sukhbaatar District-1,
Ulaanbaatar 14230, Mongolia
T + 976 70 110744
F + 976 70 110722

"Мандал даатгал" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

## *Дүгнэлт*

Бид "Мандал даатгал" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлан (цаашид "санхүүгийн тайлан" гэх)-д аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, "Мандал даатгал" ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн 2015 оны 11 дүгээр сарын 6-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдсан "*Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар*"-ын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

## *Дүгнэлтийн үндэслэл*

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, тохиромжтой гэж итгэж байна.

## *Бусад асуудал*

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь Компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
5473489



МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

*Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага*

Компаний удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

*Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуух аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Үнэт цаасны танилцуулга
2018.08.29

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ U1
.... он .... сар .... өдөр

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

### *Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар*

Монгол улсад даатгалын үйл ажиллагааг зохицуулах үндсэн хууль тогтоомж нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, СЗХ-ны тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрэм, журмууд байна.

Компани нь 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдаж, 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн даатгалын байгууллагууд дагаж мөрдөх үүрэгтэй "Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар"-ыг баримталж санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

### *Төлбөрийн чадварын талаар*

Компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа 109.82% (2016: 101.27%) байгаа нь Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журмын 3.12-д заасан "Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино" гэсний дагуу зохистой байна.

### *Аудитын тайлангийн хэрэглээ*

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

**Б.ОСОРГАРАВ**
**УДИРДАХ ПАРТНЕР**
Монгол улс, Улаанбаатар хот
2018 оны 3 дугаар сарын 23

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ



МОНГОЛ УЛС
ГОНОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

# Санхүүгийн байдлын тайлан

| Мянган төгрөгөөр | Тодруулга | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|---|
| Хөрөнгө | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 4 | 1,805,207 | 3,719,555 |
| Даатгалын авлага | 5 | 4,402,449 | 3,350,298 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 6 | 401,174 | 445,097 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгө | 7 | 182,385 | 189,857 |
| Хөрөнгө оруулалт | 8 | 9,229,438 | 3,257,706 |
| Даатгалын хөрөнгө | 9 | 4,868,576 | 5,711,215 |
| Үндсэн хөрөнгө | 10 | 288,956 | 293,718 |
| Биет бус хөрөнгө | 11 | 57,325 | 105,343 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 12 | 236,640 | 236,640 |
| | | 21,472,150 | 17,309,430 |
| *Өр төлбөр ба эзэмшигчийн өмч* | | | |
| Өр төлбөр | | | |
| Даатгалын өглөг | 13 | 2,055,456 | 2,037,198 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 14 | 1,138,865 | 677,000 |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөц | 15 | 9,366,278 | 7,473,062 |
| Нөхөн төлбөрийн нөөц сан | 16 | 2,910,659 | 2,223,803 |
| | | 15,471,258 | 12,411,063 |
| *Эздийн өмч* | 17 | | |
| Хувьцаат капитал | | 6,243,016 | 6,243,016 |
| Халаасны хувьцаа | | (1,243,016) | (1,243,016) |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | | 1,000,892 | (101,634) |
| | | 6,000,892 | 4,898,366 |
| Нийт өмч ба өр төлбөр | | 21,472,150 | 17,309,430 |

Уг санхүүгийн тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-д батлав:

Б.Жавхлан
Гүйцэтгэх захирал

Г.Баярцэцэг
Ерөнхий нягтлан бодогч

Энэхүү санхүү байдлын тайланг 9-өөс 27 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.



Үнэт цаасны танилцуулга 2018.08.29
МАНДАЛ ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС ... CAPITAL LLC 171
Огноо: 2018/04/16

Үнэт цаасны танилцуулга
2018 .08. 29

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

# Орлогын дэлгэрэнгүй тайлан

| Мөр | Мянган төгрөгөөр | Тодруулга | 2017 оны 12 сарын 31-нээр дууссан болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дууссан болсон |
|---|---|---|---|---|
| 1 | Даатгалын хураамжийн нийт орлого | 18 | 22,533,093 | 13,092,831 |
| 2 | Даатгалын хураамжийн буцаалт | 18 | (1,207,753) | (973,051) |
| 3 | Давхар даатгалын хураамжийн зардал | 18 | (11,243,874) | (7,418,632) |
| 4 | Даатгалын хураамжийн цэвэр орлого (1+2+3) | | 10,081,466 | 4,701,148 |
| 5 | Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт | 18 | (1,893,215) | (5,254,992) |
| 6 | Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт | 18 | (1,145,087) | 4,770,843 |
| 7 | Орлогод тооцсон хураамж (4+5+6) | | 7,043,164 | 4,216,999 |
| 8 | Нийт нөхөн төлбөрийн зардал | 18 | (4,705,634) | (4,116,181) |
| 9 | Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр | 18 | 2,533,555 | 2,114,675 |
| 10 | Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр | 18 | 97,611 | 110,774 |
| 11 | Нөхөн төлбөрийн цэвэр зардал (8+9+10) | | (2,074,468) | (1,890,732) |
| 12 | Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт | 18 | (444,324) | (238,650) |
| 13 | Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт | 18 | 379,999 | 334,629 |
| 14 | Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт | 18 | (242,532) | (235,694) |
| 15 | Зардалд тооцсон нөхөн төлбөр (11+12+13+14) | | (2,381,325) | (2,030,447) |
| 16 | Даатгалын гэрээний зардал | 19 | (1,203,701) | (1,121,118) |
| 17 | Давхар даатгалын шимтгэлийн орлого | 20 | 925,392 | 1,270,895 |
| 18 | Хөрөнгө оруулалтын орлого | 21 | 1,226,959 | 993,979 |
| 19 | Даатгалын үйл ажиллагааны ашиг (7+15+16+17+18) | | 5,610,489 | 3,330,308 |
| 20 | Хүү, эрхийн шимтгэлийн орлого | | 28,145 | 22,858 |
| 21 | Бусад орлого | | 62,809 | 26,525 |
| 22 | Ерөнхий ба удирдлагын зардал | 22 | (3,522,843) | (2,685,868) |
| 23 | Борлуулалт, маркетингийн зардал | 23 | (517,291) | (456,125) |
| 24 | Бусад зардал | 24 | (416,597) | (5,410) |
| 25 | Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | | 28,366 | (61,748) |

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК




Огноо: 2018/04/16

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
...6007 5473489

Үнэт цаасны хаянии улга 2018.08.29

МАНДАЛ даатгал БҮРТГЭВ 01

| Мөр | Мянган төгрөгөөр | Тодруулга | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|---|---|
| 26 | Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны гарз | | (8,004) | - |
| 27 | Бусад алдагдал (20+21+22+23+24+25+26) | | (4,345,415) | (3,159,768) |
| 28 | Татвар төлөхийн өмнөх ашиг (19+27) | | 1,265,074 | 170,540 |
| 29 | Орлогын татварын зардал | 25 | (162,548) | (85,291) |
| 30 | Татварын дараах ашиг (28+29) | | 1,102,526 | 85,249 |

Энэхүү орлогын дэлгэрэнгүй тайланг 9-өөс 27 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473469

МОНГОЛ УЛС



GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК



Огноо: 2018/04/16

нэт цаасны танилцуулга
2018 .08. 29 В

МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ
01

# Өмчийн өөрчлөлтийн тайлан

| Мянган төгрөгөөр | Хувьцаат капитал | Халаасны хувьцаа | Хуримтлагдсан ашиг/(алдагдал) | Нийт |
|---|---|---|---|---|
| 2016.01.01-ний байдлаар | 6,243,016 | (1,243,016) | (186,882) | 4,813,118 |
| Тайлант жилийн ашиг | - | - | 85,249 | 85,249 |
| 2016.12.31-ний байдлаар | 6,243,016 | (1,243,016) | (101,634) | 4,898,366 |
| Тайлант жилийн ашиг | - | - | 1,102,526 | 1,102,526 |
| 2017.12.31-ний байдлаар | 6,243,016 | (1,243,016) | 1,000,892 | 6,000,892 |

Энэхүү өмчийн өөрчлөлтийн тайланг 9-өөс 27 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
5473489



МОНГОЛ УЛС

Үнэт цаасны танилцуулга
2018.08.29

# Мөнгөн гүйлгээний тайлан

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| *Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ* | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | 19,195,234 | 10,844,304 |
| Даатгалын хураамжийн орлого | 19,064,203 | 10,219,248 |
| Давхар даатгалын нөхөн төлбөр | 65,639 | 106,429 |
| Бусад мөнгөн орлого | 65,392 | 518,627 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | (17,836,513) | (11,236,690) |
| Ажиллагчдад төлсөн | (1,443,129) | (1,399,435) |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | (366,876) | (342,800) |
| Бараа материал худалдан авахад төлсөн | (15,928) | (27,744) |
| Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж | (9,586,830) | (2,483,454) |
| Нөхөн төлбөрт төлсөн | (3,955,258) | (3,977,052) |
| Үүнээс: Сайн дурын даатгалын | (2,496,256) | (2,918,768) |
| Албан журмын даатгалын | (1,459,002) | (1,058,284) |
| Даатгалын төлөөлөгчийн шимтгэл | (80,567) | (76,565) |
| Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр | (426,213) | (571,491) |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн | (79,496) | (75,622) |
| Татварын байгууллагад төлсөн | (263,286) | (263,211) |
| Даатгалын төлбөрт төлсөн | (955) | - |
| Бусад мөнгөн зарлага | (1,617,975) | (2,019,316) |
| *Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн* | 1,358,721 | (392,386) |
| *Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ* | | |
| Мөнгөн орлогын дүн (+) | 4,820,884 | 4,110,080 |
| Хөрөнгө оруулалт борлуулсны орлого | 4,229,569 | 3,112,005 |
| Хүлээн авсан хүүний орлого | 591,315 | 998,075 |
| Мөнгөн зарлагын дүн (-) | (8,093,954) | (1,963,847) |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | (54,425) | (13,847) |
| Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн | (8,039,530) | (1,950,000) |
| *Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн* | (3,273,070) | 2,146,234 |
| Бүх цэвэр мөнгөн гүйлгээ | (1,914,349) | 1,753,847 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3,719,555 | 1,965,708 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 1,805,206 | 3,719,555 |

Энэхүү мөнгөн гүйлгээний тайланг 9-өөс 27 дугаар хуудсан дах тодруулгуудын хамт унших бөгөөд тодруулгууд нь санхүүгийн тайлангийн нэг хэсгийг бүрдүүлнэ.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
Монгол улс
"Мандал даатгал" ХХК Санхүүгийн тайлан 2017 оны 12 сарын 31

175
Огноо: 2018/04/16

Үнэт цаасны танилцуулга
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
01

# Санхүүгийн тайлангийн тодруулгууд

## 1 Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

Компани нь 2011 оны 4 дүгээр сарын 26-нд "Мандал Женерал" ХХК нэртэйгээр Монгол улсад үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн 146 дугаар тогтоолоор "Ердийн даатгалын үйл ажиллагаа" эрхлэх тусгай зөвшөөрлийг авсны дараа албан ёсны нэрээ "Мандал Женерал Даатгал" ХХК болгон өөрчилж, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх болсон байна. 2017 оны 1 дүгээр сарын 27-ны өдөр "Мандал даатгал" ХХК гэж нэрээ өөрчилсөн.

Компанийн хувьцааны 51%-ийг "Голомт Файнэншил Групп" ХХК, 49%-ийг "Юу Эм Си Капитал" ХХК тус тус эзэмшиж байна (тодруулга 31.1-с дэлгэрэнгүй харна уу).

"Голомт Файнэншил Групп" ХХК нь 2014 онд үүсгэн байгуулагдсан санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг хөрөнгө оруулалтын компани юм. Ноён Д.Баясгалан нь тус группийн ихэнх хувийг эзэмшдэг бөгөөд "Мандал даатгал" ХХК-д хамгийн дээд хяналт тавигч хувь хүн юм.

Үйл ажиллагааны чиглэл: Ердийн даатгалын үйл ажиллагааны хүрээнд Гэнэтийн осол, эмчилгээний зардлын, Хөрөнгийн, Авто тээврийн хэрэгслийн, Барилга угсралтын, Ачааны, Агаарын хөлгийн, Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын, Жолоочийн хариуцлагын албан журмын, Газар тариалангийн, Мал амьтдын, Хариуцлагын, Санхүүгийн, Зээлийн, Итгэлцлийн, Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн, Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын, Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын зэрэг даатгалын төрөл байна.

Компанийн хүний нөөц: Компанийн ажилтнуудын дундаж тоо 2017 оны туршид 100 орчим байна.

Бүртгэгдсэн хаяг: Компани нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Нарны зам 87, НСКБ барилга, 4 давхарт байрлан үйл ажиллагаагаа явуулж байна.

Компани одоогоор 17 хэлбэрийн даатгалын үйл ажиллагаа эрхлэн, 3 салбартайгаар ажиллаж байна.

## 2 Санхүүгийн тайлан бэлтгэх суурь

### 2.1 Үндсэн зарчим

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт ("СТОУС")-д нийцүүлэн 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдсан "*Нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар*"-ын дагуу бэлтгэв.

### 2.2 Хэмжилтийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн тодорхой санхүүгийн хэрэглүүрээс бусдаар түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

### 2.3 Үйл ажиллагааны ба толилуулгын валют

Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөг нь Компанийн үндсэн үйл ажиллагаа болон ажил гүйлгээний эдийн засгийн бодит байдлыг хамгийн тохиромжтой илэрхийлж байгаа учраас төгрөг нь уг Компанийн үйл ажиллагааны валют юм.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК



176
Огноо: 2018/04/16

СЭХ
Үнэт цаасны зах зээлийн
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ
..... он .... сар .... өдөр

Санхүүгийн тайлангуудын хэрэглэгчдэд хамгийн тохиромжтой гэж удирдлага үзэж байгаа учраас эдгээр санхүүгийн тайлангуудыг (өөрөөр заагаагүй бол) Монгол төгрөгөөр толилуулна. Монгол төгрөгөөр илэрхийлсэн санхүүгийн бүх мэдээлэл мянган төгрөгөөр бүхэлтгэн илэрхийлэгдсэн.

### 2.4 Тооцоолол ба үнэлэмжийн хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн бэлтгэх үйл явц нь удирдлагаас санхүүгийн тайлангийн өдрөөр тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн дүн болон тайлант хугацааны орлого, зарлагын тайлагнасан дүнд нөлөөлөх чухал таамаглал тооцоолол хийхийг шаарддаг.

Эдгээр тооцоолол нь тухайн үйл явдал, үйл ажиллагааны талаарх удирдлагын хамгийн сайн мэдлэг дээр суурилсан байдаг боловч, бодит үр дүн нь эцсийн дүндээ эдгээр тооцооллоос өөр байж болох бөгөөд анхны тооцоолол, түүний таамаглалыг тухайн нөхцөл байдал, тухайн жилд нь тохируулан өөрчлөж болно.

*Даатгалын нөөц сангийн тооцоолол*

Компанийн актуарч нь Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан Ердийн даатгалын нөөц сан бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмын дагуу даатгалын хураамжийн нөөц болон даатгалын нөхөмжлөлийн нөөц сангуудыг тооцоолдог.

Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийг (ОТХН) даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа даатгалын гэрээ бүрийн хувьд "хувь тэнцүүлсэн арга"-аар буюу тайлагналын өдрөөр даатгалын гэрээний хүчинтэй үлдэх хугацаанд хувь тэнцүүлэн тооцсон даатгалын хураамжийн хэсгүүдийн нийлбэрээр тодорхойлдог.

Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг (УБМХНС) даатгагч даатгалын хэлбэр тус бүрээр үнэн зөв бөгөөд бодитой статистикт тулгуурлан актуар аргачлалаар тооцоолсон даатгагчийн хамгийн сайн төсөөлөлд үндэслэн тооцно. Тухайн нөөцийг тайлант хугацааны эцсийн байдлаар учирсан боловч мэдэгдээгүй байгаа хохиролд зориулан байгуулна.

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санд (МБТХНС) тайлангийн хугацаанд даатгуулагч эсхүл даатгалын гэрээнд заагдсан холбогдох бусад этгээдээс даатгагчид тухайн гэрээнд заасан аливаа хэлбэрээр /бичгээр, утсаар, и мэйлээр болон бусад/ мэдэгдсэн даатгалын тохиолдлоос үүсэх даатгагчийн урьдчилан тооцоолсон хариуцлагын хэмжээ болон тайлангийн хугацаанд төлөгдөөгүй үлдсэн нөхөмжлөлийн хэмжээ хамаарна.

Учирч болзошгүй хохирлын нөөц санг (УБХНС) даатгагчийн хүчин төгөлдөр даатгалын гэрээнүүдийн хувьд өмнөх тайлант хугацааны эцэс дэх учирч болох хохирол болон үйл ажиллагааны зардлын нийлбэр нь орлогод тооцоогүй хураамжийн нөөцөөс давсан тохиолдолд тухайн нэмэгдэл хариуцлагын хэмжээгээр тооцно.

## 3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

### 3.1 Гадаад валют

***Гадаад валютаарх ажил гүйлгээ***

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайлант хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2017 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн 1 ам.доллартай харьцах ханш 2,427.13 төгрөг (2016 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 2,489.53 төгрөг). Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүний олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489



МОНГОЛ УЛС
CAPITAL LLC
КАПИТАЛ ҮЦК ХХК
177
Огноо: 2018/04/16

СЗХ
2018 он 08 сар 29 өдөр
Үнэт цаасны танилцуулга
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлгээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана.

## 3.2 Даатгалын хөрөнгө

Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийг тайлагналын өдөр УБМХНС болон МБТХНС-ийн тайлант хугацаанд давхар даатгагчид ногдох хэсгийг актуарчийн тооцоолсон дүнгээр бүртгэдэг.

Давхар даатгалын хойшлогдсон хураамж нь давхар даатгалын хураамжийн давхар даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байгаа хэсэг байдаг.

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн үлдэгдлийг давхар даатгалын хариуцлага эхэлсэн бөгөөд тайлагналын өдрөөр давхар даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа давхар даатгалын гэрээ тус бүрийн хувьд гэрээний үлдэх хугацаанд хувь тэнцүүлэх аргаар тооцдог.

Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал нь даатгалын гэрээг олж бэлтгэхтэй холбогдон гарсан зардлын тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг байдаг.

Тухайлбал зуучлагч болон төлөөлөгчийн даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал, даатгалын хураамжийн дүнтэй хамааралтай гарсан даатгалын гэрээний хойшлогдсон бусад зардлаас бүрддэг.

## 3.3 Даатгалын бүтээгдэхүүн

Компани нь ердийн даатгалын бүх нийтлэг хэлбэрийг хамарсан даатгалын бүтээгдэхүүнүүд санал болгодог. Компанийн үндсэн бүтээгдэхүүний хэлбэрүүд нь:

- Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал,
- Хөрөнгийн даатгал,
- Барилга угсралтын даатгал,
- Ачааны даатгал,
- Тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн хариуцлагын даатгал,
- Хариуцлагын даатгал,
- Санхүүгийн даатгал,
- Зээлийн даатгал гэх мэт байна.

## 3.4 Нөөц сан

Нөөц сан нь *Орлогод тооцоогүй хураамжийн нөөц* (ОТХН), *Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан* (УБМХНС), *Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан* (МБТХНС), *Учирч болзошгүй хохирлын нөөц сан* (УБХНС)-уудаас бүрдэнэ.

ОТХН-д даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй байгаа даатгалын хураамжийн хэсэг ордог.

УБМХНС-г тайлагналын өдөр болон түүнээс өмнөх хугацаанд даатгалын тохиолдол нь болсон боловч даатгагчид мэдэгдээгүй байгаа даатгалын нөхөн төлбөрийг барагдуулахад шаардагдах дүнгээр хэмждэг.

УБХНС-г тайлангийн хугацаанд даатгалын нөхөн төлбөрийн бодит түвшин нь тооцоолсон нөхөн төлбөрөөс давсан тохиолдолд тухайн хэсгийг нөхөн төлөхөд зориулсан нөөц сангаар хэмждэг.

## 3.5 Үндсэн хөрөнгө

Ажил үйлчилгээний зорилгоор ашиглаж буй машин, тоног төхөөрөмж, компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил зэрэг хөрөнгүүдийг санхүүгийн тайланд дараа үеийн хуримтлагдсан элэгдэл болон хорогдуулгыг хассан дүнгээр тайлагнана.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489



МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ХХК
1117235573 5481589
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаасны танилцуулга
2018.08.29
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ
.... он .... сар .... өдөр
01

Үндсэн хөрөнгийн данснаас хассан, ашиглалтаас гаргаснаас үүссэн олз, гарзыг тухайн хөрөнгийн борлуулалт болон дансны үнийн зөрүүгээр тодорхойлох ба олз, гарзыг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Тусад нь бүртгэсэн үндсэн хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийг солих зардлыг уг данснаас хассан бүрэлдэхүүн хэсгийн дансны үнээр капиталжуулна. Бусад дараа үеийн зардал ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөхөөр бол капиталжуулна. Засвар үйлчилгээ гэх мэт бусад бүх зардлыг үүссэн дүнгээр нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхлэнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

| | |
|---|---|
| Автомашин | - 10 жил |
| Тавилга, эд хогшил | - 10 жил |
| Компьютер, дагалдах хэрэгсэл | - 3 жил |
| Бусад | - 10 жил |

## 3.6 Биет бус хөрөнгө

Компани худалдан авсан хязгаарлагдмал ашиглах хугацаатай биет бус хөрөнгийг өртгөөс хуримтлагдсан хорогдлыг хассан дүнгээр тайлагнана.

Хорогдлыг биет бус хөрөнгийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгах ба биет бус хөрөнгийн ашиглах хугацаа 3 жил байна.

## 3.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

Түрээсийн орлого олох болон капиталын үнийг өсгөх зорилгоор эзэмшиж буй хөрөнгө буюу хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг тээврийн зардлыг багтаасан өртгөөр анх хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсний дараа бодит үнэ цэнээр хэмждэг.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг тухайн үүссэн үеийн ашиг алдагдалд хамруулна.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөс олсон түрээсийн орлого болон үйл ажиллагааны зардлыг орлого, бусад зардлаар тус тус бүртгэнэ.

## 3.8 Санхүүгийн хэрэглүүр

*Хүлээн зөвшөөрөлт, анхдагч хэмжилт ба үл хүлээн зөвшөөрөлт*

Компани тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний заалтуудын нэг хэсэг болсон үед санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгө ба бүх бодит эрсдэл, шагнал шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийг барагдуулсан, чөлөөлсөн, хүчингүй болгосон эсвэл хугацаа дууссан үед нь үл хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр анхлан хэмжсэн бөгөөд ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр илэрхийлснээс бусад санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийг анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний өртгийг нэмсэн дүнгээр хэмжинэ.

*Санхүүгийн хөрөнгийн ангилал ба дараа үеийн хэмжилт*

Дараа үеийн хэмжилтийн зорилгоор хейджийн хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгө анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр дараах категорит хуваагдана.

- Зээл ба авлага

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
"Мандал даатгал" ХХК
Санхүүгийн тайлан
2017 оны 12 сарын 31 12
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК
1117236573 5481589

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
он сар өдөр
2018 ... 19 В

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

- Ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
- Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө
- Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгүүд хэрэглүүрийн шинж чанар, зорилгоос шалтгаалан анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр өөр өөр категорит ордог. Санхүүгийн хэрэглүүрийн категори нь түүний хэмжилт, санхүүгийн хэрэглүүрийн үр дүнд бий болсон орлого, зарлагыг ашиг, алдагдлаар эсвэл шууд бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх эсэхэд чухал хамааралтай.

*i. Зээл ба авлага*

Зээл болон авлага нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй дериватив бус санхүүгийн хөрөнгө юм. Зээл, авлагад дансны ба бусад авлага, гар дээрх бэлэн мөнгө болон банкин дах мөнгө багтана.

*Дансны ба бусад авлага*

Эргэлтийн дансны авлагыг бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Харин дараа үед хорогдсон өртгөөс үнэ цэнийн бууралтын нөөцийг хассан дүнгээр хэмжинэ. Зээлдэгчид учирсан санхүүгийн томоохон бэрхшээл, гэрээ үл биелүүлэх болон төлөлт удаашрах зэрэг нь уг дансны авлагын үнэ цэнэ буурсныг илтгэнэ.

Цуглуулах боломжгүй гэж үзсэн бүх дансны авлагыг данснаас хасна.

*Даатгалын авлага*

Даатгалын авлага нь даатгалын бүтээгдэхүүн борлуулсан, үйлчилгээ үзүүлснээс үүссэн бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн нэхэмжлэх дүн байна.

Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 306/307 тоот тушаалаар батлагдсан даатгалын компанид мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн зааврын *3.2 Даатгалын авлага* хэсэгт "*Үнэ цэнийн бууралтыг тооцох СТОУС-д нийцэх аргачлалыг компани дотоoддоо боловсруулж, мөрдөж болно*" гэж заасны дагуу авлагын шууд аргыг ашигладаг. Өөрөөр хэлбэл авлага төлөгдөх найдваргүй гэдэг нь тогтоогдсон үед авлагыг данснаас хасдаг.

*Бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл*

Компанийн бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл нь гар дээрх бэлэн мөнгө, банкин дах дансад болон замд яваа бэлэн мөнгөөс бүрдэнэ.

*ii. Ашиг, алдагдын дараах бодит үнэ цэнээр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө*

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгийг худалдах зорилгоор эзэмшиж буй эсвэл анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг ашиг алдагдлаар тусгадаг гэж ангилна. Уг тодорхойлолтын дагуу хейджийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй бүх дериватив санхүүгийн хэрэглүүр энэ категорит багтана.

Дериватив санхүүгийн хэрэглүүрээс үүсч буй аливаа олз, гарз нь бодит үнэ цэнийн өөрлөлтөд суурилдаг. Уг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг идэвхитэй зах зээлийн ажил гүйлгээг, идэвхитэй зах зээл байхгүй бол үнэлгээний аргачлалд ашиглан тодорхойлно.

*iii. Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө*

Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжих ба дараа үе дэх өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз, гарзыг зөвхөн борлуулагдсан эсвэл тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнэ буурсан тохиолдолд өмнө нь бусад орлогод хүлээн зөвшөөрсөн аливаа алдагдлыг ашиг алдагдалд шилжүүлнэ. Орлогын тайлангийн өмчийн хэрэглүүрт хүлээн зөвшөөрсөн алдагдлыг орлогын тайлангаар дамжуулж буцаахгүй харин өмчийг тохируулна. Дараах үеийн өсөлт нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын дараа үүсэх үйл явдалд бодитоор холбогдох боломжтой бол энгийн үнэт цаасны үнэ

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117216007 5473489

МОНГОЛ УЛС
"Мандал даатгал" ХХК
Санхүүгийн тайлан
2017 оны 12 сарын 31 13
Огноо: 2018/04/16

ЗГХ
Үнэт цаасны зах зээлийн хороо
2018 оны 08 сарын 29
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

цэнийн бууралтын дүнд бий болсон өмнөх тайлант хугацааны орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн гарзыг орлогын тайлангаар дамжуулж буцаана.

*iv. Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө*

Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө нь тогтоосон эсвэл тодорхойлж болох төлбөртэй, тогтоосон дуусах хугацаатай дериватив бус санхүүгийн хөрөнгө бөгөөд арилжааны банкууд дах хадгаламж үүнд орно.

*Санхүүгийн өр төлбөрийн ангилал ба дараа үеийн хэмжилт*

Компанийн санхүүгийн өр төлбөрт зээл ба зээллэг, санхүүгийн түрээсийн өр төлбөрийг багтаасан Дансны ба бусад өглөг орно.

*i. Зээл ба зээллэг*

Зээл ба зээллэгийг зээллэгтэй холбоотой гаргалтын зардлын цэвэр дүн буюу бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнэ, нэрлэсэн үнэ хоорондын зөрүүг тухайн зээллэгийг эзэмшигчээс авснаас бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Тийм тохиолдолд бодит үнэ цэнэ, нэрлэсэн үнэ хоорондын зөрүүг өмчид нэмэлт капиталаар хүлээн зөвшөөрнө. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараагаар зээл ба зээллэг нь өртөг болон үр ашигт хүүгийн суурьарх зээллэгийн хугацааны турш ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн төлөх үеийн үнийн зөрүүний хамт хорогдлын өртгөөр илэрхийлэгдэнэ. Хөрөнгийн нэг хэсэг болгон капиталжуулсан бэлтгэл шаардлагатай хөрөнгийн худалдан авалт, барилга эсвэл үйлдвэрлэлд шууд холбоотой зээлийн өртгөөс бусад зээллэгтэй холбоотой үүссэн хүү болон бусад зардлыг санхүүгийн зардлын хэсгээр хүлээн зөвшөөрнө.

*ii. Дансны ба бусад өглөг*

Дансны ба бусад өглөгийг бодит үнэ цэнээр, дараа үед хорогдуулсан өртгөөр илэрхийлнэ.

## 3.9 Өмч

Компанийн гаргасан өмчийн хэрэглүүрийг хүлээж авсан орлогоор бүртгэнэ.

Хувьцаат капитал нь гаргасан хувьцааны нэрлэсэн үнийг илэрхийлнэ.

Нэмж төлөгдсөн капиталд хувьцаат капитал гаргаснаас хүлээж авсан аливаа урамшуулал орно.

Хуримтлагдсан ашигт тайлант болон өмнөх хугацааны бүх ашиг багтана.

Ногдол ашгийг зарласан хугацаанд нь өр төлбөрөөр хүлээн зөвшөөрнө.

## 3.10 Орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант оны эцсээр хүчинтэй болсон эсвэл хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тухайн оны татвар ногдох орлогод төлөх татварын өглөг болон өмнөх онуудтай холбоотой татварын өглөгийн залруулга юм.

## 3.11 Орлогын хүлээн зөвшөөрөлт

Орлого нь тайлант хугацаанд хөрөнгийн дотогшлох урсгал болон хөрөнгийн сайжруулалт, эсвэл хувь нийлүүлэгчдээс оруулсан хөрөнгөтэй холбоогүйгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, өр төлбөрийг бууруулах хэлбэрээр гарах эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм.

Даатгалын орлогод даатгалын хураамжийн орлого, давхар даатгалын шимтгэлийн орлого, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр, буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын орлого зэрэг хамаарна.

Даатгалын бус орлого, олзод түрээсийн орлого, үйл ажиллагааны бусад орлого, үйл ажиллагааны бус бусад олз, гарз багтана.

Орлогыг дараах нөхцөл бүрдсэнээр хүлээн зөвшөөрнө.

- Орлогын дүнг бодитой тооцон гаргах боломжтой,
- Ажил гүйлгээний эцсийн өгөөжийг хүртэх магадлалтай байх

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УГААНБААТАР ХОТ
1117236007 547...



МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаасны танилцуулга
2018 08 29
БҮРТГЭВ

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

Орлогыг хүлээн авсан мөнгө эсвэл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

Даатгалын орлогод даатгалын хураамжийн орлого, давхар даатгалын шимтгэлийн орлого, давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр, буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр, хөрөнгө оруулалтын орлого зэрэг багтдаг.

Даатгалын гэрээний үндсэн дээр даатгуулагч даатгалын зүйлээ даатгуулсны төлөө даатгагчид төлөх төлбөрийг *Даатгалын хураамжийн орлогоор* хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Давхар даатгагчтай давхар даатгалын гэрээ байгуулсны төлөө давхар даатгагчаас төлөх шимтгэлийг *Давхар даатгалын шимтгэлийн орлогоор* хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Давхар даатгалын гэрээний дагуу давхар даатгагчаас авсан буюу авахаар тохиролцсон даатгалын нөхөн төлбөрийг *Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөрөөр* хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Даатгалын зүйлд даатгалын эрсдэл тохиолдож даатгагчаас нөхөн төлбөрийг даатгуулагчид төлсөн бөгөөд тухайн нөхөн төлбөрийн зарим хэсгийг эсвэл бүхэлд нь буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн хэмжээг *Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөрөөр* хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

Нөөц сангийн хөрөнгө, дүрмийн сангийн хөрөнгө болон тайлант үед хийх төлбөрийн хэмжээнээс давсан сул чөлөөтэй хөрөнгийг арвижуулах зорилгоор байршуулснаар олсон орлого, олзыг *Хөрөнгө оруулалтын орлогоор* хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

### 3.12 Даатгалын зардал

*Давхар даатгалын хураамж* нь давхар даатгалын гэрээний үндсэн дээр даатгагч өөрийн даатгалын эрсдлийг давхар даатгагчид шилжүүлсний төлөө төлөх төлбөр байна.

*Даатгалын хураамжийн буцаалт* нь даатгалын гэрээ цуцлагдахад гэрээний үлдэх хугацаанд ногдох хураамжаас гэрээнд заасны дагуу даатгуулагчид өгөх даатгалын хураамж байна.

*Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт* нь ОТХНөөцийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. ОТХНөөцийг нэмж байгуулах үед зардал, бууруулж байгуулах үед орлого утгатай байна.

*Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт нь* Давхар даатгалын хойшлогдсон хураамжийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. Давхар даатгалын хойшлогдсон хураамжийг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

*Нөхөн төлбөрийн зардал гэж* даатгалын зүйлд даатгалын гэрээнд заасан эрсдэл тохиолдож даатгагчаас хохирлыг барагдуулахаар олгож буй төлбөр байна.

*Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт нь* УБМХНС болон МБТХНСанг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. УБМХНС болон МБТХНСанг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

*Нөхөн төлбөрийн нөөцийн Давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт нь* УБМХНС болон МБТХНСангийн давхар даатгагчид ногдох хэсгийг байгуулах болон зарцуулах зориулалт бүхий орлого, зардлын данс юм. Даатгалын нөөцийн Давхар даатгагчид ногдох УБМХНС болон МБТХНСанг нэмж байгуулах үед орлого, бууруулж байгуулах үед зардал утгатай байна.

Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт нь УБХБТБНСанг байгуулахад зориулсан зардлын данс байна.

*Даатгалын гэрээний зардал гэж* даатгалын хураамжийн дүнтэй хамааралтай гарсан зардал байна.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
5473489

МОНГОЛ УЛС
"Мандал даатгал" ХХК
Санхүүгийн тайлан
2017 оны 12 сарын 31 16
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаасны танилцуулга
2019.08.29
МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

## 4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Бэлэн мөнгө | 10,353 | 8,332 |
| Банкны дах харилцах данс | 817,936 | 3,059,201 |
| Банк санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө | 870,899 | 650,000 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөнд хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 106,019 | 2,022 |
| | 1,805,207 | 3,719,555 |

## 5 Даатгалын авлага

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-нии үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Даатгалын хураамжийн авлага | 2,529,442 | 2,759,877 |
| Буруутай этгээдээс авах авлага | 91,092 | 411,097 |
| Давхар даатгалаас авах авлага | 1,781,915 | 179,324 |
| | 4,402,449 | 3,350,298 |

Эдгээр авлагын насжилтын шинжилгээг дор харуулав:

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Хэвийн /30 хүртэл хоног/ | 2,652,602 | 2,031,263 |
| Хугацаа хэтэрсэн /31-60 хоног/ | 1,236,768 | 1,054,230 |
| Хэвийн бус /61-90 хоног/ | 158,841 | 182,735 |
| Эргэлзээтэй /91-120 хоног/ | - | 70,832 |
| Муу /121-ээс дээш хоног/ | 354,238 | 11,238 |
| | 4,402,449 | 3,350,298 |

"Мандал даатгал" ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогодоо эргэлзээтэй авлагыг найдваргүй нь тодорхой болсон үед авлагын данснаас шууд хасах бодлого баримталдаг ба тайлант хугацаанд нийт 376,369 мянган төгрөгийн авлагыг данснаас хассан байна.

## 6 Бусад санхүүгийн хөрөнгө

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Бусад байгууллагаас авах авлага | 388,312 | 437,498 |
| Холбоотой талаас авах авлага | 12,862 | 7,600 |
| | 401,174 | 445,097 |

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489
МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

## 7 Бусад санхүүгийн бус хөрөнгө

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Нийгмийн даатгалын шимтгэл болон бусад татварын авлага | 31,980 | 7,946 |
| Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын авлага | - | 1,653 |
| Бараа материал | 21,928 | 34,932 |
| Урьдчилж төлсөн зардал | 128,477 | 145,327 |
| | 182,385 | 189,857 |

## 8 Хөрөнгө оруулалт

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө оруулалт | 8,416,710 | 3,257,706 |
| Үнэт цаасаар оруулсан хөрөнгө оруулалт | 812,728 | - |
| | 9,229,438 | 3,257,706 |

Үнэт цаасаарх хөрөнгө оруулалт нь Засгийн газрын бонд, "Сүү бонд", "Монголиан Моргэйж Фанд" ББСБ-ын бондууд байна.

## 9 Даатгалын хөрөнгө

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Давхар даатгалын хойшлогдсон хураамж | 3,625,756 | 4,770,843 |
| Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг - УБМХНС* | 179,442 | 152,906 |
| Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсэг - МБТХНС** | 535,186 | 181,723 |
| Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал - Даатгалын зуучлагч | 34,779 | 566,392 |
| Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал - Даатгалын төлөөлөгч | 493,413 | 39,350 |
| | 4,868,576 | 5,711,215 |

*УБМХНС - Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөцийн сан

**МБТХНС - Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөцийн сан

2018 .08. 29
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ

МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ 01

## 10 Үндсэн хөрөнгө

| Мянган төгрөгөөр | Машин тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл | Тавилга эд хогшил | Компьютер, бусад хэрэгсэл | Бусад үндсэн хөрөнгө | Ний ду |
|---|---|---|---|---|---|
| *Өртөг* | | | | | |
| 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр | 273,680 | 135,275 | 209,286 | 11,611 | 629,85 |
| Нэмэгдсэн | 11,210 | 24,384 | 15,315 | 9,194 | 60,10 |
| Хасагдсан | (112,381) | - | - | - | (112,38 |
| 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр | 172,509 | 159,659 | 224,601 | 20,805 | 577,57 |
| Нэмэгдсэн | 3,552 | 8,865 | 48,868 | 24,348 | 85,63 |
| Хасагдсан | (21,624) | (132) | (5,258) | - | (27,01 |
| 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр | 154,437 | 168,392 | 268,211 | 45,153 | 636,19 |
| *Хуримтлагдсан элэгдэл* | | | | | |
| 2016 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр | 82,309 | 33,989 | 124,565 | 1,631 | 242,49 |
| Байгуулсан элэгдэл | 21,941 | 13,502 | 40,717 | 1,408 | 77,56 |
| Данснаас хассан хөрөнгийн элэгдэл | (36,206) | - | - | - | (36,206 |
| 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөр | 68,044 | 47,491 | 165,282 | 3,039 | 283,85 |
| Байгуулсан элэгдэл | 15,931 | 16,428 | 41,576 | 3,353 | 77,28 |
| Данснаас хассан хөрөнгийн элэгдэл | (10,610) | (63) | (3,234) | - | (13,907 |
| 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр | 73,365 | 63,856 | 203,624 | 6,392 | 347,23 |
| *Үлдэгдэл өртөг* | | | | | |
| Эхний үлдэгдэл | 104,464 | 112,169 | 59,319 | 17,766 | 293,71 |
| Эцсийн үлдэгдэл | 81,072 | 104,536 | 64,587 | 38,761 | 288,95 |

Зээлийн барьцаанд тавьсан хөрөнгө байхгүй байна.

2017 онд 85,633 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө (2016: 60,103 мянган төгрөг) нэмэгдсэн ба үндсэн хөрөнгийн өртөгт капиталжуулсан хөрөнгө байхгүй байна.

Элэгдлийн зардлыг Орлогын дэлгэрэнгүй тайлангийн Ерөнхий ба удирдлагын зардалд тусгадаг.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ



МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаасны танилцуулга
2018.08.29
№ 11

Хөрөнгийн бирж МАНДАЛ даатгал БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

## 11 Биет бус хөрөнгө

| Мянган төгрөгөөр | Компьютерийн програм хангамж | Нийт |
|---|---|---|
| *Өртөг* | | |
| 2016 оны 1 дүгээр сарын 1-ээрх | 123,152 | 123,152 |
| Нэмэгдсэн | 32,098 | 32,098 |
| Хасагдсан | - | - |
| 2016.12.31 | 155,250 | 155,250 |
| Нэмэгдсэн | - | - |
| Хасагдсан | - | - |
| 2017 оны 12 дугаар сарын 31-ээрх | 155,250 | 155,250 |
| *Хуримтлагдсан хорогдуулга* | | |
| 2016 оны 1 дүгээр сарын 1-ээрх | 14,625 | 14,625 |
| Байгуулсан хорогдуулга | 35,281 | 35,281 |
| Данснаас хасагдсан | - | - |
| 2016.12.31 | 49,907 | 49,907 |
| Байгуулсан хорогдуулга | 48,018 | 48,018 |
| Данснаас хасагдсан | - | - |
| 2017 оны 12 дугаар сарын 31-ээрх | 97,925 | 97,925 |
| *Үлдэгдэл өртөг* | | |
| Эхний үлдэгдэл | 105,343 | 105,343 |
| Эцсийн үлдэгдэл | 57,325 | 57,325 |

Хорогдуулгын зардлыг Ерөнхий ба удирдлагын зардалд тусгадаг.

## 12 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө

| Мянган төгрөгөөр | 2017 | 2016 |
|---|---|---|
| *Бодит үнэ цэнэ* | | |
| Эхний үлдэгдэл | 236,640 | 110,000 |
| Бодит үнэ цэнийн тохируулгаас үүссэн цэвэр олз | - | 126,640 |
| Эцсийн үлдэгдэл | 236,640 | 236,640 |

2016 онд зах зээлийн үнэлгээний хандлагад үндэслэн хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийг тогтоосон байна. Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнэ материаллаг хэмжээгээр өөрчлөгдөөгүй гэж Компанийн удирдлага үзсэн тул дахин үнэлгээ хийлгээгүй байна.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
"Мандал даатгал" ХХК
Санхүүгийн тайлан
2017 оны 12 сарын 31 19
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Нэт цаасны танилцуулга
2018 . 08 . 29 өдөр
ГЭВ
№ 1

МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ
.... он .... сар .... өдөр

## 13 Даатгалын өглөг

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Даатгалын хураамжийн буцаалтын өглөг | 2,143 | - |
| Даатгалын гэрээний шимтгэлийн өглөг | 35,257 | 55,019 |
| Давхар даатгагчид өгөх өглөг | 2,018,056 | 1,982,179 |
| | 2,055,456 | 2,037,198 |

## 14 Бусад санхүүгийн бус өр төлбөр

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Орлогын татварын өглөг | 66,396 | - |
| Цалингийн өглөг | 231,815 | 2,400 |
| Бусад өглөг | 126,209 | 73,657 |
| Урьдчилж орсон орлого | 714,445 | 600,944 |
| | 1,138,865 | 677,000 |

## 15 Орлогод тооцоогүй хураамжийн нөөц

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| 1.1. Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал | 2,492,306 | 1,070,412 |
| 1.2. Хөрөнгийн даатгал | 1,807,795 | 1,584,362 |
| 1.3. Автотээврийн хэрэгслийн даатгал | 1,996,202 | 1,476,402 |
| 1.4. Ачааны даатгал | 28,844 | 65,664 |
| 1.5. Барилга угсралтын даатгал | 590,645 | 402,180 |
| 1.9. Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | 36,159 | 46,688 |
| 1.10. Хариуцлагын даатгал | 1,819,171 | 1,400,375 |
| 1.11. Санхүүгийн даатгал | 174,915 | 162,300 |
| 1.12. Зээлийн даатгал | - | 1,516 |
| 1.13. Итгэлцлийн даатгал | 410 | 502 |
| 2.1. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал | 419,831 | 1,262,661 |
| | 9,366,278 | 7,473,062 |

**Актуарчийн нөөц сангийн тооцооллын тайланд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:**

**Орлогод тооцоогүй хураамжийн нөөц санг 2017 оны 12 дугаар 31-ний өдрийн байдлаар хүчинтэй байгаа бүх даатгалын гэрээний хураамжийн орлогыг тухайн гэрээний үргэлжлэх хугацаанд хувь тэнцүүлэх замаар тооцоолсон. Хүчинтэй даатгалын гэрээнд үндэслэн тооцоолол хийхэд нийт**

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
"Мандал даатгал" ХХК
Санхүүгийн тайлан
2017 оны 12 сарын 31 20


Огноо: 2018/04/16

Үнэт цаасны танилцуулга
2018 .08 .29

19,366,278 мянган төгрөг (2016: онд 7,473,062 мянган төгрөг)-ийн нөөц сан байгуулагдсан. Үүнээс "Мандал Даатгал" ХХК-д харгалзах орлогод тооцоогүй хураамжийн дүн нь 5,740,522 мянган төгрөг (2016: онд 2,702,219 мянган төгрөг) байсан.

## 16 Нөхөн төлбөрийн нөөц сан

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл | 2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл |
|---|---|---|
| Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан | 334,326 | 287,291 |
| Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан | 702,229 | 304,940 |
| Учирч болзошгүй хохирлын нөөц сан | 617,814 | 375,282 |
| Тусгай нөөц сан | 1,256,290 | 1,256,290 |
| | 2,910,659 | 2,223,803 |

Актуарчийн нөөц сангийн тооцооллын тайланд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц санг 2012 оны 2-р улирлаас хойших компанийн төлсөн нийт нөхөн төлбөрийн өгөгдөл дээр үндэслэн Гурвалжингийн аргаар даатгалын бүтээгдэхүүн бүрээр байгуулсан. Зарим бүтээгдэхүүн дээр гурвалжингийн аргаар байгуулахад тоон мэдээлэл хангалтгүй буюу нөхөн төлбөрийн тоо ширхэг цөөн үед хохирлын харьцааны аргаар энэ нөөцийг тооцоолсон.

Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц санг тооцохдоо 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлөгдөж амжаагүй болон системд бүртгэлтэй нийт нөхөн төлбөрийн дүнд үндэслэн тус нөөц сангийн жагсаалтыг байгуулсан. Нийт 702,230 мянган төгрөг (2016 онд: 304,939 мянган төгрөг)-ийн нөөц байгуулагдсан байна.

Учирч болзошгүй хохирлын нөөц санг байгуулахад журмын 8.2-р заасан томьёог ашиглан даатгалын хэлбэр тус бүрээр тооцоолсон. Тайлант улиралд харгалзах компанийн нийт орлогод тооцсон хураамж, цэвэр нөхөн төлбөр, НТ-ийн нөөц сангийн өөрчлөлт, үйл ажиллагааны зардал зэрэгт үндэслэн тооцоолоход учирч болзошгүй хохирлын нөөц сангийн үлдэгдэл дүн нь 617,814 мянган төгрөг (2016 онд: 375,282 мянган төгрөг)-өөр байгуулагдсан.

## 17 Эздийн өмч

### 17.1 Хувьцаат капитал

| Мянган төгрөгөөр | Энгийн хувьцаа 2017 | Энгийн хувьцаа 2016 |
|---|---|---|
| Зөвшөөрөгдсөн хувьцаа | 25,000,000 | 25,000,000 |
| Нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэтэй 5,000,000 ширхэг энгийн хувьцаа | 5,000,000 | 5,000,000 |
| Нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэтэй 1,243,016 ширхэг халаасны хувьцаа | 1,243,016 | 1,243,016 |
| Нэг бүр нь 1,000 төгрөгийн үнэтэй 6,243,016 ширхэг нийт хувьцаа | 6,243,016 | 6,243,016 |

Компани нь тогтмол орлогын эрхгүй энгийн хувьцааны нэг л ангилалтай.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК

"Мандал даатгал" ХХК Санхүүгийн тайлан 2017 оны 12 сарын 31 21

# 18 Даатгалын үйл ажиллагааны орлого, зардал

Мянган төгрөгөөр

| Даатгалын хэлбэр | Даатгалын хураамжийн нийт орлого | Даатгалын хураамжийн буцаалт | Давхар даатгалын хураамжийн зардал | Даатгалын хураамжийн цэвэр орлого | Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт | Хойшлуулсан давхар даатгалын хураамжийн өөрчлөлт | Орлогод тооцсон хураамж | Нийт нөхөн төлбөрийн зардал | Нөхөн төлбөрийн цэвэр зардал | Нөхөн төлбөрийн нөөцийн сангийн өөрчлөлт | Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт | Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт | Зардалд тооцсон нөхөн төлбөр |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **2017 он** | | | | | | | | | | | | | |
| Гэнэтийн осол, эмчилгээний даатгал | 4,943,509 | 162,586 | 875,641 | 3,905,284 | 1,421,895 | (196,978) | 2,286,411 | 648,742 | 311,793 | 30,196 | 18,363 | 283,396 | 643,750 |
| Хөрөнгийн даатгал | 3,532,545 | 80,444 | 2,121,231 | 1,330,870 | 223,434 | (166,043) | 941,393 | 253,414 | 86,218 | (3,301) | 32,884 | (78,059) | 37,743 |
| Автотээврийн хэрэгслийн даатгал | 3,672,701 | 531,479 | 425,470 | 2,715,752 | 519,800 | (473,887) | 1,722,065 | 1,763,415 | 824,465 | (30,829) | 24,583 | - | 818,218 |
| Ачааны даатгал | 118,553 | 10,144 | 23,351 | 85,057 | (36,820) | (19,920) | 101,958 | - | - | 5,750 | (274) | 2,342 | 7,817 |
| Барилга угсралтын даатгал | 6,282,411 | - | 6,258,221 | 24,190 | 188,465 | 195,023 | 30,748 | 303,769 | 3,038 | 15,113 | (17,861) | - | 290 |
| Мал амьтдын даатгал | - | 8,192 | - | (8,192) | - | - | (8,192) | - | - | (1,752) | - | - | (1,752) |
| Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | 62,346 | 8,762 | 6,034 | 47,549 | (10,530) | (25,302) | 32,777 | - | - | (3,405) | 1,532 | 6,006 | 4,133 |
| Хариуцлагын даатгал | 2,302,074 | 198,291 | 995,093 | 1,108,689 | 418,795 | 41,162 | 731,056 | 19,466 | 10,706 | 537,378 | (491,037) | - | 57,047 |
| Санхүүгийн даатгал | 262,733 | - | 155,484 | 107,249 | 12,615 | (30,267) | 64,366 | 235,352 | 16,917 | 189 | - | (1,854) | 15,252 |
| Зээлийн даатгал | - | - | - | - | (1,516) | (925) | 590 | - | - | 8,419 | (6,567) | - | 1,852 |
| Итгэлцлийн даатгал | 428 | - | - | 428 | (92) | (222) | 298 | 34,541 | 10,951 | (2) | - | 35,697 | 46,646 |
| Жолоочийн хариуцлагын даатгал | 1,355,793 | 207,855 | 383,349 | 764,590 | (842,830) | (467,728) | 1,139,693 | 1,446,935 | 810,380 | (113,432) | 58,378 | (4,996) | 750,329 |
| **2017 оны нийт дүн** | 22,533,093 | 1,207,753 | 11,243,874 | 10,081,466 | 1,893,216 | (1,145,087) | 7,043,163 | 4,705,634 | 2,074,468 | 444,324 | (379,999) | 242,532 | 2,381,325 |
| **2016 он** | | | | | | | | | | | | | |
| Гэнэтийн осол, эмчилгээний даатгал | 1,847,862 | 31,546 | 967,056 | 849,260 | 711,813 | 560,986 | 698,435 | 423,120 | 68,390 | 51,847 | (87,732) | (31,099) | 1,406 |
| Хөрөнгийн даатгал | 3,022,395 | 8,487 | 2,352,441 | 661,467 | 1,180,890 | 1,177,278 | 657,854 | 115,662 | 43,811 | 80,808 | (88,408) | 58,857 | 95,068 |
| Автотээврийн хэрэгсэл, жолоочийн хариуцлагын даатгал | 2,530,796 | 346,898 | 944,195 | 1,239,703 | 723,311 | 693,795 | 1,210,186 | 1,607,250 | 755,028 | 16,438 | (56,319) | 75,496 | 790,643 |
| Ачааны даатгал | 127,550 | 10,306 | 53,407 | 63,837 | 48,872 | 27,924 | 42,889 | 519 | 78 | 1,509 | (1,456) | (2,068) | (1,938) |
| Барилга угсралтын даатгал | 169,579 | 23,573 | 126,238 | 19,769 | 377,052 | 383,745 | 26,462 | - | - | 2,006 | - | 13,701 | 15,707 |
| Мал амьтдын даатгал | - | - | - | - | (1,047) | - | 1,047 | 57,802 | 57,802 | (25,365) | - | (2,546) | 29,890 |
| Агаарын хөлгийн даатгал | - | - | - | - | - | - | - | - | - | (2) | - | (410) | (413) |
| Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал | 85,917 | 15,858 | 39,766 | 30,292 | 36,469 | 28,539 | 22,363 | 3,093 | 1,701 | 3,309 | (1,950) | (1,632) | 1,399 |
| Хариуцлагын даатгал | 2,053,065 | 272,029 | 1,496,352 | 284,683 | 1,231,316 | 1,195,447 | 248,814 | 38,741 | 17,851 | 19,380 | (12,714) | (29,953) | (5,436) |
| Санхүүгийн даатгал | 243,784 | - | 200,948 | 42,836 | 147,013 | 133,781 | 29,605 | - | - | (2,203) | - | (2,936) | (5,139) |
| Зээлийн даатгал | 13,000 | - | 8,323 | 4,677 | (12,301) | 925 | 17,903 | - | - | (12,738) | - | (1,737) | (14,475) |
| Итгэлцлийн даатгал | 513 | - | 231 | 282 | (4,844) | 222 | 5,348 | - | - | (135) | - | (639) | (804) |
| Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | (42) | (43) |
| Жолоочийн хариуцлагын даатгал | 2,998,371 | 264,354 | 1,229,675 | 1,504,342 | 816,448 | 568,198 | 1,256,093 | 1,870,004 | 946,072 | 103,795 | (86,050) | 160,764 | 1,124,581 |
| **2016 оны нийт дүн** | 13,092,831 | 973,051 | 7,418,632 | 4,701,148 | 5,254,992 | 4,770,843 | 4,216,999 | 4,116,181 | 1,890,732 | 238,650 | (334,629) | 235,594 | 2,030,447 |



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
мандал даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489
GOLOMT CAPITAL LLC
Огноо: 2018/04/16
Үнэт цаасны танилцуулга
СЗХ
2018 .08. 29
БҮРТГЭВ
№ 01
мандал даатгал
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
2018 08 29 өдөр
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

## 18 Даатгалын үйл ажиллагааны орлого, зардал (үргэлжлэл)

Компани нь "Оюу толгой" ХХК-ийн 2-р үе шатны өргөтгөлийн төслийн Барилга угсралтын даатгалын №16/150-2 дугаартай гэрээг 2017 оны 1 дүгээр сарын 1-нд байгуулсан. Үүнтэй холбоотойгоор Компани нь нягтлан бодох бүртгэлдээ 2,298 мянган ам. доллар буюу 5,536,622 мянган төгрөгийн хураамжийн орлогыг тусгаж, тайлагнасан.

Тус даатгалын орлогыг Компани хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Монгол улсын Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2015 оны 11 дүгээр сарын 9 өдөр хамтран баталсан 306/307 дугаартай тушаалын нэгдүгээр хавсралт "*Даатгалын компанид мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн заавар*"-ын "*5.1 Даатгалын орлого*" хэсгийн "*5.1.B. Хүлээн зөвшөөрөлт*" гэсэн заалтын "*... Даатгалын компанийг нөхөн төлбөрийн үүргээс бүрэн чөлөөлж, түүний үүргийг Давхар даатгагч өөртөө шилжүүлэн авсан бол Даатгалын хураамжийн орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч, орлого үр дүнгийн тайланд тусгахгүй*" гэсэн зааварт Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн нэмэлт тодруулга, тайлбартай нийцэж байна.

## 19 Даатгалын гэрээний зардал

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| Даатгалын зуучлагчийн шимтгэл | 1,043,723 | 845,301 |
| Даатгалын төлөөлөгчийн шимтгэл | 159,978 | 275,818 |
| | 1,203,701 | 1,121,118 |

## 20 Давхар шимтгэлийн орлого

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| Факультатив давхар даатгал | 151,427 | 31,199 |
| Гэрээт давхар даатгал | 773,965 | 1,239,696 |
| | 925,392 | 1,270,895 |

## 21 Хөрөнгө оруулалтын орлого

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| *Хөрөнгө оруулалтын орлого* | | |
| Банк, ББСБ-д байршуулсан хугацаагүй хадгаламж, хугацаатай хадгаламж, хадгаламжийн сертификатын хүүний орлого | 954,770 | 830,055 |
| Үнэт цаасны хүүний орлого | 272,189 | 37,284 |
| Хөрөнгө оруулалтын үнэлгээний олз | - | 126,640 |
| | 1,226,959 | 993,979 |

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489



Огноо: 2018/04/16
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

## 22 Ерөнхий ба удирдлагын зардал

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| Ажиллагчдын цалингийн зардал | 2,019,981 | 1,553,091 |
| Аж ахуйн нэгжээс төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | 240,296 | 181,050 |
| Автомашины зардал | 59,656 | 73,467 |
| Ашиглалтын зардал | 400 | 50 |
| Бичиг хэрэг, хангамжийн зардал | 55,207 | 50,001 |
| Бусад зардал | - | 9,833 |
| Даатгалын зардал | 1,597 | 2,694 |
| Засвар, үйлчилгээний зардал | 8,369 | 45,846 |
| Мэргэжлийн үйлчилгээний зардал | 485,693 | 249,275 |
| Сургалтын зардал | 25,388 | 12,347 |
| Томилолтын зардал | 29,086 | 20,945 |
| Түрээсийн зардал | 155,583 | 177,459 |
| Уулзалт, арга хэмжээний зардал | 177,563 | 86,555 |
| Шуудан холбооны зардал | 138,718 | 110,407 |
| Элэгдлийн зардал | 125,306 | 112,848 |
| | 3,522,843 | 2,685,868 |

## 23 Борлуулалт маркетингийн зардал

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| Бизнес уулзалтын зардал | 17,158 | 43,639 |
| Борлуулалтын үеийн идэвхижүүлэлт | 17,929 | 24,317 |
| Маркетинг, сурталчилгааны зардал | 174,510 | 142,299 |
| Харилцагчийн халамжийн зардал | 307,694 | 245,870 |
| | 517,291 | 456,125 |

МОНГОЛ УЛС
"Мандал даатгал" ХХК
Санхүүгийн тайлан
2017 оны 12 сарын 31 24


Огноо: 2018/04/16

нэт цаасны танилцуулга
2018 .08. 29
МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ 01

## 24 Бусад зардал

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| Найдваргүй авлагын зардал | 376,369 | - |
| Алданги, торгууль | 40,228 | - |
| Хөрөнгө данснаас хассаны гарз | - | 5,410 |
| | 416,597 | 5,410 |

Тайлант онд Компанийн Гүйцэтгэх захирлын тушаалаар 376,369 мянган төгрөгийн авлагыг найдваргүйд тооцож, бусад зардлаар бүртгэсэн.

## 25 Орлогын татварын зардал

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|
| Тайлант жилийн татвар | 162,548 | 85,291 |
| Хойшлогдсон татвар | - | - |
| | 162,548 | 85,291 |

Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээний нэгтгэл нь дараах байдалтай байна:

| Мянган төгрөгөөр | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээ (%) | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | Хүчин төгөлдөр татварын хувь хэмжээ (%) |
|---|---|---|---|---|
| Татварын өмнөх ашиг (СТОУС-ын дагуу) | 1,265,074 | | 170,540 | |
| 10%-аар татварын хувь хэмжээг тооцсон татвар (2016: 10%) | 126,507 | 10% | 17,054 | 10% |
| Татвар тооцохгүй хэсэг, цэвэр | (62,647) | -5% | 5,910 | 3% |
| Хойшлогдсон татварын хөрөнгөөр хүлээн зөвшөөрөөгүй түр зөрүү | 2,536 | 0% | 4,069 | 2% |
| Тусгайлсан хувь хэмжээгээр тооцсон татвар (2016: 10%) | 96,152 | 8% | 58,258 | 34% |
| Орлогын татварын зардал | 162,548 | 13% | 85,291 | 50% |

## 26 Балансын дараах үйл явдал

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэснээс хойш санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхүйц үйл явдал гараагүй.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

## 27 Мэргэжлийн шийдэл бүхий нягтлан бодох бүртгэлийн тооцоолол ба үнэлэмж

Тооцоолол болон үнэлэмжийг байнга хийдэг бөгөөд тухайн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл явдлын таамаглал, түүхэн туршлага, бусад хүчин зүйлст үндэслэдэг.

### 27.1 Мэргэжлийн шийдэл шаардагдах бүртгэлийн тооцоолол

Компани нь ирээдүйн талаарх тооцоолол, таамаглалыг хийдэг.

*Нөөц сангийн тооцоолол*

"Мандал Даатгал" ХХК нь нөөц сан, хохирол нөхөлтийн харьцааг тодорхойлж, учирч болзошгүй эрсдэлээс зайлсхийх зорилгоор СЗХ-ноос зөвшөөрөгдсөн даатгалын нөөц сан байгуулах ангилал болон аргачлалыг ашиглан даатгалын нөөц сангийн хэмжээг тооцдог. Даатгалын нөхөн төлбөрийн нөөц санг Учирч болзошгүй хохирлын нөөц сан (УБНХНС), Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС), Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц (УБНХНС) гэж ангилна.

Аудитын явцад нөөц сангийн тооцооллыг хөндлөнгийн шинжээч-актуарч давтан тооцоолж, шалгасан.

## 28 Санхүүгийн эрсдэлийн удирдлага

Компани нь санхүүгийн хэрэгслүүдийг ашиглах явцад зарим эрсдэлүүдтэй тулгарч байна. Үүнд зах зээлийн эрсдэл, зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл зэрэг байна.

Компани нь арилжааны зорилгоор санхүүгийн хөрөнгийг ч мөн опцион ч худалдаалдаггүй байна.

## 29 Капиталын эрсдэлийн удирдлага

Компани нь цаашид тасралтгүй ажиллах боломжийг хангахын тулд өөрийн хөрөнгөө удирддаг.

Компанийн капиталын бүтэц нь гаргасан капитал, нөөц, хуримтлагдсан ашгийг багтаасан эздийн өмчөөс бүрдэнэ.

## 30 Үүрэг

### 30.1 Капиталаас хүлээх үүрэг

Компани нь 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар ямар нэгэн томоохон шүүхийн нэхэмжлэл, маргаангүй байна. Тийм учир компани нь холбоотой талтай холбоотой ирээдүйн капиталын зарцуулалтаас хүлээх үүрэг байхгүй.

## 31 Холбоотой тал

Доор тайлбарласанчлан Компанийн холбоотой талуудад толгой компани, хамтын хяналт, удирдлагатай аж ахуйн нэгжүүд орно.

### 31.1 Хяналтын харилцаа

Компанийн 51%-ийг "Голомт Файнэншил групп" ХХК, 49%-ийг "Юу Эм Си Капитал" ХХК эзэмшиж, хянаж байна.

### 31.2 Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Тайлант хугацаанд Компани нь дараах ажил гүйлгээг холбоотой талуудтай хийсэн байна.

СЗХ
Үнэт цаасны төлөөлөгч
2018.08.29
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
МАНДАЛ даатгал
01

| Мянган төгрөгөөр<br>*Холбоотой талуудын нэр* | Ажил гүйлгээний төрөл | 2017 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон | 2016 оны 12 сарын 31-нээр дуусвар болсон |
|---|---|---|---|
| "Юу Эм Си Альфа" ХХК | Авлага бүртгэв | 465 | 1,483 |
| "Юу Эм Си Альфа" ХХК | Авлага барагдуулав | 1,187 | 761 |
| "Юу Эм Си Холдинг" ХХК | Авлага бүртгэв | 349 | - |
| "Юу Эм Си Холдинг" ХХК | Авлага барагдуулав | 349 | - |
| "Эн Пи Си энд Мандал" ХХК | Авлага бүртгэв | - | 2,137 |
| "Эн Пи Си энд Мандал" ХХК | Авлага барагдуулав | 1,877 | 260 |
| "Мандал лайф" ХХК | Авлага, өглөг бүртгэж, барагдуулав | 27,673 | 35,080 |
| "Мандал лайф" ХХК | Авлага, өглөг бүртгэж, барагдуулав | 21,178 | 28,713 |
| "Голомт банк" ХХК | Даатгал, зуучлан борлуулалт, зуучлагчийн шимтгэлийн дүн | 4,565,437 | 2,248,737 |
| "Голомт секюритиз" ХХК | Даатгал хийлгэв | - | 459 |
| "Голомт файненшил" ХХК | Даатгал хийлгэв | 816 | - |
| "Голомт капитал" ХХК | Даатгал хийлгэв | 400 | - |

## 31.3 Төлбөрийн чадвар

Компанийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа 109.82% (2016: 101.27%) байгаа нь Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцоолох журмын 3.12-д заасан "Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 100 хувь буюу түүнээс илүү байвал зохино" гэсний дагуу зохистой байна.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1172336007 5473489

МОНГОЛ УЛС
Мандал даатгал ХХК
Санхүүгийн тайлан
2017 оны 12 сарын 31 27
GOLOMT CAPITAL LLC
1117236373 5481589
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

СЭХ
Үнэт цаасны бүртгэл, хяналт хариуцсан газар
2018.08.29
БҮРТГЭВ
№ 01

# 6.10. Хуулийн зөвлөхийн дүгнэлт

НУУЦ БАРИМТ
Эх хувь


ӨМГӨӨЛЛИЙН БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХН

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 15, Монгол ТВ цамхаг, 10-р давхар, 1001-1003 тоот, Утас/Факс: (+976) 7711 9008, Цахим шуудан: contact@bnp.mn, Вэб: www.bnp.mn


Огноо: 2018.04.16
Дугаар: BNP-32/18
Утга: ХУУЛИЙН_ДҮГНЭЛТ

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЖАВХЛАН ТАНАА

МАНДАЛ ДААТГАЛ ХХК-ААС АНХ УДАА НИЙТЭД САНАЛ БОЛГОН
ҮНЭТ ЦААС ГАРГАХТАЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН
**ХУУЛИЙН ДҮГНЭЛТ**

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН /цаашид "Хуулийн фирм" гэнэ/ нь танай компанитай 2018 оны 02 сарын 21-ний өдөр байгуулсан №18/020 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ /цаашид "Гэрээ" гэнэ/-ний дагуу Мандал даатгал ХХК-аас анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргахтай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасан асуудлын хүрээнд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, энэхүү хуулийн дүгнэлт /цаашид "Хуулийн дүгнэлт" гэнэ/ бэлтгэн хүргүүлж байна. Хүлээн авна уу.

Энэхүү Хуулийн дүгнэлттэй холбоотой аливаа асуудлаар лавлагаа, мэдээлэл шаардлагатай нөхцөлд доорх мэдээллийн дагуу холбогдож асуухыг хүсье.

**Г.Батбаяр**
Хуульч, Гишүүн өмгөөлөгч, Захирал

Б.Баасандорж
Хуульч, Гишүүн өмгөөлөгч

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН
И-мэйл: contact@bnp.mn
Холбоо барих: 7711 9008
Факс: +976 7711 9008

Энэхүү Хуулийн дүгнэлт нь үнэт цаасны танилцуулгыг олон нийтэд санал болгохоос өмнө Мандал даатгал ХХК, түүний эрх бүхий албан тушаалтнууд болон, төрийн эрх бүхий гуравдагч этгээдээс бусад этгээдийн хувьд нууц материалд тооцогдохыг анхаарна уу. Ажил хэргийн журмаар Хуулийн дүгнэлттэй танилцсан этгээдүүд нь хэсэгчлэн болон бүтнээр мэдээ, мэдээллийг бусдад дамжуулсан, арилжаа үрвүүлах, өрсөлдөөний болон бусад хувийн зорилгоор ашигласан, цааш түгээсэн, түгээх нөхцөл боломжийг бүрдүүлсэн, хувийн зорилгоор ашигласан бол нууцалсан мэдээллийг задруулсантай холбоотой үр дагаврыг бүрэн хариуцахыг анхаарна уу.

Тус Хуулийн фирм нь анх удаа олон нийтэд үнэт цаас санал болгох энэхүү төслийн үйл ажиллагаанд оролцож байгаа андеррайтерийн компани болох **Голомт капитал ҮЦК** ХХК, үнэлгээний компани болох **БДО Аудит** ХХК, аудитын компани болох **Улаанбаатар Аудит Корпораци** ХХК болон үнэт цаасаа олон нийтэд санал болгож байгаа **Мандал даатгал** ХХК, түүний хувьцаа эзэмшигчид, нэгдмэл сонирхолтой этгээдүүд, эрх бүхий албан тушаалтан болон холбоотой этгээдүүдтэй аливаа харилцан хамааралгүй, ашиг сонирхлын хувьд холбоогүй, хөндлөнгийн этгээд болохыг үүгээр баталгаажуулж байна.



МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

МАНДАЛ ДААТГАЛ
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаасны танилцуулга
2018.08.29
№ 1
ХУУЛЬ БАРИМТ
Эх хувь

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
STOCK EXCHANGE
МАНДАЛ даатгал
..... он .... сар .... өдөр

**Хуулийн дүгнэлт гаргах үндэслэл, ажлын даалгавар**

Мандал даатгал ХХК-аас анх удаа нийтэд санал болгон үнэт цаас гаргаж, компанийн хэлбэрийг өөрчлөн байгуулахтай холбогдуулан Хуулийн фирм нь Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны №408 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 5 дугаар зүйлийн 5.2.2 дахь заалт, Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2018 оны №2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасан дараах асуудлуудыг Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК хангаж буй эсэхэд Хуулийн дүгнэлт гаргаж өгөхөөр харилцан тохиролцсон. Үүнд:

(i) Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх, улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх;
(ii) Компанийн дүрэм, дотоод журмууд, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод журмуудын төсөл нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-т нийцсэн эсэх;
(iii) Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан эсэх болон тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал;
(iv) Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;
(v) Сүүлийн 3 жил дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;
(vi) Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл, үр дагавар буй эсэх;
(vii) Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;
(viii) Үнэт цаасыг бүртгүүлэх өргөдөл, танилцуулгад тусгагдсан мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;
(ix) Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийг тодорхойлох.

Гэрээгээр хүлээсэн Ажлын даалгаварт (i) Мандал даатгал ХХК-ийн хэлбэрийг өөрчлөхөд холбогдох өөрчлөн байгуулах асуудал; (ii) Санхүүгийн зохицуулах хороонд хуулиар олгогдсон хянан шалгах асуудлын хүрээнд багтсан Мандал даатгал ХХК нь даатгалын хууль тогтоомж, багц дүрэм, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьд хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар болон Санхүүгийн зохицуулах хорооноос бүрэн эрхийнхээ хүрээнд зөвшөөрөл олгосон аливаа асуудлаар дахин тусгайлсан дүгнэлт гаргах ажил багтаагүй болохыг анхаарна уу.

Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн бөгөөд гадаад улсын хууль тогтоомж, хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх, гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг тодорхойлох, гадаад улсын хуулийн дагуу хүчин төгөлдөр байдлыг тодорхойлохтой холбоотой бичгээр байгуулсан гэрээ, хэлцэлтэй холбоотой асуудал багтаагүй болно.

**Үнэт цаас гаргагчийн анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа үнэт цаасны тухай**

Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК нь дунд хугацааны бизнес төлөвлөгөөний хүрээнд компанийн мөнгөн хөрөнгийг нэмэгдүүлэх замаар эрсдэл даах чадварыг өсгөх, зах зээлд эзлэх байр суурийг дээшлүүлэх, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор нийт гаргасан өөрийн энгийн хувьцааны 25%-ийг олон нийтэд эзэмшүүлэх замаар Мандал даатгал ХХК-ийн хэлбэрийг өөрчлөхөөр шийдвэрлэсэн гэж Хуулийн фирм ойлгосон. Улмаар Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчид 2018 оны 02 сарын 12-ны өдөр ээлжит бус хурал хийж, №004 тоот "Компанийн

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489



МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
1117236573 6481529
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

хэлбэрийг өөрчлөх, түүнтэй холбоотой авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын дагуу дараах асуудлуудыг шийдвэрлэсэн байна. Үүнд:

(i) Мандал даатгал ХХК-ийг "хувьцаат компани" болгох замаар өөрчлөн байгуулж хэлбэрийг өөрчилж, эрх, үүрэг, хариуцлагыг шинээр үүсгэн байгуулагдсан хувьцаат компанид шилжүүлэх;

(ii) Компанийн зарласан энгийн хувьцаанаас нэмж 1,243,016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) ширхэг энгийн хувьцаа гаргаж олон нийтэд санал болгох;

(iii) Мандал даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигч Юу Эм Си капитал ХХК-ийн эзэмшилд байгаа Мандал даатгал ХХК-ийн 317,738 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгохоор шийдвэрлэснийг зөвшөөрч баталгаажуулах;

(iv) Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн хэлбэрийг өөрчлөн байгуулах төслийг баталж тус тус шийдвэрлэсэн байна.

Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2018 оны 02 сарын 15-ны өдрийн №002 тоот "Нийтэд санал болгох энгийн хувьцааны нэрлэсэн үнийг тогтоох тухай" тогтоолын дагуу нийтэд санал болгох энгийн хувьцааны үнийг 4,800 (дөрвөн мянга найман зуун) төгрөгөөр тогтоосон байна. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагаас гаргасан эдгээр шийдвэрүүд нь хуульд нийцсэн[1], Компанийн хуульд тусгасан шаардлагыг хангасан, хүчин төгөлдөр шийдвэрүүд байна гэж Хуулийн фирм үзлээ.

Түүнчлэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан өөрчлөн байгуулах төслөөс харвал Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн одоогийн хувьцаа эзэмшигч Юу Эм Си капитал ХХК нь Мандал даатгал ХХК-ийн хувьцааны олон нийтэд арилжаалагдах тархалтын хувийг нэмэгдүүлэх зорилгоор өөрийн эзэмшилд байгаа Мандал даатгал ХХК-ийн 317,738 ширхэг энгийн хувьцааг Мандал даатгал ХХК-ийн нийтэд анх удаа санал болгож байгаа үнэт цаасны хамт, ижил үнээр олон нийтэд санал болгохоор Хувьцаа эзэмшигчийн 2018 оны 02 сарын 09-ний өдрийн №18/001 тоот шийдвэрийн дагуу шийдвэрлэсэн байна. Ингэснээр үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болж хувьцаагаа нийтэд худалдсаны дараа Юу Эм Си капитал ХХК нь Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн 34.15% хувь буюу хяналтын багцыг эзэмшигч хэвээр үлдэж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22 дахь заалтад "нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл" гэж энэ хуульд заасан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг хэлнэ гэж заасан байх бөгөөд мөн зүйлийн 4.1.21 дэх хэсэгт "**нийтэд санал болгох**" гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу үнэт цаасаа 50-аас дээш тооны этгээдэд санал болгон худалдахаа мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэхийг хэлнэ гэж заасан байна. Эдгээр хуулийн зохицуулалтын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд Мандал даатгал ХХК-ийн энгийн хувьцааг бүртгэснээр Мандал даатгал ХХК-ийн

[1] Компанийн тухай хууль (2011).
23 дугаар зүйл.**Компанийг өөрчлөх**
23.1.Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани, хязгаарлагдмал хариуцлагатай компанийг хувьцаат компани болгох замаар компанийн хэлбэрийг өөрчилж болно.
23.2.Энэ хуулийн 23.1-д заасны дагуу компанийг өөрчлөх төслийг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ боловсруулан хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.
23.3.Энэ хуулийн 23.2-т заасан төсөлд компанийг өөрчлөх зорилго, нөхцөл, журам, хугацаа, хувьцааг харилцан хөрвүүлэх арга, тооцоо, хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах хугацаа зэргийг тусгасан байна.
23.5.Компанийг өөрчлөхөд түүний эрх, үүрэг, хариуцлага шинээр бий болж байгаа компанид шилжинэ.
23.6.Компанийг өөрчлөх тохиолдолд холбогдох өөрчлөлтийг компанийн оноосон нэр болон дүрэмд тусгана.
55 дугаар зүйл.**Эд хөрөнгийн болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох**
55.1.Компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн /компанийн хувьцаа болон бусад үнэт цаасыг оролцуулан/ зах зээлийн үнэ гэж тухайн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, түүнийг худалдах үүрэг хүлээгээгүй худалдагч болон эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн үнийн талаар бүрэн мэдээлэлтэй, худалдан авах үүрэг хүлээгээгүй худалдан авагч хоёрын харилцан тохиролцсон үнийг хэлнэ.
55.2.Энэ хууль болон компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол компанийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/ тогтооно.



197
Огноо: 2018/04/16

хэлбэр өөрчлөгдөн хувьцаат компани болж Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК болон түүний хувьцаа эзэмшигчид үнэт цаасаа нийтэд чөлөөтэй арилжих, арилжихыг санал болгох эрхтэй гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Хөрөнгө оруулагч, хувьцаа худалдан авах сонирхолтой этгээдүүдэд уламжлах санамж**

Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрт агуулагдсан зохицуулалтын дагуу даатгалын үйл ажиллагаа нь санхүүгийн үйлчилгээний[2] төрөлд хамаарах бөгөөд даатгагч даатгалын үйлчилгээ, үйл ажиллагаа явуулахдаа Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авч, түүний хяналт[3] дор үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг онцлогтой байна. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Даатгалын тухай хуульд заасны дагуу компани[4] буюу ашгийн төлөө зохион байгуулагдсан хуулийн этгээдэд олгохоор хуульд заасан бөгөөд хариуцлагын хэлбэрийн хувьд олон нийтэд нээлттэй[5] буюу хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэхийг хориглосон зохицуулалт байхгүй. Иймд Мандал даатгал ХХК нь Компанийн тухай хуульд заасны дагуу хэлбэрээ өөрчилж хувьцаат компани болох, нийтэд үнэт цаасаа санал болгох боломжтой байна. Үнэт цаас гаргагч нь нэмж гаргасан хувьцаагаа нийтэд амжилттай санал болгосон тохиолдолд Монгол Улсын хэмжээнд анхдагч даатгалын үйлчилгээ үзүүлэгч хувьцаат компани болж байна.

Үнэт цаас гаргагч нь энгийн хувьцаагаа олон нийтэд санал болгосноор хөрөнгө оруулагч Та бүхэн үнэт цаасны зах зээлийн арилжаанд оролцож үнэт цаасыг худалдан авах эрх нээлттэй боловч даатгалын салбарын онцлог болон зохицуулалттай байгууллагын хяналттай хуулиар ногдуулсан дараах хориглолт, хязгаарлалтууд үйлчилдэг болохыг анхаарч судлан хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

Үүнд:

- Санхүүгийн зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран шууд буюу шууд бусаар эзэмших, өмчлөх;
- Даатгагчийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд буй хөрөнгийг Санхүүгийн зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад худалдах, шилжүүлэх, барьцаалах зэргээр захиран зарцуулах, эсхүл захиран зарцуулахыг бусдад зөвшөөрөх.

---

[2] Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005).
3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ
3.1 Энэ хуульд заасан санхүүгийн үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна:
3.1.3.даатгагчийн Даатгалын тухай хуульд заасан үйл ажиллагаа;
[3] Даатгалын тухай хууль (2004)
13 дугаар зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх
13.1.Зохицуулах хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
13.1.1.энэ хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан даатгагчийн даатгалын үйл ажиллагаанд хяналт тавих;
13.1.2.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;
13.1.3.даатгалын багц дүрмийг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих;
13.1.4.даатгалын дотоод, гадаад зах зээлийг судлах, даатгалын талаарх албан ёсны мэдээлэл гаргах;
13.1.5.даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчийн нэгдсэн бүртгэл хөтлөх;
13.1.6.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.
13.2.Зохицуулах хороо нь даатгагч дампуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийг хамгаалах зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлнэ.
[4] Даатгалын тухай хууль (2004 он)
4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
4.1.1."даатгалын үйл ажиллагаа" гэж даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагааг;
4.1.2."даатгагч" гэж энэ хуулийн дагуу даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанийг;
[5] Компанийн тухай хууль (2011)
3.7."Нээлттэй хувьцаат компани" гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, хувьцаа нь үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэгдэж, нийтэд чөлөөтэй арилжаалагддаг компанийг хэлнэ



198
Огноо: 2018/04/16

ЗХ
Үнэт цаасны зах зээлийн зохицуулалт
2019.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 19



МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

Товчхон дүгнэж хэлбэл хөрөнгө оруулах сонирхолтой этгээд нь үнэт цаасны анхдагч зах зээлийн болон хоёрдогч зах зээлийн арилжаанд оролцогч Мандал даатгал ХХК-ийн олон нийтэд санал болгож гүйлгээнд гаргасан энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авах, улмаар өмчлөлийн үнэт цаасаа цаашид захиран зарцуулах нөхцөлд салбарын зохицуулах байгууллага буюу Санхүүгийн зохицуулах хорооны бичгээр өгсөн зөвшөөрлийг заавал авах шаардлага үүсэж байгааг анхаарна уу.

Иймд хөрөнгө оруулахаар сонирхож буй Та бүхэн Үнэт цаас гаргагч болон түүний андеррайтер Голомт капитал ҮЦК ХХК-аас тодруулан лавлаж, хууль тогтоомжийн хязгаарлалтад өртөх эсэхээ тодорхойлж, нягталж шалгасны эцэст хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

**Товчилсон үгсийн товьёг**

Хуулийн дүгнэлт гаргахад ашигласан товчилсон үгсийг дараах утгаар ойлгож хэрэглэнэ үү. Үүнд:

Үсгийн дараалалаар:

| | |
|---|---|
| ААҮАТЗТХ | Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001) |
| АНУ | Америкийн нэгдсэн улс |
| АТҮТ | Автотээврийн Үндэсний Төв |
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| ДМОТХ | Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль (2004) |
| ДТХ | Даатгалын тухай хууль (2004) |
| ЗМС | Зээлийн мэдээллийн сан |
| ИХ | Иргэний хууль (2002) |
| КТХ | Компанийн тухай хууль (2011) |
| МХБ | Монголын хөрөнгийн бирж ТӨХК |
| НӨАТТХ | Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (2006) |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| СЗХЭБТХ | Санхүүгийн зохицуулах байгууллагын эрх зүйн байдлын тухай хууль (2005) |
| ТЕГ | Татварын ерөнхий газар |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ОӨУБЕГ | Оюуны өмч, Улсын бүртгэлийн ерөнхий газар |
| ҮЦЗЗТХ | Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013) |
| ХЭУБТХ | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2015) |
| ХЭХ | Хувьцаа эзэмшигчдийн хурал |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |

**Дүн шинжилгээ хийсэн арга, аргачлал**

Энэхүү дүн шинжилгээг Үйлчлүүлэгчтэй Гэрээгээр тохиролцсон асуудлын хүрээнд гаргаж өгөх зарчмыг баримталсан бөгөөд Үйлчлүүлэгчийн гаргаж өгсөн баримт материалд үндэслэсэн болно.

Дүн шинжилгээг хийхдээ хараат бус байх зарчмыг баримталж Хуулийн дүгнэлт гаргахад ашиглах эх сурвалжийг сонгохдоо хөндлөнгийн гуравдагч этгээдээс олгосон/тодорхойлсон тодорхойлолт, лавлагаа, баримт бичиг болон гуравдагч этгээдтэй байгуулсан, солилцсон зэргээр Үйлчлүүлэгчээс хараат бусаар баталгаажсан үйл баримтад үндэслэгдсэн байхыг удирдлага болгож ажилласан.

Хууль тогтоомжоор тодорхойлсон СЗХ-ны бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон СЗХ-оос зөвшөөрөл олгосон аливаа асуудлаар Хуулийн фирм дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргаагүй болохыг тусгайлан анхаарч Хуулийн дүгнэлтэд дурдагдаагүй нэмэлт мэдээлэл шаардлагатай нөхцөлд Үнэт цаас гаргагчаас лавлана уу.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
мандал даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489



МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК
199
Огноо: 2018/04/16

СЗХ
Үнэт цаасны 2018 он 08 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

НУУЦ БАРИМТ
Эх хувь

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

Хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээ, заалт, нөхцөл, журмыг тодорхойлж ойлгохдоо хууль зүйн ач холбогдол бүхий үг, үгс, утгыг Улсын Дээд шүүхийн гаргасан албан ёсны тайлбар, албан ёсны тайлбарт заасан утгын дагуу, албан ёсны тайлбар байхгүй нөхцөлд хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл тогтсон утга агуулгыг ашигласан бөгөөд ердийн хэрэглээний оноосон нэрийг тухайн үгийн хэлзүйн шууд утга агуулгаар ойлгон, ашиглаж тайлбарласан.

Үйлчлүүлэгчийн шилжүүлэн өгсөн цаасан болон электрон хэлбэртэй баримт бичигт агуулагдаж байгаа эх болон хуулбар баримт материал, тэдгээрт агуулагдаж байгаа мэдээлэл, хөндлөнгийн эрх бүхий байгууллагын гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолт, баримт бичиг, түүнд агуулагдсан мэдээ, мэдээлэл, баримт, үйл баримтыг үнэн, зөв, хууль ёсны, хүчин төгөлдөр гэж үзэж ашигласан.

Хуулийн фирм нь төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтод тусгагдсан оноосон нэр томьёонууд харилцан адилгүй тусгагдсан байсныг нэг ижил формат, стандартад оруулж илэрхийлсэн болохыг анхаарна уу.

**Хуулийн фирмийн мэдэгдэл**

Хуулийн фирм нь дүн шинжилгээг Үйлчлүүлэгчийн хүлээлгэн өгсөн баримт бичиг, материал, тэдгээрт агуулагдсан баримтат мэдээллийн хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд тэдгээр баримт бичгүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр, жинхэнэ эх эсхүл жинхэнэ эхээс хуулбарлагдсан гэж үзэж, ашигласан болно.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийсэн баримт бичиг бөгөөд Үйлчлүүлэгч, түүнээс хүлээн авсан бусад этгээдийн хувьд заавал дагаж мөрдөх, мөрдөхийг шаардах эрх, үүрэг, хариуцлага үүсгэхгүй, хууль зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлсэнд тооцогдохгүй.

Хуулийн дүгнэлтийг зөвхөн энд дурдагдсан зорилгоор хийсэн бөгөөд Үйлчлүүлэгч нь өөр бусад зорилгоор ашиглах, хэсэгчлэн болон бүхлээр нь нийтэд дэлгэх, түгээх болон Хуулийн дүгнэлтэд зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

Хуулийн дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд тухайн баримт бичиг, үйл баримтыг үнэлж, дүгнэсэн хугацаанаас хойш болон Хуулийн дүгнэлт гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон бол Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

Хуулийн фирм нь илэрхий үг үсэг, утга найруулгын зөрүүнээс бусдаар Мандал даатгал ХХК-ийн шилжүүлж өгсөн баримт бичгийн материалд агуулагдаж байгаа дараах асуудлыг үнэн зөв гэж үзэж дүгнэлт гаргасан болно. Үүнд:

- Баримт бичигт агуулагдсан хүсэл зориг, гол санаа, дурдсан/дурдагдсан асуудал нь үндэслэлтэй, үнэн зөв, хууль ёсны дагуу илэрхийлэгдсэн, хүчин төгөлдөр;
- Баримт бичгүүд нь цаг хугацаандаа үйлдэгдсэн, үнэн, зөв, бүрэн, гарын үсэг зурсан этгээд нь хуулийн дагуу албан ёсоор төлөөлөх эрхтэй;
- Хуулийн дүгнэлт гаргах иш үндэслэл болсон баримт материалд дурдагдсан нөхцөл байдал нь Хуулийн дүгнэлт гаргаснаас хойш эсхүл тухайн баримт бичгийг үйлдсэн огноо, хугацаанаас хойш өөрчлөгдөөгүй бөгөөд аливаа байдлаар талуудын эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйл явдал үүсээгүй;
- Аливаа дарагдсан тэмдэг (тамга) нь үнэн, зөв, жинхэнэ, эрх бүхий ашиглах эрхтэй этгээдийн зөвшөөрлөөр дарагдсан.

**Энэхүү Хуулийн дүгнэлт нь Мандал даатгал ХХК-ийн нийтэд санал болгосон үнэт цаасанд гаргасан аливаа төрлийн амлалт, баталгаанд тооцогдохгүй болохыг анхаарна уу.**

Үйлчлүүлэгчээс бичгээр тавьсан хүсэлтийн дагуу Хуулийн фирм нь шаардлагатай гэж үзсэн нөхцөлд Хуулийн дүгнэлтийн талаар гуравдагч этгээдэд нэмэлт тайлбар, тодруулга өгч болно. Хуулийн фирмийн зүгээс өгөх нэмэлт тайлбар, тодруулга нь Үйлчлүүлэгчийн зүгээс гаргасан ажлын даалгаварт тусгаснаас бусад асуудлаар нэмэлт дүн шинжилгээ хийх, тайлбар өгөх үүрэг үүсгэхгүй болно.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489
МОНГОЛ УЛС

СЗХ
2018 08 29
БҮРТГЭВ
НУУЦ БАРИМТ № 01
Эх хувь

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

Хуулийн фирм нь БДО Аудит ХХК-ийн Хөрөнгийн үнэлгээний тайланд тусгагдсан үл хөдлөх эд хөрөнгө, машин механизм, тээврийн хэрэгслийн өмчлөх эрхээс бусад эргэлтийн болон эргэлтийн бус хөдлөх хөрөнгүүдийн өмчлөх эрхийг баталгаажуулах асуудлаар дүн шинжилгээ хийгээгүйг анхаарна уу.

Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийхэд ашиглагдсан лавлагаа, тодорхойлолт, Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн гаргаж өгсөн аливаа баримт, материалд дурдагдсан үйл баримт, нөхцөл байдал Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөн аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй.

**Хууль тогтоомж, хэм хэмжээний акт**

Хуулийн дүгнэлт, дүн шинжилгээг хийхдээ дараах гол хууль тогтоомж, тэдгээрийг дагалдаж батлагдсан холбогдох хэм хэмжээний актуудыг удирдлага болголоо. Үүнд:

1. Компанийн тухай хууль (2011);
2. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль (2013);
3. Иргэний хууль (2002);
4. Даатгалын тухай хууль (2004);
5. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (2005);
6. Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам (2015);
7. Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам (2018).

**Дүн шинжилгээ, дүгнэлт**

Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийхэд шаардлагатай хөндлөнгийн лавлагаа, тодорхойлолтуудыг эрх бүхий байгууллагуудаас гаргуулан авч, Мандал даатгал ХХК-аас гаргаж өгсөн баримт материал, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд дүн шинжилгээ хийгээд дараах байдлаар дүгнэж үзэх үндэслэлтэй гэж үзлээ.

**Нэг. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх, улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх асуудлаар:**

Мандал даатгал ХХК нь анх "Мандал женерал" оноосон нэртэйгээр гадаадын хөрөнгө оруулалттай, хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдаж, 2011 оны 04 сарын 26-ны өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байна. Тус компанийг Канад улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан "Mongolia Growth Group Ltd"-ийн ТУЗ-ийн 2011 оны 04 сарын 07-ны өдрийн тогтоолын дагуу 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 25,000,000 (хорин таван сая) ширхэг зарласан энгийн хувьцаатайгаар байгуулсан байна. Анх байгуулагдах үед үүсгэн байгуулагч "Mongolia Growth Group Ltd" нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 25,000,000 (хорин таван сая) ширхэг зарласан энгийн хувьцаанаас 2,000,000 (хоёр сая) ширхэг энгийн хувьцааг 2,000,000,000 (хоёр тэрбум) төгрөгөөр гүйлгээнд гаргаж худалдаж авсан байна.

Тус гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуй нэгжийг тухайн үед Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байсан Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуульд заасны[6] дагуу Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын газрын даргын 2011 оны 04 сарын 21-ний өдрийн А-1539 тоот тушаалаар олгосон зөвшөөрлийн дагуу 1,640,002.95 америк долларын дүрмийн сантайгаар буюу гүйлгээнд гаргасан энгийн хувьцааны үнийн дүн болох 2,000,000,000 (хоёр тэрбум) төгрөгтэйгөөр байгуулахыг зөвшөөрсөн байна. СЗХ-ны 2011 оны 06 сарын 02-ны №146 тоот

[6] Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль (1993).
12 дугаар зүйл.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрөл олгох
12.1 Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж, гадаадын хуулийн этгээдийн төлөөлөгчийн газар байгуулах зөвшөөрлийг өргөдөл, холбогдох баримт бичгийг үндэслэн гадаадын хөрөнгө оруулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.
Тус хуулийг 2013 оны 10 сарын 3-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаасны танилцуулга
СЗХ
2019.08.29 В
№ 01
НУУЦ БАРИМТ
Эх хувь

МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
.... он .... сар .... өдөр
01

тогтоолоор Мандал женерал ХХК-д ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож "даатгал" гэсэн нэр, нэршлийг оноосон нэрийн хамт ашиглахыг зөвшөөрсөн байна[7].

Улмаар Мандал женерал ХХК-ийн ТУЗ-ийн 2011 оны 06 сарын 21-ний өдрийн тогтоолын дагуу Мандал женерал ХХК-ийн оноосон нэрийн хойно даатгал гэсэн нэр нэмж Мандал женерал даатгал ХХК болгон өөрчлөх болон хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ 4,243,016 (дөрвөн сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) ширхэг энгийн хувьцаа болгон гүйлгээнд гаргасан энгийн хувьцааны тоог нийт 6,243,016 (зургаан сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) ширхэг энгийн хувьцаатай байхаар тогтоож хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 6,243,016,000 (зургаан тэрбум хоёр зуун дөчин гурван сая арван зургаан мянган) төгрөг болгосон байна. Мөн Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалтын газрын даргын 2011 оны 07 сарын 07-ны өдрийн А-2715 тоот тушаалын дагуу Мандал женерал ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 6,243,016,000 (зургаан тэрбум хоёр зуун дөчин гурван сая арван зургаан мянган) төгрөг болгохыг зөвшөөрсөн байна. ДТХ-ийн дагуу даатгагч нь өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх болон багасгах үр дагаварт хүргэх хувьцаа гаргах, хуваарилах, хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувийг бууруулах буюу нэмэгдүүлэх үр дагаварт хүргэх хэлцэл хийхдээ СЗХ-ны зөвшөөрлийг авах зохицуулалттай байдаг[8]. Мандал даатгал ХХК-ийн гаргасан бүх хувьцааг "Mongolia Growth Group Ltd" эзэмшиж байх үед СЗХ-ны 2012 оны 04 сарын 18-ний өдрийн №93 тоот тогтоолын дагуу Үнэт цаас гаргагч нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгөөр бууруулж, мөн оны СЗХ-ны №397 тоот тогтоолын дагуу эргүүлэн 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөгөөр нэмэгдүүлж байсан байна.

Үүнээс хойш "Mongolia Growth Group Ltd"-ийн ТУЗ-ийн 2013 оны 11 сарын 06-ны өдрийн тогтоолын дагуу тус компани өөрийн өмчлөлийн Мандал женерал даатгал ХХК-ийн 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ 1,243,016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) ширхэг энгийн хувьцааг эргүүлэн худалдаж авч халаасны хувьцаагаар бүртгэхээр шийдсэн байна. Тус өөрчлөлтийг СЗХ-ны 2013 оны 11 сарын 06-ны өдрийн №449 тоот тогтоолоор бүртгэж, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн байна.

Мөн "Mongolia Growth Group Ltd"-ийн ТУЗ-ийн 2013 оны 09 сарын 27-ны өдрийн тогтоолоор өөрийн өмчлөлийн Мандал женерал даатгал ХХК-ийн 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 5,000,000 (таван сая) ширхэг энгийн хувьцааг Юу Эм Си Капитал ХХК-д худалдахаар шийдвэрлэсэн байна. Тус өөрчлөлтийг СЗХ-ны 2013 оны 11 сарын 13-ны өдрийн №455 тоот тогтоолоор бүртгэж, өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн байна.

Үүний үр дүнд Юу Эм Си капитал ХХК нь Мандал даатгал ХХК-ийн эцсийн эзэмшигч буюу нийт гүйлгээнд гаргасан энгийн хувьцааны 100% өмчлөгч, эзэмшигч болсон байна. Улмаар Юу Эм Си Капитал ХХК нь өөрийн өмчлөлд байгаа Мандал даатгал ХХК-ийн 5,000,000 (таван сая) ширхэг энгийн хувьцаанаас 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 2,550,000 (хоёр сая таван зуун тавин мянган) ширхэг энгийн хувьцааг Голомт файнэншил групп ХХК-д худалдахаар шийдвэрлэсэн байх бөгөөд тус хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлтийг СЗХ-ны 2014 оны 10 сарын 21-ний өдрийн №390 тоот тогтоолоор бүртгэхийг зөвшөөрсөн байна.

Мандал даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигчид болох Юу Эм Си капитал ХХК, Голомт файнэншил групп ХХК нар нь 2014 оны 10 сарын 08-ны өдөр хувьцааг захиран зарцуулах болон бизнесийн үйл ажиллагаатай холбоотойгоор Хувьцаа эзэмшигчдийн гэрээ байгуулсан байна. Тус гэрээний талаар Хуулийн фирм тодруулж лавласан бөгөөд хувьцаа эзэмшигчид нийтэд санал

[7] Даатгалын тухай хууль (2004).
60 дугаар зүйл. "Даатгал" гэсэн нэр томьёог хэрэглэхийг хязгаарлах
60.1.Даатгагч нь оноосон нэртэй байх бөгөөд уг нэрийн ард "даатгал" гэсэн үгийг заавал хэрэглэнэ.
8 Даатгалын тухай хууль
21 дүгээр зүйл. Даатгагч хөрөнгөө шилжүүлэхэд тавих хяналт
21.3.Даатгагч өөрийн эзэмшил, өмчлөлд буй энэ хуулийн 21.1-д заасан хөрөнгийн талаар Зохицуулах хорооноос бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр дараах үйлдэл хийхийг хориглоно:
21.3.2.өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх болон багасгах үр дагаварт хүргэх хувьцаа гаргах, хуваарилах, хувьцаа эзэмшигчдийн эзлэх хувийг бууруулах буюу нэмэгдүүлэх үр дагаварт хүргэх хэлцэл хийх.



МАНДАЛ ДААТГАЛ
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

202
Огноо: 2018/04/16

болгох үнэт цаасыг амжилттай арилжаалагдсаны дараа дурдсан Хувьцаа эзэмшигчдийн гэрээг хүчингүй болгож, шаардлагатай заалтуудыг дүрмийн төсөлд оруулахаар тохиролцсон талаар мэдээлэл өгсөн болно.

Өнөөдрийн байдлаар Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК нь 2 (хоёр) хувьцаа эзэмшигчтэй бөгөөд 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 25,000,000 (хорин таван сая) ширхэг зарласан хувьцаатай, үүнээс 5,000,000 (таван сая) ширхэг энгийн хувьцааг гүйлгээнд гаргасан, нийт 1,243,016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) ширхэг халаасны хувьцаагаар бүртгэсэн байна.

ОӨУБЕГ-ын ХЭУБГ-ын Улсын бүртгэлийн төв архивын газрын 2018 оны 02 сарын 28-ны өдрийн №002845643 тоот Дэлгэрэнгүй лавлагаанаас харвал тус хуулийн этгээдийг 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 1,243,016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) ширхэг халаасны хувьцаатай болохыг тодорхойлсон байна.

СЗХ-ны 2018 оны 03 сарын 15-ны өдрийн №6/1009 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл Мандал даатгал ХХК нь Юу Эм Си капитал ХХК, Голомт файнэншил групп ХХК гэсэн 2 хувьцаа эзэмшигчтэй, 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 5,000,000 (таван сая) ширхэг буюу 5,000,000,000 (таван тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ 1,243,016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) ширхэг бүхий халаасны хувьцаатай болохыг тодорхойлсон байна.

Харин Мандал даатгал ХХК-ийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 6,243,016.000 (зургаан тэрбум хоёр зуун дөчин гурван сая арван зургаан мянган) төгрөг гэж бүртгэсэн байна. Мөн Мандал даатгал ХХК-ийн эзэмшиж байгаа 2/21 тоот даатгалын үйл ажиллагаа эрхлэх Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 6,243,016,000 (зургаан тэрбум хоёр зуун дөчин гурван сая арван зургаан мянган) төгрөг гэж бүртгэсэн байх бөгөөд 2012 оноос хойш шинэчлэл хийгдээгүй байна.

Халаасны хувьцааны хувьд тодруулж дурдахад Мандал даатгал ХХК-ийн үүсгэн байгуулах гол баримт бичиг болох (шинэчилсэн) дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3.3 дахь заалтаас үзвэл Мандал даатгал ХХК нь нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн үнэтэй 1,243,016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) ширхэг энгийн хувьцааг эргүүлэн худалдаж авч халаасалсан болохыг тодорхой дурдсан байна. КТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт[9] заасны дагуу халаасны хувьцаа нь компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд хамаардаггүй. Иймд СЗХ-ны олгосон Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ болон улсын бүртгэлийн байгууллагаас олгосон гэрчилгээ, баримт бичигт төрийн эрх бүхий байгууллагуудаас тусгасан зөрүүтэй мэдээлэл, техникийн алдааг тухайн төрийн эрх бүхий байгууллагуудад эргүүлэн хандаж, залруулж авахыг зөвлөж байна.

Эдгээр хувь нийлүүлсэн хөрөнгөтэй холбоотойгоор гаргасан өөрчлөлт хийх үндэслэл болсон тогтоол, шийдвэр, тухай бүр батлагдсан шинэчилсэн дүрэм нь холбогдох хуульд нийцсэн, бичгээр байгуулагдаж гарын үсэг зурах эрхтэй этгээдүүд баталсан, хүчин төгөлдөр байх бөгөөд тухай бүр бүртгэлийн байгууллагад бүртгүүлж байсан байна.

Тус хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхийг Гүйцэтгэх захирал Батсайханы Жавхланд олгосон байх бөгөөд уг бүртгэлийг 2016 оны 11 сарын 15-ны өдөр улсын бүртгэлийн байгууллагаас Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд бүртгэж, өөрчлөлт оруулсан байна.

Тус хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах хууль ёсны хаягийг Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, нарны зам, норт спринг капитал блү барилга, 2

[9] Компанийн тухай хууль (2011).
30 дугаар зүйл.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон өөрийн хөрөнгө
30.1.Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489
МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК
Огноо: 2018/04/16
203

болон 4 дугээр давхар гэж бүртгэсэн байна. Үнэт цаас гаргагчийн ХЭХ-ын 2016 оны 04 сарын 14-ний өдрийн №16/001 тоот тогтоолын дагуу үйл ажиллагаа эрхлэх, удирдах газар байрлах хаягийг Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Нарны зам 87, НСКБ барилга 2,4 давхар болгон өөрчлөхөөр шийдвэрлэсэн байна. Тус өөрчлөлтийг СЗХ-нд 2016 оны 05 сарын 02-ны өдөр хандаж Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тэмдэглэл хийлгүүлсэн бөгөөд улсын бүртгэлийн байгууллагад хандаж өөрчлөлт хийлгүүлсэн байна.

СЗХ-ны 2012 оны 12 сарын 12-ны өдрийн №355 тоот тогтоолын дагуу ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх компанийн дүрмийн сангийн доод хэмжээг 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг байхаар тогтоосон байх бөгөөд Мандал даатгал ХХК нь тус шаардлагыг хангасан байна.

Үнэт цаас гаргагчийн ХЭХ-ын 2016 оны 07 сарын 08-ны өдрийн №16/002 тоот тогтоолын дагуу "Мандал женерал даатгал" ХХК-ийн оноосон нэрийг "Мандал даатгал" ХХК болгон өөрчлөхөөр шийдвэрлэсэн байна. СЗХ-ны 2017 оны 01 сарын 03-ний өдрийн №10 тоот тогтоолоор оноосон нэр "Мандал женерал даатгал" ХХК байсныг "Мандал даатгал" ХХК болгон өөрчлөхийг зөвшөөрсөн байна. Тус өөрчлөлтийг 2017 оны 01 сарын 27-ны өдөр бүртгэлийн байгууллагад хандаж, холбогдох өөрчлөлтийг бүртгүүлэн, улсын бүртгэлийн гэрчилгээг дахин авсан байна.

ХЭУБТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтад компани, түүний салбар, төлөөлөгчийн газрыг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг хуульчилсан байна. Мөн ДТХ-ийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт "Даатгагч нь өөрийн салбар, төлөөлөгчийн газраа гадаад улсын нутаг дэвсгэрт нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулахдаа Зохицуулах хорооноос бичгээр зөвшөөрөл авна" гэж заасан байна.

СЗХ-ны 2018 оны 03 сарын 15-ны өдрийн №6/1009 тоот Хариу хүргүүлэх тухай албан тоотоос үзвэл Мандал даатгал ХХК нь 4 салбарын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн байна.

Эдгээр салбарын мэдээллүүдийг гаргуулж үзвэл ОӨУБЕГ-ын ХЭУБГ-аас Мандал даатгал ХХК-ийн Дархан-Уул аймаг дах салбарыг 2014 оны 05 сарын 06-ны өдөр бүртгэж №0001957 тоот Салбарын гэрчилгээ олгосон байна.

СЗХ-оос тус хорооны даргын 2014 оны 03 сарын 31-ний өдрийн №80 тоот тогтоолыг үндэслэн Мандал даатгал ХХК-ийн Дархан-Уул аймаг дах салбарыг байгуулахыг зөвшөөрч 2014 оны 03 сарын 31-ний өдөр №2/21/04 тоот Даатгалын байгууллагын нэгжийн гэрчилгээ олгосон байна.

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2017 оны 04 сарын 21-ний өдрийн №17/004 тоот тогтоолын дагуу Орхон аймагт салбар байгуулахаар шийдвэрлэсэн байна.

ОӨУБЕГ-ын ХЭУБГ-аас Мандал даатгал ХХК-ийн Орхон аймаг дахь салбарыг 2017 оны 09 сарын 18-ны өдөр бүртгэж №000004262 тоот Салбарын гэрчилгээ олгосон байна.

СЗХ-оос тус хорооны даргын 2017 оны 08 сарын 29-ний өдрийн №397 тоот тогтоолыг үндэслэн Мандал даатгал ХХК-ийн Орхон аймаг дахь салбарыг байгуулахыг зөвшөөрч 2017 оны 08 сарын 29-ний өдөр №2/21/05 тоот Даатгалын байгууллагын нэгжийн гэрчилгээ олгосон байна.

ОӨУБЕГ-ын ХЭУБГ-аас Мандал даатгал ХХК-ийн Өмнөговь аймаг дахь салбарыг 2012 оны 06 сарын 06-ны өдөр бүртгэж №0000786 тоот Салбарын гэрчилгээ олгосон байна.

СЗХ-оос тус хорооны даргын 2012 оны 05 сарын 22-ны өдрийн №117 тоот тогтоолыг үндэслэн Мандал даатгал ХХК-ийн Өмнөговь аймаг дахь салбарыг байгуулахыг зөвшөөрч 2012 оны 05 сарын 22-ны өдөр №2/21/3 тоот Даатгалын байгууллагын нэгжийн гэрчилгээ олгосон байна.

Эдгээр салбаруудын дүрэм болон итгэмжлэлээр төлөөлөх эрхтэй этгээдийг тогтоосон тогтоолыг Хуулийн фирм хүлээн авч дүн шинжилгээ хийсэн бөгөөд хуульд заасны дагуу үйлдэж бүртгүүлсэн, удирдах эрхтэй этгээдийг тэмдэглүүлсэн, хуулийн дагуу хүчин төгөлдөр байна гэж үзлээ.

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
2019 оны 29
БҮРТГЭВ
№ 01
НУУЦ БАРИМТ
Эх хувь

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 02 сарын 01-ний №17/001 тоот тогтоолын дагуу 2017 оны 02 сарын 01-ний өдрөөс эхлэн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4-р хороо, 1-р өөчин мянгат, 62-09 тоот хаягт байрлах салбарыг татан буулгахаар шийдвэрлэсэн байна. Тус татан буугдсан өөрчлөлтийг СЗХ-нд хандаж Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад бичигдсэн тэмдэглэлд холбогдох өөрчлөлт хийлгүүлэхийг зөвлөж байна.

Нэгтгэж үзвэл хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичиг, **бүртгэлийн байгууллагад орсон эдгээр өөрчлөлтүүд нь холбогдох хуулийн дагуу хийгдсэн, тус компани нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж улсын бүртгэлд бүртгүүлсэн байх бөгөөд Мандал даатгал ХХК, түүний салбарууд нь улсын бүртгэлийн байгууллагад зохих ёсоор бүртгүүлж гэрчилгээ авсан, аливаа бүртгэлийн зөрчилгүй байна.**

ТЕГ-ын цахим сангаас гаргаж өгсөн №1803220588017 тоот Тодорхойлолтоос үзвэл Мандал даатгал ХХК нь татварын өр төлбөрийн үлдэгдэлгүй байна. Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу даатгал, давхар даатгалын үйлчилгээ нь нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгддөг[10] болохыг энд дурдах нь зүйтэй гэж үзлээ.

Сүхбаатар дүүргийн Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтсийн 2018 оны 02 сарын 27-ны өдрийн №267 тоот албан бичгээс үзвэл Мандал даатгал ХХК нь тус хэлтэст бүртгэлтэй бөгөөд 2018 оны 02 сарын 27-ны өдрийн байдлаар өр төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

**Мандал даатгал ХХК нь татварын болон нийгмийн даатгалын шимтгэл, өр төлбөрийн аливаа үлдэгдэлгүй, зөрчилгүй, зохих ёсоор бүртгэгдсэн байна гэж үзлээ.**

**Хоёр. Компанийн дүрэм, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод журмууд нь хууль тогтоомж, Хорооноос баталсан "Монголын компанийн засаглал кодекс"-т нийцсэн эсэх асуудлаар:**

Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК нь Хуулийн дүгнэлт гаргахад зориулж дотооддоо мөрдөгдөж буй нийт 32 (гучин хоёр) дүрэм, журмыг Хуулийн фирмд ирүүлсэн. Нийт дүрэм журмын дэлгэрэнгүй мэдээллийг ***Хавсралт №1. "Мандал даатгал ХХК-ийн хүчин төгөлдөр дүрэм, журмын мэдээлэл"*** хүснэгтээс дэлгэрүүлэн үзэж танилцана уу.

Хуулийн фирм нь ирүүлсэн дүрэм, журамтай танилцаж Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаагаа тогтвортой эрхлэхэд нөлөөлөх дараах 12 (арван хоёр) төрлийн дүрэм, журмыг даатгалын үйл ажиллагаа болон засаглалын үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой гэж үзэж, түүвэрлэн авч холбогдох хууль тогтоомж, СЗХ-оос батлан гаргасан Компанийн засаглалын кодекс, Даатгалын багц дүрэмд нийцэж буй эсэхэд дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

1. Мандал даатгал ХХК-ийн дүрэм;
2. Мандал даатгал ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журам;
3. Мандал даатгал ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх "Аудит, эрсдэлийн хорооны ажиллах журам";
4. Хороодын ажиллах журам;
5. Хөдөлмөрийн дотоод журам;
6. Даатгалын үйл ажиллагааны журам;
7. Давхар даатгалын журам;
8. Актуарын журам;
9. Даатгалын нөхөн төлбөрийг шийдвэрлэх үйл ажиллагааны журам;
10. Гэрээт баталгааны журам;
11. Даатгалын гэрээт баталгаа цуцлах тухай журам;
12. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлого, журам.

---

[10] Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (2006).
13 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх.
13.6.Дараах үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө:
13.6.3.даатгал, давхар даатгал, эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээ;

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5472489



МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК
1117235573 5481589

205
Огноо: 2018/04/16

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
2018 он 08 сар 29 өдөр
№ 01
НУУЦ БАРИМТ
Эх хувь

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
....... он .... сар .... өдөр

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал гэж үзсэн дээр дурдсан дүрэм, журмын хүрээнд дүн шинжилгээ хийхэд Мандал даатгал ХХК нь хөдөлмөрийн дотоод журмаараа ажилчидтай 1 (нэг) жилийн хугацаатай хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилладаг байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1 дэх заалтад заасан "Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээг хугацаагүйгээр байгуулна" гэсэн заалттай уялдахгүй байх тул цаашид ажилтан, ажилчдын тогтвортой байдлыг хангах үүднээс хөдөлмөрийн гэрээгээ хугацаагүй нөхцөлөөр байгуулж ажиллахыг санал болгож байна.

Мөн Компанийн засаглалын кодексын 2 дугаар зүйлийн 2.2.5.в дэх дэд заалтад "Компани ямар төрлийн мэдээллийг нийтэд тогтмол болон тухай бүр хүргэх, түүнтэй холбогдон гарах харилцааг зохицуулсан мэдээллийн үйл ажиллагааны журмыг боловсруулан төлөөлөн удирдах зөвлөл батлан мөрдүүлдэг байх ёстой", 5.8.1 дэх заалтад "Компани нь компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл ба сонирхлыг зөрчлийг зохицуулах бодлоготой байна, ТУЗ-ийн ёс зүйн кодекстой байна", 7.2.3 дэх заалтад "Компани нь хөндлөнгийн аудитыг томилох үйл ажиллагааг зохицуулсан дотоод журамтай байна", 7.3.1 дэх заалтад "ТУЗ холбогдох этгээдийг компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангах журамтай байна" гэж заасныг үндэслэл болгон сонирхлын зөрчлийг зохицуулах асуудлаар холбогдох дүрэм, журмыг анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдсаны дараа даатгалын үйл ажиллагаа эрхлэгч хувьцаат компани болохын хувьд баталж ажиллахыг зөвлөж байна.

**Нэгтгэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дурдсан дүрэм журмууд нь хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзлээ.**

Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК нь Компанийн засаглалтын кодекс болон хууль тогтоомжид нийцүүлэн дараах журмуудын төслийг бэлтгэж Хуулийн фирмд ирүүлсэн. Үүнд:

1. Мандал даатгал ХК-ийн дүрмийн төсөл;
2. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зарлан хуралдуулах журмын төсөл;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын төсөл;
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны журмын төсөл;
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны журмын төсөл;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх цалин, урамшууллын хорооны журмын төсөл.

Эдгээр баримт бичгийн төслүүдийг СЗХ-ны баталсан үлгэрчилсэн дүрэм, журам, Компанийн засаглалын кодекс зэрэг баримт бичигт үндэслэсэн загварт тулгуурлан хийгдсэн, КТХ болон Компанийн засаглалын кодекс, холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн эрх зүйн баримт бичиг байна гэж үзлээ. Мөн баримт бичгүүдээ даатгалын салбарын болон өөрийн бизнесийн онцлогийг хууль тогтоомжоор зөвшөөрсөн хэмжээнд нэмж тусган батлах боломжтой болохыг Үнэт цаас гаргагчид уламжилж байна.

**Гурав. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын асуудлаар:**

**Төлөөлөн удирдах зөвлөл**

Мандал даатгал ХХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт ТУЗ нь таван (5) гишүүнтэй байх бөгөөд эдгээрийн нэг нь хараат бус гишүүн байхаар заажээ. Энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар тус компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр Ө.Ганзориг, О.Ганжолоо, Н.Монсор, А.Амундра нар, хараат бус гишүүнээр АНУ-ын иргэн Жим Двайер /Jim Dwyer/ нар томилогдон ажиллаж байна.

СЗХ-ны 2016 оны 03 сарын 04-ний өдрийн №48 тоот тогтоолоор батлагдсан "Даатгал түүнтэй холбогдох үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтийг тодорхойлох журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1.13 дахь заалтад даатгалын компани нь хамгийн багадаа нэг буюу түүнээс дээш тооны хараат бус, нийт 5-аас доошгүй гишүүдийн бүрэлдэхүүнтэй ТУЗ-тай байх шалгуур үзүүлэлтийг тогтоосон байх бөгөөд Үнэт цаас гаргагч



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн бүрэлдэхүүний мэдээлэлд үндэслэн тус журмын шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

Мөн тус журмын 5 дугаар зүйлийн 5.1.14 дэх заалтад ТУЗ-ийн гишүүд нь КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.8-д заасны дагуу компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх, 5.1.15 дахь заалтад даатгагч нь Компанийн засаглалын кодексыг үйл ажиллагаандаа заавал дагаж мөрдөж байхаар тогтоосон байна. Үүнээс гадна эдгээр шаардлага хангасан этгээдийг даатгагчаас ТУЗ-ийн гишүүнээр томилохдоо ДТХ-ийн 55 дугаар зүйлийн 55.1 дэх хэсэгт заасны дагуу заавал урьдчилан СЗХ-оос бичгээр зөвшөөрөл авахаар хуульчилсан байна. Хуулийн фирм нь эдгээр шаардлагын хүрээнд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн гишүүдийн намтар, удирдлага, ур чадварын байдал, СЗХ-оос зөвшөөрөл олгогдсон эсэх зэрэг мэдээллийг дэлгэрүүлэн авч үзлээ.

Ердийн гишүүд:

**Ө.Ганзориг** нь санхүүч, нягтлан бодогч мэргэжилтэй, Юу Эм Си Холдинг ХХК-ийн Ерөнхийлөгч бөгөөд Голомт банкны Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Хувьцаа эзэмшигч Юу Эм Си Капитал ХХК-ийн ТУЗ-ийн 2013 оны 12 сарын 03-ны өдрийн №13/009 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн даргаар томилогдсон. Мөн Мандал даатгал ХХК-ийн ээлжит бус ХЭХ-ын 2015 оны 01 сарын 21-ний өдрийн №15/001 тоот тогтоолоор ТУЗ-ийн даргаар дахин томилогдон ажиллаж байна. СЗХ-ны 2014 оны 06 сарын 25-ны өдрийн №239 тоот тогтоолоор эрх бүхий албан тушаалтнаар буюу Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн даргаар Ө.Ганзоригийг томилох зөвшөөрлийг олгосон байна. Ө.Ганзориг нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад 2013 оны 04 сарын 25-26-ны өдрүүдэд хамрагдаж гэрчилгээ авсан байна.

**О.Ганжолоо** нь эдийн засагч мэргэжилтэй, Голомт файнэншил групп ХХК-ийн Захирал бөгөөд ээлжит бус ХЭХ-ын 2015 оны 01 сарын 21-ний өдрийн хурлын №15/001 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр дахин томилогдон ажиллаж байна. СЗХ-ны 2015 оны 01 сарын 21-ний өдрийн №41 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр О.Ганжолоог томилох зөвшөөрлийг олгосон байна. О.Ганжолоо нь "Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан Компанийн засаглалын 36 цагийн сургалтад 2014 оны 11 сард хамрагдаж №0130284 дугаартай гэрчилгээ авсан байна.

**Н.Монсор** нь компьютер, програм хангамжийн мэргэжилтэй, Юу Эм Си Альфа ХХК-ийн Гүйцэтгэх захирал бөгөөд Мандал даатгал ХХК-ийн 2016 оны 07 сарын 09-ний өдрийн ХЭХ-ын №16/003 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр дахин томилогдсон бөгөөд СЗХ-ны 2014 оны 06 сарын 25-ны өдрийн №239 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр Н.Монсорыг томилох зөвшөөрөл олгогдож байсан. Н.Монсор нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан Компанийн засаглалын 36 цагийн сургалтад 2014 оны 06 сард хамрагдаж №0130207 дугаартай гэрчилгээ авсан байна.

**А.Амундра** нь Хуулийн дүгнэлт гаргаж өгөх өдрийн байдлаар ТУЗ-ийн ердийн гишүүний үүргийг гүйцэтгэж байна. Мандал даатгал ХХК-ийн ээлжит ХЭХ-ын 2018 оны 02 сарын 23-ны өдрийн №18/001 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр 1 (нэг) жилийн хугацаагаар томилогдсон. СЗХ-нд бүртгүүлэхээр холбогдох баримт материалыг 2018 оны 03 сарын 19-ны өдөр хүргүүлсэн бөгөөд Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар СЗХ-ны зүгээс эрх бүхий албан тушаалтнаар томилох этгээд мөн эсэх асуудлаар хараахан хариу гаргаагүй байна. А.Амундра нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан Компанийн засаглалын богино хугацаат сургалтад 2018 оны 03 сард хамрагдаж №0130907 дугаартай гэрчилгээ авсан байна.

Хараат бус гишүүд:

**Жим Двайер** нь АНУ-ын иргэн бөгөөд бизнесийн удирдлагын мэргэжилтэй. Монголын бизнесийн зөвлөлийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Хувьцаа эзэмшигч Юу Эм Си Капитал ХХК-ийн ТУЗ-ийн 2013 оны 12 сарын 03-ны өдрийн №13/009 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдсон. Мандал даатгал ХХК-ийн ээлжит бус ХЭХ-ын 2015 оны 01 сарын 21-ний өдрийн №15/001 тоот тогтоолоор ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдсон. СЗХ-ны 2014 оны 06 сарын 25-ны өдрийн №239 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр Жим Двайерыг томилох зөвшөөрлийг олгосон байна. Тэрээр 2013 оноос тогтвортой ажиллаж байгаа бөгөөд одоо ТУЗ-ийн дэргэдэх Гүйцэтгэлийн үнэлгээний хорооны даргаар ажилладаг. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, 2012 оны 05 сарын 23-ны өдөр гэрчилгээ авсан байна.



207
Огноо: 2018/04/16

Үнэт цаасны хяналт СЗХ
2018 08 29
НУУЦ БАРИМТ Э В
Эх хувь 01

МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

ТУЗ-ийн нарийн бичиг

З. Одмаа нь 2011 оноос Мандал даатгал ХХК-ийн Маркетингийн менежерээр ажилласан бөгөөд Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн № 17/003 тоот тогтоолын дагуу ТУЗ-ийн Нарийн бичгийн даргаар томилогдсон. СЗХ-ны 2017 оны 05 сарын 31-ний өдрийн №308 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар З.Одмааг томилох зөвшөөрлийг олгосон байна. З.Одмаа нь "Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан Компанийн засаглалын 36 цагийн сургалтад 2017 оны 4 дүгээр сард хамрагдаж №0130770 дугаартай гэрчилгээ авсан байна.

Бусад эрх бүхий албан тушаалтнууд

КТХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж хуульчилсан байдаг бөгөөд хуулийн этгээд өөрийн үүсгэн байгуулах баримт бичиг буюу дүрмээрээ илүү нарийвчлан тодорхойлох, эсхүл албан тушаалаар нэр заан тодорхойлох боломжийг олгосон байдаг. Мандал даатгал ХХК-ийн дүрмийн Хавсралт А-д тодорхойлсноор "Эрх бүхий этгээд гэж хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (хэрэв байгаа бол) зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээд"-г ойлгоно гэж заажээ.

Тус компанийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 01 сарын 05-ны өдрийн HR/18/003 тоот тушаалаар Компанийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталсан байна. Эдгээр баримт, материалаас үзвэл дараах эрх бүхий албан тушаалтнууд ажиллаж байна гэж үзэх үндэслэлтэй байна:

1. Б. Жавхлан нь 2011 оноос Мандал женерал даатгал ХХК-ийн Иргэд хариуцсан захирал, 2014-2015 онд Бүтээгдэхүүн суваг хөгжүүлэлтийн алба хариуцсан захирал, 2015-2016 онд Бизнес хөгжил хариуцсан Дэд ерөнхийлөгч, 2016 онд Гүйцэтгэх захирлын орлогчоор тус тус ажилласан бөгөөд ТУЗ-ийн 2016 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн №16/003 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирлаар томилогдож одоог хүртэл ажиллаж байна. СЗХ-ны даргын 2016 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн №255 тоот тушаалаар Мандал даатгал ХХК-ийн гүйцэтгэх захирлын албан тушаалд Б.Жавхланг томилох зөвшөөрлийн олгосон байна.
2. Г. Баярцэцэг нь 2013 оноос Мандал даатгал ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байна. СЗХ-ны 2015 оны 01 сарын 21-ний өдрийн №41 тоот тогтоолоор Мандал даатгал ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч албан тушаалд Г.Баярцэцэгийг томилох зөвшөөрлийг олгосон байна. Г.Баярцэцэг нь "Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан Компанийн засаглалын 36 цагийн сургалтад 2016 оны 04 сард хамрагдаж №0520331 дугаартай гэрчилгээ авсан байна.
3. М.Баярбахдал нь бизнесийн удирдлагын мэргэжилтэй, 2014 оны 06 сараас Мандал даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирлын зөвлөхөөр ажиллаж эхэлсэн бөгөөд Мандал даатгал ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 01 сарын 14-ний өдрийн №15/012HR тоот тушаалаар Мандал даатгал ХХК-ийн Ерөнхийлөгчөөр томилогдон ажиллаж байна. М.Баярбахдалыг өмнө нь СЗХ-ны 2014 оны 06 сарын 25-ны өдөр №239 тоот тогтоолын дагуу тохиромжтой этгээд болохыг тогтоож ТУЗ-ийн гишүүнээр томилох зөвшөөрөл олгож байсан байна. М.Баярбахдал нь "Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, нарийн бичгийн дарга" нарт зориулсан Компанийн засаглалын 36 цагийн сургалтад 2014 оны 6 дугаар сард хамрагдаж №0130192 дугаартай гэрчилгээ авсан байна.

КТХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.3 дахь хэсэгт "... (i) төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг; (ii) ял шийтгэл эдэлж байгаа этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглоно", Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.2.1 дэх хэсэгт "ТУЗ-ийн гишүүнээр аудит



МАНДАЛ даатгал ХХК
УЛААНБААТАР ХОТ
GOLOMT CAPITAL LLC
208
Огноо: 2018/04/16

Үнэт цаасны хороо СЗХ
2018 оны 08 сар 29 өдөр
БҮРТГЭВ
НУУЦ БАРИМТ № 01

эсвэл нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн дадлага, туршлага бүхий хувь хүнийг сонгон ажиллуулах нь зүйтэй" гэж тус тус нарийвчлан зохицуулсан байна. Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн №А/195 тоот тушаалаар "Мэдээллийн санд мэдээлэл цуглуулах, шалгах, шинжлэн үнэлэх, ашиглах, шилжүүлэх, хүлээн авах, хуваарилах, үр дүнг тооцох, лавлагаа өгөх журам"-ыг баталсан байна. Тус журмын дагуу Хуулийн фирм нь Мандал даатгал ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нь гэмт хэрэгт холбогдож байсан эсэх асуудлаар төрийн эрх бүхий байгууллагаас хөндлөнгийн лавлагаа, тодорхойлолт авах боломжгүй болсон байх тул уг шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүгнэлт гаргаагүй болохыг анхаарна уу.

**Хуулийн фирм нь Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд, бусад дурдагдсан эрх бүхий албан тушаалтнуудын гаргаж өгсөн анкет, хувийн мэдээлэлд үндэслэн эдгээр албан тушаалтнууд нь хуульд заасан шаардлага хангасан, удирдах албан тушаал эрхлэх, мэдлэг боловсролтой, чадвар, дадлага, туршлагын байдал хангалттай гэж үзэх үндэслэлтэй байна гэж дүгнэлээ.**

**Дөрөв. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт[11] нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд сүүлийн 3 жил буюу 2015 оны 03 сарын 01-ний өдрөөс 2018 оны 03 сарын 01-ний өдрөөр тасалбар болгон Үнэт цаас гаргагчийн бусадтай[12] бичгээр байгуулсан гэрээ, хэлцлүүдийг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээ, хэлцлүүдийг сонгон авч дүн шинжилгээ хийлээ.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримтаас үзвэл дурдсан хугацаанд нийт 234,495 (хоёр зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун ерэн таван) гэрээ, хэлцлийг байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 72,325 (далан хоёр мянга гурван зуун хорин таван) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Хүснэгт №1: Сүүлийн 3 жил дотор бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийн нийт тоон үзүүлэлт.

| № | Он | 2015.03.01-2015.12.31 | 2016 он | 2017 он | 2018.01.01-2018.03.01 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хүчин төгөлдөр гэрээ, хэлцэл | 468 | 1,703 | 57,580 | 12,574 | 72,325 |
| 2. | Дуусгавар болсон гэрээ, хэлцэл | 55,862 | 90,414 | 15,535 | 359 | 162,170 |
| | НИЙТ | 56,330 | 92,117 | 73,115 | 12,933 | 234,495 |

Хуулийн фирмийн зүгээс эдгээр гэрээ, хэлцлүүдийг (i) даатгуулагчаас бусад буюу даатгалаас бусад төрлийн үйл ажиллагаанд хамаарах гэрээ, хэлцэл; (ii) даатгуулагчтай байгуулсан даатгалын үйлчилгээнд хамаарах гэрээ, хэлцэл гэсэн 2 төрөлд ангилж дүн шинжилгээ хийлээ.

Мандал даатгал ХХК-ийн нийт байгуулсан гэрээнээс үзвэл 233,811 (хоёр зуун гучин гурван мянга найман зуун арван нэгэн) гэрээ, хэлцлийг даатгалын үйлчилгээ үзүүлэх замаар байгуулсан бол үлдсэн 684 (зургаан зуун наян дөрвөн) гэрээ, хэлцлийг даатгуулагчаас бусад этгээдтэй даатгалын үйл ажиллагаанаас бусад чиглэлээр байгуулсан байна. Үүнээс дүн шинжилгээ хийх өдрийн байдлаар 72,325 (далан хоёр мянга гурван зуун хорин таван) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Хүснэгт №2: Сүүлийн 3 жил дотор бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийн төрлийн тоон үзүүлэлт.

| № | Гэрээ, хэлцлийн төрөл | Дэд төрөл | Нийт | Хүчин төгөлдөр |
|---|---|---|---|---|
| 1. | Даатгуулагчтай байгуулсан даатгалын үйлчилгээнд хамаарах гэрээ, хэлцэл | Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал | 120,390 | 18,904 |
| | | Сайн дурын даатгал | 113,421 | 53,330 |
| 2 | Даатгуулагчаас бусад буюу даатгалаас бусад төрлийн үйл ажиллагаанд хамаарах гэрээ, хэлцэл | | 684 | 91 |
| 3. | НИЙТ | | 234,495 | 72,325 |

[11] Хөдөлмөрийн хууль (1999)-д заасан Контрактын хөдөлмөрийн гэрээний утга агуулгаас илүү өргөн хэлцэл гэсэн хууль зүйн ерөнхий утгаар ойлгож хэрэглэсэн болохыг анхаарна уу. Хуулийн фирм.

12 Бусадтай байгуулсан гэрээ хэлцэлд дотооддоо буюу ажилчидтай байгуулсан хөдөлмөрийн харилцаа үүсгэх гэрээ, хэлцлүүдийг оруулж тооцоогүйг анхаарна уу. Хуулийн фирм.



МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаас гаргагчийн дээр дурдсан гэрээнээс эхний ээлжинд Даатгуулагчаас бусад буюу даатгалаас бусад төрлийн үйл ажиллагаанд хамаарах гэрээ, хэлцлийг дэлгэрүүлэн авч үзье.

**Нэг. Даатгуулагчаас бусад буюу даатгалаас бусад төрлийн үйл ажиллагаанд хамаарах гэрээ, хэлцэл**

Мандал даатгал ХХК-ийн сүүлийн 3 жил дотор даатгуулагчаас бусад этгээдтэй бичгээр 684 (зургаан зуун наян дөрвөн) гэрээ, хэлцэл байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 91 (ерэн нэгэн) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үнэт цаас гаргагчийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа нийт гэрээ, хэлцлүүдийн дэлгэрэнгүй мэдээлэл, хүчин төгөлдөр байдлыг *Хавсралт №2: "Мандал даатгал ХХК-ийн даатгуулагчаас бусад буюу даатгалаас бусад төрлийн үйл ажиллагаанд хамаарах гэрээ, хэлцлийн хүснэгт"*-ээс дэлгэрүүлэн танилцана уу..

Хүснэгт №3: Сүүлийн 3 жил дотор даатгуулагчаас бусад буюу даатгалаас бусад төрлийн үйл ажиллагаанд хамаарах бусад этгээдтэй бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийн тоон үзүүлэлт.

| № | Он | 2015.03.01-2015.12.31 | 2016 он | 2017 он | 2018.01.01-2018.03.01 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хүчин төгөлдөр гэрээ, хэлцэл | 3 | 6 | 69 | 13 | 91 |
| 2. | Дуусгавар болсон гэрээ, хэлцэл | 243 | 198 | 146 | 6 | 593 |
| | НИЙТ | 246 | 204 | 215 | 19 | 684 |

Эдгээр хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэрээ, хэлцлүүдийг ангилж авч үзвэл худалдах, худалдан авах төрөлд хамаарах 8 (найман) гэрээ, хэлцэл байх бөгөөд бэлтгэн нийлүүлэх төрлийн болон бусдаас мөнгөн хөрөнгө зээлж авсан зээлийн гэрээ, хэлцлийг бусадтай байгуулаагүй байна.

Бусад төрлийн гэрээ, хэлцлүүдийг авч үзвэл тус компани нь зуучлал болон даатгалын хамтын ажиллагааны гэрээ, хэлцлийг түлхүү байгуулдаг байна. Эдгээр гэрээ, хэлцлүүдээс даатгалын компанийн үндсэн бизнесийг дэмжиж даатгалын хураамж, орлогын урсгалыг нэмэгдүүлж байгаа Даатгалын зуучлалын гэрээ, Даатгалын хамтын ажиллагааны гэрээ, Давхар даатгалын гэрээ, Даатгалын төлөөлөгчийн гэрээ, Түрээсийн гэрээг Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд **чухал ач холбогдолтой гэрээ** гэж Хуулийн фирм үзэж, дүн шинжилгээ хийлээ.

Хүснэгт №4: Сүүлийн 3 жил дотор даатгуулагчаас бусад этгээдтэй байгуулсан хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээ, хэлцлийн төрлийн тоон үзүүлэлт.

| № | Гэрээний нэр, төрөл | 2015.03.01-2015.12.31 | 2016 он | 2017 он | 2018.01.01-2018.03.01 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Худалдах, худалдан авах гэрээ | - | - | 7 | 1 | 8 |
| 2. | Ажил гүйцэтгэх гэрээ | 1 | 2 | 4 | 3 | 10 |
| 3. | Зуучлалын гэрээ | 1 | 1 | 19 | 4 | 25 |
| 4. | Хамтран ажиллах гэрээ | - | 2 | 5 | - | 7 |
| 5. | Үйлчилгээ үзүүлэх гэрээ | 1 | - | 10 | - | 11 |
| 6. | Түрээсийн гэрээ | - | 1 | 3 | 2 | 6 |
| 7. | Төлөөлөгчийн гэрээ | - | - | 14 | - | 14 |
| 8. | Эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ | - | - | 1 | 1 | 2 |
| 9. | Зээлэрлийн гэрээ | - | - | 1 | - | 1 |
| 10. | Хөлсөөр ажиллах гэрээ | - | - | 3 | - | 3 |
| 11 | Эд хөрөнгө хариуцах гэрээ | - | - | 1 | 1 | 2 |
| 12 | Давхар даатгалын гэрээ | - | - | 1 | - | 1 |
| 13. | Урамшууллын гэрээ | - | - | - | 1 | 1 |
| | НИЙТ | 3 | 6 | 69 | 13 | 91 |

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн хүчин төгөлдөр гэрээтэй холбоотойгоор үүссэн маргаан, сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл байдал үүсээгүй байна. Хуулийн фирм нь энэхүү ангиллын хүрээнд хүлээн авсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй гэрээ, хэлцлийг СЗХ-оос тавьсан шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах төрөл тус бүрээр дэлгэрүүлэн авч үзлээ.

Энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн эдгээр хүчин төгөлдөр гэрээтэй холбоотойгоор үүссэн маргаан, сөрөг нөлөө үзүүлэх нөхцөл үүсээгүй байна.



СЗХ Үнэт цаасны мэдээллийн газар 2018 08 7 БҮРТГЭВ НУУЦ БАРИМТ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01
МАНДАЛ ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС GOLOMT CAPITAL LLC ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК
210
Огноо: 2018/04/16

Үнэт цаасны танилцуулга
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
НУУЦ БАРИМТ
Эх хувь

МАНДАЛ даатгал
БҮРТГЭВ 01

Худалдах, худалдан авах гэрээ, хэлцэл

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн гэрээ, хэлцлийн бүртгэлээс үзвэл сүүлийн 3 жил дотор бусадтай нийт 45 (дөчин таван) худалдах, худалдан авах гэрээ байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар 8 (найман) худалдах, худалдан авах гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Үнэт цаас гаргагчийн өгсөн тайлбараас үзвэл Мандал даатгал ХХК нь өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой жижиглэн болон бөөнөөр худалдах, худалдан авах (шинэ жилийн мэндчилгээ, оффисын тавилга, ширээ, сандал), бараа бэлтгэн нийлүүлэх (Үнэт цаас гаргагчийн лого бүхий эд юмс) зэрэг бараа, бүтээгдэхүүн, хөрөнгийг захиалгаар худалдан авдаг байна.

Үнэт цаас гаргагч нь эрхэлж буй бизнесийн онцлогоосоо хамаарч харилцагчийн халамж үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаагаа өргөжүүлэн сурталчлах зорилгоор өөрийн нэр бүхий логотой бараа, бүтээгдэхүүн, хөрөнгийг захиалан хийлгүүлэх, харилцагч, даатгуулагчдад эрхийн бичиг олгох, түүнчлэн автомашины сэлбэг хэрэгсэл худалдан авах зэргээр худалдах, худалдан авах гэрээг бусадтай голчлон байгуулдаг байна.

Эдгээр хүчин төгөлдөр байгуулагдсан худалдах, худалдан авах гэрээ нь бичгээр байгуулагдсан хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хангасан, талуудыг төлөөлөх этгээдийн гарын үсэг зурагдсан, тэмдэг (тамга) дарагдсан хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлтэй, холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж дүгнэлээ.

Бэлтгэн нийлүүлэх гэрээ, хэлцэл

Үнэт цаас гаргагчийн дурдсан хугацаанд бусадтай байгуулсан гэрээ, хэлцлүүдээс үзвэл аливаа бэлтгэн нийлүүлэх буюу бусдын өмчлөлд хөрөнгө нийлүүлэх гэрээ, хэлцэл байгуулаагүй байна.

Зээлийн гэрээ, хэлцэл

2018 оны 02 сарын 28-ны өдрийн ЗМС-ын мэдээллээс үзвэл Мандал даатгал ХХК дээр 2017 оны 08 сарын 24-ны өдөр үүсгэсэн 15,700,000 (арван таван сая долоон зуун мянган) төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байх бөгөөд уг өрийн үлдэгдэл нь хэвийн ангилалд хамрагдаж байна.

Тус өрийн үлдэгдэлд хамаарах холбогдох материалыг Үнэт цаас гаргагчаас шаардаж үзсэн бөгөөд уг ЗМС-д орсон өглөг нь Мандал даатгал ХХК-ийн Иргэний нисэхийн ерөнхий газрын Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацын үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалын үйлчилгээний ажлыг гүйцэтгэх болсонтой холбогдуулан банкнаас гаргуулсан баталгааны гэрээний үнийн дүн байна. Үнэт цаас гаргагч нь Иргэний нисэхийн ерөнхий газрын "Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацийн үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгал"-ын үйлчилгээ үзүүлэх ИНЕГ/УЗ/ТББ/Ү-01/17 тоот тендерт шалгарсан байна. Улмаар Үнэт цаас гаргагч нь 2017 оны 08 дугаар сарын 11-ний өдөр №17/123 тоот "Иргэний нисэхийн ерөнхий газрын "Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацийн үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгал"-ын үйлчилгээ үзүүлэх ИНЕГ/УЗ/ТББ/Ү-01/17 тоот тендерийн даатгалын ерөнхий гэрээ"-г байгуулсан байна. Тус гэрээ нь 1 (нэг) жилийн хугацаатай буюу бөгөөд 2018 оны 08 сарын 11-ний өдрийг дуустал байгуулагдсан байна.

Тендерт тавигдсан шаардлагын дагуу баталгаа гаргуулах зорилгоор Хаан банктай Мандал даатгал ХХК нь 2017 оны 08 сарын 24-ний өдөр №17/20001 Баталгаа гаргах гэрээ байгуулсан байна. Энэхүү Баталгааны гэрээний дагуу Хаан банк **эх үүсвэртэйгээр**[13] Иргэний нисэхийн ерөнхий газрын Олон улсын өнгөрөлтийн нислэгт үзүүлэх навигацын үйлчилгээний явцад гуравдагч этгээдийн хариуцлагын даатгалын үйлчилгээний ажлыг гүйцэтгэлд Мандал даатгал ХХК-ийн нэрийн өмнөөс ИХ-ийн 457 дугаар зүйлд заасан банкны баталгаа гаргасан агуулгатай байна. Тус баталгаа нь дурдсан гэрээгээр хүлээсэн үүргээ Мандал даатгал ХХК бүрэн дуусгаж ажил дууссан тухай

[13] Эх үүсвэртэй буюу арилжааны банканд баталгааны үнийн дүнтэй тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийн тусгаарлаж байршуулсан гэж ойлгож байна. Хуулийн фирм

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ



МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
2018 08 29
БҮРТГЭВ
№ 01
НУУЦ БАРИМТ
Эх хувь



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

мэдэгдэл гаргаснаас хойш 28 (хорин найман) хоногийн хугацаанд хүчин төгөлдөр байхаар заасан байна.

Хаан банкны 2018 оны 03 сарын 06-ны өдрийн Дугаар№20180306024/2579 тоот тодорхойлолтоос үзвэл Мандал даатгал ХХК нь 2018 оны 03 сарын 05-ны өдрийн байдлаар тус банканд зээл болон хүүгийн өр төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

Иймд Баталгаа гаргах гэрээ нь хууль зүйн хувьд хүчин төгөлдөр бөгөөд дүгнэлт гаргаж өгөх өдрийн байдлаар аливаа сөрөг үр дагавар үүсгээгүй, ИХ-ийн 457 дугаар зүйлд заасан зарчим, нөхцөл журмын дагуу гэрээний нөхцөлийг тохиролцож бичгээр байгуулсан байх бөгөөд талуудын төлөөлөгчид гарын үсэг зурж тэмдэг (тамга) дарагдсан байна.

Энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Мандал даатгал ХХК-аас ирүүлсэн мэдээлэл болон ЗМС-ын лавлагаанд үндэслэн дээр дурдсанаас өөрөөр бусадтай байгуулсан зээлийн гэрээ, хэлцэл хийгдээгүй байна.

**Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, хэлцэл**

Хуулийн фирм нь хүлээн авсан гэрээ, хэлцлийг ангилан судалсны үндсэн дээр Мандал даатгал ХХК-ийн бизнесийн үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой, борлуулалт, мөнгөн хөрөнгийн урсгалыг дэмжих, үйл ажиллагаа өргөжүүлэн дэмжсэн дараах төрлийн гэрээ, хэлцлийг тус компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх буюу чухал ач холбогдолтой гэж үзлээ. Үүнд:

1. *Зуучлалын гэрээ;*
2. *Төлөөлөгчийн гэрээ;*
3. *Хамтран ажиллах гэрээ;*
4. *Түрээсийн гэрээ;*
5. *Давхар даатгалын гэрээ.*

Хуулийн фирм нь хүлээн авч танилцсан эдгээр гэрээ, хэлцлүүдийн гэрээний зүйл нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх болон талуудын тохиролцсон аливаа болзол, нөхцөл, журмууд нь хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийсэн болно.

**Даатгалын зуучлалын гэрээ, Даатгалын төлөөлөгчийн гэрээний хувьд авч үзвэл:**

Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК нь даатгалын мэргэжлийн оролцогч болох даатгалын зуучлагч болон даатгалын төлөөлөгчөөр дамжуулан бүтээгдэхүүнээ борлуулж, үйл ажиллагаагаа өргөтгөн, үйлчлүүлэгч, даатгуулагчдадаа хүрч ажиллаж байна. Даатгагчийн орлогод нөлөөлөх эдгээр төрлийн гэрээ, хэлцлүүдийг Хуулийн фирм чухал ач холбогдолтой гэж үзсэн болно.

Хуулийн фирм нь Мандал даатгал ХХК-ийн хамтран ажиллаж буй даатгалын мэргэжлийн оролцогч болох **даатгалын зуучлагч**дын мэдээллийг гаргуулан авч үзэхэд 2018 оны байдлаар 5 (таван) банк, 17 (арван долоон) брокерын компани буюу нийт 22 (хорин хоёр) даатгалын зуучлагчтай хамтран ажиллаж байх бөгөөд сүүлийн 3 жил дотор нийт 111 (нэг зуун арван нэгэн) зуучлалын гэрээ байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар дурдсан 22 зуучлагчид хамаарах 25 (хорин таван) зуучлалын хүчин төгөлдөр гэрээ үйлчилж байна.

Үнэт цаас гаргагч нь дээр дурдсан даатгалын зуучлагчдаар дамжуулан 2015 онд хураамжийн орлогын 29,5 хувь буюу 2,710,500,000 (хоёр тэрбум долоон зуун арван сая таван зуун мянган) төгрөг, 2016 онд хураамжийн орлогын 42 хувь буюу 5,458,217,922 (таван тэрбум дөрвөн зуун тавин найман сая хоёр зуун арван долоон мянга есөн зуун хорин хоёр) төгрөг, 2017 онд хураамжийн орлогын 31 хувь буюу 7,042,946,689 (долоон тэрбум дөчин хоёр сая есөн зуун дөчин зургаан мянга зургаан зуун наян есөн) төгрөгийг бүрдүүлсэн тоон үзүүлэлттэй ажилласан байна.

Мандал даатгал ХХК-ийн гаргаж өгсөн гэрээний бүртгэл болон зуучлалын гэрээ, хэлцлээс үзвэл энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн эрхэлж буй үндсэн үйл ажиллагаатай холбоотой дараах зуучлалын гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117238007 5473489



МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
2018 . 08 . 28
НУУЦ БАРИМТ
ЭХ ХУВЬ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

(i) "Ренессанс групп" ХХК-тай 2015 оны 11 сарын 23-ны өдөр байгуулсан Байгууллагын даатгалын зуучлагчаар хамтран ажиллах гэрээ;
(ii) "Голомт банк" ХХК-тай 2016 оны 09 сарын 01-ний өдөр байгуулсан Зээлдэгчийн гэнэтийн ослын даатгалын зуучлалын гэрээ;
(iii) "Эс Ти Ди" ХХК-тай 2017 оны 04 сарын 01-ний өдөр байгуулсан Даатгалын зуучлалын гэрээ;
(iv) "Нью жуулчин турс" ХХК-тай 2017 оны 03 сарын 22-ны өдөр байгуулсан Гадаадад зорчигчийн даатгалын гэрээ;
(v) "Ивээлт Очир" ХХК-тай 2017 оны 04 сарын 19-ний өдөр байгуулсан Даатгалын зуучлалын гэрээ;
(vi) "Ачит Цэрэн" ХХК-тай 2017 оны 04 сарын 18-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээ;
(vii) "Лоялти солюшн" ХХК-тай 2017 оны 05 сарын 01-ний өдөр байгуулсан Даатгалын зуучлалын гэрээ;
(viii) "Вема ББСБ" ХХК-тай 2017 оны 05 сарын 09-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээ;
(ix) "Худалдаа хөгжлийн банк" ХХК-тай 2017 оны 05 сарын 24-ний өдөр байгуулсан Даатгалын зуучлалын үйлчилгээ үзүүлэх гэрээ;
(x) "Тэгэл инвест ББСБ" ХХК-тай 2017 оны 05 сарын 25-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээ;
(xi) "Нано капитал ББСБ" ХХК-тай 2017 оны 05 сарын 25-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээ;
(xii) "Мастер шийдэл" ХХК-тай 2017оны 05 сарын 22-ны өдөр байгуулсан Даатгалын зуучлалын гэрээ;
(xiii) "Хаан банк" ХХК-тай 2017 оны 06 сарын 01-ний өдөр байгуулсан Даатгалын зуучлалын үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээ;
(xiv) "Дэвжих дэлгэрэх холдинг" ХХК-тай 2017 оны 06 сарын 15-ны өдөр байгуулсан Даатгалын зуучлалын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах гэрээ;
(xv) "Чанд финтех" ХХК-тай 2017 оны 08 сарын 23-ны өдөр байгуулсан Даатгалын зуучлалын гэрээ;
(xvi) "Фрэйндс файнэнс ББСБ" ХХК-тай 2017 оны 09 сарын 01-ний өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээ;
(xvii) "Асимон брокерс" ХХК-тай 2017 оны 09 сарын 25-ны өдөр байгуулсан Байгууллагын даатгалын зуучлагчаар хамтран ажиллах гэрээ;
(xviii) "Голомт банк" ХХК-тай 2017 оны 10 сарын 11-ний өдөр байгуулсан Гэнэтийн ослын даатгалын зуучлалаар хамтран ажиллах гэрээ;
(xix) "Арм интернэйшнл" ХХК-тай 2017 оны 12 сарын 05-ны өдөр байгуулсан Байгууллагын даатгалын зуучлалаар хамтран ажиллах ерөнхий гэрээ;
(xx) "Ай Ай Би" ХХК-тай 2017 оны 11 сарын 22-ны өдөр байгуулсан Байгууллагын даатгалын зуучлагчаар хамтран ажиллах ерөнхий гэрээ;
(xxi) "Голомт банк" ХХК-тай 2017 оны 09 сарын 01-ний өдөр байгуулсан Орон сууцны зээлийн эрсдэлийн даатгалын зуучлалаар хамтран ажиллах гэрээ;
(xxii) "Голомт банк" ХХК-тай 2018 оны 02 сарын 12-ны өдөр байгуулсан Даатгалын зуучлалаар хамтран ажиллах гэрээ.

Иймд Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Мандал даатгал ХХК нь нийт 22 (хорин хоёр) даатгалын зуучлагчтай хамтран ажиллаж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Эдгээр хүчин төгөлдөр зуучлалын гэрээ, хэлцэл нь гэрээний талуудын хүсэл зоригт нийцсэнээр байгуулагдсан байх бөгөөд бичгээр байгуулагдсан хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хангасан, талуудыг төлөөлөх этгээдийн гарын үсэг зурагдсан, тэмдэг (тамга) дарагдсан хүчин төгөлдөр гэрээ, хэлцэл байна гэж үзлээ.

СЗХ-ны 2018 оны 03 сарын 15-ны өдрийн №6/1009 тоот албан бичиг болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн **даатгалын төлөөлөгч**дийн бүртгэл, гэрээ, хэлцлээс үзвэл энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Мандал даатгал ХХК нь дараах 14 (арван дөрвөн) даатгалын төлөөлөгчтэй гэрээ байгуулан үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

(i) Иргэн Ц.Долгорсүрэнтэй 2017 оны 05 сарын 01-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489



МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК
1117236373 5481589
213
Огноо: 2018/04/16

Үнэт цаасны хорооны шийдвэр
сар өдөр
2018 08 29
БҮРТГЭВ
№ 01



МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

(ii) Иргэн Г.Ганзоригтой 2017 оны 05 сарын 01-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(iii) Иргэн Б.Жавзандуламтай 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(iv) Иргэн Б.Цолмонтой 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(v) Иргэн Б.Батболд 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(vi) Иргэн Д.Тунгалагболортой 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(vii) Иргэн Ш.Цэнгэлтэй 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(viii) Иргэн Ц.Болор-Эрдэнэтэй 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(ix) Иргэн Э.Цэрэндоржтой 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(x) Иргэн П.Мөнхзултай 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(xi) Иргэн Д.Мөнхбаатартай 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(xii) Иргэн Т.Соёлцэцэгтэй 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(xiii) Иргэн Б.Мөнхцэцэгтэй 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ;
(xiv) Иргэн А.Дашдондовтой 2017 оны 05 сарын 11-ний өдөр байгуулсан Даатгалын төлөөлөгчийн гэрээ.

Хуулийн фирмийн хүлээн авсан эдгээр хүчин төгөлдөр гэрээний хувьд Даатгалын төлөөлөгч нь Мандал даатгал ХХК-ийн өмнөөс даатгуулагчтай гэрээ, хэлцэл хэлцэл хийх, түүний эзэмшил болон хариуцлагад байгаа даатгалын зүйлийг даатгах, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний нөхцөлийг танилцуулах, даатгуулагчийн төлсөн хураамжийг шилжүүлэх, гэрээнд заасан даатгалын төлөөлөгчийн үйлчилгээний хөлс төлөх нөхцөлтэй холбогдсон харилцаанд гэрээний талуудын оролцоо, эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон байна.

Эдгээр гэрээнүүд нь бичгээр байгуулагдсан хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хангасан, талуудыг төлөөлөх этгээдийн гарын үсэг зурагдсан, тэмдэг (тамга) дарагдсан хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлтэй, ИХ болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзлээ.

Хуулийн фирм нь хүлээн авсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй даатгалын төлөөлөгчдийн гэрээний хүрээнд хууль тогтоомжид нийцсэн эсэхэд дүгнэлт гаргасан болно.

**Хамтран ажиллах гэрээний хувьд авч үзвэл:**

Даатгагч нь бизнесийн хуулийн этгээдүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулж улмаар хамтын ажиллагааны хүрээнд хэд хэдэн төрлийн даатгалын гэрээ байгуулж даатгуулагчийн хууль ёсны ашиг сонирхлыг эрсдэлээс хамгаалж ажилладаг байна. Үнэт цаас гаргагч нь нь сүүлийн 3 жил дотор даатгалын хураамжийн орлогод нөлөөлөх, даатгалын үндсэн үйл ажиллагааг дэмжих зорилгоор бусадтай хамтын ажиллагааны нийт 50 (тавин) хамтран ажиллах гэрээ байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй дараах 6 (зургаан) хамтран ажиллах гэрээг Хуулийн фирмийн зүгээс чухал ач холбогдолтой гэрээ гэж үзлээ. Үүнд:

(i) "Шарын гол" ХК-тай 2016 оны 03 сарын 07-ны өдөр байгуулсан Даатгалын үйл ажиллагаанд урт хугацаанд хамтран ажиллах гэрээ;
(ii) "Проседи" ХХК –тай 2016 оны 07 сарын 18-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээ;
(iii) "Засо" ХХК-тай 2017 оны 04 сарын 07-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээ;
(iv) "Ивээл инвест ББСБ" ХХК-тай 2017 оны 05 сарын 22-ны өдөр байгуулсан Хамтран ажиллах гэрээ;

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117336007 5473489



МОНГОЛ УЛС
1117216573 5481589
КАПИТАЛ ҮЦК ХХК
214
Огноо: 2018/04/16

(v) "Гранд мед эмнэлэг" ХХК-тай 2017 оны 11 сарын 20-ны өдөр байгуулсан "Анд Системс Тех" ХХК болон "ЛэндМН" ХК-ийн ажилчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх хамтран ажиллах гэрээ;
(vi) "Грандмед эмнэлэг" ХХК-тай 2017 оны 05 сарын 01-ний өдөр байгуулсан "Оюу толгой" ХХК-ийн ажилчдад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийх, үйлчилгээ үзүүлэх гэрээ.

Дээрх мэдээллээс үзвэл энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Мандал даатгал ХХК нь эрхэлж буй үндсэн үйл ажиллагааны чиглэлтэйгээ холбогдуулан (i) гэнэтийн осол, эмчилгээний даатгал болон (ii) хөрөнгийн даатгал гэсэн даатгал; (iii) автотээврийн хэрэгслийн даатгалын хэлбэрээр хамтран ажиллах гэрээ, хэлцлийг бусадтай байгуулан ажиллаж байна.

Эдгээр хүчин төгөлдөр хамтран ажиллах гэрээ, хэлцлийн хувьд үүргийн эрх зүйн харилцаанд хамаарах гэрээнүүд байх бөгөөд гэрээний талуудын тэгш эрхийн зарчимд үндэслэсэн бөгөөд бичгээр байгуулагдсан хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хангасан, талуудыг төлөөлөх этгээдийн гарын үсэг зурагдсан, тэмдэг (тамга) дарагдсан хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлтэй, ИХ болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзлээ.

**Түрээсийн гэрээний хувьд авч үзвэл:**

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жил дотор бусадтай нийт 41 (дөчин нэгэн) түрээсийн гэрээ байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар дараах 6 (зургаан) түрээсийн хүчин төгөлдөр гэрээг иргүүлсэн байна. Үүнд:

(i) "Гранд оффис СӨХ" ХХК-тай 2016.09.25-ны өдөр байгуулсан гэрэлт лого байршуулах түрээсийн гэрээ;
(ii) Иргэн Д. Балжиннямтай 2017 оны 03 сарын 27-ны өдөр байгуулсан Автомашин түрээслэх гэрээ;
(iii) "Анса трейд" ХХК-тай 2017 оны 06 сарын 19-ний өдөр байгуулсан Ажлын байр (42 м.кв) түрээслэх гэрээ;
(iv) Иргэн Д.Тувшинбаяртай 2017 оны 11 сарын 10-ны өдөр байгуулсан Автомашин түрээслэх гэрээ;
(v) "Сити клуб" ТББ-тай 2018 оны 02 сарын 02-ны өдөр байгуулсан Спорт заал түрээслэх гэрээ;
(vi) "Ньюком проперти" ХХК-тай 2013 оны 12 сарын 11-ний өдөр байгуулсан Дархан ТЕДИ барилгын 32.2 кв.м талбайг оффис, үйлчилгээний зориулалтаар түрээслэх гэрээ.

Эдгээр хүчин төгөлдөр түрээсийн гэрээний хувьд Мандал даатгал ХХК-ийн өдөр тутмын үйл ажиллагаа явуулах оффис, талбай ялангуяа аж ахуйн зориулалттай байрны түрээстэй холбогдуулан байгуулдаг гэрээ, хэлцэл байх бөгөөд тус гэрээнүүд нь бичгээр байгуулагдсан хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хангасан талуудыг төлөөлөх этгээдийн гарын үсэг зурагдсан, тэмдэг (тамга) дарагдсан хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлтэй, ИХ болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзлээ.

**Давхар даатгалын гэрээний хувьд авч үзвэл:**

ДТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт "Даатгагч нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ дараах даатгагчид даатгуулж болно" гэж заасны дагуу даатгалын компани нь гэрээний дагуу хүлээсэн үүргээ (i) давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани эсхүл (ii) ДТХ-ийн дагуу тусгай зөвшөөрөл аваагүй гадаадын улсын даатгалын компанид давхар даатгуулж болох хуулийн зохицуулалттай байна.

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд Мандал даатгал ХХК-аас СЗХ-д 2017 оны 12 сарын 13-ны өдрийн №17/1871 тоот албан бичгээр хүргүүлсэн Мандал даатгал ХХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 12 сарын 12-ны өдрийн №17/006 тоот шийдвэрээр баталсан тус компанийн "2017 оны давхар даатгалын тайлан, 2018 оны давхар даатгалын стратеги төлөвлөгөө, жилийн төлөвлөгөө" болон хүчин төгөлдөр хэрэгжиж буй давхар даатгалын гэрээг тус тус гаргуулан авч үзлээ.

Үнэт цаас гаргагч нь давхар даатгалын журам, баримтлах бодлогынхоо хүрээнд олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч байгууллага болох "A.M.Best Company"-ийн "A-"-аас дээш болон

СЗХ
Үнэт цаас сар таны өдөр удирдлага
2019 /08/ 23
№ 01
НУУЦ БАРИМТ
Эх хувь

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

"Standard & Poor's"-ийн үнэлгээг суурь болгон "A" болон түүнээс дээш үнэлгээ бүхий, олон улсын нэр хүнд бүхий давхар даатгагч, брокеруудтай хамтран ажиллахыг зорьж ажилладаг байна.

Мандал даатгал ХХК нь давхар даатгалын гэрээний хувьд хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй 1 (нэг) давхар даатгалын гэрээг Хуулийн фирмд ирүүлсэн. Тус гэрээний хувьд Үнэт цаас гаргагч нь 2017 оны 08 сарын 01-ний өдөр Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын брокерын компани **Tysers Co. Ltd**-аар дамжуулан (i) Trust Re (Бахрейн улс); (ii) Hannover Rück SE (ХБНГУ) болон; (iii) Russian Reinsurance Company JSC (ОХУ)-тай давхар даатгалын гэрээ байгуулсан байна. Тус гэрээний хүрээнд дараах төрлийн эрсдэлийг хамгаалуулахаар тохиролцсон байна. Үүнд:

(i) Хөрөнгийн даатгал;
(ii) Барилга угсралт, угсралт суурилуулалтын даатгал;
(iii) Гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагын даатгал, бүтээгдэхүүний хариуцлагын даатгал, мэргэжлийн хариуцлагын даатгал, ажил олгогчийн хариуцлагын даатгал;
(iv) Тусгай зориулалтын тоног төхөөрөмж болон хүнд даацын машин механизмын даатгал.

СЗХ-ны 2012 оны №03 тоот тогтоолоор батлагдсан "Даатгагчийн давхар даатгалын төлөвлөгөө, давхар даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлага, түүний биелэлтэд хяналт тавих журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг "... (i) давхар даатгагч нь энэхүү журмын 2.6-д заасан зөвшөөрөгдөх давхар даатгагчийн шалгуурыг хангаагүй; (ii) давхар даатгалын гэрээнд гадаадын даатгагч хамтран оролцсон; (iii) даатгагч фронтингийн [14] үйл ажиллагаа явуулах шаардлагатай болсон"-т зааснаар даатгагч нь давхар даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийг СЗХ-оос авахаар зохицуулалттай байна. Мөн тус журмын 2 дугаар зүйлийн 2.6.2 дахь хэсэгт "СЗХ-оос давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл аваагүй буюу дараах гадаадын давхар даатгагчийг Зөвшөөрөгдөх давхар даатгагч гэж ойлгоно" гэж тодорхойлон журамласан байна. Үүнд:

1. "A.M.Best Company"-ийн "A-"-аас дээш;
2. "Standard and Poors", "Fitch Group"-ийн "BBB"-ээс дээш;
3. "Moody's Corporation"-ийн "Baa"-аас дээш үнэлгээ авсан.

Тус журмын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг "Давхар даатгагч энэ журмын 2.6-д заасан шалгуурыг хангасан, эсхүл даатгалын нэг гэрээг хэд хэдэн давхар даатгагчид даатгуулах тохиолдолд давхар даатгалын гэрээнд оролцогч аль нэг компани зөвшөөрөгдөх давхар даатгагчийн шалгуурыг хангасан байвал Хорооноос давхар даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийг авах шаардлагагүй"-т гэж заасан эрх зүйн зохицуулалттай байна. Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн мэдээлэл, олон нийтэд зарласан **Tysers Co. Ltd**-мэдээллээс үндэслэн харвал тус компани нь эдгээр олон улсын үнэлгээний байгууллагуудын тавьсан шаардлагыг хангасан байна гэж үзсэн [15]. Иймд тус журмын 2.6 дахь хэсэгт заасан **зөвшөөрөгдөх давхар даатгагч** гэж үзэж СЗХ-оос зөвшөөрөл авах шаардлагагүй гэрээлэгч байна гэж үзлээ.

Давхар даатгалын гэрээнд тус гэрээний хүчин төгөлдөр байдлыг Монгол Улсын хуулиар тайлбарлагдаж зохицуулагдахаар тохиролцжээ. Давхар даатгалын гэрээ нь бичгээр байгуулагдсан хэлцлийн хэлбэрийн шаардлагыг хангасан талуудыг төлөөлөх этгээдийн гарын үсэг зурагдсан, тамга (тамга) дарагдсан байх учир Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр гэж үзэх үндэслэлтэй гэрээ байна.

[14] Фронтингийн хэлцэл: Тухайн улсын хуулийн дагуу тусгай зөвшөөрөл авсан арилжааны даатгагч даатгуулагчтай гэрээ байгуулж, харин эрсдэлийг давхар даатгалын гэрээ нэрийн дор даатгалын компани руу шилжүүлдэг. Энэ тохиолдолд фронтинг хийж буй даатгагч тухайн гэрээний эцсийн хариуцлагыг хүлээх боловч уг гэрээний эдийн засгийн эрсдэлийг даатгагч хариуцна гэж ойлгож хэрэглэлээ. Хуулийн фирм.

[15] https://www.standardandpoors.com/en_US/web/guest/register
https://member.ambest.com/MemberCenter/sMC/Cust_existing.aspx?NP=1&URATINGID=&nextpage=http://ratings.ambest.com/CompanyProfile.aspx?ambnum=87997&AltSrc%3d9%26Portal%3d0%26Ext_Misc%3d%26Ext_User%3d%26PPP%3d%26Site%3d%26AltNum%3d0



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117238007 5473489

МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

### Хоёр. Даатгуулагчтай байгуулсан даатгалын үйлчилгээнд хамаарах гэрээ, хэлцэл

Даатгалын бизнес эрхлэгч этгээдийн үндсэн үзүүлэх үйлчилгээ нь санхүү, даатгалын үйлчилгээ юм. Даатгагч нь даатгалын үйлчилгээ үзүүлэхдээ СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх бөгөөд үйл ажиллагаандаа СЗХ-оос баталсан даатгалын багц дүрмүүдийг удирдлага болгон түүний хяналт дор үйлчилгээгээ үзүүлдэг байна.

СЗХ-ны 2016 оны 03 сарын 04-ний өдрийн №48 тоот тогтоолоор батлагдсан "Даатгал түүнтэй холбоотой үйл ажиллагаа, даатгагчид тавигдах шаардлага, даатгагчийн дагаж мөрдөх үзүүлэлтүүдийг тодорхойлох журам"-аар даатгагчийг даатгагч нь зөвхөн даатгалтай холбоотой үйл ажиллагаа эрхлэх бөгөөд ердийн даатгалын болон урт хугацааны даатгалын үйлчилгээг зэрэг үзүүлэхийг хориглож зохицуулсан байна. Тус зохицуулалтын хүрээнд Үнэт цаас гаргагч нь ердийн даатгалын үйл ажиллагаа эрхэлж байх бөгөөд фирмд ирүүлсэн гэрээ, хэлцлийн бүртгэл, мэдээллээс үзвэл Мандал даатгал ХХК нь тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 233,811 (хоёр зуун гучин гурван мянга найман зуун арван нэгэн) гэрээ, хэлцлийг даатгуулагчтай даатгалын үйлчилгээ үзүүлэх явцдаа байгуулж даатгалын хураамж авсан тоон үзүүлэлттэй байна. Эдгээр гэрээ, хэлцлүүдээс дүгнэлт хийх өдрийн байдлаар 72,234 (далан хоёр мянга хоёр зуун гучин дөрвөн) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр үйлчилж байна.

Мөн СЗХ-ны 2015 оны 11 сарын 23-ны өдрийн №407 тоот тогтоолоор батлагдсан "Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам-ыг баталсан байх бөгөөд тус журмын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт даатгагч нь даатгалын аливаа бүтээгдэхүүнийг нийтэд үзүүлэхдээ бүтээгдэхүүний жишиг загварыг СЗХ-нд бүртгүүлсний үндсэн дээр үзүүлэхээр тогтоож өгчээ. Иймд Үнэт цаас гаргагчийн ердийн даатгалын ангилал, төрөлд хамаарах сайн дурын даатгалын хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэрээ, хэлцлүүдийг байгуулах үндэслэл болсон бүтээгдэхүүний загвар, төслүүд нь хуульд заасан эрх бүхий байгууллагын хяналтаар урьдчилсан баталгаажсан бөгөөд СЗХ-ны хяналтын бүрэн эрхэд хамаарна гэж Хуулийн фирмээс үзлээ. СЗХ нь хуульд заасны дагуу даатгагчийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж **хяналтын чиг үүргийг**[16] хэрэгжүүлэх бөгөөд даатгагчийн үйл ажиллагаа нь хуулийн дагуу тодорхойлсон ангилал, төрөл, хэлбэрээс өөр байна гэж үзвэл энэ хуульд нийцүүлэхийг даалгах бүрэн эрхтэй байна. Иймд эдгээр СЗХ-ны бүрэн эрхэнд хамаарах бүртгэгдсэн гэрээ, хэлцлүүдийн төслийг хуульд нийцсэн гэж дүгнэж явсан болно.

Хуулийн фирмийн зүгээс мэдээлэл өгөх зорилгоор тодруулж даатгагчийн эзэмшиж байгаа СЗХ-оос хянаж зөвшөөрөл олгосон даатгалын хэлбэр, түүнд хамаарах бүтээгдэхүүнийг лавлаж тодруулсан бөгөөд СЗХ-ны 2018 оны 03 сарын 29-ний өдрийн №6/1603 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл Мандал даатгал ХХК нь сайн дурын болон албан журмын даатгалд хамаарах нийт 17 (арван долоон) хэлбэрээр 52 (тавин хоёр) бүтээгдэхүүнийг СЗХ-нд бүртгүүлсэн байна.

Эдгээрийг дэлгэрүүлж тодорхойлж үзвэл:

**Албан журмын даатгал**

Үнэт цаас гаргагч нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар албан журмын даатгалын төрөлд хамаарах жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-ны 2012 оны 04 сарын 18-ны өдрийн №146 тоот тогтоолын дагуу авсан байх бөгөөд сүүлийн 3 жилийн туршид нийт 120,390 (нэг зуун хорин мянга гурван зуун ерэн) гэрээ байгуулснаас 18,904 (арван найман мянга есөн зуун дөрвөн) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Хүснэгт №5: Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын нийт гэрээ, хэлцлийн тоон үзүүлэлт.

[16] Даатгалын тухай хууль (2004).
13 дугаар зүйл. Зохицуулах хорооны бүрэн эрх
13.1 Зохицуулах хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
13.2 Зохицуулах хороо нь даатгагч дампуурах болон даатгалын үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйл ажиллагаанаас үүсэж болзошгүй хохирлоос даатгуулагч болон олон нийтийг хамгаалах зорилгоор байнгын хяналтыг хэрэгжүүлнэ.

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
2018 он 08 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 1
НУУЦ БАРИМТ
Эх хувь

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

| № | Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал | 2015.03.01-2015.12.31 | 2016 он | 2017 он | 2018.01.01-2018.03.01 | Нийт | Хүчин төгөлдөр гэрээний тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Иргэн | 26,136 | 45,385 | 17,049 | 768 | 89,338 | 13,293 |
| 2. | Хуулийн этгээд | 9,348 | 14,285 | 6,992 | 427 | 31,052 | 5,611 |
| | НИЙТ | 35,484 | 59,670 | 24,041 | 1,195 | 120,390 | 18,904 |

Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагчийн иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан Жолоочийн албан журмын даатгалын гэрээний төсөл, загварыг авч үзсэн бөгөөд тус төсөл нь СЗХ-ны 2011 оны 332-р тогтоолоор баталсан Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын гэрээний стандарт, загвар дээр суурилж хийгдсэн байна.

**Сайн дурын даатгал**

СЗХ-ны 2018 оны 03 сарын 29-ний өдрийн №6/1603 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл Үнэт цаас гаргагч нь СЗХ-д сайн дурын даатгалын 16 (арван зургаан) хэлбэрээр 52 (тавин хоёр) бүтээгдэхүүн бүртгүүлсэн байна. Үнэт цаас гаргагч нь сайн дурын даатгалын үйл ажиллагаагаа өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээ, бизнесийн онцлогт тохируулан (i) иргэд; (ii) байгууллага гэсэн хоёр ангиллаар төрөлжүүлэн хөгжүүлж ажилладаг байна.

Сайн дурын даатгалын бүтээгдэхүүний онцлог нь даатгагчийн зүгээс нийтэд санал болгож байгаа бүтээгдэхүүнийг даатгуулагч сайн дураар сонгож эрсдэлээс хамгаалагдах бөгөөд ДТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасны дагуу талуудын хооронд үүсэх гэрээний харилцаа ИХ-аар зохицуулагддаг байна.

Хуулийн фирмд ирүүлсэн мэдээллээс үзвэл сүүлийн 3 жилийн хугацаанд даатгуулагч иргэдтэй даатгалын 6 (зургаан) хэлбэрээр, хуулийн этгээдтэй даатгалын 7 (долоон) хэлбэрээр гэрээ, хэлцэл байгуулж ажилласан байна.

Хүснэгт №6: Даатгуулагч иргэдтэй байгуулсан сайн дурын даатгалын нийт гэрээ, хэлцлийн тоон үзүүлэлт.

| № | Даатгалын хэлбэр | 2015.03.01-2015.12.31 | 2016 он | 2017 он | 2018.01.01-2018.03.01 | Нийт | Хүчин төгөлдөр гэрээний тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Гэнэтийн осол, эмчилгээний даатгал | 7,298 | 13,819 | 28,464 | 6,333 | 55,914 | 29,925 |
| 2. | Хөрөнгийн даатгал | 6,636 | 10,478 | 12,851 | 4,269 | 34,234 | 14,520 |
| 3. | Авто тээврийн хэрэгслийн даатгал | 4,935 | 6,043 | 5,833 | 948 | 17,759 | 7,512 |
| 4. | Ачааны даатгал | - | - | 1 | - | 1 | 1 |
| 5. | Барилга угсралтын даатгал | - | - | 1 | - | 1 | 1 |
| 6. | Хариуцлагын даатгал | 42 | 9 | 6 | - | 57 | 6 |
| | НИЙТ | 18,911 | 30,349 | 47,156 | 11,550 | 107,966 | 51,965 |

Хүснэгт №7: Даатгуулагч хуулийн этгээдтэй байгуулсан сайн дурын даатгалын нийт гэрээ, хэлцлийн тоон үзүүлэлт.

| № | Даатгалын хэлбэр | 2015.03.01-2015.12.31 | 2016 он | 2017 он | 2018.01.01-2018.03.01 | Нийт | Хүчин төгөлдөр гэрээний тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Гэнэтийн осол, эмчилгээний даатгал | 204 | 84 | 133 | 28 | 449 | 97 |
| 2. | Хөрөнгийн даатгал | 180 | 110 | 111 | 25 | 426 | 105 |
| 3. | Авто тээврийн хэрэгслийн даатгал | 1,122 | 1,468 | 1,244 | 78 | 3,912 | 998 |
| 4. | Ачааны даатгал | 26 | 36 | 12 | 7 | 81 | 13 |
| 5. | Барилга угсралтын даатгал | 8 | 4 | 6 | 2 | 20 | 9 |
| 6. | Мал амьтны даатгал | 2 | - | - | - | 2 | - |
| 7. | Хариуцлагын даатгал | 147 | 192 | 197 | 29 | 565 | 143 |
| | НИЙТ | 1,689 | 1,984 | 1,703 | 169 | 5,455 | 1,365 |

Дээрх хүснэгтээс үзвэл Мандал даатгал ХХК нь дурдсан хугацаанд даатгуулагчтай нийт 113,421 (нэг зуун арван гурван мянга дөрвөн зуун хорин нэгэн) сайн дурын даатгалын гэрээ

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС



218
Огноо: 2018/04/16

СЗХ
Үнэт цаасны газар хүлээн авсан огноо
2018 08 29
БҮРТГЭВ
№ 01
НУУЦ БАРИМТ
Эх хувь

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
....... он .... сар .... өдөр

байгууллаас Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар иргэдийн даатгалын 53,330 (тавин гурван мянга гурван зуун гучин) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Сайн дурын даатгалын гэрээ, хэлцлүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг *Хавсралт №3:* *"Мандал даатгал ХХК-ийн даатгуулагчтай бичгээр байгуулсан гэрээний мэдээлэл"*-ээс дэлгэрүүлэн танилцана уу.

Үнэт цаас гаргагч нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа даатгалын бүтээгдэхүүн бүрээр тухайн бүтээгдэхүүний даатгалын гэрээний загвар, гэрээний төслүүдийг даатгуулагч иргэн болон даатгуулагч хуулийн этгээд /байгууллага/ хэмээн хувааж гаргаж өгсөн.

**Нэг. Даатгуулагч иргэдтэй байгуулсан гэрээ, хэлцэл**

Иргэдийн даатгалын хувьд Үнэт цаас гаргагчийн өгсөн мэдээ, статистикаас харвал нийт 6 хэлбэрээр 107,966 (нэг зуун долоон мянга есөн зуун жаран зургаан) гэрээ байгуулсан байх бөгөөд тус 6 хэлбэрт хамаарах 51,965 (тавин нэгэн мянга есөн зуун жаран таван) гэрээ хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үнэт цаас гаргагч нь эдгээр хүчин төгөлдөр гэрээ, хэлцлүүдэд хамаарах, дараах гэрээний загвар, төслийг Хуулийн фирмд танилцуулсан.

**Гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хэлбэр:**

Гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хэлбэрт хамаарах даатгалын үйлчилгээний хүрээнд Үнэт цаас гаргагч нь иргэд болон хуулийн этгээдийн онцлогт тааруулан хэд хэдэн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог байна.

Иргэдтэй байгуулж байгаа даатгалын бүтээгдэхүүнүүдийн хувьд Мандал даатгал ХХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд Гэнэтийн осол, эмчилгээний даатгалын 55,914 (тавин таван мянга есөн зуун арван дөрвөн) даатгалын бүтээгдэхүүн борлуулснаас нийт 29,925 (хорин есөн мянга есөн зуун хорин таван) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байх бөгөөд дараах бүтээгдэхүүнийг борлуулдаг байна. Үүнд:

(i) Жаргалан эрүүл мэндийн даатгал (Гоулд багц);
(ii) Жаргалан эрүүл мэндийн даатгал (Платиниум багц);
(iii) Олон улсын эрүүл мэндийн даатгал;
(iv) Ипотекийн зээлдэгчийн амь нас эрүүл мэндийн даатгал.

Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүн нь ипотекийн зээл авсан зээлдэгчдэд зориулсан бөгөөд СЗХ-ны эгээс 2017 оны 05 сарын 17-ны өдрийн №109 тоот тогтоолоор батлагдсан "Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам"-д нийцүүлэн СЗХ-ны 2017 оны 11 сарын 23-ны өдрийн №6/3431 тоот тогтоолын дагуу бүртгэгдсэн бүтээгдэхүүн байна. Мандал даатгал ХХК нь Голомт банк, ХААН банк, Улаанбаатар банктай Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр тэдгээр банкны зээлдэгч, харилцагч иргэдтэй Ипотекийн зээлдэгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын гэрээг байгуулан ажиллаж байна.

Гадаадад зорчигчдын гэнэтийн ослын даатгалын хэлбэрт хамаарах бүтээгдэхүүний хувьд даатгалын гэрээг шууд иргэдтэй байгуулан ажилладаг бол ХААН банк, Голомт банк, Нью Жуулчин Турс ХХК-тай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр тус байгууллагын карт эзэмшигч, жуулчдад зориулсан дараах тусгай бүтээгдэхүүнийг санал болгодог байна. Үүнд:

(v) Гадаадад зорчигчийн гэнэтийн ослын даатгал;
(vi) Голомт банкны амекс алтан карт, виза платиниум карт, мастер платиниум карт эзэмшигчийн гадаадад зорчигчийн даатгал;
(vii) Голомт банкны амекс грийн карт эзэмшигчийн гадаадад зорчигчийн даатгалын гэрээ;
(viii) Гадаадад зорчигчийн гэнэтийн ослын даатгал (ХААН банк);
(ix) Гадаадад зорчигчийн даатгал (Нью жуулчин).

**Хөрөнгийн даатгалын хэлбэр:**

Үнэт цаас гаргагч нь дурдсан хугацаанд Хөрөнгийн даатгалын хэлбэрт хамаарах 34,234 (гучин дөрвөн мянга хоёр зуун гучин дөрвөн) бүтээгдэхүүн борлуулснаас Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар 14,520 (арван дөрвөн мянга таван зуун хорин) бүтээгдэхүүнд хамаарах гэрээ,

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
мандал даатгал
УЛААНБААТАР ХОТ



МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

Үнэт цаасны СЗХ зохицуулга
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
НУУЦ БАРИМТ № 01
Эх хувь

МАНДАЛ даатгал
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
.... оң .... сар .... өдөр

хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр бүтээгдэхүүнд хамаарах дараах гэрээ, хэлцлүүдийг байгуулдаг байна. Үүнд:

- (i) Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгал;
- (ii) Үл хөдлөх хөрөнгийн даатгал;
- (iii) Орон сууцны даатгал;
- (iv) Хөдлөх хөрөнгийн даатгал;
- (v) Тоног төхөөрөмжийн даатгал;
- (vi) Хүнд даацын машин механизмын даатгал.

Ипотекийн барьцаа хөрөнгийн даатгалын гэрээний хувьд СЗХ-ны 2017 оны 11 сарын 23-ны өдрийн №6/3431 тоот тогтоолын дагуу бүртгэгдсэн бүтээгдэхүүний үндсэн дээр гэрээ хийгдэж байх тул "Ипотекийн даатгалын үйл ажиллагааны журам"-д нийцсэн байна гэж үзлээ.

**Авто тээврийн хэрэгслийн даатгалын хэлбэр:**

Мандал даатгал ХХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд иргэдтэй Авто тээврийн хэрэгслийн даатгалын 17,759 (арван долоон мянга долоон зуун тавин есөн) гэрээ байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 7,512 (долоон мянга таван зуун арван хоёр) хүчин төгөлдөр гэрээ хэрэгжиж байна.

Мандал даатгал ХХК нь иргэдтэй дараах төрлийн тээврийн хэрэгслийн даатгалын гэрээг байгуулан ажиллаж байна. Үүнд:

- (i) Сонголт – Тээврийн хэрэгслийн даатгал;
- (ii) Классик – Ердийн тээврийн хэрэгслийн даатгал;
- (iii) Ухаалаг хамгаалалт – Тээврийн хэрэгслийн даатгал;

Мөн түүнчлэн Голомт банк, ХААН банк болон CCI ББСБ байгууллагуудтай байгуулсан Хамтран ажиллах гэрээний үндсэн дээр эдгээр байгууллагын зээлдэгч, үйлчлүүлэгчидтэй дор дурдсан ялгаатай нөхцөл шаардлага бүхий Авто тээврийн хэрэгслийн даатгалын гэрээ байгуулдаг байна. Үүнд:

- (iv) Тээврийн хэрэгслийн даатгал /Голомт банк/;
- (v) Тээврийн хэрэгслийн даатгал /ХААН банк/;
- (vi) Тээврийн хэрэгслийн даатгал /CCI ББСБ/.

**Ачааны даатгалын хэлбэр:**

Мандал даатгал ХХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд иргэнтэй Ачааны даатгалын 1 (нэг) гэрээ байгуулснаас 2018 оны 3-р сарын 01-ний өдрийн байдлаар нийт 1 (нэг) хүчин төгөлдөр гэрээ хэрэгжиж байна.

**Барилга угсралтын даатгалын хэлбэр:**

Мандал даатгал ХХК-аас сүүлийн 3 жилийн хугацаанд иргэнтэй Барилга угсралтын даатгалын 1 (нэг) гэрээ байгуулсан байх бөгөөд тус даатгал нь хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

**Хариуцлагын даатгалын хэлбэр:**

Мандал даатгал ХХК-аас сүүлийн 3 жилийн хугацаанд иргэнтэй Хариуцлагын даатгалын 57 (тавин долоон) гэрээ байгуулснаас Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар нийт 6 (зургаан) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Эдгээр сайн дурын даатгалын эдгээр дурдсан гэрээ, хэлцлүүдийн загвар, төсөл нь тусгайлан дурдаж судалж үзэхийг санал болгосон асуудлуудаас бусдаар хууль тогтоомжид нийцсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Хоёр. Даатгуулагч хуулийн этгээд/байгууллагатай байгуулсан гэрээ, хэлцэл**

Хуулийн этгээд/байгууллагын даатгалын хувьд Үнэт цаас гаргагчийн өгсөн мэдээ, статистикаас харвал 7 хэлбэрт хамаарах 5,455 (таван мянга дөрвөн зуун тавин таван) бүтээгдэхүүн

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489



МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК
220
Огноо: 2018/04/16

СЗХ
Үнэт цаасны зохицуулалт
2018 .08. 29 өдөр
БҮРТГЭВ
НУУЦ БАРИМТ
Эх хувь



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

борлуулснаас 1,365 (нэг мянга гурван зуун жаран таван) бүтээгдэхүүнд хамаарах гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр 7 хэлбэрийн хүчин төгөлдөр гэрээ, хэлцлүүдэд хамаарах, гэрээний загвар, төслийг Хуулийн фирмд танилцуулсан. Тус хэлбэрийн бүтээгдэхүүнүүдийн хувьд даатгалын үйлчилгээний онцлогоос хамаарч Үнэт цаас гаргагч нь аливаа хуулийн этгээдтэй даатгалын ерөнхий гэрээ байгуулах замаар хамтран ажиллах бөгөөд ерөнхий гэрээний хүрээнд даатгалын бүтээгдэхүүн бүрээр давхар дэд гэрээ байгуулах зарчмаар хамтран ажилладаг байна.

**Гэнэтийн осол, эмчилгээний даатгалын хэлбэр:**

Гэнэтийн осол, эмчилгээний даатгалын 449 (дөрвөн зуун дөчин есөн) гэрээ, хэлцэл байгуулснаас нийт 97 (ерэн долоон) гэрээ хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

**Хөрөнгийн даатгалын хэлбэр:**

Хөрөнгийн даатгалын 426 (дөрвөн зуун хорин зургаан) гэрээ, хэлцэл байгуулснаас нийт 105 (нэг зуун таван) гэрээ хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

**Авто тээврийн хэрэгслийн даатгалын хэлбэр:**

Авто тээврийн хэрэгслийн даатгалын 3,912 (гурван мянга есөн зуун арван хоёр) гэрээ, хэлцэл байгуулснаас 998 (есөн зуун ерэн найман) гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

**Ачааны даатгалын хэлбэр:**

Мандал даатгал ХХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд Ачааны даатгалын 81 (наян нэгэн) гэрээг хуулийн этгээдтэй байгуулснаас нийт 13 (арван гурван) хүчин төгөлдөр гэрээ хэрэгжиж байна.

**Барилга угсралтын даатгалын хэлбэр:**

Мандал даатгал ХХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд Барилга угсралтын даатгалын 20 (хорин) гэрээг хуулийн этгээдтэй байгуулснаас нийт 9 (есөн) хүчин төгөлдөр гэрээ хэрэгжиж байна.

**Мал амьтны даатгалын хэлбэр:**

Мандал даатгал ХХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд Мал амьтны даатгалын 2 (хоёр) гэрээг хуулийн этгээдтэй байгуулснаас хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээ байхгүй байна.

**Хариуцлагын даатгалын хэлбэр:**

Мандал даатгал ХХК нь сүүлийн 3 жилийн хугацаанд Хариуцлагын даатгалын 565 (таван зуун жаран таван) гэрээ байгуулснаас нийт 143 (нэг зуун дөчин гурван) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна.

Сайн дурын даатгалын эдгээр дурдсан гэрээ, хэлцлүүдийн загвар, төсөл нь тусгайлан дурдаж судалж үзэхийг санал болгосон асуудлуудаас бусдаар хууль тогтоомжид нийцсэн байна гэж Хуулийн фирмээс үзсэн.

Даатгалын бүтээгдэхүүний жишиг гэрээ, төсөлтэй танилцах явцад даатгалын нөхөн төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр олгохоор гэрээнд тусгасан хэдэн тохиолдол ажиглагдлаа. ДТХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.6 дахь хэсэгт "даатгалын нөхөн төлбөр" гэж гэрээний дагуу даатгалын тохиолдол үүсэн нөхцөлд даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн хөрөнгийг хэлнэ" гэж тодорхойлж өгчээ. Бидэнд ирүүлсэн Голомт банкны алтан карт эзэмшигч иргэнтэй байгуулдаг Гэнэтийн ослын даатгалын гэрээний 3 дугаар зүйлийн 3.1.6 дахь хэсэгт "Нөхөн төлбөр гэдэг нь даатгалын тохиолдол бий болсон нөхцөлд даатгалын зүйлд учирсан хохирлыг нөхөн төлөх зорилгоор даатгагчаас даатгуулагчид олгох мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийг хэлнэ", Тоног төхөөрөмжийн даатгалын дэд гэрээний 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, Үл хөдлөх хөрөнгийн даатгалын дэд гэрээний 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, Тээврийн хэрэгслийн даатгалын дэд гэрээний 13.2 дахь хэсэг, Хүнд машин механизмын даатгалын дэд гэрээний 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт тус тус "Даатгалын тохиолдлын улмаас тоног төхөөрөмжид учирсан хохирлыг

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489



МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
Үнэт цаасны ... 2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01
ЖУУЦ БАРИМТ
Эх хувь

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

Даатгагчийн сонголтоор засварлах эсвэл мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө" гэж тус тус оруулсан байна. Даатгагч нь хамтран ажиллах гэрээний дагуу нөхөн төлбөрийг даатгалын зүйлийг сэргээх ажлыг гүйцэтгэж байгаа этгээдэд шууд шилжүүлэх замаар хэрэгжүүлж байгаа нь практикт маргаан, үл ойлголцол гарах эсэх, СЗХ-ны зүгээс хэрхэн үзэж байгаа талаар тодруулж, СЗХ-нд танилцуулан хэрэгжүүлэхийг санал болгож байна.

Мөн өмнө дурдсанчлан СЗХ-ны 2015 оны 11 сарын 23-ны өдрийн №407 тоот тогтоолоор батлагдсан "Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам-ыг баталсан байх бөгөөд тус журмын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт даатгагч нь даатгалын аливаа бүтээгдэхүүнийг нийтэд үзүүлэхдээ бүтээгдэхүүний жишиг загварыг СЗХ-нд бүртгүүлсний үндсэн дээр үзүүлэхээр тогтоож өгсөн байна. СЗХ-ны 2018 оны 03 сарын 29-ны өдрийн №6/1603 тоот албан бичгээс үзвэл Үнэт цаас гаргагчийн одоо хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа даатгалын бүтээгдэхүүнээс Жаргалан эрүүл мэндийн даатгал, Ухаалаг хэмнэлт зэрэг тээврийн хэрэгслийн даатгалын хэлбэрт хамаарах бүтээгдэхүүнүүдийг СЗХ-нд бүртгүүлсэн эсэх нь тодорхойгүй байгааг анхаарч, цаашид СЗХ-нд бүртгэлтэй эсэхийг тодруулж, бүртгүүлээгүй нөхцөлд бүртгүүлж ажиллахыг санал болгож байна.

**Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний хувьд авч үзвэл:**

Үнэт цаас гаргагчийн Хуулийн фирмд гаргаж өгсөн даатгалын үйлчилгээнд хамаарах гэрээ, хэлцлээс бусад гэрээ, хэлцлийг судлан үзвэл Мандал даатгал ХХК нь энэхүү хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар тайлан тэнцэлд тусгагдсан хувь нийлүүлсэн хөрөнгийн тав, түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл байгуулаагүй байна гэж үзлээ.

Мандал даатгал ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцлүүдийн хувь дээр талуудыг төлөөлөх этгээдүүд харилцан гарын үсэг зурсан, тамга, тэмдэг дарсан, хуульд зааснаар бүртгүүлэх буюу нотариатаар гэрчлүүлбэл зохих гэрээ, хэлцлийг ийнхүү бүртгүүлсэн буюу гэрчлүүлсэн, хуулийн шаардлага хангасан, холбогдох хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр бөгөөд аливаа сөрөг, ноцтой үр дагавар үүсээгүй байна гэж үзлээ.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Мандал даатгал ХХК-ийн сүүлийн 3 жил дотор даатгуулагчаас бусад этгээдтэй байгуулсан хүчин төгөлдөр үйлчилж буй худалдах болон худалдан авах гэрээ, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ, контракт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна гэж дүгнэлээ.**

Хуулийн фирм дүгнэлт гаргах үеийн байдлаар байгуулж байгаа гэрээ, хэлцлийн загвар, жишиг төсөл дээр үндэслэн дүн шинжилгээ хийсэн бөгөөд СЗХ-нд бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүндээ өөрчлөлт оруулсан эсэх, холбогдох даатгалын гэрээнд тухай бүр оруулсан өөрчлөлтийн тоо хэмжээ, өөрчлөлтийг СЗХ-д бүртгүүлсэн эсэх зэрэг СЗХ-ны хяналтад хамаарах асуудлаар дүн шинжилгээ гаргаагүй болохыг анхаарна уу.

**Тав. Сүүлийн 3 жил дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:**

Тус асуудлын хүрээнд Хуулийн фирм нь 2015 оны 03 сарын 01-ний өдрөөс хойш Мандал даатгал ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл дотор их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, байгуулагдсан нөхцөлд КТХ-ийн дагуу хийгдсэн эсэх асуудлыг судалж үзлээ.

**Их хэмжээний хэлцэл**

КТХ-ийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалт, 87.1.2 дахь заалтад зааснаар "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25%-аас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/ болон компанийн урьд гаргасан энгийн

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1172386007 5473489



МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
2018 08 29
БҮРТГЭВ
НУУЦ БАРИМТ
Эх хувь

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцдог байна. Хуулийн фирмийн зүгээс хуульд заасан **"компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй"** гэсэн нөхцөлийг баримтлан даатгагчийн эрхлэх үндсэн үйл ажиллагаанд хамаарах даатгалын гэрээ хэлцлүүдийг хураамжийн нийт үнийн дүн, гэрээ, хэлцлээр тохиролцсон нөхөн төлбөрийн дээд хэмжээнээс үл хамааруулан их хэмжээний хэлцэлд тооцоогүй.

Мандал даатгал ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас **балансын нийт актив**[17] болон балансын активын 25%-ийн дүнг тооцож үзвэл дараах хэмжээтэй байна. Үүнд:

Хүснэгт №8: Балансын активын 25%-ийн тоон үзүүлэлт.

| № | Улирал | Тухайн улирлын балансын нийт актив /төгрөгөөр/ | Тухайн улирлын балансын активын 25% /төгрөгөөр/ |
|---|---|---|---|
| 1. | 2014 оны 4 улирал | 9,390,493,594 | 2,347,623,399 |
| 2. | 2015 оны 1 улирал | 9,416,683,705 | 2,354,170,926 |
| 3. | 2015 оны 2 улирал | 9,403,159,129 | 2,350,789,782 |
| 4. | 2015 оны 3 улирал | 9,625,730,736 | 2,406,432,684 |
| 5. | 2015 оны 4 улирал | 9,797,300,456 | 2,449,325,114 |
| 6. | 2016 оны хагас жил | 13,559,636,384 | 3,389,909,096 |
| 7. | 2016 оны жилийн эцэс | 17,309,429,756 | 4,327,357,439 |
| 8. | 2017 оны хагас жил | 22,818,068,903 | 5,704,517,226 |
| 9. | 2017 оны жилийн эцэс | 21,472,150,491 | 5,368,037,623 |

Хуулийн фирм нь 2015 оны 03 сарын 01-ний өдрөөс хойш тасалбар болгон гэрээ, хэлцлийн жагсаалт, бүртгэлийг хүлээн авсан. Хүлээн авсан баримт материалын дагуу үзвэл Мандал даатгал ХХК нь дурдагдсан хугацааны дотор нийт 684 (зургаан зуун наян дөрвөн) гэрээ, хэлцлийг даатгуулагчаас бусад этгээдтэй буюу даатгалын гэрээнээс бусад төрлийн гэрээ, хэлцлийг бичгээр байгуулсан байна. Эдгээр гэрээ, хэлцлүүдээс үзвэл их хэмжээний гэрээ, хэлцэл байгуулагдаагүй байна.

**Сонирхлын зөрчилтэй хэлцэл**

КТХ-ийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт "Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай КТХ-д тодорхойлсон харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно" гэж заасан байна.

Мандал даатгал ХХК-аас нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлийг Хуулийн фирмд гаргаж өгсөн. Дэлгэрэнгүй мэдээлэл, нэрсийн жагсаалтыг *Хавсралт №4: "Мандал даатгал ХХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт"*-аас танилцана уу. **Тус мэдээлэл нь Мандал даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хувийн мэдээллийг агуулсан хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцад хамаарах үндэслэлтэй баримт тул төрийн эрх бүхий байгууллага болон одоогийн хувьцаа эзэмшигчид, ирээдүйн хөрөнгө оруулагчдаас бусад этгээдэд хаалттай, нууц мэдээлэлд тооцогдож болохыг анхаарч ажиллахыг Хуулийн фирмээс санал болгож байна.**

КТХ-ийн 91 дүгээр зүйлийн 91.3 дахь хэсэгт[18] заасны дагуу компани нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлийг тухай бүр хөтлөх үүрэгтэй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд

[17] "Балансын нийт актив" гэдэгт Санхүү байдлын тайлангийн "Өр төлбөр ба Эздийн өмч" гэсэн үзүүлэлтийн эцсийн үлдэгдэл гэсэн харгалзах баганад /босоо үзүүлэлт/ байгаа мөнгөн хөрөнгийг тооцож ойлгосон болно. Хуулийн фирм.
[18] Компанийн тухай хууль (2011).
91 дүгээр зүйл Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавих шаардлага
91.3 Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй.



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК
223
Огноо: 2018/04/16

СЭХ
Үнэт цаасны танилцуулга
БҮРТГЭВ
№

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
.... он .... сар .... өдөр

нь компанийн ТУЗ-д өөрийн хувийн байдлын талаар мэдээлэл өгөх хуулиар ногдуулсан үүрэгтэй байна.

Хуулийн фирм нь нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлохдоо Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн бүртгэл, баримт бичиг дээр үндэслэсэн бөгөөд эдгээр баримт материал нь КТХ-ийн 89.1 дэх хэсэгт заасан шаардлагыг бүрэн хамарсан эсэх болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд хэлцэл хийхдээ сүүлийн 3 жилийн хугацаанд компанид тухай бүр мэдээлэх үүргээ биелүүлсэн[19] эсэх асуудлаар бие даан дүн шинжилгээ хийх, баталгаа гаргах боломжгүй байгааг анхаарна уу.

Мандал даатгал ХХК-аас бидэнд сүүлийн 3 жилийн дотор байгуулсан нийт 20 (хорин) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийг ирүүлсэн. Үүнээс:

Хүснэгт №9: Сонирхлын зөрчилтэй гэж үзсэн гэрээ, хэлцлийн жагсаалт.

| Он | 2015 | 2016 | 2017 | 2018 | Нийт |
|---|---|---|---|---|---|
| Хэрэгжиж байгаа, дуусгавар болоогүй | - | 2 | 2 | 2 | 6 |
| Дуусгавар болсон* | 9 | 3 | 2 | - | 14 |
| НИЙТ | 9 | 5 | 4 | 2 | 20 |

*Үүрэг гүйцэтгэх хугацаа дуусгавар болсон үүргийн гүйцэтгэлийг шаардах эрх нь хэвээр байгаа гэрээ, хэлцлийг дуусгавар болсон гэрээнд тооцож явсан болохыг анхаарна уу.

Эдгээр гэрээ, хэлцлүүдийн нийт жагсаалт, гэрээний зүйл, гэрээний гол нөхцөлүүдийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг *Хавсралт №5: "Мандал даатгал ХХК-ийн сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл"*-ийн хүснэгтээс дэлгэрүүлэн үзэж танилцана уу. Тус гэрээ, хэлцлүүдийн жагсаалтын хүрээнд даатгалын гэрээ, хэлцэл байгуулагдаагүй байна.

Эдгээр бичгээр байгуулсан гэрээ, хэлцлүүд нь агуулгын хувьд хуульд харшилсан, хууль зөрчсөн нөхцөл, журмыг тохиролцоогүй, талуудын гарын үсэг зурагдсан, хуулийн этгээдийн тэмдэг (тамга) дарж баталгаажуулсан хуульд заасан нөхцөлийг хангасан, хүчин төгөлдөр гэрээ, хэлцлүүд байна гэж Хуулийн фирм үзлээ.

Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах журмыг КТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт "... сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана, 92.2 дахь хэсэгт "Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно" гэж тодорхойлсон байна. Өөрөөр хэлбэл сонирхлын зөрчилтэй хэлцлийн гэрээний зүйлийн үнийг ТУЗ тогтоох бөгөөд хэлцэл хийх зөвшөөрлийг сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхын саналаар олгохоор хуульд зохицуулсан байна.

Дурдсан сонирхлын зөрчилтэй хэлцлүүдийн хувьд ХЭХ-аас зах зээлийн жишиг үнэлгээгээр хэлцэл хийх зөвшөөрлийг Гүйцэтгэх захиралд олгож, ТУЗ-ийн хараат бус гишүүнд тухай бүр хяналт тавьж хэрэгжүүлэхийг үүрэг болгож шийдвэрлэсэн байна. Хуулийн фирмээс сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлүүдийн үнийн дүнг зах зээлийн журмаар тогтоож байгуулсан гэж үзсэн болно.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Мандал даатгал ХХК нь сүүлийн 3 жил дотор 20 (хорин) сонирхлын зөрчилтэй хэлцлийг ТУЗ-аас зөвшөөрөл олгосны үндсэн дээр байгуулсан байна гэж дүгнэх үндэслэлтэй байна.**

[19] 91 дүгээр зүйл.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавих шаардлага
91.1.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ болон аудиторт дараах зүйлийг мэдээлэх үүрэгтэй:
91.1.1.дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг хуулийн этгээдийн болон түүний хараат болон охин компанийн талаар;
91.1.2.өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь эрх бүхий албан тушаалтнаар ажилладаг хуулийн этгээдийн болон тухайн этгээд оролцогч нь байдаг компанийн нэгдлийн бусад оролцогчийн талаар;
91.1.3.компанийн хийхээр төлөвлөж байгаа хэлцлийн сонирхол бүхий этгээд болох тухайгаа;
91.1.4.энэ хуулийн 89.1-д заасан этгээд өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн талаар.



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

224
Огноо: 2018/04/16

Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.8.1 дэх хэсэгт "Компани нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл ба сонирхлын зөрчлийг зохицуулах бодлоготой байна" гэж заасан байна. Иймд цаашид жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, хангах зорилгоор нэгдмэл сонирхолтой этгээдтэй даатгалын гэрээ хэлцэл байгуулах, нөхөн төлбөр олгох харилцаандаа бодлого журам боловсруулан даган мөрдөх, мэдээллийн ил тод байдлыг баримталж ажиллахыг Хуулийн фирмийн зүгээс санал болгож зөвлөж байна.

**Зургаа. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл бүй эсэх асуудлаар:**

**Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз**[20]

ААУАТЗТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.3.2 дахь заалтад банк бус санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр арилжааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх нөхцөлд тусгай зөвшөөрөл авахаар хуульчилсан байна. Санхүүгийн үйл ажиллагааны дотроо даатгалын салбарын онцлог зохицуулалтын хувьд СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглодог[21] бөгөөд тусгай зөвшөөрлийн нөхцөлийн дагуу зөвхөн даатгал, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа эрхэлдэг байна.

Тус асуудлын хүрээнд СЗХ-ны 2011 оны 06 сарын 02-ны өдрийн №146 тоот тогтоолын дагуу Мандал даатгал ХХК-д дараах **хэлбэрүүдээр** ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Үүнд:

1. *Гэнэтийн осол, эмчилгээний зардлын даатгал;*
2. *Хөрөнгийн даатгал;*
3. *Автотээврийн хэрэгслийн даатгал;*
4. *Ачааны даатгал;*
5. *Барилга угсралтын даатгал;*
6. *Агаарын хөлгийн даатгал;*
7. *Автотээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал;*
8. *Хариуцлагын даатгал.*

Мөн СЗХ-ны 2012 оны 04 сарын 18-ны өдрийн №146 тоот тогтоолын дагуу Мандал даатгал ХХК-д дараах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Үүнд:

9. *Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал.*

СЗХ-ны 2012 оны 06 сарын 20-ны өдрийн №163 тоот тогтоолын дагуу Мандал даатгал ХХК-д дараах **хэлбэрүүдээр** ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Үүнд:

10. *Газар тариалангийн даатгал;*
11. *Мал амьтдын даатгал;*
12. *Санхүүгийн даатгал.*

СЗХ-ны 2013 оны 05 сарын 08-ны өдрийн №188 тоот тогтоолын дагуу Мандал даатгал ХХК-д дараах **хэлбэрүүдээр** ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгогдсон байна. Үүнд:

13. *Санхүүгийн даатгал;*

---

[20] Үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай төрийн байгууллагаас олгох зөвшөөрлийг ойлгож дүгнэлт хийлээ. Хуулийн фирм.
[21] Даатгалын тухай хууль (2004).
16 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох
16.1.Энэ хуулийн 16.3, 17.2-т зааснаас бусад этгээд Зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр Монгол Улсад болон Монгол Улсаас гадаад улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.
16.5.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна

СЗХ
он сар өдөр
2018-08-29
БҮРТГЭВ
№ 01
ҮНДСЭН БАРИМТ

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

14. *Зээлийн даатгал;*
15. *Итгэлцлийн даатгал;*
16. *Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал;*
17. *Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал.*

Эндээс үзвэл Мандал даатгал ХХК нь СЗХ-оос авсан зөвшөөрлийн дагуу нийт 17 хэлбэрийн ердийн даатгалд хамаарах даатгалын үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй байна. Үүнээс албан журмын даатгалын төрөлд хамаарах 1 хэлбэр, сайн дурын даатгалын төрөлд хамаарах 16 хэлбэр байна.

Мөн СЗХ-ны 2018 оны 03 сарын 29 ний өдрийн №б/1603 тоот Хариу хүргүүлэх тухай албан тоотоос үзвэл Мандал даатгал ХХК нь дээр дурдсан 17 хэлбэрт хамаарах 52 бүтээгдэхүүнийг СЗХ-нд бүртгүүлсэн байна. Тус тусгай зөвшөөрлүүд нь хүчин төгөлдөр эсэх, цуцлагдах, хугацаа дуусах аливаа нөхцөл үүссэн эсэх асуудлаар СЗХ-оос лавлагаа, тодорхойлолт хүссэн бөгөөд СЗХ-ны 2018 оны 03 сарын 15-ны өдрийн №б/1009 тоот Хариу хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл эдгээр олгогдсон тусгай зөвшөөрлүүд нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, хүчингүй болгох эрсдэлтэй нөхцөл үүссэн талаар аливаа тодорхойлолт мэдээлэл байхгүй байна.

Даатгалын тухай хууль тогтоомж болон ААҮАТЗТХ-д тодорхойлсон нөхцөл, журмаас үзвэл даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг барьцаалах хууль зүйн боломжгүй[22] болохыг тусгайлан дурдах нь зүйтэй байна.

Мандал даатгал ХХК нь үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөс бусад төрийн эрх бүхий байгууллагаас авсан аливаа зөвшөөрөл/лиценз эзэмшдэггүй байна.

**Зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг**

Хуулийн фирм нь ОӨУБЕГ-ын Оюуны өмчийн газраас Мандал даатгал ХХК дээр бүртгэгдсэн, хүчин төгөлдөр зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг зэрэг оюуны өмч, эдийн бус хөрөнгийн талаар мэдээлэл, тодорхойлолт хүссэн бөгөөд тус газраас 2018 оны 03 сарын 26-ны өдөр ирүүлсэн №10/2355 тоот Лавлагаанаас үзвэл Мандал даатгал ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй 3 барааны тэмдэг /ineed, Мандал, Жаргалан/ хүчин төгөлдөр байна. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн цахим санд хандаж хайлт хийж үзвэл тус барааны тэмдгүүд дээр бүртгэлтэй аливаа барьцааны мэдээлэл байхгүй байна.

**Дүгнэж үзвэл Мандал даатгал ХХК-ийн нэр дээр байгаа үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах нөхцөл байдал үүсээгүй, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгээгүй байна.**

**Долоо. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар:**

Үнэт цаас гаргагч компанийн гаргаж өгсөн мэдээллээс тус компанийг эзэмшил, өмчлөлдөө аливаа төрлийн үнэт цаас байхгүй бөгөөд, газар, түүнийг эзэмших, ашиглахтай холбоотой аливаа эрх байхгүй гэж үзлээ.

**Үл хөдлөх эд хөрөнгө**

ӨОУБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын Сүхбаатар дүүргийн бүртгэлийн хэлтсийн 2018 оны 02 сарын 28-ны өдрийн №002296493 тоот Тодорхойлолтоос үзвэл тус компани

[22] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль (2001).
5 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн үйлчлэх хүрээ
5.3.Тусгай зөвшөөрлийг хуульд зааснаас бусад тохиолдолд бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.
Даатгалын тухай хууль (2004).
16 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг хориглох
16.5.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473469



МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
1117236573 5481989
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК
226
Огноо: 2018/04/16

СЭХ
2018.08.29
БҮРТГЭВ
№ 01



МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

эрхийн улсын бүртгэлийн Y-2206014229 дугаарт бүртгэгдсэн Хан-Уул дүүргийн 11-р хороо, олимпийн гудамж, маршал хотхоны 102-р байрны 17 тоот орон сууцны өмчлөгчөөр бүртгэгдсэн байна. ӨОУБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын Хан-Уул дүүргийн бүртгэлийн хэлтсийн 2018 оны 3 сарын 12-ны өдрийн №11-1127799 тоот Тодорхойлолтоос үзвэл Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 05 сарын 02-ны өдрийн 101/ШЗ-2016/18032 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн шүүхийн гүйцэтгэх албанаас 2016 оны 05 сарын 09-ний өдрийн №3/17420 тоот тогтоолын дагуу дээр дурдсан орон сууцыг захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн байна.

ШШГЕГ-ын Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2018 оны 03 сарын 23-ны өдрийн №1/5229 тоот Албан бичгээс үзвэл тус газраас үл хөдлөх эд хөрөнгө захиран зарцуулах эрхийг сэргээж шийдвэрлэсэн болохыг уламжилсан байна. Иймд тус үл хөдлөх эд хөрөнгөнд аливаа барьцаа, батлан даалт болон бусад үүрэг ногдуулсан аливаа хэлцэл бүртгэгдээгүй байна гэж үзлээ.

Тус орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө нь БДО Аудит ХХК-ийн гүйцэтгэсэн Хөрөнгийн үнэлгээний тайланд тусгагдаж үнэлгээ хийгдсэн байгааг анхаарч үнэлгээтэй танилцана уу.

#### Тээврийн хэрэгсэл

АТҮТ-ийн 2017 оны 08 сарын 08-ны өдрийн "Тээврийн хэрэгслийн лавлагаа"-аас үзвэл тус компанийн нэр дээр дараах 9 (есөн) тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байх бөгөөд АТҮТ-ийн 2018 оны 02 сарын 26-ны өдрийн Лавлагаанаас үзвэл эдгээр тээврийн хэрэгслүүдэд барьцаа, батлан даалт болон барьцаа зэрэг үүрэг ногдуулсан аливаа хэлцэл бүртгэгдээгүй байна.

Хүснэгт №10. Мандал даатгал ХХК-ийн өмчлөлд байгаа тээврийн хэрэгслийн жагсаалт

| № | Нэр, модель | Улсын дугаар |
|---|---|---|
| 1. | Yamaha Tricity 3 дугуйт мотоцикл | УБ 0395 |
| 2. | Yamaha Tricity 3 дугуйт мотоцикл | УБ 0334 |
| 3. | Yamaha Tricity 3 дугуйт мотоцикл | УБ 0563 |
| 4. | Lexus LS460 | 4302 УНН |
| 5. | Lexus GX470 | 6818 УНЦ |
| 6. | Toyota Prius | 7686 УНР |
| 7. | Toyota Crown | 6325 УНТ |
| 8. | Toyota Prius | 1521 УНҮ |
| 9. | Toyota Land Cruiser 200 | 4506 УБЯ |

Мандал даатгал ХХК нь эдгээр тээврийн хэрэгслүүдээс 6818УНЦ, 6325УНТ, 4506УБЯ зэрэг тээврийн хэрэгслийн өмчлөх эрхийг бусдад шилжүүлж байгаа талаар дурдсан. Бусад тээврийн хэрэгслүүд нь БДО Аудит ХХК-ийн гүйцэтгэсэн Хөрөнгийн үнэлгээний тайланд тусгагдаж үнэлгээ хийгдсэн болохыг дурдаж байна.

Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн цахим сан[23] хандаж хайлт хийж үзвэл Мандал даатгал ХХК-ийн нэр дээр хөдлөх хөрөнгө, ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, бүх төрлийн хувьцаа, үнэт цаас, шаардах эрх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загвар болон бусад хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгөтэй холбоотой барьцааны аливаа бүртгэл байхгүй байна.

Орон сууцны зориулалттай үл хөдлөх эд хөрөнгө, тээврийн хэрэгслээс бусад БДО Аудит ХХК-ийн гүйцэтгэсэн Хөрөнгийн үнэлгээний тайланд багтсан Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайлан тэнцэл/балансаас тусгагдсан хөдлөх хөрөнгийн хувьд өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй байх тул бүртгэлтэй холбоотой асуудлаар Үнэт цаас гаргагчаас тодруулж асууна уу.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал



МОНГОЛ УЛС
...КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
Үнэт цаасны танилцуулга
он сар өдөр
2018.03.29 БҮРТГЭВ
НӨЛӨӨЛӨЛ БАРИМТ № 01

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

**Найм. Мандал даатгал ХХК-ийн үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр баримтаар нотлогдож буй эсэх асуудлаар:**

ҮЦЗЗТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу тус Хуулийн фирм нь андеррайтер Голомт капитал ҮЦК ХХК-ийн бэлтгэж ирүүлсэн "Үнэт цаасны танилцуулга"-д тусгагдсан мэдээллүүдийг нягталж нийтэд илэрхий мэдээ баримт, төрийн болон эрх бүхий байгууллагуудаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтууд, Үйлчлүүлэгчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр дүгнэлт гаргасан.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа, эзэмшиж байгаа тусгай зөвшөөрөл, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр, түүний нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн мэдээлэл, тэдгээрийн дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь хэмжээ, Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, өмнө зарласан болон гаргасан, эргүүлэн худалдан авсан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг биет болон биет бус хөрөнгийн талаарх мэдээллүүд нь үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ.

Дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад макро болон даатгалын салбарын эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлтүүд, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлтүүд болон хөрөнгө оруулагчдад санал болгож байгаа арилжааны нөхцөлүүд, үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах нөхцөл, журам, хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, нийтэд санал болгож байгаа үнэт цаасыг арилжих нөхцөл, журам, ногдол ашиг хуваарилах нөхцөл, журам, нэмж хувьцаа гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн таамаг, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө зэрэг мэдээлэлд Хуулийн фирмийн зүгээс хууль хэрэглээний дүн шинжилгээ хийх боломжгүй тул анхааралдаа авч эдгээр асуудлын хүрээнд үнэт цаас гаргагчаас дэлгэрэнгүй тайлбар, мэдээлэл авахыг Хуулийн фирмийн зүгээс хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд санал болгож байна.

**Ес. Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-ийн хяналтыг хэрэгжүүлэгч этгээдийн асуудлаар:**

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Мандал даатгал ХХК-ийн дүрмээс үзвэл 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 25,000,000 (хорин таван сая) ширхэг энгийн хувьцааг зарласан байна.

Эдгээр зарласан энгийн хувьцаанаас гүйлгээнд 5,000,000 (таван сая) ширхэг хувьцаа гаргасан байх бөгөөд дараах этгээдүүд эзэмшиж байна. Үүнд:

Хүснэгт №11. Мандал даатгал ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт

| № | Хувьцаа эзэмшигч | Эзэмшлийн хувь | Ширхэг | Нэрлэсэн үнэ /мянгаар/ | Нийт /төгрөгөөр/ |
|---|---|---|---|---|---|
| 1. | Голомт файнэншил групп ХХК | 51% | 2,550,000 | 1,000 | 2,550,000,000 |
| 2. | Юу Эм Си капитал ХХК | 49% | 2,450,000 | 1,000 | 2,450,000,000 |
| | Нийт | 100% | 5,000,000 | 1,000 | 5,000,000,000 |

Мөн Үнэт цаас гаргагчийн 1,243,016 (нэг сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаан) ширхэг энгийн хувьцааг халаасны хувьцаагаар бүртгэсэн байна.

Эндээс Хуулийн фирм нь КТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт заасны дагуу Мандал даатгал ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 5,000,000,000 (таван тэрбум) төгрөг байна гэж



МОНГОЛ УЛС
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

СЗХ
Үнэт цаасны зах зээлийн хэлтэс
20 ОН 04 САР 29 ӨДӨР
БҮРТГЭВ
№ 01

НУУЦ БАРИМТ
Эх хувь

МАНДАЛ даатгал
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

Хариуцлага хязгаарлах тухай

Энэхүү Хуулийн дүгнэлт нь хууль зүйн туслалцаа, зөвлөх үйлчилгээнд тооцогдохгүй бөгөөд Хуулийн фирмийн зүгээс Мандал даатгал ХХК-ийн хэлбэрийг өөрчлөн байгуулах төслийн нийт үйл ажиллагаанд хууль зүйн туслалцаа, зөвлөгөө өгөөгүй болно.

Хуулийн фирмийн дүгнэлт нь энд тусгайлан дурдсан асуудлыг хамарсан бөгөөд даатгалын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэгч Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, шалгалтын эрх хэмжээнд хамаарах хууль тогтоомж, даатгалын багц дүрэм, холбогдох журмыг Мандал даатгал ХХК хэрхэн биелүүлж байгаа аливаа асуудлаар дүн шинжилгээ хийгээгүй, Хуулийн дүгнэлтэд хамруулаагүй болохыг анхаарна уу.

Хуулийн дүгнэлтэд тусгайлан дурдсанаас бусад Үнэт цаасны танилцуулгад дурдагдсан асуудлын талаар Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК-аас дэлгэрүүлэн тодруулж асууж нягталсны үндсэн дээр шийдвэрээ гаргахыг хөрөнгө оруулахаар сонирхож буй этгээдүүдэд зөвлөж байна.

Эрх олгогдсон этгээдийн зөвшөөрөлгүйгээр энэхүү дүгнэлтийг бүхэлд нь болон хэсэгчлэн салган авч ашиглах, түгээх, дамжуулах, СЗХ-ны зөвшөөрөлгүйгээр үнэт цаасыг бусдад санал болгохыг хориглоно.

Үнэт цаас гаргагч Мандал даатгал ХХК, түүний холбоо, хамааралтай этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтнууд энэхүү Хуулийн дүгнэлтийг Гэрээгээр харилцан тохиролцсоноос бусад зорилгоор ашигласан, түгээсэн, бусдад танилцуулсан, тайлбарласнаас үүсэх асуудлаар Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

Хуулийн фирм нь хараат бус байх, гаргаж өгсөн баримт материалд үндэслэн дүгнэлт гаргах зарчмыг баримталсан бөгөөд (i) Үйлчлүүлэгчээс орхигдуулсан дүн шинжилгээнд хамруулах шаардлагатай аливаа бусад гол баримт, материалыг санаатай болон санамсаргүй орхигдуулсан, буруу дутуу, худал, төөрөгдүүлсэн мэдээлэл гаргаж өгсөн; (ii) дүн шинжилгээ хийхэд ашигласан хөндлөнгийн этгээдийн гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолт бусад баримт материалд дурдагдсан хууль зүйн ач холбогдолтой аливаа нөхцөл байдалд дүн шинжилгээ хийснээс хойш Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн гарах аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй.

Хуулийн дүгнэлтийг одоо байгаа нөхцөл байдал, өнгөрсөнд болж өнгөрсөн үйл баримтад тулгуурлан хийсэн бөгөөд уг дүгнэлтэд тусгагдсан үр дүнгүүд нь ирээдүйд хэвээр үргэлжлэн байх, хадгалагдах эсхүл өөрчлөгдөх асуудал нь Үнэт цаас гаргагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас шууд шалтгаалах учир Үнэт цаасны танилцуулгад дурдсаны дагуу нийтэд санал болгож байгаа үнэт цаасыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийхдээ үнэт цаасны танилцуулга, үнэт цаас гаргах ажиллагааг сайтар анхааран судалсны үндсэн дээр хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

ХҮНДЭТГЭСЭН,

ЗАХИРАЛ, ӨМГӨӨЛӨГЧ Г.БАТБАЯР

БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХК

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489



МОНГОЛ УЛС
... КАПИТАЛ ҮЦК ХХК
1117236573 5481589
229
Огноо: 2018/04/16

## 6.11. Бизнесийн үнэлгээний тайлан

Нууцлалын гэрээгээр хатуу хязгаарлагдсан

# МАНДАЛ ДААТГАЛ ХХК

**Бизнесийн үнэлгээний тайлан**

**2017 оны 12-р сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон**

### БДО Аудит Хязгаардлагдмал Хариуцлагатай Компани

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

*Энэхүү тайлан нь Хавсралт А-д заасан Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл болон Удирдлагад хаягласан захидалд тусгасан үнэлгээний зорилгын дагуу бэлтгэгдсэн болно. Таны хэрэгцээнд зориулж энэ тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж байна. Зөвхөн гарын үсэг зурж, тамга дарсан хувилбар нь хүчин төгөлдөр болно.*

Монгол улс, Улаанбаатар хот
СБД-1, ЮНЕСКО-гийн гудамж
Нарны зам-62, Юнион Бюлдинг
В блок, 15-р давхар, 1502 тоот

Мандал Даатгал ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
14230, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
13-р хороолол, Нарны зам 87
НСКБ Билдинг

Ноён Б. Жавхлан (цаашид "Та" гэх) танаа:

Огноо: 2018 оны 3-р сарын 23-ны өдөр

Хүндэт ноён,

Бидний хооронд 2018 оны 2-р сарын 21-нд байгуулсан Үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын захидал (цаашид "Гэрээ" гэх)-д заасан дагуу бид Мандал Даатгал ХХК (цаашид "Мандал" гэх)-ийн захиалгаар тус компанийн ердийн даатгалын үйл ажиллагаар хамарсан бизнес (цаашид "Бизнес" гэх)-ийн 100 хувийн хувь оролцоог үнэлж, бизнесийн үнэлгээний тайлан бэлтгэлээ.

Компани нь хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргаж, өмчийн санхүүжилт босгох зорилгоор бизнесийн 100 хувийн хувь оролцоо буюу өмчийн 100 хувийн үнэлгээ (цаашид "Үнэлгээ" гэх) хийхийг биднээс хүссэн.

Энэхүү тайлан нь 2017 оны 12-р сарын 31 ("Үнэлгээний өдөр")-ны байдлаар бизнесийн үнэлгээний үр дүнг нэгтгэсэн болно. Үнэлгээний зорилго нь хараат бус экспертийн журмаар компанийн эрхэлж буй бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцоход оршино.

Үнэлгээний хураангуй дүгнэлт нь энэ тайланд толилуулагдсанаас гадна бидний ашигласан горим, арга зүйн тайлбар, үнэлгээний шинжилгээ хийхэд авч үзсэн хүчин зүйлс багтсан. Бид мөн ашигласан мэдээллийн эх сурвалжийг аливаа хязгаарлалтын хамт энэхүү тайлангийн Хавсралт А-И-д жагсаасан. Хавсралт А-И-д дурдсан мэдээлэл, тооцоолол, үнэлгээний хязгаарлалтын нөхцөл нь уг тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Энэхүү тайланд тусгагдсан бизнестэй холбогдох шинжилгээ нь танай өгсөн мэдээлэлд үндэслэсэн. Бизнесийн үнэ цэнийг мэргэжлийн шүүмж (шийдэл) ашиглан тооцсон тул бусад үнэлгээчид үүнтэй ижил үр дүнг гаргахгүй байж болно гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Бидэнд өгсөн мэдээлэл ба ашигласан төсөөллүүдэд суурилан бид энэхүү тайланд тооцоолсон үнэ цэнэ нь ул үндэслэлтэй гэж үзэж байна.

Энэ үнэлгээнд материаллаг үр нөлөөтэй аливаа мэдээллийг бид олж мэдсэн нөхцөлд холбогдох нэмэлт мэдээллийг тусгах үүднээс өөрсдийн үнэлгээний дүгнэлтээ шинэчлэн найруулах эрхтэй боловч ийм үүрэг хүлээхгүй.

Хэрэв танд аливаа тайлбар эсвэл дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай бол Г.Баянмөнх-тэй +976 9111 4040, bayanmunkh@bdo.mn гэсэн хаягаар, эсвэл Д.Алтансүх +976 9999 1614, altansukh@bdo.mn хаягаар холбоо барина уу.

Таныг хүндэтгэсэн,

Гомбын БАЯНМӨНХ
Удирдах партнер
Тэргүүлэх үнэлгээчин
БДО Аудит ХХК

Даланбаярын АЛТАНСҮХ
Гүйцэтгэх захирал
МНБ
БДО Аудит ХХК

## Тодорхойлолт, товчилсон үгийн тайлар

| Товчилсон үг | Утга |
|---|---|
| БДО Монгол/Бид | БДО Аудит Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани; Улсын бүртгэлийн 2546442 регистрийн дугаартай, аудит, үнэлгээний зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж |
| Гэрээт ажлын захидал | 2018 оны 2-р сарын 21-ны өдөр БДО Монгол болон Мандал Даатгал ХХК-ийн хооронд байгуулсан хөрөнгө ба бизнесийн үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ |
| Даатгалын санхүүгийн загвар | Удирдлагын боловсруулсан даатгалын санхүүгийн загвар |
| Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөө | Удирдлагаас бидэнд ирүүлсэн ойрын ирээдүйн бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөө, ирэх 5 жилийн санхүүгийн байдал, гүйцэтгэл, мөнгөн урсгалын таамаглал |
| ЖААЗ | Жишиг арилжааны арга зүй |
| Жишиг арилжаа | Тайлангийн Хавсралт Е-д тодорхойлсон зах зээлийн арилжаанууд |
| Жишиг компани | Тайлангийн Хавсралт Г-д тодорхойлсон нээлттэй компаниуд |
| ЖКАЗ | Жишиг компанийн арга зүй |
| Зах зээлийн хандлага | Зах зээлийн өгөгдлөөс үүссэн үнэлгээний үржүүлэгч, өмнөх арилжааны харьцуулалтад үндэслэдэг үнэлгээний хандлага |
| КЖДӨ | Капиталын жигнэсэн дундаж өртөг |
| КХҮЗ | Капитал хөрөнгө үнэлгээний загвар |
| МБТХНС | Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан |
| Орлогын хандлага | Бизнесийн нэгжийн бий болгох ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэд үндэслэдэг үнэлгээний арга |

| Товчилсон үг | Утга |
|---|---|
| Оруулсан капиталын үнэ цэнэ | Эх үүсвэрээс үл хамааран бизнест одоогоор оруулсан байгаа мөнгөний нийт дүн бөгөөд нийт хөрөнгөөс өр төлбөр болон мөнгийг хассан үнэ цэнэ байдлаар ихэвчлэн тодорхойлогддог. |
| Өмчийн үнэ цэнэ | Бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэнэ юм. |
| ТЖХХБ | Түүхэн XX-р тайлант жил |
| ТЖХХТ | Ирээдүйн XX-р тайлант жил |
| Удирдлага | Мандал Даатгал ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлан, Эрсдэлийн менежер П.Оргодол |
| УБМХНС | Учирсан боловч мэдээгүй хохирлын нөөц сан |
| УБХНС | Учирч болзошгүй хохирлын нөөц сан |
| Мандал/Компани/ Үйлчлүүлэгч | Мандал Даатгал Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани; Улсын бүртгэлийн 5473489 регистрийн дугаартай,ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж |
| Үнэлгээний баг | Хавсралт 3-д тодорхойлсон БДО Монголын арилжааны үйлчилгээний баг |
| Үнэлгээний өдөр | 2017 оны 12-р сарын 31 |
| ҮОУС | Үнэлгээний олон улсын стандартын консулаас бэлтгэн толилуулдаг Үнэлгээний олон улсын стандарт |
| ХМУ-ийн арга | Хорогдуулсан мөнгөн урсгалын арга |
| Хөрөнгийн хандлага | Бизнесийн нэгжийн тохируулсан цэвэр үнэ цэнэд суурилсан үнэлгээний хандлага |
| ХТӨА | Хүү, татварын өмнөх ашиг |
| ХТЭХӨА/ХТЭӨА | Хүү, татвар, элэгдэл, хорогдолын өмнөх ашиг |
| ХТЭХТТА | Хүү, татвар, элэгдэл, хорогдол, түрээсийн төлбөрийн өмнөх ашиг |
| ХДЗХ | Хятадын Даатгалын Зохицуулах Хороо |

## Тайлангийн агуулга

1. Хураангуй үр дүн ....4
2. Үндсэн мэдээлэл ....5
2.1 Захиалагчийн мэдээлэл ....6
2.2 Гүйцэтгэгчийн мэдээлэл ....6
2.3 Үнэлгээний зорилго ....6
2.4 Үнэ цэнийн суурь ....6
2.5 Үндсэн ба тусгай таамаглалууд ....8
2.6 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал ....9
3. Салбарын тойм ....10
3.1 Макро эдийн засаг ....11
3.2 Хөрш орнуудын даатгалын салбар ....12
3.3 Монгол улсын даатгалын салбарын онцлог ....13
4. Бизнесийн үндсэн мэдээлэл ....14
4.1 Бизнесийн үндсэн мэдээлэл ....15
4.2 Орлого бий болгогч нэгж ....16
5. Санхүүгийн мэдээлэл ....17
5.1 Түүхэн санхүүгийн байдлын тайлан ....18
5.2 Түүхэн орлогын дэлгэрэнгүй тайлан ....19
6. Үнэлгээний шинжилгээ ....20
6.1 Үнэлгээний арга хандлага ....21
6.2 Санхүүгийн таамаглал ....23
6.3 Зах зээлийн шинжилгээ ....25
7. Үнэлгээний үр дүн ....28
Орлогын хандлага: ХМУ загвар ....29
Зах зээлийн хандлага: ЖКАЗ ....30
Зах зээлийн хандлага: ЖААЗ ....31
Өртгийн хандлага: Тохируулсан цэвэр активын арга ....32
Хавсралт ....33
Хавсралт А. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл ....34
Хавсралт Б. Үнэлгээний нийтлэг хандлагууд ....35
Хавсралт В. Капиталын жигнэсэн дундаж өртөг ....36
Хавсралт Г. Жишиг компанийн мэдээлэл ....39
Хавсралт Д. Мөнгөн урсгалын төсөөлөл ....41
Хавсралт Е. Жишиг арилжааны мэдээлэл ....47
Хавсралт Ё. Мэдээллийн эх сурвалж ....48
Хавсралт Ж. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл ....49
Хавсралт З. Үнэлгээний баг ....50
Хавсралт И. Үнэлгээчний тусгай зөвшөөрөл ....51



МАНДАЛ ДААТГАЛ ХХК

МОНГОЛ УЛС

GOLOMT CAPITAL LLC

БҮРТГЭВ

233
Огноо: 2018/04/16

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

## 1. Хураангуй үр дүн

- Бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо бид зах зээлийн хандлага ба орлогын хандлагыг авч үзсэн. Зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээнд бид жишиг компанийн арга зүй болон жишиг арилжааны арга зүйг ашигласан бол орлогын хандлагаар тооцсон үнэлгээнд хорогдуулсан мөнгөн урсгалын загварыг удирдлагын төсөөлөлд үндэслэн тооцсон. Ашигласан аргачлал тус бүрийн үнэлгээний үр дүнг зэрэгцүүлэн хүснэгтэд хураангуйлав.

**Бизнесийн 100 хувийн хувь оролцооны үнэ цэнийн дүгнэлт**

- Бид мэргэжлийн багийн түвшинд шүүн тунгаасны үндсэнд дээр дурдсан арга хандлагуудаас Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүн нь үнэлгээний өдрөөр байдлаар бизнесийн зах зээлийн үнэ цэнийг илүү сайн төлөөлж чадна гэж дүгнэсэн.
- Мандал Даатгал ХХК нь үнэлгээний өдрийн байдлаар 1,805,206 мянган төгрөгийн мөнгө ба мөнгөтэй адилтгах хөрөнгө, 8,416,719 мянган төгрөгийн хадгаламжийн сертификат, 812,728 мянган төгрөгийн үнэт цаастай, санхүүгийн өр төлбөргүй бөгөөд бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **23,619,153 - 25,208,593** мянган төгрөг байх үндэслэлтэй байна.
- Хорогдуулсан мөнгөн урсгалын загвараар тооцсон үнэлгээний дэлгэрэнгүй тооцооллыг 7-р бүлэг болон Хавсралт Д-гээс харна уу.

*Үнэлгээний эцсийн үр дүн*

| *мян төгрөг* | *Доод хязгаар* | *Дээд хязгаар* |
|---|---|---|
| *Урт хугацааны өсөлтийн түвшин* | *3.61%* | *5.61%* |
| Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ | 23,619,153 | 25,208,593 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

*Үнэлгээний үр дүнгүүдийн харьцуулалт*

| *Үнэлгээний арга хандлага* | *мянган төгрөг* |
|---|---|
| Жишиг арилжааны арга | 23,209,501 |
| Жишиг компанийн арга | 27,294,624 |
| Хорогдуулсан мөнгөн урсгал | 23,619,153 |
| Тохируулсан цэвэр активын арга | 5,411,286 |




*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



СЗХ ... 29 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

МОНГОЛ УЛС GOLOMT CAPITAL LLC

234
Огноо: 2018/04/16

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

## 2. Үндсэн мэдээлэл

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

### 2.1 Захиалагчийн мэдээлэл

- Монгол улс, Улаанбаатар 14230, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Нарны зам 87, НСКБ Билдинг-т байрлах Мандал Даатгал ХХК нь энэ үнэлгээний ажлын захиалагч тал бөгөөд бизнесийн үнэлгээний объект мөн.

### 2.2 Гүйцэтгэгчийн мэдээлэл

- Үнэлгээчин нь компанийн бизнесийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар, хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргах зориулалтаар тодорхойлж, үнэлгээний тайланг үйлчлүүлэгчид хүргүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.
- БДО Монгол нь захиалагчийн хүсэлтээр Мандал-ын ердийн даатгалын үйл ажиллагаар хамарсан бизнесийн үнэлгээг гүйцэтгэгч хараат бус мэргэжлийн байгууллага болно. Бид өөрийн компанид ажилладаг тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн үнэлгээчид болон үнэлгээний мэргэжилтнүүдэд суурилан хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэхээс гадна үнэлгээний бус үйлчлүүлэгчдэд аудитын болон бусад зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг, БДО олон улсын сүлжээний Монгол улс дахь гишүүн компани юм.
- Үнэлгээний багийг БДО Монгол-ын үнэлгээ хариуцсан партнер ноён Г.Баянмөнх удирдан гүйцэтгэсэн. Үнэлгээний багийн гишүүдийн талаарх мэдээллийг Хавсралт 3-аас харна уу. Энэ үнэлгээний ажилд тооцооллын болон шинжилгээний аливаа нарийн түвэгтэй нөхцөл байдал үүсэх магадлал бага гэж таамагласан учраас үнэлгээний ажилд аливаа хөндлөнгийн туслалцаа аваагүй.
- Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу БДО Монгол нь энэ үнэлгээний тайланд хариуцлага хүлээх бөгөөд мэргэжлийн хариуцлагаа ХААН даатгал ХХК-иар даатгуулсан. Мөн түүнчлэн манай мэргэшсэн үнэлгээчид нь өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа ХААН даатгал ХХК-иар даатгуулсан болно. Даатгалын гэрчилгээний хуулбарыг Хавсралт И-ээс харна уу.
- БДО Монгол болон үнэлгээнд оролцсон үнэлгээчид, мөн үнэлгээний туслах ажилтнууд нь Мандал-д энэхүү үнэлгээний үйлчилгээнээс өөр үйлчилгээ үзүүлдэггүй, хувьцаа эзэмшдэггүй, үнэлгээний үр дүнд нөлөөлөх аливаа ашиг сонирхлын зөрчилгүй болно.

### 2.3 Үнэлгээний зорилго

- БДО Монгол болон Мандал Даатгал компанийн хооронд 2018 оны 2-р сарын 21-нд байгуулсан үнэлгээний үйлчилгээ үзүүлэх гэрээт ажлын захидалд заасан дагуу бид уг компанийн ердийн даатгалын үйл ажиллагаар хамарсан бизнесийн 100 хувийн хувь оролцоог үнэлж, бизнесийн үнэлгээний тайлан бэлтгэхээр сонгогдсон.
- Үйлчлүүлэгч нь энэ үнэлгээний тайланг зөвхөн хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргах дотоод зорилгоор ашиглана. Бидний шинжилгээний үр дүн нь хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргах үндэслэл болохгүй.
- Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн бүртгэлийн дүрмийн дагуу бид өөрсдийн бэлтгэсэн үнэлгээний тайланд тусгагдсан үнэ цэнийн талаарх дүгнэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) болон бусад эрх бүхий зохицуулагч байгууллагын шаардлагаар хамгаалах эрхтэй.

### 2.4 Үнэ цэнийн суурь

- Бид энэхүү тайланг бэлтгэхдээ Үнэлгээний олон улсын консул (УОУК)-ын бэлтгэн толилуулдаг Үнэлгээний олон улсын стандарт (ҮОУС)-ыг даган мөрдсөн. Энэхүү үнэлгээний хүрээнд зах зээлийн үнэ цэнийн суурийг ашигласан бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно.
- Зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь ҮОУС 104-ийн 30.1-р мөрөнд тодорхойлсны дагуу нь *"зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн"*-г хэлнэ. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтыг дараах үзэл баримтлалын дагуу ашиглана:



МАНДАЛ ДААТГАЛ ХХК

МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

ХОРООНЫ ХУРЛААР БҮРТГЭВ 2018 .08. 29 өдөр

- **"Тооцоолсон дүн"** - харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийн төлөө төлөх мөнгөөр илэрхийлэгдэх үнэ юм. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу зах зээлийн үнэ цэнэ нь тухайн зах зээлээс ул үндэслэлтэйгээр олж авч болох, үнэлгээний өдрөөрх хамгийн их магадлалтай үнэ байдаг. Энэ нь борлуулагчийн ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнэ ба худалдан авагчийн ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн давуу талтай үнэ байна. Харин ерөнхий санхүүжилт, борлуулалт ба буцаан түрээслэх тохиролцоо, борлуулалттай холбоотойгоор хэн нэгнээс олгосон тусгай төлбөр, хөнгөлөлт гэх мэт тусгай нөхцөл буюу заалтаар, эсвэл зөвхөн тодорхой нэг өмчлөгч буюу худалдан авагчид хамаарах үнэ цэнийн ямар нэг элементээр нэмэгдүүлэх буюу бууруулах байдлаар тооцоолсон үнийг энэхүү тооцоололд тусгайлан хамруулдаггүй.
- **"Хөрөнгө, болон өр төлбөрийг арилжвал зохино"** - гэдэг нь хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнэ бол урьдчилан тодорхойлсон дүн эсвэл бодит борлуулалтын үнэ биш, харин тооцоолсон дүн байх нөхцөлийг илэрхийлнэ. Энэ нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын бүх элементүүдийг үнэлгээний өдрөөр хангах уг ажил гүйлгээний үнэ байдаг.
- **"Үнэлгээний өдрөөр"** - гэдэг нь тухайн үнэ цэнэ уг өдрийн байдлаар гэх мэт тусгай цаг хугацаатай байхыг шаарддаг. Зах зээл ба зах зээлийн нөхцөл байдал нь өөрчлөгдөж болох учраас уг тооцоолсон үнэ цэнэ нь өөр нэг хугацаанд буруу эсвэл тохиромжгүй байж болох юм. Үнэлгээний дүн нь өөр бусад дурын өдрийн биш, харин үнэлгээний тэр өдрийн байдлаарх зах зээлийн төлөв байдал ба нөхцөлүүдийг тусган илэрхийлдэг.
- **"Бэлэн байгаа худалдан авагч"** - гэдэг нь худалдан авах сэдэл санаачлагатай боловч тийм албан үүрэг хүлээгээгүй талыг илэрхийлнэ. Уг худалдан авагч нь ямар ч хамаагүй үнээр худалдан авахаар хэт хүссэн эсвэл худалдан авна гэж урьдчилан тодорхойлогдсон этгээдийн аль нь ч биш юм. Мөн худалдан авагч нь оршин байгаа гэдгийг батлан харуулж эсвэл урьдчилан баримжаалж чадахгүй тийм төсөөллийг буюу таамаглалын зах зээлтэй холбоотойгоор биш, харин одоогийн зах зээлийн бодит байдал болон одоогийн зах зээлийн хүлээлтийн дагуу худалдан авах этгээд байдаг. Уг төсөөлсөн худалдан авагч нь зах зээлээр шаардахаас илүү өндөр үнийг төлөхгүй. Одоогийн эзэн нь "тухайн зах зээл"-ийг бүрдүүлэгчдийн нэг болдог.
- **"Бэлэн байгаа борлуулагч"** - нь ямар ч хамаагүй үнээр борлуулахаар хэт хүссэн буюу албадлагын дагуу борлуулагч эсвэл одоогийн зах зээлийг ул үндэслэлтэйгээр харгалзан үзэхгүйгээр үнэ тогтоож буй этгээдийн аль нь ч биш юм. Бэлэн байгаа борлуулагч нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа нээлттэй зах зээлээс олж авах хамгийн сайн үнэ бүхий зах зээлийн нөхцөлөөр хөрөнгийг борлуулах сэдэл санаачлагатай байдаг, гэхдээ уг сайн үнэ нь хэд ч байж болох юм. Бэлэн байгаа борлуулагч бол таамагласан эзэн бөгөөд жинхэнэ бодит эзний үнэн бодит нөхцөл байдал нь энэхүү хэлэлцүүлгийн хэсэг болохгүй.
- **"Хамааралгүй талуудын ажил гүйлгээ"** нь жишээлбэл, толгой ба охин компаниуд эсвэл газрын эзэн ба хөлслөгч гэх мэт үнийг зах зээлийн шинж, агуулгагүй болгох буюу нэмэгдүүлж болох тийм тухайлсан буюу тусгай харилцан хамааралтай биш байх талуудын хоорондох ажил гүйлгээ юм. Зах зээлийн үнэ цэнээр тооцогдох ажил гүйлгээ нь тус бүрдээ хараат бусаар үйл ажиллагаа явуулж буй холбоогүй талуудын хооронд хийгдэнэ гэж урьдчилан таамагладаг.
- **"Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа"** - гэдэг нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнээр борлуулахад нөлөө үзүүлэхийн тулд тухайн хөрөнгийг хамгийн тохиромжтой арга замаар зах зээлд гарган танилцуулахыг хэлнэ. Борлуулагчийн хандан нэвтрэх зах зээлээс хамгийн сайн үнийг олж авахад борлуулалтын арга нь хамгийн тохиромжтой гэж үздэг. Зах зээлд гарган таниулах хугацаа нь тодорхой тогтсон байдаггүй бөгөөд хөрөнгийн төрөл, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран өөр өөр байдаг. Цорын ганц шалгуур нь зах зээлд оролцогчдын зохих тоон хэсгийн анхааралд уг хөрөнгийг хандуулах боломж олгох хангалттай хугацаатай байх ёстой. Зах зээлд гарган таниулах хугацаа нь үнэлгээний өдрөөс өмнө байна.
- **"Талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй"** - гэдэг нь тухайн хөрөнгийн төрөл ба шинж чанар, түүний бодит болон боломжит ашиглалт, зах зээлийн төлөв байдлын талаар уг бэлэн байгаа худалдан авагч болон бэлэн байгаа борлуулагчийн аль алинд үнэлгээний өдрийн байдлаар ул үндэслэлтэйгээр мэдээлсэн байна гэсэн урьдчилсан нөхцөлийг илэрхийлнэ. Талууд тус бүр нь уг ажил гүйлгээ дэх өөрийн хэтийн байр

СЗХ 2019 .08 .29 өдөр БҮРТГЭВ № 01

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

GOLOMT CAPITAL LLC

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

суурины хувьд хамгийн тааламжтай байх үнийг олохын тулд тухайн мэдлэгийг бодол төлөвлөгөөтэйгөөр ашиглана гэж урьдчилан төсөөлдөг. Хожмын нэгэн өдрийн урьдчилан харах боломжгүй үр ашгийг биш, харин тухайн үнэлгээний өдрөөрх зах зээлийн байдлыг лавлагаа болгосноор "бодол төлөвлөгөө"-г үнэлдэг. Жишээлбэл, борлуулагч нь зах зээлийн үнэ буурсан үед хөрөнгийг зах зээлийн өмнөх үнээс бага үнээр борлуулах нь заавал бодол төлөвлөгүй байна гэсэн үг биш юм. Ийм тохиолдолд энэ нь үнэ өөрчлөгдсөн зах зээл дэх өөр арилжааны хувьд зөв байх бөгөөд бодол төлөвлөгөөтэй худалдан авагч буюу борлуулагч нь тухайн үед бэлэн боломжтой байгаа зах зээлийн хамгийн сайн мэдээллийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

- **"Албан шахалт шаардлагагүй"** - гэдэг нь тал тус бүр уг ажил гүйлгээг хийх сэдэл санаачлагатай боловч түүнийг гүйцэтгүүлэхээр аль ч талыг хүчлээгүй буюу хэт албадан шахаагүй байхыг илэрхийлнэ.

Үнэлгээний тайланд ашигласан орц мэдээлэл болон эцсийн үр дүнг үнэлгээний тайлангийн туршид монгол төгрөгөөр, мянганы оронгийн нарийвчлалтайгаар ашиглана. Иймд үнэлгээний валют нь монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг болно.

## 2.5 Үндсэн ба тусгай таамаглалууд

Бид дараах таамаглалуудад үндэслэн 100 хувийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэнийг тооцсон. Үүнд:

- Компани нь урьдчилан харах боломжтой ирээдүйд өөрийн ердийн даатгалын бизнесээ тасралтгүй үргэлжлүүлэх үйл ажиллагааны төсөөлөл баримтална.
- Компанийн тасралтгүй ажиллагаа эсвэл бизнесийн үндсэн чиглэл урьдчилан харах боломжтой ирээдүйд мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй гэж таамагласан. Жишээбэл, амьдралын даатгалын салбарт үйл ажиллагаагаа тэлэх гэх мэт.
- Мөнгөн урсгалын төсөөлөл нь Мандал-аас бидэнд ирүүлсэн дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд суурилсан бөгөөд уг төлөвлөгөөнд багтсан мэдээллийн агуулга, тооцоолол нь үнэн зөв, бодитой гэж таамагласан.
- Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд багтсан аливаа тооцоолол нь бизнесийн үйл ажиллагааны хамгийн сайн ашиглалтад үндэслэсэн. Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд байгууллагын нөөц ашиглалтыг боломжит хамгийн дээд түвшин[1]-д тодорхойлсон бөгөөд эдгээр тооцоолол нь удирдлагын хамгийн сайн мэдлэг, туршлага дээр үндэслэн бэлтгэгдсэн гэж таамагласан.
- Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд тодорхойлсноор Мандал-ын бүтээгдэхүүний багцад таамагласан хугацааны туршид мэдэгдэхүйц өөрчлөлт гарна. Ялангуяа эрүүл мэнд, тээврийн хэрэгслийн даатгалын зах зээлд үйл ажиллагааны хүрээг тэлснээр хураамжийн орлого мэдэгдэхүйц өснө гэж таамагласан. Нийт хураамжийн орлого 2022 он гэхэд 45.5 тэрбум төгрөг болж 2018 оны таамагласан орлогоос 86%-иар өснө. Энэ өсөлтийн 36%-ийг тээврийн хэрэгслийн даатгал, 66%-ийг эрүүл мэндийн даатгалын өсөлт бүрдүүлнэ. Бусад даатгалын бүтээгдэхүүний хувьд жил бүр тогтмол 10%-иар өсөхөөр хүлээгдэж байна.
- Үйлчилгээний өртөгт материаллаг үр нөлөөтэй хөдөлмөрийн орцын өсөлт, боловсон хүчний сургалт, ажил олгогчоос ажилтанд олгох нийгмийн халамжийн төлөвлөгөө байхгүй. Мөн түүнчлэн боловсон хүчний мэргэжлийн ур чадварын дутагдал, мэргэжлийн ёс зүйн доголдолоос үүсэх аливаа зарга, маргаан үүсэхгүй гэж таамагласан.
- Засгийн газрын бодлого, зохицуулалтын гэнэтийн өөрчлөлт Мандал-ын бизнесийн үйл ажиллагаа (загвар) болон ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд мэдэгдэхүйц нөлөөлөхгүй.
- Мандал-ын бизнесийн үйл ажиллагаа нь Монгол улсын татварын хуулиар зохицуулагдах бөгөөд урьдчилан харах боломжтой ирээдүйд татварын орчин мэдэгдэхүйц өөрчлөгдөхгүй гэж таамагласан.

[1] Энд үнэ цэнийн урьдчилсан нөхцөл "Хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт" гэсэн ойлголтыг ижил утгаар ойлгоно. Хамгийн өндөр ба хамгийн сайн ашиглалт гэдэг нь оролцогчийн хэтийн төлөвөөс авч үзсэн, тухайн хөрөнгийн хувьд хамгийн өндөр үнэ цэнийг бий болгох ашиглалт юм.



МАНДАЛ ДААТГАЛ ХХК

238
Огноо: 2018/04/16

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

- Мандал-ын санхүүгийн тайланд тусгагдсан бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас бусад тодруулаагүй хөрөнгө/өр төлбөр эсвэл хэвийн бус үүрэг хариуцлага, үнэлгээний өдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй шүүхийн зарга маргаан зэрэг үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөөтэй аливаа болзошгүй зүйл байхгүй.
- Ердийн даатгалын бизнест мэдэгдэхүйц нөлөөлөх байгалийн гамшиг, цаг уурын таагүй нөхцөл урьдчилан харах боломжтой ирээдүйд үүсэхгүй.

### 2.6 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал

- Үнэлгээний тайлан нь Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд Монгол хэлнээс өөр хэлээр энэ тайланг орчуулах эрх зөвхөн БДО Монгол-д байна. Бид энэхүү үнэлгээний тайланг хэвлэмэл хэлбэрээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ. Гарын үсэг зурж, тамга дарсан хэвлэмэл болон цахим тайлангууд аль аль нь адил хүчин төгөлдөр болно.
- Үнэлгээний тайлангийн 2.3-т дурдсанчлан, үнэлгээний тайланг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь хөрөнгийн зах зээл дээр анхдагч хувьцаа гаргахаас өөр зорилгоор хувилж, эсвэл иш татаж ашиглахыг хориглоно. Энэхүү тайланг зөвхөн Мандал-ын дотоод албан хэрэгцээнд ашиглана.

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЗХ
2018 08 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 3. Салбарын тойм

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ



МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

### 3.1 Макро эдийн засаг

- ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 16.9 их наяд төгрөг болж, өмнөх оноос 826.0 (5.1%) тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд үйлчилгээний салбарын нэмэгдэл өртөг 573.9 (8.5%) тэрбум төгрөг, бөөний болон жижиглэн худалдааны салбарын нэмэгдэл өртөг 191.8 (9.7%) тэрбум төгрөг, бүтээгдэхүүний цэвэр татвар 259.1 (18.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

*Бодит ДНБ, улсын инфляцийн өөрчлөлт, %*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

- Өмнөх оны эцсийн байдлаар 1.1% байсан инфляцийн түвшин 2017 оны жилийн эцэст 6.4% болж даруй 5.3%-иар өссөн. 2018 онд төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үзэл баримтлалд инфляцийн зорилтот түвшинг 8%-д барихаар баталсан.

- Мөнгөний нийлүүлэлт (M2) 2017 оны эцэст 15.8 их наяд төгрөг болж, өмнөх сараас 976.6 (6.6%) тэрбум төгрөг, өмнөх оноос 3.6 (29.9%) их наяд төгрөгөөр өссөн байна. Үүнд төгрөгийн хадгаламж 657.1 тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлөв.

- Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл 2017 оны эцэст 823.3 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 70.4 (7.9%) тэрбум төгрөг, өмнөх оноос 81.0 (9.0%) тэрбум төгрөгөөр буурлаа. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 6.0 хувийг эзэлж, өмнөх сараас 0.6 пункт, өмнөх оноос 1.3 пунктээр буурсан байна.

*Мөнгөний зарим үндсэн үзүүлэлт, улирлын эцсийн байдлаар*

| Тэрбум төгрөгөөр | 2015Q4 | 2016Q4 | 2017Q4 |
|---|---|---|---|
| Мөнгөний нийлүүлэлт, M2 | 10,049 | 12,159 | 15,798 |
| *Жилийн өөрчлөлт, %* | -5.5% | 21.0% | 29.9% |
| Нийт хадгаламж | 7,382 | 8,580 | 11,093 |
| *Жилийн өөрчлөлт, %* | 0.0% | 16.2% | 29.3% |
| Төгрөгийн хадгаламж | 5,434 | 5,790 | 8,562 |
| *Жилийн өөрчлөлт, %* | 0.4% | 6.5% | 47.9% |
| Валютын хадгаламж | 1,948 | 2,790 | 2,532 |
| *Жилийн өөрчлөлт, %* | -1.1% | 43.2% | -9.2% |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

- Төгрөгийн америк доллартой харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2017 оны 12 дугаар сард 2433.49 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 49.08 (2.0%) төгрөг, өмнөх сараас 0.6 хувиар чангарсан байна. Төгрөгийн юаньтай харьцах Монголбанкны нэрлэсэн дундаж ханш 2017 оны 12 дугаар сард 369.0 төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 10.26 (2.9%) төгрөгөөр суларч, өмнөх сараас 0.2 хувиар чангарсан байна.

*Төгрөгийн гадаад валюттай харьцах Монголбанкны нэрлэсэн, дундаж ханш*

| Төгрөгөөр | 2015Q4 | 2016Q4 | 2017Q4 |
|---|---|---|---|
| Америк доллар | 1,995.84 | 2,482.57 | 2,433.49 |
| *Жилийн өөрчлөлт, %* | 6.0% | 24.4% | -2.0% |
| Евро | 2,171.72 | 2,619.89 | 2,879.43 |
| *Жилийн өөрчлөлт, %* | -6.5% | 20.6% | 9.9% |
| Юань | 309.34 | 358.73 | 369.00 |
| *Жилийн өөрчлөлт, %* | 1.6% | 16.0% | 2.9% |
| Рубль | 28.57 | 40.00 | 41.52 |
| *Жилийн өөрчлөлт, %* | -15.6% | 40.0% | 3.8% |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*



СЗХ БҮРТГЭВ 2018.08.29 № 01
МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01
МОНГОЛ УЛС BDO GOLOMT CAPITAL LLC ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

- Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 7.2 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 8.9 их наяд төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1.7 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оноос 1.9 их наяд төгрөгөөр буурахад татварын орлого 1.4 (27.3%) их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн.

- Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 2.3 (27.3%) тэрбум америк доллар, үүнээс экспорт 1.3 (26.1%) тэрбум америк доллароор, импорт 977.3 (29.1%) сая америк доллароор тус тус өссөн байна. Гадаад худалдааны тэнцэл 2016 онд 1.6 тэрбум америк долларын ашигтай гарч байсан бол 2017 онд өмнөх оноос 307 (19.7%) сая америк доллароор нэмэгдэж, 1.9 тэрбум америк долларт хүрсэн. Экспорт 2017 онд өмнөх оноос 1.3 тэрбум америк доллароор өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.4 тэрбум америк доллар, үүнээс нүүрсний экспорт 1.3 тэрбум америк доллароор өссөн нь голлон нөлөөлсөн байна.

*Гадаад худалдааны төлөв байдал*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

- Эрдэс бүтээгдэхүүн, нэхмэл бүтээгдэхүүн, үнэт, хагас үнэт чулуу, металл гоёлын зүйлсийн экспорт нийт экспортын 94.6 хувийг эзэлж байгаа бол импортын 67.1 хувийг эрдэс бүтээгдэхүүн, машин, механик тоноглол, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги болон хүнсний бэлэн бүтээгдэхүүний импорт эзэлж байна.

## 3.2 Хөрш орнуудын даатгалын салбар

- Сүүлийн жилүүдэд Хятадын даатгалын салбар чийрэг өсөлттэй байлаа. Жишээлбэл, 2008 оноос хойш даатгалын салбар хамгийн өндөр өсөлттэй салбаруудын эгнээнд багтаж 2016 онд нийт хураамжийн орлого 27.5%-иар өсч, 3.1 их наяд юань (490 тэрбум ам доллар) хүрсэн. 2016 оны эцсийн байдлаар даатгалын салбарын нийт хөрөнгө 15.12 их наяд юань болж оны эхнээс 22.3%-иар өссөн. Хураамжийн орлогын өсөлт 2017 онд Хятадын Даатгалын Зохицуулах Хороо (ХДЗХ)-ны шинэчлэлээс үүдэн суларсан ч статистик үзүүлэлтүүд болон салбарын талаарх төсөөллүүд өөдрөг хэвээр байна. Жишээлбэл, 2017 онд даатгалын хураамжийн орлого 3.66 их наяд юань (571.33 тэрбум ам доллар) болж оны эхнээс 18.6%-иар өссөн байна.

- Хятадын даатгалын салбарт 2017 онд гарсан гол дэвшлүүдээс дурдвал: (1) 11-р сард Хятадын Сангийн яам амьдралын даатгалын салбарт гадаадын хөрөнгө оруулалтыг нээх болсноо мэдэгдсэн (2) ХДЗХ хил дамнасан давхар даатгалын арилжааны барьцаанд тавигдах шаардлагыг нэмэгдүүлж, Хятад-Хонг Конг-ийн төлбөрийн чадварын хамтарсан гэрээ байгуулсан (3) ХДЗХ салбарыг урт хугацааны тогтвортой өсөлтөд чиглүүлэх, илүүдэл эрсдэлийг хянах зорилготой шинэ зохицуулалт хэрэгжүүлсэн (4) Улсын зөвлөлөөс санхүүгийн бүх зохицуулалтыг нэгтгэн зохион байгуулах зорилгоор дээд шатны байгууллага байгуулсан (5) Хятадын Цахим аюулгүй байдлын шинэ хууль батлагдах дөхөж байна.

- ОХУ-ын даатгалын зах зээл тайлант онд бодит өсөлттэй буюу инфляцийн түвшнээс давсан өсөлт үзүүллээ. Үүнд амьдралын даатгалын сегментийн үйл ажиллагаа сайжирсан нь голлон нөлөөлөв. 2016 онд амьдралын даатгалаас олсон хураамжийн орлого 66%-иар өсч, цаашлаад нийт салбар 15%-иар өсөхөд хүргэсэн.

- ОХУ-ын даатгалын салбарт 2017 оны байдлаар нийт 226 даатгалын компани үйл ажиллагаа явуулж, урьдчилсан гүйцэтгэлээр 1.3 их наяд рублийн хураамжийн орлого төвлөрүүлсэн. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 7%-иар өссөн үзүүлэлт юм. Тайлант оны байдлаар амьдралын даатгалын салбар нийт хураамжийн орлогод 22%-ийг эзэлсэн. Салбарын шинжээчдийн таамаглалаар амьдралын даатгал нь салбарын өсөлтийг дунд хугацаанд тайлбарлах магадлалтай байна.

- ОХУ-ын тэргүүлэх 5 компанид нийт зах зээлийн 53% ногдож байгаа бөгөөд цаашид энэ харьцаа өсөх хандлагатай байна.

СЗХ 2018 08. 29 өдөр БҮРТГЭВ №

МАНДАЛ ДААТГАЛ ХХК

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ... он .... сар .... өдөр

МОНГОЛ УЛС BDO GOLOMT CAPITAL LLC ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

### 3.3 Монгол улсын даатгалын салбарын онцлог

- Даатгалын салбар нь төвлөрсөн бус зах зээлтэй. Тэргүүлэх дөрвөн компани нийт активаар 49%, нийт хураамжийн орлогоор 55%-ийг бүрдүүлдэг ч зах зээлд дангаараа манлайлсан компани байхгүй. Дийлэнх оролцогчид өрсөлдөх чадвараар ойролцоо. 2017 оны 3-р улирлын байдлаар Монгол даатгал компани зах зээлийн 18.1%-ийг бүрдүүлж өрсөлдөгчдөө манлайлсан бол нийт активын өсөлтөөр Бодь даатгал компани тэргүүлсэн (нийт активаа 76.3%-иар өсгөсөн).

- Салбарын амьдралын мөчлөгийн хувьд даатгал нь огцом өсөлттэй, ашгийн түвшин нэмэгдэх хандлагатай, өрсөлдөөн бага (урт хугацаанд), активын хэмжээг нэмэгдүүлэх тусам эрсдэл даах чадвар сайжир байгаа зэргээс үзэхэд өсөлтийн мөчлөг дээрээ байна.

*Салбарын амьдралын мөчлөгийн шинжилгээ*

| Бойжилтын мөчлөг | Өсөлтийн мөчлөг | Тогтворгүй мөчлөг | Тогтмол мөчлөг | Уналтын мөчлөг |
|---|---|---|---|---|
| удаан өсөлт | огцом өсөлт | удаан өсөлт | тогтвортой өсөлт | сөрөг өсөлт |
| өндөр үнэ | ашиг өсөх | ашиг буурах | нэгдэх | илүүдэл нийлүүлэлт |
| өндөр эрсдэл | үнийн бууралт | үнэ хэлбэлзэх | бага эрсдэл | өндөр эрсдэл |
| их хөрөнгө оруулалт | бага өрсөлдөөн | ширүүн өрсөлдөөн | шинэ тоглогч бага | өндөр өрсөлдөөн |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Салбарын жигнэсэн дундаж туршлага 13.3 жил буюу харьцангуй бага.

- Бизнесийн мөчлөгөөс эрэг хамааралтай. Эдийн засгийн уналтын шок байгууллагын борлуулалтын сувгаар дамжин нөлөөлдөг. Зарим даатгалын бүтээгдэхүүн албан журмаар борлуулагддаг тул даатгалын компаниуд бизнесийн мөчлөгийн нөлөөг тодорхой хүрээнд хязгаарлаж чаддаг.

- Даатгалын компанид нийлүүлэгч болон худалдан авагчаас ирэх аливаа аюул занал, дарамт шахалт бага. Мөн түүнчлэн, энэ салбарт шинээр нэвтэрч ороход дүрмийн сан их хэмжээний хөрөнгө оруулалт хийхийг шаарддаг.

- Даатгалын салбарын гадаад орчныг шинжилснээр бид дараах ажиглалтыг хийсэн. Үүнд:

  - Даатгалын салбар нь макро эдийн засгийн өөрчлөлтөд мэдрэг хариу үйлдэл үзүүлдэг. 2018 онд эдийн засгийн орчинд аливаа материаллаг өөрчлөлт гарахгүй гэж үзвэл даатгалын салбарын хураамжийн орлого 5-10%-иар өсөх боломжтой. Мөн түүнчлэн, салбарын нийт активын өсөлт ирэх онд 23-24%-иар өсөх магадлалтай байна.

  - Дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх тухай Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 12-р сарын 12-ны 355 дугаар тогтоолыг ихэнх даатгалын компаниуд хэрэгжүүлээгүй. СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр 2018 оны 1-р сарын 1-нээс хүчин төгөлдөр болсон.

  - Дижитал технологийн огцом өөрчлөлтөд дасан зохицох бизнесийн загвар боловсруулалт "Шинэ хандлага үүсэх" шатанд хэрэгжиж байна.

*Даатгалын компаниудын төвлөрүүлсэн нийт актив*




*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

СЗХ 2018.08.29 өдөр БҮРТГЭВ №01

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ 1117...

МОНГОЛ УЛС BDO GOLOMT CAPITAL LLC

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01 ...он ...сар ...өдөр

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

## 4. Бизнесийн үндсэн мэдээлэл

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

## 4.1 Бизнесийн үндсэн мэдээлэл

- Мандал нь 2011 оны 4-р сарын 26-нд Мандал Женерал ХХК нэртэйгээр Монгол улсад үүсгэн байгуулагдсан. Мөн өдөр Монгол улсын Бүртгэлийн Ерөнхий Газар-т бүртгүүлж, Улсын бүртгэлийн 5473489 регистрийн дугаар бүхий 000136728 тоот гэрчилгээ авсан.
- Санхүүгийн Зохицуулах Хорооны 2011 оны 6-р сарын 2-ны өдрийн 2/21 тоот тогтоолоор Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авсны дараа албан ёсны нэрээ Мандал Женерал Даатгал ХХК өөрчилж, ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх болсон. Компани 2016 онд Мандал Женерал Даатгал нэрээ Мандал Даатгал болгон өөрчилсөн.
- Голомт Файнэншил Групп ХХК болон Юу Эм Си Капитал ХХК нь Компанийн хувьцаа эзэмшигчид бөгөөд харгалзан 51% болон 49%-ийг тус тус эзэмшдэг.
- Голомт Файнэншил Групп ХХК санхүүгийн үйлчилгээний байгууллага бөгөөд 2014 онд Монгол улсын иргэн Д.Баясгалангийн 100% хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдсан.
- Компанийн үндсэн үйл ажиллагаа нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр ердийн даатгалын үйлчилгээ үзүүлэх болно. Мандал нь СЗХ-ны 2011 оны 6-р сарын 2-ны 2/21 тоот тогтоолын дагуу гэнэтийн осол, хөрөнгө, тээврийн хэрэгсэл, онгоц, санхүү болон хариуцлагын даатгалын үйлчилгээ үзүүлдэг.

*Хувьцаа эзэмшигчдийн өмчийн бүтэц*



*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

### 4.2 Орлого бий болгогч нэгж

- Мандал-ын бизнесийн үндсэн сегмент нь ердийн даатгалын үйл ажиллагаа юм. Компанийн бүтээгдэхүүний багцад тээврийн хэрэгслийн даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, эд хөрөнгийн даатгал, гэнэтийн ослын даатгал зонхилох байр эзэлдэг.
- ТЖ16 оны байдлаар нийт орлогод тооцсон хураамжийн 30%-ийг жолоочийн хариуцлагын даатгал, 29%-ийн тээврийн хэрэгслийн даатгал бүрдүүлж байсан. Цаашид эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын бүтээгдэхүүний багцад эзлэх хувь өсөх хандлагатай байна.
- Өнгөрсөн 5 жилийн түүхэн санхүүгийн гүйцэтгэлээс харахад ТЖ13-ТЖ16 хооронд татвар төлөхийн өмнөх ашиг бууралттай байсан, энэ хугацаанаас ТЖ14 онд алдагдалтай ажилласан. ТЖ17 онд Мандал-ын санхүүгийн гүйцэтгэл түүхэн дээд түвшиндээ хүрсэн. Цаашид санхүүгийн гүйцэтгэл тогтворжих хандлагатай байна.

*Түүхэн санхүүгийн гүйцэтгэл*




Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ

*Орлогод тооцсон хураамжийн задаргаа*







Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC
246
Огноо: 2018/04/16

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЗХ
2018 он 08 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 5. Санхүүгийн мэдээлэл



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC

247
Огноо: 2018/04/16

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

## 5.1 Түүхэн санхүүгийн байдлын тайлан

*Аудитлагдсан түүхэн санхүүгийн байдлын тайлан*

| мян.төгрөг | ТЖ15 | ТЖ16 | ТЖ17 |
|---|---|---|---|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 1,965,708 | 3,719,555 | 1,805,206 |
| Даатгалын авлага | 2,056,290 | 3,350,298 | 4,402,450 |
| Хөрөнгө оруулалт ба бусад | 4,700,781 | 3,892,660 | 9,812,997 |
| Даатгалын хөрөнгө | 468,636 | 5,711,215 | 4,868,576 |
| Цэвэр үндсэн хөрөнгө | 387,358 | 293,718 | 288,956 |
| Цэвэр биет бус хөрөнгө | 108,527 | 105,343 | 57,325 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 110,000 | 236,640 | 236,640 |
| Нийт хөрөнгө | 9,797,300 | 17,309,429 | 21,472,150 |
| Даатгалын өглөг | 318,186 | 2,037,198 | 2,055,456 |
| Бусад санхүүгийн бус өр төлбөр | 698,467 | 677,000 | 1,138,866 |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөц | 2,218,070 | 7,473,062 | 9,366,278 |
| Нөхөн төлбөрийн нөөц сан | 1,749,459 | 2,223,803 | 2,910,659 |
| Нийт өр төлбөр | 4,984,182 | 12,411,063 | 15,471,259 |
| Эзэмшигчдийн өмч | 6,243,016 | 6,243,016 | 6,243,016 |
| Халаасны хувьцаа | (1,243,016) | (1,243,016) | (1,243,016) |
| Хуримтлагдсан ашиг | (186,882) | (101,634) | 1,000,892 |
| Өөрийн хөрөнгийн дүн | 4,813,118 | 4,898,366 | 6,000,892 |
| Өр төлбөр ба эзэмшигчийн өмч | 9,797,300 | 17,309,429 | 21,472,150 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Мандал нь аливаа нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэдэггүй бөгөөд удирдлагын баг санхүүгийн тайлан бэлтгэн толилуулах үүрэг хүлээнэ. Бид түүхэн санхүүгийн байдлын тайланд шинжилгээ хийж, дараах зүйлсийг илрүүлсэн. Үүнд:
- ТЖ17 оны санхүүгийн байдлын тайланд тусгагдсан 1.8 тэрбум төгрөгийн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө нь 0.8 тэрбум төгрөгийн харилцах дансанд байршуулсан, 0.9 тэрбум төгрөгийн банкинд байршуулсан мөнгөн хөрөнгө болон 0.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгөд хуримтлуулж тооцсон хүүний авлагаас бүрдэнэ.
- ТЖ17 оны санхүүгийн байдлын тайланд тусгагдсан 4.4 тэрбум төгрөгийн даатгалын авлагад 2.5 тэрбум төгрөгийн даатгалын хураамжийн авлага, 1.8 тэрбум төгрөгийн давхар даатгагчаас авах авлага, болон бусад авлага багтана.
- ТЖ17 оны санхүүгийн байдлын тайланд толилуулагдсан 9.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт нь 8.4 тэрбум төгрөгийн хадгаламжийн сертификат, 0.8 тэрбум төгрөгийн засгийн газрын үнэт цаасаас бүрдэнэ.
- ТЖ17 оны санхүүгийн байдлын тайланд толилуулагдсан 4.9 тэрбум төгрөгийн даатгалын хөрөнгөд давхар даатгалын хойшлогдсон хураамж болох 3.6 тэрбум төгрөг багтсан.
- Даатгалын өглөг нь үндсэндээ давхар даатгагчид өгөх өглөгөөс бүрдэнэ.
- ТЖ17 оны санхүүгийн байдлын тайланд тусгагдсан бусад санхүүгийн бус өр төлбөрийн дунд 0.2 тэрбум төгрөгийн цалингийн өглөг, 0.7 тэрбум төгрөгийн урьдчилж олсон орлого багтана. Урьдчилсан олсон орлогыг дотор нь задлавал 128 сая төгрөгийн урьдчилсан орлого, 541 сая төгрөгийн давхар даатгалын урьдчилсан орлого, 45 сая төгрөгийн бусад урьдчилгаа багтана.
- ТЖ17 оны эцсийн байдлаар 67 мянган гэрээнээс цуглуулсан 9.4 тэрбум төгрөгийн орлогод тооцоогүй хураамж байна. Үүнээс давхар даатгалд харгалзах хойшлуулсан орлого нь 3.6 тэрбум төгрөг байна.
- ТЖ17 оны санхүүгийн байдлын тайланд толилуулагдсан 2.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн сан нь 0.3 тэрбум төгрөгийн УБМХНС, 0.7 тэрбум төгрөгийн МБТХНС, 0.6 тэрбум төгрөгийн УБХНС, 1.3 тэрбум төгрөгийн тусгай нөөц сангаас бүрдэнэ. Тайлант хугацаанд тусгай нөөц санд өөрчлөлт гараагүй.



МАНДАЛ ДААТГАЛ ХХК

BDO

GOLOMT CAPITAL LLC

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

## 5.2 Түүхэн орлогын дэлгэрэнгүй тайлан

*Аудитлагдсан түүхэн орлогын дэлгэрэнгүй тайлан*

| мян.төг | ТЖ15 | ТЖ16 | ТЖ17 |
|---|---|---|---|
| Даатгалын хураамжийн цэвэр орлого | 3,169,600 | 4,701,148 | 10,081,466 |
| Орлогод тооцоогүй хураамжийн нөөцийн өөрчлөлт | 399,580 | 5,254,992 | 1,893,216 |
| Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт | - | (4,770,843) | 1,145,087 |
| Орлогод тооцсон хураамж | 2,770,020 | 4,216,999 | 7,043,163 |
| Нөхөн төлбөрийн цэвэр зардал | 966,743 | 1,890,732 | 2,074,468 |
| Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт | (53,441) | 238,650 | 444,324 |
| Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт | - | (334,629) | (379,999) |
| Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт | 357,322 | 235,694 | 242,532 |
| Зардалд тооцсон нөхөн төлбөр | 1,270,624 | 2,030,447 | 2,381,325 |
| Даатгалын гэрээний зардал | (730,781) | (1,121,118) | (1,203,701) |
| Давхар даатгалын шимтгэлийн орлого | 1,732,407 | 1,270,895 | 925,392 |
| Хөрөнгө оруулалтын орлого ба олз, гарз | 974,882 | 993,979 | 1,226,959 |
| Даатгалын үйл ажиллагааны ашиг | 3,475,904 | 3,330,308 | 5,610,489 |
| Даатгалын үйл ажиллагааны бус ашиг (алдагдал) | (2,967,697) | (3,159,768) | (4,345,415) |
| Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал) | 508,207 | 170,540 | 1,265,073 |
| Орлогын татварын зардал | (91,273) | (85,291) | (162,548) |
| Татварын дараах ашиг (алдагдал) | 416,934 | 85,249 | 1,102,525 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Мандал нь аливаа нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэдэггүй бөгөөд удирдлагын баг санхүүгийн тайлан бэлтгэн толилуулах үүрэг хүлээнэ. Бид түүхэн орлогын дэлгэрэнгүй тайланд шинжилгээ хийж, дараах зүйлсийг илрүүлсэн. Үүнд:
- ТЖ17 онд Мандал нь 10.1 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж, түүхэн дээд түвшиндээ хүрсэн. Үүнээс 7 тэрбум төгрөгийн хураамжийг орлогод тооцсон. Тайлан үеийн орлогод тооцсон хураамжийн өсөлт 67% байсан.
- Мөн тайлант хугацаанд нөхөн төлбөрийн цэвэр зардал 5%-иар өсөж, 2 тэрбум төгрөг, зардалд тооцсон нөхөн төлбөр 20%-иар өсөж, 2.4 тэрбум төгрөг болж өссөн. Энэ нь орлогод тооцсон хураамжтай харьцуулахад мэдэгдэхүйц бага өөрчлөлт юм.
- ТЖ17 оны орлогын дэлгэрэнгүй тайланд толилуулагдсан 1.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын орлого нь хадгаламжийн сертификат болон засгийн газрын үнэт цааснаас олсон орлого болно.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



249
Огноо: 2018/04/16

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

## 6. Үнэлгээний шинжилгээ

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC
250
Огноо: 2018/04/16
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЗХ
2018.08.29
БҮРТГЭВ
№ 01

### 6.1 Үнэлгээний арга хандлага

- Бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнийг үнэлэхдээ бид дараах зүйлсийг нэгтгэн авч үзсэн. Үүнд:
  - Ердийн даатгалын үйл ажиллагааг хамарсан бизнесийн зах зээлийн үнэ цэнэ;
  - Мандал-ын эзэмшиж буй хөрөнгийн зах зээлийн үнэ цэнэ;

- Мандал-ын үндсэн бизнесийн шугам нь ердийн даатгалын үйл ажиллагаа бөгөөд энэ бизнесийн шугамаас өөр аливаа үйл ажиллагаа, түүнээс бий болсон орлого түүхэн тайлант хугацаанд үүсээгүй болно.

- Мандал-ын бизнесийг үнэлэхдээ бид дараах төсөөлөлд үндэслэн орлогын хандлагаас ХМУ-ний загвар, зах зээлийн хандлагаас жишиг компани ба жишиг арилжааны арга зүйг сонгон ашигласан бөгөөд хөрөнгийн хандлагаар тооцсон үнэлгээнд ач холбогдол өгөөгүй ч үнэ цэнийн баталгаажуулалт хийх зорилгоор авч үзсэн. Бизнес ба бизнесийн хувь оролцооны үнэлгээнд ашигладаг нийтлэг хандлагуудын хураангуй тайлбаруудыг Хавсралт Б-ээс дэлгэрүүлнэ үү.

  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 *Үнэлгээний хандлагууд ба аргууд*, догол мөр 40.2 буюу 40.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд орлогын хандлагыг тогтмол хэрэглэдэг. Мөн түүнчлэн, компани нь урьдчилан харах боломжтой ирээдүйд бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх төсөөлөл баримталдаг. Иймээс тасралтгүй хугацаанд уг бизнесийн бий болгож чадах эдийн засгийн өгөөж буюу мөнгөн урсгалд үндэслэн ХМУ-ний загвар боловсруулах боломжтой.

  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 *Үнэлгээний хандлагууд ба аргууд*, догол мөр 20.2 буюу 20.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд зах зээлийн хандлагыг ихэвчлэн ашигладаг. Зах зээлийн хандлага нь бизнесийн хувьд хамгийн бодитой, ул үндэслэлтэй үнэ цэнийн дүгнэлт гаргах боломж олгодог. Учир нь энэ аргын үед бизнесийн үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа, ижил буюу жишиг боломжтой бизнесийн орц мэдээлэлд үндэслэдэг. Даатгалын салбарын уламжлалт эрсдэлээс (зохицуулалтын нөлөө, системийн эрсдэл) шалтгаалан дан ганц ХМУ загвар ашиглан үнэ цэнэ тооцох нь хангалтгүй бөгөөд хүрэлцээгүй гэж бид үзсэн. Иймээс сүүлийн жилүүдэд даатгалын салбарт хийгдсэн бодит арилжаа, нэлттэй жишиг компаниудын зах зээлийн үнэ цэнийг шинжлэх замаар үнэлгээний өдрөөр байдлаар зах зээлийн арилжааны ханшийг тогтоосон. Хавсралт Г-д зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээнд ашиглагдсан жишиг компаниудын хураангуй танилцуулгыг тусгасан.

  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 *Үнэлгээний хандлагууд ба аргууд*-ын догол мөр 70.2 юм уу 70.3-ын шалгуурыг маш цөөн тохиолдолд хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд өртгийн хандлагыг ихэвчлэн хэрэглэдэггүй. Гэсэн ч хөрөнгөд суурилсан бизнесийн хувьд орлого болон зах зээлийн хандлагын үр дүнг баталгаажуулах зорилгоор хөрөнгийн аргаар үнэлгээ бэлтгэж болно.

- Орлогын ба зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээний үр дүн хоорондоо нийцгүй байж болно. Энэ нь үнэлгээний хандлагуудын дотоод шинж чанараас ихээхэн хамаарна. Тухайлбал, ХМУ-ний хандлага нь ирээдүйд бүтээн босгох үйлдвэрийн ажилд шаардагдах капитал, хугацааны мэдээллийг тусгахад хамгийн зохистой хандлага юм. Харин зах зээлийн хандлага нь салбарын өнөөгийн төлөв байдал, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэр, хөрөнгө оруулагчдын хандлагыг тусгахад илүү тохиромжтой байдаг.

*Зах зээлийн хандлага: Жишиг компанийн арга зүй (ЖКАЗ) ба жишиг арилжааны арга зүй (ЖААЗ)*

- Бизнес дэх өмчийн сонирхлыг үнэлэхдээ зах зээлийн хандлага нь үнэлж буй бизнесийн санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, түүхэн ба хүлээгдэж буй санхүүгийн гүйцэтгэлийг нэлттэй компаниуд болон (1) ижил буюу төстэй бизнесийн шугамд үйл ажиллагаа явуулдаг (2) эдийн засгийн, байгаль орчны, улсын төрлийн эрсдэлд адилхан өртдөг, (3) хөрөнгө оруулагчийн дараагийн сонголт байх боломжтой компаниудын зах зээлийн үнэлгээ болон эдгээр компанийн бодит арилжаатай харьцуулдаг.

- Дээрх хоёр арга зүйг дараах байдлаар тодорхойлдог:
  - ЖКАЗ: Энэ арга зүй нь нэлттэй чөлөөт зах зээлд идэвхтэй арилжаалагддаг, бизнесийн ижил шугаманд үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны зах зээлийн үнээс тооцсон зах зээлийн үржүүлэгчийг ашигладаг. Үнэлж буй бизнесийн санхүүгийн гүйцэтгэлийг илтгэх хэмжүүрт тохирох



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ
1117236007 5473489

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

BDO
GOLOMT CAPITAL LLC

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

үржүүлэгчийг сонгосноор арилжаалагдахуйц цөөнхийн сонирхлоор үнэ цэнэ тодорхой болдог.

- ЖААЗ: Энэ арга зүйг мөн "арилжааны арга" эсвэл "нэгдэл ба худалдан авалтын арга" гэж нэрлэдэг. Жишиг арилжаагаар зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо ижил бизнесийн шугамд үйл ажиллагаа явуулдаг компаниудын хяналтын эрхтэй буюу их дүнтэй арилжаанаас үүссэн үржүүлэгч ашигладаг. Ингэснээр арилжаалагдахуйц хяналтын эрхтэй сонирхлоор зах зээлийн үнэ цэнэ тодорхой болдог.

- Бид өөрсдийн дотоод мэдээллийн сан болон албан ёсны төлбөртэй мэдээллийн эх сурвалжид үндэслэн үнэлгээний шинжилгээнд ЖКАЗ болон ЖААЗ-н аль алиныг авч үзсэн.

- Жишиг компани болон жишиг арилжааны арга зүйд үндэслэн зах зээлийн үржүүлэгчдийг бид дараах байдлаар тооцсон:

  - ЖКАЗ: Бид үнэлгээний өдрийн байдлаар жишиг компаниудын зах зээлийн үнэ ба эдгээр компаниудын санхүүгийн гүйцэтгэлийг харгалзан цаашид ашиглах үнийн үржүүлэгчийг тодорхойлно. Ингэхдээ жишиг компани тус бүрийн хувьд үнэлгээний өдрийн байдлаар үржүүлэгчдийг албан ёсны мэдээллийн эх сурвалж болон өөрсдийн дотоод шинжилгээнд үндэслэн тооцсон.

  - ЖААЗ: Жишиг арилжааны хэлцлийн үнэ, тэдгээртэй холбогдох санхүүгийн ба эрсдэлийн хэмжүүр үзүүлэлтүүдийн харилцан хамаарлыг олж тогтооно. Арилжааны эрх зүйн байдал, компанийн өөрчлөн байгуулалт, шинэчлэгдсэн бүтцийг шинжилж арилжааны ханшаар илэрхийлэгдэх үнэлгээний үржүүлэгчийг тодорхойлно.

*Орлогын хандлага: ХМУ-ын загвар*

- Ирээдүйн мөнгөн урсгалын цэвэр өнөөгийн үнэ цэнийн шинжилгээ буюу ХМУ-ний загвар нь ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ нь бизнесийн үнэ цэнийг илтгэнэ гэсэн үзэл баримтлалд суурилдаг. Энэ арга зүйг ашиглахын тулд ирээдүйн мөнгөн урсгалын хүлээгдэж буй дүнг капиталын жигнэсэн дундаж өртгөөр хорогдуулдаг. Хэрэв мөнгөн урсгалын төсөөлөл нь шууд өмч рүү чиглэсэн бол өмчийн өртгийг хорогдуулах хүү болгон ашигладаг. КЖДӨ-ийн бүрэлдэхүүн болох өмчийн капиталын өртгийг Капитал хөрөнгө үнэлгээний загвар (КХҮЗ) ашиглан тооцно.

- Мөнгөн урсгалын прогноз эсвэл хорогдуулах хүүний аль нэгэнд тусгагдаагүй хүчин зүйлийг тодорхойлох нь орлогын хандлагаар тооцсон үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг. Жишээлбэл, үнэлж буй хувь оролцооны зах зээлд арилжаалагдах чадвар, эсвэл бизнесийн хяналтын юм уу хяналтын бус хувь оролцоо гэдгээс шалтгаалан холбогдох тохируулга хийгдэнэ. Хэрэв дээрх хүчин зүйлс аль хэдийн мөнгөн урсгалын төсөөлөлд багтсан бол хорогдуулах хүүнд тохируулга хийх шаардлагагүй байдаг. Үнэлгээний баг Мандал-ын бизнесийн загвар, үнэлгээний зорилгод нийцгүй гэж үзэж, мөнгөн урсгалын загварт хяналттай нэмэгдэл, хяналтгүйн болон хөрвөх чадваргүйн хорогдуулаг тооцоогүй.

- Хорогдуулсан мөнгөн урсгалын тооцоололтой холбогдон эдийн засгийн болон салбарын ирээдүйн төлөв байдлыг зайлшгүй харгалзан үздэг. Бид Мандал-ын ердийн даатгалын бизнест учирч болзошгүй аливаа эрсдэл, боломжийг шинжлэхийн тулд гадаад болон дотоод орчны эрсдэлийг онилсон салбарын судалгаа бэлтгэсэн. Дотоод орчны эрсдэлд салбарын өрсөлдөөн, нийлүүлэлтийн болон эрэлтийн шок, салбарт шинээр нэвтрэх болон гарах зардал, орлуулах бүтээгдэхүүний нөлөө зэргийг харгалзан үзсэн бол гадаад орчны эрсдэлд макро эдийн засгийн орчин, технологийн өөрчлөлт, хүн ам зүйн нөлөө, эрх зүйн орчин, нийгмийн нөлөөг багтаан судалсан.

- Ирээдүйн хүлээгдэж буй мөнгөн урсгал нь тодорхой бус шинжтэй тул холбогдох эрсдэлийг бууруулах зорилгоор бид олон хувилбар бүхий БДО Корпорацийн санхүүгийн загвар боловсруулж, үнэлгээний үр дүнг олон талаас шинжилдэг. БДО Корпорацийн санхүүгийн загвар нь ирээдүйн мөнгөн урсгалын хамгийн багадаа гурван хувилбарыг үнэлж, бизнесийн үнэ цэнийг харуулдаг. Ингэснээр үнэлгээний үр дүнг тодорхой интервалаар илэрхийлэх боломжтой болдог.



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
BDO GOLOMT CAPITAL LLC
252
Огноо: 2018/04/16

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

## 6.2 Санхүүгийн таамаглал

- Мандал-ын дунд хугацааны санхүүгийн таамаглал нь удирдлагын сайн засаглалын түвшинд боловсруулсан Даатгалын санхүүгийн загвар-т үндэслэсэн бөгөөд ҮОУС 105 *Үнэлгээний хандлагууд ба аргууд*, 10.7-р догол мөрний дагуу үнэлгээний орц мэдээлэл үнэлгээний зорилгод тохиромжтой эсэхийг нягталсан.

- Удирдлагаас бидэнд ирүүлсэн санхүүгийн таамаглал нь органик өсөлтөөр тооцсон, санхүүжилтийн нөлөөг тусгасан гэсэн үндсэн хоёр төрөлтэй байсан. Бид өөрсдийн шинжилгээнд үндэслэн дээрх хоёр таамаглалаас ялгаатай, харьцангуй тогтвортой өсөлт бүхий загвар мөн боловсруулсан.

### Хураамжийн орлого

- Таамагласан хугацааны туршид эдийн засгийн анхдагч орчин таатай уур амьсгалтай байж, даатгалын бүтээгдэхүүний эрэлт тогтвортой хадгалагдана гэж таамагласан.

### Таамагласан хугацааны хураамжийн орлого




*Эх сурвалж: Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөө*

- Таамагласан хугацаанд хураамжийн орлогын бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлт гарна гэж таамагласан. Үүнд, (1) тээврийн хэрэгслийн даатгалын зах зээлд компани байр сууриа тэлэх бүрэн боломжтой, эрүүл мэндийн даатгалын бүтээгдэхүүний эрэлт дунд хугацаанд хэвээр хадгалагдаж хураамжийн өндөр өсөлттэй байна, (2) бусад даатгалын бүтээгдэхүүнүүд жил бүр тогтвортой 10%-иар өсөхөөр хүлээгдэж байгаа зэрэг нь голлон нөлөөлсөн.

### Давхар даатгалын хураамж

- Давхар даатгагчид төлөх хураамжийн бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлт гарна гэж таамагласан. Эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалын өсөлттэй холбогдон Трийти давхар даатгалын хураамж ТЖ19 оноос хойш таамагласан хугацааны туршид өснө. Харин эрсдэл даах чадварын сайжирснаар факултатив давхар даатгалын хураамж буурна гэж таамагласан.

### Давхар даатгалын хураамжийн төсөөлөл

| сая төгрөг | ТЖ17Б | ТЖ18Т | ТЖ19Т | ТЖ20Т | ТЖ21Т | ТЖ22Т |
|---|---|---|---|---|---|---|
| Давхар даатгалын хураамж - Трийти | 3,585 | 2,412 | 3,588 | 5,127 | 7,202 | 10,266 |
| Давхар даатгалын хураамж - Факултатив | 9,071 | 8,859 | 9,195 | 9,564 | 4,471 | 4,918 |

*Эх сурвалж: Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөө*

- ТЖ21 оноос хойших факултатив давхар даатгалын бууралт нь (1) дунд хугацаанд компанийн эрсдэл даах чадвар сайжирна, (2) барилга угсралтын даатгал буурна гэж таамагласантай холбоотой.

### Нөхөн төлбөр

- Компанийн даатгалын бизнес гарааны үетэйгээ харьцуулахад харьцангуй тогтворжсон тул дунд хугацаанд үйл ажиллагааны зардлын харьцаа буурч, цаашлаад нийлмэл харьцаа буурна гэж хүлээж байна. Хохирол нөхөлтийн харьцааны хувьд таамагласан хугацааны туршид түүхэн дунджаас хэт савлахгүй гэж таамагласан. Дунд хугацааны санхүүгийн төсөөлөлд тодорхойлсны дагуу хохирол нөхөлтийн харьцаа ТЖ18-ТЖ22 онд ойролцоогоор 33.1%-36.9%-ийн хооронд хэлбэлзэхээр байна.

СЗХ
2018 оны 08 сарын 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

*Цэвэр нөхөн төлбөрийн зардал, нөөц сангийн өөрчлөлт*




*Эх сурвалж: Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөө*

- Дээрх дүрслэлд тод ногоон өнгөөр цэвэр нөхөн төлбөрийн зардлыг, бүдэг саарал өнгөөр нөөц сангийн өөрчлөлтийг тэмдэглэсэн.

- Орлогод тооцсон хураамжид цэвэр нөхөн төлбөрийн эзлэх хувь ТЖ18 онд 29%, ТЖ19-ТЖ20 онд 31%, үүнээс цааш жил бүр нэг хувиар өсөхөөр хүлээгдэж байна. Хураамжийн орлогын өсөлттэй зэрэгцэн цэвэр нөхөн төлбөрийн өсөлт ирэх таван жилийн дунджаар 31% байна гэж таамагласан.

*Харьцааны төсөөлөл*

| | ТЖ18Т | ТЖ19Т | ТЖ20Т | ТЖ21Т | ТЖ22Т |
|---|---|---|---|---|---|
| Хохирлын харьцаа | 33.8% | 33.1% | 34.2% | 35.6% | 36.9% |
| Зардлын харьцаа | 58.8% | 56.5% | 50.7% | 44.4% | 38.3% |
| Нийлмэл харьцаа | 92.5% | 89.5% | 84.9% | 80.0% | 75.2% |

*Эх сурвалж: Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөө*

- Удирдлагын тооцооллоор хохирлын харьцаа таамагласан хугацааны туршид 33.8%-36.9% болж өсөх хандлагатай, зардлын харьцаа 58.8%-иас 38.3% болж буурах хандлагатай байна. Зардлын харьцааны бууралт нь өргөжилтийн тогтмол үр өгөөжөөр тайлбарлагдана.

*Үйл ажиллагааны зардал*

- Үйл ажиллагааны зардал нь удирдлагын зардал, маркетингийн зардал гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Удирдлагын зардалд бизнесийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилготой зардлууд багтдагаас ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын зардал нь гол бүрэлдэхүүн болдог. Маркетингийн зардалд даатгалын үйлчлүүлэгчидтэй харилцаагаа гүнзгийрүүлэх, шинэ холбоо тогтоох, бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэх зорилготой аливаа үйл ажиллагаанаас үүссэн зардлууд багтана.

*Үйл ажиллагааны зардлын төсөөлөл*




*Эх сурвалж: Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөө*

- Дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөнд тодорхойлсноор ТЖ18 онд компанийг олон нийтэд танилцуулж, бренд бүтээх, болон бусад маркетингийн үйл ажиллагаанаас үүдэн үйл ажиллагааны зардал 19%-иар өсөхөөр төлөвлөсөн. Цаашид үйл ажиллагааны зардал тогтмол буурсаар ТЖ22 онд 7%-иар өсөхөөр хүлээгдэж байна.

*Татвар ба төлбөр, хураамж*

- Мөнгөн урсгалын төсөөлөлд багтсан татвар ба төлбөр, хураамжийн тооцоолол нь Монгол улсын татварын хууль, тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн. Үндсэн татвар ба төлбөр, хураамж нь орлогын албан татвар болно.



СЗХ 2018.08.29 БҮРТГЭВ № 01

МАНДАЛ ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС BDO GOLOMT CAPITAL LLC

254
Огноо: 2018/04/16

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

- Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд заасан дагуу 3,000,000 мянган төгрөг хүртэлх татвар ногдох орлогод 10%-ийн татвар, 3,000,000 мянган төгрөгөөс дээш давсан дүнд 25%-ийн орлогын албан татвар ногдуулна.

### Мөнгөн урсгал таамагласан хугацаа

- Бизнесийн үнэлгээний практикт мөнгөн урсгалыг ихэвчлэн хугацааны хоёр мөчлөгтэй тооцдог. Бид мөн уг практикийг баримтална (1) ТЖ18-ТЖ22 он хүртэлх таван жил, (2) ТЖ22 оноос цаашид хязгааргүй хугацаа[2] -гаар мөнгөн урсгалыг таамагласан.

### Инфляцийн түвшин

- Мөнгөн урсгалын төсөөлөлд үнэлгээний валютын үнэ цэнийн өөрчлөлтийг тусгахын тулд инфляцийн нөлөөг тусгах шаардлагатай болдог. Жишээлбэл, орлогын багцын дийлэнх хэсэг нь гадаад валютаар хэрэгждэг тохиолдолд тухайн гадаад валютын инфляцийг мөнгөн урсгалд, эсвэл хорогдуулах хүүний аль нэгэнд тусгах шаардлагатай. Хэрэв борлуулалтын үнийн өсөлтийг тооцох замаар инфляцийн нөлөөг мөнгөн урсгалд тусгасан бол хорогдуулах хүүг нэрлэсэн хүүгээр тооцох нь зохистой. Харин үнийн өсөлтийг шууд мөнгөн урсгалд тусгаагүй тохиолдолд хорогдуулах хүүд уг нөлөөг тохируулсан байх шаардлагатай.

- Бид өөрсдийн мөнгөн урсгалын төсөөлөлд төгрөгөөр илэрхийлэгдсэн үзүүлэлт ашигласан тул Монгол улсын инфляцийн түвшинг шинжилсэн. Мөнгөн урсгалын төсөөлөлд борлуулалтын үнийг тогтмол байдлаар тусгасан тул хорогдуулах хүүг бодит хүүгээр тооцсон.

**Инфляцийн төсөөллийн хураангуй**

| | 2015 | 2016 | 2017 | 2018 | Урт хугацаанд |
|---|---|---|---|---|---|
| Монгол улс | 1.13% | 0.48% | 6.13% | 6.07% | 6.44% |

Эх сурвалж: Bloomberg, IMF

- Олон улсын валютын сангийн төсөөллөөр Монгол улсын инфляцийн түвшин 2018 онд 6.07%, урт хугацаанд 6.44% байхаар хүлээгдэж байна.

**Инфляцийн урт хугацааны төсөөлөл**




Эх сурвалж: Bloomberg, IMF

- Нэрлэсэн хүүг бодит хүүний рүү хөрвүүлэхдээ бид Фишерийн тэгшитгэл ашигласан бөгөөд тооцооллыг Хавсралт Д-гээс дэлгэрүүлнэ үү.

## 6.3 Зах зээлийн шинжилгээ

- Үнэлж буй бизнестэй ижил үйл ажиллагаа эрхэлдэг нэлттэй компаниудын зах зээлийн үнэлгээг бид шинжилсэн. Ингэхдээ гадаад зах зээл дэх ижил төстэй компаниудын зах зээлийн үнэлгээ, үнэлгээний үржүүлэгчдийг өөрсдийн өгөгдлийн санд тулгуурлан судалсан.

- Доорх хүснэгтэд үйлчлүүлэгчтэй ижил төстэй бизнес бүхий нэлттэй компаниудын зах зээлийн үнэлгээний гол үржүүлэгчид болон зарим харьцаануудыг хураангуйлав.

[2] Үнэлгээний практикт 50 жилээс дээш хугацааг хязгааргүй хугацаа гэж тайлбарладаг. Энэ нь тасралтгүй буюу дискрет мөнгөн урсгалын тооцоолол 50-иас дээш үеэр тооцоход тасралтгүй буюу хязгааргүй хугацаанд тооцсон мөнгөн урсгалын үр дүнтэй материаллаг зөрүүгүй болдогтой холбоотой.

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

*Ижил төстэй бизнес бүхий нээлттэй компаниудын зах зээлийн үнэлгээний үржүүлэгчид*

| Жишиг компанийн ангилал | Бизнесийн үнэ цэнэ/ Борлуулалт | Бизнесийн үнэ цэнэ/ ХТӨА | Бизнесийн үнэ цэнэ/ ХТЭХӨА | Хувьцааны үнэ/ Цэвэр ашиг | Форвард үнэ | Хувьцааны үнэ/ Дансны үнэ | Хувьцааны үнэ/ Мөнгөн урсгал | Хувьцааны үнэ/ Бие хөрөнгө |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Том даатгалын компаниуд | | | | | | | | |
| Хамгийн өндөр утга | 3.00x | 83.90x | 52.10x | 41.40x | 13.10x | 1.60x | 27.90x | 2.30x |
| Хамгийн бага утга | 0.50x | 4.10x | 2.80x | 1.00x | 0.10x | 0.10x | 0.50x | 0.10x |
| Медиан | 1.50x | 13.60x | 11.10x | 17.10x | 12.00x | 1.30x | 9.45x | 1.80x |
| Дундаж | 1.47x | 19.46x | 14.72x | 18.01x | 10.11x | 1.19x | 11.65x | 1.54x |
| Томоохон даатгалын компаниуд | | | | | | | | |
| Хамгийн өндөр утга | 2.40x | 14.80x | 13.40x | 20.30x | 13.80x | 3.00x | 21.30x | 4.60x |
| Хамгийн бага утга | 0.50x | 9.30x | 7.90x | 12.40x | 10.50x | 0.70x | 6.40x | 1.20x |
| Медиан | 1.20x | 11.50x | 10.80x | 15.20x | 12.70x | 1.45x | 12.50x | 1.55x |
| Дундаж | 1.38x | 12.12x | 10.62x | 15.44x | 12.26x | 1.75x | 12.62x | 2.23x |
| Дунд даатгалын компаниуд | | | | | | | | |
| Хамгийн өндөр утга | 34.80x | 82.90x | 59.80x | 1321.00x | 186.30x | 2.30x | 108.40x | 6.50x |
| Хамгийн бага утга | 0.10x | 0.50x | 0.50x | 0.10x | 4.70x | 0.10x | 0.10x | 0.10x |
| Медиан | 1.40x | 16.10x | 14.25x | 19.95x | 12.90x | 1.20x | 14.20x | 1.30x |
| Дундаж | 2.34x | 21.63x | 17.83x | 60.63x | 19.26x | 1.28x | 20.49x | 1.49x |
| Жижиг даатгалын компаниуд | | | | | | | | |
| Хамгийн өндөр утга | 15.60x | 93.50x | 56.30x | 230.40x | 22.70x | 4.50x | 979.00x | 4.50x |
| Хамгийн бага утга | 0.10x | 1.00x | 0.60x | 5.50x | 6.20x | 0.30x | 0.10x | 0.30x |
| Медиан | 0.85x | 9.90x | 9.00x | 14.25x | 10.30x | 1.10x | 13.45x | 1.40x |
| Дундаж | 1.93x | 16.53x | 13.75x | 34.22x | 13.25x | 1.50x | 60.39x | 1.54x |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

СЗХ
он 2018 сар 08 өдөр 29
БҮРТГЭВ
№ 01

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC
256
Огноо: 2018/04/16

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

*Мандал даатгалын өрсөлдөгч компаниудын санхүүгийн зарим харьцааны шинжилгээ*

| Санхүүгийн харьцаанууд | Мандал даатгал | Жишиг-1 | Жишиг-2 | Жишиг-3 | Жишиг-4 | Дундаж | Медиан |
|---|---|---|---|---|---|---|---|
| *Хөрөнгийн байдлын үнэлгээ* | | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн нийт хөрөнгөнд эзлэх хувь | 0.01 | 0.13 | 0.08 | 0.11 | 0.12 | 0.09 | 0.11 |
| *Санхүүгийн байдлын үнэлгээ* | | | | | | | |
| Өөрийн хөрөнгийн хувийн жин | 0.29 | 0.22 | 0.42 | 0.26 | 0.26 | 0.29 | 0.26 |
| Эргэлтийн харьцаа | N/A | N/A | N/A | N/A | N/A | N/A | N/A |
| УХӨТ-ийн нийт эх үүсвэр эзлэх %-ийн жин | N/A | N/A | N/A | N/A | N/A | N/A | N/A |
| Нөөц сангийн орлогод тооцсон хураамжид эзлэх жин | 1.74 | 0.93 | 0.67 | 1.11 | 1.04 | 1.10 | 1.04 |
| Нөөц сангийн нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин | 0.57 | 0.65 | 0.30 | 0.55 | 0.61 | 0.54 | 0.57 |
| *Ашигт ажиллагааны үнэлгээ* | | | | | | | |
| Орлогод тооцсон хураамж/хураамжийн цэвэр орлого | 0.70 | 0.88 | 0.93 | 0.90 | 1.00 | 0.88 | 0.90 |
| Үйл ажиллагааны ашгийн түвшин | 0.80 | 0.35 | 0.87 | 0.49 | 0.55 | 0.61 | 0.55 |
| Өөрийн хөрөнгийн ашигт ажиллагаа | 0.18 | 0.03 | 0.22 | 0.24 | -0.24 | 0.08 | 0.18 |
| Даатгагчид үлдэх хураамжийн хувь | 0.45 | 0.91 | 0.93 | 0.91 | 0.39 | 0.72 | 0.91 |
| Даатгалын цэвэр ашгийн хувь | 0.16 | 0.01 | 0.20 | 0.13 | -0.11 | 0.08 | 0.13 |
| Нийт хөрөнгийн ашигт ажиллагаа | 0.05 | 0.01 | 0.09 | 0.06 | -0.06 | 0.03 | 0.05 |
| Хөрөнгийн өгөөж | 0.06 | 0.01 | 0.10 | 0.07 | -0.07 | 0.03 | 0.06 |
| Өмчийн өгөөж | 0.20 | 0.02 | 0.15 | 0.15 | -0.21 | 0.06 | 0.15 |
| *Өсөлтийн үнэлгээ* | | | | | | | |
| Нийт хураамжийн өсөлт | 0.72 | 0.21 | 0.06 | 0.09 | 0.40 | 0.30 | 0.21 |
| ЭХ- ийн эргэц | N/A | N/A | N/A | N/A | N/A | N/A | N/A |
| Авлагын эргэц | N/A | N/A | N/A | N/A | N/A | N/A | N/A |
| *Даатгалын үйл ажиллагааны шинжилгээ* | | | | | | | |
| Хохирлын харьцаа | 0.29 | 0.61 | 0.33 | 0.43 | 0.35 | 0.40 | 0.35 |
| Зардлын харьцаа | 0.57 | 0.50 | 0.60 | 0.32 | 0.50 | 0.50 | 0.50 |
| Нийлмэл харьцаа | 0.87 | 1.10 | 0.94 | 0.75 | 0.86 | 0.90 | 0.87 |
| Үйл ажиллагааны харьцаа | 0.69 | 0.93 | 0.71 | 0.26 | 0.75 | 0.67 | 0.71 |
| Хөрөнгө оруулалтын харьцаа | 0.17 | 0.17 | 0.23 | 0.49 | 0.10 | 0.23 | 0.17 |



СЭХ
2018.08.29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

СЗХ
2018.08.29
БҮРТГЭВ
№ 01

## 7. Үнэлгээний үр дүн

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС
GOLONT CAPITAL LLC
258
Огноо: 2018/04/16

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЗХ
2018 оны 08 сарын 29 өдөр
№ 01

## Орлогын хандлага: ХМУ загвар

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ, удирдлагаас хүлээн авсан бизнесийн төлөвлөгөөнд суурилан Мандал-ын ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг тооцож, бизнесийн үнэ цэнийг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав. (Үнэлгээний тооцоолныг Хавсралт Д-ээс дэлгэрүүлнэ үү.)

- Мөнгөн урсгалын төсөөлөл нь удирдлагаас бидэнд ирүүлсэн дунд хугацааны бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн бөгөөд хорогдуулах хүүний тооцооллыг БДО Монгол-ын шинжилгээгээр 23.8%-иас 24.8% байхаар тооцсон. Мөн түүнчлэн бид дараах арга зүй, параметрүүдийг мөнгөн урсгалын төсөөлөлд ашигласан.

  - Бизнесийн үлдэх үнэ цэнэ буюу эцсийн мөнгөн урсгалыг Гордоны тогтмол өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон.
  - Урт хугацааны өсөлтийн параметрийг сонгохдоо Сангийн яам-ны урт хугацааны эдийн засгийн өсөлтийн судалгаанд тодорхойлсон 3.6%-иас 5.6% байхаар сонгон авсан.
  - Урт хугацааны хүлээгдэж буй инфляци 6.44% байна.
  - Хувьцаат капиталын цэвэр дансны үнэ таамагласан хугацааны туршид өөрчлөгдөхгүй гэж таамагласан.
  - Бид хорогдуулах хүүний үеийг дундаж үеийн аргаар тооцсон.

- Хорогдуулсан мөнгөн урсгалын загварын үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **23,619,153 - 25,208,593** мянган төгрөг байна.

### *Хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар тооцсон үнэлгээний үр дүн*

| Мөнгөн урсгалын төсөөлөл | ТЖ18Т | ТЖ19Т | ТЖ20Т | ТЖ21Т | ТЖ22Т |
|---|---|---|---|---|---|
| Татварын дараах цэвэр ашиг | 1,906,234 | 2,602,224 | 3,869,198 | 5,519,404 | 7,927,123 |
| Хойшлогдсон татвар | - | - | - | - | - |
| Тохируулсан татварын дараах цэвэр ашиг | 1,906,234 | 2,602,224 | 3,869,198 | 5,519,404 | 7,927,123 |
| Хувьцаат капиталын эхний үлдэгдэл | 5,000,000 | 5,000,000 | 5,000,000 | 5,000,000 | 5,000,000 |
| Нуугдмал чөлөөт мөнгөн урсгал | 1,906,234 | 2,602,224 | 3,869,198 | 5,519,404 | 7,927,123 |
| Хувьцаат капиталын эхний үлдэгдлийн өгөөж | 38.12% | 52.04% | 77.38% | 110.39% | 158.54% |
| Хувьцаат капиталын эхний үлдэгдлийн тохируулсан өгөөж | 38.12% | 52.04% | 77.38% | 110.39% | 158.54% |
| Хөрөнгө оруулалтын өгөөж | 10.85% | 14.14% | 15.06% | 15.75% | 16.26% |
| Нуугдмал үлдэгдэл орлого | 665,338 | 1,361,328 | 2,628,302 | 4,278,508 | 6,686,227 |

| Үнэ цэнийн тооцоолол | ТЖ18Т | ТЖ19Т | ТЖ20Т | ТЖ21Т | ТЖ22Т |
|---|---|---|---|---|---|
| Тасралттай мөнгөн урсгал | 1,906,234 | 2,602,224 | 3,869,198 | 5,519,404 | 7,927,123 |
| Тасралтгүй мөнгөн урсгал | | | | | 31,681,740 |
| Хорогдуулах үе | 0.50 | 1.50 | 2.50 | 3.50 | 4.50 |
| Хорогдуулах хүчин зүйл | 0.90 | 0.73 | 0.59 | 0.47 | 0.38 |
| Хорогдуулсан дискрет мөнгөн урсгал | 1,712,606 | 1,888,175 | 2,268,266 | 2,611,841 | 3,029,698 |
| Хорогдуулсан эцсийн мөнгөн урсгал | | | | | 12,108,567 |
| 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян төгрөг) | | | | | 23,619,153 |
| 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян ам доллар) | | | | | 9,731 |



| Мэдрэмжийн шинжилгээ | | 1.6% | 2.6% | 3.6% | 4.6% | 5.6% |
|---|---|---|---|---|---|---|
| | 21.8% | 24,827,485 | 25,625,043 | 26,510,206 | 27,498,247 | 28,608,210 |
| | 22.8% | 23,510,655 | 24,212,611 | 24,987,658 | 25,847,837 | 26,807,991 |
| | 23.8% | 22,315,996 | 22,936,851 | 23,619,153 | 24,372,498 | 25,208,593 |
| | 24.8% | 21,227,635 | 21,779,227 | 22,382,836 | 23,046,186 | 23,778,606 |
| | 25.8% | 20,232,325 | 20,724,400 | 21,260,791 | 21,847,766 | 22,492,834 |
| Хорогдуулах хүчин зүйл - 1 | 21.8% | 0.91 | 0.74 | 0.61 | 0.50 | 0.41 |
| Хорогдуулах хүчин зүйл - 2 | 22.8% | 0.90 | 0.73 | 0.60 | 0.49 | 0.40 |
| Хорогдуулах хүчин зүйл - 3 | 23.8% | 0.90 | 0.73 | 0.59 | 0.47 | 0.38 |
| Хорогдуулах хүчин зүйл - 4 | 24.8% | 0.89 | 0.72 | 0.57 | 0.46 | 0.37 |
| Хорогдуулах хүчин зүйл - 5 | 25.8% | 0.89 | 0.71 | 0.56 | 0.45 | 0.36 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ



МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

## Зах зээлийн хандлага: ЖКАЗ

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үйлчлүүлэгчтэй ижил бизнесийн эрсдэл бүхий жишиг компаниудын зах зээлийн үнэлгээг тооцож, бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнийг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав. (Жишиг компанийн мэдээллийг Хавсралт Г-ээс дэлгэрүүлнэ үү.)

- Үнэлгээний баг жишиг компаниудыг сонгохдоо эдийн засгийн анхдагч орчны (1) ижил эрсдэлтэй улс орнуудын (2) ойролцоо эрсдэлтэй улс орнуудын ердийн даатгал компаниудыг судалсан. Хэрэв ижил эрсдэлтэй орчин байрлах даатгалын компаниуд хангалттай буюу хүрэлцээтэй орц мэдээлэлгүй бол ойролцоо эрсдэлтэй компаниуд руу шилжих замаар түүврийн цар хүрээг өргөтгөсөн.

- Жишиг компанийн арга зүйгээр тооцсон үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **27,294,624** мянган төгрөг байна.

- Жишиг компанийн мэдээлэлд тохируулга хийснээр орц мэдээллийн түвшин 1-р зэрэглэлээс 2-р зэрэглэл рүү шилжсэн тул жишиг компанийн арга зүйд үнэлгээний баг ач холбогдол өгөөгүй болохыг анхаарна уу.

*Жишиг компанийн аргаар тооцсон үнэлгээний үр дүн*

| Жишиг компанийн аргаарх зах зээлийн үнэлгээ | |
|---|---|
| Татварын өмнөх ашиг | 1,265,073 |
| Хүүний зардал | - |
| Элэгдэл, хорогдол | - |
| ХТЭХӨА | 1,265,073 |

| Жишиг компанийн аргаарх зах зээлийн үнэлгээ | |
|---|---|
| Анхдагч үнэлгээ | |
| Санхүүгийн хэмжүүр | 1,265,073 |
| Үндсэн үржүүлэгч | 21.58x |
| Тохируулсан зах зээлийн үнэлгээ | 27,294,624 |
| Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян.төг) | 27,294,624 |
| Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян.ам дол) | 11,246 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



СЗХ БҮРТГЭВ 2018.08.29 № 01
МАНДАЛ ДААТГАЛ ХХК УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС BDO GOLOMT CAPITAL LLC 260
Огноо: 2018/04/16
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЭХ
он сар өдөр
2018 08 29
БҮРТГЭВ
№ 01

## Зах зээлийн хандлага: ЖААЗ

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үйлчлүүлэгчтэй ижил бизнесийн эрсдэл бүхий жишиг компаниудын нэгдэл ба худалдан авалтын зах зээл дахь арилжаануудыг судлах замаар бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнийг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав. (Жишиг арилжааны мэдээллийг Хавсралт Е-ээс дэлгэрүүлнэ үү.)
- Ази Номхон далайн бүс нутагт хийгдсэн жишиг арилжааны мэдээлэл хомс байснаас үүдэн үнэлгээний түүврийн хязгаарыг тэлж, Ойрх дорнод, Европын бүс нутагт хийгдсэн даатгалын арилжаар судалсан. Цаашлаад, сонгогдсон арилжааны параметрүүдийг эдийн засгийн анхдагч орчны ялгаагаар тохируулж, хэт хэлбэлзэлтэй элементүүдийг засварласан.
- Жишиг арилжааны аргаар тооцсон үр дүнгээс дүгнэхэд үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **23,209,501** мянган төгрөг байна.
- Жишиг арилжааны мэдээлэлд тохируулга хийснээр орц мэдээллийн түвшин 1-р зэрэглэлээс 2-р зэрэглэл рүү шилжсэн тул жишиг арилжааны арга зүйд үнэлгээний баг ач холбогдол өгөөгүй болохыг анхаарна уу.

*Жишиг арилжааны аргаар тооцсон үнэлгээний үр дүн*

| Жишиг компанийн аргаарх зах зээлийн үнэлгээ | |
|---|---|
| Татварын өмнөх ашиг | 1,265,073 |
| Орлогын албан татвар | 162,548 |
| Цэвэр ашиг | 1,102,525 |

| Жишиг арилжааны аргаарх зах зээлийн үнэлгээ | |
|---|---|
| Анхдагч үнэлгээ | |
| Санхүүгийн хэмжүүр | 1,102,525 |
| Үндсэн үржүүлэгч | 21.05x |
| Тохируулсан зах зээлийн үнэлгээ | 23,209,501 |
| Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян.төг) | 23,209,501 |
| Бизнесийн 100%-ийн хувь оролцооны үнэ цэнэ (мян.ам дол) | 9,563 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
Б. Нэмэхбаяр? ОТ

МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
261
Огноо: 2018/04/16

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

## Өртгийн хандлага: Тохируулсан цэвэр активын арга

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон судалгаанд үндэслэн үйлчлүүлэгчийн хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлж, цэвэр активт тохируулга хийх замаар бизнесийн үнэ цэнийн доод хязгаарыг тодорхойлсон. Үнэлгээний үр дүнг зэргэлдээ хүснэгтэд хураангуйлав.
- Тохируулсан цэвэр активын аргыг ихэвчлэн устгалын үнэ цэнэ[3] тооцоход ашигладаг. Бид энэ аргыг үйлчлүүлэгчийн өмчид ногдох үнэ цэнийн доод хязгаар тогтоох зорилгоор ашигласан.
- Мандал-ын хөрөнгийн үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгасны дараа үнэлгээний өдрийн байдлаар үйлчлүүлэгчийн бизнесийн 100%-ийн хувь оролцоонд ногдох зах зээлийн үнэ цэнэ **5,411,286** мянган төгрөг байна.

*Тохируулсан цэвэр активын аргаар тооцсон үнэлгээний үр дүн*

| мянган төгрөг | Үнэлгээний өдрийн дансны үнэ | Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ |
|---|---|---|
| А. Эргэлтийн бус хөрөнгө | 582,921 | 622,353 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж байгаа орон сууц | 236,640 | 249,864 |
| Тээврийн хэрэгсэл | 78,167 | 71,733 |
| Конторын тоног төхөөрөмж | 13,607 | 13,607 |
| Тавилга эд хогшил | 103,797 | 103,797 |
| Тооцоолох техник | 67,124 | 67,124 |
| Бусад үндсэн хөрөнгө | 26,262 | 19,628 |
| Програм хангамж | 57,325 | 96,600 |
| Б. Эргэлтийн хөрөнгө | 20,889,229 | 20,260,192 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн | 1,805,206 | 1,805,206 |
| Даатгалын авлага | 4,402,450 | 3,854,656 |
| Бусад авлага /цэвэр дүнгээр/ | 401,174 | 341,860 |
| Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн | 182,385 | 160,457 |
| Хөрөнгө оруулалт | 9,229,438 | 9,229,438 |
| Даатгалын хөрөнгө | 4,868,576 | 4,868,576 |
| В. Нийт хөрөнгө | 21,472,151 | 20,882,545 |
| Г. Нийт өр төлбөр | (15,471,259) | (15,471,259) |
| Д. Цэвэр өмч | 6,000,891 | 5,411,286 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

[3] Устгалын үнэ цэнэ гэдэг нь хөрөнгийн бүлгийг хэсэгчилсэн байдлаар борлуулах үед хэрэгжих дүн юм. Устгалын үнэ цэнэд тухайн хөрөнгийг борлуулах боломжтой нөхцөл байдалд оруулах өртөг зардал, түүнчлэн дансныс хасалтын ажиллагааны өртөг зардлыг хорогдсон үзнэ.



МАНДАЛ ДААТГАЛ ХХК
УЛААНБААТАР ХОТ 3489

СЗХ он сар өдөр 2018 .08.28 № 01

МОНГОЛ УЛС BDO GOLOMT CAPITAL LLC

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ ... он ... сар ... өдөр 01

262
Огноо: 2018/04/16

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

## Хавсралт

Хавсралт А. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл
Хавсралт Б. Үнэлгээний нийтлэг хандлагууд
Хавсралт В. Капиталын жигнэсэн дундаж өртөг
Хавсралт Г. Жишиг компанийн мэдээлэл
Хавсралт Д. Мөнгөн урсгалын төсөөлөл
Хавсралт Е. Жишиг арилжааны мэдээлэл
Хавсралт Ё. Мэдээллийн эх сурвалж
Хавсралт Ж. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл
Хавсралт З. Үнэлгээний баг
Хавсралт И. Үнэлгээчний тусгай зөвшөөрөл



263
Огноо: 2018/04/16

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЗХ
2018.08.29өдөр
БҮРТГЭВ
№01

**Хавсралт А. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл**

- Энэхүү тайланд багтсан үнэ цэнийн дүгнэлттэй холбогдох хязгаарлах нөхцөлийг доор хураангуйлан оруулсан.
- Энэхүү үнэлгээний тайлан нь бусад үнэлгээ эсвэл судалгаатай хамт хэрэглэгдэхгүй. Үнэлгээний дүгнэлт, тайланд багтсан судалгаа, гүйцэтгэсэн горимууд нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд эдгээрийг тусад нь салгаж хэрэглэхгүй.
- Үнэлгээг зөвхөн тайланд заасан зорилго, зориулалт, этгээдүүдэд л зориулж бэлтгэсэн. БДО Монгол-оос бичгээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд тайланг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн хувилах, энд дурдсан мэдээлэл, тоо, дүнг ямар нэгэн өөр зорилгоор гуравдагч этгээд ашиглахыг хориглоно.
- БДО Монгол-оос өөр байгууллага, хувь хүн тайлангийн ямар нэг хэсэгт зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно. Ийм төрлийн өөрчлөлт орсон тохиолдолд БДО Монгол ямар нэгэн хариуцлага хүлээхгүй.
- Гэрээт ажилтай холбоотой ажлын баримтыг бид хадгалж үлддэг бөгөөд үнэлгээний дүгнэлтэд тайлбар авах шаардлага гарсан тохиолдолд ажлын баримттай танилцаж болно. Гэхдээ энэ үйлчилгээ үнэлгээний гэрээт ажлын захидалд тусгайлан заагаагүй тохиолдолд нэмэлт төлбөртэй байна.
- Энэхүү тайланг БДО Монгол-оос бичгээр зөвшөөрөл авалгүйгээр бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зар сурталчилгаа хийх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж олон нийтэд түгээх, Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороо эсвэл Засгийн Газар-ын бусад байгууллагад санал өгөхөөс өөрөөр хувийн болон олон нийтэд мэдээлэл өгөхдөө иш татах зэргээр нийтэд дэлгэх, түгээхийг хориглоно.
- Үнэлгээний дүгнэлтэд нөлөөлж болох үнэлгээний өдрөөс хойш гарсан аливаа үйл явдал, нөхцөл байдалд бид ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй.
- Энэхүү үнэлгээнд ашигласан зарим таамаглал эсвэл төсөөлөл нь хэрэгжихгүй байж болох ба урьдчилан таамаглаагүй үйл явдал үүсэж болзошгүй. Үүнд: эдийн засгийн томоохон өөрчлөлт; үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн томоохон өөрчлөлт; татвар ба бусад хууль зүйн орчинд гарсан томоохон өөрчлөлтүүд багтана. Тиймээс төлөвлөсөн хугацааны бодит үр дүн нь хөрөнгө оруулагчийн шаардлагаас өөр байх магадлалтай. Энэ хэлбэлзэл нь материаллаг байж болох ба үнэлгээний тайланд багтсан үнийн дүнд нөлөөлж болзошгүй.
- Ирээдүйн үйл явдалтай холбоотой төсөв/урьдчилсан таамаглал/прогноз зэрэг нь төлөвлөсөн хугацаанд хүчинтэй хэвээр байна гэсэн таамаглалд суурилсан боловч энэ нь биелэхгүй байж болно. Иймээс төсөвлөсөн/урьдчилсан таамаглал нь бодит дүнтэй хэр ойрхон буух тал дээр бид ямар нэгэн дүгнэлт гаргаагүй болно.
- Удирдлагаас болон түүнээс эрх олгогдсон төлөөллөөс бидэнд өгсөн мэдээллийн үнэн зөв байдал эсвэл иж бүрэн байдалд бид ямар нэгэн үүрэг хариуцлага хүлээхгүй.
- Энэхүү ажлыг хийхтэй холбоотой гэрээгээр урьдчилан тохироогүй эсвэл үйлчлүүлэгчийн зүгээс хүсэлт тавьж, нэмэлт төлбөр санал болгож, урьдчилсан тохиролцоо хийгээгүй л бол бид үнэлсэн хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн гэрчийн мэдүүлэг өгөх, шүүх хуралд оролцох, захиргааны үйл ажиллагаанд оролцох үүрэг хүлээхгүй.
- Энэхүү тайланг зөвхөн тайланд дурдсан зориулалтаар хэрэглэх бөгөөд тайлан нь иж бүрнээрээ байхдаа хүчинтэй байна. Тайланд эцсийн байдлаар оруулсан тооцоолсон зах зээлийн үнэ цэн нь зөвхөн үнэлгээний өдрөөр хүчинтэй байна.
- Үйлчлүүлэгчийн төлөөлөгчийн бидэнд өгсөн нягтлан бодох бүртгэлийн болон хууль эрх зүйн мэдээллийн үнэн зөв байдалтай холбоотой санал дүгнэлтийг БДО Монгол-оос гаргаагүй бөгөөд бид хөрөнгийн эзэмшлийн эрхэд ямар нэгэн дью дилижинсийн үйлчилгээ үзүүлээгүй болно.
- Зөвхөн тайланд багтсан төсөөлөл ба хязгаарлах нөхцөлүүдээр л БДО Монгол-ын гүйцэтгэсэн шинжилгээ болон дүгнэлт хязгаарлагдана.
- Бид үйлчлүүлэгчийн өгсөн мэдээллийн иж бүрэн байдал ба үнэн зөв байдалтай холбоотой ямар нэгэн өр төлбөр эсвэл үүрэг хариуцлага хүлээхгүй.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC
Огноо: 2018/04/16

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ 2018.08.28
№ 01

## Хавсралт Б. Үнэлгээний нийтлэг хандлагууд

- Аливаа хөрөнгө ба бизнесийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлоход ашигладаг уламжлалт гурван үнэлгээний хандлага байдаг. Үүнд: (i) Орлогын хандлага; (ii) Зах зээлийн хандлага; ба (iii) Хөрөнгөд суурилсан хандлага багтана. Эдгээр үндсэн гурван хандлага дотор үнэ цэнэ тооцоолох хэд хэдэн арга хамаарна.
- Гурван хандлага тус бүрийг доор хураангуйлан тайлбарлав.

### Орлогын хандлага

*Орлогын хандлага нь хөрөнгө ба бизнесийн ирээдүйд бий болгохоор хүлээгдэж буй эдийн засгийн орлогын үнэ цэнэд суурилан зах зээлийн үнэ цэнэ тооцдог. Чөлөөт мөнгөн урсгал нь (i) тодорхой таамагласан хугацааны чөлөөт мөнгөн урсгал (ii) үлдэх эцсийн үнэ цэнэ гэсэн хоёр бүрэлдэхүүний өнөөгийн үнэ цэнэтэй тэнцүү байна. Хүлээгдэж буй чөлөөт мөнгөн урсгал (жишээ нь: таван жил)-ыг тооцохдоо түүхэн өгөгдөл ба удирдлагаас хүргүүлсэн таамаглалыг авч үздэг. Эцсийн үнэ цэнэ нь таамагласан хугацаанаас цааших үнэлж буй хөрөнгө ба бизнесийн ирээдүйн мөнгөн урсгалыг илтгэнэ. Тасралтгүй үйл ажиллагааны арга эсвэл урт хугацаанд салбараас гарах өгөөжийг ашиглан эцсийн үнэ цэнийг тооцдог. Урт хугацаанд салбараас гарах арга нь таамагласан хугацааны сүүлийн жилийн чөлөөт мөнгөн урсгалыг капиталжуулдаг арга юм. Үүний дараа таамагласан чөлөөт мөнгөн урсгал ба эцсийн үнэ цэнийг нийт хөрөнгө оруулсан капиталд шаардлагатай өгөөжөөр өнөөгийн үнэ цэнэ хүртэл дискаунтлана. Орлогын хандлага дотор хамгийн өргөн ашиглагддаг арга зүй нь хорогдуулсан мөнгөн урсгалын загвар юм.*

### Хорогдуулсан мөнгөн урсгалын загвар

Хорогдуулсан мөнгөн урсгалын загвар нь хөрөнгө ба бизнесийн үнэ цэнэд нөлөөлөх түлхүүр хүчин зүйлсийг системтэйгээр нэг загварт нэгтгэдэг. Үнэ цэнэд олон хүчин зүйлс нөлөөлдөг ч академик хүрээнд хийгдсэн судалгааны ажлуудаас дүгнэхэд хөрөнгө оруулагчид дараах долоон хүчин зүйлс зах зээлийн үнэ цэнийг илүү тайлбарладаг гэж үздэг.

- Хүлээгдэж буй татварын дараах үйл ажиллагааны цэвэр мөнгөн урсгал
- Хүлээгдэж буй капиталын зардал
- Хүлээгдэж буй ажлын капиталын хэрэгцээ
- Удирдлага капиталын өртгөөс давсан өгөөж олно гэсэн зах зээлийн хүлээлтийн хугацаа
- Хүлээгдэж буй капиталын өгөөж
- Бизнесийн эрсдэл
- Санхүүгийн хөшүүрэг

"ХААН ДААТГАЛ" ХХК (Даатгагч) болон "БДО АУДИТ" ХХК (Даатгуулагч) нар нь Монгол улсын хууль тогтоомжийн дагуу дор дурдсан нөхцөлөөр Даатгалын гэрээг байгуулсан болохыг үүгээр гэрчилж байна.

| | |
|---|---|
| ГЭРЭЭНИЙ ДУГААР: | № Г17089873 |
| ДААТГУУЛАГЧ: | "БДО АУДИТ" ХХК<br>Хөрөнгийн үнэлгээчин-Г.Баянмөнх /РП67042814/<br>Хөрөнгийн үнэлгээчин - Ж.Энхчимэг /ТИ65050264/ |
| ДААТГАГЧ: | "ХААН ДААТГАЛ" ХХК<br>47/2,Энхтайваны өргөн чөлөө, Баянзүрх дүүрэг,<br>Улаанбаатар-210644, Монгол Улс |
| ДАВХАР ДААТГАГЧ: | HANNOVER RUCKVERSICHERUNG AG<br>Karl-Wiechert-Allee 50, 30625 Ханновер,<br>Герман Улс |
| ДААТГАЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТӨРӨЛ: | МЭРГЭЖЛИЙН ХАРИУЦЛАГЫН ДААТГАЛ |
| ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ: | 1,000,000,000.00 ₮ |
| ДААТГАЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ: | МОНГОЛ УЛС |
| ДААТГАЛЫН ХУГАЦАА: | Эхлэх хугацаа: 2017.08.16<br>Дуусах хугацаа: 2018.08.15 |

ДААТГАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ж. БАЯРСАЙХАН

УЛААНБААТАР ХОТ ХААН ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС GOLOMT CAPITAL LLC ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

МАНДАЛ ДААТГАЛ ХХК мандал даатгал

## 6.12. Хөрөнгийн үнэлгээний тайлан

Нууцлалын гэрээгээр хатуу хязгаарлагдсан

# МАНДАЛ ДААТГАЛ ХХК

### Хөрөнгийн үнэлгээний тайлан

### 2017 оны 12-р сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон

## БДО Аудит Хязгаардлагдмал Хариуцлагатай Компани

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

*Энэхүү тайлан нь Хавсралт А-д заасан Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл болон Удирдлагад хаягласан захидалд тусгасан үнэлгээний зорилгын дагуу бэлтгэгдсэн болно. Таны хэрэгцээнд зориулж энэ тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж байна. Зөвхөн гарын үсэг зурж, тамга дарсан хувилбар нь хүчин төгөлдөр болно.*

BDO

Монгол улс, Улаанбаатар хот
СБД-1, ЮНЕСКО-гийн гудамж
Нарны зам-62, Юнион Бюлдинг
В блок, 15-р давхар, 1502 тоот

СЗХ
2018 оны 08 сарын 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Мандал Даатгал ХХК
Монгол улс, Улаанбаатар хот
14230, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо
13-р хороолол, Нарны зам 87
НСКБ Билдинг

Ноён Б. Жавхлан (цаашид "Та" гэх) танаа:

Огноо: 2018 оны 3-р сарын 23-ны өдөр

Хүндэт ноён,

Бидний хооронд 2018 оны 2-р сарын 21-нд байгуулсан Үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээт ажлын захидал (цаашид "Гэрээ" гэх)-д заасан дагуу бид Мандал Даатгал ХХК (цаашид "Мандал" гэх)-ийн захиалгаар тус компанийн эзэмшиж буй биет ба биет бус хөрөнгө (цаашид "Хөрөнгө" гэх)-ийн тооцоолсон зах зээлийн үнэ цэнийг тооцож, хөрөнгийн үнэлгээний тайлан бэлтгэлээ.

Компани нь хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргаж, өмчийн санхүүжилт босгох зорилгоор биет ба биет бус хөрөнгийн үнэлгээ (цаашид "Үнэлгээ" гэх) хийхийг биднээс хүссэн.

Энэхүү тайлан нь 2017 оны 12-р сарын 31 ("Үнэлгээний өдөр")-ны байдлаар хөрөнгийн үнэлгээний үр дүнг нэгтгэсэн болно. Үнэлгээний зорилго нь хараат бус экспертийн журмаар компанийн эзэмшиж буй хөрөнгийн тооцоолсон зах зээлийн үнэ цэнийг тодорхойлоход оршино.

Үнэлгээний хураангуй дүгнэлт нь энэ тайланд толилуулагдсанаас гадна бидний ашигласан горим, арга зүйн тайлбар, үнэлгээний шинжилгээ хийхэд авч үзсэн хүчин зүйлс багтсан. Бид мөн ашигласан мэдээллийн эх сурвалжийг аливаа хязгаарлалтын хамт энэхүү тайлангийн Хавсралт А-Ё-д жагсаасан. Хавсралт А-Ё-д дурдсан мэдээлэл, тооцоолол, үнэлгээний хязгаарлалтын нөхцөл нь уг тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

Энэхүү тайланд тусгагдсан бизнестэй холбогдох шинжилгээ нь танай өгсөн мэдээлэлд үндэслэсэн. Бизнесийн үнэ цэнийг мэргэжлийн шүүмж (шийдэл) ашиглан тооцсон тул бусад үнэлгээчид үүнтэй ижил үр дүнг гаргахгүй байж болно гэдгийг бид хүлээн зөвшөөрч байна. Бидэнд өгсөн мэдээлэл ба ашигласан төсөөллүүдэд суурилан бид энэхүү тайланд тооцоолсон үнэ цэнэ нь ул үндэслэлтэй гэж үзэж байна.

Энэ үнэлгээнд материаллаг үр нөлөөтэй аливаа мэдээллийг бид олж мэдсэн нөхцөлд холбогдох нэмэлт мэдээллийг тусгах үүднээс өөрсдийн үнэлгээний дүгнэлтээ шинэчлэн найруулах эрхтэй боловч ийм үүрэг хүлээхгүй.

Хэрэв танд аливаа тайлбар эсвэл дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай бол Г.Баянмөнх-тай +976 9111 4040, bayanmunkh@bdo.mn гэсэн хаягаар, эсвэл Д.Алтансүх +976 9999 1614, altansukh@bdo.mn хаягаар холбоо барина уу.

Таныг хүндэтгэсэн,

Гомбын БАЯНМӨНХ
Удирдах партнер
Тэргүүлэх үнэлгээчин
БДО Аудит ХХК

Даланбаярын АЛТАНСҮХ
Гүйцэтгэх захирал
МНБ
БДО Аудит ХХК

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

GOLOMT CAPITAL LLC

## Тодорхойлолт, товчилсон үгийн тайлар

| Товчилсон үг | Утга |
|---|---|
| БДО Монгол/Бид | БДО Аудит Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани; Улсын бүртгэлийн 2546442 регистрийн дугаартай, аудит, үнэлгээний зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж |
| Гэрээт ажлын захидал | 2018 оны 2-р сарын 21-ны өдөр БДО Монгол болон Мандал Даатгал ХХК-ийн хооронд байгуулсан хөрөнгө ба бизнесийн үнэлгээний зөвлөх үйлчилгээний гэрээ |
| Зах зээлийн хандлага | Зах зээлийн өгөгдлөөс үүссэн үнэлгээний үржүүлэгч, өмнөх арилжааны харьцуулалтад үндэслэдэг үнэлгээний хандлага |
| ЗТБХБ эсвэл БХБ | Зам тээвэр, барилга, хот байгуулалт эсвэл Барилга Хот Байгуулалт |
| кв.м | Метр квадрат |
| Орлогын хандлага | Бизнесийн нэгжийн бий болгох ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэд үндэслэдэг үнэлгээний арга |
| Оруулсан капиталын үнэ цэнэ | Эх үүсвэрээс үл хамааран бизнест одоогоор оруулсан байгаа мөнгөний нийт дүн бөгөөд нийт хөрөнгөөс санхүүгийн бус өр төлбөрийг хассан үнэ цэнэ байдлаар илэрхийлэн тодорхойлогддог. |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| Өмчийн үнэ цэнэ | Бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэнэ юм. |
| Удирдлага | Мандал Даатгал ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлан, Эрсдэлийн менежер П.Оргодол |
| Мандал/Компани/ Үйлчлүүлэгч | Мандал Даатгал Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани; Улсын бүртгэлийн 5473489 регистрийн дугаартай,ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж |

| Товчилсон үг | Утга |
|---|---|
| Үнэлгээний баг | Хавсралт Е-д тодорхойлсон БДО Монголын мэргэжлийн үйлчилгээний баг |
| Үнэлгээний өдөр | 2017 оны 12-р сарын 31 |
| ҮОУС | Үнэлгээний олон улсын стандартын консулаас бэлтгэн толилуулдаг Үнэлгээний олон улсын стандарт |
| Хөрөнгийн хандлага | Бизнесийн нэгжийн тохируулсан цэвэр үнэ цэнэд суурилсан үнэлгээний хандлага |

СЗХ
2018 он 08 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01


Огноо: 2018/04/16

## Тайлангийн агуулга

1. Хураангуй үр дүн ........ 4
2. Үндсэн мэдээлэл ........ 6
2.1 Үйлчлүүлэгчийн мэдээлэл ........ 7
2.2 Гүйцэтгэгчийн мэдээлэл ........ 7
2.3 Үнэлгээний зорилго ........ 7
2.4 Үнэ цэнийн суурь ........ 7
2.5 Үндсэн ба тусгай таамаглалууд ........ 9
2.6 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал ........ 10
3. Үнэлгээний зүйлийн мэдээлэл ........ 11
3.1 Үнэлгээний зүйлийн бүтэц, бүрэлдэхүүн ........ 12
3.2 Биет үзлэгийн тэмдэглэл ........ 12
3.3 Үнэлгээний зүйлийн өмчлөх эрхийн мэдээлэл ........ 13
4. Үнэлгээний шинжилгээ ........ 14
4.1 Үнэлгээний хандлага ........ 15
4.1.1 Зах зээлийн хандлага ........ 15
4.1.2 Орлогын хандлага ........ 15
4.1.3 Өртгийн хандлага ........ 15
4.2 Индексжүүлэлт ........ 17
5. Үнэлгээний үр дүн ........ 18
5.1 Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээний үр дүн ........ 19
Хавсралт ........ 23
Хавсралт А. Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл ........ 24
Хавсралт Б. Үнэлгээний нийтлэг хандлагууд ........ 26
Хавсралт В. Үнэлгээний тооцоолол ........ 27
Хавсралт Г. Мэдээллийн эх сурвалж ........ 36
Хавсралт Д. Ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдэл ........ 37
Хавсралт Е. Үнэлгээний баг ........ 38
Хавсралт Ё. Үнэлгээчний тусгай зөвшөөрөл ........ 39

СЗХ
он 2018 сар 08. 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС
GOLOMT CAPITAL LLC

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
..... он .... сар .... өдөр

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЗХ
2018 08 28
БҮРТГЭВ
№ 01

## 1. Хураангуй үр дүн

*Эргэлтийн бус хөрөнгө*

- Хөрөнгө оруулалтын буюу ирээдүйд борлуулах зориулалтаар эзэмшиж байгаа орон сууц болон тээврийн хэрэгслийн үнэ цэнийг тооцохдоо бид зах зээлийн хандлагыг хэрэглэсэн.
- Харин бусад үндсэн хөрөнгө болон компанийн үндсэн үйл ажиллагаандаа ашиглаж байгаа программ хангамжийн үнэ цэнийг тооцохдоо тухайн хөрөнгийг олж бэлтгэх үеийн ам долларын төгрөгийн ханш ба үнэлгээний өдрийн ам доллартой харьцах төгрөгийн ханш хоорондын ялгаагаар индексжүүлэн тооцсон нөхөн оруулах өртгөөс ашигласан хугацаанд ногдох хуримтлагдсан элэгдэл, аливаа үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тооцоолсон.

*Эргэлтийн хөрөнгө*

- Компанийн 2017 оны 12 сарын 31-ний санхүүгийн тайланд авлага болон бараа материалаар тусгагдсан эргэлтийн хөрөнгийг тэдгээрийн насжилтын тайланд суурилан шинжилж, авлагын цуглуулагдахгүй байх магадлалаар жигнэсэн хорогдуулсан өртгөөр үнэлсэн.
- Бид өөрсдийн хийсэн шинжилгээ, компанийн удирдлагатай хийсэн ярилцлага, аудиторын тайланд суурилан мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө болон хөрөнгө оруулалтын дансны үнэ нь эдгээр хөрөнгийн бодит үнэ цэнэтэй тэнцүү байна гэж дүгнэсэн.
- Компанийн даатгалын хөрөнгө болон урьдчилж гарсан зардал зэрэг хөрөнгө нь ирээдүйн орлого болон актуар тооцоололд суурилан тооцоологдсон учраас үнэлгээний өдрийн бодит үнэ цэнийг илэрхийлнэ гэж дүгнэсэн.
- Үнэлгээний үр дүнг Хуудас 5-д нэгтгэн харуулав.

*Үнэлгээний үр дүнгийн талаарх дүгнэлт*

- Бидний гүйцэтгэсэн үнэлгээний шинжилгээгээр, Мандал даатгал ХХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-нээрх Борлуулах зориулалтаар эзэмшиж буй орон сууц нь ойролцоогоор 249,364 (хоёр зуун дөчин есөн сая гурван зуун жаран дөрвөн мянган төгрөг) мянган төгрөг, конторын болон үйл ажиллагаанд ашиглаж байгаа үндсэн хөрөнгө нь ойролцоогоор 275,888.7 (хоёр зуун далан таван сая найман зуун наян найман мянга долоон зуун төгрөг) мянган төгрөг, даатгалын үйл ажиллагаанд ашиглаж байгаа программ хангамжууд нь ойролцоогоор 96,600 (ерөн зургаан сая зургаан зуун мянган төгрөг) мянган төгрөгийн зах зээлийн үнэ цэнэтэй байх үндэслэлтэй гэж бид дүгнэж байна.
- Бидний хийсэн шинжилгээ, цуглуулсан нотолгоо, тооцоолол, аудит хийгдсэн санхүүгийн тайлангаас үзэхэд үнэлгээний тохируулгын дараах байдлаар Мандал даатгал ХХК-ийн эргэлтийн хөрөнгө нь 20,260,192.3 (хорин тэрбум хоёр зуун жаран сая нэг зуун ерөн хоёр мянга гурван зуун төгрөг) мянган төгрөг байна.
- Мандал даатгал ХХК-ийн 2017 оны 12 сарын 31-нээрх орлогод тооцоогүй хураамжийн нөөц нь 9,366,278.0 мянган төгрөг, нөхөн төлбөрийн нөөц сан нь 2,910,658.8 мянган төгрөг, даатгалын өглөг нь 2,055,456.1 мянган төгрөг, бусад санхүүгийн бус өр төлбөр 1,138,865.0 мянган төгрөг байх бөгөөд эдгээрийн нийлбэрээр 15,471,258.9 мянган төгрөгийн нийт өр төлбөртэй байна.
- Дахин үнэлэгдсэн нийт хөрөнгө ба нийт өр төлбөрийн зөрүүгээр тооцсон Мандал даатгал ХХК-ийн 2017 оны 12 сарын 31-нээр цэвэр өөрийн хөрөнгийн хэмжээ 5,411,256.1 мянган төгрөг байна.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК
287
Огноо: 2018/04/16
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
01

МАНДАЛ даатгал

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

СЗХ
он 2018 сар 08 өдөр 29
БҮРТГЭВ
№ 01

*Хөрөнгийн үнэлгээний үр дүнгийн нэгтгэл*

| мянган төгрөг | Үнэлгээний өдөөрх дансны үнэ | Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ | Ашигласан арга, хандлага |
|---|---|---|---|
| **А.Эргэлтийн бус хөрөнгө** | **582,921.3** | **622,352.7** | |
| Борлуулах зориулалтаар эзэмшиж байгаа орон сууц | 236,640.0 | 249,864.0 | Зах зээлийн хандлага |
| Үндсэн хөрөнгө | - | - | |
| Тээврийн хэрэгсэл | 78,166.5 | 71,733.0 | Зах зээлийн хандлага |
| Конторын тоног төхөөрөмж | 13,606.8 | 13,606.8 | Өртгийн хандлага |
| Тавилга эд хогшил | 103,797.4 | 103,797.4 | Өртгийн хандлага |
| Тооцоолох техник | 67,123.9 | 67,123.9 | Өртгийн хандлага |
| Бусад үндсэн хөрөнгө | 26,261.5 | 19,627.6 | Өртгийн хандлага |
| Биет бус хөрөнгө | - | - | |
| Программ хангамж | 57,325.3 | 96,600.0 | Өртгийн хандлага |
| **Б. Эргэлтийн хөрөнгө** | **20,889,229.2** | **20,260,192.3** | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн дүн | 1,805,206.3 | 1,805,206.3 | Нэрлэсэн үнэ |
| Даатгалын авлага | 4,402,449.9 | 3,854,655.9 | Хорогдуулсан өртөг |
| Бусад авлага /цэвэр дүнгээр/ | 401,174.1 | 341,859.5 | Хорогдуулсан өртөг |
| Бусад санхүүгийн бус хөрөнгийн дүн | 182,385.1 | 160,456.9 | Хорогдуулсан өртөг |
| Хөрөнгө оруулалт | 9,229,437.6 | 9,229,437.6 | Бодит үнэ цэнэ |
| Даатгалын хөрөнгө | 4,868,576.1 | 4,868,576.1 | Дансны үнээр |
| **В. Нийт хөрөнгө** | **21,472,150.5** | **20,882,545.0** | |
| **Г. Нийт өр төлбөр** | **-15,471,258.9** | **-15,471,258.9** | Дансны үнээр |
| **Д. Цэвэр өмч** | **6,000,891.3** | **5,411,286.1** | |

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC

288
Огноо: 2018/04/16

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
01
..... он .... сар .... өдөр

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

## 2. Үндсэн мэдээлэл

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

### 2.1 Үйлчлүүлэгчийн мэдээлэл

- Монгол улс, Улаанбаатар 14230, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол, Нарны зам 87, НСКБ Билдинг-т байрлах Мандал Даатгал ХХК нь энэ үнэлгээний ажлын захиалагч тал бөгөөд үнэлж буй хөрөнгийн хууль ёсны өмчлөгч болно.
- Мандал даатгал ХХК нь Улаанбаатар хот болон Өмнөговь аймгийн Цогтцэций сум, Дархан-Уул аймгийн Дархан сум, Орхон аймгийн Эрдэнэт хотод салбар төлөөлөгчийн газартай.

### 2.2 Гүйцэтгэгчийн мэдээлэл

- Үнэлгээчин нь компанийн бизнесийн зах зээлийн үнэ цэнийг үнэлгээний өдрийн байдлаар, хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргах зориулалтаар тодорхойлж, үнэлгээний тайланг үйлчлүүлэгчид хүргүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.
- БДО Монгол нь захиалагчийн хүсэлтээр Мандал-ын ердийн даатгалын үйл ажиллагаар хамарсан бизнесийн үнэлгээг гүйцэтгэгч хараат бус мэргэжлийн байгууллага болно. Бид өөрийн компанид ажилладаг тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн үнэлгээчид болон үнэлгээний мэргэжилтнүүдэд суурилан хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэхээс гадна үнэлгээний бус үйлчлүүлэгчдэд аудитын болон бусад зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг, БДО олон улсын сүлжээний Монгол улс дахь гишүүн компани юм.
- Үнэлгээний багийг БДО Монгол-ын үнэлгээ хариуцсан партнер ноён Г.Баянмөнх удирдан гүйцэтгэсэн. Үнэлгээний багийн гишүүдийн талаарх мэдээллийг Хавсралт Е-ээс харна уу. Энэ үнэлгээний ажилд тооцооллын болон шинжилгээний аливаа нарийн түвэгтэй нөхцөл байдал үүсэх магадлал бага гэж таамагласан учраас үнэлгээний ажилд аливаа хөндлөнгийн тусламж аваагүй.
- Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу БДО Монгол нь энэ үнэлгээний тайланд хариуцлага хүлээх бөгөөд мэргэжлийн хариуцлагаа ХААН даатгал ХХК-иар даатгуулсан. Мөн түүнчлэн манай мэргэшсэн үнэлгээчид нь өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа ХААН даатгал ХХК-иар даатгуулсан болно. Даатгалын гэрчилгээний хуулбарыг Хавсралт Ё-ээс харна уу.
- БДО Монгол болон үнэлгээнд оролцсон үнэлгээчид, мөн үнэлгээний туслах ажилтнууд нь Мандалд энэхүү үнэлгээний үйлчилгээнээс өөр үйлчилгээ үзүүлдэггүй, хувьцаа эзэмшдэггүй, үнэлгээний үр дүнд нөлөөлөх аливаа ашиг сонирхлын зөрчилгүй болно.

### 2.3 Үнэлгээний зорилго

- БДО Монгол болон Мандал Даатгал компанийн хооронд 2018 оны 2-р сарын 21-нд байгуулсан үнэлгээний үйлчилгээ үзүүлэх гэрээт ажлын захидалд заасан дагуу бид уг компанийн ердийн даатгалын үйл ажиллагаар хамарсан бизнесийн 100 хувийн хувь оролцоог үнэлж, бизнесийн үнэлгээний тайлан бэлтгэхээр сонгогдсон.
- Үйлчлүүлэгч нь энэ үнэлгээний тайланг зөвхөн хөрөнгийн зах зээлд анхдагч хувьцаа гаргах дотоод зорилгоор ашиглана. Бидний шинжилгээний үр дүн нь хөрөнгө оруулалтын аливаа шийдвэр гаргах үндэслэл болохгүй.
- Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн бүртгэлийн дүрмийн дагуу бид өөрсдийн бэлтгэсэн үнэлгээний тайланд тусгагдсан үнэ цэнийн талаарх дүгнэлтийг Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) болон бусад эрх бүхий зохицуулагч байгууллагын шаардлагаар хамгаалах эрхтэй.

### 2.4 Үнэ цэнийн суурь

- Бид энэхүү тайланг бэлтгэхдээ Үнэлгээний Олон Улсын Консул (УОУК)-ын бэлтгэн толилуулдаг Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС)-ыг даган мөрдсөн. Энэхүү үнэлгээний хүрээнд дараах үнэ цэнийн суурийдыг ашигласан. Үүнд:
  - Зах зээлийн хандлагын аргад ашигласан үнэ цэнийн суурь нь Зах зээлийн үнэ цэнэ,
  - Орлогын хандлагад ашигласан үнэ цэнийн суурь нь Зах зээлийн түрээс төлбөр болно.
- Зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь ҮОУС 104-ийн 30.1-р мөрөнд тодорхойлсны дагуу нь "*зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр*

СЗХ
төмп ...сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
Хүүдас 7 | Мандал Даатгал ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайлан
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
01

МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT ... LLC
ГОЛОМТ КАПИТАЛ ҮЦК ХХК

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

*оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж үг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн*"-г хэлнэ. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтыг дараах үзэл баримтлалын дагуу ашиглана:

- **"Тооцоолсон дүн"** - харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийн төлөө төлөх мөнгөөр илэрхийлэгдэх үнэ юм. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу зах зээлийн үнэ цэнэ нь тухайн зах зээлээс ул үндэслэлтэйгээр олж авч болох, үнэлгээний өдрийн байдлаар хамгийн их магадлалтай үнэ байдаг. Энэ нь борлуулагчийн ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнэ ба худалдан авагчийн ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн давуу талтай үнэ байна. Харин өрөнхий санхүүжилт, борлуулалт ба буцаан түрээслэх тохиролцоо, борлуулалттай холбоотойгоор хэн нэгнээс олгосон тусгай төлбөр, хөнгөлөлт гэх мэт тусгай нөхцөл буюу заалтаар, эсвэл зөвхөн тодорхой нэг өмчлөгч буюу худалдан авагчид хамаарах үнэ цэнийн ямар нэг элементээр нэмэгдүүлэх буюу бууруулах байдлаар тооцоолсон үнийг энэхүү тооцоололд тусгайлан хамруулдаггүй.

- **"Хөрөнгө, болон өр төлбөрийг арилжвал зохино"** - гэдэг нь хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнэ бол урьдчилан тодорхойлсон дүн эсвэл бодит борлуулалтын үнэ биш, харин тооцоолсон дүн байх нөхцөлийг илэрхийлнэ. Энэ нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын бүх элементүүдийг үнэлгээний өдрөөр хангах уг ажил гүйлгээний үнэ байдаг.

- **"Үнэлгээний өдрөөр"** - гэдэг нь тухайн үнэ цэнэ уг өдрийн байдлаар гэх мэт тусгай цаг хугацаатай байхыг шаарддаг. Зах зээл ба зах зээлийн нөхцөл байдал нь өөрчлөгдөж болох учраас уг тооцоолсон үнэ цэнэ нь өөр нэг хугацаанд буруу эсвэл тохиромжгүй байж болох юм. Үнэлгээний дүн нь өөр бусад дурын өдрийн биш, харин үнэлгээний тэр өдрийн байдлаар тооцсон зах зээлийн төлөв байдал ба нөхцөлүүдийг тусган илэрхийлдэг.

- **"Бэлэн байгаа худалдан авагч"** - гэдэг нь худалдан авах сэдэл санаачлагатай боловч тийм албан үүрэг хүлээгээгүй талыг илэрхийлнэ. Уг худалдан авагч нь ямар ч хамаагүй үнээр худалдан авахаар хэт хүссэн эсвэл худалдан авна гэж урьдчилан тодорхойлогдсон этгээдийн аль нь ч биш юм. Мөн худалдан авагч нь оршин байгаа гэдгийг батлан харуулж эсвэл урьдчилан баримжаалж чадахгүй тийм төсөөллийг буюу таамаглалын зах зээлтэй холбоотойгоор биш, харин одоогийн зах зээлийн бодит байдал болон одоогийн зах зээлийн хүлээлтийн дагуу худалдан авах этгээд байдаг. Уг төсөөлсөн худалдан авагч нь зах зээлээр шаардахаас илүү өндөр үнийг төлөхгүй. Одоогийн эзэн нь "тухайн зах зээл"-ийг бүрдүүлэгчдийн нэг болдог.

- **"Бэлэн байгаа борлуулагч"** - нь ямар ч хамаагүй үнээр борлуулахаар хэт хүссэн буюу албадлагын дагуу борлуулагч эсвэл одоогийн зах зээлийг ул үндэслэлтэйгээр харгалзан үзэхгүйгээр үнэ тогтоож буй этгээдийн аль нь ч биш юм. Бэлэн байгаа борлуулагч нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа нээлттэй зах зээлээс олж авах хамгийн сайн үнэ бүхий зах зээлийн нөхцөлөөр хөрөнгийг борлуулах сэдэл санаачлагатай байдаг, гэхдээ уг сайн үнэ нь хэд ч байж болох юм. Бэлэн байгаа борлуулагч бол таамагласан эзэн бөгөөд жинхэнэ бодит эзний үнэн бодит нөхцөл байдал нь энэхүү хэлэлцүүлгийн хэсэг болохгүй.

- **"Хамааралгүй талуудын ажил гүйлгээ"** нь жишээлбэл, толгой ба охин компаниуд эсвэл газрын эзэн ба хөлслөгч гэх мэт үнийг зах зээлийн шинж, агуулгагүй болгох буюу нэмэгдүүлж болох тийм тухайлсан буюу тусгай харилцан хамааралтай биш байх талуудын хоорондох ажил гүйлгээ юм. Зах зээлийн үнэ цэнээр тооцогдох ажил гүйлгээ нь тус бүрдээ хараат бусаар үйл ажиллагаа явуулж буй холбоогүй талуудын хооронд хийгдэнэ гэж урьдчилан таамагладаг.

- **"Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа"** - гэдэг нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнээр борлуулахад нэлээ үзүүлэхийн тулд тухайн хөрөнгийг хамгийн тохиромжтой арга замаар зах зээлд гарган танилцуулахыг хэлнэ. Борлуулагчийн хандан нэвтрэх зах зээлээс хамгийн сайн үнийг олж авахад борлуулалтын арга нь хамгийн тохиромжтой гэж үздэг. Зах зээлд гарган таниулах хугацаа нь тодорхой тогтсон байдаггүй бөгөөд хөрөнгийн төрөл, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран өөр өөр байдаг. Цорын ганц шалгуур нь зах зээлд оролцогчдын зохих тоон хэсгийн анхааралд уг хөрөнгийг хандуулах боломж олгох хангалттай хугацаатай байх ёстой. Зах зээлд гарган таниулах хугацаа нь үнэлгээний өдрөөс өмнө байна.

Хавсралт 8.1 Мандал Даатгал ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайлан

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он 2018 сар 08 өдөр 29
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

- **"Талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй"** - гэдэг нь тухайн хөрөнгийн төрөл ба шинж чанар, түүний бодит болон боломжит ашиглалт, зах зээлийн төлөв байдлын талаар уг бэлэн байгаа худалдан авагч болон бэлэн байгаа борлуулагчийн аль алинд үнэлгээний өдрийн байдлаар ул үндэслэлтэйгээр мэдээлсэн байна гэсэн урьдчилсан нөхцөлийг илэрхийлнэ. Талууд тус бүр нь уг ажил гүйлгээ дэх өөрийн хэтийн байр суурины хувьд хамгийн таатамжтай байх үнийг олохын тулд тухайн мэдлэгийг бодол төлөвлөгөөтэйгээр ашиглана гэж урьдчилан төсөөлдөг. Хожмын нэгэн өдрийн урьдчилан харах боломжгүй үр ашгийг биш, харин тухайн үнэлгээний өдрийн байдлаар зах зээлийн байдлыг лавлагаа болгосноор "бодол төлөвлөгөө"-г үнэлдэг. Жишээлбэл, борлуулагч нь зах зээлийн үнэ буурсан үед хөрөнгийг зах зээлийн өмнөх үнээс бага үнээр борлуулах нь заавал бодол төлөвлөгөөгүй байна гэсэн үг биш юм. Ийм тохиолдолд энэ нь үнэ өөрчлөгдсөн зах зээл дэх өөр арилжааны хувьд зөв байх бөгөөд бодол төлөвлөгөөтэй худалдан авагч буюу борлуулагч нь тухайн үед бэлэн боломжтой байгаа зах зээлийн хамгийн сайн мэдээллийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.
- **"Албан шахалт шаардлагагүй"** - гэдэг нь тал тус бүр уг ажил гүйлгээг хийх сэдэл санаачлагатай боловч түүнийг гүйцэтгүүлэхээр аль ч талыг хүчлээгүй буюу хэт албадан шахаагүй байхыг илэрхийлнэ.

- Зах зээлийн түрээсийн төлбөр гэдэг нь ҮОУС 104-ийн 40.1-т тодорхойлсны дагуу *"зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа түрээслүүлэгч ба түрээслэгчийн хооронд харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр зохих түрээсийн нөхцөлийн дагуу ул хөдлөх хөрөнгийн хувь оролцоог түрээслэвэл зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн"*-г хэлнэ.

- Үнэлгээний тайланд ашигласан орц мэдээлэл болон эцсийн үр дүнг үнэлгээний тайлангийн турш монгол төгрөгөөр, мянганы оронгийн нарийвчлалтайгаар ашигласан. Иймд үнэлгээний валют нь монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг болно.

Хүснэгт 9. Мандал Даатгал ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайлан

## 2.5 Үндсэн ба тусгай таамаглалууд

- Бид дараах таамаглал ба төсөөллийг дэвшүүлснээр хөрөнгийн тооцоолсон зах зээлийн үнэ цэнийг тодорхойлсон. Үүнд:
  - БДО Монгол-д үйлчлүүлэгчийн өгсөн мэдээллийг бид үнэн зөв бөгөөд иж бүрэн гэж таамагласан.
  - Бид үнэлгээг хойшлуулсан нөхцөлтэй гэрээ, хамтран ажиллах гэрээ эсвэл түүнтэй адилтгах өмчийн оролцооны үнэ цэнэд нөлөөлөх үйлчилгээний гэрээгээр бус, хөгжүүлэлтийн зориулалтаар эзэмшиж буй ул хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ, худалдах, худалдан авах гэрээ болон нээлттэй зах зээлийн мэдээлэлд үндэслэн өмчийг дангаар нь борлуулна гэсэн төсөөлөлд суурилан гүйцэтгэсэн.
  - Бид үнэлгэдэж буй хөрөнгүүдийг цаашдаа бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэгдсээр байх ба хөрөнгийн одоогийн ашиглалт нь өөрчлөгдөхгүй гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, хөрөнгөд тохиромжтой засвар үйлчилгээ болон хамгаалалтыг хийж одоогийн байдал, зорилгоор ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ гэж үзсэн.
  - Аливаа засмал зам барих болон хот төлөвлөлт, бусад төсөл төлөвлөгөө нь өмч хөрөнгөнд сөргөөр нөлөөлөхгүй гэж төсөөлсөн бөгөөд газар дээрх үзлэг, ярилцлага болон аливаа албан бичгийн хариуд ирсэн зүйлсээс үнэлгээнд сөргөөр нөлөөлөх зүйлс ажиглагдаагүй болно.
  - Өмч нь өнгөрсөн хугацаанд ямарваа нэгэн газрын бохирдолд өртөөгүй, ирээдүйд ч бохирдолд өртөхгүй гэсэн төсөөлөлд суурилсан.
  - Бид ямар нэгэн муугаар төсөөлөх юм уу тийм болгож харагдуулахаар судалгаа тооцоолол хийгээгүй бөгөөд иймхүү боломжуудыг үнэлээгүй болно.
  - Бид өөдрөг төсөөлөл болон зах зээлд байж болох хамгийн сайн ашиглалтын төсөөллөөр үнэлгээнд хандаж дүгнэлтээ гаргаснаар хууль эрхзүйн ямар нэгэн хариуцлага хүлээхгүй гэж төсөөлсөн болно.

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЗХ
он 2019 сар 08 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

- Хамгийн сайн ашиглалт гэдэг нь тэр хөрөнгийн хүчин чадал ашиглалтыг дээд хэмжээнд байлгах биет байдлаараа боломжтой, хууль ёсоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн хувьд биелэгдэх ашиглалтыг хэлнэ. Үйлдвэрийн барилгын хувьд хуулиар зөвшөөрөгдөх хувилбар нь үйлдвэрлэлийн дээд хүчин чадлыг аливаа доголдол, сул зогсолтгүйгээр бүрэн ашиглагдаж байгаа байдлыг хамгийн сайн ашиглалт гэж үзсэн.
- Үнэлгдэж байгаа өмч хөрөнгө нь хариуцлагатай эзэмшигч, чадамгай удирдлагад харьялагдаж байгаа бөгөөд аливаа шүүхийн зарга маргаанд өртөөгүй гэж үзсэн.
- Үнэлгээнд ашигласан ирээдүйн талаарх таамаглал нь өнөөгийн зах зээлийн ирээдүйн орлого ба зардалтай холбоотой гаргасан үнэлгээчдийн хамгийн сайн тооцоолол боловч үнэлгээчид ирээдүйг урьдчилан харж чадахгүй учраас зөвхөн таамаглал гэж ойлговол зохино.
- Бид хөрөнгийн эзэмшил, ашиглалтын зарим байдал, хөрөнгийн тодорхойлолт, байршил болон план зургуудын талаар хийсэн албан бичгийг үйлчлүүлэгчээс хүлээн авсан. Энэхүү тайланд орсон хэмжээ, солбицол болон талбай нь бидэнд өгсөн баримт бичгүүдийн мэдээлэлд үндэслэн хийгдсэн болно.
- Даатгалын болон бусад авлагын дансны үнийг авлагын насжилтын тайланд суурилан тооцоолсон цуглуулагдахгүй байж болох магадлалаар жигнэсэн хорогдуулсан өртгөөр хэмжих нь зохистой гэж таамагласан.
- Компанийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хангамжийн шинжтэй зүйлс нь ашиглалтад тавьж олгогдох үедээ зардал шингэсэн байна гэсэн таамаглал дэвшүүлсэн.
- Борлуулах зориулалтаар эзэмшиж байгаа орон сууцны барилга нь цаашид түрээсийн орлого оруулахгүй учраас зөвхөн зах зээлд арилжаалагдаж болох үнэ цэнээр хэмжигдэнэ гэсэн таамаглал дэвшүүлсэн.
- Тээврийн хэрэгслүүд болон конторын зориулалттай тавилга эд хогшил, тооцоолох техник, бусад үндсэн хөрөнгө нь ашиглалтаас хасагдах хүртлээ компанийн үндсэн үйл ажиллагаанд ашиглагдах боловч эдийн засгийн ашиглалтын дээд хугацаа нь 10 жилээс хэтрэхгүй гэж төсөөлсөн.
- Одоо ашиглаж байгаа программ хангамжийг программ хангамж хөгжүүлэгч талаас бүрэн шинэчилж өөрчлөхөөс бусад тохиолдолд жил бүрийн засвар үйлчилгээний хураамжийг төлсний үндсэн дээр компанид үргэлжлүүлэн ашигласаар байх боловч үндсэн суурилуулалтын өртгийг хорогдуулах жил нь 5 жилээс хэтрэхгүй гэж таамагласан.

### 2.6 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал

- Үнэлгээний тайлан нь Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд Монгол хэлнээс өөр хэлээр энэ тайланг орчуулах эрх зөвхөн БДО Монгол-д байна. Бид энэхүү үнэлгээний тайланг хэвлэмэл хэлбэрээр болон цахим хэлбэрээр хүргүүлнэ. Хэвлэмэл болон цахим тайлангууд аль аль нь адил хүчин төгөлдөр болно.
- Үнэлгээний тайлангийн 2.3-т дурдсанчлан, үнэлгээний тайланг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь хөрөнгийн зах зээл дээр анхдагч үнийн санал гаргахаас өөр зорилгоор хувилж, эсвэл иш татаж ашиглахыг хориглоно. Энэхүү тайланг зөвхөн Мандал-ын дотоодын албан хэрэгцээнд ашиглана.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС
BDO
293
Огноо: 2018/04/16

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
01

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

СЗХ
2018 08 29
БҮРТГЭВ
№ 01

## 3. Үнэлгээний зүйлийн мэдээлэл



МАНДАЛ ДААТГАЛ ХХК

МОНГОЛ УЛС
BDO



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

### 3.1 Үнэлгээний зүйлийн бүтэц, бүрэлдэхүүн

- Энэ тайлангийн 2.3-р хэсэгт тодорхойлсны дагуу бид үйлчлүүлэгчийн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийг хамарсан хөрөнгийн үнэлгээ хийж гүйцэтгэх үүрэг хүлээсэн. Энэхүү хөрөнгийн үнэлгээнээс гадна тус компанийн бизнесийн үнэлгээг хийж, энэ тайлангаас тусад нь Бизнесийн үнэлгээний тайланг гаргасан. Бизнесийн үнэлгээний үр дүн, тэдгээртэй холбогдох тооцоолол энэ тайланд тусгагдаагүй бөгөөд тусдаа тайлан байдлаар хүргэгдэнэ. Энэ тайланд зөвхөн үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн үнэ цэнийг ҮОУС-ын дагуу тодорхойлсон.

### 3.2 Биет үзлэгийн тэмдэглэл

- Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт байрлах Мандал даатгал ХХК-ийн өмчлөлийн борлуулах зориулалтаар эзэмшиж байгаа орон сууцны зориулалттай нэг үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслийг багтаасан хөдлөх хөрөнгийн бичиг баримттай танилцаж, дэлгэрэнгүй мэдээллийг шинжилсэн. Хөрөнгийн биет үзлэгийн туршид Мандал даатгал ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Жавхлан, эрсдэлийн менежер П.Оргодол нар хамт байлцаж, мэдээллээр хангасан.

- Биет үзлэгийн явцад үйлчлүүлэгчээс бидэнд ирүүлсэн хөрөнгийн жагсаалт, өнгөрсөн жилийн аудитын тайланд үндэслэн дараах үл хөдлөх ба хөдлөх хөрөнгүүдэд үзлэг хийсэн. Үүнд:

  - Орон сууцны байр-ХУД, 11-р хороо, Маршал таун хотхон, 102-р байрны 17 тоотод байрлах 000107249 дугаартай гэрчилгээтэй, Ү-2206014229 тоот улсын бүртгэлийн дугаартай, 116 кв.м талбайтай 4 өрөө байр. 2013 оны 6 сарын 10-нд Мандал даатгал ХХК-д олгогдсон үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхийн гэрчилгээтэй.

  - Тээврийн хэрэгсэл:
    - 15-21 УНҮ улсын дугаартай, 2014 оны 1 сарын 23-нд ашиглалтад орсон PRIUS маркийн суудлын автомашин
    - 76-86 УНО улсын дугаартай, 2011 оны 9 сарын 5-нд ашиглалтад орсон PRIUS 20 маркийн суудлын автомашин
    - 43-02 УНН улсын дугаартай, 2011 оны 7 сарын 1нд ашиглалтад орсон Lexus маркийн суудлын автомашин
    - УБ0563 (цагаан өнгийн), УБ0395 (хар өнгийн), УБ0334 (улаан өнгийн) улсын дугаартай, 2014 онд үйлдвэрлэгдэж, 2017 оны 6 сарын 15-нд ашиглалтад орсон Yamaha маркийн Tricity загварын 3 дугуйт мотоцикл 3 ширхэг
    - Конторын зориулалттай тооцоолох техник, тавилга эд хогшил

- Үзлэгийн явцад орон сууцны барилгад нэвтэрч биечлэн үзэж, хэмжилт хийх боломж олгоогүй учраас үл хөдлөх хөрөнгийн бичиг баримтад суурилан үнэлгээ хийсэн.

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



СЭХ БҮРТГЭВ он 2018 сар 08 өдөр 29 № 01

МОНГОЛ УЛС BDO GOLOMT CAPITAL LLC

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

### 3.3 Үнэлгээний зүйлийн өмчлөх эрхийн мэдээлэл

- Мандал-ын хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгөөр эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгүүд

| Объектын хаяг, нэр | ҮХХ-ийн өмчлөгчийн нэр, Регистрийн дугаар | ҮХХ-ийн гэрчилгээний дугаар | Эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн огноо, дугаар | Талбайн хэмжээ (холбогдох нэгж) |
|---|---|---|---|---|
| ХУД, 11-р хороо, Маршал таун хотхон, 102-р байрны 17 тоот | Мандал даатгал ХХК Регистрийн дугаар: 547389 | 000107249 | Ү-2206014229 2013/06/10 | 116 кв.м |

СЗХ
он сар өдөр
2018.08.29
БҮРТГЭВ
№ 01



МАНДАЛ ДААТГАЛ ХХК

МОНГОЛ УЛС
BDO
GOLOMT CAPITAL LLC



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
....... он .... сар .... өдөр

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЭХ
2018 .08 сар 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 4. Үнэлгээний шинжилгээ

МАНДАЛ ДААТГАЛ ХХК



МОНГОЛ УЛС
BDO
297
Огноо: 2018/04/16

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
...... он .... сар .... өдөр

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЭХ
он сар өдөр
2018.08.29
БҮРТГЭВ
№ 01

## 4.1 Үнэлгээний хандлага

- Компанийн эзэмшиж буй хөрөнгүүдийг үнэлэхдээ бид үнэлгээний үндсэн гурван хандлага болох зах зээлийн хандлага, орлогын хандлагыг авч үзсэн. Зах зээлийн хандлагаар тооцсон үнэлгээнд бид шууд харьцуулалтын аргыг сонгосон бол орлогын хандлагын хувьд Орлого капиталжуулалтын арга тохиромжтой гэж үзсэн.
- Зах зээлийн хандлага, орлогын хандлагаар тооцсон үнэ цэнийн тооцооллоос үнэлгээчин мэргэжлийн шүүмж (шийдэл) ашиглан үнэлгээний зорилгод хамгийн нийцтэй хандлагыг сонгон эцсийн тооцоолсон үнэ цэнийг тогтоосон болно.
- Тээврийн хэрэгслийг худалдан авах өдрийн ам доллар ба төгрөгийн ханшаар индексжүүлэн тооцоолж шинжилсэн. Тооцоолсон элэгдэл тооцсон орлуулах өртгийг хуучин тээврийн хэрэгслийн зах зээлийн үнэ цэнэтэй харьцуулж шинжилсэн.
- Бусад хөдлөх хөрөнгийн үнэлгээг худалдан авалтын үеийн ам доллар төгрөгийн ханшийг үнэлгээний өдөр хүртэл индексжүүлэн тооцож, үнэлгээний өдрийн дансны үнэтэй харьцуулж шинжилсэн.

### 4.1.1 Зах зээлийн хандлага

- Зах зээлийн хандлага нь тухайн хөрөнгийг үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа ижил буюу жишиж болох (өөрөөр хэлбэл, төсөөтэй) хөрөнгүүдтэй харьцуулснаар үнэ цэнийн үзүүлэлтийг тодорхойлдог.
- Бид дараах нөхцөл хангагдсан гэж үзэж үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн үнэлгээг зах зээлийн хандлагаар тооцсон. Үүнд:
  - Тухайн үнэ цэнийн суурийн дагуу харгалзан үзэхэд тохиромжтой тийм ажил гүйлгээгээр уг үнэлж буй хөрөнгийг саяхан борлуулсан,
  - Үнэлж буй хөрөнгийг эсвэл түүнтэй ихээхэн ижил төсөөтэй хөрөнгийг нийтэд идэвхитэй арилжаалдаг,
  - Ихээхэн ижил төсөөтэй хөрөнгийн хувьд байнга ба/буюу сүүлийн үед гарсан ажиглаж болох ажил гүйлгээнүүд байгаа.

*Жишиж ажил гүйлгээний арга*

- Зэрэгцүүлэх ажил гүйлгээний арга гэж бас нэрлэгдэх жиших ажил гүйлгээний арга нь үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахын тулд үнэлж буй хөрөнгөтэй ижил буюу төсөөтэй хөрөнгөтэй холбоотойгоор гарсан ажил гүйлгээнүүдийн талаарх мэдээллийг ашигладаг.
- Хэрэв зах зээл дээр үнэлж буй хөрөнгөтэй холбоотой цөөн ажил гүйлгээ гарсан бол борлуулахаар жагсаасан буюу санал болгосон ижил эсвэл төсөөтэй хөрөнгийн үнийг харгалзан үзнэ. Гэхдээ энэхүү мэдээллийн хамааралтай байдлыг оновчтой тогтоож, хянамгай шинжлэн баримтжуулсан байх шаардлагатай. Үүнийг зарим үед жиших жагсаалтын арга гэж нэрлэдэг бөгөөд үнэ цэнийн ганц хэмжүүр үзүүлэлт байдлаар ашилах нь зохисгүй, харин бусад аргуудтай хамтад нь авч үзвэл тохиромжтой байдаг. Худалдан авах эсвэл борлуулах жагсаалт буюу саналуудыг харгалзан үзэх үедээ уг жагсаалт/саналын үнэд өгөх жингийн хувьд тухайн үнэд агуулагдах хариуцлагын түвшин ба энэхүү жагсаалт/саналын үнэ нь зах зээлд хир удаан байх эсэхийг харгалзан үзвэл зохино. Тухайлбал, хөрөнгийг уг заасан үнээр худалдах буюу борлуулах үл цуцлагдах хариуцлагыг хүлээсэн саналын хувьд ийм хариуцлагыг хүлээхгүйгээр гаргасан жишиг үнээс илүү их жин өгнө.

### 4.1.2 Орлогын хандлага

- Орлогын хандлага нь ирээдүйн мөнгөн гүйлгээг өнөөгийн үнэ цэнэд хөрвүүлснээр үнэ цэнийн нэг л үзүүлэлтийг тооцоолдог. Орлогын хандлагын дагуу тухайн хөрөнгийн бий болгох орлогын үнэ цэнэ, мөнгөн гүйлгээ эсвэл өртгийн хэмнэлтийг харгалзсанаар хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлдог.
- Тус компанийн өмчлөлд байгаа ганц үл хөдлөх хөрөнгө нь түрээсийн болон өөр хэлбэрээр ямар нэгэн орлого авчрахгүй байгааг бид ажигласан. Иймд үл хөдлөх хөрөнгийн үнэлгээнд орлогын хандлага хэрэглэх шаардлагагүй гэж үзсэн.

### 4.1.3 Өртгийн хандлага

- Зохисгүй хугацаа, тохиромжтой бус байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлс нь хамааралтай биш л бол худалдан авагч нь худалдан авсан эсвэл барьж

МАНДАЛ ДААТГАЛ ХХК
Хуудас 15 / Мандал Даатгал ХХК-ийн хөрөнгийн үнэлгээний тайлан
МАНДАЛ даатгал
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ 01
... он ... сар ... өдөр

BDO
GOLONT CAPITAL LLC

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

байгуулсан эсэхээс үл хамааран ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг олж бэлтгэх өртгөөс илүү дүнг тухайн хөрөнгийн хувьд төлөхгүй гэсэн эдийн засгийн зарчмыг баримтлан өртгийн хандлагаар үнэ цэнэ тооцдог. Энэхүү хандлага нь хөрөнгийн одоогийн орлуулалт болон дахин үйлдвэрлэлтийн өртгийг тооцоолох ба биет чанаргүйдэл болон хоцрогдлын холбогдох бусад бүх хэлбэрүүдийн хувьд хасагдуулга хийснээр үнэ цэнийн үзүүлэлтийг гаргадаг.

- Бид дараах нөхцөлүүд хангагдсан гэж үзэж өртгийн хандлагын хэрэглээнд мэдэгдэхүйц ач холбогдол өгсөн. Үүнд:
  - оролцогчид нь зохицуулалтын буюу хуулийн саад хязгаарлалтгүйгээр үнэлж буй хөрөнгөтэй бараг ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг дахин бий болгох боломжтой байх бөгөөд үнэлж буй хөрөнгийг нэн даруй ашиглах боломжит байдлын төлөө мэдэгдэхүйц урамшуулал төлөхгүйгээр тухайн хөрөнгийг маш хурдан дахин бий болгох боломжтой,
  - хөрөнгө нь орлогыг шууд бий болгодоггүй бөгөөд тухайн хөрөнгийн өвөрмөц онцлог нь орлогын хандлага эсвэл зах зээлийн хандлагыг ашиглах ямар ч боломжгүй болгодог байх, ба/буюу
  - хэрэглэж буй үнэ цэнийн суурь нь орлуулалтын үнэ цэнэ гэх мэт орлуулалтын өртөгт үндсэндээ суурилсан байх,

*Орлуулалтын өртгийн арга*

- Ерөнхийдөө орлуулалтын өртөг нь хөрөнгийг яг ижил биет зүйлээр биш, харин тухайн хөрөнгийн хэрэгцээт чанарыг орлуулан бий болгох боломжид үндэслэн оролцогчийн төлөх үнийг тодорхойлоход хамаарах өртөг юм.
- Биет элэгдэл болон хоцрогдлын холбогдох бусад бүх хэлбэрүүдийн хувьд орлуулалтын өртгийг ихэвчлэн тохируулдаг. Ийм тохируулгуудын дараа үүнийг элэгдэл тооцсон орлуулалтын өртөг гэж нэрлэдэг.
- Бид орлуулалтын өртгийн аргыг ашиглахдаа дараах алхмуудыг баримтална. Үүнд:
  - адилтгах хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг бий болгох эсвэл олж авахын тулд ердийн оролцогчийн гаргах бүр өртөг зардлыг тооцоолох,
  - үнэлж буй хөрөнгөтэй холбоотой биет, үүрэг ажиллагааны болон гадаад хоцрогдолд хамаарах аливаа элэгдэл байгаа эсэхийг тодорхойлох, ба
  - үнэлж буй хөрөнгийн хувьд үнэ цэнийг гаргахын тулд нийт өртгөөс нийт элэгдлийг хасах.

*Үл хөдлөх хөрөнгө*

- Бие даасан үл хөдлөх хөрөнгийг өртгийн аргаар үнэлэхдээ ЗТБХБ-ын сайдын 2016 оны 203 тоот тушаалын хавсралтаас батлагдсан Барилгын нэгж жишиг үнэлгээ тооцох арга зүйн баримт бичигт үндэслэн тооцдог. Үйлчлүүлэгчийн үл хөдлөх хөрөнгө нь бие даасан барилга биш учраас энэ аргазүйг ашиглах нь тохиромжгүй гэж үзсэн.

*Тээврийн хэрэгсэл, компьютер, тавилга эд хогшил*

- Тээврийн хэрэгсэл ангилалд нийт 3 автомашин, 3 мотоциклоос бүрдсэн тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байсныг үнэлгээнд хамруулсан. Тээврийн хэрэгслийг эхлээд Индексжүүлсэн өртгийн аргаар үнэлж, гарсан үр дүнг ижил төрлийн шинэ тээврийн хэрэгслийн зах зээлийн үнэлгээнээс элэгдүүлэх болон хуучралтын өртгийг хасаж гарсан дүнг Индексжүүлсэн өртгийн үр дүнтэй зэрэгцүүлэн шинжилсэн.

*Элэгдэл ба үнэ цэнийн бууралтад нөлөөлөх хүчин зүйлс*

- Эцсийн үнэлгээг тодорхойлсны дараа үнэлэгдсэн хөрөнгөд үнэ цэнийн бууралт байгаа эсэхийг Мөнгө бий болгогч нэгжийнх нь хувьд шинжилсэн.

*Цаашид ашиглах хугацаа*

- Хөрөнгийн анги бүрийн хувьд эдийн засгийн ашиглалтын хугацааг тогтоохдоо дараах хугацааг ашигласан.

| Хөрөнгийн анги | Эдийн засгийн ашиглалтын хугацаа |
|---|---|
| ХОЗҮХХ-Орон сууц | 40 жил |
| Тээврийн хэрэгсэл | |
| Суудлын автомашин | 10 жил |
| Мотоцикл | 10 жил |
| Тавилга, эд хогшил | 3-10 жил |

СЗХ он сар өдөр 2019 ...ГТ 1Ф В № 01
МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛ УЛС BDO
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ ... он ... сар ... өдөр 01
299
Огноо: 2018/04/16

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

| | |
|---|---|
| Тооцоолох техник | 3-5 жил |

*Биет бус хөрөнгө*

- Компанийн биет бус хөрөнгө нь дараах 3 төрлийн программ хангамжаас бүрдэж байна. Бид эдгээр программ хангамжийг валютын ханшийн өөрчлөлтийн индексээр индексжүүлэн тооцоолсон нөхөн орлуулах өртгөөс 5 жилийн ашиглалтын хугацаагаар хорогдуулж, хорогдол тооцсон тооцоолсон зах зээлийн өртгийг нь тодорхойлсон. Компани эдгээр программ хангамжид жил бүр засвар үйлчилгээний хөлсийг төлөн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

*Эргэлтийн хөрөнгө*

- Компанийн мөнгө, түүнтэй адилтгах зүйлсээс бусад эргэлтийн хөрөнгийг өртөг, цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмжигдсэн эсэхийг шинжилсэн.

*Худалдааны болон бусад авлага*

- Компанийн худалдааны болон бусад авлага нь Даатгалын хураамжийн авлага, Давхар даатгагчаас авах авлага, Бусад авлага зэргээс бүрдэж байна. Үнэлгээчид авлагын дэлгэрэнгүй жагсаалт, насжилтын тайлан, тэдгээрийн үүссэн болон цуглуулагдахгүй байгаа шалтгааны талаарх тайлбарыг авч шинжилсэний үндсэн дээр Найдваргүй авлагын нөөцийг дараах хувь хэмжээгээр тооцоолж хассан Цэвэр боломжит үнэ цэнэ хүртэл нь бууруулж үнэлсэн.

| Авлагын ангилал | Нөөц байгуулах хувь |
|---|---|
| Хэвийн авлага | 0% |
| Хугацаа хэтэрсэн авлага | 5% |
| Хэвийн бус авлага | 25% |
| Эргэлзээтэй авлага | 50% |
| Муу авлага | 100% |

*Бараа материал*

- Компанийн бараа материал нь оффисын хэрэгцээнд ашиглагдаж байгаа хангамжийн шинжтэй зүйлсээс бүрдэнэ. Иймд бид үнэлгээний зорилгоор эдгээр нь үйл ажиллагааны зардалд шингэсэн гэж үзэж үнэ цэнийг тэг хүртэл бууруулж үнэлсэн.

*Урьдчилж төлсөн зардал*

- Компанийн урьдчилж төлсөн зардлаар тайлагнасан зүйлс нь орлоготой уялдуулан дараагийн тайлант жилд зардлаар хуваарилагдах урьдчилгааны дүнг илэрхийлж байна. Эдгээр урьдчилгаа тооцоо нь ирээдүйн өгөөжийн өнөөгийн үнэ цэнийг илэрхийлнэ.

*Хөрөнгө оруулалт*

- Хөрөнгө оруулалт нь хадгаламж, хадгаламжийн сертификат болон үнэт цаасанд оруулсан хөрөнгө оруулалтаас бүрдэж байна. Эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн эсэхийг шинжилсэн.

*Даатгалын хөрөнгө*

- Даатгалын хөрөнгө нь Давхар даатгалын хойшлогдсон хураамж, Нөхөн төлбөрийн нөөцийн давхар даатгалд ногдох хэсэг, Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал зэргээс бүрдэж байна. Эдгээр нь ирээдүйн орлого хүлээн зөвшөөрөлтөд шингэж, зардлаар хүлээн зөвшөөрөгдөх тооцоолсон дүн байна.

## 4.2 Индексжүүлэлт

Бага дүнтэй хөрөнгийг өртгийн хандлагаар үнэлэхдээ индексжүүлсэн өртгийн арга ашигласан талаар дээр дурдсан. Энэ аргын хэрэглээ нь аливаа хөрөнгийн түүхэн өртөг нь хөрөнгийг бүтээн босгох/олж эзэмшиж, ашиглахад бэлэн болгох өдөр хүртэл гарсан өртөг зардлын нийлбэр буюу түүхэн бодит арилжааны мэдээллийг илэрхийлдэг гэсэн төсөөлөлд үндэслэдэг. Өөрөөр хэлбэл, түүхэн өртөгт өнгөрсөн хугацаанд бодитой хэрэгжсэн арилжааны мэдээлэл тусгагдсан байдаг.



СЗХ
он 2018 сар 08 өдөр 29
БҮРТГЭВ
№ 01
МАНДАЛ ДААТГАЛ ХХК
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
БҮРТГЭВ
01
BDO
300
Огноо: 2018/04/16

*Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.*

СЭХ
он 2018 сар 08 29 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 5. Үнэлгээний үр дүн



301
Огноо: 2018/04/16

Монгол улсын БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн Монгол улс дахь албан ёсны гишүүн компани мөн.

### 5.1 Эргэлтийн бус хөрөнгийн үнэлгээний үр дүн

- Бид үнэлгэдэж буй объектын байршил болон шинж чанар, зориулалттай нь ижил төрлийн хөрөнгийн зах зээлийг шинжилсэн. Үүний үр дүнд үнэлгээнд харьцуулалтын зорилгоор ашиглаж болох жишиг хөрөнгийн хангалттай/хүрэлцээтэй борлуулах саналыг цуглуулсан. Зах зээлийн бодит арилжаа болон жагсаалтын үнэд зохих тохируулга хийсний үндсэн дээр зах зээлийн хандлагаар тооцсон хөрөнгийн үнэлгээний дүнг доорх хүснэгтэд хураангуйлав.
- Үнэлгээний тооцооллыг Хавсралт В-ээс дэлгэрүүлнэ үү.

*Зах зээлийн хандлагаар тооцсон борлуулах зориулалтаар эзэмшиж буй үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ*

| Хөрөнгийн нэр | Тоо хэмжээ | ХОЗҮХХ-өөр ангилах үеийн анхны өртөг | ХОЗҮХХ-өөр ангилсан огноо | Бодит үнэ цэнийн тооцоолол хийсэн хамгийн сүүлийн огноо | ХОЗҮХХ-ийн хамгийн сүүлийн бодит үнэ цэнэ | Тохируулгын ерөнхий итгэлцүүр | Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ |
|---|---|---|---|---|---|---|---|
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 1.00 | 110,000,000 | 1/1/2015 | 12/31/2016 | 236,640,000 | 1.06 | 249,864,000 |



СЗХ он 2018 сар 08 өдөр 29 БҮРТГЭВ № 01

МАНДАЛ ДААТГАЛ ХХК МАНДАЛ даатгал УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС BDO GOLOMT CAPITAL LLC 302 Огноо: 2018/04/16

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE БҮРТГЭВ 01

